



ЦАГААТГАХ АЖЛЫГ  
УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
УЛСЫН КОМИСС



Конрад  
-Аденауэр-  
Сан

# “УЛС ТӨРИЙН ХЭЛМЭГДҮҮЛЭЛТ: ШАЛТГААН, ҮР ДАГАВАР, СУРГАМЖ”

(ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН ЭМХЭТГЭЛ)

Улаанбаатар хог  
2017

*“Улс төрийн их хэлмэгдүүлэлт гарсны 80 жил”,  
“Хэлмэгдэгсдийн дурсгалыг хргдэтгэж 22 дахь өдөр”-т зориулав.*

Эмхэтгэсэн: П.Нарандалай, П.Оюун

Хэвлэлийн эх бэлтгэсэн: С.Даш-Очир

Цаасны хэмжээ: 176x250

Хэвлэлийн хуудас:

Конрад-Аденауэр-Сангийн дэмжлэгтэйгээр хэвлэв.



# ГАРЧИГ

Босго үг	6
Монгол улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулгын хэлмэгдэгсэд, тэдний үр хүүхэд, ар гэрийнхэнд хандаж хэлсэн үг	8
Улс төрийн хэлмэгдүүлэлт: шалтгаан, үр дагавар, сургамж олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд:	
УИХ-ын дэд дарга, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга Я.Санжмятавын хэлсэг үг	10
МУ-ын Ерөнхийлөгчийн Соёл, шашны бодлогын зөвлөх Ц.Хулангийн хэлсэг үг	13
Улс төрийн хэлмэгдэгсдийн холбооны тэргүүн Д.Цогтбаатарын хэлсэг үг	15
Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын үйл ажиллагааны талаарх мэдээлэл	
Улсын комиссын нарийн бичгийн дарга П.Нарандалай	20

## I ХЭСЭГ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛ

- Үндсэн илтгэл  
*Ж.Болдбаатар*  
Доктор (Sc.D) Академич, Монгол улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн  
ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн  
“Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлт, түүний уршиг, үр дагавар” 26
- Илтгэлүүд  
*Акира Оно*  
Доктор (Ph.D), Профессор  
Япон улс, Шизуока их сургууль  
“Хятадын соёлын хувьсгалын үед Хятадын засгийн газраас явуулсан Монголчуудын геноцид” (1966-1976 он) 45
- Г.Ариунболд*  
Магистр  
Монголын улс төрийн хэлмэгдэгсдийн холбоо,  
“Панмонголизм”-ын улс төрийн хилс хэрэгт Монголын улс төрчдийг хэлмэгдүүлсэн нь (1937-1941 он) 63
- Н.Батболд*  
Магистр  
ТЕГ-ын Тусгай архив,  
Угсаа залгамжилсан засаг ноёдыг хэлмэгдүүлсэн асуудал 69

5. *О.Батсайхан*  
*Доктор (Sc.D)Монгол Улсын Төрийн соёрхолт*  
*ШУА-ийн ОУХХ, Удирдлагын Академи*  
**Монголд гарсан улс төрийн хэлмэгдэл, түүний хор уршиг**  
**Монголын төрийн тэргүүн Лосолын Лааганы жишээн дээр** 82
6. *Б.Баттөмөр*  
*Доктор (Ph.D)*  
*МУБИС-ийн Түүхийн тэнхим*  
**Монголын нийгмийг үзэл сурталжуулсны үр дагаварыг үнэлэх нь** 106
7. *Ж.Баасандаш*  
*Эдийн засагч*  
*Монголын улс төрийн хэлмэгдэгсдийн холбоо*  
**Үндэсний эрх ашиг ба сэхээтний хэлмэгдэл**  
**Үндсэрхэх үгүйсгэх үзэлтэн, төөрөлдсөн сэхээтэн, намын эсрэг бүлэг**  
**гэгдэгчид (1940-1960 он)** 112
8. *Ч.Болдбаатар*  
*Доктор (Ph.D), Дэд профессор*  
*МУБИС-ийн Түүхийн тэнхим*  
**1932 оны зэвсэгт бослогод оролцогчдыг цагаатгах ёстой юу?** 134
9. *С.Ганболд*  
*Доктор (Ph.D), Профессор, хурандаа*  
*Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Цэргийн түүх*  
*судлалын төв*  
**Улс төрийн хэлмэгдүүлэлтэд Монгол Ардын Хувьсгалт Цэргийн бие**  
**бүрэлдэхүүн өртсөн нь** 143
10. *Д.Дашдулам*  
*Доктор (Ph.D), Профессор*  
*МУИС, ШУС, Түүхийн тэнхим*  
**Монголд 1930-аад оны улс төрийн хэлмэгдүүлэлтийг хийх нийгмийн**  
**сэтгэл зүйг бэлдсэн нь** 150
11. *Даниел Шмюкинг*  
*Доктор (Ph.D)*  
*Конрад-Аденауэр-Сан*  
**Социалист нийгмийн үеийн монгол оронд гарсан улс төрийн**  
**хэлмэгдүүлэлт** 161
12. *Б.Зинамидэр*  
*Судлаач*  
**1932 оны бослогыг Банчин Богд, Ензон хамба хоёр удирдалцсан** 172
13. *С.Л.Кузьмин*  
*Түүхийн шинжлэх ухааны Доктор, Профессор*  
*ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины хүрээлэн*  
**БНМАУ дахь бурхан шашны сүм хийдийг устгасан нь: механизм**  
**хийгээд учир шалтгаан** 182
14. *Р.Мөнхтариа*  
*УЕП-ын газарт цагаатгал хариуцан хяналтын прокуророор ажиллаж*  
*байсан судлаач, хуульч*  
**Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгах хууль зүйн**  
**үндэслэл** 195
15. *Б.Пунсалдулам*  
*Доктор (Ph.D), Профессор*  
*ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн*  
**Улс төрийн хэрэг явдал ба Монголын үндэсний соёл (1935-1955 он)** 198

16. Г.Пүрэвбат Бурханч лам “Үгүйсгэж болохгүй хэлмэгдүүлэлтийн баримт”	209
17. Р.Төрдалай Магистр ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн Монгол оюутан сурагчид улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртсөн нь (1926-1930 он)	236
18. С.Туяа Түүхч, судлаач “Дело №17093”	251
19. Удо Баркман Доктор (Ph.D), Профессор ХБНГУ “Монгол дахь хэлмэгдүүлэлт ба нийгмийн хөгжил”	270
20. Н.Хүдэрбат Магистр, хошууч Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Цэргийн түүх судлалын төв Монгол ардын хувьсгалт цэргийн байшинтын 7 дугаар морьт дивизээс улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн цэргийн алба хаагчдын судалгаа	278
21. Д.Цотгбаатар Улс төр судлаач, эрх зүйч Улс төрийн хэлмэгдэгсдийн холбоо Хэлмэгдүүлэлт ба цагаатгал	293
22. Ш.Цэрэндоо Шинжлэх ухааны тэргүүний ажилтан Хэлмэгдэгчийн нэр төр-хүний үнэ цэнэ	320
23. Да.Эрдэнэбат Доктор (Ph.D) ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн Их хэлмэгдүүлэлтийн үеийн Монголын орон нутаг: Хэнтий аймгийн жишээн дээр	337
24. С.Энхжин Доктор (Ph.D), Дэд профессор МУБИС-ийн Түүхийн тэнхим Хар жагсаалт хаанаас эхтэй вэ?	345

## II ХЭСЭГ. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, ЗӨВЛӨМЖ

Эрдэм шинжилгээний хуралд үг хэлсэн оролцогчид	354
Эрдэм шинжилгээний хурлаас гарсан зөвлөмж	378

## III ХЭСЭГ. ХАВСРАЛТ

Тушаал, шийдвэрүүд	382
Гэрэл зураг	386

## БОСГО ҮГ

Хүн төрөлхтөнд заяасан хамгийн эрхэм үнэт зүйл бол хүний амь нас, амьд явах эрх юм. Дэлхийн олон оронд хүний амьд явах эрхийг тунхаглан Үндсэн хууль бусад хууль тогтоомжоороо баталгаажуулсан байдаг түүнчлэн Монгол Улс ч Үндсэн хуулиндаа хүний амьд явах эрх, эрх чөлөө, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулсан улсын нэг.

Монгол Улс хүн төрөлхтний үнэт зүйлийн эрхэм дээд илэрхийлэл болсон хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн ардчилсан тогтолцоонд хөл тавиад даруй 27 жил болжээ. Олон ургальч үзэл, тэгш эрх, хууль, шударга ёс, ил тод байдал, хүний эрх, эрх чөлөө ямар үнэ цэнэтэй, ямар нандин байдгийг Монголчууд улам бүр мэдэрч, иргэнийхээ хувиар улс төрийн оролцоо, сонголт шийдвэрт төдийгүй нийгэм, төрийн үйл ажиллагаа, өдөр тутмын үйл хэрэг, амьдрал ахуйдаа хандах хандлагадаа тусган төлөвшүүлэхээр хичээж, хэрэгжүүлж байгаа нь өнөөдрийн мэдээллийн эрин зуунд амьдарч байгаа бидэнд илт мэдрэгдэж, харагдаж байгаа билээ. Мэдээж, бид огт баргаа саадгүй цэх шулуун замаар замнасангүй. Алдаа, оноо, сургамжтай басхүү хатуу сорилт шалгууртай түүхэн жилүүдийг үджээ.

Монгол орныг улс төрийн хэлмэгдүүлэлтийн улаан шуурга эрчлэн дайрсны 80 дахь жил энэ онд тохиож байгаа ба улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг 22 дахь удаагаа улс даяар өргөн тэмдэглэв.

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын захирамжаар Монгол улсад их хэлмэгдүүлэлт гарсны 80 жил, хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх 22 дахь өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх хэлмэгдэгсдийг санан дурсах, тэдний гэгээн дурсгалыг хүндэтгэн мөнхжүүлэх ажлыг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэхээр шийдвэрлэж, хэлмэгдэгсдийн дурсгалд зориулсан үзэсгэлэн, лам хуврагуудыг олноор цаазлан хороосон газар болох Хамбын овоонд хэлмэгдэгсдийг хүндэтгэн дурсах, хойч үеийнхэнд эргэн сануулах, болж өнгөрсөн түүхэн гашуун сургамжийг иргэдэд таниулан сурталчлах зорилгоор шашин, соёлын хүндэтгэлийн арга хэмжээ, “Улс төрийн хэлмэгдүүлэлт: шалтгаан, үр дагавар, сургамж” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал зэрэг дорвитой арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

Энэ эрдэм шинжилгээний хурлаар монголчуудын туулж өнгөрүүлсэн XX зууны хамгийн эмгэнэлт түүх хэлмэгдүүлэлтийн зарим асуудлуудаар санаа бодлоо солилцон, хэлэлцэж мөн хэлмэгдүүлэлт хэмээх хар сүүдэр дэлхийн зарим оронд хэрхэн болж өнгөрсөн тухай түүний хор уршиг, сургамжийг сонсож ярилцлаа.

Улс төрийн хэлмэгдүүлэлтийн хор уршгийг энэ цаг үед амьдарч байгаа хүн бүрийн сонорт хүргэн олон нийтэд тайлбарлан таниулах, хэлмэгдүүлэлт хэмээх зүйл өнөө цаг үед өөр хэлбэрээр дахин давтан үүсч гарахаас урьдчилан сэргийлэх улмаар хэлмэгдүүлэлт судлалыг түүхийн болон шинжлэх ухааны талаас авч үзэх, хэлмэгдүүлэлтийн хор уршгийг барагдуулах, цагаатгалын үйл ажиллагааг үргэлжлүүлэх талаар шийдвэр гаргагчдад тодорхой санал зөвлөмж хүргүүлэх асуудал энэ эрдэм шинжилгээний хурлын гол, зорилго байлаа.

Олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд нийт 24 илтгэл тавьж хэлэлцүүлэгдсэн бөгөөд илтгэлүүдтэй холбогдуулан хуралд оролцогсод өөрсдийн санал бодлыг илэрхийлэв. Хуралд оролцогчдоос 3 зүйл бүхий зөвлөмж гарган шийдвэр гаргагчдад хүргэжээр тогтсон болно.

Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр, Их хэлмэгдүүлэлтийн 80 дахь жилийн хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар болон зарим хүмүүсийн хэлсэн үг, Олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд тавьж хэлэлцүүлсэн эрдэмтэн судлаачдын илтгэлүүдийг нэгтгэн эмхэтгэл болгон хэвлүүлээ.

Хамтран ажилласан МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газар, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Конрад-Аденауэрын-Сан, ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн, Тагнуулын Ерөнхий газрын Тусгай архив, Монголын улс төрийн хэлмэгдэгсдийн холбоо, Нийслэлийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комисс, Монголын үндэсний музей, Үндэсний төв архивын газар, Гандантэгчэнлин хийд, Дашчойлон хийд, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улсын Драммын Эрдмийн театр, П.Гэндэнгийн нэрэмжит сан, гадаад дотоодын эрдэмтэд судлаачидад Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын зүгээс гүн талархал илэрхийлэе.

Илтгэлүүд зохиогчийн редактороор хэвлэгдлээ.

Энэхүү эмхэтгэлд орсон илтгэл мэдээлэлтэй холбоотой санал, хүсэлт, шүүмжлэл байх аваас бидэнтэй 51-265723 утсаар холбогдоно уу.

*Цагаатгах ажлыг удирдан  
зохион байгуулах улсын комиссын  
нарийн бичгийн дарга П.Нарандалай*



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ХАЛТМААГИЙН БАТТУЛГА

“Монголчууд аа, Эрхэм төрийн түшээд, энд хүрэлцэн ирсэн улс төрийн намуудын удирдлагууд аа, Хатагтай, ноёд оо,

Та бид 80 жилийн өмнөх хэзээ ч мартаж болохгүй хар өдрийг нэхэн санаж, улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэхийн зэрэгцээ түүхэн, гашуун, сургамжийг төрийн ой санамжид багтай суулгаж, иргэнийхээ эрх, эрх чөлөөг ямагт сахин хамгаалах Төрийн дархлааг нь бэхжүүлэхийн чухлыг ахин эргэцүүлэхийн тулд энд хуран цуглаад байгаа билээ.

Их хэлмэгдүүлэлтийн талаарх Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссоос гаргасан тоо баримтуудаас заримыг нь дурдахад л сэтгэл хирдхийлгэж байна. 1937-1939 он хүртэл хоёр жилийн хугацаанд Онцгой бүрэн эрхт комисс гэх хэлмэгдүүлэлтийг гардан хэрэгжүүлэгч бүтэц 25 мянга 824 хүнийг хилс хэрэгт унаган таслан шитгэснээс 20 мянга 474 хүнд буудан алах ял оноож байжээ.

Нийт 17 мянга орчим лам хувраг хилс хэрэгт шийтгэгдсэний 14 мянга нь цаазаар авахуулсан байна. Энэ бол сонссон монгол хүн бүр сэтгэл шимшрэхгүй байхын аргагүй тоо! Энэ бол Монголын өв уламжлал, язгуур сэтгэлгээ, үндэстний ой санамж, эх оронч тэмүүллийг хэдий хэмжээгээр тасдан хаясныг илтгэх тоо.

Улс төрийн хэлмэгдүүлэлт бол аль ч цаг үед Төрөөс гаргаж, давтаж болохгүй балмад үйлдэл бөгөөд үндэстний тэргүүний оюун ухаан, дархлааг мөхөөх далд явуулгын илэрхийлэл юм. Монголын төр ахин хэзээ ч ард иргэдээ хэлмэгдүүлэхгүй байх, төрийн өндөр албан тушаалтнууд улс төрийн зорилгоор өрсөлдөгчөө хэрэгт унагаадаг

шат дамжлага, шударга бусын хонгилыг төрийн бүтцийг ашиглан бий болгодоггүй байх тийм бат бөх ардчилал, шударга ёс бүхий иргэний төрийг бид өдөр тутмын шаардлага, сонор сэрэмжээрээ л бий болгож, бэхжүүлэх учиртайг би энэ өдөр ахин дахин сануулмаар байна. Үүний тулд Монголын төр хэлмэгдэгсдээс, тэдний гэр бүл, үр хүүхэд, залгамж хойчоос оройтсон ч гэсэн бүрэн уучлал гуйх ёс зүйтэй байх ёстой.

Би ард олныхоо итгэлээр Монголын төрийг тэргүүлж байгаагийн хувьд өнөөдөр Улс төрийн хэлмэгдэгсдээс, тэдний гэр бүл, төрөл төрөгсдөөс гүнээ уучлал гуйж байна.

Хүлээж авна уу.

Монголын төр дахин хэзээ ч ийм алдаа гаргах ёсгүй. Хойч үе маань үүнийг хэзээ ч бүү мартаг! Их хэлмэгдэлд өртөн амь нас, эрүүл мэндээрээ хохирч, ажил амьдралаа алдсан Та бүхний хохирлыг юугаар ч нөхөж чадахгүй. Энэ бол монгол үндэстэнд учирсан асар том гарз хохирол байсан.

*Сайн амгалан болтугай.*

*Монгол оронд эрх чөлөө, хүний эрх үеийн үед дэлгэрэх болтугай.*



*Я.Санжмятав  
УИХ-ын дэд дарга,  
Цагаатгах ажлыг удирдан зохион  
байгуулах улсын комиссын дарга*

Эрхэм хүндэт зочид оо, эрдэмтэн судлаачид аа

Эрдэм шинжилгээний бага хуралд хүрэлцэн ирсэн хүндэт зочид та бүхний амар амгаланг айлтгахын ялдамд, улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдний дурсгалыг мөнхжүүлэх, улс төрийн хэлмэгдүүлэлтийн хор уршгийг арилгах, түүний шалтгаан нөхцөлийг зөв тодорхойлох, хэлмэгдэгчдийн бодит түүхийг хувь хүний төдийгүй нийгмийн талаас нь тодруулах, зарим тодорхой үйл явдлыг олон талаас нь задлан шинжлэх, улмаар улс төрийн хэлмэгдүүлэлтийг дахин гаргахгүй байх зорилго бүхий чухал ажилд хамтран оролцож байгаа бүх байгууллага, хамт олон, эрдэмтэн судлаачид Та бүхэнд талархал илэрхийлье.

Монголын түүхэнд хар мөр үлдээсэн хамгийн эмгэнэлт үйл явдал бол ардын хувьсгалт төр засаг байгуулагдсаны дараахнаас эхэлсэн, 1937-1939 онуудад илүү өргөн хүрээг хамарч өрнөсөн улс төрийн хэлмэгдүүлэлт билээ. Уг хэлмэгдүүлэлтэд манай улс олон арван мянган иргэд, түүний дотор чадвартай сэхээтэн, удам судартай иргэд (нударган хэмээгдсэн) лам хуврагууд илүүтэй өртсөн юм. Энэ нь хэлмэгдүүлэлтийн зорилгыг тодорхойлсон улс төрийн бодлого байсан юм. Эрдэмтэн судлаачдын гаргасан судалгаанаас үзэхэд тухайн үеийн манай улсын хүн амын насанд хүрсэн зургаан эрэгтэй тутмын нэг нь улс төрийн хилс хэрэгт өртөн баривчлагдаж, тэдний дөрвөн хүн тутмын нэг нь амь насаа алдан цаазлагдсан байдаг билээ.

Ардчилсан хувьсгал өрнөсөн 1990 оноос өмнө оршин тогтнож байсан төр-нийгмийн тогтолцооны он жилүүдэд ард түмнийхээ элэг зүрхийг эмтэлсэн, олон мянган хүний цус нулимс, амь нас, өнчрөл хагацлын эмгэнэлт үйл явц болох “Улс төрийн их хэлмэгдүүлэлт”



болсноос хойш эдүгээ 80 жил болжээ. Түүнчлэн улс төрийн хилс хэрэгт олон мянган гэмгүй иргэдийг хилсээр хэлмэгдүүлснийхээ төлөө Монголын төр ард түмнээсээ уучлал хүсэж, амь насаа алдсан хэлмэгдэгсдийнхээ дурсгалыг хүндэтгэн мөнхжүүлэх, санан дурсах зорилгоор Монгол Улсад улс төрийн хэлмэгдүүлэлт нийгмийн олон салбар, давхаргыг хамран өргөн далайцтай нийтийг хамарч өрнөсөн 1937 оны 09 сарын 10-ны өдрөөр төлөөлүүлэн жил бүрийн 09 сарын 10-ны өдрийг “Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалын өдөр” болгон улс орон даяар тэмдэглэх тухай УИХ-ын тогтоолын дагуу энэ өдрийг 22 дахь жилдээ тэмдэглэнэ.

Эдгээртэй холбогдуулан Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссоос эрхлэн “Улс төрийн хэлмэгдүүлэлт шалтгаан, үр дагавар, сургамж” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж байна.

Эрдэм шинжилгээний бага хуралд МУ-ын Ерөнхийлөгчийн Зөвлөх, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Хүний эрхийн үндэсний комисс, Улсын Дээд Шүүх, Улсын Ерөнхий Прокурорын Газар, Тагнуулын Ерөнхий Газар, МУ-ын Шинжлэх Ухааны Академийн Түүх, археологийн болон Олон улсын харилцааны хүрээлэнгийн эрдэмтэд, Монгол улсын их сургууль, Монгол Улсын боловсролын их сургууль, Батлан хамгаалахын их сургуулийн багш эрдэмтэн судлаачид, УБ хотын болон зарим аймаг дүүрэг дэх Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссын удирдлагууд, Улс Төрийн Хэлмэгдэгсдийн Холбоо, Цаазлагдсан Улс төрийн хэлмэгдэгчийн хүүхэд ТББ, ХБНГУ-ын Конрад Аденауэрын Сан, Хэлмэгдэгсдийн гэр бүлийн төлөөллүүд, ХБНГУ, ОХУ, Япон улсын эрдэмтэд болон хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд оролцож байна.

Бид өнөөдрийн энэ эрдэм шинжилгээний хурлаар Монголчуудын туулж өнгөрсөн XX зууны хамгийн харамсалтай үйл явдал улс төрийн хэлмэгдүүлэлтийн зарим асуудлуудаар эрдэмтэн судлаачдын илтгэлийг сонсож санал бодлоо солилцон, хэлэлцэх болно.

Их хэлмэгдүүлэлт бол Монголын ард түмний XX зууны түүхийн салшгүй нэг хэсэг учир түүнийг тойрсон, үйл явцыг элдэв өнгө будаггүйгээр үнэн зөвөөр үнэлэн цэгнэх, олон түмэнд нэг мөр зөв ойлголт өгөх, хэлмэгдэгсдийн түүхэн өвийг нь хадгалах, судалгаа шинжилгээ хийж, алдаа сургамжийг нь залуу хойч үедээ ойлгуулан үлдээх, хэлмэгдүүлэлтийг дахин гаргуулахгүй байх түүхэн шаардлага эдүгээ нэн чухал байна.

Энэ хурлын хүрээнд дээр дурдсан чиглэлүүдэд онцгой анхаарал хандуулж, хэлэлцүүлж байгаа илтгэлүүдтэй холбогдуулан санаа бодлоо илэн далангүй солилцож, шинэ үеийн Монголын түүхийн

нэгэн чухал зангилаа асуудал болох “хэлмэгдүүлэлт судлал”-ын ажилд тодорхой ахиц гаргахад сэтгэл гарган идэвхитэй оролцохыг та бүхнээсээ хичээнгүйлэн хүсье.

**Эрхэм хүндэт эрдэмтэн, судлаачид аа**

**Хүндэт зочид оо,**

Улс төрийн хэлмэгдүүлэлтийг үнэн бодитоор нь судалж дүгнэх, тухайн үеийн нам, төр иргэнийхээ эрхийг ноцтой зөрчиж, халдашгүй эрхийг нь хамгаалж чадаагүйгээ ойлгож, нэр төрийг нь сэргээх, алдар гавьяаг нь мөнхжүүлэх, хохирлыг нөхөн барагдуулах, хэлмэгдэгсэд тэдний ар гэр, үр хүүхдүүдэд хандах асуудлыг Монголын төрөөс цаашид ч нухацтай авч үзэх болно.

Улс төрийн хэлмэгдүүлэлтийн талаарх үнэн бодит шалтгаан нөхцөлийг түүхэн үйл явц төдийгүй тухай үеийн нийгэм, улс төрийн болоод шашин, үзэл суртал, хувь хүн талаас нь судлан, бодит байдлыг тодорхойлж улмаар өнөө болон хойч үеийнхэндээ сургамж болгон үлдээхэд энэ эрдэм шинжилгээний хурлын ач холбогдол орших болно.

Монгол Улсын тусгаар тогтнол, хөгжлийн түүхийн оноо нь ч, алдаа нь ч бидэнд өв болон үлдэх учиртай. XX зууны Монголын түүх бол бидний дээд өвөг Чингис хаан, Хөх монголчуудын түүхийн үргэлжлэл учраас Хэлмэгдүүлэлт хэмээх гунигт боловч үнэнд гүйцэгдсэн түүхийг Монголын түүхээс баллуурдах юм уу, бүхнийг өнгөрсөн цаг хугацаанд тохож болохгүйн учир тэр. Түүхээ бодитоор нь шастирлан үлдээж, түүхэн үйл хэрэг, түүхэн хүн, түүхэн цаг үеийг бодитой зөв үнэлэн дүгнэж өнөөгийн болон хойшдын ажил амьдралын зам мөртөө зөвөөр тусгаж чадаж гэмээнэ бид ирээдүй рүүгээ итгэлтэй замнаж чадна.

Эрдэм шинжилгээний хурлын үйл ажиллагаанд амжилт хүсч нээснийг мэдэгдэе.

*Та бүхэндээ сайн сайхны ерөөл өргөе.*

*Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай!*



*Ц.Хулан*

*МУ-ын Ерөнхийлөгчийн Соёл,  
шашны бодлогын зөвлөх*

Эрхэмсэг ноёд, хатагтай нар аа,  
Хүндэт зочид оо,  
Монгол Улсын болон гадаадын эрдэмтэн, судлаачид аа,

Туулсан түүхийнхээ хар толбыг эргэн харж, сургамж авч чадах эсэхээ аливаа төр ард түмний ухааны цараар хэмжиж болох билээ. Ихийг үзэж туулсан хүн төрөлхтний түүхэнд ч ховор Монголын ард түмний эмгэнэл, харууслын туйл болсон их хэлмэгдүүлэлт, ард түмнийхээ хамгийн оюунлаг, шилдэг нийгмийн давхрааг үгүй хийсэн цуст яргалалаас хойш 80 жил өнгөрчээ.

Гэвч 80 жилийн салхи бороо ард түмний ой дурсамжаар энэхүү аймшигт он жилүүдийг угааж, баллуурдаж ер чадсангүй. Учир нь энэхүү хэлмэгдүүлэлтийг давхин бүү давтагдаасай гэхдээ төр ард иргэдэд олон улсад ямагт сануулж байдаг шилдэг оюунтай эрдэмтэн мэргэд байсаар ирсэн юм. Өнөөдөр ч гэсэн Монгол Улсын маань болон гадаадын олон эрдэмтэн судлаачид энэ л бодит шалтгаанаар хуран цуглараад байна. Та бүхэндээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Хэлмэгдүүлэлтийг зүгээр л нэг бодоод өнгөрсөн үзэгдэл төдийд нь биш хэлмэгдэл гээч ойлголтыг ёзоор, мөн чанараар нь судлан илрүүлэх, хэсэг бусад хүмүүсийг цагаатгаж, нөхөх олговор олгох төдийгөөр ам таглах төдийд биш цаг хугацааны болон үйл явдлын өргөн цар хүрээнд нь шинжиж улс төрийн дүгнэлт гаргах эр зоригийг өнөө цагийн монголын төрөөс ард иргэд маань шахаж, шаардаж байна. Энэ бол цаг үеэ олсон хождуулж болохгүй захиалга юм. Тийм ч болохоор их хэлмэгдүүлэлтийн сэдэв эрдэмтэн судлаачид та бүгдийг улам улам шинэ баримт, түүн дээр баримталсан баталгаа нотолгоог ар араасаа нэхэж байна.

Хоёр чонын дунд таарсан талын гөрөөс шиг хотолсон шуурган дунд өргөсөн зул шиг Монголынхоо төр, улсын хувь заяаг атгаж ирсэн өвөг дээдсийнхээ уламжлалт төрийн бодлогыг их хэлмэгдүүлэлтийн гүн хар ангалаас өнөө үе рүү татан авч сэлбэн сэргээж, нөхөн тордож, уламжлуулан хөгжүүлж байж Монгол Улс хөгжлийнхөө зөв голдрилд орно. Энэ нь та бүгдийн судалгаа шинжилгээний нөр их хөдөлмөрөөс ихээхэн хэмжээнээс хамаарах нь гарцаагүй. Хэлмэгдүүлэлт гээч хувирамтгай, олон үртэй, зальхай харгис гэмт үйлдлийг таньж мэдэж, хор хохирлыг нь бүрэн гүйцэд тогтоож олон улсад хүлээн зөвшөөрүүлж, монголын ард түмэн хөрш гүрнүүдийн улс төрийн харгис бодлогын золиос хэзээ ч болох ёсгүйг дэлхий нийтэд тунхаглаж байж хэлмэгдүүлэлт дахин давтагдахаас бид сэрэмжилж чадна.

Үндэсний язгуур эрх ашгаа дээдлэн ард түмнээ намч, үзэл суртлаар талцуулахгүй, эв нэгдлээ сахин хамгаалах Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгч жинхэнэ ардчилсан сонгууль, шударга сонгуулиар ялалт байгуулсан Халтмаагийн Баттулгын мөрийн хөтөлбөрийн үзэл санаатай эрдэмтэн та бүгдийн хүмүүнлэгийн энэ агуу үйлс яв цав нийцэж байгаа юм.

Анхаарал хандуулсанд баярлалаа. Хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.



*Д.Цогтбаатар*

*Монголын Улс төрийн  
хэлмэгдэгсдийн холбооны тэргүүн*

Юуны өмнө хэлмэгдүүлэлтийн талаар, хэлмэгдүүлэлтийн учир шалтгааны талаар олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд хүрэлцэн ирсэн эрхэмсэг, ноёд, хатагтай, төрийн төлөөлөл, Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгч, эрдэмтэн судлаачид, олон улсын эрдэмтэн судлаачдад энэ өдрийн мэндийг уламжилъя.

Та бид өнөөдөр маш чухал асуудлыг хэлэлцэж байгаа. Чухлын чухал асуудлыг хэлэлцэж байгаа. Монголчууд бид нарт тохиолдсон энэ уй гашуу бол XX зууны түүхэнд, сүүлийн жилийн түүхэнд гарсан ийм хар толбо байна. Үүнийг маш товчхон ярихыг хичээе. Мөн дүн шинжилгээ хийхийг хичээе.

Хэлмэгдүүлэлт бол мэдээж энд хүн оролцсон байгаа. Хүнээ хэлмэгдүүлсэн. Хүн хэлмэгдлээ гэдгийг бид бүхэн аливаа улс орны хөгжлийг эдийн засгаар нь хэмждэг юм байдаг юм байна. Одоо тэгвэл хүний хөгжлөөр нь хэмждэг цаг үе бий болсон байгаа. Ингээд үзэх юм бол тухайн үеийн монголын сор болсон, оюунлаг, гэгээлэг энэ улсуудыг аваад явчих тийм эрхэм улсуудаа бид хэлмэгдүүлсэн байдаг. Ингээд дүгнээд үзэх юм бол ерөөсөө хүнээ хэлмэгдүүлсэн улс орон бол хөгжлийн хоцрогдолд ордог юм байна. Тэгээд бид 70, 80 жил дэлхийн хөгжлөөс хоцорсон байна гэж дүгнэж болохоор байна. Үүнийг би албан ёсоор хэлье гэж бодож байна.

Монголд өрнөсөн улс төрийн их хэлмэгдүүлэлт бол Монголын ард түмний хувьд хэзээ ч мартаж болохгүй, мартахын аргагүй, шарх шаналал дахин давтах ёсгүй түүхийн гашуун сургамж юм. Үзэл бодол, гарал үүсэл, язгуур угсаа, шашин шүтлэгээрээ ялгаварлагдсан улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн олон мянган иргэдийн үр сад өнөөдөр шударга ёсыг шаардсаар байна, хүлээсээр байгаа. Мөн бид нарт Их

Хурал, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, төрийн бус байгууллагаас манай байгууллага гээд сүүлийн 20 гаруй жил хэлмэгдүүлэлтийн талаар тодорхой ажлуудыг хийсэн. Хийсэн боловч бид нар өнөөдөр хүний эрх талаасаа, хүний эрх зөрчиж байгаа талаасаа түүнийг урьдчилан сэргийлэх талаас тодорхой үр дүнтэй ажлуудыг хийж чадсангүй. Энийг миний хувьд ч гэсэн хүлээн зөвшөөрөх ёстой гэж бодож байгаа.

Манай эрдэмтэн судлаачид ч гэсэн та бүхнийг шүүмжилж байгаадаа хүлцэл өчье. Тэгэхээс ч өөр арга байхгүй. Бид нар зөвхөн нэг хэсэг юмаа тойроод яваад байгаа болохоос биш яг гол юман дээрээ ороод юмаа тодорхой баримтан дээрээ түшиглээд ярьсан юмнууд бас л учир дутагдалтай байгаа. Шинэ үеийн хэлмэгдүүлэлт, хуучин үеийн хэлмэгдүүлэлтийнхээ хоорондын уялдааг харуулсан, түүнийг дүгнэсэн, энэ тал дээрээ илүү бодитой хандах ёстой. Өнөөдөр бид нар баруунтан, зүүнтэн гээд ярьж байдаг. Тэд нарынхаа үнэн мөн чанарыг өнөөдөр хуучин нийгмийнхээ үеийн үзэл суртлаар тайлбарласан чигээрээ байгаа болохоос биш өнөөдөр яг өнөөдрийн өнцгөөс тэр улсуудын юу хийж бүтээсэн, хэн нь юу хийгээд байгаа гэдгийг бас дүгнэж хэлж чадаагүй л байгаа. Ийм учраас өнөөдрийн энэ эрдэм шинжилгээний хурал бол үүнд бодитой дүгнэлт өгөх байх гэж бодож байна, зоригтой хэлэх байх гэж бодож байна. Энэ дээр эрдэмтэн судлаачид маань дуугарч чадна гэдэгт эргэлзэхгүй байгаа.

Энэхүү хэлмэгдүүлэлтийн ужиг асуудал дээр Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгчийн бие төлөөлөгч Соёл, шашны бодлогын зөвлөх хатагтай Ц.Хулан таныг Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулгын анхаарлыг хандуулж ажиллана гэдэгт итгэлтэй байгаа. Яагаад гэвэл энэ цаг үеийнхээ хувьд Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс, иргэний нийгмийн байгууллагууд бид нар бас хамтарч ажиллах, цаг үеийнхээ өнөөдрийн хувьд тохирох ажлуудыг эхлүүлж байна. Төр оролцохгүй бол аливаа асуудал бодитой явдаггүй юм байна гэдгийг сүүлийн үеийн бидний амьдралаар харуулж байна. Тухайлбал, хууль бус орлогыг гадаад дансанд байрлуулсан оффшорын асуудлыг бид өнөөдөр бас хэлмэгдүүлэлттэй холбогдуулж ярихаас өөр аргагүй. Мөн төр оролцохгүй бол энэ асуудал шийдэгдэхгүй. Төр оролцох юм бол шийдэгдэнэ гэхэд харьцаа амьдрал дээр бодитой харагдаж байна.

Тэгэхээр хэлмэгдүүлэлт бол бид 1940-өөд он хүртэл цуст яргалал, залхаан цээрлүүлэлт, олноор нь хоморголон алсан ийм гэмт үйлдэл болсон. Өнөөдөр бид хэн нэгнийг яллана гэхээсээ илүү энэ гэмт үйлдэл байна гэдгээ шүүхээр тогтоолгоогүй байна. Бид нарын өвөг дээдэс маань 90-ээд оны үед энэ асуудлыг тавьж байсан. Дээд шүүх энэ дээр хариулт өгөөгүй. 2016 онд миний бие бас л Дээд шүүхэд хандсан.

Монголд өрнөсөн энэ гэмт үйлдэл нь хэн нэгнийг яллах гэж байгаа биш үйлдэл болсон юмуу, үгүй юмуу гэдгийг тогтоох л асуудал байгаа юм. Гэтэл анхан шат руугаа шилжүүлсэн. Бид анхан шатны шүүхэд хандаад явж байгаа.

Мөн энэ хэлмэгдүүлэлт бол оюун санааны, бид нарын өвөг дээдсийн маань бүтээсэн Монголын тусгаар тогтнол, өв соёлыг маань устгасан ийм аймшигтай хэлмэгдүүлэлт болсон. Энэ юугаараа батлагдаж байна гэхээр сүм хийдийн барилга, дацангууд, соёлыг устгаснаараа батлагдаж байгаа юм.

Гуравдахь асуудлыг би Та бүхэнд их хэрэгтэй байх гэж бодож байна. Энэ хэлмэгдүүлэлт гарах үндэс нь юунаас үндэслэж гарсан юм бэ? Эрх зүйн талаасаа юунаас болж вэ гэдгийг бид бас зоригтой хэлээд явах ёстой юм шиг байгаа юм. Гэхдээ энэ хэлмэгдүүлэлтийн уг үндэс нь 1924 онд батлагдсан анхдугаар Үндсэн хууль. Анхдугаар Үндсэн хууль бол товчхон дүгнэж хэлбэл, хуульчилсан төрийн эргэлт байсан. Хуулиндаа юу гэж заасан гэхээр ангиар ялгаварлах тэр үзэл санааг тэр хуулинд зааж өгсөн. Өөрөөр хэлбэл, бид жинхэнэ ард гэж ялгадаг, жинхэнэ бус ард гэсэн. Үүгээрээ хамаг гамшиг эндээс эхэлж байгаа. Тийм учраас жинхэнэ бус ардыгаа бид нар шоовдорлосон, алан хядсан, эд хөрөнгийг нь хураасан, бүр ирж суугаад булаасан. Одоо хүртэл өгөхгүй байгаа шүү дээ. Тэгэхээр бид юу гэж бодож байна гэхээр өнөөдөр Монголын улс төрийн хэлмэгдэгсдийн холбоо юу гэж байна гэхээр энэ болсон үйл явдал бол геноцид байсан. Төрлөөр устгах гэмт хэрэг геноцид байсан. Ингэж хэлэхээс өөр арга байхгүй. Яагаад гэвэл НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхагт заасан байгаа. Хэрвээ тэр аймаглан устгасан гэх юмуу зөвхөн лам хувраг гэдгээр нь, буриад гэдэг үндэстнээр нь устгасан байх юм бол төрлөөр устгах гэмт хэрэгт тооцно.

Мөн орон байрыг нь устгасан байх юм бол мөн тооцно гэж бүр зачихсан байгаа. Тэгэхэд өнөөдрийг хүртэл бид энэ дээр асуудал тавиад байхад өнөөдрийг хүртэл шийдэхгүй яваад байгаа. Тэгэхээр Монгол Улсын шинэ Ерөнхийлөгч онцгой анхаарах байх гэж бодож байна. Хүн талаас нь, хүмүүнлэг талаас нь хандах ёстой. Өнөөдөр монголчууд бид хүнээ үнэлээгүй явж байна. Монгол хүнээ үнэлж чадахгүй явж байна. Монгол хүнээ үнэлэх ёстой. Монголчууд ямар оюунлаг байна гэхээр дэлхий нийтэд хүүхэд залуучууд маань оюуны спортоор байнгын харуулж байгаа шүү дээ. Тэгэхээр бид дэлхий дээр оюунлаг ард түмэн гэдгээ бас нотлох ёстой, бид энэ үнэлгээг хийх ёстой юм. Өнөөдөр зөвхөн Цагаатгалын хууль гэдэг юмуу, нөхөх олговрын хууль гэхээс илүү ариун чухал асуудал бол хүний эрхийн тухай. Хүнээ хамгаалсан хууль хэрэгтэй байгаа. Энэ хуулийг баталж байж цаашдаа хэлмэгдүүлэлтийг үе шаттай гаргахгүй байх боломжийг таслан зогсоох юм.



Намууд гэдэг чинь нэг бол үзэл бодлоор нь ажлаас нь халж байдаг, хоморголон халж байдаг. Нэг бол эдийн засаг руу нь халдаж байдаг, хууль бусаар халдаж байдаг, гэмт хэрэгтэн болгох гэж оролдож байдаг, энэ шинэ үеийн үзэгдэл чинь хэлмэгдүүлэлт өөрөө үе шаттайгаар өөрсдөд нь яг хамелеон шиг хувираад байгаа юм. 40-өөд оны өмнөх үе бол яг цуст яргалал, алан хядах үйл ажиллагааг дүгнэж үзэх юм бол ерөөсөө 4-хөн жилийн дотор 27,000 хүнийг шүүхээр шийтгээд, 20,000 хүнийг шууд цаазалсан. Өөрөөр хэлбэл, шүүхээр шийтгэж байгаа хүмүүсийнхээ 79 хувийг нь шууд цаазлаад авсан. Эндээс харагдаж байгаа юм. Энэ дээр бид дүгнэлт гаргах ёстой гэж бодож байна. Онцлогийнх нь хувьд.

Та бид өмнөх үеэ бас хүндэтгэж байх ёстой, хайрлаж байх ёстой. Алдаж оносон зүйл бидэнд байдаг байх. Өвөг дээдэст маань ч байдаг байх, бидэнд ч өнөөдөр харагдаж байгаа. Дарга түшмэл царайлсан хүмүүс ер нь хэнийг ч хайрлахгүй хэлмэгдүүлдэг цаг үе өнөөдөр ч харагдаж байгаа. Хүний эрхийн зөрчил амьдрал дээр нүдэнд харагдаад байгаа юм. Тийм учраас бид нар өөрөөр хэлбэл, энэ оффшорт хууль бусаар нууц мөнгө, эдийн засгийн том эргэлтэд орох мөнгийг хувийнхаа эрх ашигт зориулаад зарж завшаад нуучихна гэдэг чинь энэ нь монголын баялаг өөрөө байгаа юм. Монголын хөрөнгө байж байгаа юм, тэр мөнгө чинь байж байгаа юм. Гол нь Монголын баялагийг гадаадынханд боломж олгож өөртөө боломжоо авна гэдэг чинь монголын 3 сая иргэдийг эдийн засгийн хэлмэгдүүлэлтэд өртүүлж байна гэсэн үг. Энэ шинэ үеийн хэлмэгдүүлэлт бол эдийн засгийн хэлмэгдүүлэлт байна гэж харах ёстой.

Улс орны үндэсний эрх ашгийн төлөө тэмцсэн хүн бүхэн гай зовлонд учирдаг гэж нэг хүн хэлсэн байдаг юм байна лээ. Яагаад гэвэл үндэсний эрх ашиг, тусгаар тогтнолынхоо тэмцсэн хүн бүхэн хохирч байдаг. Үүний жишээ бол 1911 оны үндэсний хувьсгал, 1921 оны ардын хувьсгалд оролцож байсан манай эрх чөлөөний тэмцэгчид сайн ноён Намнансүрэн, Чин ван Ханддорж, Хатанбаатар Магсаржав, Манлай баатар Дамдинсүрэн, Сангийн яамны анхны сайд Нандинбалын Чагдаржав гэж хүн байна. Чагдаржав гэж хүн бол анх удаа монголд гадныхан уул уурхай ухаж байхад нь татвар ногдуулахыг анх удаа санаачилсан юм. Дараа нь учир битүүлгээр тэр хүнийг хороосон. Энэ бол үе үедээ үндэснийхээ эрх ашгийн төлөө тэмцсэн бүхэн хохирч байдаг, хэлмэгдэж байдаг тод жишээ юм.

1921 оны Ардын хувьсгалд оролцож байсан Бодоо, Данзан, Догсом, Лосол, Чагдаржав, Амар, Жигжиджав, Гэндэн, Дэмид, Бадрах, Лхүмбэ, Лааган, шинэ үеийн 50, 60-аад оны үеийнхээс Дамба, Төмөр-Очир, Аварзэд, Лоохууз, Нямбуу, Сурмаажав, 70-аад оныхоос Жамъян гуай байж байна, 80-аад оныхоос Чимидийн Энхээ гэх мэтчилэн үе



шаттайгаар үндэснийхээ эрх ашгийн төлөө дуу хоолойгоо хүргэсэн бүхэн хэлмэгдэлд орсон.

Тэгвэл би маш ойрхоны жишээ товчхон хэлье. Өнөөдөр болж байгаа үйл явдал дээр анхаарлаа хандуулах ёстой байх. Өнөөдөр Монгол Улсын 6 дахь Ерөнхий сайд Жигжиджавын байрлаж байсан, төр нийгмийн зүтгэлтнүүдийн байрлаж байсан байшин барилгад халдаад эхэллээ. Та нар очоод хараарай. Тойроод нүхийг нь ухчихсан. Ийм л увайгүй, бид нар өнөөдөр ингэж загнах юм бол хэлмэгдүүлэлтийнхээ асуудлыг шийднэ гэхэд маш төвөгтэй. Гэхдээ энд шийдэхгүй биш шийдэж чадна. Энд би эргэлзэхгүй байна. Тийм хэн нэгнийхээ байшин барилга, тэр өвөг дээдсийнхээ өв болсон байшин барилгыг ичгүүр сонжуургүйгээр булааж авах гэсэн ийм улсуудын дэргэд бид ажиллаад, амьдарч байна гэхэд сэтгэл өвдөхөөс өөр аргагүй байна шүү дээ. Гэхдээ би энэ хүний тухай товчхон хэлэх нь зүйтэй гэж бодож байна.

Нэгд, энэ хүн бол төр нийгмийн зүтгэлтэн, төрд томоохон үйл хэргийг хэрэгжүүлсэн ийм хүн байгаа юм. Бид нар хэлэлцүүлгийнхээ эцсийн эцэст хүн бүхний хийсэн, бүтээсэн, алдсан оносон бүгдийг ярина. Тийм учраас бид нар шинэ үеийнхээ юмтай хавсаргаж хэлж байгаа учраас энийг бас ойлгох ёстой. Энэ 1925 онд Манжийн хааны сүргийг ард иргэддээ өгөх ийм шийдвэрийг энэ хүн гаргаж, ард түмнээ өмчтэй болгох, өмч хувьчлалын эхний суурийг тавьсан.

Хоёрт, бид бүхний одоо үнэт цаас, облигац гэж яриад байдаг үнэт цаасыг анх өөрийнхөө гарын үсгийг зурж байж монголын анхны үнэт цаас гарсан. Энэ үнэт цаас нь Сингапур улсын үнэт цаасны зах зээлд байсныг саяхан эрдэмтэн судлаач авчирч бидэнд албан ёсоор үзүүлсэн байгаа. Энэ бол бидэнд энэ хүний үлдээсэн том үйл хэрэг. Мөн Манжийн хааны үед бид нарын бүтэц маань тархай бутархай, 180-аад нэгжийн бүтэцтэй байсныг шинэ цагийн бүтэцэд оруулж, энэ оруулах үйл хэрэгт өөрийн гар биеэр оролцсон хүн бол энэ Жигжиджав. Гэхдээ бид ийм хүмүүсийнхээ хийж бүтээсэн зүйлийг, өвөг дээдсээс үлдсэн үнэт зүйлсийг өнөөдөр шинэ үеийн бид хэн нэгний хувиа хичээсэн үйлдлээр булааж авах гэсэн эдийн засгийн хэлмэгдүүлэлтэд өртүүлэх гэсэн ийм үйл ажиллагааг бид хийх ёсгүй гэдгийг та бүхэнд онцолж хэлье.

Ингээд энэ эрдэм шинжилгээний хуралд амжилт хүсье. Баярлалаа.



*П.Нарандалай*

*Цагаатгах ажлыг удирдан зохион  
байгуулах улсын комиссын нарийн  
бичгийн дарга*

Хуралд хүрэлцэн ирсэн та бүхний амар амгаланг айлтган мэндчилье.

1937 онд их хэлмэгдүүлэлт гарснаас хойш эдүгээ 80 жил өнгөрсөн байна.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссоос их хэлмэгдүүлэлт гарсны 80 жил, хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх 22 дахь өдрийн хүрээнд хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх, тэдний гэгээн дурсгалыг санан дурсах, хэлмэгдүүлэлтийн хор уршгийг арилгах хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд Улсын комиссын даргын захирамжаар тодорхой ажлыг төлөвлөн улс орон даяар хэрэгжүүлж байгаагийн нэг чухал ажил нь “Улс төрийн хэлмэгдүүлэлт: шалтгаан, үр дагавар, сургамж” олон улсын эрдэм шинжилгээний бага хурал юм. Энэ бага хурлыг Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод зохион байгуулж байгаадаа баяртай байна.

Бага хуралд хүрэлцэн ирсэн эрдэмтэн судлаачид, зочид төлөөлөгчид Та бүхэнд Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нэрийн өмнөөс талархал илэрхийлье.

Та бүхэнд Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссоос хийж хэрэгжүүлсэн ажлыг талаар товч танилцуулга хийе.

### **Нэг. Бүтэц, бүрэлдэхүүн**

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн нэр төрийг сэргээн цагаатгах, хэлмэгдэгсэд болон тэдний гэр бүл, үр хүүхэд, ач, зээ

нарт хуульд заасан нөхөх олговор олгох, хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгах, хэлмэгдэгсдийн дурсгалыг мөнхжүүлэх, улс төрийн хэлмэгдүүлэлтийн хор уршгийг нийтэд таниулан сэрэмжлүүлэх ажлыг улс орны хэмжээнд зохион байгуулах гол чиг үүрэгтэй ажилладаг.

1939-1955 онд Дотоод явдлын яамны шийдвэрлэсэн улс төрийн зарим хэргийг хянан үзэх тусгай комисс, 1957-1962 онд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дэргэдэх Цагаатгах ажлыг эрхлэх комисс, 1988-1990-ээд оны сүүл хүртэл МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Цагаатгалын комисс ажиллаж тухайн цаг үедээ үүргээ гүйцэтгээд татан буугдсан юм. Гэвч улс төрийн хэрэгт шийтгүүлэгсдийн хэргийг иж бүрнээр нь нягтлан шалгаж хэлмэгдсэн бүх иргэнийг цагаатгаж чадаагүй тул цагаатгалын ажлыг үргэлжлүүлэх бие даасан Улсын комиссыг БНМАУ-ын Ерөнхийлөгчийн 1990 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 56 дугаар зарлигаар байгуулж ажиллуулсан юм.

1990 оноос одоо хүртэл Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргаар 11, Улсын комиссын нарийн бичгийн даргаар 5, Улс төрийн хэлмэгдэгсдийн судалгааны төвийн захирлаар 8 хүн тус тус ажиллаж байсан байна.

1990-2014 онд Улсын комиссын ажлын алба 8, Судалгааны төв 11 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд судалгааны төвийг 2014 онд татан буулгажээ.

Одоо улсын комиссын ажлын алба нь 10 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн баталсан тус комиссын дүрэмд зааснаар Улсын комиссын дарга, нарийн бичгийн дарга, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга, Сангийн сайд, Улсын ерөнхий прокурор, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн, Тагнуулын ерөнхий газрын дарга, тус газрын Мөрдөн байцаах хэлтсийн дарга, Улсын комиссын Ажлын албаны Захиргаа, дүн шинжилгээний албаны дарга комиссын гишүүнээр ажилладаг. Орон тооны Ажлын албатай бөгөөд Улсын комиссын нарийн бичгийн дарга Ажлын албыг тэргүүлж, өдөр тутмын удирдлагаар хангаж ажилладаг.

Тус комисс хуульд заасны дагуу Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд ажлаа танилцуулж, удирдамж чиглэл авч ажилладаг бөгөөд Улсын комиссын ажлын тайланг 1995, 2000, 2014 онд хэлэлцэж үүрэг чиглэл өгснийг хэрэгжүүлэн ажиллаж ирсэн.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн асуудлыг шалгах, цагаатгаж нэр төрийг сэргээх ажилд Улсын дээд шүүх, анхан шатны шүүхүүд, Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар гол үүрэг гүйцэтгэдэг.

Нийслэл, аймаг, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал салбар комиссын үүргийг гүйцэтгэдэг бөгөөд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нь салбар комиссын даргаар, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга нь салбар комиссын нарийн бичгийн даргаар ажилладаг.

### **Хоёр. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах ажлын явц байдал**

1922 онд Ерөнхий сайд С.Бодоо, Д.Чагдаржав нарын хэрэг гэгчээр эхэлж, С.Данзан, Баваасан нарын болон тайж Эрэгдэндагва, дилав хутагт Б.Жамсранжавын хэрэг гэгчээр үргэлжлэн, 1933 оны “Лхүмбийн хэрэг, 1937 оны П.Гэндэн, Г.Дэмид нарын хувьсгалын эсэргүү бүлгийн хэрэг гэгчээр дээд цэгтээ хүрч, 1939 онд А.Амар, Д.Лувсаншарав нарын бүлгийн хэрэг гэгчээр эрч далайц нь хумигдсан улс төрийн залхаан цээрлүүлэлт, хэлмэгдүүлэлт бол XX зууны Монголын түүхэнд тохиолдсон аймшигт эмгэнэлт явдал юм. 1937 оны 9 дүгээр сарын 10-аас 1939 оны 4 дүгээр сар хүртэлх хугацаанд улс төрийн өргөн баривчилгаа явагдсан бөгөөд хувьсгалын эсэргүү, тагнуулын хэрэг гэгч улс төрийн хилс хэргийг хүчээр тулган хүлээлгэж байсан юм. 1950-1990-ээд оны хооронд “намын эсрэг бүлэг, сэхээтний төөрөгдөл, үндсэрхэг үзэл, шашнаар нөлөөлж мунхруулсан” гэхчлэнгийн үндэслэлээр ял шийтгэх, нутаг заан суулгах, ажил албан тушаалаас нь өөрчлөн хэлмэгдүүлж байв. Энэ мэтчилэнгээр 1922-1990 оны хооронд бүрэн бус мэдээгээр нийтдээ 36,0 мянга гаруй хүн улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн бөгөөд өнөөдрийн байдлаар 31220 хүнийг цагаатгаад байна. Үүнд:

- 1939-1990 онд 4065 хүн
- 1990-2017 онд 27155 хүн

*1922-1990 оны хүртэлх хугацаанд улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэж, цагаатгагдсан иргэдийн мэдээлэл*

Ажил мэргэжлээр нь:

- Аграмба, гавж, равжамба, хувилгаан, хутагт лам, ширээт лам зэрэг мяндаг тушаалтан болон лам хуврагууд 18816
- Тайж, ноён, ван, гүн, бэйс, бээл, захирагч зэрэг язгууртан албан хаагч 2447
- Дарга, ажилтан, ажилчин, малчин, оюутан 3413
- Цэргийн дарга, үүрэгтэн 1169
- Эрхэлсэн ажил, мэргэжил тодорхойгүй 5381

Цагаатгагдсан иргэдийг ялын байдлаар авч үзвэл:

- Буудан алах ялаар-20417 хүн
- Хорих ялаар-7444 хүн

- Тэнсэн харгалзах, торгох, ажил албан тушаалаас халагдаж, нутаг заагдан цөлөгдсөн, мөрдөгдөж байгаад суллагдсан 822 хүн
- Мөрдөгдөн шалгагдаж байх хугацаандаа нас барсан 124 хүн
- Ялын байдал нь тодорхойгүй 2413 хүн

*Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдэд нөхөх  
олговор олгосон байдал*

1998 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр батлагдсан Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 13 дугаар зүйлийг үндэслэн 18197 нэхэмжлэгчид 16,4 тэрбум төгрөгийн нөхөх олговор, мөн хуулийн 23 дугаар зүйлийг үндэслэн 153 иргэнд орон сууц, 208 иргэнд орон сууц орлосон мөнгөн олговор нийт 3,4 тэрбум төгрөгийг тус тус олгоод байна.

Хэлмэгдэгсдийг нөхөх олговор авсан байдлаар ангилвал:

- Хэлмэгдэгч -269,
- Хэлмэгдэгчийн эхнэр (нөхөр)-383,
- Хэлмэгдэгчийн үр хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, ач, зээ, ач дүү, зээ дүү-17568.

Одоогоор 1000 гаруй иргэн нөхөх олговроо авахаар нотлох баримт бүрдүүлэх шатандаа явж байна. Мөн Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн нөхөх олговрыг аваагүй 12,0 мянга орчим иргэн байна.

*Улс төрийн хэлмэгдүүлэлтийн судалгааны ажлын талаар*

Улсын комиссын дэргэд байгуулагдсан Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн Судалгааны төвийг 1991 онд байгуулж 23 жил ажиллаж, 2014 онд татан буулгасан. Судалгааны төв ажилласан дээрх хугацаанд хэлмэгдэгсдийн талаарх судалгааны ажлыг шинээр эхлүүлж нилээд эрчимтэй ажилласны үр дүнд “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн намтрын товчоон” цуврал 20 боть, 30378 гаруй хэлмэгдэгсдийн мэдээлэл багтаасан “Цагаан ном” 4 боть, Ц.Дамдинсүрэн, Сэхээтний төөрөгдөл, Москвад хэлмэгдсэн Монгол иргэд, Лам нарыг хэлмэгдүүлсэн нь зэрэг эрдэм шинжилгээ, судалгааны ач холбогдол бүхий олон арван бүтээлүүд, Төр нийгмийн зүтгэлтнүүдийн намтарчилсан бүтээл 100 гаруйг тус тус хэвлэн нийтлэжээ. Мөн 20 гаруй удаа “Эрдэм шинжилгээний хурал” зохион байгуулж ажиллажээ.

Судалгааны төвд ажиллаж байсан үе үеийн эрдэмтэн судлаачдын нөр их хөдөлмөрийн үр дүнд бий болсон дээрх бүтээлүүд бүх их дээд сургууль, аймаг, нийслэлийн номын сангуудад хүргэгдэж уншигчдын хүртээл болоод байна.

## Гурав. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

1. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэхэд Улсын комиссын зүгээс анхаарч бэлтгэх ажлыг хангаж ажиллах (Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасан цагаатгуулах өргөдөл гаргах хугацаа 2011 оны 12 дугаар сарын 30-аар дуусгавар болсон тул шинээр өргөдөл хүлээж авах ажил зогсож иргэд энэ чиглэлээр хүсэлтээ шийдвэрлүүлэх боломжгүй болсон юм. Ийм байдал өмнө нь гарч байсан учир хэлмэгдэгчдийг цагаатгуулах, нөхөх олговор нэхэмжлэх хугацааг УИХ-аас 2000, 2002, 2006, 2009 онд нийтдээ 4 удаа сунгаж байсан юм. Дээрх байдлыг үндэслэн УИХ-ын дэд дарга, Улсын комиссын дарга Я.Санжмятав нарын гишүүд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж УИХ-д өргөн барьсан).

2. Эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр ажиллах төсөв, санхүү, хүний нөөцийн асуудлыг зохистой шийдвэрлэх,

3. Цагаатгагдсан боловч нөхөх олговрыг аваагүй иргэдийн асуудлыг холбогдох хуулийн хүрээнд шийдвэрлэж, эцэслэх,

4. Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалыг мөнхжүүлэх, хор уршгийг арилгах соён гэгээрүүлэх чиглэлээр тогтмол үйл ажиллагаа явуулах,

5. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах болон нөхөх олговор олгох чиглэлээр ажилладаг байгууллагуудын хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулах,

6. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн нэмэлт өөрчлөлт батлагдсан тохиолдолд хуулийн хэрэгжилтийг хангахад холбогдон гарах дүрэм журмыг шинэчлэх, мөрдөж ажиллах,

7. Хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр Улс төрийн хэлмэгдүүлэлт, цагаатгалын үйл ажиллагааг тогтмол хугацаанд тодорхой давтамжтайгаар олон нийтэд хүргэх асуудлыг судлаж шийдвэрлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх,

8. Өнгөрсөн хугацаанд цагаатгалын үйл ажиллагаатай холбоотой хийгдсэн ажлуудыг архивлах, олон нийтэд хүргэх ажлыг оролцогч талуудын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх зэрэг зорилтыг дэвшүүлж байна.

*Олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд амжилт хүсье.*

*Анхаарал хандуулсанд баярлалаа*



# I ХЭСЭГ

ЭРДЭМ  
ШИНЖИЛГЭЭНИЙ  
ИЛТГЭЛҮҮД

## МОНГОЛ ДАХЬ УЛС ТӨРИЙН ХЭЛМЭГДҮҮЛЭЛТ, ТҮҮНИЙ ХОР УРШИГ, ҮР ДАГАВАР



*Ж.Болдбаатар  
Доктор (Sc.D) Академич, Монгол улсын  
шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн  
ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн*

### Нэг . Улс төрийн хэлмэгдүүлэлтийн эхэн

Өнгөрсөн түүхээс үзэхэд, улс төрийн тэмцлийн явцад ялж дийлсэн бүлэглэл нөгөө хэсгээ егүүтгэх нь ёс мэт дагаж иржээ. Үүний хамгийн тод, төвлөрсөн бурангуй илэрхийлэл нь улс төрийн хэлмэгдүүлэлт юм. Хэлмэгдүүлэлт хэмээх нэр томъёо нь *repressio* хэмээх латин үгнээс гаралтай. Улс төрийн шинжлэх ухааны тайлбар толиудад хэлмэгдүүлэлт гэдэг нь төрөөс хууль бусаар хийж буй залхаан цээрлүүлэх бусармаг ажил үйлдэл хэмээн тодорхойлсон байна.

1921 оны үндэсний ардчилсан хувьсгал ялсны дараа үзэл бодлын зөрөө, улс төр, албан тушаалын хэнээрхэл, харийнхны яс хаях бодлогын уршгаар Монголын удирдагчид бие биенээ хардан сэрдэж егүүтгэн хэлмэгдүүлж эхэлжээ. 1922 онд Ерөнхий сайд Д.Бодоог элдвээр гоочлон ажлаас нь халаад, улмаар хувьсгалын эсэргүү хүчинтэй сүлбэлдсэн хэмээх хилс хэргээр цаазаар авчээ. 1924 онд Монгол Ардын Намын анхны дарга асан Бүх цэргийн жанжин С.Данзанг намын жанжин шугамыг гажуудуулахыг санаархсан, хувьсгалын эсэргүү үйл ажиллагаа өдөөсөн хэмээх хилс хэргээр Монгол Ардын Намын III их хурал хуралдаж байх явцад баривчлан шүүлгүйгээр амь насыг нь хороож байв.

**Улс төрийн хэлмэгдүүлэлтийн хамгийн том анхны илрэл нь 1933 онд “Лхүмбийн хэрэг” гэгч зохиомол хэргийг үүсгэн бүрдүүлсэн явдал юм.**

Лхүмбийн хэрэг гэгчид 2140 хүнийг холбогдуулж, МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга Ж.Лхүмбэ зэрэг олон хүнийг дайчлан



баривчилж, тэдэнд Японы тагнуулын байгууллагын даалгавраар зэвсэгт бослогод бэлтгэж байсан хэмээх ял тулгаж, 317 хүнийг хилсээр шийтгэжээ. Энэхүү зохиомол хэрэг нь Монголд дагаар орсон буриадуудыг цагаантны оргодол, японы тагнуул, панмонголизмын үзэлтэн хэмээн зөвлөлтийн тал үзэж, монголын зарим удирдагчид түүнийг идэвхтэй дэмжин өөгшүүлснээс үүдэн бий болсон юм.

Эл хилс хэрэг нь 1937-1940-өөд оны Монгол дахь улс төрийн нийтээр хэлмэгдүүлэлтийн оршил, эхлэл болж өгсөн юм.

### ***Хоёр. Хүмүүсийг үй олноор нь хомрогolon хэлмэгдүүлсэн нь***

Дотоодыг хамгаалах газрын ажилд гарсан алдаа завхрал нь төрийн яам болж зиндаа дээшилснээр засрах байтугай улам гүнзгийрчээ. Угаасаа эл газрыг төрийн яам болон өргөжүүлсэн нь И.В.Сталин, түүний гар хөл бологчид Монголын дотоод хэрэгт оролцох “хар савраа” уртасгасан явдал байв. Учир нь 1934, 1935 онд Монголын нам, төрийн удирдагчид ЗХУ-д ажлын айлчлал хийж, И.В.Сталин, В.Молотов, К.Е.Ворошилов нартай хэд хэдэн удаа уулзаж ирснээс хойш Дотоодыг хамгаалах газрынхны дур зоргоороо аашлах явдал эрс нэмэгджээ.

**И.В.Сталин шинэ нийгэм байгуулалт гүнзгийрэх тусам ангийн тэмцэл хурцадна хэмээн номлож, дотоодын хувьсгалын эсэргүү ноёд, лам нартай эрс тэмцэхийг улс төрийн гол чиг шугам болгохыг шаарджээ. Тэд Монголын удирдагчдын Х.Чойбалсанг онцгойлон сонгож, бүх талаар дэмжин хөхиүлэх бодлого баримталсан байна. Зөвлөлтийн шууд оролцоо дэмжлэгтэйгээр тэр бээр шинэ тутам тэргүүлсэн яамныхаа орон тоог өргөжүүлэх, эрх мэдлийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч, Зөвлөлтийн зөвлөх сургагч нарын тоог олшруулжээ.**

Тэр үед хэрэгтэн өөрөө хэргээ хүлээхээс илүү нотолгоо байхгүй гэсэн А.Я.Вышинский нонол мөрдөн байцаалтад хүчтэй нэвтэрч эхэлжээ. ЗХУ-д гэм зэмгүй хүмүүсийг хэлмэгдүүлэх явдал өргөн хүрээтэй өрнөж байсан энэ үеэс ЗХУ-ын Дотоод хэргийн ардын комиссиарат, БНМАУ-ын Дотоод явдлын яамны удирдлагатай үйл ажиллагаагаа зохицуулж эхэлсэн байна. Ийнхүү 1930-1940-өөд онд явагдсан нийтээр хомрогolon улс төрийн талаар хэлмэгдүүлэх ажлын бэлтгэл 1937 оны хагас гэхэд үндсэндээ хангагдсан байна. П.Гэндэнг Крымээс Сочид шилжин очсон өдөр 1937 оны 7 дугаар сарын 17-нд баривчилжээ. Түүнчлэн тагнуульч бүдүүн хэмээх Ц.Өлзийг ЗХУ-д баривчилжээ. П.Гэндэн, Ц.Өлзий нарыг эрүүдэн байцаасаар Лхүмбийн эсэргүү хэргийг Дэмид нарын хамт үргэлжлүүлсэн хэмээх зохиомол мэдүүлгийг ЗХУ-ын Дотоод хэргийн ардын комиссариат гаргуулж авчээ.

**Маршал Г.Дэмидийг ЗХУ-ын төмөр замын “Тайга” өртөөндээр хорлон, алснаас хойш хоёр хоногийн дараа буюу 1937 оны 8 дугаар**

сарын 24-нд ЗХУ-ын ДХАК-ын орлогч сайд М.П.Фриновский, Батлан хамгаалах яамны орлогч сайд П.Смирнов, ЗХУ-аас БНМАУ-д суух элчин төлөөлөгч С.М.Миронов нар Улаанбаатарт хүрэлцэн ирж, Японоос БНМАУ-ыг эзлэх төлөвлөгөө гэдгийг монголын удирдлагад танилцуулжээ. М.Фриновский 8 дугаар сарын 28-наар өдөрлөсөн “Хуйвалдаан” (заговор) хэмээх хэрэгт холбогдуулах 115 хүний нэрсийн жагсаалтыг Чойбалсанд гардуулсан байна. Хоёр хоногийн дараа Гэндэнгийн хэргээ хүлээсэн мэдүүлэг гэгчийг бас өгчээ.

1937 оны 9 дүгээр сарын 2-нд Чойбалсан Цэргийн яамны сайд, бүх цэргийн жанжнаар томилогдов.

Ийнхүү Чойбалсан Ерөнхий сайдын нэгдүгээр орлогч сайд, Цэргийн яамны сайд, Бүх цэргийн жанжин, Дотоод явдлын яамны сайдын тушаалыг хавсран гүйцэтгэх болж, Засгийн эрх үнэн хэрэгтээ түүний гарт төвлөрчээ. Чойбалсан ЗХУ-ын сталинч удирдлагын дэмжлэгийг хүлээж байсан учир Монголын бусад удирдагчдаас илүү эрх мэдэлтэй илүү хүчтэй байжээ.

1937 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр Монголын түүхэнд аймшигт хар толбо үлдээсэн юм. Тэр өдөр Х.Чойбалсангийн тушаалаар нам, төр, цэргийн удирдах ажилтан 65 хүнийг баривчилжээ. Эл гунигт хар өдрөөс эхлэн төрийн сайдаас эгэл малчныг хүртэл улс төрийн хэлмэгдүүлэлтийн аймшигт сүүдэр дайрч, монголын нийгэм айдас хүйдэст автжээ.

1938 оны 4 дүгээр сард болсон ДЯЯ-ны гүйцэтгэх ажилтны зөвлөлгөөний дараа Х.Чойбалсан тушаал гаргаж, хасгийг “молда”, буриадыг “цагаантны оргодол”, чинээлэг аж ахуйтныг “нударган”, ил тод ярьж шүүмжлэлтэй хандсан хүмүүсийг “урвагчид”, “Японы талыг баримтлагчид”, бүх зиндааны лам нарыг “ардын дайсан” гэж баривчлахыг анги, хэлтсүүддээ даалгаж хэрэгжүүлжээ.

**“Онцгой бүрэн эрхт комисс”** гэгч шүүх эрх мэдлийг булаан өөртөө төвлөрүүлж, Дотоод яамнаас оруулсан нэрсийн жагсаалтаар асуудал шийдэн, **нэг өдрийн хурлаар 129-1278 хүний хэргийг шийтгэж байв.** Хэргийг таслан шийдвэрлэхдээ яллагдагчийг хуралд биеэр оруулдаггүй, улсын ялагч (прокурор/, өмгөөлөгчийг оролцуулдаггүй байсан байна.

**Баривчлагдагсдын дотор эмэгтэй, тэр тусмаа жирэмсэн эмэгтэйчүүд хэд хэд байжээ.** Лхүмбийн хэрэгт хоёр эмэгтэй, Гэндэн, Дэмидийн хэрэгт түүний эхнэр Навчаагаас гадна хэд хэдэн жирэмсэн эмэгтэйг буудан алжээ. **Ямар ч гэм зэмгүй, давхар биетэй бүсгүй хүнийг буудан хороосон жигшүүрт явдал Монголоос өөр дэлхийн бусад улс орнуудад тэр бүр гараагүй болов уу.**

Японы тагнуулын байгууллагын даалгавраар БНМАУ-ын нутагт тагнуул үйлдэх, бослого гаргах, алан хядах, хорлон сүйтгэх үйл ажиллагаа явуулсан хэмээх хилс ялыг 1937-1939 онд баривчлагдсан хүмүүст тулгаж байв. Ийм замаар “Гэндэн, Дэмидийн хувьсгалын эсэргүү байгууллага”, “Ёнзон хамба, дэд хамба нарын эсэргүү байгууллага” гэгч болон түүнтэй холбоотой “Улаан Пүрэвийн хэрэг”, “14-ийн хэрэг”, “Дамба, Найдан нарын хэрэг”, “Амар, Довчингийн хэрэг” зэрэг зохиомол хэргүүдийг бий болгожээ.

Улс төрийн хэлмэгдүүлэлтийн хурц үзүүр нь феодализмтай тэмцэх тугийн дор Чингисийн удам, ноёд язгууртны угсааг үндсээр нь таслахад чиглэж байв. 1938 оны 8 дугаар сард Х.Чойбалсангаас нууц алба, дотоодын тагнуулын ажлыг хүчтэй болгох зорилго бүхий маш нууц тушаалд тодорхойлсноор хар ноёд, тайж 900 хүнийг дайсагнагч этгээд гэж үзэж байсан бол ажил хэрэг дээрээ 1940 гэхэд 1489 тайж нарыг баривчилж, бараг толгой дараалан буудсан байна. Мөн Монголд шинээр дөнгөж бүрэлдэж байсан сэхээтний давхрааг хомроглон устгажээ.

*Гурав. Нам, төрийн удирдах байгууллагуудын үүрэг алдагдсан нь*

Улс төрийн хэлмэгдүүлэлтийн жилүүдэд Дотоод яам, түүний харьяа байгууллагууд эрх баригч нам, төрийн байгууллагуудын дээр гарч, бүхнийг айлган сүрдүүлэх, дарамтлах газар болон хувирчээ. МАХН-ын **IX их** хурлаас (1934 он) сонгогдсон Намын Төв Хорооны **51** гишүүний **83,6** хувь нь улс төрийн хилс хэргээр хэлмэгджээ. Намын анхдугаар их хурлаас (1921 он) IX их хурал (1934 он) хүртэл намын их болон Төв Хорооны бүгд хурлаас сонгогдсон Намын Төв Хорооны дарга, орлогч, нарийн бичгийн даргаар сонгогдсон хүмүүс (өвчнөөр нас эцэслэсэн Б.Элдэв-Очир, 1939 оны 7 дугаар сард нарийн бичгийн даргаар сонгогдсон Д.Дамбыг эс оруулбал) толгой дараалан баривчлагдаж, бүгд цаазын тавцанд очжээ. Намын **IX их** хурлаас сонгогдсон НТХ-ы тэргүүлэгч **11** гишүүнээс зөвхөн Х.Чойбалсан ганцаар үлдсэн байна.

Дээр дурдсан бүхэн нь өгүүлэн буй үед улс төрийн хэлмэгдүүлэлтийн субъект байх байтугай МАХН зохион байгуулалтын хувьд намын дүрэмд заасны дагуу оршин тогтнож чадахаа больсныг харуулж байна.

Төрийн эрх барих, хууль тогтоох дээд байгууллагын үйл ажиллагаа хэлмэгдүүлэлтийн харгайгаар бараг тасалджээ. Тухайлбал, БНМАУ-ын VII их хурлаас сонгогдсон Бага Хурлын гишүүдийн бараг тал хувь нь баривчлагджээ. Чингэснээр хууль тогтоох дээд байгууллага Үндсэн хуулийн дагуу ажиллах чадваргүй болсон байна. Улсын Бага Хурлын гишүүнийг зөвхөн Бага Хурлын тэргүүлэгчдийн буюу онцгой

тохиолдолд Бага Хурлын даргын зөвшөөрлөөр баривчилж мөрдөн байцаах тухай 1933 онд батлагдсан “Монгол Ардын Улсын Бага хурлын гишүүдийн тухай” дүрмийн заалтыг огтхон ч хэрэгсэхгүй байв. Үндсэн хуульд заасны дагуу жилд 2 удаа хуралдах ёстой Улсын Бага Хурал 1937, 1938 онд хуралдаагүй.

Төрийн хүчирхийллийн гол хэрэгсэл-ардын арми, цагдаа, тэр ч байтугай Дотоодыг хамгаалах байгууллагын өөрийнх нь олон зуун ажилтнууд улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртжээ.

1937 оны 9 дүгээр сараас 11 дүгээр сар хүртэлх хугацаанд Цэргийн яам болон жанжин штаб, корпус, дивизүүдийн удирдлагыг бараг бүхэлд нь дайчлан баривчилжээ.

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчид, Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор (1936 оны 11 сарын 21-нээс 1939 оны 07 сарын 19-ний хооронд) өдгөөгийн генералтай дүйцэхүйц цол олгосон МАХЦ-ийн дээд тушаалын 77 дарга нарын 72 нь буюу 93,5 хувь нь хэлмэгдэж, бараг бүгдээрээ хуулийн дээд хэмжээгээр шийтгүүлсэн байна.<sup>1</sup>

Дотоод яам, түүний төв орон нутаг дахь хэлтсийн ажилтан буюу Х.Чойбалсангийн тушаалыг үг дуугүй биелүүлэгч байгаагүй, хууль ёс ноцтой зөрчиж байгаад шүүмжлэлтэй хандаж, засаж залруулах талаар санал бодлоо хэлж байжээ.

### *Дөрөв . Лам нарыг аймаглан устгах довтолгоон*

**И.В.Сталин, түүний Монгол дахь гар хөл бологчдын залхаан цээрлүүлэлт нийгмийн оюунлиг давхраа-лам нарын эсрэг чиглэгджээ.**

**И.В.Сталин 1934, 1936 онуудад П.Гэндэн, А.Амар зэрэг Монголын удирдагчдыг ЗХУ-д айлчлахад эхлээд лам нарт туслах, сэнхрүүлэх маягаар тойрон бүслэх аргаар асуудлыг шийдвэрлэх зөвлөгөө өгч байснаа сүүлдээ лам нарыг даруй шууд даран устгахыг тулган шаардах болсон юм.**

Дотоод явдлын яам лам нарын эсрэг довтолгооныг нийтээр хомроглон баривчлахаас өмнө эхэлжээ. Бүр 1936 онд Ёнзон хамбатай холбоотой хэрэг гэгчийг лам Жамъянтивээр хүлээлгэж, 48 сүм хийдийн лам нарын хэрэг гэгчийг бүрдүүлсэн байв. Үүнийг үндэс болгож 1937 онд “Ёнзон хамба Лувсанхаймчиг, дэд хамба Дамдин нарын “Төв” хэмээх эсэргүү байгууллага” зохиомол хэрэг үүсгэн, лам нарыг олноор нь баривчилж бүрэлгэх ажил эхэлжээ.

1938 оны 4 дүгээр сард ДЯЯ-ны эсэргүүцэн тагнах хэлтсийн дарга Ж.Баясгалан тэргүүтэй хэсэг хүмүүс Хөвсгөл аймагт очиж, 600

<sup>1</sup> Б.Даваасүрэн. Монгол Улсын цэргийн боловсон хүчин бэлтгэсэн нь, үр дүн, сургамж. (1921-1940), Түүхийн ухааны дэд докторын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол.УБ.,1993.т.127.

шахам лам нарыг мөрдөн байцаах ажлыг 20 шахам хоногт дуусгасан туршлагыг тухайн үед ид бах болгон дэлгэрүүлж байжээ.

**Бүртгэлд ороогүй эгэл лам, хар хүнийг алдсан оргосны оронд нөхөх, тоо бөглөх үүднээс баривчлан хэлмэгдүүлэх, мухар сүсгийн харгайгаар сайн дураараа баривчлагдах нэн харамсалтай явдал гарч байжээ.** Хэнтий аймаг дахь хэлтсийн нэг төлөөлөгч Батын Жав гэдэг мяндаг тушаалтай ламыг оргуулж алдаад, оронд нь хөдөө хонь хариулж явсан Жавын Бат гэдэг залууг дайчлан баривчилж байсан аж.

Монголын олон зуун сүм хийд эзгүйрэн орхигджээ. Эхлээд тус улсын 767 сүм хийдийн барилгыг албан байгууллагуудын мэдэлд шилжүүлсэн боловч, сүүлдээ ард олны сүсэг бишрэлийг тэтгэх голомт хэмээн устгаж эхэлжээ.

Лам нарын эсрэг довтлон устгах үйл ажиллагаа бол хүн амыг нийгмийн байдал, шашин шүтлэг, үзэл суртлын зөрөөгөөр нь аймаглан устгасан геноцид гэмт хэрэг байлаа.

***Тав. Мөрдөн байцаах арга хэрэгсэл, шоронгийн нөхцөл, алан хядах үйл ажиллагаа***

Баривчлагдсан хүмүүст ямар нэг аргаар хилс хэрэг тулган хүлээлгэж, зохиомол мэдүүлэг гаргуулж авах нь Дотоодыг хамгаалахын ажилтнуудын гол үүрэг, зорилт байлаа. Байцаагчид баривчлагдагсдыг өндөр сандалд хөлийг нь унжуулан суулгаж, олон хоног нойр хоолгүй тамлан, жижүүрлэн байцааж, хилс хэрэг хүлээлгэж байв. Байцаалтыг гол төлөв өглөөний 10 цагт эхэлж оройн 4 цагт завсарлаад, оройн 19 цагт дахин үргэлжлүүлэн, өглөөний 6 цаг хүртэл байцааж байжээ. Зарим тохиолдолд өглөөний 9 цагаас оройн 17 цаг хүртэл, оройн 17 цагаас шөнийн 1 цаг хүртэл, шөнийн 1 цагаас өглөөний 9 цаг хүртэл жижүүрлэн байцааж байсан аж.

Мөрдөн байцаалтын асуултыг эхэн үедээ байцаагч бүр өөр өөрийнхөөрөө тавьдаг байснаа сүүлдээ нэгдсэн журамд шилжжээ. **Асуултад үл хариулж, хэргээ хүлээхгүй бол дараах бусармаг аргуудыг ээлжлэн хэрэглэж, эрүүдэж байжээ.** Үүнд:

1. Хэрэгт холбогдогсдыг хэл амаар доромжилж, “хуйхыг чинь ярж, хулхинд чинь сум зооно”, “эрэг дэрлүүлж, элсэн хөнжил нөмөргөнө”, “чи одоо хамуутай золбин нохойноос үнэгүй болсон, чамайг нам буудна” гэх мэтээр заналхийлж, буу тулгаж айлган сүрдүүлж байв.

2. Баривчлагдагсдын нүүр рүү нулимах, эмзэг газар нь няслах, чих, хамрыг нь мушгих, үзэг харандаагаар хатгах, шугамдах, тамхины гал, монгол гаансны халсан толгойгоор төөнөх, жигнэх, цохиж тогших зэргээр авирлаж байжээ.

3. Хацар нүүр, чихний тус газраар алгадах, элэг, төмсөг мэт эмзэг эрхтэн рүү нь өшиглөх, бичгийн чулуун хэрэгсэл, сандлын хөлөөр нүүр нүдгүй балбах, шүдийг нь цөм цохих, үсдэж шалан дээгүүр чирч гулдрах, даавуунд элс чулуу боож нүдэх, кабелийн гурав, дөрөв давхарласан утсаар ороолгох зэргээр харгислаж байв.

4. Хүйтэнд гадаа нүцгэн зогсоох, цонх задгайлж дааруулах, хүйтэн мөстөж цантсан өрөөнд дотуур хувцастай нь өчиг өгтөл нь хорих, гар, хөлд нь гав гинж хийх, бууны бөгсөөр ууц руу, тархи толгой руу ёврох нь олонтаа байжээ.

5. Хэргээ хүлээвэл амь өршөөж, хөнгөн ял эдлүүлнэ гэж ятгаж хууран зохиомол хэрэг хүлээлгэх зэрэг олон янзын арга ов мэх хэрэглэж байжээ. Чингэхлээр тэр цагт Монголд ЗХУ-д мөрдөн байцаалтад ашиглаж байсан залхаалтын харгис аргуудыг үндсэнд нь авч хэрэглэж байсан гэж үзэж болно. Харин манай оронд харх байгаагүй учраас баривчлагсдыг зодож нүдэж, цус нөжтэй нь хольж, ухаан алдуулаад хархтай зооринд хаяж, амьдаар нь хүний цусыг сорж зулгаалгадаг харгис арга л арай нэвтрээгүй бололтой.

Хөдөө орон нутагт баригдагсдыг буудан хороох явдал заримдаа хоттой хонь, малаасаа өвлийн идэш хийхээс илүү амархан шийдэж байсан аж. Дотоод яамны Дорноговь дахь хэлтэс 1938 онд 300 гаруй хүн бариад аймгийн шоронд багтахгүй болохоор нь 30 шахам хүнийг буудан алж зай гаргаж байжээ. Дэндүү цадиггүй, балмад үйлдэл гэж энэ буюу.

### ***Зургаа. “Ардын дайсан”-ы ул мөрийг арилгах хийрхэл***

Аливаа хувьсгалт эргэлт, нийгмийн хямрал, давалгааны үед “муу эр дайнд хөөрөв” гэгчийн үлгэрээр улс төрийн хийрхэл дэгдэх нь ёс мэт. Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлтийн үед ч “ардын дайсан”-ы ул мөрийг оргүй арилгах гэсэн хийрхэл дэгджээ. 1937 оны 11 дүгээр сарын 15-нд хуралдсан Намын Төв Хорооны Тэргүүлэгчдийн хурал “ардын дайснууд”-ын ном бүтээлүүдийг “шүүрдэн бүртгэж хураан авах ба цаашид хэрэглэгдэх улс төрийн дэвтэр зохиох” ажлыг хариуцсан комисс байгуулжээ. Энэхүү комиссын шийдвэрээр 1920, 1930-аад онд хэвлэгдсэн ном, товхимол, сэтгүүлийн бүртгэлийг нэг бүрчлэн гаргуулж, улс төрийн хэргээр баривчлагдсан, шийтгэгдсэн хүмүүсийн бичиж туурвисан ном, товхимлыг шатаах, хураах, түүнчлэн эмхэтгэл сэтгүүлд нийтлэгдсэн өгүүллийг хайчлан авч устгах, эсвэл нэр зургийг нь баллах, сохлох зэргээр авирлажээ. БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлөөс томилогдсон комисс 1935-1936 онд хилийн чанадад явж, их хэмжээний зардал гарган хуурч Д.Түдэв, лимбэч Л.Цэрэндорж, дуучин М.Дугаржав зэрэг алдарт хүмүүсийн пянзанд бичүүлж ирсэн ардын урт, богино дууны ховор нандин бичлэг, ардын дууг анх удаа

ноотлож бичсэн эмхэтгэлийг хянан үзээд, 1938 оны 11 дүгээр сарын 15-нд тогтоол гаргаж, хориглон устгахаар шийдвэрлэжээ.

**Тус комиссоос ардын зарим дууны бадгийг дуулахыг хориглож хасах, үгийг засварлах шийдвэр гаргаж байв.** Жишээ нь: “Сийлэн бор” хэмээх ардын дууны:

Талд тавьдаг яс нь байна

Тамд очдог сүнс байна

Тавилант хорвоод бүтдэггүй юм бол

Тамынхаа үүдэнд заргатайхан очно доо хө

Элсэнд тавьдаг яс нь байна

Эрлэгт очдог сүнс байна

Энэхэн хорвоод бүтдэггүй юм бол

Эрлэгийнхээ үүдэнд заргатайхан очно доо хө гэсэн сүүлчийн хоёр бадгийг “там”, “сүнс” мэтчилэн шашны ойлголтууд орсон гэж хасч, дуулахыг хоригложээ.

**“Ардын дайсан “-ы мөрийг баллах хийрхэл дөнгөж урын сан нь бүрдэж эхэлж байсан “Монгол кино” үйлдвэрт хүнд тусчээ.** Тухайлбал, 1936-1939 онд хийсэн 30 шахам баримтат киноны нэлээдийг устгах буюу “хувьсгалын эсэргүү нар” оролцсон хэсгийг танаж сэглэсэн байна. 1940 оны эцсээр гаргасан актаас үзэхэд негатив, позитив нийлсэн бүгд 91,2 мянган метр кино хальсыг устгажээ.

### *Долоо. Их хэлмэгдүүлэлтийн эрч суларсан нь*

Х.Чойбалсан Зөвлөлтийн Дотоод явдлын ардын шинэ комиссар Л.П.Бериятай уулзаж нөхцөл байдлыг сайтар мэдэж авчээ. 1939 оны 3 дугаар сард Зөвлөлтийн тал ДЯЯ-нд ажиллаж байсан хуучин зөвлөхүүдээ татаж, шинэ хүмүүс ирүүлэв. Хэрэг бишдэж байгааг ухаарсан Х.Чойбалсан нутаг буцаж ирмэгц өөрийгөө хариуцлагаас мулталж, алдаа завхралыг засч залруулах ажлыг эхлэн санаачлагч болохыг оролдож эхэлжээ. Мөн цагийн байдал наашилж байгааг мэдэрсэн ДЯЯ-ны зарим удирдах ажилтан ч алдаа завхралыг засах тухай яриа хөөрөө гаргаж эхлэв. Тухайлбал, 1939 оны 4 дүгээр сарын 8-нд ДЯЯ-ны эсэргүүцэн тагнах хэлтсийн дарга Ж.Баясгалан нарын хэдэн хүн Ерөнхий сайд бөгөөд ДЯЯ-ны сайд, маршал Х.Чойбалсанд рапорт бичиж, тус Дотоод яамны мөрдөн байцаалтын ажиллагаанд ужиг болсон хууль бус явдлын тухай илтгэн, зохих арга хэмжээ авч, засаж залруулж өгөхийг хүссэний мөрөөр хянаж шалгах ажлын эхлэл тавигджээ.



Х.Чойбалсан 1939 оны эхээр ДЯЯ-ны орон нутгийн байгууллагын дарга нарт цахилгаан явуулж, Онцгой бүрэн эрхт комиссоос буудан алах ял ногдуулсан хүмүүсийн ялыг гүйцэтгэхийг зогсоож, хэргүүдийг нь шүүхэд шилжүүлэхээр бэлтгэхийг даалгажээ.

Улс төрийн хэлмэгдүүлэлтийг зогсоох гэсэн дээрх оролдлогуудын үрээр 1939-1941 оны 7 дугаар сар хүртэл холбогдох дээд газруудад өргөн айлтгасан өргөдлийг үндэслэн 2134 хүний хэргийг шалгаж, 51 хүний хоригдох хугацааг багасган, 1974 хүнийг холбогдолгүй болгон суллажээ.<sup>2</sup> Энэ бүхний үрээр үй олноор баривчлах явдал нэлээд саарсан боловч, бас хэлмэгдүүлэлт үргэлжилсээр байсан байна. 1939 онд Лувсаншарав, Догсом нарын бүлэг хэрэг, 1940 онд Баасанжаваар толгойлуулсан “Төв” гэдэг хэрэг, 1941 онд Доржпүрэв, Жамсран нарын хэрэг, Өмнөговь аймгийн дарга Дамбарэнцэнгийн хэрэг, мөн герман тагнуулын хэрэг, 1942 онд “Монгол тээхийн хэрэг”, 1943 онд Сүхбаатар аймагт гарсан “Урвагч” гэдэг хэрэг, мөн аймагт Дэндэв, Лувсанням нарын бүлэг хэрэг, 1944 онд Хүүхэн хутагтын хэрэг, Эрүүлийг хамгаалах яамны сайд Гонгоржавын хэрэг, 1949 онд “Порт-Артурын” хэрэг зэрэг зохиомол хэргийг үүсгэжээ. Мөн Дотоод явдлын яамны хэлтэс, тасгийн дарга, ажилтан, түүний харьяа газруудын гүйцэтгэх ажилтнуудын их зонхийг баривчилсан нь хүмүүсийг үй олноор хилс хэргээр хэлмэгдүүлж залхаан цээрлүүлэх үйл ажиллагаанд шууд гар бие оролцсон буюу үйл явдлын амьд гэрч болох гол гол хүмүүсийг зайлуулан цэвэрлэсэн хэрэг юм. 1939 оны сүүлчийн хагасаас 1940-өөд онд 1400 орчим хүнийг баривчлан хэлмэгдүүлсний дотор МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга Б.Баасанжав, Ерөнхий сайдын орлогч Доржпүрэв, Жамсран, Гэгээрлийн яамны сайд Наваан, Улсын прокурор Пунцагдорж, МАХН-ын Төв шалган байцаах комиссын дарга Балганжав, МХЗЭ-ийн Төв Хорооны дарга Магсар, нарийн бичгийн дарга Сэнгэдорж, Нийслэл хотын дарга Лувсаннаваан зэрэг нам, төр, олон нийтийн байгууллагын удирдах ажилтнууд оржээ.

А.Амарыг баривчлагдмагц Х.Чойбалсан Ерөнхий сайд болж, Гадаад явдлын яамны сайдыг хавсран, Дотоод яам, Цэргийн яамыг толгойлж, бас бүх цэргийн жанжны албыг хүлээжээ. Түүний гарт хязгааргүй эрх мэдэл төвлөрчээ. Хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр Х.Чойбалсанг үгийн сайныг уралдуулан цоллож, өргөмжлөн магтах болов. Ингэж Монгол оронд тоталитар дэглэм баттай тогтох шимтэй хөрс бүрджээ.

2 А.Думбурай. Залхаан цээрлүүлэлт.УБ.,1997.т.225.



### ***Найм . Хэлмэгдүүлэлтийн арга, хэлбэрт гарсан өөрчлөлт***

1940-өөд оны сүүлч 1950-иад оны эхнээс олноор хилсдүүлэн баривчилж, хэлмэгдүүлэх явдал “Порт-Артурын хэрэг”-ийг эс тооцвол үндсэндээ зогссон ч улс орны хөгжлийн цаашдын төлвийн тухайд санаа, оноогоо харамгүй илэрхийлэх, нам, засгийн удирдагчдын ажлын алдаа, дутагдлыг шүүмжилсэн, түүх, соёлоо бахархан дээдэлсэн хэнийг ч улс төр-үзэл суртлын талаар хавчин дарамтлах бусармаг аргад шилжжээ. Энэ нь 1940-өөд оны сүүлийн хагаст МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооноос гаргасан тогтоолуудаас (“Ардын унших бичгийн тухай”, “Манай их удирдагч Янжмаагийн 25 жилийн хувьсгалт бүтээл”, “БНМАУ-ын түүх, утга зохиолын сургуулиудад зааж байгаа байдлын тухай” зэрэг) эхлэлтэй.

1950-иад оны эхэн үеэс намын бодлого, улс орны хөгжлийн асуудлаар намын дотор шүүмжлэлт уур амьсгал бий болсон байна. Тухайлбал, 1956 онд хуралдсан МАХН-ын Төв Хорооны бүгд хурал ЗХУКН-ын ХХ их хурлын үйл ажиллагаанаас дүгнэлт хийж, нэг хүнийг тахин шүтэхийн хор холбогдлыг арилгах талаар чухал шийдвэр гаргав. Энэ хурлын дараа болон ер нь 1950, 1960-аад онд нийгмийн амьдралд ардчилсан, шүүмжлэлт уур амьсгалыг сэргээх талаар зарим нэг ахиц гарсан боловч, хуучинсаг хүчнээс тэднийг “сэхээтний төөрөгдөл”, “намын эсрэг явуулга”, “үндсэрхэг, үгүйсгэх үзэлтэн”, “намын эсрэг бүлэг” гэх мэт нэр хоч өгч нухчин даржээ. Үүнд: МАХН-ын Төв Хорооны III бүгд хурал (1959 он. Д.Дамба нар), III бүгд хурал (1962 он. А.Төмөр-Очир), V бүгд хурал (1963 он. Л.Цэнд), VI бүгд хурал (1964 он. Н.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав) холбогдох шийдвэрүүдийг хамруулж болох юм. Үүнээс Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нар социализмын нэлээд ардчилсан, арай илүү үндэсний нүүр царайтай загварыг бий болгох санал бодолтой байсныг, намын эсрэг шугам баримталж, намын дотор хагарал гаргах зорилго бүхий бүлэглэсэн явууллага үйлдсэн хэмээн үзэж, Намын Төв Хорооны бүрэлдэхүүнээс гаргаж, намын эгнээнээс хөөжээ.

Улмаар дээрх бүгд хурлуудаар арга хэмжээ авагдсан хүмүүс болон тэднийг далдуур дэмжигч хэмээн үзсэн хэдэн арван хүнийг албан тушаалаас нь халж, нам, захиргааны арга хэмжээ авч, хөдөө газар нутаг заан суулгаж, тодорхой албан тушаал, үйл ажиллагаа эрхлэх эрхийг нь хаан, мөрдөн хавчиж хүний эрх, эрх чөлөөг ноцтой зөрчиж байв.

Хэлмэгдсэн хүмүүсийг гэр орондоо байхад нь хоёр талын айлаар нь, ажил албан дээр нь хамт ажиллагсадаар нь мэдүүлэг тавьж ашиглан, тэдний аар саар хов живээр хэлмэгдэгсдийг байх суух аргагүй болгон хавчиж хяхна. Сумаасаа өөр суманд, сумаасаа аймгийн төв орох болбол хэлтсийн төлөөлөгчөөс зөвшөөрөл авна. Улаанбаатар хот орох бол төвөөс тусгай зөвшөөрөл өгнө. Үр хүүхэд, ах дүү төрөл төрөгсдийг

нь элдвээр нүд үзүүрлэнэ. Хүүхдийг нь сургууль, соёлд явахад саад учруулна. Нэг ёсондоо “Амьдын там” гэгч болж байлаа. Ийнхүү 1960-аад оны дунд үе гэхэд нэг хүний ганцаар захирах авторитари дэглэм тогтож, 1970-80-аад онд улам гүнзгийрэн бэхжсэн бүлгээ.

*Ес. Алдаа завхралыг засах талаар авсан арга хэмжээ, үр дүн*

МАХН, ардын төр 1930-1940-өөд оны улс төрийн хилс хэрэгт шийтгэгдсэн хүмүүсийг шалгаж цагаатгах ажлыг ЗХУКН-ын ХХ их хурал (1956), түүнээс үйл ажиллагаандаа дүгнэлт хийхээс өмнө эхэлсэн байна. МАХН-ын Төв Хорооны IV бүгд хурлын дараа мэдэгдэхүйц том алхам хийж эхэлсэн юм. Д.Дамбын илтгэлийг авч хэлэлцээд, Х.Чойбалсанг тахин шүтэж байсныг болон хууль ёсыг ноцтой гажуудуулсныг анх удаа албан ёсоор шүүмжилж, «Хувьсгалын эсэргүү хэрэгт худал зэмлэгдсэн хилс шийтгэгдсэн зарим хүний нэрийг хянаж үзэх нь чухал гэж Улс төрийн Товчоо үзэж байна. Ийм арга хэмжээ бол зөвхөн шийтгэгдээд амьд үлдсэн хүмүүсээр зогсохгүй, амь үрэгдсэн үнэнч шударга хүмүүсийн нэрийг ариутган цэвэрлэх, тэдний үр хүүхэд, төрөл садны ирээдүйд их ач холбогдолтой юм.»<sup>3</sup> гэж тэмдэглэжээ.

Тус бүгд хурлын шийдвэрийн дагуу Намын Төв Хороо Б.Ширэндэв даргатай комисс байгуулж, алдаа завхралын мөн чанар, үндсэн шалтгааныг илрүүлэн тавьсан байна. Уг комиссын саналыг үндэслэж, БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1957 оны 106-р зарлигаар АИХ-ын Тэргүүлэгчдийн дэргэд цагаатгах комиссыг байгуулсан байна. 1960 оны VII сард МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчоо «цагаатгах комиссыг эрхлэх комисс, шалгах хэлтсийн ажлын тухай» авч хэлэлцээд, цагаатгах ажлыг эрчимжүүлэх шийдвэр гаргажээ. Намын Хянан Шалгах Хорооны дарга Т.Гэндэнгийн тодорхойлсон комисс «Лхүмбийн хэрэг», «Гэндэн, Дэмидийн хувьсгалын эсэргүү, японы тагнуулын хэрэг» зэргийг хилс болохыг тогтоож, олон мянган хүнийг цагаатгаж, нэр төрийг сэргээсэн дүнг 1962 онд хуралдсан Намын Төв Хорооны II бүгд хурлаар хэлэлцүүлсэн байна. Энэ комисс 1936 оноос 1953 он хүртэл аюулаас хамгаалах байгууллага улс төрийн хилс хэрэгт 29132 хүнийг баривчилсан, 21001 хүнийг буудан алжээ гэдгийг хууль ёсоор шалган тогтоосон байна.<sup>4</sup> эл ажил нэг хэсэг хугацаанд Монголд тогтсон тоталитар дэглэмийн уршгаар эрч далайц нь суларсан боловч, ямар нэгэн байдлаар үргэлжилсээр байсан юм.

Ардчилал, шинэчлэлийн уур амьсгал үүнд шинэ түлхэц өгсөн бөгөөд 1988 онд МАХН-ын Төв Хороо дахин комисс томилж, дээрх хэрэгт холбогдон хэлмэгдсэн олон арван удирдах ажилтныг цагаатгаж, нэр төрийг нь сэргээсэн байна. Түүнчлэн уг комисс 1930-аас 1940-

<sup>3</sup> МАХН-ын төв архив. Ф-4, т-10, ХН-4, т.56

<sup>4</sup> МАХН-ын дотоод архив Улсын аюулаас хамгаалах газрын ажилд гарч байсан алдаа завхралыг шалгасан тухай МАХН-ын Төв Хорооны комиссын илтгэл.(1961.ХИ).т.113

өөд оны улс төрийн хэрэгт холбогдогчдыг нэрсийнх нь дагуу нэг ч хүн үлдээхгүй шалгах зарчим баримтлан, өмнө нь хөндөж шалгалгүй орхисон цөөнгүй хэрэг, тухайлбал: лам нарын асуудлыг шалгаж шийдвэрлэх ажлыг эхлүүлж, нийт цагаатгах ажлыг эрчимжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

1990 онд БНМАУ-ын Ерөнхийлөгчийн 56-р зарлиг гарч, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс байгуулагдснаар Намын Төв Хорооны комисс үүргээ түүнд шилжүүлсэн юм. Гэхдээ МАХН нь үүгээр цагаатгалын ажлыг дуусгаагүй эл хэрэгт тус дэм үзүүлэх талаар зохих анхаарал тавьсаар байсан билээ. Тухайлбал: МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчид 1991 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 30-р тогтоолоор “1950-аас 1980-аад онд улс төрийн талаар хилс зэмлэл хүлээж хохирсон хүмүүсийн өргөдөл, гомдлыг хянан үзэж холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, нэр төрийг нь сэргээхэд туслах үүрэг бүхий комисс” байгуулсан юм. Энэ комисст түүхч эрдэмтэд, намын ажилтнууд, улс төрийн талаар хэлмэгдэгсдийн холбооны зарим гишүүд оролцож, намын зарим гишүүдийн нэр төрийг сэргээх, улс төрийн хэлмэгдэлд өртсөн хүмүүст сэтгэл санааны болон эд материалын дэмжлэг үзүүлэн арга хэмжээ авсаар байсан билээ.

1950-иад оны дунд үеэс хүнийг үзэл бодлынх төлөө хянан хавчиж, хүний эрхийг зөрчиж байсан алдаагаа МАХН шударгаар хүлээх ёстой, хүлээсэн ч юм. Энэ нь 1990 оноос хойших олон үйл явдлаар нотлогдоно. Үүнд:

1. МАХН -ын Төв Хорооны VIII бүгд (1990) хурлаас Д.Төмөр-Очир болон Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нарыг, тэдэнтэй холбогдсон хүмүүсийг Намын Төв Хорооны тэргүүлэгчдийн 1990 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 20 дугаар тогтоолоор улс төрийн талаар цагаатгасан билээ.

2. Намын хянан шалгах хороо, Намын хянан шалгах төв комисс улс төрийн учир шалтгаанаар арга хэмжээ авагдсан хүмүүсийн намын шийтгэлийг нэг бүрчлэн судлан үзэж, МАХН-ын гишүүнээр сэргээн тогтоох, нэхэн сэргээн тогтоох, шийтгэлийг нь хүчингүй болгосон билээ.

3. БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1990 оны 6 дугаар сарын 7-ны өдөр 69-р тогтоолоор тэдгээр хүмүүсийн өндөр насны тэтгэврийн хэмжээг шинэчлэн тогтоох (хэрэв тухайн хүн өөрөө хүсвэл 1964 оны VI бүгд хурлын өмнө хийж байсан ажлынх нь цалингийн дунджаар бодож, тогтоож өгөх), мөн гадаадад суралцаж байсан зардлаа төлсөн бол уг зардлыг эргүүлэн олгохоор шийдвэрлэж, хэрэгжүүлсэн юм.

4. Дээрх тогтоолын дагуу БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1990 оны 6 дугаар сарын 16-ны өдөр 32 дугаар захирамжаар нэр бүхий 56 хүнд 6000-10000 төгрөгний буцалтгүй тусламж олгосон байна.

5. БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчид, Сайд нарын Зөвлөл, МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчдийн 1990 оны 6 дугаар сарын 4-ний хамтарсан хурлын протоколоор нутаг заагдан очиж, орон нутагт ажиллаж байсан хүмүүсийн Улаанбаатар хотод нүүж ирэх зардлыг олгосон байна.

6. Мөн машин унаа хямдралтай үнээр худалдах, орон байр тэргүүн ээлжинд олгуулах, байрны нөхцөлийг сайжруулах, амралт сувилал, ахуй амьдралын элдэв хөнгөлөлтийг хоёр дайнд оролцсон ахмад дайчдын хэмжээнд эдлүүлэх зэргээр тал бүрийн дэмжлэг туслалцаа үзүүлж ирсэн байна.

7. 1990-1994 онд Шүүхийн шийдвэрээр МАХН-д 43 хүний холбогдолтой 1852698 төгрөгний хохирол барагдуулах нөхөн төлбөр тавьж, түүнийг намын хөрөнгөнөөс гаргасан юм. Энэ нь тухайн үеийн ханшаар 44215,5 ам.доллар болж байна. Мөн МАХН авто баазаас 3 хүнд суудлын авто машин хямдралтай үнээр худалдсан байна. Энэ хэлмэгдэлд өртсөн хүмүүсийн эд материалын гарз хохирлыг зохих хэмжээгээр барагдуулсан тухай ярьж байгаа болохоос биш, сэтгэл санаа, ёс суртахууны хохирол нь хэзээ ч нөхөгдөшгүй гэдгийг МАХН ойлгон, гүн хүндэтгэлтэйгээр хандаж байгаа билээ.

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс 1990 онд байгуулагдснаас хойш улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн нэр төрийг сэргээн цагаатгах, хэлмэгдэгсэд болон тэдний гэр бүл, үр хүүхэд, ач, зээ нарт хуульд заасан нөхөх олговор олгох, хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгах, хэлмэгдэгсдийн дурсгалыг мөнхжүүлэх, улс төрийн хэлмэгдүүлэлтийн хор уршгийг нийтэд таниулан сэрэмжлүүлэх ажлыг улс орны хэмжээнд зохион байгуулах гол чиг үүрэгтэй ажилладаг.

Тус комисс төрийн орон тооны бус байгууллага. Улсын комисс гишүүдээс бүрддэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн баталсан тус комиссын дүрэмд зааснаар Улсын комиссын дарга, нарийн бичгийн дарга, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга, Сангийн сайд, Улсын ерөнхий прокурор, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн, Тагнуулын ерөнхий газрын дарга, тус газрын Мөрдөн байцаах хэлтсийн дарга, Улсын комиссын Ажлын албаны Захиргаа, дүн шинжилгээний албаны дарга комиссын гишүүнээр ажилладаг. Орон тооны Ажлын албатай бөгөөд Улсын комиссын нарийн бичгийн дарга Ажлын албыг тэргүүлж, өдөр тутмын удирдлагаар хангаж ажилладаг.

Тус комисс хуульд заасны дагуу Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд ажлаа танилцуулж, удирдамж чиглэл авч ажилладаг бөгөөд Улсын комиссын ажлын тайланг 1995, 2000, 2014 онд хэлэлцэж

үүрэг чиглэл өгснийг хэрэгжүүлэн ажиллаж ирсэн юм.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн асуудлыг шалгах, цагаатгаж нэр төрийг сэргээх ажилд Улсын дээд шүүх, анхан шатны шүүхүүд, Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар гол үүрэг гүйцэтгэж байна.

Нийслэл, аймаг, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал салбар комиссын үүргийг гүйцэтгэдэг бөгөөд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нь салбар комиссын даргаар, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга нь салбар комиссын нарийн бичгийн даргаар ажилладаг.

Тагнуулын ерөнхий газрын бүрэн бус мэдээгээр 1922-1990 оны хооронд улс төрийн хилс хэрэгт 36,0 мянга орчим хүн хэлмэгдсэн гэгддэг бөгөөд 1939 оноос өнөөг хүртэл нийтдээ 31220 хүн цагаатгагдсаны 28256 нь Улсын комисс байгуулагдсанаас хойших хугацаанд цагаатгагджээ.

УИХ-аас 1998 онд “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай” хуулийг баталснаар цагаатгах ажлын эрч далайц нэмэгдэх, улс төрийн хэлмэгдүүлэлтийн хор уршгийг арилгах ажилд тодорхой ахиц дэвшил гарах эрх зүйн үндэс бүрдсэн юм. Уг хуулийн 13 дугаар зүйлд хэлмэгдэгчид болон тэдний гэр бүлийнхэнд нэг удаагийн нөхөх олговрын 500,000-аас 1 сая төгрөг, 23 дугаар зүйлд амьд сэрүүн байгаа хэлмэгдэгч болон нас барсан хэлмэгдэгчийн эхнэр (нөхөр)-т орон сууц олгох тухай заалт орсон нь хэлмэгдэгсэд болон тэдний гэр бүлийн амьдралд тус дэмтэй чухал шийдвэр болсон юм.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль мөрдөгдөж эхэлснээс хойш 19 жилийн хугацаанд уг хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгч, тэдний гэр бүл, ач, зээ 18,0 мянга гаруй иргэнд 16.4 тэрбум гаруй төгрөгийн нөхөх олговор, мөн хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу амьд сэрүүн байгаа хэлмэгдэгч, нас барсан хэлмэгдэгчийн эхнэр (нөхөр) 153 иргэнд орон сууц, 208 иргэнд орон сууц орлосон мөнгөн олговор 3,4 тэрбум төгрөгийн орон сууц болон түүнтэй дүйцүүлсэн буцалтгүй тусламж олгожээ.

Тус комисс хэлмэгдэгсдийн дурсгалыг мөнхжүүлэх талаар чамгүй ажил хийж иржээ. Монгол Улсын Их хурал 1996 онд жил бүрийн 9 дүгээр сарын 10-ны өдрийг улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр болгон орон даяар тэмдэглэж байхаар шийдвэрлэснээс хойш энэ жил 22 дахь удаагаа тэмдэглэх гэж байна.

Улаанбаатар хотын төв хэсэгт улс төрийн талаар хэлмэгдэгсдийн хөшөөг босгож:

Халуун итгэл цөхөрсөн

Хатан зүрх шархирсан

Хар дарсан жилүүдийг

Хамаг Монголчууд бүү мартагтун! гэсэн бичиг сийлжээ. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг мөнхжүүлэх зорилгын хүрээнд хэлмэгдэгсдийн намтрын 40 гаруй судалгааны товхимол, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн намтрын товчоон”, баримт бичгийн эмхэтгэл зэрэг 20 боть, 30378 хэлмэгдэгчийн мэдээллийг багтаасан улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалын “Цагаан ном”-ын I-IV ботийг хэвлүүлэн нийтийн хүртээл болгоод байна.

Улаанбаатар хот, орон нутагт хэлмэгдэгсдийн дурсгалд зориулсан нийт хөшөө 56, музей булан 45, нэрэмжит гудамж талбай, сургууль, байгууллага 66, суварга 114, гэрэлт самбар 28, дурсгалын багана 31 тус тус босгосон байна.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасан цагаатгуулах өргөдөл гаргах хугацаа 2011 оны 12 дугаар сарын 30-аар дуусгавар болсон тул шинээр өргөдөл хүлээж авах ажил зогсож, иргэд энэ чиглэлээр хүсэлтээ шийдвэрлүүлэх боломжгүй болсон юм. Ийм байдал өмнө нь гарч байсан учир хэлмэгдэгчдийг цагаатгуулах, нөхөх олговор нэхэмжлэх хугацааг УИХ-аас 2000, 2002, 2006, 2009 онд нийтдээ 4 удаа сунгаж байсан юм. Дээрх байдлыг үндэслэн УИХ-ын дэд дарга, Улсын комиссын дарга хуулийн үйлчлэх хугацааг сунгуулахаар “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж 2015 онд УИХ-д өргөн барьсан бөгөөд 2016 оны 6 дугаар сард холбогдох байнгын хорооны хуралдаанаас дэмжигдэж, УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэгдэх шатанд хүрээнд байна.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссоос 2017 онд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн цагаатгуулах өргөдөл гаргах хугацааг сунгах, нэмэлт нөхөх олговор олгох асуудлыг тусгасан хуулийн төслийг Засгийн газраас саналыг авч УИХ-ын Тамгын газарт хүргүүлж, өргөн барихад бэлэн болоод байна. Хууль батлагдан гарсанаар цагаатгалын тухай хуулийн үзэл санаа бүрэн хэрэгжих нөхцөл бүрдэх юм.

Цаашид цагаатгах ажлыг эрчимжүүлэх зорилгоор дараах чиглэлээр ажиллах боломжтой юм. Үүнд,

- Цагаатгалын ажлын хууль эрх зүйн үндсийг боловсронгуй болгох зорилгоор “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах,

тэдэнд нөхөх олговор олгох тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-д үндэслэгээ, нотолгоо сайтайгаар танилцуулж батлуулах,

- Хэлмэгдэгсэд, түүний үр хүүхэд, төрөл төрөгсдийг оюун санааны хохирлыг арилгах боломж хомс ч хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх, мөнхжүүлэх чиглэлээр дараах ажлыг зохиох. Үүнд:

а. Хөшөө, дурсгал байгуулах ажлыг үргэлжлүүлэн хийх, аймаг, хот, суурин газрын төв талбай юм уу, цэцэрлэгт хүрээлэнд хэлмэгдэгсдийн нэрсийг жагсаасан дурсан хүндэтгэх самбар байрлуулах,

б. Нэрэмжит газруудаас тухайн хүнийхээ дүр төрх, үйл ажиллагааг илтгэсэн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг өргөжүүлэх,

в. Телевиз, радио, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр түүхээс сурах, суралца, сургамж авах асуудлыг өргөн сурталчилах,

- Залуу идэр улс төрийн зүтгэлтнүүдэд тэвчихгүй, үл тэвчихгүй шүтэн барилдлагыг хангах ноён нуруу, хат суулгахын тулд түүхийн шинжлэх ухааны мэдлэг, түүхийн сургамжаас суралцах асуудлыг төр засаг, улс төрийн намууд анхааралдаа авах.

Цагаатгах ажлын сурталчилгааны цаашдын том гол зорилт бол өнгөрсөн үед түүхэн зүхлийн үүднээс биш түүхэн ухаарлын үүднээс хандах мэдрэмж ухамсарыг ард иргэддээ суулгах явдал юм.

### Дүгнэлт

1930-иад оны II хагасын нийгэм-сэтгэл зүйн уур амьсгалын тухайд яруу найрагч Дашзэвэгийн Банзрагч:

Гучаад оны шуурга хаяа хатавчаар исгэчнэ

Гунигийн бараан сүүдэр хар цайнд тунана

Гол харлуулсан бодолд цагаан гэр минь барайна

Гай зовлон нөмөргөсөн улаан Сталины сүүдэр

Лай ланчиг ихтэй Монгол цусыг минь хөргөнө

Хөрст газар хөрвөж байхад ч ийм гарз гараагүй

Хөвчин улс байлдаж байхад ч ийм гай дайраагүй хэмээн ончтой шүлэглэжээ.

Дээр дурдсан цухас төдий баримт сэлт, судлаач эрдэмтдийн гаргалгаанаас үзэхэд, бусармаг байдал газар авсаар 1930-1940-өөд онд Монголын нийгэм бүхэлдээ улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртжээ. Үүний цаад учир холбогдол нь:



- Хувьсгал хэмээх нийгмийн үзэгдлийн сөрөг үр дагавартай,
- Монголд өрнөсөн империализм, феодализмыг эсэргүүцсэн хувьсгалын үндсэн зорилттой,
- Их гүрнүүдийн, ялангуяа ЗХУ-ын геополитикийн орчин, зөрчил, ашиг сонирхолтой,
- 1920-1930-аад онд үүсэн бий болсон БНМАУ-ын гадаад, дотоод улс төрийн ээдрээтэй байдалтай,
- Түүхийн огцом эргэлтийн үед олон түмний дотор хүчтэй илэрдэг хэт хувьсгалчархах туйлшрах “өвчин”-тэй,
- Нам, төрийн удирдлагад байсан хүмүүсийн хувийн араншин, зан чанар, мэдлэг боловсролын түвшинтэй,
- Нэг хүнийг тахин шүтэх явдал, түүний нийгмийн сэтгэл зүйд үзүүлэх уршигт нөлөөтэй,
- Монголын ойрхи түүхийн янз бүрийн шатан дахь төр, намын роль, байр суурь зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой байв. Ингэхлээр Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлт нь үлэмж олон томоохон гадаад, дотоод хүчин зүйлүүдийн харилцан үйлчлэлийн интеграль үр дагавар болон гарч ирсэн нарийн түвэгтэй үзэгдэл байв. Эдгээр харилцан сүлжилдсэн хүчин зүйлийн дотроос их гүрнүүдийн, ялангуяа **ЗХУ-ын геополитикийн сонирхол нь хөтлөгч, тодорхойлогч хүчин зүйл** байлаа.

Хүмүүсийг үй олноор нь хомрогolon хэлмэгдүүлсэн нь ХХ зууны Монголын түүхэнд тохиолдсон хамгийн эмгэнэлт үйл явдал байлаа. 1990-ээд оны эхэнд Оросын Холбооны Улс, Монголд архивын сан хөмрөгийн нууцлаж байсан баримт сэлтийг тодорхой хэмжээгээр нээж өгсөн нь Монголын нам, төрийн зүтгэлтнүүдийг хэлмэгдүүлсэн үйл явцын цаад учир холбогдлыг илрүүлэн гаргах боломж олгосон юм. Өмнө өгүүлснээс үзэхэд, Монгол дахь залхаан цээрлүүлэлтийг гардан зохион байгуулагчид нь И.В.Сталин, түүний шадар гар хөл бологсод Г.Г.Ягода, Н.И.Ежов, Л.П.Берия, тэдний манайд илгээсэн эрлэгийн элч Блюмкин, Хичиков, Чибисов зэрэг “чекистүүд” байв. 1937 онд Сталины даалгавраар боловсруулсан ажлын арга маягийг манай зөвлөхүүд, чекистүүд бүх социалист оронд хэрэглэснийг би гэрчилнэ”<sup>5</sup> гэж Зөвлөлтийн нам, засгийн тэргүүн байсан Н.С.Хрущев дурсан бичжээ. Монгол дахь нийтээр хомрогolon хэлмэгдүүлэлт нь ЗХУ-д 1937-1938 онд хамгийн эрчтэй явагдсан улс төрийн хэлмэгдүүлэлтийн хуулбар байсан юм.

1993 онд Монгол Улс, Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч нарын хамтран гаргасан мэдэгдэлд: “Хуучин ЗСБНХУ, БНМАУ-д 30-

5 Н.С.Хрущев. Воспоминания.//Огонёк. 1989.№28.с.32

40-өөд онд гэм буруугүй олон хүний амь насыг бүрэлгэн, хоёр орны ард түмэнд сэтгэл санааны болон эд материалын асар их хохирол учруулж, үй олноор нь хомрогolon хэлмэгдүүлж байсанд хоёр улсын Ерөнхийлөгч нар гүнээ харамсаж байна.

БНМАУ-ын энэхүү хэлмэгдүүлэлт нь тэр үеийн Зөвлөлтийн удирдагчид, Коминтерний шууд даралт шахалтаар эхэлж, түүнд Зөвлөлтийн сургагч, зөвлөхүүд оролцож байсныг баримт хэрэглэгдэхүүн гэрчилж байна. Үүний улмаас Монголын ард түмэн туйлын хүнд хохирол үзсэн бөгөөд ялангуяа сэхээтний давхраа онцгой зүдүүр эдэлж, санваартан нар нийгмийн нэг хэсгийн хувьд хэрэг дээрээ устгагджээ. Монгол Улсын олон иргэн ЗСБНХУ-д хэлмэгдэн цаазлагдсан юм”<sup>6</sup> гэжээ.

Улс орныг бүхэлд нь нөмөрсөн залхаан цээрлүүлэлтээр Чингисийн алтан ургийн язгууртнуудын үндсийг тасалж, монголын нийгмийн оюун билгийн сор болсон цөм хэсгийг устгажээ. Энэхүү аймшигт хэлмэгдүүлэлт нь цагтаа дэлхийг донсолгож малгайчилж явсан монгол үндэстнийг доройтуулан эрхэндээ оруулах, яваандаа мөхөөх гэсэн хорон муу санаа, монголын нийгмийн оюунлиг давхраалам санваартнуудыг нийтэд нь устгах гэсэн геноцид үйл ажиллагаа, яс угсаа, элэг ургаа дагасан буриадуудад хилэгнэн хорсож аймаглан устгах гэсэн зөвлөлтийн удирдагчдын өширхөг үйлдэл байсан юм.

XX зууны эхний хагаст Монгол орон дэлхийн болоод бүс нутгийн нөлөө бүхий их гүрнүүдийн ашиг сонирхлын талбар болон хувирчээ. Юуны өмнө, БНМАУ-д газар зүйн байрлалын хувьд ЗХУ, Хятад, Японы геополитикийн сонирхол төвлөрч байв. Хятад Монгол руу хичнээн санаархавч, хувьсгалын давалгаанд автан хямарч, ЗХУ, Японд алхам алхмаар байраа тавьж өгч байв. 1930-аад оны үеэс Япон улс Ази, Номхон далайн бүс нутаг, ялангуяа Зүүн хойт Азид эрхшээл нөлөөгөө нэмэгдүүлэхэд чиглэгдсэн цэрэг-стратегийн бодлогоо илт идэвхжүүлжээ. Ийнхүү Монголын талаарх Японы ашиг сонирхол ЗХУ-ын ашиг сонирхолтой зөрчилдөх болов. ЗХУ-ын удирдагчид Монгол дахь байр сууриа бусармаг муу аргаар ч хамаагүй авч үлдэх нь чухал гэж үзэж байлаа. Их гүрэн бага буурай улс үндэсний эрх ашгийг уландаа гишгэдэг нь түүхэн жам ёсны үзэгдэл мэт явж ирсэн буурал түүхийн өнгөрсөн гашуун сургамжийг эрх тэгш олон улсын харилцааны цоо шинэ зарчмыг тунхаглаж байна хэмээн зарласан Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс ч аанай л дахин давтсан билээ. ЗХУ, Коминтерний удирдах зүтгэлтнүүд 800 мянгахан хүн амтай Монголд шинэ нийгэм байгуулах нь гол зорилт биш, газар нутаг нь л чухал гэдгээ өөр хоорондоо аминчлан ярьж, сэтгэл нийлж байлаа. Ингэхлээр Монголын удирдлагад хэн байх, гадаад орчиндоо ямар чиг шугам баримтлах нь ЗСБНХУ-ын хувьд амин чухал эрх ашгийн

6 “Ардын эрх” сонин. 1993.№13

асуудал байв. И.В.Сталин чухамхүү энэ эрх ашгийн үүднээс Монголын удирдагчдыг ЗХУ-ыг талархан дагагч, үл дагагч гэж хоёр хуваагаад үл дагагсдыг залхаан цээрлүүлэх замыг сонгон авсан юм. Үл дагагсдыг залхаан цээрлүүлэх ажлыг Монголд удирдах, зохион байгуулах гол түшиг тулгуур, өөрсдийнхөө бодлогыг үг дуугүй биелүүлж, аялдан дагалдагчийг эрж хайж туршсаны эцэст Х.Чойбалсанг сонгон авчээ. Их хэлмэгдүүлэлтийн буруутан нь монголын геополитикийн орчинд гарсан их хувьсгал, түүнд үндэслэсэн Оросын стратегийн сонирхол байсан боловч, Х.Чойбалсангийн хахир хатуу, хардамтгай зан авир ихээхэн нөлөөлжээ. Түүнчлэн тэр үеийн улс төрийн зүтгэлтнүүдийн доторх албан тушаал, эрх мэдлийн төлөө өрсөлдөөн, бие биетэйгээ барьцсан атгаг санаа, хүний мөсөө гээсэн олхиогүй зан авир нь үндэстэн даяараа улс төрийн залхаан цээрлүүлэлтэд өртөх шимтэй хөрс болсныг бас тэмдэглэх хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл, энэхүү харгис үйлдлэг нь их гүрнүүдийн бага буурайгаа дээрэлхэж ирсэн, “хүчитний дэргэд хүчгүй нь буруутай”-н сонгодог жишээ, түүнчлэн монголын нийгэм-улс төрийн амьдралд ардчилал нэвтрээгүйн балаг, хэт улс төржсөнөөс хүмүүсийн хооронд үл тэвчих уур амьсгал газар авсны харгай байсан юм.

“Ардын дайсан”, “Хувьсгалын эсэргүү”, “Японы тагнуул”-уудын ажил явуулга гэдэгт монголын ард иргэд эхлээд эргэлзэж тээнэгэлзэж байснаа 1939 онд Япончууд Монгол улсын дархан хил рүү халдаж, Халх голын дайн дэгдээснээр үнэхээр манайд Японы тагнуулын байгууллагатай холбоотой дайсагнагч бүлэглэл байж хэмээн итгэн, маршал Чойбалсанг маш зөв зүйтэй алхам хийсэн гэж үзэж, алсын хараатай, их жолоодогч гэж өргөмжлөн магтах болжээ. Ийнхүү түүний ял нь гавьяа болон хувирах таатай нөхцөл бүрэлдсэн байна.

1940-өөд оны сүүлч 1950-иад оноос балмадаар хэлмэгдүүлэн залхаан цээрлүүлэх, олноор алан хядах явдал зогссон авч, хүмүүсийг “сэхээтний төөрөгдөл”, “намын эсрэг явуулга”, “үндсэрхэх, үгүйсгэх үзэл үзэлтэн”, “намын эсрэг бүлэг” гэх мэтээр улс төр-үзэл суртлын талаар дарамтлан насаар нь мөрдөн хавчиж, “амьдын там”-д унагах бусармаг аргад шилжсэн юм.

## “ХЯТАДЫН СОЁЛЫН ХУВЬСГАЛЫН ҮЕД ХЯТАДЫН ЗАСГИЙН ГАЗРААС ЯВУУЛСАН МОНГОЛЧУУДЫН ГЕНОЦИД” (1966-1976 ОН)



*Акира Оно  
Доктор (Ph.D), Профессор  
Япон улс, Шизуока их сургууль*

1966 онд Хятадын Соёлын Их Хувьсгал гарах үед Өвөр Монголын өөртөө засах оронд амьдарч байсан Монгол хүмүүсийн тоо 1.5 сая хүрэхтэй үгүйтэй байсан бол тэнд амьдардаг Хятад хүмүүсийн тоо Монгол хүмүүсийн тооноос 9 дахин их байв. Монгол хүн өөрийн эх нутагтаа цөөнх болсноос гадна Монгол үндэстнийг тэр чигт нь хавчин гадуурхаж, хэлмэгдүүлж байсан цаг үе юм. Тэр үед 346,000 Монгол хүнийг баривчилснаас 27900-г цаазаар аваачсан бөгөөд ойролцоогоор 120000 хүнийг эрэмдэг зэрэмдэг болгосон гэдэг. Дээрх нь Хятадын Засгийн Газраас зарласан тоо боловч бодит байдал дээр илүү аймшигтай байсан гэдэгт итгэлтэй байна. Гэхдээ энэ албан ёсны тоо баримтад үндэслэн тооцоолоход л Соёлын Хувьсгалын үеэр Монгол айл бүрээс дор хаяж нэг хүн баривчлагдаж байсан гэсэн үг болно.

### **1. Монгол үндэстнийг аймаглан устгах их хядлагын хэдэн арван жилийн нуугдмал түүх**

Хятадын Засгийн Газар болон Хятад хүмүүсийн гарт үрэгдсэн Монгол хүмүүсийн тоог хэд хэдэн янзаар тооцоолон гаргасан байдаг.

1981 онд ӨМӨЗО-ы Намын Нарийн Бичгийн Дарга байсан Жоу Хуйн (周惠) тооцоолсноор нийт 790,000 Монгол хүнийг албадан саатуулж, мөрдөн байцаасан байна. ӨМӨЗО-ы Коммунист Намын Хорооны Тамгын Газраас гаргасан 1989 оны статистикаас үзвэл нийт хохирогчдын тоо 480,000-д хүрч байна. (Алтандэлхий 1999:85). Энэ тал дээр гадны орнуудын эрдэмтэн судлаачдын хийсэн бие даасан судалгаануудаас үзвэл хагас сая орчим Монгол хүн баривчлагдаж үүнээс 100 000 орчим нь амь үрэгдсэн байна. (Жановойка 1988: 276,

Снийт 1994: 422). Сүүлд ӨМӨЗО-ы нэгэн сэтгүүлч өөрийн номондоо энэ талаар дурдахдаа баривчилгааны үеэр газар дээрээ амь үрэгдсэн болон ачилт, байцаалт болон шоронд хоригдож байх үедээ, мөн түүнчлэн суллагдан харих замдаа амиа алдсан нийт хохирогчдын тоо 300 000 хүрсэн гэж бичжээ. (Шаравжамц 2006: 44). Энэ бол Хятад улсад Монгол үндэстний эсрэг үйлдэгдсэн маш аймшигтай харгислал байсан бөгөөд Хятадын болон Дэлхийн орчин үеийн түүхэнд том хар толбо үлдээсэн явдал яахын аргагүй мөн билээ. Энэ аймшигт түүхэн үйл явдлын амьд гэрч болсон Монгол хүмүүс энэ явдлыг “Хятадын Коммунист нам (ХКН) болон Хятад үндэстний үйлдсэн Монгол үндэстнийг аймаглан устгах их хядлага” гэж нэрлэх хэрэгтэй гэж үздэг (Ян 2008a: 419-453; 2009a: 2009b; 2009c: 2010a).

Үнэнийг хэлэхэд хэлмэгдэлтэд өртөж амиа алдсан нийт Монгол хүмүүсийн үнэн бодит тоо хараахан тодорхой бус байгаа юм. Эцсийн байдлаар Соёлын Хувьсгалын үеийн хохирогчдын тоо тодорхой болоогүй ч энэ үйл явдал нь яахын аргагүй Аймаглан устгах их хядлага байсан гэдэгтэй Монгол хүмүүс санал нийлж байна. Уг явдлал нь Социалист Югослав улсыг задрах үед Зүүн Европт гарсан “үндэстний цэвэрлэгээ”-с шинж чанарын хувьд эрс ялгаатай. Югославын задрал нь угсаатан угсаатныхаа эсрэг тулалдаж байсан аймшигт дайны үр дагавар байсан юм. ӨМӨЗО-ы хядлага нь Хятадын төр, ард түмэн Монгол үндэстний эсрэг нэг талаас дагнан үйлдсэн гэмт хэрэг гэдгээрээ Зүүн Европын хэргээс ялгаатай. Энэ нь л Монгол үндэстнийг аймаглан устгах их хядлагын гол онцлог болоод байгаа юм. “БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах оронд гарсан Их Соёлын Хувьсгал” гэхийн оронд Өвөр Монголын Монголчууд “Өвөр Монголын өөртөө засах оронд хийсэн Хятадын Соёлын Их Хувьсгал” гэж ярьдаг.

Хэдийгээр ӨМӨЗО нь Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-н нутаг дэвсгэрт харьяалагддаг ч Өвөр Монголыг 1949 онд БНХАУ-д нэгтгэснийг “саяхны” үйл явдал гэж хэлж болно. Өвөр Монголыг хүчээр Хятадад нэгтгэснээр иргэд нь “Хятадын Монгол Үндэстэн” болж хувирсан. Тэдгээрийн эсрэг л энэхүү аймшигт хядлагын гэмт хэрэг үйлдэгдсэн бөгөөд үүнийг Монгол судлалын бүх эрдэмтэд ойлгож хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

### **Монгол үндэстнийг аймаглан устгах их хядлагын шинж чанар**

1966 оны 05 сарын 16-ны өдөр Хятадын Коммунист нам (ХКН)-р толгойлуулсан Их Соёлын Хувьсгал эхэлсэн ба ӨМӨЗО-д хийх “хувьсгалыг” эхлүүлэх тушаалыг Мао Зедун өөрөө гаргасан байна. Ийнхүү 1967 оны төгсгөлөөс эхлэн 1976 оны намар хүртэл “Өвөр Монголын Ардын Хувьсгалт Нам”-тай үгсэн хуйвалдсан гэх шалтгаанаар Өвөр Монголын маш олон Монгол хүмүүсийг баривчилж хэлмэгдүүлсэн байдаг. Ийнхүү үй олноор нь баривчлах шалтгаан нь

“Өвөр Монголын Ардын Хувьсгалт Нам нь Өвөр Монголыг Агуу Хятадаас салган тусгаарлах хуйвалдаан зохион байгуулж байгаа” гэсэн сэрдлэг байсан ба тус хуйвалдааны талаар албан ёсоор мэдэгдсэнээр цуст хядлага эхэлсэн түүхтэй.

Аймаглан устгах их хядлага гэдгээр юуг илэрхийлдэг вэ? 1948 оны 12 сарын 09-ний өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблей “Аймаглан устгах их хядлагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шийтгэх тухай” Конвенцийг баталсан байна. Доор тус Конвенцийн 2-р зүйлийг иш татав. (Л.Купер 1986: 14-15):

Тус Конвенцийн 2-р зүйлд “аймаглан устгах их хядлага” гэдэг нь аливаа үндэстэн, угсаатан, арьс өнгө эсвэл шашны бүлгийг бүтнээр нь эсвэл хэсэгчлэн устгах зорилготой дараах үйлдлүүдийг хэлнэ. Үүнд:

- (a) Тухайн бүлгийн гишүүдийг алах;
- (b) Бүлгийн гишүүдэд биеийн болон сэтгэл санааны хүнд гэмтэл учруулах;
- (c) Санаатайгаар тухайн бүлэг хүмүүст бие махбодийн бүрэн болон хэсэгчилсэн гэмтэл бэртэл учруулахуйц амьдралын нөхцөл байдлыг үүсгэх;
- (d) Тухайн бүлэг хүмүүсийн төрөлтөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
- (e) Тухайн бүлгийн хүмүүсийн хүүхдүүдийг хүчээр өөр бүлэгт шилжүүлэх.

Хядлага нь зөвхөн Монгол үндэстний аллагаар тогтоогүй бөгөөд 1969 оны 07 сарын 05-ны өдөр Хятадтай хиллэх Хятадын болон Лалын (муслим) Хошуу аймгуудад буюу Өвөр Монголын Зүүн талд 3 Холбоо, Баруун талд 3 Аймаг, Зүүн талд 3 Хошуу аймаг байгуулсан. (Газрын Зураг 1, 2. Өвөр Монголын өөртөө засах орон, 1969-1979). Энэ нь “зэрлэг бүдүүлэг Монголчуудыг” “салган бутаргаж, эзлэн түрэмгийлэх” бодлогын хэрэгжилт юм. 1979 оноос хойш л эдгээр газар нутгуудыг буцаан Монголтой нэгтгэсэн байдаг.

Монгол хүмүүс аймшигт хэрцгий хядлагын хохирогч болоод зогсохгүй өөрсдийн үе удмаараа эцэг өвгөдөөсөө уламжлан авсан газар нутгаа алдсан юм. БНХАУ болон Бүгд Найрамдах Монгол Ард Улс (өнөөгийн Монгол Улс)-н хил орчмоор амьдардаг байсан хүмүүсийг албадан нүүлгэн шилжүүлж алслагдсан нутаг орон руу цөлсөн байдаг. Энэ явдал гэнэтхэн болсон бөгөөд иргэдэд өмч хөрөнгөө авах боломж ч олгоггүй үл таних, харийн бөгөөд амьдрахад нэн тохиромжгүй нөхцөлтэй нутаг руу нүүлгэсэн бөгөөд ийнхүү нүүлгэн шилжүүлэх явцад маш олон Монгол хүн амь насаа эмгэнэлтэйгээр алдсан.

Хэлмэгдүүлэлт үүгээр хязгаарлагдсангүй. Монгол үндэстний соёл ч хядлагаас хэлтэрсэнгүй. Сүм дугануудыг нураан сүйтгэж, Монгол хэлээ хэрэглэхийг нь хүртэл хориглож, Монгол хэл дээр хичээл зааж байсан сургуулиудыг хаасан байна. Үүгээр үл барам, Монгол хүмүүсийг өөрсдийн нэрнээс татгалзаж Хятад үндэстэн болохыг хүчээр тулгасан. Зохиолч би ч мөн адил Монгол хүн атал Соёлын Хувьсгалын хүнд хэцүү цаг үеийг эсэн мэнд туулах гэж Хятад нэртэй болсон билээ. (Зураг 1, Хятадын эрхшээл дэх Өвөр Монгол).

Улсын хэмжээнд зохион байгуулалттай хийгдэж буй колоничлол эсвэл үндэстний цэвэрлэгээний үеэр хохирогчид бэлгийн хүчирхийлэлд өртөх нь элбэг. Өвөр Монголд Соёлын Хувьсгал ид хүчээ авч байх тэр цаг үед нутгийн маш олон эмэгтэйчүүдийг Хятад эрчүүд хүчирхийлж бэлгийн хүчирхийлэлд автуулсан. Тэр үед маш олон Монгол эмэгтэй энэхүү төрийн зохион байгуулалттай бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн золиос болсон. (Ян 2013a:32-37; 2013b: 95-103) Нүүдэлчин ард түмний эмэгтэйчүүд ийм аймшигтай харгис бэлгийн хүчирхийлэлд өртсөн явдал нь түүхэнд байгаагүй гутамшигтай үйл явдал бөгөөд Хойд болон Төв Азийн нүүдэлчин соёлтой ард түмний дунд анх удаа тохиосон харгислал гэж хэлэхэд хилсдэхгүй.

Хятадын Коммунист Нам (ХКН)-н үйлдсэн Монгол үндэстнийг аймаглан устгах их хядлага гэдэг нь үнэндээ үй олноор алж устгах, хүчээр албадан нүүлгэн шилжүүлэх, үндэстний соёлыг устгах, бэлгийн хүчирхийлэл болон бусад аймшигтай гэмт хэргүүдийг нэгтгэл юм. НҮБ-ын “Аймаглан устгах их хядлагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шийтгэх тухай” Конвенцид тусгайлан тодотгож заасан гэмт хэргүүд юм. Хятадад болсон Монгол үндэстнийг аймаглан устгах их хядлагыг нарийвчлан авч үзвэл хүн төрөлхтний туулж өнгөрүүлсэн XX зууны түүхийг илүү тодорхой ойлгох боломжтой болно.

## **2. Монгол үндэстнийг аймаглан устгах их хядлагын шалтгаан Алтандэлхийн ижилгүй гайхалтай бичмэлүүд**

Юуны түрүүнд Алтандэлхий хэмээх монгол зохиолчийн судалгааны ажилтай та бүхнийг танилцуулахыг хүсч байна. Алтандэлхий Өвөр Монголын зүүн аймагт төрсөн бөгөөд Хувьсгалын үеэр Өвөр Монголын Ардын Хувьсгалт Нам (ӨМАХН)-н гишүүн болсон гэсэн шалтгаанаар баривчлагдаж, угсаа нэгт Монгол ахан дүүсээ харгисаар тамлуулж амиа алдаж байхыг өөрийн нүдээр харсан хүн юм. Аз таарч тэрээр цаазаас мултарч Хувьсгалын аймшигт үеийг эсэн мэнд даван туулж чадсан юм. Сүүлд тэрээр “Өргөдлийн Алба” гэдэг Засгийн Газрын Агентлагт төрийн албан хаагч болсон бөгөөд Засгийн Газарт шууд өргөдөл гомдол гаргагсдын “*Shangfang Renyun* (上訪人員)” өргөдлийг хүлээн авч зохицуулах ажлыг гүйцэтгэж



байв. Өргөдөл гаргагсад нь Өргөдлийн Албанд өөрийн биеэр ирж өргөдөл гомдлоо гаргадаг байсан. Энэ өргөдлийн систем нь хуулинд суурилаггүй боловч удаан хугацаанд Хятадын улс төрийн онцлог шинж чанаруудын нэг байсан бөгөөд “ард түмний удирдлагатай улс” гэдэг ойлголтод суурилдаг байлаа.

Соёлын Хувьсгалын сүүлийн хагаст Алтандэлхий тус агентлагт ажилд орж Монгол хүмүүсийн өргөдөл гомдлыг өдөр бүр шахуу сонсдог байсан байна. Өргөдөл гомдол гаргагч нь нэг бол хохирогч өөрөө нэг бол хохирогчийн ар гэрийнхэн байдаг байв. Тэд өргөдөлдөө хэрхэн хохирсон талаараа дэлгэрэнгүй мэдээлэл өгч ХКН-с өршөөн нигүүлсэж тэдгээрийн зовлон зүдүүрийг шийдвэрлэж өгөхийг хүснэ. Эдгээр хөөрхийлөлтэй хохирогчдод ингээд өөрийн биеэр ирж зовлонгоо тоочиж өргөдөл гомдол гаргахаас өөр арга байсангүй.

ХКН Соёлын Хувьсгалыг болсон гэдгийг эрс үгүйсгэдэг. Хувьсгалтай холбоотой аливаа баримт сэлтийг нэг бүрчлэн устгах тушаалыг ар араас нь гарган мөрдүүлж байсан. Энэ Хувьсгал нь орчин үеийн Хятад орны нэр хүндэд айхтар сэв суулгах үйлдэл болсон гэдгийг ХКН-н удирдагч нар ойлгож тэр үед болсон бүх үйл явдлыг түүхийн хуудаснаас арчин хаяхаар мэрийн ажилласаар ирсэн. Өргөдлийн Албанд ажиллаж байхдаа болсон явдлын ул мөрийг устгаж байгааг Алтандэлхий олж мэдсэн байдаг. Ийнхүү тэрээр өөрийн бололцооны хирээр баримт сэлтийг олж хамгаалахаар ажиллаж эхэлсэн. Өөрт нь ирсэн хохирогчдын өргөдөл гомдлыг авч хадгалж, Соёлын Хувьсгалтай холбоотой аливаа баримт бичгүүд тэр дундаа засгийн газрын тушаал, архивын баримт, цэргийн дарга нарын лекцүүдийн текст буюу бичмэлүүдийг цуглуулж хадгалахаар мэрийн ажилласан. 1999 онд Алтандэлхий өөрийн цуглуулсан баримтууд дээрээ үндэслэн “Өвөр Монголын Ардын Хувьсгалт Нам (ӨМАХН, 內蒙古挖肅実録)-н гишүүдийг олж илрүүлэн, алж хядах улс төрийн ажиллагааны хохирогч нарын баримтууд” нэртэй судалгааны ажлаа хэвлүүлсэн юм.

Хятадын засгийн газар Алтандэлхийд судалгааны ажлаа хэвлэхэд нь саад болох үүднээс улсаас хүлээн зөвшөөрөгдсөн хэвлэлийн кампаниудаар хэвлүүлэх зөвшөөрөл өгсөнгүй. Гиймээс Алтандэлхий номоо хувиараа хэвлүүлсэн юм. Өвөр Монголын өөртөө засах орон (ӨМӨЗО)-ы засгийн газар түүнийг байнгын хараа хяналтан дор байлгах хүмүүсийн жагсаалтад оруулж номоо хэвлүүлж Монгол хүмүүст түгээн дэлгэрүүлэхгүй байлгах үүднээс бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлсэн боловч Алтандэлхийн ном олны хүртээл болж маш олон хүн уншсан юм.

### Өвөр Монголын Ардын Хувьсгалт Нам (ӨМАХН)-н түүх

13-р зуунд нүүдэлчин Монголчуудын сэргэн мандалтын үе байсан ба энэ үед л Евразийн Эх Газрын ихэнх хэсгийг эзэлсэн Монголын Юань Гүрэн гэх хүчирхэг Эзэнт Гүрэн байгуулагдсан. Монголын Эзэнт Гүрэн өргөжин тэлэхийн хирээр Хятадын газар нутгийг эзэлж улмаар Юань Гүрэн байгуулагдсан юм. 14-р зууны үеэр Жу Юаньжан гэх хятад босогч жанжин Юань Гүрний эсрэг бослого дэгдээж Монголчуудыг Цагаан Хэрэмнээс хойш хөөн гаргажээ. Жу Юаньжан нь Хятадад арай бага нутаг дэвсгэртэй Мин Гүрнийг байгуулсан. Хэдэн зуун жилийн дараа буюу 17-р зуунд хойд зүгийн Манжууд цэргийн хүчээр Хятадын бүс нутгийг тэр чигт нь эзлэн авсан. Хятадын газар нутаг Манжуудад эзлэгдэхэд Монголчууд үг дуугүй хүлээн зөвшөөрсөн бөгөөд энэ цагаас эхлэн Монгол, Манжийн найрсаг харилцаа бий болсон. 1636 онд Говийн өмнөд хэсгийн Монголчуудыг Манж эзэлж тэр нь явсаар өнөөгийн “ӨМӨЗО” үүсгэн байгуулагдах үндэс тавигдсан гэж үздэг. Хятадын Засгийн Газар Өвөр Монголын нутаг дэвсгэрийг Аймаг, Хошуудад хуваан шинэ засаг захиргааны нэгж байгуулсан. Үүний гол зорилго нь Монголын овог аймгуудыг хооронд нь холбоо харилцаагүй болгож нэгдмэл байдлыг устгах явдал байсан юм.

Чин Гүрэн үүсгэн байгуулагдаад удаагүй байх үед төр засаг Хятад тариаланчдыг Монголын тал нутаг руу нүүдэллэхийг эрс хориглосон байдаг. 19-р зуунд Чин Гүрэн нуран унах нь тодорхой болж барууны хүч Хятадыг эзлэн түрэмгийлж эхлэв. Чин Гүрэн эрх мэдлээ алдахын хирээр Хятад тариаланчдыг Монголын тал нутаг руу нүүдэллэхийг хориглож дийлэхгүй болсон. Тухайн үеийн төр засагт дургүй байсан олон тооны хятад хүмүүс Өвөр Монголын тал нутаг руу нүүдэллэн очиж сууршижээ. Тэд их хэмжээний тал хээр буюу бэлчээрийг тариалангийн талбай болгон өөрчилж боловсруулж улмаар тус нутагт цөлжилт хүчтэй явагдаж эхэлж улмаар Хятад болон Монгол хүмүүсийн хоорондын зөрчил улам гүнзгийрсэн.

1891 онд Хятадад “Жиндандао”(金丹道) нэртэй Хувьсгал гарсан. Жиндандао гэдэг нь Ян Юуэчунь гэдэг хүнээр толгойлуулсан Хятадын нууц нийгэмлэг юм. Ян өөрийгөө “*saobei wushengren*” буюу “хойд нутгаас бүх Монголчуудыг хөөж зайлуулах зоригт нэгэн” гэж нэрлэдэг байжээ. Жиндандаогийн гишүүд нь Өвөр Монголын зүүн өмнөдөд байрладаг Зост, Зуу Уд Аймагууд руу хэд хэдэн газарт халдаж хядлага үйлдсэн. Ян Юуэчунь Хятад хүмүүсийг “Монгол, Манжуудыг алж Чин Гүрнийг устгая” эсвэл “Монголчуудыг алж газар нутгийг нь эзлэе” уриан дор нэгтгэж аллага үйлдэж байсан. Энэ бослого нь Монгол хүмүүсийн зүрхэнд айдас хуруулж нийгэмд нөхөж баршгүй хохирол учруулсан юм.

20-р зуунд Сун Ят-Сэн гэгч Жиндандаотой ойролцоо утгатай уриан дор өөрийн улс төрийн хөдөлгөөнийг эхлүүлсэн байдаг. Тэрээр Бүгд Найрамдах Хятад Улсыг 1912 онд үүсгэн байгуулж “Монгол хүмүүсийг хөөн зайлуулж Хятадыг сэргээн мандуулья” хэмээн уриалж эхлэв. Тэрээр Мин Гүрний анхны Эзэн Хаан Жу Юаньжанаас үлгэр жишээ авдаг байсан ба нийслэл хотоо Наньжинд байгуулсан. Энэ үеэр Ар Монголчууд Манжийн дарлалаас гарахаар шийдэж Ар Монголын 8-р Богд Жавзандамба Хутагт бүх Монголчуудыг нэгдэхийг уриалсан байдаг. Тэрээр монголын олон овог аймгуудыг “нэгдэж Хятадуудад түрэмгийллээс ангижрая” хэмээн уриалж эхэлсэн. Жавзандамба Хутагт Монголчууддаа зориулсан хэд хэдэн сургаалиа түгээн дэлгэрүүлж Хятадын эзлэн түрэмгийллийг сөрөн зогсохыг уриалж зоригжуулж байв.

Монголчууд өөрсдийн тусгаар тогтносон улсыг байгуулахад Жавзандамба Хутагт Богд Хаан болсон. Өвөр Монголын олон овог аймгууд тусгаар тогтнохыг хүссэн ч тэдгээрийг Хятадын цэргийн хүчээр дарангуйлсан. Өвөр Монголын салан тусгаарлагч хөдөлгөөнүүдийн нэгийг Харчин хошууны Жүн Ван Гүнсээноров гэгч тэргүүлж байв. Түүнийг баривчилж Бээжинд хэсэг хугацаагаар хорьсны эцэст суллан явуулсан байдаг. Суллагдсаныхаа дараа түүнийг Монгол, Төвдийн Хэрэг Эрхлэх Хорооны Ерөнхий Нарийн Бичгийн Даргын ямар ч эрх мэдэлгүй албан тушаалд томилов. Жүн Ван Гүнсээноровыг толгойлогч манлайлагчийн байр сууринаас түлхэн унагасан нь салан тусгаарлагч хөдөлгөөнийг хүчгүйдүүлсэн гэхэд болно. Монголын овог аймгууд бага багаар Бүгд Найрамдах Хятад Улсын “улс төрийн байгууллага, механизмуудад” эзлэгдсэн.

1921 онд Оросод Октябрийн Хувьсгал гарсан нь Ар Монголын эрх чөлөөний төлөөх хөдөлгөөнд шинэ цог нэмж сэргээсэн. Тус хөдөлгөөн шинээр хүчээ авсан явдал нь Өвөр Монголын сэхээтнүүдэд их урам зориг өгсөн. Хятадад Сун Ят-Сэн үндэстний цөөнхийн талаарх өөрийн улс төрийн хандлагаа өөрчилж Коминтерн (Коммунист Интернациональ)-д долигонож эхэлсэн. Тэрээр “Хятадын үндэстний цөөнхүүдэд үзэл бодлоо иэлрхийлэх эрх олгох хэрэгтэй” хэмээн зарлав. Шинэ нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан Монголын улс төрч Ба Ян Тай(白雲梯) Харчин хошууны Цэрэндонров болон түүний нөхөдтэй нийлж “ӨМӨЗО-н Ардын Хувьсгалт Нам (ӨМАХН)” нэртэй улс төрийн намыг байгуулсан. Ба Ян Тай Гүнсээноровын үүсгэн байгуулсан Бээжин дэх Монгол, Төвдийн Сургуулийг төгссөн байна. Өвөр Монголын өнцөг булан бүрийн сэхээтэн залуучууд энэ сургуулийг төгссөн байдаг. 1925 оны 10 сард Ба Ян Тай Монголын сэхээтнүүдийг Цагаан Хэрэмний хажууд байрлах Жан Жиа Коу (Калган) тосгонд дуудан цуглуулж улс төрийн уулзалт зохион байгуулсан. Тус уулзалтыг ӨМАХН-н Намын Нэг Дүгээр Хурал гэж

нэрлэсэн. Тус хуралд Коминтерн болон Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ)-н төлөөлөгч нар оролцсон байдаг. Баянтай, Алтаночир, Энхбүрэн, Идээчин, Мэдэлт, Мэрсэ, Сайнбаяр (包悦卿) гэх мэт хэсэг залуучуудыг ӨМАХН-ын Төв Хорооны гишүүдээр сонгогдож, империализм, феодализм болон Хан үндэстний шовинизмын эсрэг гэсэн үндсэн зарчим бүхий намын тунхаглалаа бичсэн байна.

1929 онд Төмөрбагана, Пунцаг болон тухайн үед Москвад байсан Өлзийочир нар Өвөр Монголын зүүн аймаг рүү эргэн ирж ӨМАХН-нд шинэ гишүүд элсүүлж эхэлсэн ба энэ үеэр ирээдүйн шилдэг удирдагч нарын төлөөлөл болсон Хаванга (Хаафунгаа/, Асган гэсэн залуучуудыг элсүүлжээ. Анхандаа Японы армийн эсрэг цэрэг хөдөлгөхөөр төлөвлөж байсан ч Коминтернийн дэмжлэг байгаагүйн улмаас тус төлөвлөгөө цуцлагджээ. 1936–с 1941 онуудад ӨМАХН-н удирдагч нарын нэг Төмөрбаганыг Японы эсрэг улс төрийн хөдөлгөөн өрнүүлсэн хэмээн сэжиглэж баривчилсан ч Хафанга түүнийг удаа дараа аварсан байдаг. Хаванга Японы хүүхэлдэй улс Манж-год Японы элчин сайдын яаманд ажилладаг байсан. Төмөрбагана аюулд орох бүрт Хаванга Өвөр Монголд эргэн ирж түүнийг авардаг байв. Коминтернийн ч зарим агентууд Японы армид сэжиглэгдэж аюулд ороход Хаванга мөн л аварч байсан.

Нөгөө талаар Өвөр Монголын Дэ Ван Дэмчигдонров (Дэ Ван, 1900-1966, 德王) Монголын Армийн 9-р дивизийг даргалж байсан. Энд ӨМАХН-ын шилдэг гишүүд болох Билигбаатар болон Өлзий-Очир нар байсан ба тэд Хафанга, Асган болон бусадтайгаа байнгын холбоо харилцаатай байдаг байв. Сайнбаяр, Дэлгэр болон бусад гишүүд Коминтернтэй холбоотой ажиллах үүрэгтэй байлаа. Японы арми Хятад руу цөмрөн орохын хирээр Өвөр Монголын баруун хэсэг Манж-год дагаар орох үед өсөж торниж байсан сэхээтэн залуучууд сүүлд Өвөр Монголын салан тусгаарлах хөдөлгөөний үндэс суурь болж Монгол угсаатнуудын эрх чөлөөний төлөө тэмцэгчид болсон.

1945 оны хавар ӨМАХН-ын ахлах удирдагч нарын нэг Пунцаг Өвөр Монголд эргэж ирсэн. Түүнд ЗХУ болон Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ)-ын цэргийн хүчний дэмжлэг байв. Тэр үед Хафанга, Төмөрбагана нар удирдлагын байр сууринд очоод байсан бөгөөд Монголчууд тэднийг хүчтэй дэмжиж байсан. 1945 оны 08 сарын 18-нд Хафанга, Төмөрбагана, Пунцаг нар хэсэг нөхдийн хамтаар ӨМАХН-ыг шинэчилж байгууллаа. Хафанга намын нөхдийн хамтаар “Өвөр Монголыг Чөлөөлөх Тунхаглалыг” бичсэний зүйл заалтуудыг (Ян 2010а: 520-521) доор жагсаав. Үүнд:

1. Өвөр Монгол Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ)-д нэгдэж харин БНМАУ нь ЗХУ-н хамтаар Өвөр Монголд тус дэмжлэг үзүүлнэ.

2. Өвөр Монголыг Чөлөөлөх Арми Зөвлөлт Холбоот Улсын армитай хамт Японы эзлэн түрэмгийлэгчдийн эсрэг тэмцэж газар нутгаасаа хөөн гаргана.
3. Феодализмыг эсэргүүцэх үндэслэл ул суурьтай арга хэмжээ авч хүн ардаа чөлөөлж капитализмын эсрэг дараа дараачийн арга хэмжээг авч ажиллана.
4. Угсаа гарлаар гадуурхан дээрэлхэхийг зогсоож нутаг дэвсгэртээ амьдарч буй үндэстний цөөнх бүлгүүдийг ялгаварлан гадуурхахгүй. Мөн түүнчлэн Хятадын ард түмнийг чөлөөлөх хөдөлгөөнд туслалцаа үзүүлнэ. ӨМАХН болон Хятадын хувьсгалт намуудтай хамтын ажиллагааны харилцаа тогтоох нь.

Цаашлаад ӨМАХН Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ)-ын хамгийн хүчирхэг хоёр удирдагч болох Х.Чойбалсан болон Ю.Цэдэнбал нарт дараах захидлыг илгээж байжээ. (Ян 2010а: 521-522)

Өвөр Монголын иргэд хувьсгалт тэмцэл хийхээр олон арван жилийн оролдлого хийж байгаа бөгөөд энэ удаад Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ) болон Зөвлөлт Холбоот Улсын (ЗХУ) тусламж дэмжлэгийг авна гэдэгт найдаж байна. Өвөр Монгол дахь манай хоёр сая Монгол ахан дүүс БНМАУ буюу өөрсдийн эх орондоо буцан нэгдэнэ гэдэгт чин зүрхний угаас итгэж найджаж байна. Бүх Монгол хүмүүс нэгэн тугийн дор нэгдэх цаг иржээ.

Та Бүхнийг Хүндэтгэсэн,

Ерөнхий нарийн бичгийн дарга: Хафанга

Гүйцэтгэх Хороо: Буянмандах, Төмөрбагана, Сагалжав, Оюундалай, Оюунбилиг, Асган, Элдэнтэй, Найралт, Зонхов, Лхамжав, Санжайжав, Ванда

Өвөр Монголын Ардын Хувьсгалт Нам (ӨМАХН), Зүүн Монгол Намын Тойрог

1945 оны 08 сарын 18

Дээрх явдлаас шалтгаалан Өвөр Монголын баруун Монголчууд “Бүгд Найрамдах Өвөр Монгол Улсын Түр Засгийн Газар” байгуулах тухайгаа зарлав. Эдгээр асуудлууд нь Америкийн Нэгдсэн Улсын анхааралд өртөж Сталинаас Монголд юу болоод байгааг лавлажээ. Ингээд Сталин анх удаагаа Маршал Чойбалсан болон БНМАУ-н бусад удирдагч нарт “Ялтын гэрээ” байдаг тухай ил болгосон байна.

Ингээд зүүн Монгол болон баруун Монголын “Бүгд Найрамдах Өвөр Монгол Улсын Түр Засгийн Газар”-с төлөөлөгчдийг Улаанбаатар хотод хүрэлцэн ирэхийг урьж Төлөөлөгчидтэй уулзахдаа Чойбалсан дараах тодорхой заалтуудаар мэдэгдэл хийв:

1. БНМАУ үүсгэн байгуулагдаж олон улсад хүлээн зөвшөөрөгдөөд удаагүй байна. Энэ шалтгаанаар Ар болон Өвөр Монголыг Нэгтгэхэд маш хэцүү байх болно. Тиймээс Өвөр Монголчууддаа Хятадын Коммунист Намтай (ХКН) харилцаагаа сайжруулах арга хэмжээ авах нь зүйтэй гэж зөвлөж байна.
2. ӨМАХН-н дотоод бүтэц зохион байгуулалт их ярвигтай юм байна. Энэ нь Өвөр Монголд хувьсгал удирдан зохион байгуулахад нэн хэцүү болгоно гэж бодож байна.
3. Өвөр Монголын ангийн ялгаврыг арилгах тал дээр та бүхэн санаа тавьж ажиллах нь зүйтэй.

Чойбалсан болон БНМАУ-ын улс төрийн удирдагч нар ийм зөвлөгөө өгсөний учир “Бүгд Найрамдах Өвөр Монгол Улс” задрахаас өөр аргагүй болж Зүүн Монголын Өөртөө Засах Төр ХКН-тэй холбоо тогтоож зөвшилцөлд хүрэхээс өөр замгүй болов. Баруун Монголын “Бүгд Найрамдах Өвөр Монгол Улсын Түр Засгийн Газар” тэдгээрийн жишгийг дагахаас өөр үггүй болов. Хэрэг явдал ийм болсныг ашиглан ХКН өөрийн Төв Хорооны Зүүн-Хойд Хятадын Товчооны харьяа Баруун Манжийн Бүлгийн үйл ажиллагааг хүчитгэж Өвөр Монголыг өөрийн эрхэнд оруулж эхлэв.

1946 оны 04 сард Өвөр Монголын Зүүн болон Баруун бүсүүдийн төлөөлөгчид Рэхэ Аймгийн Чэндэд цугларч Өвөр Монголыг нэгтгэх асуудлыг хэлэлцэв. Дараа жилийн 04 сард баруун Монголын Түмэд бүсээс гаралтай Юньцы хэмээх Монгол удирдагч (дараа нь нэрээ Улаанхүү болгож өөрчилсөн) Зүүн Монголын Ван-Ун Сүмд ирэхэд халуун дотноор хүлээн авч уулзсан байдаг. (зураг 2, Улаанхүү (баруун талаас) болон Жоу Энлай нар, Лиу Шаочи) Ван-Ун Сүм гэдэг нь Улаанхотын хуучин нэр юм. Түүнийг угтаж авахдаа буу буудан мэндчилж, Хүмүүс түүнийг “агуу Монгол удирдагч” хэмээн нэрийдэж байв. 1947 оны 05 сарын 01-ний өдөр Өвөр Монголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО) Ван-Ун Сүмд анх байгуулагдаж, Улаанхүү ӨМӨЗО –ы засгийн газрын Тэргүүн болсон билээ.

Манж-гогийн үед ӨМӨЗО-д ХКН хүчгүй байсан бөгөөд энэ нь 20-р зууны түүхэн дэх Монгол үндэстний хувьд ер бусын үе байсан юм. Өвөр болон Ар Монголчууд нэгдэж улс үндэстнийхээ хувиар өөрсдийгөө бусдад хүлээн зөвшөөрүүлэхийг хүсэх нь байгалийн жам юм. Өвөр Монголыг Хятадад нэгтгэхэд ХКН-с Ван-Ун Сүмыг “Хятадын үндэстний эв нэгдлийг хагалан бутаргах салан тусгаарлах



хөдөлгөөний үндэс суурь” болсон газар хэмээн зарлаж, Японы дарангуйллын үед өсөж торнисон Монголын сэхээтнүүдийг “Япон сэлэм бүсэндээ зүүсэн алуурчид” хэмээн гүтгэж, Монгол үндэстний тусгаар тогтнолын төлөөх хөдөлгөөнийг “Хятад Эх Орноо хагалан бутаргахаар хуйвалдаж улс үндэстнээсээ урвасан” үйлдэл гэж үзсэн бөгөөд энэ нь л Монголчуудыг үй олноор нь хомроголсон хядлагын “зүй ёсны” шалтгаан буюу үндэслэл гэж үздэг.

ХКН Соёлын Хувьсгадын үеэр Монголчуудыг үй олноор хядах болсон шалтгаанаа ӨМАХН-ын түүхээр хаацайлдаг гэдгийг ойлгох хэрэгтэй. Дэлхийн II Дайны дараа Бүгд Найрамдах Хятад Ард Улс байгуулагдсанаас хойш арван найман жил өнгөрсний дараа ХКН нь Японы эзлэн түрэмгийллийн үеийн хорслоо тайлж Монголчуудаас өшөө авсан гэхэд болно. Монголчуудыг салан тусгаарлах гэж оролдсон гэдгээс гадна Япончуудтай үгсэн хуйвалдаж хамтарсан гэдэг ял тулгав. Монголчуудын салан тусгаарлалтыг толгойлж байсан Монголын сэхээтэн язгууртнууд нь Японы эзлэн түрэмгийллийн үед өсч торнисон бөгөөд Японы шинэчлэлтийн талаар ихийг сурч мэдсэн байдаг. Гэтэл Японы дарангуйллын эсрэг тэмцэлд ХКН –н оролцоо маш бага байсан. Тэгсэн хэдий ч Дэлхийн II Дайн дуусахаас өмнөхөн Монголчууд Хятадаас салан тусгаарлах, тусгаар тогтнолоо зарлах зорилгоор Японтой онцгой харилцаа үүсгэснийг марталгүй санаж хариуцлага тооцсон хэрэг юм.

### **3. Аймаглан устгах их хядлагын баталгаа: Их Зуу Аймагас ирсэн Хэргийн тайлангууд**

1966 оны 05 сард “ХКН-н Төв Хорооны Зүүн-Хойд Хятадын Товчоо” Өвөр Монголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО)-ы засгийн газрын 146 гүйцэтгэх албан тушаалтай гишүүдийг Бээжин дэх Чيانьмэн Зочид Буудалд зохион байгуулагдсан “Чيانьмэн Зочид Буудлын Хуралд” оролцуулахаар дууджээ. Хурлын үеэр Улаанхүүг албан тушаалаас нь татан буулгаснаар аймшигт үйл явдлуудын эхлэл тавигдав. Хятадын талаас Монголчуудыг үй олноор нь хомрогolon хядсанаа “жинхэнэ төрхийг илрүүлэх ажиллагаа” гэж нэрлэж байлаа. Тус зохион байгуулалттай гэмт хэргийн чанартай үйл ажиллагаа нь хоёр талтай байсан ба нэг талаас Улаанхүүгийн талынхныг олж илрүүлэн “жинхэнэ дүр төрхийг илчилж хорт үйл хэргийг нь таслан зогсоож үйлдсэн буруу хэргийнх нь хариуцлагыг хүлээлгэх” явдал байсан бол нөгөө талаас ӨМАХН-н гишүүдийг олж илрүүлэн устгах зорилготой байж. Цаг хугацаа өнгөрөхийн хирээр тэд “үйл хэргээ” хоёр ангилахаа байсан ба тэдгээрийн эцсийн болоод гол зорилго нь Монголчуудыг алж хядах болж хувирав. Тэд үүнийгээ “хоёр ялгаж салгах хэрэггүй. Тэд бүгд Улаанхүүгээр удирдуулсан босогч бүлгийн гишүүд” гэж тайлбарлаж байв.



Алтандэлхийн бичсэнд үндэслэн Өвөр Монгол дахь хядлагын бүрэн дүр зургийг ерөнхийд нь илтгэхийг хүслээ. (Алтандэлхий 2008: 17-47)

Их Зуу Аймаг (сүүлд Ордос гэж нэрлэгддэг болсон)-т ойролцоогоор 150,000 хүнийг “ӨМАХН-н гишүүд” хэмээн баривчилсан нь Аймгийн тухайн үеийн нийт 740 000 хүн амын 21% нь байлаа. Бараг бүх Монгол хүнийг “ӨМАХН-н гишүүд” гэж зарлаж байв.

Энэ үеэр 1260 хүн алагдаж, 5016 хүн гэмтэж хохирсон бол 2322 хүнийг эрэмдэг болгон 739 хүн бүр мөсөн тахир дутуу болсон байдаг. Алагдсан хүмүүсийн тоонд орон нутгийн төр захиргааны, улс төрийн удирдагч нар, аймгийн өмнөх болон тухайн үеийн удирдагч нар, төр захиргааны хэлтэс, хэсгүүдийн 150 дарга, үйлдвэрлэлийн бригад болон тэдгээрийн салбар нэгжүүдээс 500 хүнийг цаазаар аваачсан. Ханжин Хошуунд 118, Уушин Хошуунд 149 удирдагч манлайлагч нарыг хөнөөсөн байна.

#### **Засгийн Газрын нууцлалтай баримт бичгүүдэд бүртгэгдсэн аймшигт хэргүүд**

1978 оны 08 сарын 05-ны өдөр ХКН-н Их Зуу Аймгийн Комиссын Бодлого Хэрэгжүүлэгч Хорооноос гаргасан “Товч Баримтыг” авч үзье. “Товч Баримт” гэдэг нь ХКН-н Намын Хурал дээр тавьдаг дотоодын зориулалттай баримт бичгүүд бөгөөд ийм баримтыг зөвхөн ХКН-н онцгой эрхтэй гишүүд эсвэл улс төрийн томоохон удирдагч нарт л үзүүлдэг. Доор нэг ийм баримт бичгээс сийрүүлэв:

Их Зуу Аймгийн Уушин Хошууны Туг Ардын Коммунд байдаг Жинзы 355 Дэглэмийг байгуулах үеэр олон тооны Монголчууд алагдсан. Тус Коммунд 2961 хүн амьдардаг байснаас 929-г нь “ӨМАХН-н гишүүд” хэмээн илрүүлсэн. Энэ нь тухайн коммуны насанд хүрсэн хүн амын 71% болж байна. Тэдний дундаас 270-г нь “гэмт хэрэгтэн” хэмээн яллаж, 49-г цаазаар аваачсан. Тахир дутуу болсон хүний тоо 270. Бүгд Монгол хүмүүс.

Монголын тал нутгийг “Монголын Эзэнт Гүрний агт морьдын бэлчээр” гэж зарлав. Хөдөө аж ахуйн зориулалтаар ухсан усалгааны худгуудыг “Монголчууд Хятадын эсрэг бослого гаргахад” бэлтгэж гаргасан гэж буруушаав. Хөрш Шаньчи мужийн хятад хүмүүсийг дайчлан Их Зуу дахь Монголчуудыг мөрдөн мөшгөж баривчлахад ашигласан байна. 1950-иад оноос хойш ажилгүй болсон олон тооны Хятад иргэд нэг газраас нөгөө рүү хэрэн хэсч амьдардаг байсан. Эсгий урлал зарж амь зогоодог байсан хэсэг ийм ажилгүй Хятадуудыг хөлсөлж “ӨМАХН-ын гишүүдийг олж илрүүлэх чухал ажилд” дайчилжээ. Ардын Чөлөөлөх Армийн цэргүүд Монгол хүмүүсийг тамлан тарчлаах 50 гаруй харгис хэрцгий аргуудыг ашигладаг байсан

ба олон газар санаанд багтамгүй харгислалыг үйлдэж байснаас цухас дурдвал:

1. Төмөр улайсгаж эмэгтэйчүүдийн үтрээ рүү хийх, гэдсийг нь цоо түлэх зэргээр тамалсан байсан ба дараа нь тэдгээр эмэгтэйчүүдийг бэлэг эрхтнээс эрүүл газар юу ч үлдээгүй нь хохирогчдын хүйсийг танихад ч хэцүү болгож байсан. Зарим эмэгтэйчүүдийн гэдсийг цоо түлснээс болж гэдэс дотор нь цувсан байв.
2. Төмөр утсаар үхрийн ширэн ташуурыг ороож түүгээрээ Монголчуудыг ташуурдахад арьс мах нь огло үсэрч, цус олгойддог. Тэдэнд эмчийн туслалцаа үзүүлэхийг тас хориглосон бөгөөд газар дээрээ үхэг гээд үлдээдэг байсан. Хохирогчдын шархнаас олгойдсон цус ханыг тэр чигт нь будаж, бүр сүүлд ч цусны үнэр арилахгүй маш удсан гэдэг. Зарим тохиолдолд хохирогчдын шархан дээр давс эсвэл буцламгай халуун ус асгаж зэрлэгээр тарчлаан алдаг.
3. Төмрөөр хийсэн өргөн туузаар хүмүүсийн толгойг ороож аажмаар чангалсаар хохирогчийн толгой зад үсэртэл үргэлжлүүлнэ.
4. “Хувьсгалын эсрэг гэмт хэрэгтнүүд” хэмээн яллагдсан Монголчуудыг галтай зууханд дээр наах шахам ойртуулж түлэн удаанаар шарж алдаг байсан. Зарим тохиолдолд хохирогчийн толгой руу улайсгасан төмөр дүрж ална.
5. Хохирогчийн гарыг ард нь хүлж таазнаас өлгөхөд үе мөчнүүд нь мултардаг. Зарим тохиолдолд таазнаас өлгөөтэй байхад нь олсыг тасалж газар бяц унагаж ална.
6. Монгол эмэгтэйг шалдлан зогсоогоод салтаан дотуур нь үхрийн ширэн өргөн олс оруулж ард урд нь хятад хүмүүс зогсон олсны хоёр үзүүрээс барьж нааш цааш татаж чангаана. Ингэхэд эмэгтэйн бэлэг эрхтэн маш аймшигтай гэмтдэг.
7. Монгол эрчүүдийг алсны дараа АЧА-н цэргүүд эхнэрүүдийг нь ахин дахин хүчинддэг. Залуухан жоохон охидыг ч мөн адил хүчиндэнэ.
8. Монгол хүмүүсийн өмч хөрөнгийг хураан авна.

Дээр бичсэн баримтуудыг Хятадын засгийн газрын нууцлалтай баримт бичиг болох “Товч баримтуудаас” авсан. Дээрх нь тодорхой хугацааны л үйл явдал бөгөөд цаашлаад түүхэн баримтуудыг үзэх хэрэгтэй.

### **Их Зуу аймагт болсон хядлага**

Уушин хошууны Туг Ардын Коммуны Тугалтай Үйлдвэрлэлийн бригадад нэгэн Хятад эхнэр нөхөр хоёр амьдардаг байсан ба нөхрийг нь Чен Вэнкуй, эхнэрийг нь Ма Ланфан гэдэг байсан. Тэд гэртээ Монгол хүмүүсийг авчирч өдөр шөнөгүй тамладаг байсан бөгөөд 50 гаруй тамлах арга зохиосон байсан гэдэг. Тэр хоёр л гэхэд 3 монгол хүнийг харгис зэрлэгээр хөнөөж, 30 гаруй хүнийг хүнд гэмтээсэн байв.

Тус үйлдвэрлэлийн бригадын дарга нь Батцэрэн хэмээгч Монгол хүн байсан. Түүнийг Хятад хүмүүс жирэмсэн эхнэрийнх нь хамтаар барьж яргалан гэдсэнд байгаа хүүхдээ хүртгэл “ӨМАХН-ын гишүүн” гэж хүлээн зөвшөөрөхийг тулгаж байв.

Мөн тухайн коммунын Мэйрэн Сүмэ үйлдвэрлэлийн бригадын нарийн бичгийн дарга Данзан гэгч Монгол хүнийг барьж аманд нь морины амгай зуулгаж нуруун дэр нь мордоод морь шиг давхиулж дараа нь сэлмээр цавчиж алсан.

Шида хэмээх Монгол хүний гэр бүлийн 6 гишүүнийг тэр дундаа 83 настай аавыг нь 43 хоногтой нялх хүүхдийг “ӨМАХН-ын гишүүн” хэмээн яллаж, эхнэрийг нь зодсоор байгаад алж, нялх хүүхдийг нь ч хөнөөсөн байдаг.

Тухайн Коммуны нарийн бичгийн дарга байсан Сэмчиг нэртэй Монгол хүний гэр бүлийг тэр чигт нь хүйс тэмтэрч ганц 9 настай охин нь амьд гарч чадсан. Хятад хүмүүс болон АЧА-н цэргүүд “олон монголыг алвал хүнсээ хэмнэнэ. ӨМАХН-ын бүх гишүүдийг устгачихвал санаа зовох асуудалгүй болно” гэж ярьцгаадаг байсан.

Их Зуугийн Ээжийн Хороо хошууны Суварган Ардын Коммуны нарийн бичгийн дарга Бадай гэгч Монгол хүнийг Хятадууд барьж хэлийг нь тастсан бол Дуншен тойргийн Ардын Армийн хэлтсийн орлогч дарга байсан Чен Фүтин гэгч монгол эрийг 47 янзаар яргалж, сэлмээр 16 удаа сүлбэж алсан байна.

### **Их Зуу аймаг дахь бэлгийн хүчирхийлэл**

Их Зуу Аймгийн орон нутгийн засгийн газрын гүйцэтгэгч албан тушаалтай байсан Бай Сиужэн гэх Монгол эмэгтэйг Хятад эрчүүд барьж ахин дахин хүчиндэж үтрээ рүү нь улайсгасан төмөр чихэж бэлэг эрхтэн болон дотор эрхтнүүдийг нь маш ихээр гэмтээж алсны дараагаар цогцсыг нь худагт хаяж амиа хорлосон болгосон.

Түмэнжаргал гэгч Монгол эрийг санаанд багтамгүй харгис аргаар яргалж бэрийнх нь салтаан доогуур мөлхүүлсэн байдаг.

Уушин хошууны Туг Ардын коммунын нарийн бичгийн даргын орлогч Чулуун гэх залуухан Монгол эмэгтэйг барьж шалдлан 5

хоногийн турш өдөржин шөнөжин зодсоор алсан. Тэр Коммунын бас нэгэн гишүүд Донров гэдэг хүнийг цусаар бөөлжтөл зодож нь 12 янзаар яргалан илжиг, гахай гэх мэт амьтадтай бэлгийн харилцаанд албадан оруулж “Монголчууд та нар заваан адгуусууд” гэж орилдог байсан.

### **Монгол эрчүүдийг ялахын тулд Монгол эмэгтэйчүүдийг бэлгийн хүчирхийлэлд өртүүлдэг байсан**

Соёлын Хувьсгал бол дайн биш бөгөөд ард түмэн энх найрамдалтай “аз жаргалтай” амьдарч байсан энх тайвны үед болсон үйл явдал. Монгол эмэгтэйчүүдийг Хятад эрчүүд хүчиндэж, ингэснээрээ бүх Монгол хүмүүсийг дийлнэ гэдгээ харуулах зорилготой байсан. Монгол эрчүүдийг доромжлох гэж Монгол эмэгтэйчүүдийг хүчирхийлдэг байсан. Ийм аймшигтай гутаан доромжлол, тамлалыг Монгол хүмүүс дуугүй тэвчиж, тэдгээр айшигт жилүүдийн хар дурсамжийг ой тойноосоо авч хаяж чадна гэж үү? Монгол эрчүүдийг өөрсдийг нь яргалан тамлаад зогсохгүй, эхнэр, охин, ээж, эгч нарыг нь Хятад хүмүүс хүчирхийлж доромжлон гутаадаг байсан. Хятадын Соёлын Хувьсгал бол бодит байдал дээрээ зөвхөн Монгол хүмүүсийн эсрэг үйлдсэн хүн ёсноос гажсан гэмт хэрэг байгаад зогсохгүй бүх хүн төрөлхтөний эсрэг үйлдсэн гэмт хэрэг юм. Энэ асуудлыг ингээд намжааж болохгүй. Бид олон улсын нийгэмлэг, хүний эрхийг хамгаалах олон улсын шүүхэд хандаж шударга ёсыг тогтоолгох хэрэгтэй .

#### **4. Өвөр Монголын нийт хохирлыг тооцоолбол**

Өвөр Монголд нийт хичнээн Монгол хүнийг хядсан бол? Үүнийг хариулт тодорхойгүй бөгөөд үнэнийг чандлан нуусаар л байна. Хятадын засгийн газраас гаргасан статистикт итгэх аргагүй.

Зарим статистикаас үзвэл Хөлөнбуйр Аймагт л гэхэд нийт 2794 хүн алагдаж, 6612 хүн маш хүнд гэмтэж тахир дутуу болсон байна. 1968 онд Өвөр Монголд долоон аймаг, хоёр хот, 1046 ардын коммун байсан гэж үздэг. Хөх Хот болон Баотоу хоёрт маш олон засаг захиргааны нэгжүүд байрладаг байсан. Эд бүгд аймшигт хядлагад өртсөн. Өвөр Монголд энэ зэрлэг аллага, хэлмэгдүүлэлт, харгислалд өртөөгүй нэгээхэн ч газар үлдээгүй.

Түмэд Аймгийн Сижиаяо ардын коммунд 32 хүн алагдаж, Ордосын Уушин хошууны Туг ардын коммунд 54 (өөр статистикаар бол 69) хүн алагдсан (Ян 2009с: 124; 2011: 185). Өвөр Монголын Геологийн Товчооны нэгэн жижигхэн туршилтын лабораторт л гэхэд Ву ГуйИн гэх Хятад эмэгтэй ганцаараа дөрвөн хүнийг алсан байдаг. Ингээд бодохоор Өвөр Монголын долоон аймаг, хоёр хот, 1046 ардын коммунд үнэндээ нийт хэдэн хүн харамсалтайгаар амиа алдан бол? Хятадын засгийн газраас зарласан тооцоонд нийт 346000 хүнийг

баривчилснаас 27900 нь алагдаж 120000 тахир дутуу болсон гэж байна. Яасан бага тоо вэ? Бодит тоо нь хавьгүй илүү байгаа гэдэгт итгэлтэй байна. Өөрийн хийсэн судалгаан дээрээ үндэслэн дүгнэлт гаргавал Монголын сэтгүүлч Шаравжамцын тооцоо үнэнд хамгийн ойр очиж байна. Тэрээр бие даан судалгаа хийсний үндсэн дээр “баривчилгааны үеэр газар дээрээ амь үрэгдсэн болон ачилт, байцаалт болон шоронд хоригдож байх үедээ, мөн түүнчлэн суллагдан харих замдаа амиа алдсан нийт Монгол хохирогчдын тоо 300 000 хүрсэн” гэдэг дүгнэлтэд хүрсэн. (Шаравжамц 2006: 44)

Соёлын Хувьсгал нь дайны үед болоогүй. Цаг хугацаа өнгөрч Хятадын засгийн газар тэр аймшигт улс төрийн дэмжлэгтэй хядлагыг харах өнцөгөө өөрчилсөн. Сүүлийн үед “иргэний дайн” гэж нэрлэх гээд байдаг болсон. Соёлын Хувьсгал нь яахын аргагүй улс төрийн бодлоготой алхам байсан бөгөөд дайн бол биш юм. Тус үйл явдлыг бодит хор уршгийг олон улс ойлгох хэрэгтэй. Харин Монгол хүмүүсийн хувьд аймаглан устгах их хядлагыг өнгөрсөнд болсон харамсалтай хэрэг гэж үзээд тоохгүй орхиж болохгүй. Тиймээс Монгол үндэстнийг аймаглан устгах их хядлагыг өнөөг хүртэл шийдэгдээгүй байгаа хүний эрхийн эсрэг үйлдэгдсэн ноцтой гэмт хэрэг гэдгийг олон улсад дэлгэн тавихын төлөө хүн бүр хүчин чармайлт гаргах хэрэгтэй. Энэ асуудал шийдэгдэхгүй байсаар байвал Монгол хүмүүсийн үндэстний тусгаар байдал улам бүр алдагдаж Хятадын колони болоход ойрхон байна. Дээрх асуудал нь зөвхөн Өвөр Монголд байгаа Монголчуудад хамаатай бус Монголтой угсаа гарал нэгтэй Буриад, Халимаг гэх хоёр үндэстний бүлгийн тусгаар байдалд ч бас муу нөлөө үзүүлж байна. Монголчуудыг “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тагнуулч” эсвэл “Монголын Эзэнт Гүрнийг дахин цогцлоохыг завдаж буй урвагчид” хэмээх зүй бус гүтгэлгээр шалтгаалан Монгол үндэстэн үндэстний эсрэг аймаглан устгах их хядлага явуулсан. Эцэст нь би бүх Монгол хүмүүс нэгдэж энэ асуудлыг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч, улмаар дэлхий дахины хүний эрхийн асуудалд хувь нэмрээ оруулах хэрэгтэй гэж үзэж байна.

### Ном зүй

阿拉腾德力海1999『内蒙古挖肃灾难实录』出版地不明。

達林太2009「那日布札木蘇和道爾吉桑的短暫人生」『察右旗後旗文史資料』(第七輯)、221-226。

樊永貞2009「阿布達爾營挖“內人黨”的經過」『察右旗後旗文史資料』(第七輯)、194-208。

趙桑島 趙傑2009「我所經歷的“挖肅”運動」『察右旗後旗文史資料』(第七輯)、215-226。

中国人民政治協商委員會察右後旗委員會

—2004『察右旗後旗文史資料』(第三輯)。

—2009『察右旗後旗文史資料』(第七輯)。

楊海英2008b 「モンゴル人の日記のなかの中国文化大革命(1)」静岡大学人文学部『人文論集』58(2):43-70。

—2008c 「〈少数民族虐殺は正しかった〉—中国共産党唐山学習班班員の日記」静岡大学人文学部アジア研究プロジェクト『アジア研究』3:21-75。

—2008d 「モンゴル人の日記のなかの中国文化大革命(2)」静岡大学人文学部『人文論集』59(1):113-140。

—2009a 『モンゴル人ジェノサイドに関する基礎資料(1)—藤海清將軍の講話を中心に』(内モンゴル自治区の文化大革命1)東京:風響社。

—2009b 『墓標なき草原(上)』東京:岩波書店。

—2009c 『墓標なき草原(下)』東京:岩波書店。

—2009d 「〈モンゴル人の心は北京と毛沢東に向いてきた〉のか—中国北部とモンゴル国との人的移動の現代史から」『民博通信』126号、13-15。

—2009e 「中国文化大革命中に内モンゴルで発行された大衆新聞について」静岡大学人文学部 農学部『グローバルの中でのアジアの環境と生活文化』、51-66。

—2010a 『モンゴル人ジェノサイドに関する基礎資料(2)—内モンゴル人民革命党粛清事件』(内モンゴル自治区の文化大革命2)東京:風響社。

—2011 『モンゴル人ジェノサイドに関する基礎資料(3)—打倒ウラーンフー(烏蘭夫)』(内モンゴル自治区の文化大革命3)東京:風響社。

—2013a 『モンゴル人ジェノサイドに関する基礎資料(5)—被害者報告書(1)』(内モンゴル自治区の文化大革命5)東京:風響社。

—2013b 『植民地としてのモンゴル—中国の官制ナショナリズムと革命思想』東京:勉誠出版。

—2013c 『中国とモンゴルのはざま—ウラーンフーの実らなかった民族自決の夢』東京:岩波書店。

—2014 『モンゴル人ジェノサイドに関する基礎資料(6)—被害者報告書(2)』(内モンゴル自治区の文化大革命6)東京:風響社。

—2015 『モンゴル人ジェノサイドに関する基礎資料(7)—民族自決と民族問題』(内モンゴル自治区の文化大革命7)東京:風響社。

—2016 『モンゴル人ジェノサイドに関する基礎資料(8)—反右派闘争から文化大革命へ』(内モンゴル自治区の文化大革命8)東京:風響社。

—2017 『モンゴル人ジェノサイドに関する基礎資料(9)—紅衛兵新聞(1)』(内モンゴル自治区の文化大革命9)東京:風響社。

Atwood, P. Christopher, 2002 *Young Mongols and Vigilantes in Inner Mongolia's Interregnum Decades, 1911-1931 (Volume one)*, Leiden · Boston · Kūln: BRILL.

Bulag, Uradyn, 2002 *The Mongols at China's Edge*. Lanham · Boulder · New York · Oxford: Rowman & Littlefield Publishers, Inc.

Brown, Kerry, 2006 *The Purge of the Inner Mongolian People's Party in the Chinese Cultural Revolution, 1967-69*. Global Oriental.

Jankowiak, William, 1988 *The Last Hurraah? Political Protest in Inner Mongolia*. *The Australian Journal of Chinese Affairs*, 19/20:269-288.

Sneath, David, 1994 *The Impact of the Chinese Cultural Revolution in China on the Mongolians of Inner Mongolia*. *Modern Asian Studies*, 28:409-430.

Sirabjamsu, Gha, 2006 *Sirabjamsu-yin Jokiyal-un Sungghumal*, a Private edition.

Тьмен and Ju Дьнг Li, 1996a *Kang Šeng kiged “Цьг Arad-un Nam”-un kilis kereg. Цьг Mongγol-un arad-un keblel-ын qorigy-a.*

———1996b *Kang Šeng kiged Цьг Mongγol-un Arad-un Qubisqaltu Nam-un kilis kereg. Ындьсьтен-ь keblel-ын qorigy-a.*

Yang Haiying, 2013 *Ulanhu, A Nationalist Persecuted by the Chinese Communists: Mongolian Genocide during the Chinese Cultural Revolution*. Nagoya University.



## “ПАНМОНГОЛИЗМ”-ЫН УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ МОНГОЛЫН УЛС ТӨРЧДИЙГ ХЭЛМЭГДҮҮЛСЭН НЬ (1937-1941 ОН)

*“БНМАУ-ын засгийн газрын эсрэг зэвсэгт бослого бэлтгэж байсан хуйвалдагч байгууллагад” хамаарах хэмээх улс төрийн зохиомол хэрэгт Монголын төр, олон нийтийн зүтгэлтнүүдийг хилсээр ялласан тухай*



*Г.Ариунболд  
Магистр  
Монголын улс төрийн хэлмэгдэгсдийн  
холбоо,*

1940 оны 9 сарын 6-нд Берия Дээд Шүүхийн Цэргийн Коллегид дахин 537 хүний хэргийг зөвшөөрөл хүсэж илгээсэн байх юм. Нэрсийн жагсаалтын хавсралтаас харахад 472 хүнд буудан алах ял оноосон байх бөгөөд түүний дотор 411 нь “БНМАУ-ын засгийн газрын эсрэг зэвсэгт бослого бэлтгэж байсан хуйвалдагч байгууллагад” хамаарах, үлдсэн 65 хүн нь 15-аас доошгүй жил хорих ял төлөвлөгдсөн байжээ.

Нэрсийн жагсаалтын албан ёсны баримтжуулалт нь урьд өмнөхөөсөө ялгаатай байгаа нь зэрэглэл тус бүр нь тусгай дотуур нүүр хуудастай, дараа нь баригдахын өмнөх албан тушаалыг тусгайлан зааж тоочсон байх ба мөн хуудасны дугаарыг тэмдэглэсэн байсан, мөн баривчлагдсан хүний талаарх лавлагаа хийгдсэн (урьд өмнө лавлагааг зөвхөн гадаадынханд хийдэг байсан, гэхдээ дандаа ч бас биш). Гэхдээ энэ хэрэгт архивт Улс Төрийн Товчооны ямар нэгэн шийдвэр хадгалагдаж үлдсэнгүй, харин илтгэх хуудас дээр Сталины “Нөх. Бериягаас” хэмээн тэмдэглэсэн байх ажээ. Хавтаст хэргийг Дээд Шүүхийн Цэргийн Коллегид шилжүүлэх зөвшөөрлийг ямар ч байсан (харахад) өгсөн байсан бололтой. Ямар ч л байсан сонгож авсан шалгалтын явцад, энэхүү нэрсийн жагсаалтад орсон олонхи нь цээрлүүлэгдсэн нь тодорхой байгаа юм хэмээн Оросын хэлмэгдэл судлаачид тэмдэглэжээ (зарим нь таамаглаж байснаас ч харгис хэрцгий ял шийтгэл оногдуулсан ажээ) 1. БНМАУ-ын эдгээр иргэдийг

ЗСБНХОУ-ын Эрүүгийн Байцаан шийтгэх хуулийн 58-ын 1б., болон 58-ын 11-р зүйл ангиар (ст.ст. 58-1б, 58-11 УК РСФСР) шийтгэж 40 гаруйг нь буудан алсан байх юм. Энэ бол зөвхөн энэ хавтаст хэрэгт холбогдох хүмүүсийн тухай дурдахад ийм болой.

Дараагийн буудан алсан нэрсийн жагсаалтууд дайны цаг үед хамаарах ажээ. Улс Төрийн Товчооны бүх үүрэг хариуцлага мэдэж байгаагаар Улсыг Батлан Хамгаалах Хороонд (УБХХ) ноогдсон байлаа.

НКВД-гийн хуучин ажилтан агсдын хувьд шүүх үйл ажиллагааны ёс журам илүү “хялбарчилсан” арай өөр хэлбэртэй байгаа ажээ. Түүний дээрх нэрсийн жагсаалт нь ихэвчлэн Сталинд тусгайлан өгдөг байсан бөгөөд, бусдаас ялгаатай нь хавтас үгүй, эсхүл зөвхөн “Жагсаалт” хэмээн гарчигласан байх буюу “Нэрсийн жагсаалт” гэсэн байдаг байв. Эдгээрт нэр заагдсан хүмүүс нь Дээд Шүүхийн Цэргийн Коллегид шүүгдэх ёстой бөгөөд хэрвээ чекистүүдийн нэр ерөнхий нэрсэд явж байх ахул тэдний ар талд нь: “НКВД-гийн ажилтан байсан” хэмээн эсрэгцүүлэн тавьдаг байлаа. Ийм нэрсийн жагсаалтыг баталсны дараа Дээд Шүүхэд хэлэлцдэггүй байсан бөгөөд-эдгээр хүмүүсийг шууд л бууддаг байжээ. Энэ тохиолдолд Сталин болон түүний хамтран зүтгэгчдийн гарын үсэг л эцсийн шийдвэр гаргахад хангалттай байжээ.

Ийнхүү ЗХУ-д 1934 оноос эхлэн 1941 оныг хүртэлх цаг хугацааны дотор ид явагдаж байсан “сталинизм”-ын улс төрийн хилс хэлмэгдүүлэлт нь мөн цаг хугацааны дотор “улаан империализм”-ын хор уршиг болж, жижиг хөрөнгөтний Бүгд Найрамдах Улсын хөгжлийн жам ёсны замаар урагшлан байсан тухайн цаг үедээ “нүүдэлчдийн” өвөрмөц онцлогтой Монгол оронд шууд нөлөөлсөн гэлтэй.

Үүний үр дүнд “Лхүмбийн хэрэг”-ээс эгсүүлээд “Гэндэн Дэмидийн хэрэг” хэмээх зохиомол улс төрийн хилс хэргүүдийг зохиох доо ЗХУ-д явагдаж асан Коминтерн хийгээд БХК(б)Н- дахь “сталины оппозиц” удирдагчид асан Г.Е.Зиновьев, Л.Б.Каменев нарын 1935 оны “Московский центр” буюу “Москвагийн төв” хэрэг, Н.И.Бухарин, А.И.Рыков, Г.Л.Пятаков, К.Б.Радек нарын гэгдэх 1937 оны 1-р сарын, мөн 1938 оны 3-р сарын улс төрийн зохиомол “Пятаков-Радек”-ийн хэрэг, “Рыков-Бухарин”-ы гэх зэрэг хэргүүдийн шууд хуулбар (копия) нь болж Монголд мөн онуудад 1 хэрэгжиж байсан ажээ.

Үүнээс удалгүй Хорлоогийн Чойбалсан нь ЗСБНХУ-ын “Дотоод Хэргийн Ардын Комиссириатын гавьяат ажилтан” 2 (звание «Заслуженный работник НКВД СССР» - Г.А.) - хэмээх цол хэргэмээр 1940 оны үед шагнагдсан талаар орос хэл дээрхи Википедиа-гийн түүний намтарт өгүүлсэн нь зохих ёсоор анхаарал татна. Чухамхүү 1940 оноос эхлэн НКВД буюу ЗСБНХУ-ын “Дотоод Хэргийн Ардын Комиссириатын гавьяат ажилтан” цол хэргэмийг Иосиф

Виссарионович Сталины үед буй болгосон байх ажээ. Хожим энэ цолыг дахин татан буулгаж, оронд “КГБ-ын хүндэт ажилтан”, өнөөдөр бол “ОХУ-ын ФСБ-ын сөрөг тагнуулын албаны хүндэт ажилтан” (албан хаагч) цол, тэмдэгээр сольсон ажээ. Дээрхээс дүгнэн үзэхэд Х.Чойбалсан нь ЗХУ-ын НКВД-д итгэмжлэгдсэн хүний нэгэн яахын аргагүй байсан үнэн гэдэг нь батлагдах мэт.

Энэхүү илтгэл (өгүүлэл)-д судлаач миний бие ХХ зууны эхэн үеэс эхлэн буй болсон “Панмонголизм” буюу “Нармай Монгол”-ын үзэл санаа, мөн зууны 1920-иос 1930-аад онуудад хэрхэн ЗХУ-аас Монгол хийгээд монголын улс төрчдийг хилсээр хэлмэгдүүлэх бодлогын нэгэн зүйл болсоныг товч ч атугай тэмдэглэх, мөн энэхүү улс төрийн хилс хэлмэгдүүлэлтэд чухамхүү Орос Улсад хүргэгдэн аваачиж хилсээр хэлмэгдсэн олон монголчууд хамрагдах болсон учир шалтгаан, нөхцөл байдал, мөн тэднийг чухам хаана ямар байдлаар шийтгэсэн талаар товч дурдахыг (өгүүлэхийг) зорьсон болмуй.

Энэхүү илтгэл (өгүүлэл)-д судлаач миний бие дотор нь 3 зүйл хэсэг болгон хувааж авч үзэж байна.

1. Монголд “Нармай Монгол”-ын үзэл хэзээ хэрхэн үүсэж, дэлгэрсэн талаар цухас дурдав.

2. ХХ зууны эхэн үеэс Буриад нараар дамжин Ар буюу Халх Монголд энэ үзэл санаа хэрхэн нөлөөлсөнөөр, чухамхүү, Халх Монголын нэртэй улс төрчдийг Буриад Ринчино нарын нөлөөтэйгээр хэрхэн хилсээр хэлмэгдүүлсэн ажээ.

3. ХХ зууны 1920-иос 1930-аад онуудад Халх Монголд өрнөсөн “панмонголизм” нь чухам хэрхэн нууц байдалд орж, улмаар Коминтерн болон “зүүнтэн” нарын шууд гар бие оролцоотойгоор буруу тийш хандаж, мөн л улс төрийн хилс хэлмэгдүүлэлт өргөн хүрээнд явагдсанаар 1937-1942 (бараг 1990-ээд) он хүртэл үргэлжилсэн байна.

1. Монголд (хэмээн ерөнхий нэрлэн) “Нармай Монгол”-ын буюу “панмонголизм”-ын үзэл санаа үүсэж буй болох уг үндсийг чухамхүү Оросын Хаант Улсын бүрэлдэхүүнд байсан Буриад Монгол буюу буриадуудын санал санаачлагаар анх Чита хотноо хуралдсан Нармай буюу Панмонголизмын анхдугаар их хурал дээр гаргасан шийдвэр дээрээс үндэслэн тавьсан ажээ.

Чита хотноо хуралдсан энэ их хуралд буриадын эсер намын гишүүн, хожим Коминтерний шугамаар 1921 оны Ар Монголын хувьсгалд гар бие оролцох болсон Элбэгдорж Ринчино мөн идэвхтэй оролцсон болой... Чухамхүү тэр энэ их хуралд ямар байдлаар оролцсон, хаанаас ирж оролцсоныг цаашид тодруулан судлах нь сонирхол татах амой.

2. XX зууны эхэн үеэс Буриад нараар дамжин Ар буюу Халх Монголд энэ үзэл санаа хэрхэн нөлөөлсөнөөр, чухамхүү, Халх Монголын нэртэй улс төрчдийг Ринчино нарын нөлөөтэйгээр хэрхэн хилсээр хэлмэгдүүлсэн талаар...

XX зууны эхэн үеэс Буриад нараар дамжин Ар буюу Халх Монголд энэ үзэл санаа нөлөөлсөнөөр, чухамхүү, Халх Монголын нэртэй улс төрчид тухайлбал, МАН-ын анхны “долоо”-гийн нэг, МАН-ын хоёр бүлгэмийн “Хүрээний бүлгэм”-ийн үндэслэгч, МАН-ын анхны дарга удирдагч, Солийн Данзанг МАН-ын 3-р их хурал дээр устгах, улс төрийн зохиомол гүтгэлэгт хилсээр хэлмэгдүүлэх нууц хуйвалдаан явагдсан хэмээн судлаач миний бие үзэж байна.

ЗХУ-ын олон улсад нэрд гарсан “Хаврын арван долоон учрал” киноны гол дүр штандартанфюрер Штирлиц буюу Максим Исаев нь Богд Хаант Монголд Барон Унгерны дэргэд тагнуулын үүрэг гүйцэтгэж байсныг саяхан тодруулсан шиг, мөн л Элбэгдорж Ринчино “Коминтерний” нууц агент (цаана РСФСР-ын НКВД буюу ЧК-гийн хүн) байсан байхыг үгүйсгэж болохгүй гэлтэй.

Энэ ч зорилгоо МАН-ын дэргэд бошгыг халах МХЗЭ-ийг Х.Чойбалсангаар анх санаачлан мөн удирдан, байгуулуулаад, дараа нь Ц.Дамбадорж, Нацов (Шойжелов/, Старков, Ринчино Элбэгдорж, Ө.Бадрах (Ойрад/, Бадрах (Өвөрмонгол/, Х.Чойбалсан... нарын удирдлага мөн оролцоотой зохион байгуулсан гэлтэй ...

Харин үүний эсрэг мөн буриад Цэвээн Жамцарано нарын сэхээтнүүд сөрөн зогсож байсныг ч үгүйсгэж болохгүй.

Тэгвэл буриад Монголоос Оросын “эсер” (намын) талыг баримталсан Ринчино, мөн “панмонголизм”-ыг Халх Монголд сурталчилагч Цэвээн Жамцарано нар гэх мэт аль аль нь эерэг, сөрөг байр суурь баримтлагчид 20-иод оны улс төрийн бодлогод нөлөөлж, нөлөөлөх төдийгүй нилээд ширүүн өрнөлийг буй болгож байцгаажээ.

Солийн Данзангаас эгсүүлээд РСФСР –ийн “улаан” хувьсгалчидад “Урианхайн хязгаар буюу хожмын Тагну-Тува-г нэхэж, эр зориг гаргасан, мөн “хичээнгүй” гэгдэх Балингийн Цэрэндоржийн даалгавраар Тагну-Тува-д нууц ажиллаж Туваг Монголтой нэгтгэх оролдлого хийж байсан Өлзийтийн Бадрах (нууц тагнуулын ажиллагаа хийж явсан/, Тува болон ОХУ-тай Монголын талаас хэлэлцээг явуулж байсан “ардын” Хатанбаатар Магсаржав, Гомбо Идшин гүн, Лаварын Дэмбэрэл, ... нарын зэрэг монголын төлөөлөгчдийг дурдаж болох юм.

3. XX зууны 20-30-аад онуудад Халх Монголд өрнөсөн “панмонголизм” нь чухам хэрхэн нууц байдалд орж, улмаар Коминтерн болон “зүүнтэн” нарын шууд гар бие оролцоотойгоор буруу тийш

хандаж, мөн л улс төрийн хилс хэлмэгдүүлэлт өргөн хүрээнд явагдсанаар 1937-1942 (бараг 1990-ээд) он хүртэл үргэлжилсэн тухай тус тус товч тэмдэглэх нь зүйтэй буй за.

XX зууны 20-30-аад онуудад Халх Монголд өрнөсөн “панмонголизм” нь чухам ... нууц байдалд орж, ...улмаар Коминтерн болон “зүүнтэн” нарын шууд гар бие оролцоотойгоор буруу тийш хандаж, мөн л улс төрийн хилс хэлмэгдүүлэлт өргөн хүрээнд явагдсанаар 1937-1942 (бараг 1990-ээд) он хүртэл үргэлжилсэн байх юм.

XX зууны 20-30-аад онуудад Халх Монголд өрнөсөн “панмонголизм”-ын гол төлөөлөгч нар бол Анандын Амар, Цэвээн Жамцарано нар мөн хожим хойно ЗХУ-ын НКВД-гийн нууц архивын түүхэн баримтуудаас үзэхэд мөн “зүүнтэн” гэгдэгсэд болох Пэлжидийн Гэндэн, “зүүний зүүнтэн” буюу “хөдөө”-гийнхэний бүлгийн удирдагч Өлзийтийн Бадрахаас эгсүүлээд ... Золбингийн Шижээ, С.Нацов, (А.Амар,) Д.Догсом, .....нарын зэрэг олон зуун халх, дөрвөд, өөлд, барга, буриад, өвөрмонгол ...монголчуудыг дурдаж болох билээ.

Энэ асуудалд холбогдох нэгэн хэрэг бол “панмонголизм”-ын үзэл баримтлагчдад хамаарах мөн “Халхын төв” буюу “Халхаский центр” бүлгийн улс төрийн зохиомол хэрэгт хамаарах хүмүүс болой.

“Халхаский центр” хэргийн гол удирдагч нарт чухамхүү Пэлжидийн Гэндэнг гол удирдагч нь хэмээн нэрлэж, мөн удирдагч нарт Ц.Дамбадорж, Н.Жадамба, Ө.Бадрах, Д.Готов (корпус командлан захирагч/, өндөр Готов, Цэрэн, Лувсандоной (1939 оны бүх цэргийн жанжны орлогч, Халх голд Монголын цэргийн дэд командлагч асан) ...нарын зэрэг олон хүмүүсийг хилсээр хэлмэгдүүлсэн ажээ ...

Их Наран Улсаас нууц удирдлагатай Инокучи, ... нартай нууц холбоо бүхий, Японы империализмын нууц тагнуул туршуулууд хэмээгдэн хардагдсан эдгээр хүмүүсийг 1937-1942 онуудад ЗХУ-ын НКВД-гийн шууд оролцоотой, ЗХУ-ын Москва хотноо баривчлан аваачиж, Лефортово, Бутырийн болон бусад шорон гяндангуудад байцаан, шийтгэсэн ажээ.

Өөрөөр хэлбэл, чухам (Японы нэрт эрдэмтэн Танакагийн номонд тэмдэглэсэнээр) “Японы тагнуул” хэмээх хэсэгт “...1932 оноос хойш Японтой харилцаа тогтоож “Японы тагнуул” хэмээх шалтгаанаар Монголын удирдлагууд ар араасаа улсын дайсан хэмээн баривчлагдан цаазлагдав гэх нилээн олон хэрэг гарсан. Үүний дотроос хамгийн анхаарал татсан Лхүмбэ-ийн хэргийн шүүхийн баримтад 1932 онд Японы тагнуул Танака Манжго улсаас хил даван Монголд нэвтрэн орж тагнуулын бүлэг байгуулахад оролцсон гэсэн баримт байна.

Энэ Танака гэгч хэн бэ? Хэдэн хүний таамаг байгаа боловч, түүний дотроос тэр цаг үетэй харьцуулбал консул Танака Буничиро хамгийн нөлөөтэй хүн гэж бодогдохоор байгаа ч, консул өөрийн биеэр нууцаар хил даван Монголд орсон гэхэд хэцүү. Өөр бас нэгэн Танака гэх хүн бол Бавуужавын хүү Жонжууржав болов уу гэж бодогдох боловч энэ нь таамгаас цаашгүй байлаа. Ингээд Японы талын байгуулсан маш том тагнуулын байгууллага нь үнэхээр байдаг гэдэгт ихэнх монголчууд эргэлзээгүй итгэж байсан. Энэ тагнуулын тухай дам яриа нь манжгогийн хэлэлцээ эхэлсэн 1935 оны үед анх дэлгэрч түүнээс хойш энэ байдал ноёрхож эхэлсэн юм...” гэжээ... Танакагийн тэмдэглэснээр мөн : “...” 20 мянга гаруй хүнийг хороосон их аллага” хэмээх зүйлд “...Энэ “анхны 14” гэгчийг эхлэл болгон түүний үргэлжлэл болох Номонхааны дайн гарах хүртэлх 1939 оны 5 дугаар сар хүртэлх зөвлөлтийн эсэргүү, хувьсгалын эсэргүү, японы тагнуул гэх хилс хэрэгт нийт 25824 хүн ялласнаас 20474-ийг буудан хороож, 5103 хүнд 10 жил хорих, 240 хүнд 10-аас доош жил хорих ял оноон 7 хүнийг суллажээ (Өлзийбаатар х.294)...”

“...Тэр үеийн монголын хүн амыг 700 мянга байсан гэж үзвэл энэ нь маш аймшигтай тоо баримт юм. Япон-Манжго улсын дунд аюултай байдал газар авч байсан энэ үед шөнө болгон ачааны машинаар хүмүүсийг олноор нь зөөн буудан хороож байсныг амьсгаа түгжин сонсож байсан хэмээх дурдатгалуудыг энд дахин нуршихаа больё...”

Судлаач миний бие ОХУ-ын улс төрийн хэлмэгдэгсдийн “Мемориал” сангийн АНУ-ын Соросын сангийн санхүүжилтээр явагдсан судалгаан дээр үндэслэгдсэн каталогийг нягтлан үзэж, ойролцоогоор 40 гаруй Монголын харьяат хүний нэрсийг товч дүгнэлттэйгээр тодруулсныг товч дурдсу ...

### **Иш татсан ном, архивын баримт**

1. Г.АРИУНБОЛД “Нармай Монголизм”-ын (“Панмонголизм”)-ын хэрэгт хэлмэгдсэн монголчууд. (1937-1941), УБ. 2011.
2. Г.АРИУНБОЛД “Нармай Монголизм”-ын (“Панмонголизм”)-ын хэрэгт хэлмэгдсэн монголчууд. (1937-1941), УБ 2013.

## УГСАА ЗАЛГАМЖИЛСАН ЗАСАГ НОЁДЫГ ХЭЛМЭГДҮҮЛСЭН АСУУДАЛ



*Н.Батболд  
Магистр  
ТЕГ-ын Тусгай архив*


**Товч агуулга:** Угсаа залгамжилсан сүүлчийн засаг ноёдоос эдүгээ 34 засаг ноён хэлмэгджээ. Тэдгээрээс 14 засаг ноён 1930-1932 оны хооронд хөрөнгө дарагдуулсан, цуурхал тараасан, зэвсэгт бослого гаргах гэсэн үндэслэлээр 2-10 жил хорихоос эхлээд ялын дээд хэмжээгээр шийтгэгджээ. 1937 оны их хэлмэгдүүлэлтэд угсаа залгамжилсан засаг ноёдыг тайж язгууртай хэмээн хэлмэгдүүлэхдээ тэдгээрийн төрөл тайж, эцэг хүү хоёрыг хамтад хэлмэгдүүлжээ.

**Түлхүүр үг:** Угсаа залгамжлал, хошуу, засаг ноёд, хөрөнгө хураалт, хэлмэгдүүлэлт.

Монгол Улсад өрнөсөн их хэлмэгдүүлэлтэд өртсөн хүмүүсийн нэгээхэн хэсэг нь чингисийн алтан ургийн угсаа залгамжилсан засаг ноёд, тэдгээрийн удмынхан байв.

“Зарлигаар тогтоосон хууль зүйлийн бичиг”-г тогтоосноор: “Түшээт хан аймаг 21 хошуу, Сэцэн хан аймаг 25 хошуу, Сайн ноён хан аймаг 25 хошуу, Засагт хан аймаг 20 хошуу, Дөрвөдийн зүүн гарын Бат-Ерөөлт төгс Хүлэг Далай ханы аймаг 12 хошуу, баруун гарын Үнэн Зоригт ханы аймаг 15 хошуу”-тай байхаар тус тус заасан байдаг. Олноо өргөгдсөн Монгол Улсын үед Баргаас тасарч Халхад дагаар орсон Манлай ван Дамдинсүрэнд үе улиран хошуу захирах эрх олгосноор Сэцэн хан аймагт 1912 онд нэг хошуу, Л.Сумъяаг үе залгамжлан хошуу захирах эрх ялгуун баатар бэйс цолоор шагнаснаар Түшээт хан аймагт 1918 онд нэг хошуу тус тус нэмэн байгуулагджээ.





(Богд хаант Монгол Улсын засаг захиргааны бүтэц)

1921 онд Ардын хувьсгал ялж орон нутгийн засаг захиргааны бүтцийг өөрчлөн шинэчлэх хүртэл Монгол Улс 6 аймаг, 118 хошуу<sup>1</sup>-тай байжээ. Эдгээр 118 хошуудыг угсаа залгамжлан захирч байсан засаг ноёдын хувь заяаны асуудлыг хэрхсэн бэ?, Тэдгээрээс хичнээн ноёд юуны учир хэлмэгдсэнг ТЕГ-ын Тусгай архивын баримт материалд тулгуурлан өгүүлэхийг зорилоо.

ТЕГ-ын Тусгай архивын сан хөмрөгийг шүүн үзэхэд Түшээт хан аймгаас 5, Сэцэн хан аймгаас 12, Сайн ноён хан аймгаас 8, Засагт хан аймгаас 5, Дөрвөд далай хан аймгаас 4 засаг ноён хэлмэгдсэнг одоогоор тогтоогоод байна. Мөн засаг хэргэмээ залгамжлуулан өгсөн хойноо хэлмэгдсэн Илдэн жүн ван М.Доржпалам зэрэг нилээдгүй засаг ноёд байна.

Эдгээр угсаа залгамжилсан гучиндөрвөн засаг ноёд, тэдгээрийн хамт хэлмэгдсэн нэг угсаа гарвал бүхий тайж нарын хэрэг материалыг шүүн үзэхэд хэлмэгдүүлэлтийн асуудлыг:

1. Хөрөнгө хураалт ба засаг ноёдыг хэлмэгдүүлж эхэлсэн нь,
2. Засаг ноёд их хэлмэгдүүлэлтэнд өртсөн нь хэмээн хоёр ангилан авч үзэж болохоор байна.

1 Сономдагва,Ц. Монгол улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт. (1691-1997) 2 дугаар хэвлэл.

**Нэг. Хөрөнгө хураалт ба засаг ноёдыг хэлмэгдүүлж эхэлсэн нь:**

1922 оны 3 дугаар сарын 31-нд Ардын Засгийн газраас баталсан Ардын төрийн албан татварын түр дүрэмд феодалуудаас албан татвар хураах тухай заахдаа “засаг ба засаг бус ван, гүн, хутагт, лам нар, жич зарлиг лүндэн ба гавьяа зүтгэлээр алба хугацагдсан аливаа түшмэд тайж ардын хөрөнгөнөөс элдэв албан татварыг цөм бусдын адил нийгэмчлэн гаргуулж эрхэм, доод гэж ялгаварлан үзсэн шүүмжлэлгүй болговол зохино”<sup>2</sup> гэжээ. Хувийн аж ахуйтнаас албан татвар хураах түр дүрэмд мөн энэ тухай заахдаа “Анх удаагийн нэг зуун түмэн ланг ийнхүү хураахад өөр өөрийн аймгийн доторх тамга бүхий, үгүй хутагт хувилгаад ба засаг ба засаг бус ноёд, түшмэд тайж нар хэмээн ялгалгүй одоогийн баян үгээгүй байдалд тэнцүүлж мөнгө малыг гаргамой”<sup>3</sup> гэсэн байх бөгөөд энэхүү дүрмээр хар, шар феодалууд, ардын нэгэн адил албан татвар төлөх үүрэгтэй болсон байна.

Албан татварын анхны дүрмийг боловсронгуй болгох тухай асуудлыг 1923-1924 онуудад бүх аймгуудад ардын хурлуудаар авч хэлэлцэхэд ард олноос албан татварыг нийт аж ахуйтанд жигдээр оноож байгаа нь зохилдохгүй бөгөөд феодалын аж ахуйд өсгөн нэмэгдүүлэх журмаар оноож, тэдгээрийн эдийн засгийн хүч чадлыг нь эвдэн устгахад чиглүүлэх нь зүйтэй гэж үзэцгээсэн байна.

1924 оны 11 дүгээр сард хуралдсан БНМАУ-ын анхдугаар их хурал дээрх байдлыг харгалзан үзэж феодалын аж ахуйд ногдох татварыг өсгөн нэмэгдүүлэх зарчмыг баримтлах нь зүйтэй гэж зааж байсан төдийгүй 1926 оны 2 дугаар сард албан татварын шинэ хуулийг батлан гаргажээ.

Энэхүү татвар ногдуулах, хөрөнгө хураах асуудлыг эхлүүлэхийн өмнө, засаг ноёдын эрх, хэм хэмжээг хязгаарлах арга хэмжээнүүдийг явуулжээ. Тухайлбал: 1921 оны 9 дүгээр сард Намын Төв хорооноос улс орны дотоод байдлын тухай асуудлыг авч хэлэлцээд “олон хошуудын хамжлагуудыг боолын байдлаас чөлөөлөн гаргаж улсын харьяат болгон тусгай дүрэм хэмжээ гаргахыг чухал болгон даруй зарлабаас зохино”<sup>4</sup> гэж тогтоожээ. Хамжлага нарыг чөлөөлөх тухай асуудлыг Ардын засгийн газар хэд хэдэн удаа авч хэлэлцэн 1922 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр хамжлагат ёсыг халах тухай тогтоол гаргасан бөгөөд түүгээр ноёд, тайж нарын хамжлага нарыг сумын эрийн тоонд шилжүүлэн оруулахаар тогтжээ. Мөн оны 11 дүгээр сарын 23-нд гаргасан тогтоолоор хамжлага захирах эрхийн тамгыг хурааж, “... үүний урьд аливаа сул ван, гүн нарын хамжлагыг нэгэнт устгасан болох тул одоо тэднийг тахилгалан хадгалахад татгалзах зүйлгүй. Гагцхүү өөрийн ба албан зүйлд даран хэрэглэж үл болохоос гадна

2 Гончигсүрэн.Б МАХН-аас явуулсан албан татварын бодлого. (1921-1940/. УБ.,1973. Тал-65-66

3 Мөн тэнд

4 “Уриа” сонин. 1921 оны 9 дүгээр сарын 14-ний 6 дугаар дугаарт. (дам/

аливаа албан бичигт ... бичих явдлыг бүрмөсөн устган зогсоовол зохих ба харин үүнээс өөр хамжлага ардыг захирах тамга олгосон газар бий аваас шууд татан хураавал зохино”<sup>5</sup> хэмээн заажээ.

1922 онд Адын Засгийн газрын хурлаар: “Монголын олон засаг ба засаг бус ван гүнгүүдийн эрх хэмжээний дүрэм”<sup>6</sup>, 1923 оны 3 дугаар сарын 22-нд “Монгол Улсын нутгийн захиргааны дүрэм”<sup>7</sup>-ийг батлан гаргаснаар засаг ноёдын улс төр хийгээд бусад эрх ямбаны асуудлыг бүрэн шийдвэрлэжээ. Гэвч “Монголын олон засаг ба засаг бус ван гүнгүүдийн эрх хэмжээний дүрэм”-ийн гуравдугаар зүйлд: засаг дарга ба сул ван гүнгүүдийн эрдэм чадлыг нь үзэж, улс төрийн аливаа хүнд хөнгөн албан тушаалд нэгэн адил сонгон хэрэглэнэ хэмээн заасны дагуу засаг ноёд хэргэм зэргээсээ татгалзан энгийн хар болж эрдэм мэдлэг, оюун чадлаа Монгол улсын төлөө зориулан улс төрийн албыг хашиж байжээ. 1928 оны бүрэн бус мэдээгээр “4 аймаг, хошууны дарга, гишүүдээр сонгогдсон 259 хүний 47 нь тайж, 88 нь хуучны түшмэдүүд байсан”<sup>8</sup> байна. Засаг ноёдыг нутгийн захиргааны байгууллагад улиран сонгогдож буйг эсэргүүцэх явдал нилээд гарч байжээ. Тухайлбал: МАХН-ын гишүүн Дэндэвээс: “олон харьяат газруудад нутгийн захиргаа байгуулахад хуучин засаг ноёдыг их төлөв устган, зарим нь хуучин засгуудыг хэвээр батлан бүхий нь одоо үүнээс урагш БНМАУ-ын үндсэн ёсыг дагуулан энэ завсар батлагдсан ба үл батлагдсаныг ялгаварлахгүй хуучин засгуудыг засаг даргад батлахыг хэрэгсэхгүй болгох тухай”<sup>9</sup> шүүмжлэлийг тавьж байжээ.

БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчид ба засгийн газрын эрхлэх товчооны хамтарсан хурлаас 1929 оны 9 дүгээр сарын 16-нд феодал ангийн мал хөрөнгийг хураах ажлыг эхлэн явуулах тухай шийдвэр гаргаж, орон нутгуудад хөрөнгө хураах комиссыг байгуулан 1930 он хүртэл хөрөнгийг хурааж дуусгажээ. Энэхүү хөрөнгө хураах явцад 100 хувь үл хүрэх хөрөнгөтэй Сайн ноён хан аймгийн Эрх гүний хошууны засаг ноён Ү.Содномбигмэддорж зэргийн нилээдгүй хүмүүсийг хөрөнгө хураахаас хэлтрүүлсэн байна. Гэвч 1930 оны 2 дугаар сард хуралдсан МАХН-ын 8 дугаар их хурлаар феодалуудын мал хөрөнгийг нягтлан бүртгэж дахин хураалт явуулахаар шийдвэрлэжээ. Энэхүү 2 дахь удаагийн хөрөнгө хураалтын ажлыг гүйцэтгэх хэрхэн явуулах санал боловсруулахыг ДХГ<sup>10</sup>-г даалгаж, энэ дагуу тус байгууллагаас “феодалуудын улс төр, эрүүгийн үйлдэл, холбогдлыг ашиглах

5 Минис.А МАХН-аас феодал ангийн улс төр, эдийн засгийн ноёрхлыг устгахын төлөө явуулсан тэмцэл./1921-1930/. УБ.,1968. Тал-104

6 Монгол Ардын хувьсгалт намын түүхэнд холбогдох баримт бичгүүд. УБ.,1966. Тал-118

7 Монгол Ардын хувьсгалт намын түүхэнд холбогдох баримт бичгүүд. УБ.,1966. Тал-121-122


8 Минис.А МАХН-аас феодал ангийн улс төр, эдийн засгийн ноёрхлыг устгахын төлөө явуулсан тэмцэл./1921-1930/. УБ.,1968. Тал-150

9 Монгол Ардын хувьсгалт намын түүхэнд холбогдох баримт бичгүүд. УБ.,1966. Тал-77

10 Дотоодыг Хамгаалах байгууллага 1922 онд байгуулагдаж орон нутагт суух төлөөний түшмэдээр дамжуулан хошуудийн тайж, лам, хар зэрэг ардуудын бүртгэл мэдээлүүдийг цуглуулж байсан. 1925 оноос өөрийн салбар ангиудыг орон нутагт байгуулан ажилласан.

санал” төлөвлөн 1931 оны 1 дүгээр сарын 13-нд Улсын бага хурлын даргад уламжилсан байна. ДХГ, Улсын бага хурлын тэргүүлэгчдийн саналыг Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарын 6 дугаар хурлаар зөвшөөрч, ДХГ 1931 оны 2 дугаар сарын 14-нд ажлын заавар боловсруулж, феодалыг хөрөнгө хураалгасан, хувь үл хүрсэн, нуун дарснаар ангилан хөрөнгөө нуун дарсан феодал, эрүү, улс төрийн хэрэг өдүүлсэн бол шүүхэд шилжүүлэх, 100-гаас дээш хувьтайг улс төр, эрүүгийн хэрэгт холбогдуулж хураах, 1929-1930 онд ёс журмын дагуу хураагаад үлдээсэн хөрөнгө нь өсөн 100, түүнээс дээш хувь хүрснийг дахин хураалгүй орхих, хэргийг шүүхээр хэлэлцэн шийдвэрлэх, орон нутгийн намын байгууллагатай харилцан ажиллахыг харьяа байгууллагууддаа даалгажээ.

ДХГ-аас хоёр дахь удаагийн хөрөнгө хураалтыг явуулахдаа засаг ноёдыг хөрөнгө нуун дарагдуулсан, мөн 1930 оны Төгс буянтын хийдийн бослого, 1932 оны Тариатын хүрээний бослогод оролцсон, цуурхал тараасан зэрэг хэргүүдийг тулган шүүхэд шилжүүлэн таслан шийтгэж эхэлжээ. Тухайлбал: Түшээт хан аймгийн Эрдэнэ дайчин ван Х.Жамбалдоржийг 1930 онд, Сайн ноён хан аймгийн Цогтой гүн Д.Гомбосүрэнг 1930 онд, Дархан чин ван Н.Пунцагцэрэнг 1932 онд, Сэцэн хан аймгийн Эрдэнэ гүн С.Пунцагдэжидийг 1932 онд, Эрдэнэ далай ван Н.Наваанцэрэнг 1933 онд тус тус ялын дээд хэмжээгээр, Мэргэнван Ананд-Очирын Магсаржавыг хөрөнгө дарагдуулсан хэргээр 3 жил, Сэцэн хан аймгийн Илдэн жүн ван Д.Жамьянчойжилсүрэнг 1932 онд 3 жил хорих, Чин ачит бэйс С.Тогтохыг 1932 онд 10 жил хорих, Сэцэн ван Ю.Гомбосүрэнг 1932 онд 5 жил хорих, Сайн ноён хан аймгийн Үйзэн засаг Д.Бат-Очирыг 1932 онд 8 жилээр хорих, Илдэн бэйл Д.Норовжанцанг 1932 онд 4 жил хорих, Засагт хан аймгийн Илдэн засаг Ж.Гомбосүрэнг 1932 онд 5 жил хорих, Ёст бэйл Ч.Ширбазарыг 1931 онд 5 жил хорих, Дөрвөд далай хан аймгийн Дачин ван Н.Самданжамцыг 1929 онд зэвсэг дарагдуулсан хэмээн 1 жил 6 сар хорих, 1932 онд хувьсгалын эсэргүү хэрэг өдүүлсэн хэмээн 10 жил хорих ялаар тус тус шийтгэжээ.



*(1929-1932 онд улс төрийн хэрэгт ял шийтгэгдсэн засаг ноёд)*

Угсаа залгамжилсан засаг ноёдоос 1929-1932 оны хооронд 13 засаг ямар нэгэн хэмжээгээр ял шийтгүүлж байсан төдийгүй эдгээрээс 5 засаг ноёдыг ялын дээд хэмжээгээр шийтгэжээ. Эдгээр засаг ноёдоос гадна хөрөнгө хураалгаснаас өөр бүртгэлгүй, ялын тогтоолгүй Засагт хан аймгийн Эрдэнэ бэйл А.Гүнсэнсүрэн, Дархан гүн М.Доржжанцангарамжав, Цогт засаг З.Дамдин-Абишаа нарын ноёд байна. Хөрөнгө хураалтын үр дүнд угсаа залгамжилсан засаг ноёд хөрөнгийн хувьд хоосорч зарим ноёд айл хэсүүчилэн амьдрахад хүрч байжээ.

Тухайлбал: Түшээт хан аймгийн Мэргэн ван Ананд-Очирын Магсаржав 1938 оны 5 дугаар сарын 25-нд өгсөн анхны мэдүүлэгтээ: “Эдүгээ орон гэргүй өргөмөл хүүхэн Дальмаагийн хамт хоёр биеэр айл хэсүүчлэн явж буй. Хөрөнгийн зүйл огт үгүй”<sup>11</sup> хэмээн дурджээ.

### **Хоёр. Засаг ноёд их хэлмэгдүүлэлтэд өртсөн нь:**

Хөрөнгө хураалтын үеэр ял шийтгэлд холбогдож байсан, хоцорч үлдсэн засаг ноёдыг улс төрийн хилс хэрэгт угсаа гарвал, урдын хэргэм зэрэгтэй явснаар нь холбогдуулан дайчлан баривчилж хэлмэгдүүлжээ.

1935 оны 4 дүгээр сарын 30-нд ДХГ-аас Дорнод аймгийн Дэчин гэгээний хийдийн тив лам Буян-Оршихын Агваанжамьян буюу Жамьяндивийг ардын засгийг устгаж феодалын төрийг сэргээн японы колони болгох зорилгоор зэвсэгт бослого гаргахаар бэлтгэж байсан хэргээр дайчлан баривчилсан боловч Улсын Бага Хурлын тэргүүлэгчдээс суллах шийдвэр гаргаж Улаанбаатар хотод байнга суулгаж хяналтандаа байлгахыг ДХГ-т даалгаж байжээ. Улмаар Тив лам Жамьяндивээс 1936 онд дахин байцаалт авч “Ёнзон хамба

11 ТEG-ын Тусгай архив. Сан-5, хн-3912, тал-102



Лувсанхаймчиг бол бүх монголын хувьсгалын эсэргүү лам нарын толгойлогч” гэсэн утгатай мэдүүлэг авч “Гандан хүрээн дэх эсэргүү бүлгэмийн хэрэг” гэгчийн сэдэн гаргаж иржээ. Ингээд 1937 оны 10 дугаар сарын 7-нд ардын хувьсгалт засаг төрийг устгаж, хуучин эзэрхэг хаант төрийг байгуулах зорилготой лам нарын удирдах төв хэрэгт Ёнзон хамба Ц.Лувсанхаймчиг, дэд хамба Б.Дамдин, Манзушир хутагт С.Цэрэндорж нарын 23 хүнийг шийтгэснээр бусад лам, засаг ноёдыг төрийн эсрэг бүлэг хэрэгт зохиомлоор холбон шийтгэх болжээ.

Тухайлбал: 1938 оны 3 дугаар сарын 18-нд ДЯЯ-ны Хөвсгөл аймаг дахь хэлтсээс хуучин Сайн ноён хан аймгийн Эрх гүний хошууны засаг байсан Ү.Содномбигмэддоржийг “хувьсгалт засаг төрд эсэргүүцэн тэмцэх зорилгоор эсэргүү ажиллаж буй материалтай”<sup>12</sup> хэмээн баривчилжээ. Ингэж баривчлахдаа тус хошууны хил залгаа Мэргэн гүн, Цогтой гүн хошууны тайж гарвалтай С.Сампилдэндэв, Санжаажав нарын хүмүүсийг мөн дайчилсан байна.


Эрх гүн Ү.Содномбигмэддоржийг байцаахдаа: “Таны бие ер нь энэ ардын засаг төрд угаас дургүй байсан ба учир юу?, Чухам ардын засаг төрийг устгахын тулд ямар эсэргүү ажил хийж байсан бэ?” гэсэн асуултыг тавьж байжээ.

Эрх гүнээс: “Манай нутаг бөгөөд феодал Сампилдэндэвийн бие 28 онд хавар нэг өдөр манай гэрээр ирсэн бөгөөд тэрхүү Сампилдэндэвээс чамтай уулзахаар ирэв хэмээн гэрийн гадаа гарч ярилцваас хэлсэн нь чиний бие урд гүн явсан ба одоо ямарч эрх тушаалгүй байж байдаг. Иймд ер нь ардын засаг төр нь феодал болон лам нар биднийг туйлын ихээр хавчиж байдаг учрыг чиний бие сайтар мэдэж баймой. Иймд тэрээр Улаанбаатар хотын гандан ба зүүн хүрээний Ёнзон хамба ба дэд хамба Дамдин нарын удирдлага зааврыг хүлээж манай Намнан хүрээ болон өөр бусад хүрээ хийдээр энэ ардын засаг төрийг устгаж хуучны хаант засгийг дахин байгуулахын тулд ажиллаж байгаа эсэргүү бүлгэмүүд нилээд олон газруудаар зохион байгуулагдсан юм гэнэ. Энэ ажлын тухай Дожоосамбуу ба цорж Давааням нараас ярьж байсан болно. Үүнд дээрээс эрх биш бид нарын биес энэ ажилд оролцож энэ засаг төр устгах ажилд оролцох явдал нь аргагүй чухал байна хэмээн хэлсэнд миний бие ерөөс энэ ардын засаг төрд дургүй учир уг эсэргүү бүлгэмийн ажлыг дуртайгаар зөвшөөрөн элсэгдэж орсон” хэмээн мэдүүлжээ. Түүнийг Мэргэн гүний хошуу туслагчаар ажиллаж байсан Санжаа гэгчийг элсүүлсэн хэмээгээд Санжаагаас: “25 онд хаврын сүүл сараар хуучин Үржинжав гүний хүү Содномбигмэддоржийн бие миний гэрийг Сэлэнгэ голын урд дэрст булаг хэмээх газар сууж байхад нэг өдөр ирсэн ба ... тантай хэдэн үг ярих санаатай ирэв хэмээн хэлсэн нь ардын засаг төрийг устгах, хуучны эзэрхэг засгийг дахин байгуулахын тул Намнангийн хүрээний Давааням, цорж нарын зэрэг

нилээд олон хүмүүс Улаанбаатар хотын Гандан хүрээний Ёнзон хамба ба дэд хамба Дамдин нарын удирдлага зааврыг хүлээн ажиллан буй тул таны бие эрх биш энэ ажилд оролцож туслах буй хэмээн хэлэхэд миний бие дуртай зөвшөөрөн элссэн” хэмээх мэдүүлгийг авчээ.

Эрх гүнийг хошуудын тайж нарын хамт нэгээс хоёр удаа байцааж тэдгээрийг өөр хоорондоо харилцаа холбоо бүхий ардын засгийг устгах Ёнзон хамбыг өдүүлэн буй хэрэгт элсэгдэж, элдэв цуурхал тараан тагнуулын мэдээг цуглуулан Ёнзон хамбад илгээж байсан групп хэмээн шүүх цаазны бичгийн 43, 44, 47 дугаар зүйлд зааснаар дээд хэмжээгээр шийтгэжээ.

Нөгөөтэйгүүр Монгол Улсын өмнөд хилийн аймгууд хийгээд орон нутагт энгийн сууж байсан засаг ноёдыг “Монгол Улсаас урван оргон зайлж, Банчин богдтой нийлэн японы дэмжлэгийг авч ардын засгийн устгах гэж байсан” гэх зүйлээр холбогдуулан баривчилж байжээ. Тухайлбал: Мэргэн ван Ананд-Очирын Магсаржав, Цогтой гүн Бадамлэгдэнзул нарын засаг ноёд, тэдгээрийн угсаа гарвал бүхий тайж нарыг баривчлан: “Нэгд. Өөрийн хувьсгалаар алдсан эрх тушаалдаа хорсож монголын засаг төрийн байдлыг гадаадын эзэрхэг түрэмгий нарт тагнан мэдээлж, оргон гарахаар завдаж байсан. Хоёрт: Гадаадын зүүн сөнөдийн хошууны лам ... лугаа холбоо барьж гадаадад оргон гарах тухайд тэндэх газрын байдлыг заалган мэдэж байсан. Гуравт: Банчин богд ба хүчирхэг япон улс нь монголд нэвтрэн ирж ардын засгийг устгах ба хуучин хаант засгийг байгуулмой хэмээн ятгаж явсан”<sup>13</sup> хэмээн шүүх цаазны бичгийн 43, 47 дугаар зүйлд зааснаар дээд хэмжээгээр шийтгэжээ.



Нэгэн зүйлийг дурдахад: ЗХУ-ын ДХАК-ын орлогч М.П.Фриновский, БХАК-ын орлогч П.Смирнов, ЗХУ-аас БНМАУ-д суух бүрэн эрхт элчин төлөөлөгч С.М.Миронов нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчдийн 1937 оны 8 дугаар сарын 24-нд авч ирсэн японы тагнуулын байгууллагын гишүүн гэх 115 хүний нэр бүхий “Загвор” буюу “Хуйвалдаан” хэргийн нэрсийн жагсаалтын 58 дугаарт Цэцэн хан Навааннэрэн<sup>14</sup>, 68 дугаарт Дархан засаг чин ван Намжилдэндэв нарын нэрсийг бичсэн төдийгүй жагсаалтын сүүлд “СССР” гэсэн гарчиг тавьж Цэвээн Жамсранаар эхлүүлсэн 6 хүний нэрсийн 4 дүгээрт Мэргэн гүн Гомбожав<sup>15</sup>-ыг тэмдэглэсэн байна.

13 ТЕГ-ын Тусгай архив. МБЦХС, хн-3912, хуудас 102-114

14 ТЕГ-ын Тусгай архив. МБЦХС, хн-ц-2088

15 ТЕГ-ын Тусгай архив. МБЦХС, хн-3



Энэхүү “Загвор” хэргийн жагсаалтын дагуу Цэцэн хан Наваанэрэнг монголд, Мэргэн гүн Гомбожавыг ЗХУ-д баривчлан хэлмэгдүүлсэн билээ. Хэлмэгдсэн засаг ноёдоос эрдэм мэдлэг, оюун чадвараа Монгол судлалд зориулан зүтгэж байсан Мэргэн гүн М.Гомбожав<sup>16</sup>-ыг энд дурдахгүй өнгөрч болохгүй юм. Одоогоор бидний судлан тогтоогоод байгаа гучиндөрвөн засаг ноёдоос харьд хэлмэгдсэн нь Мэргэн гүн М.Гомбожав юм. Тэрээр Сайн ноён хан Түмэнхэний аравдугаар хөвүүний удамчир бөгөөд 1923 онд Мэргэн гүний хошууны засаг ноёны хэргэмийг залгамжилсан алтан ургийн угсааны ноён билээ. М.Гомбожав 1923 онд МХЗЭ-ийн гишүүнээр элсэн Нийслэл хүрээнд төлөөлөгчөөр ирснээр сургуульд сурч, Судар бичгийн хүрээлэнд ажиллаж, ЗХУ-ын Ленинград (Санкт Петербург) хотын Дорно дахины сургуульд суралцахаар томилогдож, 1927-1929 онд Франц улсад суралцаж, улмаар судар бичгийн хүрээлэнгийн томилолтоор 1930-1933 онд Буриад Монголын шинжлэх ухааны хүрээлэнд судалгааны ажил гүйцэтгэн ирж, ЗХУ-ын ШУА-д аспирантаар суралцаж байхад нь “Япон буриадын хувьсгалын эсэргүү тагнуулын байгууллагын төв” хэрэгт холбогдуулан 1937 онд баривчлан ялын дээд хэмжээгээр шийтгэсэн билээ.

Өгүүлэн буй гучиндөрвөн засаг ноёдыг хэлмэгдүүлэн баривчилж, нэгээс хоёр удаагийн байцаалтыг авч ялын дээд хэмжээгээр шийтгэхдээ тэдний төрөл тайж нарыг ч хөрөнгө хогшилгүй хэсүүлэн амьдарч буй байдлыг харгалзахгүй, хэлмэгдүүлэлтийн ажлыг гардан гүйцэтгэсэн байсан ч өөрийн тал хэмээн үлдээлгүй, эцэг хүү хоёрыг хамтад нь “тайж” язгууртай хэмээн хэлмэгдүүлсэн билээ. Тухайлбал: Илдэн жүн ван М.Доржпаламыг хүү Жамьянчойжилсүрэнгийн хамт, Мэргэн ван Ананд-Очирын хүү Магсаржавыг айлаар хэсүүлэн амьдарч байхад нь, Дөрвөд далай хан аймгийн Дачин ван Н.Самданжамцын төрөл тайж, ДЯЯ-ны ажилтан, А.Амар сайдыг хэлмэгдүүлэхэд оролцсон С.Галиндэвийг ч мөн л ялын дээд хэмжээгээр шийтгэжээ.

Эдүүгээ Монгол Улсад өрнөсөн их хэлмэгдүүлэлтэд өртсөн хүмүүсийн нэгээхэн хэсэг болох чингисийн алтан ургийн угсаа залгамжилсан засаг ноёд, тэдгээрийн удмынханы монголын түүхэнд оруулсан хувь нэмэр хийгээд тэдгээрийн хувь заяаны талаар баримталж байсан бодлого, түүний үр дагавар ураг удмынханд нь хэрхэн нөлөөлсөн асуудлыг лавшруулан судлах нь чухалтай байна.

16 Улс төрийн хэлмэгдэгсдийн намтрын товчоон. 17 дугаар боть. УБ., 2013. Тал-117

Хавсралт.

**Хэлмэгдсэн засаг ноёдын жагсаалт**

№	Хошуудын нэрс	Олноо өргөгдсөн нэршил	Ардын засгийн үеийн нэршил	Сүүдчийн засаг ноён	Залгамжилсан он	Хэлмэгдсэн эсэх
<b>Түшээт хан аймаг</b>						
1	Түшээт ханы хошуу	Халхын Очирбатын Түшээт ханы хошуу	Богд хан уулын аймгийн Хайрхан уулын хошуу	Дашнямын Доржсүрэнхоролжав /Дамдиндорж/	1921-1923	Хэлмэгдсэн
2	Эрдэнэ дайчин чин вангийн хошуу	Эрдэнэ дайчин чин вангийн хошуу	Булган хан уулын хошуу	Ханддоржийн Жамбалдорж	1915-1923	Хэлмэгдсэн
3	Дархан чин вангийн хошуу	Дархан чин вангийн хошуу	Богд хан уулын аймгийн Богд хан уулын хошуу	Намжилдэндэвийн Пунцагцэрэн	1914-1921	Хэлмэгдсэн
4	Мэргэн вангийн хошуу	Мэргэн вангийн хошуу	Богд хан уулын Хутаг уулын хошуу	Ананд-Очирын Цэсүнжав	1912-1920	Хэлмэгдсэн
5	Цогтой гүний хошуу	Цогтой гүний хошуу	Богд хан уулын аймгийн Сүүж уулын хошуу	Чадраабалын Бадамлэгдэнзул	1889-1921	Хэлмэгдсэн
<b>Сэцэн хан аймаг</b>						
1	Халхын Сэцэн ханы хошуу	Халхын Сэцэн ханы хошуу	Хан Хэнтий уулын аймгийн Өндөрхаан уулын хошуу	Дэмчиндоржийн Навааннэрэн	1910-1923	Хэлмэгдсэн
2	Илдэн жүн вангийн хошуу	Илдэн жүн вангийн хошуу	Хан хэнтий уулын аймгийн Халх гол хошуу	Доржпаламын Жамьянчойжилсүрэн	1921-1925	Эцэг Доржпаламын хамт хэлмэгдсэн
3	Сэцэн вангийн хошуу	Сэцэн вангийн хошуу	Хан хэнтий уулын аймгийн Опол Сансар уулын хошуу	Юндэндоржийн Гомбосүрэн	1908-1923	Хэлмэгдсэн
4	Эрдэнэ далай вангийн хошуу	Эрдэнэ далай вангийн хошуу	Хан хэнтий уулын аймгийн Мөнх хаан уулын хошуу	Намсрайжавын Наваанцэрэн	1919-1923	Хэлмэгдсэн
5	Үйзэн вангийн хошуу	Үйзэн вангийн хошуу	Хан хэнтий уулын аймгийн Матад хан уулын хошуу	Дорж-Юлжиндогийн Гомбосүрэн	1913-1921	Хэлмэгдсэн
6	Эрх гүний хошуу	Эрх гүний хошуу	Хан хэнтий уулын аймгийн Өлзийт уулын хошуу	Цэрэндоржийн Пунцагпадайнамжил	1914-1921	Хэлмэгдсэн

7	Мэргэн гүний хошуу	Мэргэн гүний хошуу	Хан хэнтий уулын аймгийн Өндөрцагаан уулын хошуу	Цэрэнгомбын Цэрэнвандуйбавуудорж	1911-1923	Хэлмэгдсэн
8	Эрдэнэ гүний хошуу	Эрдэнэ гүний хошуу	Хан хэнтий уулын аймгийн Батхан уулын хошуу	Санванцэрэндоржийн Пунцагдэжид	1908-1921	Хэлмэгдсэн
9	Саруул гүний хошуу	Саруул гүний хошуу	Хан хэнтий уулын аймгийн Түшлэг хан уулын хошуу	Дамдинжавын Дамдинжав	1903-1921	Хэлмэгдсэн
10	Чин ачит бэйсийн хошуу	Чин ачит бэйсийн хошуу	Хан хэнтий уулын аймгийн Баянтүмэн хан уулын хошуу	Сансрайдоржийн Тогтох	1918-1923	Хэлмэгдсэн
11	Зоригт бэйсийн хошуу	Зоригт бэйсийн хошуу	Хан хэнтий уулын аймгийн Дашбалбар уулын хошуу	Лхамсүрэнгийн Мишигдорж	1903-1921	Хэлмэгдсэн
12	Манлай вангийн хошуу	Манлай баатар ван Дамдинсүрэнгийн хошуу	Амгалан хан уулын хошуу	Дамдинсүрэнгийн Долсон	1917	Хэлмэгдсэн
<b>Сайн ноён хан аймаг</b>						
1	Цэцэн чин вангийн хошуу	Цэцэн чин вангийн хошуу	Хан-Өндөр уулын хошуу	Дарамын Наянт	1874-1921	Хэлмэгдсэн
2	Үйзэн засгийн хошуу	Үйзэн вангийн хошуу	Цэцэрлэг Мандал уулын аймгийн Арвайхээр уулын хошуу	Дэчинравдангийн Бат-Очир	1911-1923	Хэлмэгдсэн
3	Илдэн бэйлийн хошуу	Илдэн бэйлийн хошуу	Цэцэрлэг Мандалын уулын аймгийн Өлзийт уулын хошуу	Довдонжанцангийн Норовжанцан	1915-1923	Хэлмэгдсэн
4	Цогтой гүний хошуу	Цогтой засгийн хошуу	Цэцэрлэг Мандал уулын аймгийн Баянхонгор Хайрхан уулын хошуу	Дашдоржийн Гомбосүрэн	1917-1923	Хэлмэгдсэн
5	Мэргэн гүний хошуу	Мэргэн гүний хошуу	Цэцэрлэг Мандал уулын аймгийн Рашаант уулын хошуу	Мөнх-Очирын Гомбожав	1921-1922	Хэлмэгдсэн
6	Ачит гүний хошуу	Ачит гүний хошуу	Цэцэрлэг Мандал уулын аймгийн Цэцэрлэг голын хошуу	Сэд-Очирын Довчинжамц	1907-1923	Хэлмэгдсэн

7	Эрх гүний хошуу	Эрх гүний хошуу	Цэцэрлэг Мандал уулын аймгийн Баян-Агт уулын хошуу	Үржинжавын Содномбагмиддорж	1911-1923	Хэлмэгдсэн
8	Ёст бэйлийн хошуу	Ёст бэйлийн хошуу	Цэцэрлэг Мандал Уулын аймгийн Гурвансайхан уулын хошуу	Чүлтэмийн Ширбазар (Дашням/)	1920-1923	Хэлмэгдсэн
<b>Засагт хан аймаг</b>						
1	Илдэн засгийн хошуу	Илдэн засгийн хошуу	Хан Тайшир уулын аймгийн Чандмань уулын хошуу	Жигмэддоржийн Гомбосүрэн	1898-1923	Хэлмэгдсэн
2	Эрдэнэ бэйсийн хошуу	Эрдэнэ бэйсийн хошуу	Хан Тайшир уулын аймгийн Сутай хайрхан уулын хошуу	Аюурсэдданзанжамцын Гүнсэнсүрэн	1901-1921	Хэлмэгдсэн
3	Дархан гүний хошуу	Дархан бэйлийн хошуу	Хан Тайшир уулын аймгийн Цэцэг нуурын хошуу	Маньбазарын Доржжанцангарамжав	1918-1923	Хэлмэгдсэн
4	Цогт засгийн хошуу	Цогт вангийн хошуу	Хан Тайшир уулын аймгийн Нөмрөг уулын хошуу	Загдсамбарын Дамдин-Абишаа	1895-1922	Хэлмэгдсэн
5	Ахай бэйсийн хошуу	Ахай бэйлийн хошуу	Хан Тайшир уулын аймгийн Наранжаргалант уулын хошуу	Няланбарын Цэдэндорж	1905-1923	Хэлмэгдсэн
<b>Төгс хүлэг Дөрвөд далай хан аймаг</b>						
1	Дөрвөд далай хан аймаг	Дөрвөд хошуу	Төгс буянт уулын хошуу	Галсаннамжилын Түмэндэлгэржав	1912-1921	Хэлмэгдсэн
2	Дайчин засаг төрийн жүн ваны хошуу	Дайчин вангийн хошуу	Чандмань уулын аймгийн Баян мандал уулын хошуу	Насанбуянгийн Самданжамцай	1906-1921	Хэлмэгдсэн
3	Эрдэнэ гүний хошуу	Эрдэнэ гүний хошуу	Чандмань уулын аймгийн Баянмандал уулын хошуу	Очирын Минжүүрдорж	1914-1921	Хэлмэгдсэн
4	Эетэй засгийн хошуу	Эетэй гүний хошуу	Чандмань уулын аймгийн Баянмандал уулын хошуу	Өлзийбаярын Жанжинбал	1919-1921	Хэлмэгдсэн

### Ном зүй

1. Алтанхуяг.А, Монгол Улсын Улсын аюулгүй байдлыг хангах байгууллагын түүхэн тойм. УБ.,1992
2. Болдбаатар.Ж, Монгол Улсын төр эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997
3. Батболд.Н, С.Галиндэвийн намтар, үйлажиллагааг тодорхуулахуй. МУИС.Түүх эрдэм шинжилгээний бичиг. №474/36/.УБ.,2017
4. Гончигсүрэн.Б, МАХН-аас явуулсан албан татварын бодлого./1921-1940/.УБ.,1973
5. Улс төрийн хэлмэгдэгсдийн намтрын товчоон. 17 дугаар боть. УБ., 2013
6. Минис.А, МАХН-аас феодал ангийн улс төр эдийн засгийн ноёрхлыг устгахын төлөө явуулсан тэмцэл.УБ.,1968
7. Монгол Ардын хувьсгалт намын түүхэнд холбогдох баримт бичгүүд. УБ.,1966
8. Монголын үндэсний хувьсгал-95.УБ., 2007
9. Монгол Улсын аймаг, хошуу, сумын товчоо.УБ., 2014
10. Мөнхбаяр.Х, Говын ёст засгийн хошуу ба Улиастайн сайд Чүлтэм бэйл. УБ., 2012
11. Кузьмин.С.Л, Социализмын эсрэг 1932 оны монгол дахь бослого. УБ., 2014
12. Сүхбаатар.Д, Хасбаатар.Т, Монгол улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хуваарилалтын түүхэн уламжлал.УБ., 2011
13. Сономдагва.Ц, Монгол улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт. (1691-1997) 2 дугаар хэвлэл
14. Цэрэнбалжир.Д, 1932 оны хувьсгалын эсэргүү зэвсэгт бослогыг дарахад дотоодыг хамгаалах газрын гүйцэтгэсэн үүрэг. УБ.,1986

### Ашигласан цахим сан, хуудас.

1. [www.mongoltoli.mn](http://www.mongoltoli.mn)
2. ТЕГ-ын Тусгай архив. Цахим сан.

## МОНГОЛД ГАРСАН УЛС ТӨРИЙН ХЭЛМЭГДЭЛ, ТҮҮНИЙ ХОР УРШИГ

*Монголын төрийн тэргүүн Лосолын Лааганы жишээн дээр*



*О.Батсайхан  
Доктор (Sc.D) Монгол Улсын Төрийн  
соёрхолт  
ШУА-ийн ОУХХ, Удирдлагын Академи*

XX зуунд коммунизмын дэглэмийн дор Монгол оронд гарсан улс төрийн хэлмэгдэл нь Монгол үндэстэний оршихуйн үндсийг тасалж, үндэсний ой санамж, үндэсний уламжлал, соёл, эх бичиг, эх түүх тэргүүтэй үнэт зүйлсээ гээхэд хүргэсэн юм. Үүний хор уршиг одоо хэр арилаагүй байна. Учир нь хэлмэгдэл хэмээх хорт үзэгдэл монгол хүн бүрийг, монгол өрх бүрийг дайрсан гэхэд болно. Гинжин урвал мэт нэгийг нь нөгөөгөөр нь хөнөөлгөсөн эл хэлмэгдэл монгол үндэстэний оршихуйн үндсийг тасалжээ. Ийм байхад энэхүү үндэсний хэмжээнд явагдсан улс төрийн хэлмэгдлийн талаар улс төрийн дүгнэлт гаргахгүйгээр үнэн мөнийг тогтоож чадахгүй юм. Улс төрийн хэлмэгдлийн хамарсан хүрээ, цаг хугацааг аваад үзсэн ч эл асуудлын эрэг шураг төдийг шүүхээр цагаатгаснаас хэтрэхгүй байна.

Орчин үеийн Монголын түүхэнд 1911 оноос 1990 он хүртэлх төрийн тэргүүн, засгийн газрын тэргүүн, МАХН-ын тэргүүнээр нийт давхардасан тоогоор 33 хүн (нарийн бичгийн дарга нар ороогүй) ажилласанаас 8 хүнээс бусад нь ямар нэгэн хэмжээгээр хэлмэгдсэн буюу учир битүүлэг эсвэл харийн оронд нас барсан байна. Ийм дүр зургаас үзвэл, эл үед эгэл нэгэн монгол хүний эрх, аюулгүй байдлын тухай асуудал ярих ямар ч утгагүй байсныг тодорхой харж болно.

Орчин үеийн Монголын төрийн тэргүүнээр 1911 оноос 1990 он хүртэл 11 хүн ажиллаж байснаас хэлмэгдсэн болох нь албан ёсоор тогтоогдсон 5 хүн байна.

1. Пэлжидийн Гэндэн - Зүүнтэн мөн шинэ баруунтан,
  2. Ж. Дамдинсүрэн - баруунтан
  3. Л.Лааган - зүүнтэн
  4. А.Амар - баруунтан
  5. Д.Догсом -
- Мөн албан ёсоор цагаатгагдсан байна

Харийн оронд “нас барсан”

1. Хорлоогийн Чойбалсан
  2. Ю.Цэдэнбал
- Учир битүүлэг буюу гэнэтээр нас барсан:
1. Наймдугаар Богд Жавзандамба хутагт
- 

Нийт: 8 хүн

Үлдсэн 3 хорвоогийн жам ёсоор таалал төгссөн:

1. Г.Бумцэнд
2. Ж.Самбуу
3. Ж.Батмөнх

Коммунизмын үеийн түүхэнд баруунтан, зүүнтэн хэмээн хүмүүсийг хооронд нь хуваан анги ялгаварлан авч үзсэн нь бий. Тэгвэл, баруунтан хэмээх нь ЗХУКН-ын чиг шугамыг эсэргүүцэгч, үндэсний үзэл баримтлагчид байсан тул хэлмэгдэлд өртөх магадлал хамгийн өндөр байжээ гэж үзэж болно байх. Харин зүүнтэн нь ЗХУКН-ын чиг шугамыг дагагч буюу зүүний чиг баримтлагч байсан хүмүүс юм, гэтэл тэд ч гэсэн мөн л хэлмэгдсэн байх юм. Энэ удаа БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн даргаар 1930-1932 онд ажиллаж байсан Лосолын Лааганы хувь заяаны талаар өгүүлэх юм.<sup>1</sup>

**Түлхүүр үгс:** Улс төрийн хэлмэгдэл, Японы тагнуул, төрийн тэргүүн, Лосолын Лааган, цагаатгал, Орчин үеийн Монголын түүх, хэлмэгдэгсэд

Амьдралдаа 3 удаа (1928, 1934, 1937 онуудад) улс төрийн хилс хэргийн золиос болж, шорон гянданаа хоригдаж байгаад амь насаа егүүтгүүлсэн Монгол улсын төрийн тэргүүн асан Лосолын Лааганы эмгэнэлт хувь заяаны талаар энэхүү илтгэлдээ өгүүлнэ.

Амьд явах хугацаа нь цаг, хормоор хэмжигдэж байсан тэр мөчид: “Би өөрийн эх орноосоо урвасан хувьсгалын эсэргүү байгууллагад оролцож ажилласан удаа огт байхгүй”<sup>2</sup> “Би аль ч эсэргүү хэрэгт ороогүй боловч Дотоод яамны хатуу тулгалт, зодуур, жанчуурт эс

1 О.Батсайхан Лосолын Лааган: Төрийн тэргүүний хувь заяа УБ., УБ., 2007 он.  
2 НАХБ-ын ТА. Ф-МБ. Х.н.1967, 71 дэх тал (Тагнуулын сронхий газрын архив)



тэсвэрлэн худал мэдүүлэг гаргаж байсан”<sup>3</sup> хэмээн Лааган 1940 оны 5 дугаар сард болсон шүүх хурал дээр сүүлчийн үгээ хэлжээ.

Тиймээ “Японытагнуул”, “Хувьсгалын эсэргүү нууц байгууллагын гишүүн” хэмээх хилс хэргүүдийг бүтэн хоёр жил долоон сар шахам хугацаагаар тулгуулан, өдөр тутам зодуулан жанчуулж, халуун хүйтэн өрөө дамжуулан байцаалгаж байсан хүний амьдралын сүүлчийн үгс энэ. 1940 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн Улсын дээд шүүхийн 17 дугаар хурлаас түүнд “буудан алах ял” оноожээ. Ус уух хоногийнх нь хугацаа дуусаж байгааг мэдэрсэн тэрбээр ямарч л байсан “Би эх орноосоо урваж, хувьсгалын эсэргүү болоогүй шүү” гэдгээ хойч үедээ хэлжээ.

Төрийн, тэргүүн байхдаа олон хүний хувь заяаг шийдэхэд оролцож явсны хувьд тэрээр ямарч ялтан амь гуйх эрхтэй байдгийг мэдэх учраас эцсийн горьдлого: “буудан алах ял” аваад Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдэд амь гуйх хүсэлтээ уламжилжээ. Түүний хүсэлтийг Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1940 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 28 дугаар хурлаар хэлэлцээд **“онц хорлол бүхий жигшүүрт гэмт хэргийг өдүүлсэн заналтай дайсан этгээд”** хэмээн үзэж “уг тасалсан тогтоолыг хэвээр баталж, түүний амь гуйсныг шууд хэрэгсэхгүй” болгосноор Лааганы эцсийн горьдлого тасарчээ. Улсын Бага Хурлын тэрхүү шийдвэрийг 1940 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн баримт бичгээр Дотоод явдлын яамнаа мэдэгдсэн нь архивт үлджээ. Бодоход уг шийдвэр тэр өдрөө гүйцэтгэгдээ байх даа... Харин гүйцэтгэсэн тухай ямар нэгэн баримт олж үзсэнгүй.

## НАМТРЫН ӨЛГӨЦ

Засагтхан аймгийн Дүүрэгч вангийн хошууны ард Лосолынх амьдралын эрхээр Монголын өрнө хязгаарт (одоогийн Ховд аймгийн Буянт сум) шилжин суурьшиж Цагаан гол хэмээх газар нутаглаж ахуйдаа 1887 онд нэгэн хөвгүүнтэй болсон нь Лааган байлаа. Тэрбээр бага насандаа Наран хутагтын хүрээ хийдэд шавилан сууж байсан ба мал адгуулах, тариа тарих, өртгөө улаа нэхэх зэрэг ажил эрхэлж эрийн цээнд хүрсэн байна. Харин Л.Лааган сургуульд суралцаагүй ажээ.

Тэрбээр 1922-1923 оны үеэс Ховд хязгаарын Тариачин хошууны хурлын төлөөлөгчөөр сонгогдсон төдийгүй, улмаар 1923 оны 5 дугаар сарын 10-нд тус хошуунд анхны Ардын намын 39 дүгээр үүрийг байгуулахад сайн дураар элсэн орсон анхны гишүүдийн нэг болов.<sup>4</sup>

3 НАХБ-ын ТА. Ф-МБ. Хн.1967, 72 дахь тал (Тагнуулын ерөнхий газрын архив/

4 НТА. ф.2, д.4. хн.1, 122 дахь тал

1925 онд хуралдсан МАХН-ын IV их хуралд Л.Лааган Ховдын хязгаарын Тариачин хошууг төлөөлж оролцсон тэр үеэс нам, төрийн ажилд улам идэвхтэй оролцож эхэлжээ.<sup>5</sup>

Тэрбээр 1925-1928 онд Чандмань уулын аймгийн Намын хянан байцаахын дарга, 1928-1930 онд МАХН-ын Хянан байцаах төв комиссын дарга, 1930-1932 онд БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн даргаар ажиллаж байв. Лааган МАХН-ын IV-VIII их хуралд төлөөлөгчөөр оролцон, намын IV их хурлаас МАХН-ын Төв Хорооны гишүүн, V, VI их хурлуудаас Намын хянан байцаах төв комиссын гишүүн Намын VIII их хурлаас Намын Төв Хорооны Тэргүүлэгч гишүүн, Улсын VI их хурлаас БНМАУ-ын Бага Хурлын гишүүнээр тус тус сонгогдон ажиллаж байв. Ам бүл тавуул, 2 хүүтэй, 1 охинтой хэмээн анкетад бичигдэн үлджээ. Лааганыг гаднаас нь харахад “хөдөөний өвгөн”, гол төлөв дээл өмсдөг, ЗХУ-д одоодоо ч дээлтэй явдаг байсан гэж өвгөд дурсан ярьж байв.

## УЛС ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫХ НЬ ТАЛААР

Лааган анх хэрхэн нам, төрийн ажилд гарч ирэв?

Лааган бол хөдөөний ардын дундаас гарсан хүн. Хориод оны эхээр засаг захиргааг шинэчлэн зохион байгуулах ажил ид өрнөж, хөдөө нутагт өөрчлөлт, шинэчлэлийн уур амьсгал оргилж байсан тэр үед Ховдын хязгаарын орон нутгийн захиргааг шинэчлэн байгуулалцсан Засгийн газрын төлөөний түшмэл Догсом, түүний туслах Лувсанцэрэн нар ярихдаа: тэр үед хязгаар нутгаас нам, улсын их хуралд төлөөлөгч сонгохдоо, очоод орон нутгаа төлөөлөөд үг хэлчих чадвартай, үүргэлж сууж байгаад буцаад ирэхээргүй тийм хүнийг олж сонгож явуулах хэрэгтэй болдог байлаа. Тийм учраас Лааган бол хэрэлдвэл ч хэрэлдчихнэ, хэлэлцвэл ч хэлэлцчих хэл амтай хүн гэж үзээд түүнийг сонгож явуулсан юм хэмээн ярьсан гэж Б.Банзрагч гуай 1989 оны 3 сарын 31-нд Нийгмийн ухааны институтээс зохион байгуулсан Л.Лааганы тухай ярилцлага дээр өгүүлсэн юм.<sup>6</sup>

Л.Лааган 1925 онд МАХН-ын IV их хуралд Ховдын хязгаарын Тариачин хошууг төлөөлж оролцож, Ховдын намын хорооны илтгэлийг мөн хорооны төлөөлөгч Пүрэвийн өмнөөс уншсан байна.<sup>7</sup> Намын V их хурал (1926) дээр Жаргалант хязгаарын намын хорооны илтгэл<sup>8</sup>, намын VI их хурал (1927) дээр Чандмань уулын аймгийн намын хорооны илтгэлийг<sup>9</sup> намын VIII их хурал (1930) дээр Намын Хянан байцаах Төв комиссын илтгэлийг тавьжээ.

5 НТА. Ф.4. д.2, хн.57, 9 дахь тал

6 О.Батсайхан Лосолын Лааган: Төрийн тэргүүний хувь заяа УБ., УБ., 2007 он

7 МАХН-ын IV их хурал, УБ., 1978., 26 дахь тал

8 МАХН-ын V их хурал, УБ., 175 дахь тал

9 МАХН-ын VI их хурал, 259 дэх тал

Л.Лааган намын анхдугаар бага хурал (1930, XII, 26-1931. 1. 13) дээр “Тус улсын орон нутгийн хилийг шинэчлэн тогтоож захиргааг байгуулах явдлын тухай” илтгэл тавьж, 1931 оны хоёрдугаар сард Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн V хуралд “Тус улсын орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарилалтад өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг оруулж хэлэлцүүлэхдээ тухайн үед оршиж байсан орон нутгийн байгуулалтын хил хязгаар, засаг захиргааны нэгжүүд (5 аймаг, 12 хошуу, 525 сум)-ийг өөрчилж, “хөрөнгийн замын гадуур явуулах улсын хөгжилтийн” дагуу эдийн ба газар орны байдал, үйлдвэрлэх чадварын байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр” шинээр 13 аймаг байгуулах саналыг оруулсан байна.<sup>10</sup> Энэхүү санал нь Коминтернээс эхтэй гэдэг бөгөөд харин тэр үеийн манай нам, төрийн удирдлага маань уг саналыг улс орны эдийн засаг, ард түмний аж амьдралын өвөрмөц байдалд тохируулан тус орны нутаг дэвсгэрийг эдийн засгийн талаар ангилж, засаг захиргааны нэгжийг ард түмэнд ойртуулах бодлого хэмээн ойлгож, амьдралд хэрэгжүүлж эхэлсэн нь нүүдлийн өвөрмөц онцлог бүхий монгол орны нөхцөл байдалд тийм ч нийцсэн шийдвэр байгаагүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй болов уу.

Л.Лааганы үйл ажиллагаанд бүр 1928 оны үеэс өнгөрсөн нийгмээс уламжлагдан ирсэн бүх зүйлсийг үгүйсгэх “зүүний” үзэл хандлага илэрч байв. Тэр намын VII их хурал дээр хэлсэн үгэндээ: “V их хурал дээр Богдыг залахгүй хэмээн олон төлөөлөгчид гар өргөж, маргааш нь Жадамба Богдыг залуулахаар хэлж тогтоолгосон зүйл буй нь нэгэн зүйлийн сэдэв”<sup>11</sup> хэмээн баруунтны үүсэл тэр үеэс л эхэлсэн мэт тайлбарлахыг оролдож, “эзэрхэг”, “харгис” гэх мэтийн хувьсгалчирхсан үг хэллэгийг ухуулга, сурталчилгаанд хэлэхийг зогсоохоор гаргасан намын шийдвэрийг мөн л барууны нэг “жиг” гэж үзэж байв.

Нам, төрийн удирдлагад гарч ирсэн “зүүнтнүүд”, түүний дотор Л.Лааган Коминтернд гүнзгий итгэж, түүнийг дээдлэн дагаж, заавар шийдвэрийг нь ёсчлон дагахыг мэрийж байсан явдал улс орны хөгжлийн томоохон асуудлуудыг шийдвэрлэх үйл явцад өрөөсгөл, сөрөг нөлөө үзүүлсэн байна. Тухайлбал 1928 оны 1 сард Коминтерний Дорнод хэлтсээс МАХН-ын Төв Хорооны дарга Ц.Дамбадоржийн нэр дээр ирүүлсэн захидалд: “Холбоот Улс нь өөрийн олон газруудыг хэзээ ямагт үйлдвэрчний чанартай болгохыг оролддогын нэгэн адил та бүгд болбоос харьяат улсын ба намын олон газруудыг хөдөөгийн чанартай болгох зүг дор хандуулах ажлыг мөн хэзээ ямагт хичээх нь чухал”<sup>12</sup> хэмээн манай орны онцлог нөхцөл байдалд үл нийцсэн хэтэрхий “зүүний” өнгө аястай зорилтыг МАХН-д тулгасан нь шинэ нийгэм

10 МАХН-ын тогтоол шийдвэр, баримт бичгүүд. II боть, УБ., 1984, 249 дэх тал

11 МАХН-ын V их хурал, УБ., 175 дахь тал

12 НТА. ф.1, д.1, хн.27, 80 дэх тал.

байгуулах замд “орсон” ЗСБНХУ, БНМАУ хоёрыг эн зэрэгцүүлэн тавьж нэгнийх нь туршлагыг нөгөөд “механикаар” буулгах гэсэн үл биелэх оролдлого байв.

Ийн атал Коминтернээс ирүүлсэн захидал, зөвлөмж, тогтоол зэргийн агуулга, үзэл санаатай манай улсын нам, эвлэлийн байгууллагууд “ширхэг дараалан танилцаж” түүнийг хэрэг тутамдаа биелүүлэн гүйцэтгэх ёстой “нам ба улс төрийн хийгээд аж ахуйн зэрэг одоо үеийн хамгийн үндсэн чухал зүйлүүдийг тодорхойлон заасан” мөрийн хөтөлбөр” гэж Л.Лааган бусдын нэгэн адил үзэж байжээ.

МАХН Б.Шмераль тэргүүтэй Коминтерний нөхдийн оролцоо “туслалцаатайгаар” 1928 онд намын VII их хурал дээр “баруунтнууд болон тэдний үзэл бодол нэгтнүүдийг няцааж, намыг “үзэл суртал-зохион байгуулалтын талаар бэхжүүлэх”<sup>13</sup>, түүний удирдан чиглүүлэх ролийг “дээшлүүлэх”, хамтын удирдлагын зарчмыг бататгах, намын сахилга батыг “дээшлүүлэхийн чухлыг” заагаад ард ангийн ядуу ба дунд давхрааны тэргүүний хэсгээр намын эгнээг өргөтгөх, намд хоёр дахь цэвэрлэгээ хийх шийдвэр гаргасан нь Монгол орны нөхцөлд үл нийцсэн шийдвэрүүд байсан бөгөөд хэдхэн жилийн дараа тар нь танигдсаныг эдүгээ түүх гэрчилнэ. Нөгөө талаас Коминтерний зүгээс манай хэрэгт илэрхий оролцож байсан нь ч харагддаг юм.

VII их хурлын шийдвэрийн дагуу 1929 оны 3 дугаар сарын 19-ний өдөр МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн хурлаар<sup>14</sup> намын II цэвэрлэгээний заавар боловсруулах комисс байгуулах тухай Л.Лааганы саналыг авч хэлэлцээд Ө.Бадрах, Б.Элдэв-Очир, Д.Лосол, Р.Мэнд, Г.Содном нарын бүрэлдэхүүнтэй комиссыг байгуулав. Уг комисс намын хоёрдугаар цэвэрлэгээг явуулах заавар боловсруулж, Намын Төв Хорооны Тэргүүлэгчдийн Хуралд оруулан хэлэлцүүлсний үндсэн дээр 1929 оны 5 дугаар сард хуралдсан МАХН-ын Төв Хорооны II бүгд хурлаар батлуулжээ. Түүхэнд намын II шалгалт гэж нэрлэгдсэн энэхүү цэвэрлэгээ нь нам, төрийн удирдлагад гарч ирсэн “зүүнтний”-хний зүгээс “баруунтан” гэгдсэн, тэднийг дэмжигчдийн эсрэг чиглэсэн арга хэмжээ болсон юм.

Уг цэвэрлэгээний үеэр тайж, санваартан лам л бол феодалд тооцогдож, баруунтныхны хань хамсаатан байсан гэсэн нэрийн дор хохь тайж, ядуу лам, хувьсгалын үйл хэргийн төлөө үнэнчээр зүтгэж явсан олон олон ард иргэдийг намаас хөөх буюу намд дахин элсэх эрхийг хасаж байжээ. Тухайн үед намын гишүүн бус байна гэдэг бол төрд алба хаших буюу өөдрөг амьдралд тэмүүлэх үүд хаалга хаалттай гэсэн үг байжээ.

13 МАХН-ын 7 дугаар их хурал, УБ., 1980

14 НГА. ф.1. д.3, хн.162, 116 дэх тал

**Мөн түүнчлэн намд ядуучуудыг хэт олноор нь кампаничлан эслүүлж, данц ганц тооны хойноос хөөцөлдөх явдал ч гарч байсныг тэмдэглэх хэрэгтэй.**

МАХН “зүүний” талын бодлогод ид автагдаж, нам, төрийн бүхий л үүргийг гардан удирдаж, хэрэгжүүлж байсан тэр үед МАХН-ын VIII их хурал (1930.И.21-IV.3) хуралдаж, улс орны хөгжлийн түвшин, онцлог байдлыг үл харгалзан социализмын зорилтуудыг тунхагласан явдал<sup>15</sup> бол “зүүний” алдаа завхралыг улам лавшруулсан билээ.

Намын VIII их хурал дээр Л.Лааганы тавьсан МАХН-ын Хянан байцаах төв комиссын илтгэлд<sup>16</sup> намын II цэвэрлэгээний явцын тухай дэлгэрэнгүй мэдээлж, ололт дутагдлыг нь тэмдэглэжээ. Уг илтгэлд намын II цэвэрлэгээгээр намаас хөөгдөгсдийн жар шахам хувийг хохь тайж, ядуу лам, доод ангийн болох хүмүүс эзэлж байгааг тэмдэглэж, энэ бол “гол шугамаас хазайсан туйлын их алдагдал болмой” гэжээ. Ийнхүү “алдагдалд учруулсан нь гагцхүү хянан байцаахаас өөрийн удирдлагыг дүүрнээ өгч чадаагүйгээс”<sup>17</sup> болсон хэмээн өөртөө шүүмжлэлтэй ханджээ. Гэвч намын VIII их хурал барууны хэлбэрэлд оролцсон гэсэн нэрийн дор хувьсгалын үйл хэргийн төлөө үнэнчээр зүтгэж явсан олон хүнийг намаас хөөж байсан II цэвэрлэгээний алдаатай ажиллагааг зогсоох талаар зохих дүгнэлт хийж, дорвитой арга хэмжээ авч эс чадав.

Лааган нам, төрийн өндөр алба хашиж байх үедээ удаа дараа Ховд хязгаар, Чандмань уулын аймгаар явж, орон нутгийн ажил байдалтай танилцаж байсны зэрэгцээ Ховд хязгаарын болон бага ястны тухай асуудлаар Улсын Бага Хурал, Намын Төв Хороон дээр тусгайлан илтгэл<sup>18</sup> тавьж байжээ. Тэрээр монгол дахь бага ястны талаар санаа тавьж, ЗСБНХУ-ын Бага Хурлын дарга М.И.Калининд захидал<sup>19</sup> илгээн: олон бага үндэстэн ястны тухай тэднийг улсын дотор хэрхэн авч явуулж байгаа өөрийнхөө туршлагаас бичиж ирүүлнэ үү гэх зэргээр бичиж байсан нь архивт хадгалагджээ.

МАХН “зүүний” талын бодлогод ил автагдаж байсан тэр үед Коминтерн, түүний төлөөлөгчдийн зүгээс Монголын хувьсгал шинэ шатнаа орж байна гэсэн онолын буруу дүгнэлт хийж, Монгол оронд явуулах шинэ шатны зорилтыг тодорхойлсон захидал, зөвлөмж, тогтоол илгээж, бие төлөөлөгчдийг ирүүлж байсан явдал нь намын удирдлагад байсан З.Шижээ, Ө.Бадрах, Л.Лааган нараар дамжуулж “зүүний” алдаа завхралыг улам лавшруулахад хүргэсэн байна.

15 Намын VIII их хурлын илтгэл. I. УБ., 1930. 6-10 дахь тал

16 Намын VIII их хурлын илтгэл. I. УБ., 1930. 6-10 дахь тал.

17 Намын VIII их хурлын илтгэл. I. УБ., 1930. 6 дахь тал.

18 НТА. ф.4., д.3, хн.162, 27-33 дахь талууд

19 УТА. ф.11, д.1, хн.270

Л.Лааганыг 1932 оны 6 дугаар сард хуралдсан МАХН-ын Төв Хороо, Намын хянан байцаах төв комиссын хамтарсан онц III бүгд хурлаас Намын Төв Хорооны Тэргүүлэгч гишүүнээс гаргаж, улмаар БНМАУ-ын XVII бага хурлаас (1932.VII.2) Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн даргын үүрэгт ажлаас нь чөлөөлсөн байна.<sup>20</sup> Харин 1932 оны гуравдугаар сарын 15-ны өдрийн НТХ-ны Тэргүүлэгчдийн хурлын тогтоолоор Бага Хурлын дарга н.Лааганы биеийг докторын актын ёсоор ЗСБНХУ-д удаа хугацаагаар явуулж эмчлүүлэх шийдвэр гаргаж, түүнд замын зардал, хэлмэрч зэргийг өгөх нь зүйтэй гэж тогтсон байдаг. Үүнээс өмнө хоёр ч удаа Лааганы биеийг ЗХУ-д эмчлүүлэх чөлөө олгох тухай Намын Төв Хорооны шийдвэр гарч байжээ.<sup>21</sup> Удалгүй Лааганы биеийг Намын Төв Хорооны дэргэдэх эмнэлгийн комисс, бусад докторуудын хамтаар комисслон үзээд нэн даруй Севастополийн халуун усанд явуулж биеийг сувиллуулваас зохимой гэсэн актыг<sup>22</sup> 1932 оны гуравдугаар сарын 8-нд гаргажээ. Ийнхүү Л.Лааган Зөвлөлтөд яваад ирээгүй байхад нь Намын Төв Хороо, Хянан байцаах төв комиссын хамтарсан Онц III бүгд хурал, Улсын XVII бага хурал болжээ.

Л.Лааганы Зөвлөлт Холбоот Улсаас ирсэн цаг хугацаа тодорхойгүй байна. Гэвч 1932 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн Ардын Сайд нарын Зөвлөлийн 7 дугаар хурлын тогтоолоор түүнийг монгол банкны орлогч даргаар томилжээ. 1932 оны есдүгээр сарын 20-ны өдрийн “Ардын үндэсний эрх” сонины дугаарт Л.Лааганы бичсэн “Улсын XVII бага хурлаас тогтоосон шинэ эргэлтийг биелүүлэхэд зээллэгийн явдал хэрхэн холбогдох вэ?” өгүүлэл хэвлэгдэж байжээ. Дараа нь өөрийн хүсэлтээр хөдөө орон нутаг Ховд аймгийн 10-р ангийн хэлтсийн газар ажилласан байна.<sup>23</sup>

## ХИЛС ХЭРЭГТ ХОЛБОГДСОН НЬ

Л.Лааган 1928-1940 онд улс төрийн хилс хэрэгт 3 удаа холбогдож байжээ.

### Нэг. “Шар Санжийн хэрэг” гэгчид холбогдсон нь:

Дөрвөд аймгийг автономит эрхтэй болгохыг эрмэлзсэн ”Шар Санжийн хэрэг” гэгч 1927 онд илэрч, түүнд холбогдуулан Л.Лааганыг Намын Төв Хороо, Хянан байцаахын зөвшөөрөл “шаардлагаар”<sup>24</sup> Дотоодыг хамгаалах газар (ДХГ) 1928 оны VII сарын орчим Дадан, Хандсүрэн, Янжив нарын хамтаар Ховд хотноо баривчлан Улаанбаатарт авчирч шоронд хорьжээ.

20 МАХН-ын товч түүх, нэмж засварласан гурав дахь хэвлэл, Улсын хэвлэлийн газар, УБ., 1985, 159 дэх тал

21 НТА. ф.4. д.4, хн.221, 157-159 дэх талууд

22 НТА. ф.4. д.4, хн.161, 154-155 дэх талууд

23 НТА. ф.4. д.5, хн.27, 19-21 дэх талууд

24 МАХН-ын VII их хурал. УБ., 1980, 136 дахь тал

Чухам яагаад Лааганыг хорив? Чандмань уулын (Дөрвөд) аймгийн тусгаар болгох тухай хэрэг гэгч юу байв? Гэх зэрэг асуултуудад хариу өгөх үүднээс эргэцүүлж үзье.

Намын Төв Хорооны III бүгд хурал (1928) дээр Хянан байцаах комиссын нарийн бичгийн дарга Норовсүрэн: Лааганыг барих тухай зөвшөөрөл олгох үед н.Лосол (НХБТК-ын дарга) Дэлгэрсан (Комиссын тэргүүлэгч гишүүн) нар албанаа одож эзгүй байсан ба Норовсүрэн би тус комиссын өдөр тутмын явуулах хэргийн ганцаар оролдож, нөгөөх гишүүн нь Жамсранов, Насанбат нар байсан.

Нэгэн өдөр ДХГ-аас нэгэн цахилгаан утас авчирч үзүүлсэн нь Дөрвөд аймгийг тусгай болгох хэмээсэн шар Санжийн хэрэг илэрч буй эл хэрэгт Лааган, Дадан нар холбогджээ гэсэн үгтэй утсыг нөхөр Жамсрановт үзүүлэхэд түүнээс Лааганыг барих зөвшөөрөл шууд өгвөөс зохимой хэмээсэн тэр тухайд, хамгаалахын нууц хэлтсийн дарга Сэрээтэр бие өвчтэй учир уулзаж чадсангүй нэлээд хоног алгуурласан нь дараагаар мөн Жамсрановаас зөвшөөрөл өгсөнгүй удаашруулав хэмээн зэмлэж, эрх үгүй нэн даруйхнаа Сэрээтэрийн гэрт Цэвэл очиж зөвшөөрөл өгвөөс зохимой гэж шаардмагц мөнхүү Лааганы бие энэ хэрэгт лавтай оролцсон нь үнэн баримттай болохул түүгээр хэргийн ёсоор гүйцэтгэж болох хэмээхийг ДХГ-ын нууц хэлтсийн дарга Сэрээтэрт хэлж явуулсан зүйл бий гэх зэргээр ярьсан байх бөгөөд тэрээр өөрөө ч “Лааганыг баахан мөчид барив уу”<sup>25</sup> хэмээн дотроо эргэлзэж байснаа ч бас дурссан байдаг.

Уг нь шүүх, прокурорын зөвшөөрлөөр хүнийг барьж, цагдан хорьдог байтал Намын Хянан Байцаах Төв Комиссоос зөвшөөрөл өгч Лааган нарыг бариулж байсан нь хууль ёс гээч юм үнэхээр тоглоом болсон байжээ гэдгийг хэлэх нь зүйтэй.

Энэ асуудалтай холбогдуулан Дотоодыг Хамгаалах Газрын дарга Хаянхярваа ирээд: “Миний бие Дөрвөд аймгийг тусгаар болгох тухай сонсч мэдсэн болох ба энэ хэргийг төв газар албан хааж бүхий гишүүн Бадрахаас зааварласан хэрэг” хэмээсэн Лааганы өчигтэй биечлэн танилцаад “Чандмань уулын аймгийг тусгаар улс болгох хэмээн бусдад нууцаар хатган хэлж мэргэлүүлэх зэргээр ард олны сэтгэл санааг үймүүлэн явсан зэрэг хэргийн ялт шар Санжийн энэ хэргийн арга сэдвийг анх тэргүүлж удирдсан чухал холбогдох этгээд болбоос гишүүн Бадрах болох нь хэргийн байдалд зүйл зүйлээр илэрхийлэгдсэн нь хэрхэвч зайлах газаргүй болсон учир түүнийг барьж байцааж болох эсэхийг заана уу”<sup>26</sup> хэмээн 1928 оны есдүгээр сарын 18-ны Намын төв Хорооны Тэргүүлэгчдийн хурлаас зөвшөөрөл авч улмаар Бадрахыг асууж байцааж, хариуд нь Бадрах тас зөрж байтал Шмераль тэргүүтэй

25 МАХН-ын Төв Хорооны III бүгд хурал (1928) эмхэтгэл

26 МАХН-ын Төв Хорооны III бүгд хурал (1928) эмхэтгэл



Коминтерний комисс ирж, Бадрах, Лааган нарыг суллан тавьсан байна.

Учир битүүлэг ийм нэгэн хэргийн талаар Коминтерний төлөөлөгчдийн тэргүүн Б.Шмераль юу гэж ярьсныг сонирхоцгооё.

Тэрээр: “Лааганыг чингэж бариад байх нь мөн хэмээж чадахгүй нь уг мэдээ хэргийн баримт бүрдсэн эсэх нь тодорхойгүй болохыг би үнэн шударгыг барьж хэлмөй”<sup>27</sup> гээд “Бидний комисс Лааганы хэргийн тухай 10 зүйлийн өчиг мэдүүлгийг үзсэн. Үүний дотор Бадрах оролцон буй. Үүний үндэс нь нэгэн Чойжин ламаас шар Санж гэгч хүн аврал гуйж явсны улмаас мэдээлэгдсэн болно. Тэрхүү аврал гуйсны дотор эхнэр авах тухай бас нөгөө чухал нэгэн зүйл нь Дөрвөд аймгийг тусгаар болгох тухай бөгөөд энэ зүйлийг н.Лааган өгүүлсэн бус шар Санж гэгч хүн өгүүлсэн хэрэг болох ба энэ хэрэг болбоос жижиг бөгөөд төдий л чухал бус амой. Уг хэрэг зүйлийг сайтар хянаж мэдэхийг их л оролдсоны дээр шар Санж гэгч хүнийг засаг захиргааны газраас барьж асуужээ. Түүний өчиг мэдүүлгийн дотор бөөрөнхий зүйл олон ба мөн хэрэгт Лааганы нэр байхгүй атал харин Бадрахын нэр оролцон байсныг өгүүлбээс тэрхүү шар Санжийн өчигт Бадрахын хэлсэн нь: Дөрвөд аймгийг тусгаар болгох тухайг дурдаж арван гэрийн хурлаар хэлэлцүүлж хэмээсэн зүйл буй ба бас эл олон хэргийн дотор Лааган буруу хийснээ хүлээсэн зүйл огт үгүй байна.

Бас Лааганы өчиг мэдүүлгийн дотор Улсын Бага Хурлын үеэр Лааган Нанзадын хамт Бадрахын гэрт очиход мөнхүү Бадрахын хэлсэн нь харьяат Дөрвөд аймагт албан татварын тухай амиа хорлосон нэгэн хүний хэргийг н.Гэлэгсэнгэ төдий л хайхрахгүй байна. Жадамба Чандмань уулын аймагт уурын тэрэг гаргахад татгалзсан зэргээр Дөрвөд аймгийг гадуурхах төлөвтэй тул Ховд хязгаарыг тусгаарлаж болох юм хэмээн хэлж байсан хэмээхээс үзвээс энэ хэрэгт Лааганыг холбогдуулж барьж хорьсноос шударгыг хэлэхэд н.Бадрахыг 10 дахин барьж хорих хэрэгтэй<sup>28</sup> юмсанж” гэжээ.

Бүгд хурлын дараа залгаад МАХН-ын VII их хурал хуралдсан. Тус их хурал дээр тавьсан НХБТК-ын илтгэлд<sup>29</sup>: энэ хэргийн тухай өгүүлсэн Шмералийн хэлсэн үгнээс зөрөхөөргүй зүйлийг хэлээд дээр нь Бадрахаас мөнхүү Лааганы өдүүлсэн хэргийн байдал хараахан улс төрөөс урвах тэрсэлсэн хэрэг бус, гагцхүү намын дотоод явуулгаас үүдсэн болов уу хэмээн үнэн чанар илрээгүй мэт эргэлзэлтэй зүйл буй тул намын газар татан авч уул холбогдсон хэргийн үндэс чанарыг урьдаас намын дотор байцаан илрүүлж өдүүлсэн хэргийг намын хувиар таслан дуусгуулбаас ямар гэж байсныг хэлж байна.

27 МАХН-ын Төв Хорооны III бүгд хурал (1928) эмхэтгэл

28 МАХН-ын Төв Хорооны III бүгд хурал (1928) эмхэтгэл

29 МАХН-ын Долдугаар их хурал, УБ., 1980 он

Эндээс үзэхэд Бадрах Лааганыг өмөөрсөн байдал харагдаж байгаа юм.

Мөн их хурал дээр Бадрахаас: “Лааганы өнгөрсөн үеийн тухай яриад Лааган бол намын ажилд шударгаар зүтгэж ирсэн ядуу хоосон ард ийм хүнийг энэхэн хэрэгт далимдуулан дайчлан барьж нэгэн ядуу гишүүнийг 40 гаруй хоног хүнд гянданаа хорьж зовлон зүдүүрийг хүлээлгэн үзүүлсэн нь хэлэвч занавч баршгүй барууны аюулын долгионы гашуун хор мөн болой”<sup>30</sup> гэжээ.

Бадрахаас Лааганыг чөлөөлөх талаар бичиг өргөсөн тухай н.Дугаржав ярьсан байдаг. Лааган хэлсэн үгэндээ: уг хэргийн тухай юу ч хэлээгүй байгаа юм. Зөвхөн: би элдэв янзын юм их сонсдог. Энэ сонссоноо хэлэх дуртайн харгайгаар гяндан шоронд хүртэл орж явсан амой<sup>31</sup> гэж хэлж байна.

Харин 1928 оны 9 дүгээр сарын 15, 17, 21-нд 3 удаа Лааганыг байцаасан баримт байх бөгөөд түүнд тэмдэглэгдсэнийг үзвээс: “Бадрахаас тус дөрвөд аймгийг автономит эрхтэй Монголоор удирдуулсан тусгай улс болбоос юунд ингэж дарлагдах билээ хэмээн надад 3 удаа хэлсэн нь туйлын түмэн үнэн энэ билээ. Өчүүхэн хүн Төв Хорооны Тэргүүлэгч гишүүн байтугай өнгийн хэнийг ч би чингэсэн хэмээн хилс гүтгэж огт чадахгүй” хэмээгээд Бадрахтай ямар харьцаатай байсан талаар ярихдаа: “Бадрах бид хоёр болбоос хоорондоо өшөө хонзон огт үгүй. Гишүүний хувиар хэзээнээс эхлэн эв найрамдалтай явсан хүн болох тул Бадрахыг би болбоос итгэлтэй нөхөр хэмээн итгэж явсан хүн. Гэтэл одоо хэлсэн үгээ хэлээгүй хэмээснийг үзхүл Лааган миний амийг хорлох эрлэг мөн юм байна хэмээн санаж улсын гянданаа хоригдож элдвийн зовлон зүдүүрийг эдлэж”<sup>32</sup> буй гэж мэдүүлсэн байна. Мөн өгсөн мэдүүлэг бүртээ шахам тэр: “өчүүхэн хүн хаана ч очсон энэ удаа дараагийн мэдүүлснээс өөрчлөх зүйл огт үгүй”<sup>33</sup> хэмээн дахин давтан хэлж байсныг дурдахад илүү бус хэмээн санана.

Энэ бүгд дээр нэмж хэлэхэд бүр 1939 онд өгсөн нэг мэдүүлэгтээ: Тэр үед Чандмань уулын аймгийг тусгаар улс болгох хэргийг Бадрах нараас толгойлон удирдаж байсан бөгөөд Бадрахын бие 17 онд (1927) Чандмань уулын аймгийн намын ажлыг үзэхээр очихдоо Лааган миний биед ярьж байсан нь Чандмань уулын аймгийг тусгаар улс болгох асуулт бол туйлын ихээхэн улс төрийн утга чанар бүхий чухал хэрэг тул энэ хэргийг та нараас хамаагүй толгой мэдэж задруулан ажиллаж болохгүй, нарийн аргаар явуулах хэрэгтэй гэх зэргээр даалгаж байсан нь үнэн гэж өчсөн байх юм.

30 МАХН-ын Долдугаар их хурал, УБ., 1980 он

31 МАХН-ын Долдугаар их хурал, УБ., 1980 он

32 НАХБ-ын ТА. Ф.БХ. хн.536

33 НАХБ-ын ТА. Ф.БХ. хн.536

Мөн Ө.Бадрахаас Л.Лааганд хандаж “Манай аймаг тусгай улс болбоос элдэв зардлаа дотор зуураа зарах хэрэгт нь дөхөмтэй болохоос гадна эд нарт (баруунтнууд).. юунд дарлуулах билээ”<sup>34</sup> гэж байжээ. Энэ ярианы дараа Ө.Бадрах, Л.Лааганыг өөрийн холбоотон гэж ярьж байснаас “Шар Санжийн хэрэг” гэгчид сэжиглэгдэхэд хүрчээ.

1929 оны эхээр Дотоодыг хамгаалах газрын тасгийн дарга Очиржав хэмээгчээс намын хянан байцаах төв комисст бичсэн захидалдаа өнгөрсөн намар цагт Чандмань уулын аймгийг тусгаар болгох хэмээв гэх зэргээр мөн аймгийн Намын хянан байцаахын дарга Лааганд “худал ташаа хэргийг хилсээр хүлээлгэж нэгэн сар илүү болсон”<sup>35</sup> тухай мэдээлжээ. Түүнээс гадна Засгийн газрын эрхлэх товчооны гишүүдийн 1929 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 20 дугаар хурлын тогтоолоор шар Санжийн “...тусгаар болгох гэсэн явдал баримтгүй учир хэргийг хэрэгсэхгүй”<sup>36</sup> болгов гэсэн нэгэн баримт архивт байдаг юм.

Лааган, Бадрах нарын нэр холбогдож илэрч гарсан “Шар Санжийн хэрэг” хэмээгч нь намын анги, бүлгүүдийн өөр хоорондох сөргөлдөөнөөс үүссэн утга учиргүй хардалт, сэрдэлт байсан юм хэмээн хийсвэрлэн дүгнээд өнгөрч болох боловч уг хэргийг Коминтерн, түүний бие төлөөлөгчид анх сэдэвлэн гаргаж Бадрах нараар дамжуулан хэрэгжүүлж байгаад Монголчууд түүнийг илрүүлэхийн даваан дээр өөрсдөө ирж шууд зогсоосон учир битүүлэг улс төрийн нарийн хэргийн учиг байсан байж болох талтайг тэмдэглэхгүй өнгөрч эс чадав.

### **Хоёр. Л.Лааган “Лхүмбийн хэрэг” гэгчид холбогдсон нь**

Л.Лааган хоёр дахь удаагаа 1934 оны долдугаар сарын 28-нд “Лхүмбийн хэрэг” гэгчид холбогдон Ховд дахь Дотоодыг хамгаалах газар баригдан Улаанбаатарт хүргэгджээ.

Гэм зэмгүй олон арван хүний амь насыг үзтэл хилсээр хөнөөсөн энэхүү “Лхүмбийн хэрэг” гэгчийн тухай энд нуршихаа больж, зөвхөн Улсын Бага Хурлын дарга агсан Лааганыг холбогдуулсан тэр хэсгийнх нь талаар товч өгүүлье.

1932 оны VI, VII саруудад “зүүнтнүүдийг” нам, төрийн удирдлагаас зайлуулсан дараахан үеэс эхлэн энэхүү учир битүүлэг “жүжиг” эхэлсэн боловч уу хэмээн санагддаг. “Зүүний” гол гол удирдагчдын заримыг халсан боловч заримыг ойр зуурын албанд тавьж, тухайлбал Ө.Бадрахыг ЭХЯ-ны сайдаар түр торгоож, З.Шижээ нарын хэдэн хүнийг холбоот Улсад “сургуульд” явуулан Л.Лааганыг

34 НАХБ-ын ТА. Ф.БХ. хн.536

35 НАХБ-ын ТА. Ф.БХ. хн.536

36 НАХБ-ын ТА. Ф.БХ. хн.536

Монгол банк, Хоршоодын холбоо хавиар барьж аргацаан цаг хугацааг хүлээзнэсэн маягтай байлгасан шиг санагддаг юм. Харин тэдэнтэй гар нийлж явсан “зүүнтний” нэг удирдагч П.Гэндэн ерөнхий сайд болсон нь нөгөөдүүлийнхээ эсрэг ашиглагдахад хүрээ биз дээ.

Одоо Лааган баригдахынхаа өмнө хаагуур явж, ямаршуухан байдалтай байсныг сонирхъё.

1934 оны 1 сарын 19-ний өдөр Лхүмбэ анх удаа “хэрэг” хүлээж: “Шодоев Дамдин, Япон хүний хамт их хурал хийлгэхэд Лааган, Жигжиджав бид нар оролцсон” хэмээн мэдүүлснээр Лааганыг “Японы тагнуулын байгууллагын гишүүн”-д тооцох болж, улмаар Ховдын хоршоонд ажиллаж байсан түүнийг Намын Төв Хороо ба Дотоодыг Хамгаалах газраас удаа дараа дууджээ.

Энэхүү дуудлагыг хүлээн авсан Лааган машинаар Улаанбаатар хот руу 1934 оны 4 дүгээр сарын 2-нд гарахад нь түүнийг Дотоодыг хамгаалахынхан сэмхэн салахгүй дагаж мөшгөсөөр нийслэлд ирсэн бололтой. Энэ талаар бяцхан тодруулбал,

Ховд аймгийн цэргийн хэлтсээс Дотоодыг хамгаалах газрын дарга Намсрайд явуулсан (1934.4.3-ны шифр) цахилгаандаа: “Лааганыг хоршооны орос жолоочтой хамт хөнгөн машинаар манай нэг хүний хамт явууллаа” гэсэн байна. Энэ нь Лааганыг Ховдын дотоодыг хамгаалахын хүн өөрт нь мэдэгдэлгүй хамт дагалдан явжээ гэсэн үг. Тиймээс ч Лааганы явсан ул мөрийг хоног, цаг гээлгүй төвдөө уламжилж байжээ.

1934 оны 4 дүгээр сарын 5-ны орой Лааганы сууж явсан машин Архангайд ирээд хоносон байна. Дотоодыг хамгаалахын шугамаар Лааганыг хэдийд Ховдоос гарч хэдийд Архангайд ирснийг урьдчилан мэдсэн Ерөнхий сайд Гэндэн, Лувсаншарав нар Улаанбаатар хотоос даруй гарч, Архангай аймгийн төв дээр 4 дүгээр сарын 6-ны өглөө “санамсаргүй”, “тохиолдлын чанартай” уулзалтыг зохион байгуулсан байна.<sup>37</sup>

Уг “уулзалтыг” дээрээс зохион байгуулж, ногоон малгайтнууд хэрэгжүүлсэн нь хөдөлбөргүй нотлогддог юм. Баримт сөхвөл,

Архангайн Дотоодыг хамгаалах ангийн дарга Дүгээ 1934 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр “5-ны орой Лааган ирсэн. Бид танаас өгсөн зааврын дагуу машинд нь зохих хэмжээний саатал учруулж чадсанаар хонуулж чадлаа. 6-ны өглөө Гэндэн, Лааган нар уулзлаа”<sup>38</sup> гэсэн мэдээг Дотоодыг хамгаалах газарт явуулсан байдаг. Энэ “уулзалтаар” Гэндэн Лааганд шахалт үзүүлж:

37 НАХБ-ын ТА. Ф.БХ. хн.536

38 НАХБ-ын ТА. Ф.БХ. хн.536

Нэгд, чамайг Японы тагнуулын хэрэгт холбогдсон хэмээн Лхүмбээс мэдүүлсэн,

Хоёрт, чи энэ хэргийн талаар хүнд хэлж болохгүй, эл хэргийг зөвхөн Намсрай бид хоёроос бусад хэн ч мэдээгүй хэрэг хэмээн дотночилон хэлсэн.

Гуравт, чи Улаанбаатараас гадагш гарч болохгүй, хотод очоод хэнд ч болов хэлж болохгүй<sup>39</sup> хэмээн хатуугаар тулгасан байна.

Лааган хариуд нь: Лхүмбийн “хэрэгт” холбогдсоныг огт хүлээхгүй гэдгээ хэлж байжээ. Энэ тухай Гэндэн: “Лааган хүчтэй эсэргүүцээд байна...” гэж төвд мэдэгдсэн байдаг.<sup>40</sup>

Лааган хотод ирээд хэсэг ажилгүй байв. 1934 оны 5 дугаар сарын эхээр Ерөнхий сайдаас Лааганд “Хөвсгөл аймагт ажлаар явсугай”<sup>41</sup> хэмээн тушаасан байна. Гэтэл үүний хариуд Л.Лааган өмнө дурдсан улс төрийн эсэргүү гүтгэлгийн хэргээс ангижиртал төвд байлгахыг хүссэн захидлыг<sup>42</sup> Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарт 1934 оны тавдугаар сарын 13-нд бичсэн байна. Уг хүсэлтийг нь хүлээж аваагүй учир Л.Лааган тушаалын дагуу Төв Кооперативын дарга Равдангийн хамт Хөвсгөл аймагт очиж мал махны ажил, өлөн гэдэсний заводад түр ажиллажээ.

Лааганыг чухамдаа Хөвсгөл аймагт илгээсэн нь цаана их л утга учир бүхий үйлдэл байв. Лааган ийш тийшээ явах дургүй байсан тухай дээр нэгэнт дурдсан билээ. Тэгэхлээр түүнийг Хөвсгөл руу хүчилж явуулаад тэндээс нь Алтанбулаг руу аваачиж цааш нь зөвлөлтийн хилийн цэрэгт барьж өгөх зорилготой байжээ.

Дотоодыг хамгаалах газраас 1934 оны 6 дугаар сарын 4-ний өдөр Алтанбулагийн ангид явуулсан мэдээнд: Лааган Хөвсгөл аймгаас танай хоршоонд түр ажиллахаар очно. Энэ үед нь бага сага ажил өгч байгаад цааш СССР-т явахыг тушаа. Хэрэв явахгүй бол шууд баривчилж, зөвлөлтийн хилийн цэрэгт тушаа!<sup>43</sup> Гэж үүрэг өгч байжээ. Үүний зэрэгцээ 1934 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Алтанбулаг боомтоор Лааганыг хил гаргах виз, паспортыг урьдчилан бэлтгэж өгсөн Лааганыг Монголоос зайлуулах зохион байгуулалттай үйлдэл өрнөж байсныг илтгэнэ.

Энэ үед Лааган хэрэг хүлээгээгүй байсан тул хилээр түүнийг хүчлэн гаргаж чадсангүй. Ингээд тэр 1934 оны 7 сарын 1-ний үеэр буцаж Улаанбаатарт иржээ. Лааган угийн юманд няхуур ханддаг хүн учраас учир битүүлэг хэргийн үнэн мөнийг олох, өөрийн буруугүй

39 НАХБ-ын ТА. Ф.БХ. хн.536

40 НАХБ-ын ТА. Ф.БХ. хн.536

41 НТА. ф.4. д. хн. 27, 112 дахь тал.

42 НТА. ф.4. д. хн. 27, 29 дэх тал

43 НТА. ф.4. д.5, хн.27, 133-114 дэх тал

гэдгийг ойлгуулах үүднээс нам, засаг, төрийн удирдлагуудад удаа дараа хандаж, уг ажлаа цөхрөлтгүй хөөцөлдөж байсан нь баримт бичгээс ажиглагддаг юм.

Тэгтэл Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга Лувсаншарав, Дэмид нараас таны бие Лхүмбийн хэрэгт холбогдсон хэмээх мэдүүлгүүд гарсан боловч бид таныг бусдын адилаар баривчилж байцааж зохилдохгүй. Иймд танаас эл хэргийн тухай өөрөө үнэнээ мэдүүлэх ахул ямарч ялгүй харин сонин хэрэг болно. Ийм учраас таныг Холбоот Улсад явуулахаар тогтсон бөгөөд энэ тухай Төв Хорооноос Холбоот Улсын элчин лүгээ гэрээ байгуулж СССР-т та нарыг 2 жил суулгах болсон. Одоо 3 хоногийн дотор ажил ахуйгаа бэлтгэн гарваас зохимой”<sup>44</sup> хэмээн тушаажээ. Энэ тушаалыг Лааган хилс хэрэг гэж үзэж хүлээж аваагүй. Энэ тухайгаа ойлгуулах үүднээс өөрийн нас 50 хүрсэн, 7-гоос 14 насны хэдэн балчир хүүхэдтэй зэрэг гачигдал зовлон тоочсон захидлыг<sup>45</sup> Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарт 1934 оны 7 дугаар сарын 13-нд бичиж өгчихөөд зугатаагаад Ховдод төрсөн нутагтаа оччихсон бололтой.

Тэндээс нь Л.Лааганыг 1934 оны 7 дугаар сарын 28-нд Дотоодыг хамгаалах газар барьж авчраад түүнд: “Японы тагнуулын нууц байгууллагын” хэрэгт оролцсон гэсэн хилс хэргийг тулгаж, 7 дугаар сарын 30-наас 8 дугаар сарын 23 хүртэл байцаажээ. Эхний 7 өдөр тэр ямар ч хэрэг хүлээгээгүй бөгөөд байцаалтад “Лхүмбийн хэрэг” бол зохиомол, хуурамч юм гэдгийг удаа дараа хэлж байжээ.<sup>46</sup>

Ердийн байцаалтаар хилс хэргийг Лааганд хүлээлгэж дөнгөхгүй болохоороо Дотоодыг хамгаалах газраас түүнийг “7 өдөр 7 шөнө” тасралтгүй байцааж мөрдөн байцаалтын хууль бус арга хэрэглэж эхэлжээ. Энэ тухай Лааган 1934 оны 10 дугаар сард МАХН-ын IX их хурал, Коминтерний Дорнод хэлтэст бичсэн өргөдөлдөө: “Чиний бие Японы тагнуулын байгууллагын хэрэгт оролцон холбогдсон явдал зайлшгүй үнэнтэй учир эрх үгүй тодорхойлон хүлээж мэдүүлэх хэрэгтэй хэмээх зэргээр хүчлэн дарлаж шаардсан боловч би энэ мэтийн хувьсгалын эсэргүү ажил хэрэгт оролцон холбогдож явсан явдал урьд хожид хэзээ ч үгүй байтугай санасан ч үгүй. Хэдийгээр засгийн өршөөлийг авахгүй хийхгүй боловч худал хэрэг хүлээж чадахгүй хэмээн үнэн учир гарсан мэдүүлэвч түүнийг ер хэрэгсэх үгүй. Харин чамайг Засгийн газраас суллаж тавих тухай тогтоол гарсан. (хуурахыг оролдсон О.Б.) Одоо эл хэргийг хүлээж мэдүүлэх хэрэгтэй, чамайг урьд адил өмгөөлөн хамгаалах хүн үгүй, чамайг эл хэргийг хүлээж байна хэмээн хэн ч яллахгүй. Хэрэв тухайд яллах хэмээвэл хэрэг хүлээвээс яллах үгүй хэмээсэн та нарын их хууль худал ахул

44 НТА. ф.4. д.5, хн.27, 133-114 дэх тал

45 НТА. ф.4. д.5, хн.27, 27-29 дэх талууд

46 НТА. ф.4. д.5, хн.27, 112 дэх тал

миний мэдүүлэг ч худал хэмээн мэдүүлгийг буцаах үгүй юү. Чамайг эл хэргийг заавал хүлээх хэрэгтэй хэмээхийг Засгийн газраас ч шаардан буй. Чиний үйлдсэн хэрэг 100 хувь үнэнтэй бөгөөд заавал чиний амаар мэдүүлэх хэмээсэн хэрэг бөгөөд “Чи болбоос ганцаар, бид болбоос олон. Манай Дотоодыг хамгаалах газрын аппарат өргөн, өдөр олон, сарын хоног удаан. Чи эл хэргийг хүлээж мэдүүлэхгүй болбоос чиний толгойн үсийг цагаан болтол байтугай өвс хамхуул ургатал суулгаж байцаана. Үүнээс хойш чамайг хэрэг хийсэн буюу үгүй буюу. Үнэн буюу худал уу, “Үүнээс өөр зүйлгүй үнэнийг мэдүүлэв” хэмээн хэлэх эрхийг мөрдөн байцаах хууль ёсоор шууд хасав”<sup>47</sup> гэх зэргээр шаардаж байсныг тодорхой өгүүлжээ.

Ийм хүчинд автсан Лааган арга буюу хилс хэргийг “хүлээж” ам түр боловч завсарлажээ.

Лааган “нүүрэлдүүлсэн” Дэндэв нарын хэлсэн бүгдийг үнэн” хэмээн хилс хэрэг хүлээж ам нээтэл түүнийг хэдэн өдөр байцаахгүй амраажээ. Тийн шоронд байцаалт түр завсарлаж “амарч” байтал Лааганыг урьдах байдлаар дахин байцааж эхлэх нь л тэр.

Урд нь “Японы тагнуулын байгууллагад оролцоотой эсэхийг” байцаадаг байсан бол энэ удаагаас “Танай байгууллагын удирдагч хэн байсан, бусад удирдагч нараас хэн хэн оролцсон, цэргийн талаас хэн хэн хичнээн хүн оролцсон, чиний бие Москвад очихдоо ямар хүмүүстэй уулзаж харилцсан”<sup>48</sup> гэх зэргээр байцаадаг болж, улмаар Улсын прокурор Ядамсүрэн, Бага Хурлын нарийн бичгийн дарга Сурахбаяр, Мал тариалангийн яамны сайд Ширнэн нараар ятгуулан: “Бид нарыг Засгийн газраас тийн уул хэргээ түргэн хүлээж мэдүүлж өгвөөс хэрхэвч ял шийтгэх ёсгүйг мэдэгдэхээр зориуд томилон явуулав. Иймд эл хэргийг эрхиш хүлээж дэлгэрэнгүйгээр мэдүүлэх хэрэгтэй болохыг бид нөхрийн ба албан тушаалын алины ч хувиар эл Засгийн газрын хүсэн шаардаж буй өршөөлийг сануулмой”<sup>49</sup> гэх зэргээр хэлүүлж, тулгаж шаардаж байсан байна.

1934 оны зун наадмын үеэр Лхүмбийн хэрэгт холбогдсон 33 хүний хэргийг шийдсэн тухай хэвлэлд гарсан. Энд бол 5 хүнээс бусдад нь өршөөл үзүүлж тодорхой хугацааны хорих ял оноосон. Гэхдээ энд 33 хүн гэж бичээд 32 хүний нэрийг тавьсан байна. 1 хүн бол байхгүй байгаа. Энэ бол Лааган байжээ гэж бодож байна. Яагаад гэвэл тэр хэрэг хүлээхгүй байсан. Мөн 1934 оны есдүгээр сард Намсрай (ДХГ дарга), Төв аймгийн намын хурал дээр тавьсан илтгэлдээ: Бага хурлын дарга Лааган бол Лхүмбийн хэргийг удирдагчдын нэг, тэр 33-ын 1 гэж хэлж байна.

47 НТА. ф.4. д.5, хн.27, 112 дэх тал

48 НТА. ф.4. д.5, хн.27, 112 дэх тал

49 Мөн тэнд



Энэ бүхний эцэст 1934 оны 8 дугаар сарын 21-ний өдөр Л.Лааганы бие “нэгэнт өтөлж өвгөн буурай болсны дээр өөрийн гэмт хэргийг шударгаар хүлээсэн” тул Дотоодыг хамгаалахын тусгай хэлтсээс ялын төлөвлөгөө үйлдэж түүнд хуулийн дээд хэмжээ өгөхөөр төлөвлөжээ.

Гэвч “Засгийн газрын бодлогыг баримталж Холбоот Улсад 2 жилээр явуулан шийтгүүлье” гэсэн шийдвэр гарчээ. Ингээд 1934 оны 9 дүгээр сарын 1-нд Лааганыг Зөвлөлтийн хязгаарын цэргийн отрядад шилжүүлсэн байна. Шилжүүлсэн тухай актад Алтанбулаг ангийн дарга Готов гарын үсэг зурсан байдаг. Энэ талаар өндөр настан Б.Банзрагч 1989 онд ярихдаа: “1934 оны намар (9 дүгээр сард) би Намын Төв Хороонд байж байгаад бага Самдантай хамт 1 жилийн курст явсан. Энэ үед машинаар Улаан-Үүд хүрдэг байв.

Алтанбулагаас наана бид буугаад амарч байтал урдаас Улаанбаатараас ачааны машин ирээд хажуугаар шур хийгээд өнгөрлөө. Дээр нь 2-3 хүн байх юм. Нэг нь Лааган гуай, толгой нүцгэн байсан шиг санагдана. Бусад 2 нь цэргийн хүн байна. Баригдсан хүнийг авч яваа аятай харагдсан. Лааган байна гэдгийг бид таньсан юм. Ингэж л түүнийг хойш нь аваад явахыг нүдээрээ харсан юм”<sup>50</sup> хэмээн өгүүлснийг өчүүхэн судлаач би өөрийн гараар тэмдэглэж үлдсэн билээ.

Чухам тэр хэдийд Москвад хүргэгдсэн нь тодорхойгүй байна. Гэвч 1939 онд өгсөн нэгэн мэдүүлэгтээ: Лхүмбийн хэрэгт баригдаад хойш Москва хотноо очоод элчин Дарьзав дээр буусанд энд хүн суух байр байхгүй тул чи хоршооны байранд оч! Гэсэн, заалган явсаар тэнд очтол Бадрах, Гиваапил, Баттөмөр, Шархүү нар байсантай уулзлаа. Тэдэнд замдаа Троицкосавск, Улаан-Үүд зэрэг газар нэлээд саатаж ирсэн тухайгаа ярихад Гиваапил манай нөхдөөс нэмж ирүүлж байгаа юм байна даа хэмээсэн гэсэн үг байдаг юм.

Тэрээр 1934 оны 9 дүгээр сарын 30-нд Москвагаас Монгол улсын Бага Хурал, Засгийн газрын тэргүүн Амар, Гэндэн нарт анхныхаа захидлыг бичиж, түүндээ “Би таны тушаал шийдвэрээр энд ирэв. Эрх чөлөө бүхий болов. Хэрэв таны хүслийг хангах хугацааны дотор суух ахул хоол хувцас орон байр буюу түүнд хэрэглэх мөнгө олгох газар үгүй, өлбөрөхөд хүрэх тул түргэн хариу зааж ирүүлэхийг эртхэн мэдүүлье”<sup>51</sup> хэмээн бичиж байжээ.

Мөн Москвад очуут бичсэн болов уу гэмээр нэгэн зурвас байх бөгөөд тэр нь БНМАУ-аас СССР улсад суугаа элчин сайдын яамнаа тавьсан Лааганы хүсэлт байв. Тэрхүү зурваст: “Эдүгээ өчүүхэн хүн миний бие нааш ирэх замын зуур СССР улсын Хиагт хотноо буй Дотоодыг хамгаалах газраас миний бие дор хэрэглэж явсан хутга нэгийг хураан авсан ба мөн онц үнэ бүхий хөөрөг нэгийг үрэгдүүлсэн

50 О.Батсайхан Лосолын Лааган: Төрийн тэргүүний хувь заяа УБ., УБ., 2007, 35 дахь тал

51 Мөн тэнд

нь хууль ёс бус болох тул элдэв зүйлээр гачигдаж буй миний биед эл дурдсан үнэ бүхий зүйлүүдийг эрхлэх газар лугаа харилцаж даруйхан олгуулахыг гуйсугай. Лааган” хэмээн бичсэнээс үзэхэд түүний биед хэрэглэж явсан эд өлгийн зүйлийг хил дээр хураан авч “золигт” гаргасан бололтой.

Энэ бүхний эцэст ЗХУ-ын анхааруулга, ЗХУ-аас БНМАУ-д суугаа бүрэн эрхт төлөөлөгчтэй урьдчилан тохиролцсон ёсоор МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 1934 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 1 хурлаас Лааган нарын зургаан хүнд “Шүүх таслах ба хууль цаазны талаар ял ногдуулж хэлэлцэхгүйгээр ЗХУ-ын нутагт 2-3 жил суулгах”<sup>52</sup> тухай тогтоол гаргасан байдаг.

Уг тогтоолд Л.Лааган нарын “Монгол Улсын тусгаар тогтнол хувьсгалын ололтыг устгах, монголын ард түмнийг японы түрэмгий нарын колони болгохыг оролдож байсан нь зүйл, зүйлээр илэрсэн” хэмээн тэмдэглэж, “Эл Лааган нарын 5 хүмүүсийг шүүх таслах ба хууль цаазны талаар ял ногдуулж хэлэлцэхгүйгээр Холбоот улсын хязгаарт хоёроос гурван жил хүртэл суулгахаас гадна тэднийг хугацаа дуустал хэрхэвч Монголын хязгаар дор буцааж ирүүлэхгүй болгох ба бөөнөөр нь суулгах явдлыг аюултай хэмээн үзэж “эд нарыг Москвагаас шилүүлж өөр газар суулгах тухай Холбоот Улсын засгийн газрууд лугаа харилцан гүйцэтгэх явдлыг одоогийн явах нөхөр Гэндэн нарт даалгасан байна.

Өөрөөр хэлбэл Лааган нарыг “Монголын хязгаараас зайлуулсан” тогтоол юм.

Лааган Москвад ирээд битүүлэг хэргийн учир зүйг олох талаарх ажлаа үргэлжлүүлэн хөөцөлдөж, МАХН-ын IX их хурал, Коминтернд 1934 оны X сард өргөдөл бичин: “...зөвхөн миний нэр төдий биш харьяат намын нэр алдарт холбогдсон ба олон ардыг нэгэн адил гүтгэн халдаж буй... нэгэн цагийн хэцүү зүтгүүрээс бэрхшээж ор нэр үгүй хилс гүтгэлийг үнэн хэмээн мэдүүлснийг намын хатуу тангараг журмыг хамгаалж чадаагүйн бурууг их хурлын өмнө илэрхийлэн мэдүүлж нягтлан хянахаар байцаал болгон толилуулмой...”, “миний бие тус монгол ардын үндэсний хувьсгал дор үнэнээс итгэн шатаж өөрийн улсын тусгаар тогтнох явдал дор үнэнийг журамлан зүтгэж явсан”<sup>53</sup> гэх зэргээр бичсэн байдаг. Харин түүний энэ хөөцөлдөлгөө тухайн үед талаар өнгөрсөн боловч өнөө үед үнэнийг өчих баримт болон үлдсэнээрээ түүхийн үнэ цэнэтэй ховор материалд даруй тооцогдоно.

Лааган Москвагаас чухам ямар замаар хэрхэн ирсэн нь тодорхойгүй, ямар ч байсан 1934 оны 12 дугаар сард Монголдоо

52 О.Батсайхан Лосолын Лааган: Төрийн тэргүүний хувь заяа УБ., УБ., 2007 он

53 НГА. ф.4. д.5, хн.27, 116 дэх тал

эргэж ирсэн байна. Монгол-Орос хоёр улс төр засгийн эрх баригчдын хамтарсан шийдвэрээр ЗХУ-д 2-3 жилийн хугацаагаар нутаг заагдаж, 1928 онд анх цөлөгдсөн мөнөөх Ц.Дамбадорж, Н.Жадамба нарын хойноос хүргэгдсэн Лааганыг яагаад 40 хэдхэн хоногийн дараа эх нутагт нь дээр дурдсан тогтоолоо зөрчиж буцааж ирүүлэв?! Бодоход мөн л улс төрийн зорилготой байгаа биз ээ. Жич, тэр нэр бүхий 6 хүнээс зарим нь Москвад үлдсэн нь ч бас л санамсаргүй тохиолдол огтхон ч биш нь лавтай? Лааган ирэнгүүтээ өөрийг нь болон өрөөл бусдыг нь хамруулан егүүтгэж эхэлсэн “Лхүмбийн хэрэг” гэгчийн үнэн мөнийг олох гэсэн эрлээ үргэлжлүүлэн хөөцөлджээ. Тэр ирэнгүүт Дэмидтэй уулзаж зүгээр суухгүй байсан нь зарим хүмүүст таалагдсангүй.

1934 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Дотоодыг хамгаалах газрын ерөнхий сургагч Чибисов: “Москвагаас ирсэн этгээдүүдийг тарааж явуулах нь зүйтэй байна. Учир нь энд Дэмидтэй харилцаж байгаа нь муу хэрэг болно. Тэдний харилцаа тасрахгүй байна” гэж Намсрайд хэлсэн байна. Тийм ч учраас Лааганыг 1935 оны 3 дугаар сарын орчим Хөвсгөл аймаг руу явуулжээ. Энэ талаар Хөвсгөлийн Дотоодыг хамгаалах ангийн дарга Чонхлой Дотоодыг хамгаалах газарт мэдэгдэхдээ: “Танай дугаар тоот албан захидлыг авч, Лосолын Лааганыг энд суулгалаа”<sup>54</sup> гэжээ. Эндээс дараа нь тэр өөрөө хүсэлт гаргаж Ховдод шилжсэн бололтой юм.

Учир нь “Миний бие 1935 оны 9 дүгээр сард н.Лувсандорж, Өлзийхутаг нарын зөвшөөрснөөр нутагтаа ирж, мэнд сайн сууж бүлгөө” гэж Дадан гэдэг хүнд 1936 онд захиа бичсэн байна.

Ховдод төрсөн нутагтаа ирээд хэсэг зуур байсны дараа тэр Намын төв Хорооны нарийн бичгийн дарга нарт 1936 оны есдүгээр сарын 2-нд захидал бичиж: “Миний бие Улаанбаатар хотноо одоо харьяат дарга нартай өөрийн биеэр уулзаж тавих асуудал буй ба мөн ч өөрийн амьдрал дор холбогдсон хувцас хэрэгсэл ба гэр орны зүйл буй болох болой авч өдөр тутмын амьдрал дор хэрэглэх зэрэг учраас өчүүхэн надад Улаанбаатар хотноо одох зөвшөөрөл олгож, зохих замын зардлыг тавьж олгохыг гуйсан”<sup>55</sup> байна.

Уг захидалд төвөөс юу хэмээн хариулсан нь тодорхойгүй байгаа юм. Бодоход Лааганы бичсэн энэхүү захидлын “хариу” нь түүнийг 3 дахь удаагаа баривчлах тухай шийдвэр болон очоо биз дээ.

54 О.Батсайхан Лосолын Лааган: Төрийн тэргүүний хувь заяа УБ., УБ., 2007 он  
55 НТА. ф.4, д.6, хн.84, 82 дахь тал

### **Гурав. Хувьсгалын эсэргүү “Гэндэн, Дэмидийн хэрэг” гэгчид холбогдсон нь**

Монгол улсын гэм зэмгүй олон мянган үрсийг хоморголон баривчилж устгасан “Их баривчилгааны” эхэн үе буюу 1937 оны намар болж байв. Ховд нутагт урд урд жилүүдийн нэгэн адил намрын шаргал нар налайж, олон түмний сэтгэл тэнүүн, өдөр тутмын өөрсдийн ажлаа амжуулцгааж байсан буй за. Тэдний дунд урд нь “туг ч барьж, тугал ч хариулж” амьдралын эрээн барааныг хүртэхээрээ л болсон Лааган гэр бүл, үр хүүхдүүдийнхээ хамтаар элэг бүтэн, энэ ертөнцийн сайхнаас амсаж л яваа байх даа.

Гэтэл түүнийг нүглийн хар үүл дахиад л дайрах нь тэр. 1937 оны 8 дугаар сарын 28-наар өдөрлөсөн “Заговор” (хуйвалдаан) хэмээх хэргийн жагсаалт, түүний үргэлжлэл “Список 2-т “Лааган-Бага хурлын дарга байсан. Самбуугийн мэдүүлгээр илэрсэн” гэж нэр илэрснийг үндэс болгон Дотоод яам 1937 оны 9 дүгээр сарын 15-нд түүнийг 3 дахь удаагаа баривчилжээ. Урд нь хоёр ч удаа ямарч гэм хийгээгүй байж улс төрийн хилс хэрэгт олон олон хоногоор орон шоронд хоригдон, хууль бус залхаалт цээрлүүлэлтийг амсан, дотоод, гадаадад цөлөгдөж явсан энэ хүнд гуравдахь удаагаа баригдахад нь юу бодогдоо бол?

1940 оны 3 дугаар сарын 30-нд Дотоод явдлын яамны орлогч сайд Жамбалдоржийн баталсан ялын төлөвлөгөөнд: Дотоод яам нь 1927 оноос хойш Японы тагнуул төлөөлөгч бөгөөд ардын дайсан Лхүмбэ нарын байгууллагыг удаа дараа устгаж ирсэн бөгөөд лам, Гэндэн, Дэмидийн байгууллагыг үе дараалан толгойлж, төв удирдагч нь байсан Лааган удаа дараа нуугдан хоцорч өөрийн ажлыг идэвхжүүлж байсан тул 1937 оны 9 дүгээр сарын 15-нд баривчилсан хэмээн уг баривчилсан шалтгаанаа тодорхойлжээ.

“Гэндэн, Дэмидийн хэрэг” гэгчид холбогдуулан Л.Лааганыг 2 жил 6 сар гаруй хугацаагаар мөрдөн хорьж, Дотоод явдлын яамны төлөөлөгчид түүнд “хувьсгалын эсэргүү байгууллагын гишүүн”<sup>56</sup> гэсэн тулгалт хийж, улмаар “хэзээ хэнд элсэгдсэн. Танай байгууллагын гишүүн хэн хэн болох, хэнийг элсүүлж авсан Юу хийсэн” зэрэг асуулт тавьж 19 удаа байцаажээ. Тэрээр эхний үед “эсэргүү хэрэг” гэгчийн талаар ямарч мэдүүлэг өгөөгүй байна. 1939 оны 12 дугаар сараас байцаагч Мэнд дахин байцаахад “хувьсгалын эсэргүү хэрэгт оролцож байсан удаа байхгүй. Харин баруун “зүүний” анги бүлэгт оролцож явсан нь үнэн. Анги бүлгийн тухай мэдүүлэг авахыг шаардаж байгаа бол би түүнийг мэдүүлнэ...”

Чойбалсан эд нар өөрсдөө нугалаа хийж явсан атал түүнийгээ над тийш түлхэж улстөрийн хэрэгт холбогдуулан байна. Би өөрийн эх орноосоо урвасан хувьсгалын эсэргүү байгууллагад оролцож

ажилласан удаа огт байхгүй учир... мэдүүлэх зүйлгүй”<sup>57</sup> гэж байсан бол дараагийн байцаалтаас эхлэн Дотоод яамны олон хоногоор шоронд суулгаж ядраах, зодож жанчих, тулгаж шахах, халуун, хүйтэн өрөөнд байцаах зэрэг хууль бус аргуудыг үл тэвчин “Японы төлөөлөгчтэй харилцаатай байсан. Зөвлөлтийн барааны захиалгыг хорогдуулан, 40 гаруй сургагчийг хасаж буцаасан. Ванчин Богдтой харилцаа байгуулах ажил зохиолцсон. Хасгуудаар дээрэм хийлгэх ажлыг зохион байгуулсан”<sup>58</sup> гэсэн хилс хэрэг хүлээжээ.

Үүнийх нь төлөө түүнд 1940 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн Улсын дээд шүүхийн 17 дугаар хурлаас түүнд “буудан алах ял”<sup>59</sup> оноожээ.

Л.Лааганыг барьж хорьсон, түүнд тулгасан хэрэг бол үнэнд үл нийцэх, залхаан цээрлүүлэх замаар гаргаж ирсэн худал ташаа гүтгэлгүүдээс бүрдсэн завхруулга байсныг түүх нэгэнтээ нотолжээ.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дэргэдэх цагаатгах комиссын 1962 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 80 дугаар хурлаар Л.Лааганд тулгасан хэргийг цагаатгасан байна.<sup>60</sup>

## САНАЛ, ДҮГНЭЛТ БОЛГОХ НЬ

1990 оны ардчилсан хувьсгал Монголд ялж, хүний эрхийг дээдлэх боломж нээгдсэн цаг үеэс хойш өнөө 27 жил болжээ. Монгол үндэстэнийг хоморголон алж устгасан, монгол үндэстэний оршихуйн үндсийг тасалсан улс төрийн хэлмэгдэлийн оргил үе болох 1937 оноос хойш 80 жил болжээ. Коммунист дэглэмд хэлмэгдэн золиос болсон монгол үндэстэний түүх, өнгөрсөн уламжлалын асуудлыг нэг мөр шийдэхгүйгээр монгол үндэстэн өөрийгээ таньж, өөрийн үндэсний өвөрмөц онцлог амин шалгуураа сэргээн, үндэсний дархлаа суулгаж, даяаршиж буй орчинтой хөл нийлүүлэн алхах орчин үеийн монголын нийгэм байгуулж чадахгүй болох нь тодорхой харагдаж байна.

“Миний бие тус Монгол ардын үндэсний хувьсгалд үнэнээс итгэн шүтэж өөрийн улсын тусгаар тогтнох явдал дор үнэнийг журамлан зүтгэж явсан”<sup>61</sup> хэмээн Зүүнтэний төлөөлөл болох Монгол Улсын төрийн тэргүүн байсан Л.Лааган хэлсэн бол “Би Монголын ард түмэндээ хайртай, би Оросын ард түмэнд элэгтэй, харин улаантан, тэдний засагт дургүй. Учир нь тэд аливаа том гүрний нэгэн адил Монгол улсыг эзлэн түрэмгийлэх бодлого явуулж байна”<sup>62</sup> хэмээн баруунтаны

57 НАХБ-ын ТА. Ф.БХ. хн.536

58 НАХБ-ын ТА. Ф.БХ. хн.536

59 НАХБ-ын ТА. Ф.БХ. хн.536

60 О.Батсайхан Лосолын Лааган: Төрийн тэргүүний хувь заяа УБ., УБ., 2007 он

61 Мөн тэнд

62 А.Амарын ЗХУ-ын Цэргийн коллегийн шүүхийн хурал дээр хэлсэн сүүлчийн үгээс

гол төлөөлөл болсон Монгол Улсын төрийн тэргүүн байсан А.Амар бээр хэлж байжээ.

Эндээс үзвэл, баруунтан байна уу, зүүнтэн байна уу гэдгээс үл хамааран чиг Монголын төлөө үнэнээсээ цохилох зүрхтэй л бол “хэлмэгдэл”-д өртөх ёстой гэсэн “хууль” үйлчилж байжээ. Ингээд хүн төрөлхтөний түүхэнд хар толбо суулгасан 1917 оны “Октябрийн хувьсгалын” 100 жилийн ойн жил, 1921 оны ардын хувьсгалын 96 жилийн ой, их хэлмэгдүүлэлтийн оргил болох 1937 оны 80 жилийн ой тохиож буйтай холбогдуулан дараах саналыг дэвшүүлэн тавьж байна.

1. Хэлмэгдэл монгол үндэстэнийг бүхэлд нь тодорхой урт цаг хугацаанд хамарсан улс төрийн асуудал тул улс төрийн дүгнэлт Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага болох УИХ-аас өгөх нь зүйтэй хэмээн үзнэ. Үүнд Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн холбоо, Цагаатгалын комисс, Хүний эрхийн байгууллагууд, Эрдэм шинжилгээний байгууллагууд хамтран эл хэлмэгдлийн асуудалд улс төрийн дүгнэлт гаргуулах талаар төрд шахалт үзүүлэх хэрэгтэй байна.

2. Нэгэнт эл асуудлаар Монгол Улсын төрөөс улс төрийн шийдвэр гарсны дараа уг асуудлыг аливаа улс төрийн намууд үндэсний эрх ашигт харшилсан хэлбэрээр тоглолт хийхийг хориглох нь зүйтэй.

3. Нэгэнт монгол үндэстэний хувь заяатай холбогдол бүхий асуудал тул Монголын төрөөс тусгайлан мөнгө гаргаж, хэлмэгдлийн талаар баримтат болон уран сайханы кино хийж түмэн үед хоцроох нь хойч ирээдүйд сургамж болно.

4. Улс төрийн талаар хэлмэгдүүлэлт гарахад гол шалтгаан болж нөлөөлсөн, нийгмийг ангичлан үзэх, аливаа асуудалд ангийн байр сууринаас хандах, нийгмийн болон хүний аливаа үзэгдлийг зөвхөн нэг өнцөгөөр харах, нэг үзэл сурталд таацуулах хандлага бий болгосон коммунист үзэл Карл Марксын үүсгэсэн, В.Лениний хөгжүүлсэн онол, И.Сталины хэрэгжүүлсэн ангийн тэмцлийн онол, улс төрийн үйл ажиллагаа (Гол зохион байгуулагч нь ЗХУКН-ын Төв Хороо, түүний УТТ, хэрэгжүүлэгч нь Коминтерн, Монголд МАХН) хийгээд үүн лүгээ адил монголчуудыг дотор нь хуваан талцуулсан аливаа үзэл суртлыг Монгол улсад хориглох хууль гаргавал зохилтой.

5. Гэмзэмгүй олон мянган монголчуудыг хууль бусаар хэлмэгдүүлж, амь насыг нь бүрэлгэн, амьдралаар нь хохироосон ЗХУКН, түүний төлөөлөл И.Сталин, МАХН, түүний төлөөлөл ЗХУКН-ын гишүүн, Лениний одонт Х.Чойбалсан нарын дарангуйлагчдын нүгэлийг цайруулах ямар ч үндэслэл байж таарахгүй. Учир нь эрдэнэт хүний амь наснаас илүү амжилт, хөгжил гэж байж таарахгүй. Бүр монгол үндэстэний оршихуйн үндсийг таслахад хүргэсэн гэм этгээдүүд хэмээн үзэх нь зүйд нийцнэ. Тиймээс он удаан жил төрийг зайдагнан

нэг хүний дарангуйлал тогтоосон тэдэнд хөшөө дурсгал үйлдэх нь монгол үндэстэн эгээтэй л өөрийгөө доромжилсон хэрэг болно.

6. Төр хэлмэгдэгсдээс уучлал гуйсан нь төр монголын ард түмний өмнө буруу үйлдэл хийсэнээ хүлээн зөвшөөрч буй хэмээн үзэх учиртай. Нэгэнт төрөөс буруутай үйлдлээ хүлээн зөвшөөрсөн учраас хэлмэгдэгсдэд нөхөх олговор олгох нь зүйн хэрэг. Гэвч 1998 онд батлагдсан хуулиар олгосон нэг сая төгрөг нь хэлмэгдсэн хүмүүсийн гомдлыг бүрэн барагдуулж чадаагүй, бөгөөд магадгүй тухайн цаг үеийн эдийн засгийн байдалд таацуулсан байж мэдэх тул эдүгээ монголын улсын төсөв их наядаар яригддаг байдалтай уялдуулан нөхөх олговрыг нэг удаа өсгөн нэмэгдүүлж олгох нь зүйд нийцнэ.

7. Монгол хүн бол Монголын төрийн хамгийн чухаг дээд үнэт зүйлс мөн. Монголын төрийн бүхий л шийдвэр зөвхөн энэхүү үнэт зүйлст зориулагдсан байх учиртай. Монгол үндэстэний ой санамжаа сэргээж, үнэт зүйлсээ эрхэмлэх, үндэстний эв нэгдлийг хангах эрхэм дээдлэгч зүйлсийн талаар монголын төрөөс шаардагдах хөрөнгийг гар таталгүй гаргаж, дэс дараатай бодлого явуулж, үндэстэний дархлааг нэн даруй бэхжүүлэх шаардлагатай байна.

Эс тэгвээс агуу түүхтэй монгол үндэстэн мөхлийн ирмэгт байна шүү.

### Ном зүй

А.Амарын ЗХУ-ын Цэргийн коллегийн шүүхийн хурал дээр хэлсэн сүүлчийн үгээс

О.Батсайхан Лосолын Лааган: Төрийн тэргүүний хувь заяа УБ., УБ., 2007 он.

МАХН-ын IV их хурал, УБ., 1978., 26 дахь тал

МАХН-ын V их хурал, УБ., 1980, 175 дахь тал

МАХН-ын VI их хурал, УБ., 1979, 259 дэх тал

МАХН-ын тогтоол шийдвэр, баримт бичгүүд. II боть, УБ., 1984, 249 дэх тал

МАХН-ын 7 дугаар их хурал, УБ., 1980

Намын VIII их хурлын илтгэл. I. УБ., 1930. 6-10 дахь тал

МАХН-ын Төв Хорооны Ш бүгд хурал (1928) эмхэтгэл

МАХН-ын товч түүх, нэмж засварласан гурав дахь хэвлэл, Улсын хэвлэлийн газар, УБ., 1985, 159 дэх тал

НАХБ-ын ТА. Ф-МБ. Х.н.1967, 71 дэх тал (Тагнуулын ерөнхий газрын архив)

НАХБ-ын ТА. Ф.БХ. хн.536



НТА. ф.2, д.4, хн.1, 122 дахь тал (МАХН-ын төв архив/

НТА. Ф.4. д.2, хн.57, 9 дахь тал

НТА. ф.1, д.1, хн.27, 80 дэх тал.

НТА. ф.1. д.3, хн.162, 116 дэх тал

НТА. ф.4. д. хн. 27, 112 дахь тал.

НТА. ф.4. д.5, хн.27, 133-114 дэх тал

НТА. ф.4. д.5, хн.27, 27-29 дэх талууд

НТА. ф.4. д.5, хн.27, 112 дэх тал

НТА. ф.4. д.5, хн.27, 116 дэх тал

НТА. ф.4, д.6, хн.84, 82 дахь тал

НТА. ф.4., д.3, хн.162, 27-33 дахь талууд

НТА. ф.4. д.4, хн.221, 157-159 дэх талууд

НТА. ф.4. д.4, хн.161, 154-155 дэх талууд

НТА. ф.4. д.5, хн.27, 19-21 дэх талууд

ҮТА. ф.11, д.1, хн.270

## МОНГОЛЫН НИЙГМИЙГ ҮЗЭЛ СУРТАЛЖУУЛСНЫ ҮР ДАГАВРЫГ ҮНЭЛЭХ НЬ



*Б.Баттөмөр  
Доктор (Ph.D)  
МУБИС-ийн Түүхийн тэнхим*

Дэлхийн хоёрдугаар дайны дараа нийгмийн хоёр систем тогтсон нь хүн төрөлхтнийг үзэл суртлын талаар хуваан зааглах үндсийг тавьж өгчээ. Дэлхий дахины хүчний харилцаан дахь хүйтрэлийн энэ үе нь тухайн систем дотор нэгэн талын өрөөсгөл үзэл бодол гүнзгийрч, догматизм лавшран суурьших, загвардсан хэвшмэл сэтгэлгээ түрэн орж ирэх боломжийг улам даамжруулжээ. Үүний улмаас олсон ололтоо зөвхөн социализмын хүрээнд харж, өөрөө өөртөө тайвшрал өгч, түүнийгээ зөвтгөн тайлбарлах, хөгжлийг дэндүү явцуу ойлгох явдал ч гүнзгийрчээ.

Үнэндээ социализмыг дан ганц хувийнх нь үзэл, хүч бололцоонд барьж атгаснаар дэлхийн дэвшил хөгжил, ялангуяа хөгжингүй орны үйлдвэрлэл, техник технологиос олон жилээр хоцорсон болно.

Манай улсад сургалтын бүх арга хэлбэр, ном хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, хурал зөвлөлгөөн, лекц, ярианы утга агуулгыг зөвхөн социализмаар хязгаарлаж, ийм байдал бас соёлын салбар, утга зохиол урлагийг ч тойрон гараагүй нь тодорхой билээ.

Хамгийн сөрөг үр дагаварын нэгэнд марксизм-ленинизмийн гол утга санааг гагцхүү социализмаар хэмжиж, түүнийг хэтэрхий явцуу, загварчилсан шинжүүдээр ойлгож, цөөн хэдэн зүй тогтол, зарчмыг нийтээр хатуу мөрдөн, сэтгэлгээний бүтээлч чанарыг хомсдуулах байдалд хүргэсэн нь хэт үзэл сурталжуулсны уршиг байлаа. Нөгөө талаар социализмын материаллаг үр өгөөжийг үйлдвэрлэлийн үндсэн фондын өсөлт, тав, гурван жилээр тооцоолсон төвлөрсөн төлөвлөгөөний үзүүлэлт, уралдааны дүн, нийгэмчилсэн өмчийн ашиглалт төдийгөөр хэмжих болсон нь социализмыг үзэх үзэл, түүний

практик хоёрын дунд зохиомол зөрчил бий болгосон гэхэд нэг их буруудахгүй болов уу.

1940 оноос МАХН улс нийгмийг удирдан чиглүүлэгч гол хүчин байсны хувиар нийгэм, улс төрийн амьдралын бүх шатанд бүхнийг намч чанартай болгон намын нэрийг өмнөө барьж, намаар далайлган бамбай хийх, нөгөө талаар нам ч өөрөө бүхнийг удирдан жолоодох чигээ өндөрт өргөх үзэлд автах болжээ. Энэ нь яваандаа намын дотор, нарийвчлан өгүүлбэл түүний удирдлагын нийт системд болон нам, улсын боловсон хүчний дотор олны санал бодлыг төдий л үл хайхрах, биеэ тоох, шүүмжлэлд дургүйцэх, хамтын удирдлагыг сулруулах, удирдагчийн ролийг тухайлбал Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал нарын байр суурийг удтал зөвтгөн бэхжүүлэх мэтийн үзэгдэл даамжрахын үндэс болжээ. Ийм байдал ажлын хариуцлага, нам, улсын сахилга, дэг журам, зохион байгуулалтын ажилд ч улс төр, үзэл санааны ухамсрын хувьд ч муу нөлөө үзүүлсэн билээ. Дурдан буй үед хөдөлмөрчин ардын диктатур “Үнэн” сонины толгойд тавигдсан пролетарынхаар солигдоогүй, харин эрх баригчдын дарангуйлал тогтсон бөгөөд улирах цагийн аясаар тэрхүү дарангуйлал улам хүчирхэгжсэн билээ. Социалист ардчиллын илэрхийлэл болсон сонгууль нэр төдий явагдаж (депутатыг танихгүй мөртөө сонгож байдаг) улс төрийн хуурамч ардчилал, үзэл суртлын хоосон амлалт, уриа лоозонгоор халхавчлан жинхэнэ бодит байдлыг нуун дарагдуулж, олон түмнийг төөрөгдүүлж байлаа.

Аппаратын ноёрхол тогтоож, хүнд суртлыг газар авахуулах, ёс төдий ардчиллыг хөгжүүлэх, нэг хүнийг тахин шүтүүлэх зэрэг нь тэдний дарангуйллыг бататгаад зогсохгүй, бэхжин хөгжихөд түлхэц өгч байжээ.

Дурдан буй үед хүн ардын оюун санааны баялгийг асуудал, үзэл суртлын ажил хоёрыг хэт хольж бүдүүвчлэн ойлгох болсны улмаас бүхнийг үзэл суртлын жингээр дэнсэлж, үзэл санааны талаас хардан сэрдэх явдал жилээс жилд ихсэх болсныг амьдрал нотолж байна. Ард түмний дайсан, социализм, ард түмний үйл хэрэг, найрамдал интернационализмд харш үгүйсгэх, үндсэрхэх үзэл, ревизионизм гэх мэтийн элдэв нэрээр сэхээтэн, жирийн хувь хүний эрхэнд халдаж, хардаж, тухайн хүний ажил амьдралын тодорхойлолт, намтар, анкет, бүртгэлийг нь хөтлөх төдийгүй, гадаадаас ирж буй захиа занааг хүртэл замаас нь уншдаг зэрэг зохисгүй харилцаа дэлгэрсэн нь тэр аяараа үзэл суртлын шинжтэй хэмжүүр байлаа. Хүн амыг ялангуяа мэргэжилтэй боловсон хүчнийг толгой дараалан хянан мөрдөх явдал бол дарангуйллын нэг гол чиглэл юм. Түүнээс гадна дотуур утаснаас авахуулаад хүний сэтгэл оюуныг түгшээсэн, цагдан хянасан бүхэл бүтэн тогтолцоо үйлчилж байв.

Социализм байгуулахын хэрээр ангийн дайсны эсэргүүцэл нэмэгддэг хэмээх Сталины онол амьдралд хэрэгжиж, нам, эвлэлийн гишүүд, сэхээтэн, олон нийтийг сэм тагнах, тэдний үзэл бодол, улс төрийн байр суурийн тухай дүгнэлт гаргуулах гэх мэт ажлыг хийж байжээ. Бие биенээ хардах, сэрдэх явдал газар авчээ. Үүний илрэл нь 1947 онд гадаадын тагнуулын ”Порт-Артурын” хэрэг гэгчийг ДЯЯ бүрдүүлэн, түүнд холбогдуулан 80 гаруй хүнийг баривчлан шийтгэсэн болон нам, улсын их хурлын төлөөлөгчдийг хүртэл мөрдөн мөшгиж, хэлсэн ярьсныг нь тагнаж байсан явдал мөн. Ийм учраас бүтээлчээр бодож, сэтгэх хүрээ явцуурч, зарим талаар сургууль, ном зохиолд орчин цагийн сэтгэлгээ давамгайлж, малчин монголчуудын маань тал шигээ талбиун, уужим сэтгэдэг хийсвэр сэтгэлгээ хумигдахаас аргагүй хөрс суурь баттай бэхжижээ.

Намын удирдах ажилтан бэлтгэдэг Намын шинэ хүчний дээд сургуулийг байгуулж, “ухаан бүхний охь манлай болсон марксизм-ленинизмийг судлах”-ыг эрхэм зүйлд үзэн Эв хамт намын түүх, Шинжлэх ухаан коммунизмын онол, Олон улсын ажилчны болон үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний түүх, МАХН-ын түүх, нам ба улсын зохион байгуулалт, СССР-ийн гадаад улсуудад явуулах төрийн бодлого, Зөвлөлтийн ард түмний эх орны дайн<sup>1</sup> зэрэг үзэл суртлаар дэнслэгдсэн хичээлүүдийг зааж байсан нь дэндүү туйлширсан хэрэг байсан билээ.

Гэтэл Намын Төв Хорооны баримт бичгүүдэд монголын ард түмний оюун санааны үндэс нь марксизм-ленинизм боллоо гэсэн дүгнэлтийг оруулж, манай хүмүүсийн дийлэнх олонх нь нийгмийн үзэгдэл, орчин үеийн дэлхий дахины амьдралын асуудалд марксист-ленинист үзэл суртлын үүднээс хандсан ухуулга, суртал нэвтрүүлгийг л хүлээж авна гэх мэтээр өргөн сурталчилж байсан аж. Дээрх дүгнэлтийг 1958 оноос хийсэн бөгөөд 1960-аад оны эхнээс үзэл суртлын нийт ажил дээр социализмыг шулуун дардан замын ойлголт болгон тавьж, социалист байгуулалтыг онцын зөрчил, бартаа саад багатай хялбарчилсан үйлс мэтээр үзэж, түргэн дуусгах гэж нам, улсын үндсэн баримт бичгүүдэд ч, суртал ухуулгын ажилд ч нэгэн адил дүрслэх болсон байна.

Социализмын онол, практикийн асуудал бүхэнд цаг тухайд нь нарийн дүн шинжилгээ хийж, зөрчил бэрхшээлийг даван туулах арга замыг боловсруулахын оронд онол, практикийн гол дүгнэлтийг нам, улсын цөөн тооны удирдах бүрэлдэхүүн хийж, гаргасан шийдвэр чиглэл бүхэндээ онцгой эрх өгснөөр, үзэл суртлын ажил өөрийн онол, шинжлэх ухааны бэл суурь муутай байдалдаа автан, амьдралтай хөлөө төдий л сайн нийлүүлж явж чадахгүй байсныг эргэцүүлэн бодох нь зайлшгүй.

1 Үнэн 1946.1.16. №16

Үүний зэрэгцээ социалист бусад орны туршлагад түлхүүхэн байр өгч, хөгжлийн өөр түвшин, өөр ахуй нөхцөлийн байдлыг оновчтой харгалзан бүтээлчээр хандалгүйгээр хуулбарлан дууриах сэтгэлгээг хөгжүүлж, сэтгэлгээний бэлэнчлэх аргыг нам, төр аж ахуй сургалтын бүх аргад өргөн хэрэглэх болсныг тэмдэглэвэл зохих болов уу.

Улс төрийн хүрээнд эл үеийг Монгол улсын түүх бүтээлд “... нийгэмд нам, төрийн дээд түвшинд нэг хүнийг тахин шүтэх, ганцаар захирах ёс, захирагдах арга оршсоор байсан нөхцөлд хоосон шийдвэр, тунхаг төдий болж, ажил амьдрал дээр захиргаадалтын эрх сургааль улам чангарч байв. Нэг хүнийг тахин шүтэх явдал, түүний шууд сүүдэр тусгал болсон захиргаадалт саарсангүй улам өргөжин гүнзгийрч байв. Тэр нь 1945 онд Х.Чойбалсангийн 50 насны ой, 1949 онд Сталины 70 насны ойг өргөн дэлгэр тэмдэглэх үеэр дээд цэгтээ хүрчээ. 1940-1953 оны үеийн БНМАУ-ын улс төрийн тогтолцоо нь:

1. Дайны үеийн нөхцөл байдлаас шалтгаалан удирдлагын төвлөрөл, хатуу диктатурт түшиглэсэн;

2. Дайны дараа олон улсын хүчний харьцаа өөрчлөгдөж капиталист, социалист хоёр систем зэрэгцэн орших болсноор үзэл суртлын хүлээсэнд баригдсан байв”<sup>2</sup> хэмээн тэмдэглэсэн нь зөв тодорхойлолт юм.

Соёлын хүрээнд 1950-1960-аад онд гарсан орчин үеийн сэдэвт үндэсний жүжгүүдэд хоорондоо төстэй, давтагдсан шинжтэй, амьдралаас тасархай, номлол сургамжийн аястай дүрүүд түгээмэл байлаа. Энэ нь шинэ хуучны зөрчлийг арилгах ойлголтын дор зориудын зөрчил бий болгож, гарах дүрүүдийг хоёр талд хувааж, сөрөг талын баатрууд нь эерэг баатруудынхаа нөлөөгөөр хүмүүжин зөв замд орж буйгаар амьдралыг “гоёчлон засварлаж үзүүлдэг” байсантай холбоотой. Иймээс дүрийн сэтгэхүйд тулгуурлан баатруудын харилцаагаар дамжин илрэх ёстой урлагийн хөдөлгөгч хүч, түүний амин утга санаа болсон зөрчлийн тухай ойлголтыг “зөрчилгүйн онол” гэгчээр бүдгэрүүлэн хучиж, үзэл сурталжуулсаны алдаа юм.

Өнгөрсөн зууны түүхэнд Монголын төр хуучнаа уламжлан хадгалах үүрэг гүйцэтгэж, цаг үеийн шаардлагаар агуулга, хэлбэрээ хувьсган шинэчилж байсан бол ардын төр засаг хуучныг эвдэх, шинийг бүтээн байгуулах үндсэн хоёр талтай үүрэг гүйцэтгэж байсан байна. Гэтэл энэ хоёрын диалектик алдагдсан. Үгүйсгэлийн хуулиар хуучин үеэ өнгөрөөсөн шинж, тал харилцаа зэргийг халах ёс механик үгүйсгэл буюу устгалт болж хувирсан, хуучны хамаг зохистойг уламжилж авах ёсыг алдагдуулсан. Энэ нь Монгол орныг феодализмаас капитализмыг алгасуулан ардчилсан хийгээд социалист үе шаттайгаар социализмд дэвшүүлэх гэсэн “онолын” буруу чиглэл, түүнийг ягштал баримталсан

2 1 Монгол улсын түүх. Тавдугаар боть. УБ., 2003. тал 270

бөгөөд ЗХУ-ын заавар зөвлөгөөнийг үг дуугүй дагасан, юм бүхэн дээр Зөвлөлтийн социализмын загварыг механикаар хуулж мөрддөг байсан, МАХН-ын хэт ангичирхаж, намчирхаж, үзэл сурталжуулж байсан үйл ажиллагаатай шууд холбоотой юм. Энэ бүхэн нь нийгэм, орон зай, газарзүйн байршил, цаг хугацааны хувьд түүхэн гарцаагүй байдалтай холбоотойг хэлэх хэрэгтэй юм.

Үүний хамт 1950-1960-аад оны нийгмийг шинэчлэх, ардчилахын төлөө тэмцэл, үндэсний өв соёлоо хайрлан хамгаалж, бахархах үндэсний үзэл нь огт үр дүнгүй өнгөрсөн хэмээн үзэж бас үл болно. МАХН-ын Төв Хорооны УТТ-оос гаргасан 1949 оны 56/104-р тогтоол, 1956 оны 413-р тогтоолыг хүчингүй болгох саналыг сэхээтнүүд удаа дараа тавьж байсны дүнд Чингис хааны талаар гаргасан зарим буруу заалтыг засч залруулан Монголын түүхэнд түүний гүйцэтгэсэн эерэг үүргийг бодитойгоор үнэлэх болсон билээ. Мөн МАХН-ын Төв Хорооны УТТ-ноос 1956 оны 10 сарын 23-нд “Соёлын өвийг хамгаалах тухай” 346-р тогтоолыг гаргаж байв. Уг тогтоолд 1937 оноос хойш үндэсний соёлын өв болсон уран зохиол, түүхийн дурсгалт бичгүүдийг нийтлэх ажил зохиогдоогүйг дурдаад өвөг ДЭЭДСИЙНХЭЭ ҮЕЭС ХАДГАЛЖ ИРСЭН ХУУЧИН ном судрыг харгис хуучны юм гэж буруушаан үзэж болохгүйг онцлон тэмдэглээд, “Түүх, утга зохиол, ард түмний зан заншил, ёс суртахууныг судлах явдалтай холбогдсон хуучны ховор түүх, судар, ном бичгүүдийн нэрсийн жагсаалтыг гарган тодорхойлж, улмаар орон нутгийг судлах кабинет, соёл гэгээрлийн бусад газруудаар дамжуулан нийтэд зарлаж цуглуулах, түүх дурсгалын бусад материалыг үрэгдүүлэн сүйтгэх ажлыг явдлыг зогсоож, тэрхүү өвийг хайрлан хамгаалах, арчлан хадгалах талаар сурталчилгаа хийх, маш ховор үлдсэн түүх, утга зохиол, бусад төрлийн зарим зохиолуудаас жил бүрийн хэвлэлийн төлөвлөгөөнд оруулж хэвлүүлж байхыг аймаг хотын нарийн бичгийн дарга нарт даалгажээ<sup>3</sup>.

МАХН-ын Төв Хорооны УТТ-ноос 1957 оны 10 сарын 17-ны өдрийн хуралдаанаас “Түүх дурсгалын зарим уран барилгыг хайрлан хамгаалах ба сэлбэж засах тухай” 328-р тогтоолыг гаргасан байна. Тогтоолд, “Тус улсын нутаг дэвсгэрт байгаа түүх дурсгалын зүйлүүд ба эртний уран барилгуудыг хайрлан хамгаалах талаар анхаарч, ойрын жилүүдэд Чойжин ламын сүм, Эрдэнэ зуу, Богдын ордон, Амарбаясгалангийн дурсгалт барилгуудыг засварлах талаар арга хэмжээ авахыг Соёлын яаманд, соёлын өв болсон ном бичиг, түүх дурсгалд холбогдсон баримт материалиудыг цуглуулж, орон нутгийг судлах кабинет, музейнүүдийн үзмэрийг баяжуулах ажил зохиох, соёлын өвийг хайрлан хамгаалахын ач холбогдлыг хөдөлмөрчдийн дунд өргөнөөр сурталчилахыг аймаг, хотын намын хороодын нарийн бичгийн дарга нарт даалгажээ<sup>4</sup>.

3 1 УТА. МАХН-ын баримтын төв. Х-4, Т-3, ХН-26. тал 124

4 2 УТА. МАХН-ын баримтын төв. Х-4, Т-4, ХН-24. тал 5-6

Эдгээр тогтоолууд нь монголын ард түмний түүх, соёлын өвийг бүртгэх, хадгалан хамгаалахад зохих үр дүнгээ өгсөн юм. Гэвч нийгэмд “пролетарын интернационализмын зарчим”, “социалист үзэл суртал”-ыг хүчтэй сурталчлан нэвтрүүлэх болсноор үндэсний өв соёлд хандах дээрх эерэг шийдвэрүүд нь өрөөсгөл, дутуу дулимаг хэрэгжихэд хүргэсэн юм.

МАХН-ын бодлогыг бүрэн биелүүлэхэд үзэл суртлын ажил тэргүүлэх үүрэгтэй байх ёстой хэмээсэн чиглэл 1940-өөд оноос дээд цэгтээ хүрч, сумын намын хорооноос эхлээд МАХН-ын Төв Хороо хүртэлх бүх шатны байгууллагад үзэл суртлын ажлыг намын үүрийн товчооны нэгээс хоёр гишүүн, эсвэл аймаг, хотын намын хороодод үзэл суртлын тасаг буюу хэлтэс (4-6 ажилтантай), Төв Хороонд үзэл суртлын хэлтэс хэд хэдэн тасагтай ажиллаж байжээ. Эдгээр тасаг хэлтсийн ажилтнуудын цалин, аппаратын зардалд улсын төсвөөс үлэмж хэмжээний хөрөнгө зарцуулж байжээ. Гэвч аж ахуйн ажлын биелэлтэд намын үзэл суртлын ажил дэм туслалцаа үзүүлэхээсээ илүү зарим тохиолдолд сөрөг үр дагавар бий болгох нь түлхүү байсныг тэмдэглэж байна.

Хураангуйлж хэлэхэд, монголын нийгмийн захиран тушаах тогтолцооны улс төр, танин мэдэхүйн үндэс нь ард олонд үл итгэн, ардчилсан шинжтэй үйл ажиллагаанд болгоомжтой хандаж байсан, үзэл суртлын үндэс нь марксизм-ленинизмийн сталинчлагдсан хэлбэр болж байжээ. Эл тогтолцоо 1980-аад оны дунд үе хүртэл бат үндэстэй, тогтвортой хадгалагдаж байсныг түүхэн үйл явц нотолж байна.



## ҮНДЭСНИЙ ЭРХ АШИГ БА СЭХЭЭТНИЙ ХЭЛМЭГДЭЛ



**Үндсэрхэх үгүйсгэх үзэлтэн,  
төөрөлдсөн сэхээтэн, намын  
эсрэг бүлэг гэгдэгчид  
(1940-1960 ОН)**

*Ж.Баасандаш  
Эдийн засагч  
Монголын улс төрийн хэлмэгдэгсдийн  
холбоо*

Монгол Улсын 1924 онд батлагдсан Үндсэн хуулиар иргэдээ “жинхэнэ ард”, “жинхэнэ бус ард” гэж хоёр хуваагаад “жинхэнэ бус”-чуудыг хөнөөх дайн 70 жил дэгдсэн, энэ дайнд олон мянган лам хуврагууд, тайж язгууртнууд, төр нийгмийн зүтгэлтнүүд хамрагдсан билээ. Иргэдээ хомрогolon хөнөөх ажиллагаа үүгээр зогссонгүй, цаашид өргөжиж үндэсний эрх ашгаа дээдлэн хамгаалахын төлөө сэтгэсэн бүхнээ хөнөөх болжээ. Энэхүү гашуун түүхийн нэгээхэн хэсгийг буюу 1950-60-аад онд нам, төрөөс сэхээтний эсрэг явуулсан “булчингаар хариу авах” залхаан цээрлүүлэлтийн тухай баримтад түшиглэн бэлтгэсэн товч илтгэлийг танилцуулж байна.

“Эрдмээ барвал эдээ барна” гэж эцэг дээдэс маань сургадаг билээ. Цин улсын эзэн хаан Шихуанди М.Э.Ө. 221 онд төрийн толгойд гармагцаа эрдэмтэн мэргэдээ цөмийг нь амьдаар нь газар булах тушаал буулгажээ. Тэрхүү балмад үйлдэл 2000 гаруй жилийн дараа манай улсад давтагдаж, төрийн эрх баригчдын зүгээс мэдлэг оюунтнаа хөнөөх хар нүгэлийг олон арван жилийн турш үлджээ. Үндэсний сэхээтнүүдээ ийнхүү үзэл бодлоор нь ялган бүлэглэж, үзэн ядаж, хомрогolon хөнөөх учир шалтгааны уяа зангилаа ганцхан байжээ. Энэ нь үндэсний язгуур эрх ашгаас урган гарч байв. Их Британийн улстөрч Г.Пальмерстон «Англи Улсад мөнхийн дайсан гэж байхгүй, мөнхийн анд ч гэж байхгүй, гагцхүү мөнхийн эрх ашиг л бий» гэж хэлсэн нь аливаа орны үндэсний аюулгүй байдлын бодлогын үндсэн зарчим болжээ. Энэ оршлыг хэлээд үндсэн сэдэвтээ та бүхний анхаарлыг хандуулья.

### Нэг. Үндэсний үзэлт сэхээтнээ хөнөөх болсон учир шалтгаан

Монгол орон төв азийн өндөрлөгт өргөн уудам газар нутагтай, цөөхөн хүн амтай, бараг хэмжих боломжгүй их эрдэс баялагтай билээ. Энэхүү онцлог болон их нөөцийн талаар манай хоёр хөрш ялангуяа Орос орон биднээс илүү мэдээлэлтэй. Нөгөө талаар Монгол орон хүчирхэг хөршүүдийн хооронд халхавч, бамбай байсаар ирсэн, цаашид ч энэ үүрэг хэвээр байх болно. байв МАХН-ын IX их хуралд зааварчлага өгөөд буцсан төлөөлөгч Б.Шмераль Коминтерний Дорнодын нарийн бичгийн дарга нарын газрын зөвлөлгөөн дээр тавьсан илтгэлдээ дурдсан “Монголын хүн ардаас илүү газар нутаг нь чухал шүү” гэсэн анхааруулга Сталинд үнэтэй мэдээлэл. XX зуунд хойт хөрш илүү хүчирхэгжих хэрээр стратегийн түүхий эдийн хэрэгцээ гэрлийн хурдаар өссөн. Амандаа мөнгөн халбага зуусан Монгол орныг их орос гүрэн эрхшээл нөлөөндөө авахын тулд ОСИХ-ыг экспортолож, бодлогоо хэрэгжүүлэх аянд морджээ. Энэхүү бодлогоо маш уран, холын бодолтой аргаар хэрэгжүүлсэн байдаг. Тухайлбал:

- Ангийн тэмцлийн онол, пролетарийн диктатурын үзэл санаанд суурилсан үндсэн хуулийг 1924 онд коминтерний удирдамж, зааврын дагуу хүчлэн батлуулж мөрдүүлсэн нь хуульчилсан төрийн эргэлт байлаа. *(1993 онд хэвлэгдсэн “Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн дурсгал цагаан ном”-д дурдсанаар 1921-1953 оны хооронд төрийн эсрэг гэмт хэрэг 40 гаруй удаа гарч 80000 орчим хүн холбогдон хэлмэгдсэн баримжаа тооцоо буй гэжээ. 1953 оноос хойш энэ тоо ихээхэн нэмэгдэнэ. Хэлмэгдсэн хүмүүс эхнэр хүүхэд, эцэг эх, төрөл садантай)*
- Шинэ Үндсэн хуулийг хэрэгжүүлэх явцад үндэсний онцлог, түүхэн уламжлалыг таслан хааж, дуулгавартай захирагдах цөөнхийн дарангуйлал тогтоосон. *(“БНМАУ-ын төр, нийгмийг удирдан чиглүүлэгч хүч бол бүхнийг ялагч Марксист-Ленинист онолыг үйл ажиллагаандаа удирдлага болгодог МАХН мөн” гэж Үндсэн хуульд тунхаглан зааснаар Монголд МАХН хэмээх хэсэг бүлгийн хязгааргүй ноёрхол тогтоож, тусгаар тогтнолын баталгаа алдагдаж, ардчилал, төр хоёр мөхсөн түүхтэй/.*
- 1940-өөд он болоход Монголын хувьсгалт хэмээх нам, ардын хэмээх төр засаг ор нэрийн төдий болж эзгүйрсэн эгзгийг тааруулж ОКБН, Сталинизмын эрх ашигт үг дуугүй захирагдах дуулгавартай гүйцэтгэгчийг сонгон бэлтгэж, өндөр эрх мэдэл олгон тэтгэж ажиллуулсан. Ийм гүйцэтгэгч нь Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал хоёр гэдэг нь нууц биш болжээ. Энэ хоёр эрхэмд хоёуланд нь шинэ албан тушаал бий болгож НКВД (ЗХУ-ын дотоод хэргийн ардын комиссарын газар), КГВ (Улсын аюулгүй байдлын хороо)-ын дохио зангаа, байнгын хяналт дор ажиллуулсан байна.

- Ийнхүү “Өөрийн хүн”-ээрээ дамжуулан Монгол орон аажмаар их оросын хөнжилд орох бэлтгэлийг алгуур, шаргуу бэлтгэсэн. *(төрийн бүтцийг орос загварт шилжүүлсэн, удирдлагын бүх салбар хэсэгт зөвлөх мэргэжилтэн 30000 орчим орос хүн ажиллуулах болсон, төрийн гол албан хэргийг орос хэлээр хөтлөн явуулсан, нутаг дэвсгэртээ 100000 орчим бүрэн зэвсэглэсэн орос цэрэг байрлуулсан, боловсон хүчнийг үнэлэх үндсэн шалгуур нь орос хэлний мэдлэг гэж үзэх болсон, оросыг дээдэлж, хятадыг үзэн ядах сэтгэлгээг төлөвшүүлсэн, Монголчууд өөрсдөө Оросын холбооны улсад нэгдэн орох санал хүсэлт гаргах ажлыг зохион байгуулсан/*

Тодруулга. 1933 оны гурваас есдүгээр сард буюу Х.Чойбалсан (НКВД, КГБ-ын хатгалгаар Лхүмбийн хэрэгт орооцолдсон) Москвад 6 сар суусны дараа нутаг буцдаг өдрөө ЗХУ-ын Батлан хамгаалахын ардын комиссар бөгөөд БХКБН-ын ТХ-ны дэргэдэх Монголыг хариуцсан комиссын ахлагч Ворошиловт бичсэн захидалдаа “...намайг Москвад байх хугацаанд та...үнэлж баршгүй гүн итгэл хүлээлгэснийг бидний нийтлэг үйл хэргийн төлөө чин үнэнч тэмцлээр хариулж, түүнийг би үлдэж буй амьдралынхаа зорилго болгоно” гэжээ. 1936 онд ДХГ-ыг ДЯЯ болгон өөрчилж сайдаар нь 1895 онд төрсөн, 41 настай Х.Чойбалсан томилогдсон. Мөн ондоо Мал тариалангийн яамны сайдаар, 1940-1950 онд Ерөнхий сайдаар ажилласан. Тэр 1937 онд БНМАУ-ын Бага хурал, СнЗ-ийн тогтоолоор Цэргийн яамны сайд, бүх цэргийн жанжнаар томилогдсон.

1916 онд төрсөн, 24 настай Ю.Цэдэнбал 1940 онд МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга хэмээх шинэ албан тушаалд томилогдсон. Ю.Цэдэнбал 1984 оны 8 дугаар сарын 20-нд ЗХУКН-ын ТХ-нд хандаж бичсэн захидалдаа “Суут Лениний эх орон ЗХУ-д болон түүний ленинч ЗХУКН-д үргэлж үнэнч байсан бөгөөд эцсийн амьсгалаа хүртэл үнэнч байх болно” гэжээ. Ю.Цэдэнбал 1944, 1949, 1953 онд Монголыг ЗХУ-ын нэг республик болгох хүсэлтийг зохион байгуулж, 1949 онд өөрөө ЗХУК(б)Н-ын гишүүн болох хүсэлт тавьж байжээ.

Ю.Цэдэнбал 44 жил жил нам, төрийн хамгийн өндөр албан тушаалд ажиллахдаа Монгол орныг ОХУ-д нэгтгэх холын санаагаа гүйцэд хэрэгжүүлэх, үүний тулд эрх мэдэл, албан тушаалаа хадгалах, улмаар тусгай хангамж эдэлж жаргах, энэ зорилгоор тойрон хүрээлэгчдийн баг бүрдүүлж, өөрийнх нь эрх ашгийн эсрэг санаа бодол бүгдийг хайр найргүй нухчин дарж, залхаан цээрлүүлж ирсэн байна.

### **Хоёр. 1950-1960-аад онд монголын гадаад, дотоод нөхцөл байдлын тойм**

60 сая хүний амийг авч одсон дэлхийн II дайны дараа хүн төрөлхтөн дайн самуунаас уйдаж бүхний анхаарал сэргээн босголт, бүтээн байгуулалтад чиглэсэн мэт байв. Гэвч сөргөлдөгч талуудын хоорондын улс төр, үзэл суртлын тэмцэл зогсоогүй төдийгүй улмаар хүйтэн дайн нэртэй өрнөсөн.

Сталины удирдсан Дорнодын эвсэл 1949 онд бүрэлдэн тогтжээ. Үүнтэй зэрэгцэн Маршалын төлөвлөгөө буюу Өрнөдийн эзэнт гүрний эвсэл, улмаар Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг байгуулагдсан.

Зүүн Европт Сталины үйлдэж буй хэрэг явдлын хариу болгож АНУ, Канад, Их Британи, тэрчилэн Европын болон Скандиновын хэдэн улс 1949 онд Умард Атлантын гэрээний байгууллага НАТО-г үүсгэн байгуулав.

НАТО байгуулагдсантай зэрэгцэн ЗХУ хариу барьж, Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл (ЭЗХТЗ) буюу СЭВ-ийг байгуулсан бөгөөд энэ нь «төмөр хөшиг»-ний ард байгаа орнуудын хоорондын худалдааг дэмжих, Дорнод Европын орнуудад санхүүгийн туслалцаа үзүүлэх хөтөлбөр гэж нэрлэж байв. Монгол Улс тус зөвлөлд 1962 онд гишүүнээр элссэн.

Хүйтэн дайны ид үед сөргөлдөгч талууд хамтран ажилласан нэгэн сонирхолтой түүх нь тэд 1945 онд НҮБ-ыг үүсгэн байгуулсан явдал байв. Шинэ байгууллага нь хүний эрхийг дээдлэх, Дайн, Өлсгөлөн, Өвчин, Үхэл дөрвөөс хүн төрөлхтнийг ангижруулах явдлыг эрхэм зорилгоо хэмээн ил тунхагласан. Эдүгээ дэлхийн 172 орныг эгнээндээ нэгтгэсэн энэхүү хүчирхэг байгууллагад Монгол Улс 1961 оны 10 дугаар сарын 27-нд гишүүнээр элсэн орж манай гадаад харилцаанд чухал алхам болсон.

1960-аад оны үед дэлхийн коммунист, ажилчны намуудын харилцаанд ч бас үлэмж зөрчил, маргаантай байжээ. 1954 онд БНАГУ, Польшид, 1956 онд Унгарт, 1964 онд Польшид, 1968 онд Чехид социализмыг эсэргүүцсэн, ЗХУ-ыг эсэргүүцсэн олон нийтийн хөдөлгөөн, тэмцэл хүчтэй өрнөж, тэдгээрийг ЗХУ, СЭВ-ийн орнуудын цэрэг, танкийн хүчээр цус урсган дарсан. Энэ үед Хятад Зөвлөлтийн харилцаа бүр дайсагналын байдалтай, Хятадын зүгээс Зөвлөлтүүдийг “социалист-империализм” гэж шуудхан нэрлэж байв.

Социалист гэгдэх ертөнцийн дотоодод үүссэн маргаан зөрчлийг шийдвэрлэхийн тулд 1957 онд Москвад 64 орны коммунист ажилчны намууд зөвлөлдөж тунхаглал, 1960 онд олон улсын коммунист

ажилчны намуудын 80 гаруй орны төлөөлөгчдийн зөвлөлгөөн зохион байгуулж уриалга бичиг гаргасан. Ийнхүү олон оролдлого хийгдсэн боловч үүссэн зөрчил, маргааныг бүрэн шийдвэрлэж чадаагүй ажээ.

Социалист системийн орнууд энэ үед дотроо гурав хуваагдаад байжээ. ЗХУКН-ын бодлогыг Ардчилсан Герман, Болгар, Куба улс дэмжиж байсан бол Хятадын талд Албани, Румын, Югослав улс багтаж, Польш, Чехословак, Унгар, Вьетнам, Ардчилсан Солонгос төвийг сахиж, хоёр их гүрний аль алинтай нь аядуу харилцаж, эв түнжинтэй байх дундаж байр суурь баримталж байв.

Харин Монгол улс газар зүйн байршлын хувьд Орос ба Хятад хоёр их гүрэнтэй сайн хөршийн харилцаатай байх, төвийг сахисан бодлого баримтлах цорын ганц зам байсаар атал Ю.Цэдэнбал тэргүүтэй МАХН-ын ТХ-ны УТТ “Хятадын аюул” гэдэг нэртэй сүржин баримтлал зохиож ЗХУКН-ын бодлогыг аялдан дагах болсноор өөрийн эх орон, ард түмэндээ үлэмж хохирол учруулжээ.

Тухайлбал, 1950-иад оноос эхлэн урьд их хөрштэй тогтоосон найрсаг хамтын ажиллагаа тасалдаж, Хятад улсаас манайд үзүүлж байсан зээл, тусламж хаагдсан байна. Өмнөх 10 гаруй жилд БНХАУ-ын тусламжаар байгуулагдаж байсан үйлдвэр, орон сууц, зам, гүүрийн ажлууд зогсож, эдгээр барилга байгууламжуудад ажиллаж байсан өндөр мэргэжилтэй, хямд зардалтай олон мянган хятад ажилчид нутаг буцахад хүрчээ. Хятад ажилчид цалин хөлс, орон байр голдоггүй байв.

Түүнээс гадна Монголчуудын хэрэглэж дассан чанар сайтай бээжин бараа, Хятад улсаас манайд бэлтгэн нийлүүлж байсан үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, хөдөлмөрийн багаж хэрэгсэл, түүхий эд тасалдахад хүрч зөвхөн хойт ахын гар харахаас өөр өргагүй болжээ. Энэ бүхэн эрх баригч МАХН-ын гадаад бодлогын алдаа байлаа.

1950-1960-аад онд Улс орны хөгжил зогсонги болж, ард түмний амьдралын түвшин эрс доройтсоны нөгөө нэг гол шалтгаан нь МАХН-ын дээд удирдлагын дотоод бодлогын гүнзгий алдаанаас үүдэлтэй байжээ. Тухайлбал:

**Нэгд,** Нэгдэлжүүлэх хөдөлгөөний бодлогын алдаа ноцтой сөрөг үр дагаварт хүргэсэн байна. МАХН мал сүргийг нийгэмчилж, малчдыг нэгдлийн гишүүнд элсүүлэх ажлыг 1959 онд дуусгасан. Монголын малчин өрх орон сууц, хоол хүнс, хувцас хунар, унаа унаш зэрэг өөрийн бүхий л хэрэгцээгээ хувийн өмчийн мал сүрэгтээ түшиглэн хангаж ирсэн нүүдэлчин ард түмэн. “1921 оны ардын хувьсгалын ялалттай эн зэрэгцэхүйц ач холбогдолтой хувьсгалт том өөрчлөлт.” хэмээн Ю.Цэдэнбал даргын тодорхойлсон МАХН-ын алдаатай бодлого хэрэгжсэнээр 1959 оны эцэст ардын аж ахуйтны 99 хувь, мал сүргийн

73.3 хувь нь нийгэмчлэгдсэн байв. Өөрөөр хэлбэл малчдыг Марксын нэрлэсэн “гинжнээсээ өөр алдах юмгүй хөл нүцгэн” порлетари болгож, социализмыг Монголд малгүй малчдын хүчээр бүтээн босгох гэсэн харалган оролдлогын биелэл байв.

Хувийн өмчийн мал, сүргээсээ салж хагацсан олон мянган иргэд амьжиргааны эх үүсвэргүй болж, ядуусын арми бүрдүүлсэн. Нэгдлийн гишүүд нийгэмд хураалгасан малаа хариулдаг хөлсний зарц нар болжээ. Хамгийн гол нь тэдний “хөдөлмөрийн хөлс” хэмжээний хувьд тун бага бөгөөд тэр нь хувцас, хоол болон наад захын хэрэгцээнд огт хүрэлцэхгүй байв. Тухайлбал Өвөрхангай аймгийн Сант суманд нутаг заагдан цөлөгдөөд байсан хоньчин Ц.Лоохуузын сарын цалин 17 төгрөг 80 мөнгө байжээ. Малчид халуун зунаар хар цай ууж, нярайлсан эхнэртээ шөл оочуулахын тулд нэгдлийн даргын контор сахиж царайчлах болсон.

**Хоёрт**, Монгол оронд социализм байгуулахад саад болох бас нэг аюул бол хувийн хэвшил гэж МАХН үзэж байв. Хувийн өмчит малчин өрхүүдийг нэгдэлжүүлсэний дараа гол төлөв хот суурин газруудад эрч хүчтэй хөгжиж байсан хувийн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааг 1959 онд хааж бас нэг бүлэг ядуус бий болжээ.

Хувийн өмч, хувийн хэвшлийг ийнхүү зориуд устгаснаар ард түмний амьдрал дээшлэхийн оронд “эрс доройтол” нүүрлэсэн. Ардын хувьсгалын эхний жилүүдэд “жинхэнэ бус ард” буюу “хар шар феодалууд”-ын эд хөрөнгийг цөлмөн хурааж тэднийг сөнөөн устгасан аймшигт гэмт хэргийн үргэлжлэл ийнхүү энгийн иргэдийнхээ амьжиргааг тасалсанаар үргэлжилжээ. Ард олны хоол, хувцас, үйлчилгээг хангаж байсан хувийн хэвшлийг ийнхүү хааж хориглосноор ачаалал улсын нуруун дээр тохогдож төрийн өмчит аж ахуйнууд энэ ачааллыг даахгүй болж ард иргэд мах, сүү, гурил, талх олж авахын тулд очерь хэмээх урт дараалалд удаан зогсож, хоосон хонохгүйн төлөө дайн дэгдсэн. Энэ үед манайд улс, хоршооллын ердөө л 170 үйлдвэртэй, эдгээр нь хэзээ ч хүчин чадлаа гүйцэд ашиглах боломжгүй алдагдалтай, газар тариалан огт хөгжөөгүй, гадаадаас гуйлга гуйж, зээл авч амьдрахаас өөр гарцгүй болсон байв.

**Гуравт**, 1950-1960-аад онд нэг хүнийг тахин шүтэх явдал хэрээс хэтэрсэн байжээ. Нам, төрийн удирдлагыг хослон барьж байсан Ю.Цэдэнбалын болон намын дээд удирдлагын алдаа дутагдлыг шүүмжилсэн, санал бодлоо илэрхийлсэн бүх хүмүүсийг “үндсэрхэх үгүйсгэх үзэлтэн”, “төөрөлдсөн сэхээтэн”, “намын бодлогод харш дайсагнасан этгээд” гэж буруутгаж байв.

Гэтэл энэ үед манай улс НҮБ болон СЭВ-д гишүүнээр элссэн, олон улсын хурал, зөвлөлгөөнд сэхээтнүүд олноор оролцох болсон,

нийгмийн янз бүрийн байгуулалтай орнуудад элчин төлөөлөгчид ажиллах болсон зэргээр гадаад харилцаа өргөжиж, энэ хэрээр сэхээтнүүд, иргэд олон талын мэдээлэл авч, тэд улс орныхоо цаашдын хувь заяаны талаар санал бодлоо илэрхийлэх болов. **Сэхээтний шинэ үе төрөн гарч тэд үндэсний эрх ашгаа хамгаалан хөдөлж эхэлсэн байна. Эрх баригчдын хувьд энэ нь шинэ аюул, байж болшгүй зүйл байв.**

### Гурав. Үндсэрхэх, үгүйсгэх үзэлтэн

1921 онд ялсан Ардын хувьсгал 1924 оноос эхлэн илт большевик хэлбэрт шилжиж бүх асуудлыг БОК(б)Н, Сталины дохио зангаа, зааварчилгаагаар шийдвэрлэх болсон явдал үндэсний эрх ашигт илт харшилж байлаа. Нөгөө талаар алтан ураг, төрийн удам дамжсан, мэргэшсэн угсаатныг “хар феодал” гэж, хөрөнгө чинээтэй хүмүүсийг “мөлжигч анги” гэж, лам хуврагуудыг “шар феодал” гэж нэрлээд тэднийг ангийн хувьд устгах бодлого, төлөвлөгөө зохиож хэрэгжүүлсэн. Энэхүү хэлмэгдүүлэлт 1950-иад он хүртэл үргэлжилсэн байна. Маршал Х.Чойбалсан, ТХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга Д.Лувсаншарав, Шүүх яамны сайд Г.Цэрэндорж гурваас бүрдсэн Онцгой бүрэн эрхт комисс 1939 оны 4 дүгээр сарын 22-нд татан буугдсан боловч хэлмэгдүүлэлт, яргалал зогссонгүй. Тухайлбал:

- 1940-1943 онд Эсэргүү нарын үлдэгдлийн хэрэг гэгчид холбогдон хэлмэгдсэн зүтгэлтнүүдийн оронд тавигдсан нам, улсын залуу ажилтнууд сайд, прокурор, аймгуудын болон цэргийн дарга 37 хүнийг баривчилж 12-ыг нь цаазалсан, зарим нь эрүү шүүлт даалгүй мөрдөн байцаалтын үед нас барсан,
- 1941 онд “Германы тагнуулын бүлэг хэрэг” гэгчид 1920-иод онд Европт сурч байсан хүмүүс, түүний дотор өмнө нь Японы тагнуул гэж яллагдсан Наваан-Юндэн, Б. Ринчен нарыг хамруулсан,
- 1942 оны шинэ Эрүүгийн хуулийн 137 дугаар зүйлээр шашны зан үйл үйлдсэн, ардын эмнэлгийн эмчилгээ хийсэн гэж иргэд болон лам байсан хүмүүсийг үй олноор нь баривчлан ялласаар байв,
- 1942 онд Сүхбаатар аймгийн 11 малчны “харилцаа” нэртэй хэрэг, 1943 онд мөн аймгийн малчдын “урвагч” хэмээх хэргийг “илрүүлэн” шийтгэсэн,
- 1944 онд Хүүхэн хутагтын хойт дүр Хэнтий аймгийн Дундбаян сумын харьяат 11 настай Ламаадан хүүг эцэг эхтэй нь хамт хөнөөсөн,
- 1945-1946 онд Өвөрмонголоос орж ирсэн 500-гаад дүрвэгсдийг Японы тагнуулын гэх хэрэг үүсгэж цээрлүүлсэн,



- 1948-49 онд “Порт Артур” гэх алан хядах томоохон ажиллагаа явуулсан
- Казакийн оргодлын хөдөлгөөний, Дэмчигдонровын хүү Дугарсүрэн нарын хэрэгт цээрлэл хүлээлгэсэн
- “Жамбалдоржийн хар хууль”-иар буюу малыг 200 саяд хүргэх төлөвлөгөөний дагуу ногдуулсан МАА-н бүтээгдэхүүн бэлтгэх даалгаврыг биелүүлээгүй 20 орчим мянган малчныг шоронд хорих зэргээр шийтгэсэн зэрэг арваад бүлэг зохиомол хэрэгт олон хүнийг холбогдуулан хэлмэгдүүлжээ.

Ер нь 1940-өөд оны дунд үе хүрэхэд өөрийн итгэл үнэмшлээр төр засгийн бодлогод хандах хүн байхгүй болсон юм. Гэтэл 1950-иад он гэхэд үндэсний сэхээтний шинэ үе төрөн гарч, тэд нийгэм улс төрийн тухайн үеийн нөхцөл байдлын талаар бодох, дүгнэлт хийх боломж үүсчээ. Үүнтэй уялдан 1950-иад оноос хойш явагдсан хэлмэгдүүлэлт их төлөв сэхээтнүүдийн эсрэг чиглэсэн. Нийгэмд үүссэн шинэ үеийн сэхээтнүүдийн сэтгэх, бодох сэтгэлгээг хааж боох, “булчингаар хариу авах” оюун санааны залхаан цээрлүүлэлтийн 2 дугаар үе чухамхүү энэ үеэс эхлэлтэй.

Босоо монгол бичгийг устгах, Монголын түүх, соёлыг адлах бодлогыг баримталж, нүүдлийн сонгодог мал аж ахуй эрхэлдэг, хүн амынх нь үнэмлэхүй олонхи малчид бүхий байгаль-цаг уур, нийгэм-сэтгэл зүйн давтагдашгүй онцлог бүхий Монгол орныг Сталины большевик томъёололд шахан оруулж, оросчлох оролдлого нь монгол түмний, монголын сэхээтнүүдийн улс үндсээ гэх нийтлэг ашиг сонирхолтой эрс зөрчилдөж байлаа.

МАХН-ын ТХ-ны УТТ-ны 1949 оны 34/64 дүгээр тогтоолоор Г.Жамсранжавын бичсэн “Ардын унших бичиг” номыг шатааж, зохиогч болон хэвлэлийнхнийг цээрлүүлжээ. Энэ үеэс хойших бүх хугацаанд улс төрийн хэлмэгдэгсдийг зэмлэн буруутгахад уг тогтоолд дурдагдсан нэр томъёо, үг хэллэгүүд давтагдаж ирсэн байдаг. Тухайлбал: “Чингисийг магтсан зүйл байна. Энэ бол үндэсний явцуу үзэл шигдэн оршиж байгаагийн илрэл”, “Үндэсний явцуу үзлийн өчүүхэн ч илрэлтэй шийдвэртэй тэмцлийг бүх шугамаар явуулж... Хувьсгалч эх оронч үзлийг хөгжүүлэх хэрэгтэй” гэж заасан.

1949 оны 10 дугаар сард “БНМАУ-ын түүх ба утга зохиолыг сургуулиудад зааж байгаа байдлын тухай” хэлэлцэхдээ нэрт эрдэмтэн Х.Пэрэнлэйн “Монгол цэргийн ур чадвар”, Б.Содномын “Монголын утга зохиолын түүхчилсэн төлөв”, Ш.Нацагдоржын “Нууц товчооны оршил”, Л.Дүгэрсүрэнгийн “Монголын ард түмэн эх орон ба эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцсэн нь” ном, өгүүллүүдийг үндсэрхэг үзэл шингэсэн бүтээлүүд гэж эрс шүүмжлэв. Энэ хорон шүүмжлэлд

их эрдэмтэн Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, Ш.Лувсанвандан нар ч өртөв.

Ю.Цэдэнбал, юуны түрүүнд, нийт монголчуудын хэдэн зуун жилийн турш “их эзэн богд” гэж Чингис хааныг шүтэн биширч, хүндэлж ирсэн явдлыг марксизмд харш үзэгдэл, үндэсний үзэл гэж үзэн, монголчуудын болон дэлхийн түүхэнд Чингис богдын гүйцэтгэсэн үүргийг үгүйсгэн баллуурдаж байв. Тэрээр 1949 оны 3 дугаар сард УТТ-д захидал бичихдээ: **“Чингис харгис аллага хядлагаараа гайхуулж явснаас биш, өөр юу ч хийгээгүй. Чингис одоогийн Гитлер шиг л байсан”** гэжээ.

Лхүмбийн гэх хилс хэрэгт холбогдон баривчлагдаж, Тусгай комиссын 1939 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн тогтоолоор буудан алах ялаар шийтгэгдсэн боловч эрдэм мэдлэгийнхээ хүчээр амь мултарсан Б.Ринчен үл засрах үндсэрхэх үзэлтэн хэмээгдэн, ам хэлний дайралтад насан туршдаа өртсөн байна. Үүний эхлэл нь Б.Ринчен М.Горькийн “Салхич шувууны дуун” зохиол, “Хириг рыцарь” найраглалыг феодал ангийн хэлээр орчуулсан хэмээн Жамбалон, Г.Жамсранжав нар 1935 оноос дайрч давшилсан явдал байв.

1950-иад оноос Б.Ринченг шүүмжлэхэд шинэ аяс нэмэгджээ. Ч.Чимидийн “Манай утга зохиол дахь националист үзлийн тухай” өгүүлэл, Д.Сэнгээгийн “Далан насад ч даруулга хэрэгтэй” хэмээх дайрал шүлэг, “Үнэн сонинд нийтлэгдсэн “Бидний эгнээнд хөрөнгөтний үзэлтэнд байр байхгүй” редакцын өгүүлэл, С.Дашдэндэв, Ш.Нацагдорж, Т.Пагва, Ж.Пүрэв, Г.Чимэд нарын “Үндэсний явцуу үзлийн элдэв илрэлтэй эвлэршгүй тэмцье” өгүүлэл, 1959 онд Намын амьдрал сэтгүүлд “Доктор Ренчиний сүүлийн үеийн зохиолууд дахь зарим харш үзэл санааны тухай”, “Бид аргадахгүй” өгүүлэл, 1960 онд Зөвлөлтийн хэсэг эрдэмтэн “Проблемы Востоковедения” сэтгүүлд захидал тус тус нийтлэгдсэн байв.

НАХЯмнаас Б.Ринчений алхам бүрийг шиншилж, энэ тухай 1954 онд Ю.Цэдэнбалд ховын бичиг хүргэж байсан, БНМАУ-д сууж байсан Зөвлөлтийн элчин сайдын яамны ажилтнууд, зөвлөлтийн чекистүүд ч түүний алхам бүрийг мөшгөн мөрдөж, орос бичгийг Өвөр Монголд хэрэглүүлэхгүй байх талаар Б.Ринченээс Маод бичсэн захидлын талаар өгүүлээд “оросын хүргэн Цэдэнбал Монголд бүх юмыг оросжуулахыг санаархаж байна гэж үздэг” хэмээн тодотгосон байна.

Чингэж төвийн бүх хэвлэлээр Б.Ринченг дайрсан нь МАХН-ын ТХ-ны УТТ-оос “Доктор Б.Ринчений сүүлийн үеийн зохиолууд дахь зарим харш үзэл санааны тухай” гэсэн нэртэй тогтоол гарахын угтал байжээ. 1959 оны 7 дугаар сарын 13-нд гарсан уг тогтоолд: “Эх орон-ард түмний социалист бүтээн байгуулалтын үйл хэрэгт тус болж чадахгүй, интернационализмын эсрэг үндэсний үзлийг сурталчилсан,

манай намын үзэл сурталд харш зохиол гаргасан явдалд Ринченг МАХН-ын ТХ-ы УТТ-оос эрс буруушааж, эх орон ард түмэндээ тустай ажил хийхийг Ринченгээс хатуу шаардсугай” гэжээ Тэр тогтоол гарснаас хойш Ринчений түүх соёлын талаар бичсэн өгүүллийг төвийн хэвлэлд нийтлэхээ больсон байна.

1954 оны 7 дугаар сарын 3-нд “БНМАУ дахь анги ба ангийн тэмцлийн тухай” МАХН-ын Төв Хорооны сэдэв зохиох 32/132 тоот тогтоол гарч, тусгай комисс томилогджээ. Чухамдаа бол зохиомол анги, ангийн тэмцлийг бий болгохыг зорьжээ. Энэ хийрхэлийн хүрээнд “үндэсний үзэл хэмээх хий үзэгдэл”, “хятадын аюул”...зэрэг зохиомол дайснуудыг тодруулж, нам, монгол-зөвлөлтийн найрамдал, интернационализм, орос хэл, соёл зэрэг “**дагшин шүтээнүүд**”-ийг буй болгон хөөрөгджээ. Энэ бүхнийг Ц.Дамдинсүрэн зэрэг дэвшилт сэхээтнүүд эрс буруушааж байжээ.

1956 онд хуралдсан ТХ-ны IV бүгд хурлаар “ЗХУКН-ын ХХ их хурлын дүн ба намын байгууллагуудын зорилтын тухай” асуудал хэлэлцсэн. 1952 онд Х.Чойбалсан, 1953 онд И.В.Сталин нас барсны дараа болсон тус бүгд хурал нэг хүнийг тахин шүтэхийн хор уршгийг арилгах талаар дорвитой алхам хийж чадаагүй төдийгүй сэхээтнүүдийг хэлмэгдүүлэх шинэ арга, хэлбэрийг улам бататгасан байна. Энэ бүгд хурлаас сэхээтнүүд, олон түмэн их зүйлийг хүсэн хүлээж байсан нь талаар болж, цаашид ч олигтой зүйл хийгдэхгүй нь тодорхой болжээ.

Энэ жилүүдэд нэг орноос хараат байдал улам лавшрав. Захиргаадалт, Цэдэнбалыг тойрон хүрээлсэн хэсэг бүлгийн хязгааргүй ноёрхол хэрээс хэтэрчээ. 1958 оны II бүгд хурлаар Ю.Цэдэнбал нам, засгийн бүх эрх мэдлийг гаргаа төвлөрүүлсэн байна. Сэхээтнүүдийн залхаан цээрлүүлэлт шууд бууддаг аргаас далд, илүү хорлонтой зохион байгуулалттай нарийн аргаар солигдов.

Ю.Цэдэнбал даргын удирдлагын арга барил, баримталж байгаа байр сууринаас өөр бодолтой хүмүүс, түүний эрхэлж байгаа албан тушаалд заналхийлж байгаа мэт хардлага, айдас төрүүлж, эрх дарх, албан тушаалаа хамгаалж үлдэхийн тулд хамтран зүтгэгч нараа хардан зайлуулах арга замыг байнга хэрэглэдэг болжээ.

### **Дөрөв. Төөрөлдсөн сэхээтэн**

Үндэсний эрхэм дээд бүхнээ сүйтгүүлсэн ард түмнийг санасан зоргоороо барьж чиглүүлж байна гэдэг амаргүй байх нь мэдээж, өнгөрсөн болоод өдгөөгийнхөө бусармаг бүхнийг хүчирхийллийн замаар л дарж байхаас өөр зам МАХН буюу Цэдэнбалд байсангүй. Нөгөө талаас өмнөх жилүүдийн гамшиг зовлон, цаг үеийнхээ шинж

төрхийг төсөөлөх чадвар бүхий сэхээтний төлөөлөл өсч өндийж байлаа. Сэхээтэн бол нийгмийн хошуучлагч хэсэг учраас тэд дарангуйлагчид хамгийн аюултай хэсэг байв. Тийм учраас ард олны тэдэнд итгэх итгэлийг сарниулах, үл итгэх, бүр зэвүүцэх жигших үзэл сэтгэлийг төрүүлэх замаар ангийн тэмцлийн хурц үзүүрийг сэхээтний эсрэг чиглүүлэх, тэднийг өөр хооронд нь сөргөлдүүлэн хутган үймүүлэхийг зорьсон байна.

Ийм нөхцөлд 1956 оны эхээр ЗХУКН-ын ХХ их хурал болж, улс төрийн шинэ нөхцөл бүрдэв. Цэдэнбал ч өөрийнх нь идэвхтэй оролцоо бүхий өмнөх үеийн бусармаг бүхнийг сөхүүлэхгүй байхын төлөө амь тэмцэн зүтгэж, эх оронч сэхээтний хэсэг ч эзэн гүрэнд буй болсон “Хрущевын урин цаг”-ийн тусгалаар идэвхжих болов.

Сэхээтнүүд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжтой боллоо хэмээн үзэж улс орны хөгжлийн болон нам засгийн явуулж байгаа бодлогын асуудлаар нилээд шүүмжлэлтэй хандсан үг яриа сонсогдох болсон байна.

Амьдралын тулгамдсан асуудлаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэхийг уриалснаар үйл хэрэг эхэлжээ. 1956 оны 11 дүгээр сард сэхээтэн олноор төвлөрсөн буюу үг яриа гараад байгаа МУИС, УТК, НТИ, НДС, УБДС, МХЗЭ-ийн ТХ, ШУА, НХШХ, Үнэн сонин, МОНЦАМЭ зэрэг 26 байгууллагын сэхээтнүүдтэй ТХ-ны удирдлагууд уулзалт ярилцлага зохион байгуулж, улс орны хөгжлийн байдал, нийгмийн. Сэхээтнүүд ч Намын удирдлага маань бидний саналыг сонсож, ажил үйлсдээ тусган, эх орныхоо хөгжилд санаа тавьж байна гэж гэнэхэн бодож санасан бодсоноо чөлөөтэй илэрхийлж байв.

Тоймлон авч үзвэл:

Ц.Дамдинсүрэн/ШУА/: “Ардын ашиг орлого муу, хоршоонд өгөх нь их. Гэр нь бүрээсгүй, зун нь цагаан идээгүй. Бид ингэж амьдарвал ямар байх вэ? ... малыг амьдаар гаргадгийг зогсоомоор...ардын аж ахуйтан малаа улсын ялтай мал гэдэг болсон. Хотонд нь навч цэцэг, гэрт нь нар сар мандаж байна. Ажилчин анги өслөө гэдэг. Гэтэл тэд хоосорсон малчдаар өсч байна. Удирдагчид олон түмнээс тасархай, малчидтай уулздаггүй. Цэдэнбал дарга сүүтэй цай уудаггүй хүн байх аа. Тэгээд малчид бидэнтэй уулзахгүй байна”,

Балчинжав (МХЗЭ-ийн/): “Манайх ЗХУ, Хятадтай худалдаа хийдэг. Гэвч ашигтай худалдаа хөгжүүлэх шаардлагатай ...хөрөнгөтөн оронтой ч худалдаа хиймээр байна”,

Жамц (МХЗЭ-ийн/): “өргөн хэрэгцээний бараа гаднаас их авчирч, машин төхөөрөмж ховор байна. ЗХУ-аас шинэ юмнууд авахын оронд хуучныг нь авдаг, Зөвлөлт онц муу машинаа манайд өгдөг, худалдаа

бол худалдаа л байх ёстой, хэнтэй ч гэсэн худалдаачны ёсоор ажиллах хэрэгтэй, ямар ч улс гэсэн улсынхаа ашиг тусын төлөө бодохгүй тийм худалдаа байж болохгүй”,

Лувсанцэрэн (МХЗЭ-ийн/:"... үйлдвэр маш их хоцрогдсоныг анхаарч тэргүүний орон болох шийвэртэй алхамд орууштай..."

Дашдондог (МХЗЭ-ийн/:"...совмонгол металл зэргээр дамжин эрдэс баялгаа түүхий хэвээр гарган, өөртөө боловсруулахгүй байгаагаас олигтой орлого алга байна..."

Балдорж (МХЗЭ-ийн/:"МАН-хаа бүтээгдэхүүнийг өөртөө бүрэн боловсруулмаар байна..."

Чойжил (МХЗЭ-ийн/:"Үндэсний түүх соёлоо үгүйсгэсэн, үндэсний юм бүхнийг феодалын гэж үздэг болсон. Үндэсний бахархал, эх оронч үзлийг нухчин дарж, сэхээтнүүддээ итгэдэггүй, санаагаа чөлөөтэй хэлэх боломжгүй болсон. 1949 онд НТХ үндэсний үзлийг буруушаасан тогтоол гаргаснаас хойш Чингис зэрэг хүмүүсийн тухай дурдахаас ч айдаг болсон, үндэсний болон түүхэн ухамсрыг хааж боож байгаа, сургуулиудад эх орны түүхийг заахгүй болсон”

Б.Жамсран (НТХ/:"нэг хүнийг тахин шүтэхийн хор холбогдлын тухай, хор уршгийг нь арилгах тухай их ярьдаг атлаа Цэдэнбалгүйгээр шийдвэрлэгдэх юм нэг ч алга. Монголын засгийн газрын толгой яагаад монголоор ажил үүргээ хөтлөхгүй байна вэ? НТХ-нд цэвэрлэгч бичээчийг авахад хүртэл гарал үүслийг нь шалгадаг”

Чимиддамба (Үнэн сонин/:"...нэг хүнийг шүтэх асуудал дээрээс, НТХ-ноос хийгдэж байна. Х.Чойбалсангийн тухай Ю.Цэдэнбалын илтгэлд буруу зүйл их байна..."

Бат-Очир (НТИ/:"манайд дутагдлаа нуудаг, хэлэхээсээ айдаг, бэмбэгнэсэн явдал дээр дооргүй байна. Хэрэв дутагдлаа сайн ярилцвал үр дүн гарах биз. шүүмжлэлийг чөлөөтэй өрнүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авмаар байна”

Дүгэрсүрэн (НТИ/:"Гадаад яам, Дотоод яам хоёрыг сонинд бичиж болдоггүй. Тийм тусгай эрхтэй байдлыг зогсоох...тусгай дэлгүүр эмнэлэгийг болиулах, НТХ-ноос эхлээд нүсэр орон тоог цөөлөх, машин унадаг дарга нар олширч байгааг зогсоох..."

Төмөрбаатар (МУИС/:"Ард түмний амьдрал туйлын дорой байна. Ардын хувьсгалын жилүүдэд ялангуяа сүүлийн 10 жилд олигтой амжилт олох байтугай хувьсгалын өмнөх үетэй зэрэгцүүлэхэд ард түмний эд материал ахуй байдал доройтсон, ард түмний амьдрал сайжирсаар байна гэж худлаа ухуулдаг, үнэн байдал түүнээс өөр байна. Навч цэцгээ хотондоо мандуулаад, нар сараа гэртээ мандуулж байна. Малчид ялны хэдэн мал гэх болжээ. 1945 онд улсын сайн малчин

гэгдэж, шагнал авч байсан хүмүүсийн тал хувь нь албан журмын ногдлоо дийлэхгүй шоронд орлоо. Хувьсгалын жилд бүтээсэн зүйл бол ажилчин ангитай боллоо гэдэг..үнэн хэрэгтээ манайд классик ажилчин анги бүрдээгүй, байгаагүй. Сонгууль ихээхэн ёс төдий болж байна. Депутатаа ард түмэн танихгүй мөртлөө дээрээс өгсөн чиглэлийн дагуу нэг хүнийг намын даалгавараар сонгодог. Увс аймгийн Сагил сумаас сонгогдсон депутат Ш.Тогтох гэдэг хүн 4 жил хулгай хийж, би дархан эрхтэй депутат хүн гэж байсан...”

Сэнгэдорж (УБТС/): “одоо бид намын түүхийн материал үзэх дээр урьдын байдал огт өөр болж байна. Нэг хүнийг тахин шүтэх асуудлын талаар IV бүгд хурлаас шийдвэр гаргасан, энэ талаар тодорхой хариу өгөөгүй учир хүмүүс төөрөлдсөөр байна...” гэх мэтээр ярьцгаасан байна.

Мөн Бирваа, Сүрэнхорлоо, Цэдэн, Лхамжав, Жамц, Шагдар, Ичинхорлоо, Дорж, Базар, Авирмэд, Пунцаг нарын нам төрийн хариуцлагатай ажилтан олон хүмүүс санал бодлоо чөлөөтэй илэрхийлжээ.

1956 оны 12 дугаар сарын 4-ний шөнө МХЗЭ-ийн ТХ-ны 1 дүгээр нарийн бичгийн дарга Н.Дангаасүрэнг УТТ-ны хуралд дуудаж “улс орноо хөгжүүлэх өөрийн бодлогыг ярь” гэжээ. Ингэж яриулж байгаа нь ямар учиртайг Н.Дангаасүрэн хардаж сэрдээгүй, нам, төрийн удирдлагаас ярианы маань аль оновчтой зөвийг тунгаан авах гэж байна гэж урамшин чөлөөтэй ярьжээ. Тухайлбал “...Сонгуулийн систем буруу байна. Хүний нэрийг дээрээс тулгадаг буруу. Олон түмэн өөрсдөө нэр дэвшүүлэх хэрэгтэй. Төр засгийн удирдлагууд олон түмэнд тайлангаа тавихгүй байна. Хэдхэн эрх баригчид бүхнийг шийдвэрлэж, АИХ-ын депутатууд, хуулийн байгууллага цөм тэдний дуулгавартай зарц болон хувирчээ. Ард түмнээ үнэлэх ба итгэх хэрэгтэй. Ард түмнийхээ соёлын өвийг зөвөөр уламжлан ашиглах хэрэгтэй. Ардын дууг хориглодог бол маш буруу. Сэхээтэндээ итгэхгүй байна. Худалдааг социалист, социалист бус гэхгүй хэрэгцээтэй бүх оронтой харилцан ашигтай нөхцөл дээр өргөжүүлэх хэрэгтэй. Олон улсын зах зээл дээр өөрийн гэсэн бүрэлдэхүүнээр байр сууриа эзлэх хэрэгтэй. Улсын аппарат нүсэр байна. Төв хороо Засгийн газрын орон тоо дэндүү их байна. Хувьсгалт намын урьдын түүхийг гоёчлон бичиж байна. Олон хүн баривчилж хэлмэгдүүлэн сүм дуган зэрэг соёлын өвийг эвдэлсэн. Энэ мэт олон саналыг олон түмэн ярьж байна. Эдгээрийг тунгаан цаашдын үйл хэрэгт анхааран үзүүштэй...” гэжээ.

Сэхээтнүүд тухайн үед өөрсдийнхөө толгой дээр булуу хурааж байна гэдгээ ухамсарлаагүй байв. Д.Дамба болон ТХ-ны удирдлагын дийлэнх олонх нь олон нийтийн санал бодлыг сонсож, тэдний дотор өрнөж буй шүүмжлэлт хандлагыг идэвхжүүлж, түүнээс санаа авч

үйл ажиллагаандаа тусгах нь чухал гэж үзэж байсан. Гэтэл уулзалт ярилцлагын мөрөөр зохиох ажил, авах арга хэмжээний тухай яригдаад эхэлмэгц уур амьсгал өөрчлөгдөөд явчихжээ. Шүүмжлэлийн хурц үзүүр юуны өмнө Цэдэнбал руу чиглэж байснаас тэрбээр дахин ийм яриа, хэл гаргуулахгүй болгох, үүний тулд “давтарсан сэхээтнүүдийг бага дээр нь дарж авах” далим болгон ашиглахаар шийдсэн бололтой.

Ийнхүү 1956 оны 12 дугаар сарын 5-нд “Манай намын бодлогод харш үзэл санаа, үг өгүүлэл гарч байгаа тухай” МАХН-ын ТХ-ны УТТ-ны 413 дугаар тогтоол гарч, уг тогтоолыг сар гаруй хугацаанд намын бүх шатны байгууллагуудын хаалттай хурлаар хэлэлцүүлжээ.

Уг тогтоолд: “Эд нар монголын хөдөлмөрчин ард түмэн, МАХН-ын удирдлагаар явж, ардын хувьсгалын 35 жилийн дотор байлдан олсон маргашгүй амжилтыг үгүйсгэн монгол-зөвлөлтийн ард түмний ах дүүгийн эвдэршгүй найрамдлын эсрэг чиглэсэн, үндэсний үзлийн яриа өгүүлүүдийг гаргаж байна”, “Үндэсний үзэл бол манай нам ард түмэнд хамгийн аюултай зүйл байсан ба одоо ч байгаа юм... одоо үед манай дотор гарч байгаа үндэсний үзэлтэй хатуу тэмцэх явдал хурцаар тавигдаж байна...Үндэсний үзлийн яриа өгүүллийн хурц үзүүр нь юуны өмнө Зөвлөлт-Монголын ард түмний ах дүүгийн найрамдлыг таслахад чиглэгдсэн байна” гэж дүгнэжээ.

Гэтэл хүмүүс олсон амжилтыг үгүйсгэсэн биш бодит амьдралыг, найрамдлын эсрэг биш зөвхөн зөвлөлтийн хараат байхын оронд дэлхийн олон улс оронтой харилцаа найрамдалтай байхын төлөө, үндэсний үзлийг биш эх оронч үзэл, үндэсний ухамсрын хүрээнд асуудлыг авч үзсэн ярьсан байдаг.

Энэ хэрэгт Н.Дангаасүрэн, З.Содномцэрэн, Д.Лхамжав, А.Жамц, Ө.Дорж, Ц.Дамдинсүрэн, Ч.Балчинжав, Н.Гунгаажав, Д.Лхамжав, Т.Пунцаг, Д.Базарсад, Д.Лхамсүрэн, намын эсэргүү Д.Дамба, Ч.Сүрэнжав, Дамдин, Л.Самдан, Ламчин, Балган гэх мэт олон шилдэг сэхээтнүүд холбогдон хэлмэгджээ.

1956-1964 он хүртэлх 8 жилийн хугацаанд “дайсан” дараагүй бүгд хурал гэж бараг байсангүй. Тоймлон дурдвал:

-1956 оны 12 дугаар сарын 5-нд төөрөлдсөн сэхээтэн, Зөвлөлтийн эсрэг үзэлтнээр нэгэнт тодроод байсан З.Содномцэрэнгийн тухай МАХН-ын ТХ-ны УТТ-ны 394 тоот тусгай гаргажээ.

-1957 онд империализмын хоёр төлөөлөгч гэж нэрлэн Н.Лхамсүрэн, Б.Ширэндэв нарыг УТТ-ны бүрэлдэхүүнээс гаргаж ажлаас нь чөлөөлсөн байна.

-1958 онд “хоцрогдсон” хэмээн Дашийн Дамбыг эхлээд МАХН-ын ТХ-ны нэгдүгээр нарийн бичгийн даргын албан тушаалаас өөрчилж,



Ю.Цэдэнбал төрийн бүх эрх мэдлийг гартаа төвлөрүүлсэн бөгөөд 1959 оны III бүгд хурлаар түүнийг намын удирдлагаас бүрмөсөн зайлуулж нутаг заан цөлжээ.

-1962 онд МАХН-ын ТХ-ны ээлжит бус III бүгд хурлаас тусгай тогтоол гаргаж, УТТ-ны гишүүн, ТХ-ны II нарийн бичгийн дарга Д.Төмөр-Очирыг үндсэрхэх үзэл, хятадын талыг баримталсан, дээд албан тушаалд санаархсан хэмээн хэлмэгдүүлж, түүний хамсаатнууд гэх Ш.Бат-Очир, Ж.Төмөрбаатар, Д.Юмжав, Г.Чогсом, С.Авирмэд, Д.Доржсүрэн нарын олон сэхээтний хамт цөллөгөд илгээжээ.

-1963 онд МАХН-ын ТХ-ны V бүгд хурлаас УТТ-ны гишүүн, ТХ-ны II нарийн бичгийн дарга Л.Цэндийг “хутган үймүүлсэн, намч биш ажил явуулсан” эзнээр тодруулан маш нарийн зохион байгуулалт бүхий хуйвалдааны аргаар нухчин дарсан байна.

Энэ он жилүүдэд НХШК-ыг Хороо болгон өргөтгөж, Нийгмийг аюулаас хамгаалах байгууллагуудыг МАХН-ын тагнан туршиж, илчлэн мэдээлэх, залхаан цээрлүүлэх үүрэгтэйгээр ажиллуулсан байна. Тухайлбал:

- МАХН-ын ТХ-ны УТТ-ны шийдвэрээр 1945 оны 5 дугаар сард Дотоод яамны төв аппаратын намын хороог НТХ-ны Нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөнд шууд харьяалуулах журам тогтоожээ.
- МАХН-ын ТХ-ны УТТ-ны 1956 оны 125 дугаар тогтоолоор тагнах ажлыг ТХ-ны зөвшөөрлөөр гүйцэтгэж байх, тус орны доторх “дайсагнагч этгээд”-ийг нууц тагнуулын хяналтад авч, урьдчилан сэргийлж ажиллахыг аюулаас хамгаалах газарт үүрэг болгожээ.
- МАХН-ын ТХ-ны УТТ-ны 1958 оны 125 тоот тогтоолоор лам нарын асуудал дахин сэргэж, тэднийг тагнах, хянах ажил эрс идэвхжүүлжээ.
- МАХН-ын ТХ, СнЗ-ийн 1962 оны хамтарсан тогтоолоор МАХН аюулаас хамгаалах байгууллагын үйл ажлыг удирдана гэж зааж өгөв. Тиймээс аюулаас хамгаалах байгууллага тагнуулын үйл ажиллагааны дүнгээ МАХН-ын Төв Хорооны 1 дүгээр нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбалд шууд тайлагнадаг, удирдамж чиглэл авдаг болжээ.
- МАХН-ын ТХ-ны УТТ-ны 1963 оны 03 тоот тогтоолоор залуучууд, оюутан, сэхээтний дотор зохиох тагнах ажлыг хүчтэй болгох, сонин хэвлэл, радио нэвтрүүлэг, хийсвэр зураг, урлал, хэлбэрдэх утга зохиол, кино гэх мэт чиглэлээр аюулаас хамгаалах алба анхаарч ажиллахыг шаардав

- МАХН-ын ТХ-ны УТТ-ны 1963 оны тогтоолоор нууц аппаратын бүрэлдэхүүн чанарыг сайжруулан түүнийг гүйцэтгэх ажилд сургах, нууцтай ажиллах ажиллагааг эрс дээшлүүлэх шийдвэр гарган хэрэгжүүлжээ.

### **Тав. Намын эсрэг бүлэглэгчид. “Намын эсрэг бүлэг”**

1962 онд манай улс ЭЗХТЗ-ийн гишүүн болсон учир олон сэхээтнүүд төрөл бүрийн хурал зөвлөлгөөнд оролцохоор социалист орнуудад явж ирээд бусад орнуудыг бодвол манайх хол хоцрогдож, ард иргэдийн амьдрал дэндүү ядуу байгааг харилцан ярилцаад энэ байдлын шалтгаан, цаашид явал зохистой талаар нэгдмэл дүгнэлтэд хүрдэг байжээ. Энэ дүгнэлт нь намын дээд удирдлага, тухайлбал Ю.Цэдэнбал хэт хоцрогдсон, ажлын арга барил нь шударга бус, алдаа дутагдлыг хаацайлж, зусардан бялдуучилж, ая тал харж, хуурч мэхлэх зарчимгүй байдал газар авсан тухай байв.

Хэдийгээр ийм шүүмжлэлт нөхцөл, байдал үүсээд байсан боловч Ю.Цэдэнбал ТХ-ны удирдах бүрэлдэхүүнийг итгэлтэй хүмүүсээр бэхжүүлж, өөртэй нь өрсөлдөх магадлалтай гэж үзсэн чадварлаг сэхээтнүүдийг нам, улсын дээд удирдлагаас зайлуулж уужим амьсгаа аваад байв. Гэтэл 1964 оны 10 дугаар сарын 17-нд ЗХУ-д Н.С.Хрущевыг нам, төрийн тэргүүнээс гэнэт халж өөрчилсөн явдал монголдоо Хрущев болоод байсан Ю.Цэдэнбалын байр суурийг ганхуулж мэдэх нэмэлт осолтой байдал бий болгосон байна.

Улс орны гадаад, дотоод нөхцөл байдал ийнхүү ээдрээ төвөгтэй болсон эгзэгтэй үед буюу 1964 оны 12 дугаар сарын 21-22-нд МАХН-ын Төв Хорооны дуулиант ҮI бүгд хурал хаалттай хуралдсан юм. Намын дээд удирдагын урьдаас төлөвлөж, зохион байгуулсан дэгийн дагуу явуулах өөрөөр хэлбэл бүгд хурал дээр өрнөх үйл явдлыг олон нийтээс чандлан нууцлах, дараагийн арга хэмжээ нь намын дээд удирдлага руу чиглэсэн шүүмжлэлийг няцаах үүрэгтэй, даргад итгэгдсэн гишүүдийг зориуд бэлтгэж шүүмжлэгчдийг бут цохих явдал байжээ.

Бүгд хурал дээр Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нар Ю.Цэдэнбалын тухай маш хурц шүүмжлэл тавьснаас үзэхэд Ю.Цэдэнбал дарга зөвхөн өөрт нь харьяалагддаг дотоод яамны болон бусад мэдээллийн сүлжээ, эдгээр мэдээлэлд дүн шинжилгээ хийх олон талын туршлага, зөн совингоороо өрнөх үйл явдлыг урьдчилан таамаглаж, олон талаас нь нягтлан тунгаасны эцэст “намын эсрэг бүлэглэсэн явуулга хийгдсэн” гэдэг хувилбарыг ашиглахаар сонгосон бөгөөд энэ тоглолтоо гарамгай гүйцэтгэснийг тэр үеийн улс төрийн түүх харуулдаг.

Хурлаар “Нам улс олон нийтийн хяналт шалгалтыг улам сайжруулах арга хэмжээний тухай” НТХ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын СнЗ-ийн дарга Ю.Цэдэнбалын илтгэл (3 цаг 25 минут үргэлжилсэн), Улсын төлөвлөгөөнд оруулах өөрчлөлтийн тухай УлсТКом-ын дарга Т.Рагчаагийн илтгэл (45 минут)-ийг тус тус сонссон байдаг. Өөрөөр хэлбэл, эдгээр илтгэлийг ултай хэлэлцээгүй, өөр зүйл тухайлбал намын эсрэг бүлэг гэгчийн тухай л хэлэлцжээ. Үүнийг хүмүүсийн хэлсэн үгнээс харж болох юм. Өөрөөр хэлбэл Ю.Цэдэнбал тэргүүтэн өөрсдийнх нь эсрэг шүүмжлэл гарна гэдгийг аль хэдийн мэдэж бэлтгэл хангасан байжээ.

Илтгэлүүдийн дараагаар санал шүүмжлэл эхэлсэн байна. Эхлээд НХШХ-ны дарга Н.Лувсанравдан хяналт шалгалтын талаар товч үг хэлж “шүүмжлэлийг өрнүүлэх, ардчиллыг дэлгэрүүлх нэрээр зарим хүмүүс их чалчдаг болсон. Д.Төмөр-Очир Баянхонгорт ажил унагасан. Л.Цэнд Завханд олигтой ажил хийхгүй байна. Үндэсний үзэл гаргагчид намын эсрэг дайрагчидтай хатуу ширүүн тэмцэл явуулах хэрэгтэй” гэж хэлсэн нь хуралдааны уур амьсгалыг залж чиглүүлэх зорилготой байлаа. Дараа нь үг хэлсэн С.Балган, Б.Алтангэрэл, Д.Дэмчиг, Б.Бадарч, А.Отгонбаяр нарын үг ч мөн л иймэрхүү утгатай байжээ.

Үг хэлсэн хүний 7 дахь нь Б.Сурмаажав байсан бөгөөд тэр Цэдэнбалыг шүүмжилж эхэлмэгц заалнаас боль, чамайг танилаа гэх мэтээр хашгиралдаж, шүгэлдэж эхэлсэн байдаг. Дараа нь үг хэлсэн Д.Лхагвасүрэн (Хэнтий), Б.Банзрагч, Д.Балжинням нар Сурмаажав руу хошууран довтолж түүнийг бүгд хурлаар тусгайлан хэлэлцэх санал гаргасан байна. Ш.Дамбаренчин үг хэлсний дараа 12-т Б.Нямбуу хурц шүүмжлэл тавьсан бөгөөд түүнд гол цохилтыг Батаа, Б.Дэжид, Ж.Гомбосүрэн нар өгч мөн л бүгд хурлаар тусгайлан хэлэлцэхийг шаарджээ. Г.Туваан, Цэрэннадмид, Ч.Пүрэвжав нарын занал, зүхлийн дараа үг хэлсэн 19 дэх нь Ц.Лоохууз байв. Түүнд Д.Ядамсүрэн, Бүдсүрэн, Д.Ёндондүйчир, Д.Чимэдцэрэн, Д.Бямба (Увс) нар цохилт, няцаалт өгч “эсэргүүн” болгосноор хуралдааны эхний хэсэг дуусчээ.

Үдээс хойших хуралдааныг Ю.Цэдэнбал өөрөө шууд даргалсан бөгөөд “Одоо намын эсрэг бүлэг”-ийн тухай ярилцана гэж зарласнаар “ажилдаа оржээ”. Ийнхүү Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав, А.Дашнамжил, Н.Гунгаажав нараар толгойлуулсан “намын эсрэг бүлэг” гэгч зохиомол хэрэг үүссэн түүхтэй. Оройн хуралдаанд М.Даш, Ц.Пунцагноров, Нуга, Телейхан, Ж.Лхагвасүрэн, С.Жалан-аажав, Д.Балдоо, Ц.Дүгэрсүрэн нар үг хэлжээ.

Бүгд хурал Нэгдүгээрт, Лоохууз, Нямбуу, Сурмаажав нарыг ТХ-ны бүрэлдэхүүнээс гаргаж, намаас хөөх, Хоёрдугаарт, Лоохууз, Нямбуу нарыг ЗХУ-д суралцаж байсан тус тусын аспирантураас хасч суралцах хугацааны зардлыг нөхөн төлүүлэхээр ил санал хурааж шийдвэрлэсэн

байна. Харин “Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нараас намын эсрэг бүлэглэсэн явуулга хийсэн тухай” гэсэн нэртэй бүгд хурлын тогтоол гэгчийг 3 хоногийн дараа нөхөн гаргасан бөгөөд уг тогтоолыг бүгд хурлын гишүүд батлаагүй байна.

Бүгд хурлын дараах өдрөөс эхлэн Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нарын хань хамсаатнуудыг илрүүлэх кампани эхэлсэн. Энэ ажлыг Б.Лувсанравдан даргатай НХШХороо, НАХЯамны туслалцаатай улс орон даяар өрнүүлсэн байдаг. Бүлгийн хамсаатнууд нь нам, улсын ажилд оршиж байгаа дутагдлыг ил тод шүүмжилдэг, Ц.Лоохууз, Б.Нямбуу нартай уулзаж, эсвэл хамт ажиллаж, суралцаж байсан хүмүүс, мөн тэдний хамаатан, садан хамрагдсан байна.

Намын эсрэг бүлэг гэх хэрэгт холбогдсон бүх хүмүүсийг эрхэлж байсан ажил албан тушаалаас нь халж гэр бүл, үр хүүхэд, аав ээжтэй нь хамт нутаг заан хөдөө орон нутагт явуулж, уг хүмүүсийн мэргэжил боловсрол, ажлын туршлага, хүсэл сонирхлыг үл харгалзан өчүүхэн цалинтай хүнд хүчир ажил хийлгэдэг, өөрөөр хэлбэл, аж амьдралыг нь доройтуулж гачигдал зовлонд оруулах шинэ хэлбэрийн цээрлэлийн арга хэмжээ хэрэглэдэг байжээ.

МАХН-ын дээд удирдлагын зүгээс Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нарыг шүүж, шоронд хийх байр суурьтай байжээ. Тухайлбал, тэдний талаар ҮИ бүгд хурлаас гарсан тогтоол, шийдвэрийг намын бүх шатны байгууллагын хурлаар зориуд хэлэлцүүлж, тэдгээр хурлуудаас гэмтнүүдийг шүүхэд шилжүүлж, хуулийн хариуцлага хүлээлгэхийг шаардсан заалт бүхий тогтоол гаргуулсан байдаг. Гэвч НХШХороо, НАХЯамтай хамтарч олон хоног, сар нойр хоолгүй ажиллаж, мөрдлөг байцаалт явуулаад ч намын эсрэг зохион байгуулалттай бүлэг байсан гэх нотолгоо олоогүй учир тэднийг шүүн тасалж чадаагүй байдаг.

МАХН-ын ТХ-ны 1964 оны бүгд хурлын бэлтгэлийг олон хоногийн турш хангаж, маш нарийн төлөвлөж, зохион байгуулсан байдаг. Тухайлбал:

Өдөөн хагасан нэргүй захидал бэлтгэж хэргийн баримт болгох зорилгоор олон түмэнд зориуд тараасан мөн “Чи албан тушаал горьдоо юу”, “Суу, боль”, “Чи ийм хүн байсан юм уу”, “Чамайг танилаа” гэх зэргээр хашгирах, исгэрэх хүмүүсээр С.Сосорбарам, П.Шагдарсүрэн, М.Даш, Л.Ринчен нарыг “томилж” ажиллуулсан байв.

Шүүмжлэх хүмүүсийг тусгай даалгавартай гурав, гурван хүний дунд хавчуулан яриулах, тэднийг буруутгах үндэслэл, хэлэх үгийг урьдчилан бэлтгэж тохирсон байв. Элдэв мэдээлэл цуглуулах, утас чагнах, намын эсрэг бүлэгт оруулах хүмүүсийг тодруулах, хутган үймүүлэх зэрэг үүрэгтэй 2000 орчим тагнуул туршуул ажиллуулсан мэдээлэл байдаг.

ТХ-ны гишүүдийг хурлын өмнө нэг нэгээр нь дуудан уулзаж “аюулгүй болгох”-ыг Ю.Цэдэнбал өөрөө гардан удирдсан байдаг. Ерөнхий ажиллагааг НХШХ-ны дарга Лувсанравдан, НАХЯ-ны Сайд Жамбалсүрэн, Төв Хорооны боловсон хүчин Б.Бадарч нар зохион байгуулжээ.

Намын эсрэг бүлэглэл гэгчид 200 орчим хүн холбогдож, 8 хүнийг шоронд ял эдлүүлж, 30 орчим хүн гэр бүл, үр хүүхдийнхээ хамт нутаг заагдан цөлөгдсөн байдаг. Бусдыг нь мэргэжлийн бус, бага цалинтай ажил хийлгэж, иргэний эрхийг нь хязгаарлан НАХЯ-ны байнгын хараа хяналтад 25 жил “хадгалжээ”. Олон хүн амь насаа алдсан байдаг.

МАХН-ын эсрэг Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нарын бүлэглэл байсныг дор дурдсанаар нотолсон. Үүнд:

Нэгд, 1964 оны 12 дугаар сарын 16-нд барилгын нэгдсэн карьерийн дарга Д.Дамдинсүрэнгийн гэрт А.Дашнамжил, Ц.Лоохууз, Н.Гунгаажав, Ж.Нямдарь, Д.Баасанжав, Р.Тогтох, Д.Жамба нар уулзаж, шатар тоглож, ярилцсанаас үндэслэн санхүү, төсөв, төлөвлөгөө бүхий бүлэглэл байжээ гэж үзсэн.

Хоёрт, “Шинээр бүрдэх нам, төрийн удирдах албан тушаалтнуудын жагсаалт” гэх хуурамч бичиг зохиож, шүүмжлэл тавих магадлал бүхий хүмүүстэй уулзаж өдөөн хатгалга явуулсан. Уг нэрсийн жагсаалтыг Цэдэнбал зохиож, Лувсанчоймбол тагнах, тандах зорилгоор холбогдох хүмүүстэй уулзсан гэж эх сурвалжууд нотолдог. Цэнхэр өнгийн будгийн харандаагаар, тал хуудас цаасан дээр бичсэн уг жагсаалтад дор дурдсан зүйлийг тусгасан байв. Үүнд:

- Цэдэнбалын хоёр том тушаалыг салгаж, түүнийг НТХ-ны 1 дүгээр нарийн бичгийн даргаар дагнан ажиллуулах
- СнЗ-ийн даргаар Моломжамц, Жагварал 2-ын аль нэгийг тавих
- АИХ-ын тэргүүлэгчдийн дарга Ж.Самбууг өөрчилж оронд нь Лувсан, Дамба 2-ын аль нэгийг тавих
- НХШХ-ны дарга Лувсанравданг өөрчилж оронд нь С.Жалан-аажавыг ажиллуулах
- НТХ-ны нарийн бичгийн дарга Ц.Дүгэрсүрэнг өөрчилж оронд нь Г.Чимэдийг ажиллуулах
- СнЗ-ийн орлогч дарга Д.Майдар, Б.Дүгэрсүрэн нарыг өөрчлөхөөр бичсэн боловч оронд нь тавих хүнийг дурдаагүй. Цаашид өндөр албан тушаалд дэвшүүлж болох хүмүүсийн тоонд Балган, Батмөнх, Готов, Лоохууз, Гүрбадам, Нямбуу нарыг оруулсан байжээ.

Гуравт, бүгд хуралд 30 гаруй хүн үг хэлжээ. Тухайлбал, Б.Балдоо –платформ бүхий бүлэглэл мөн, Ч.Пүрэвжав –эднийг алахад бөөс нь л гомдоно, Д.Бямба –эд нар бол янхан, улс төрийн галзуу туссан улс, Ж.Лхагвасүрэн –ардын дайснууд, Б.Дэжид –нам бол Цэдэнбал, Цэдэнбал бол нам, Ц.Дүгэрсүрэн –эд нарыг шоронд хийх хэрэгтэй гэх мэт агуулгатай үг хэлцгээсэн. Энэ нь намын эсрэг бүлэг байсны нэг гол нотолгоо болгожээ.

1964 онд МАХН-ын эсрэг бүлэглэл байсан тухай тэр үед нотолгоо болгосон үндэслэл цагийн шалгарлыг давж чадсангүй. Өөрөөр хэлбэл, “Лоохууз, Нямбуу, Сурмаажав нараар толгойлуулсан МАХН-“ын эсрэг бүлэглэл” гэж байгаагүй ажээ.

VI бүгд хурлыг зохион байгуулсан зорилго нь МАХН-ын удирдлагын эсрэг аливаа хандлагыг бүрмөсөн таслах, Цэдэнбалтай үгсэн хуйвалдсан МАХН-ын удирдлага дахь өндөр албан тушаалтны бүлгийн ноёрхлыг хадгалан үлдэх, ингэснээр Зөвлөлт оронтой “ойртон нягтрах” гадаад бодлогоо үргэлжлүүлэх явдал байсан бөгөөд аргын хувьд Нам, Төрийн өндөр албан тушаалтны болон НАХЯ-ны хүч, нөлөөнд түшиглэсэн байв. Энэ утгаараа намын эсрэг бүлэглэл илрүүлсэн хэмээн өөрийгөө нэрлэдэг Ю.Цэдэнбал тэргүүтэн бол МАХН-ын доторх жинхэнэ БҮЛЭГЛЭЛ хуйвалдагчид байжээ.

Тус VI бүгд хурлын шийдвэрийн үр дүнд өөрийн буруу биш шалтгаанаар боловсрол мэдээллээс таслагдсан, эд хөрөнгийг нь цөлмөж, наад захын амин зуулгад ч хүрэлцэхгүй бага цалин хөлс олгож байсны улмаас ядуурч туйлдсан, эмчлүүлэх, эрүүл мэндээ хамгаалах боломжгүй болж хохирсон, тал талаасаа доромжлуулж, адлуулж, бухимдаж цөхөрсөн бөгөөд үе дамжсан бүлэг хүмүүсийг бий болгожээ.

Намын эсрэг бүлэглэл хэмээн сэхээтнүүдээ хэлмэгдүүлэх үйл ажиллагаанд гаднын ямар ч хүч, нөлөөлөл оролцоогүй бөгөөд уг бусармаг үйлдлийг хэрэгжүүлэгч нь МАХН байсныг цаг хугацаа харуулж байна.

**Дүгнэлт.** Монголын улс төрийн амьдралд тохиосон эл явдал нь тухайн үед өндөр албан тушаал эрх мэдэл, эзэгнэж байсан хэсэг “**хүн араатан**”-ы бөөгнөрөл улс орны олон зуун шилдэг сэхээтний амь, амьдралаар тоглосон харамсалтай түүхээс цухас дурдахад иймэрхүү жигшүүрт дүр зураг харагдаж байна. Эндээс дараах дүгнэлт хийж байна:

1. МАХН 1950-1960-аад онд үндсэрхэх үгүйсгэх үзэлтэн, төөрөлдсөн сэхээтэн, намын эсрэг бүлэглэгчид гэсэн нэрийн дор Монголын сэхээтнүүдийн идэвхтэй хэсгийг нухчин дарж, залхаан

цээрлүүлсэн ноцтой гэмт хэргийг үйлдсэн бөгөөд энэ хэрэгт гаднын ямар нэг улс орон, байгууллага огт оролцоогүй байна.

2. Ю.Цэдэнбал тэргүүтэй МАХН-ын дээд удирдлага бол монголын шинэ үеийн сэхээтнүүдийн идэвхтэй хэсгийг нухчин дарах, залхаан цээрлүүлэхийн тулд намын нэр барьсан жинхэнэ “хуйвалдагч бүлэглэл” байжээ. Үүнийг 1950-1960-аад онд нам, төрийн эсэргүү хэмээх хэрэгт холбогдогсдын үйлдэл гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй болохыг нэг бүрчилэн тогтоосон Монгол Улсын Дээд шүүхийн шийдвэрүүд нотлон харуулж байна.

3. Сэхээтнүүдийн эсрэг өдөөсөн зохиомол хэргийн гол хохирогчид нь эрх чөлөө, ардчилал, шударга ёс, зарчимч байдлын төлөө тэмцэгчид, тэдний гэр бүл, үр хүүхэд, садан төрлийн хүмүүс, хамтран тэмцэгчид байсан боловч хамгийн том хохирлыг Монгол Улс, монгол түмэн хүлээжээ. Монгол Улсын нийгэм, эдийн засагт ноцтой хохирол учирсныг 70 жилийн түүх бэлхнээ нотолж байна. МАХН-ын дээд удирдлагын хуйвалдагч бүлэглэл шилдэг сэхээтнүүдийн дэвшилтэт санал, санаачлагыг таслан хааж, 1990 он хүртэл 25 жил тамлан тарчлааснаар монгол улсын хөгжил дэвшил чөдөрлөгдөж, энэ хугацаанд иргэд аж амьдралаа дээшлүүлж, өмч хөрөнгөтэй, чинээлэг амьдрах бололцоогоо ихээр алдан хохирч үлдсэн байна.

4. Сэхээтнүүдийн манлайлагч, хошуучлан дагуулагч хэсгийн эсрэг МАХН-аас хэрэгжүүлсэн залхаан цээрлүүлэлт нь энэрэлгүй шинжээрээ энэ ертөнцөд олон давтагдаагүй арга явууллага байв. Олон давтагдаагүй гэж би зориуд хэлж байна. Үхлүүт өвчтөнд эмнэлгийн тусламж үзүүлэхгүйгээр онгоцноос буулгаж, эмнэлгээс хөөн гаргаснаар амиа алдсан, гэр орон эд хөрөнгийг нь хураан авсаны уршгаар нялх балчир үрс хөхөө өвлийн хүйтэнд хар буйран дээрээ нус нулимастайгаа хутгалдан чарлаж үлдсэн, чөлөө зөвшөөрөл олгоогүйн улмаас эцэг эх, төрөл төрөгсдөө сүүлчийн замд нь үдэж чадаагүй, гэм буруугүй нэгнээ аюулт дайсан хэмээн таниулж орчин тойронд нь жигшээн доромжилсон, алхам тутамд нь 25 жил мөрдөн тагнаж, хяналт тогтоосон гэх мэт үй түмэн баримтууд намайг ийм үг хэлэхэд хүргэж байна.

5. Монгол Улсын Засгийн газраас 1961 онд НҮБ-д гаргасан өргөдөлдөө: “БНМАУ НҮБ-ын дүрмийн үүргийг үг дуугүй хүлээн авч уг үүргийг нарийн чанд хэрэгжүүлэн биелүүлнэ” гэж амлан гишүүнээр элссэн байдаг. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 217/A/III) тоот тогтоолоор 1946 онд баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалсан “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” бол НҮБ-ын Үндсэн хууль гэж нэрлэгддэг. Гэтэл МАХН-ын дээд удирдлага НҮБ-д элссэн анхны өдрөөсөө эхлэн амлалтаасаа ухарч, НҮБ-ын тунхаглалын заалтуудыг толгой дараалан зөрчиж, хүний эрх,



эрх чөлөөг уламдаа гишгэсэн. Энэ нь анги ялгаварласан, үл тэвчих туйлшралын мөн чанарыг харуулсан сонгодог баримт гэж үзэж байна.

Би түүх ярьж та бүхнийг их чилээлээ. Эцэст нь нэг санал хэлье. Та бид алийн болгон бие биеэ лам хар, нөхөр дайсан, манай, танай нам гэж ялгаж, хялалзаж явах вэ? Больё тэгэх үү. Монголчууд бид, эхлээд хүчний байгууллагын ажилтнуудыг, дараа нь 2008 онд төрийн албан хаагчдыг аливаа намын гишүүнээс түдгэлзүүлсэн. Одоо нийт иргэдээ намд харьяалалгүй болгох санал дэвшүүлж байна.

### Ном зүй

1. Монгол улсын үндсэн хууль. УБ. 1992 он
2. Хүний эрх, олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхэтгэл. УБ 1976 он
3. БНМАУ-ын Их бага хурлын тогтоол, Үндсэн Хууль, тунхагууд. УБ. 1956 он.
4. Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлт/1940-60-аад он) эрдэм шинжилгээ судлалын бага хурлын илтгэлүүд. УБ. 2011 он.
5. МАХН-ын түүхийн лекц . Нэг, хоёрдүгээр дэвтэр. УБ. 1980 он.
6. МАХН-ын товч түүх. УБ. 1985 он.
7. МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. УБ. 1966 он.
8. Монгол ардын намын түүх. III, IV боть. УБ. 2011 он.
9. Ц.Навагчамба. Хэлмэгдсэн заяа 38. УБ. 2004 он.
10. Редактор П.Туваанжав. Хэлмэгдүүлэгчид гэж хэн байв. УБ. 2008 он

## 1932 ОНЫ ЗЭВСЭГТ ТЭМЦЭЛД ОРОЛЦОГСДЫГ ЦАГААТГАХ ЁСТОЙ ЮУ?<sup>1</sup>



*Ч.Болдбаатар  
Доктор (Ph.D), Дэд профессор  
МУБИС-ийн Түүхийн тэнхим*

XX зууны Монголын түүхийн нягтлан судлууштай асуудлын нэг бол 1929-1932 онуудад БНМАУ-д зөвлөлт маягийн социалист загварыг тулган хүлээлгэхийг оролдсон, түүний үр дагаврын тухай асуудал юм. Энэ илтгэлд 1930-1932 онд Монголд дэгдсэн зэвсэгт тэмцлийн нэршил, хэлбэр, хохирол, үр дагавар, үүнд оролцогсдыг цагаатгах эсэх асуудлаар санал бодлоо илэрхийлэхийг зорилоо. Чингэхдээ 5 жилийн өмнө 1932 оны зэвсэгт тэмцлийн 80 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэлээ үндэс болгосноо дурдсу.<sup>2</sup>

Манай түүх бичлэгт 1932 оны зэвсэгт тэмцлийн талаар хоёр үндсэн дүгнэлт зонхилж байгаа нь “хувьсгалын эсэргүү бослого, хөдөлгөөн” ба “зэвсэгт бослого, иргэний дайн” гэх санал болно. 1932 оны зэвсэгт тэмцлийг бүр тухайн цаг үед нь “хувьсгалын эсэргүү” хэмээн нэрийдэж байсан байдаг.<sup>3</sup> МАХН-ын Төв Хороо, Хянан байцаах Төв Комиссын хамтарсан онц III хурлын тогтоолд “... Сүүлийн хоёр сарын дотор хувьсгалын эсэргүү тэмцэл нь Хөвсгөл, Архангай, Завхан, Өвөрхангай зэргийн газруудад дэлгэрч, ардын хувьсгалт засгийг эсэргүүцсэн бослогын шинжтэй болж түүнд харин ч ажилчин ардууд ба нам, эвлэлийн гишүүд татагдан орж хувьсгалын эсэргүү феодалууд ба дээд лам нараар удирдуулан явж буй”<sup>4</sup> гэжээ. БНМАУ-ын Бага Хурлын XVII онц хуралдаанаас гаргасан тус улсын үгээгүй ядуу, дунд баян ардуудад ухуулан тунхаглах зарлал бичгийг

1 2017.9.7. Улс төрийн хэлмэгдүүлэлт: Шалтгаан, үр дагавар, сургамж. Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал.

2 Ч.Болдбаатар, Д.Мөнх-Очир. 1932 оны зэвсэгт тэмцэл: Бослого уу, иргэний дайн уу? (1932 оны бослогын 80 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурал. 2012.4.11. УБ

3 БНМАУ-ын XVII онц Бага Хурлын илтгэл тогтоол. УБ., 1932 т. 60

4 Намын Төв Хороо ба Төв Хянан Байцаах төв Комиссын хамтарсан онц III бүгд хурлын илтгэл ба тогтоолууд. УБ., 1932. т 60

“Үнэн” сонин 1932 оны 7-р сарын 14-ний өдрийн 162-р дугаартаа нийтэлжээ. Тэрхүү тунхаг бичигт дээрх зэвсэгт тэмцлийг “...харьяат улсын бүрэн эрхэнд гадаадын дайснуудаас гэжээгдэн халдсан энэхүү явдал”, “...Засгийн газрыг эсэргүүцэн илэрхий хөдөлгөөн бослогыг дэгдээн гаргав” гэж тэмдэглээд эцэст нь “...ардын засгийг эсэргүүцэж, хөдөлгөөнд оролцсон хүн бүхнийг амгалан тайван цагийн ажилдаа эргэн орж, өөрсдийн хорт зэвсгийг нэн даруй хураалгахыг уриалан зарлана. Зэвсгээ хураалгагчид ба эсэргүүцэхийг зогссоноо илэрхийлсэн бүхнийг тийнхүү хөдөлгөөнд оролцсон гэж барих, хорих буюу цээрлүүлэн шийтгэж үл болно. Ийнхүү сануулсаар атал зөрчих, зэвсгээ хураалгахгүй буюу ардын засгийг эсэргүүцсэн өөрийн ялт хэрэг ажлаа үргэлжлүүлэх хийгээд ялт этгээд нарыг нуун далдлах ба туслах этгээд нар гарах бол тэднийг бидний Бүгд Найрамдах Бүрэн эрхт Улс төрөөс урвагч бөгөөд ардын дайсанд үзэхийг тус улсын Ардын Хурлаас зарлаж, тэднийг урвагчдад тоолж, туйлын хатуугаар цээрлүүлэн шийтгэхийг тунхаглана” гэжээ. Монгол, Зөвлөлтийн түүхчдийн хамтран бичсэн манай түүхийн судалгааны суурь бүтээлийн нэг “БНМАУ-ын түүх” нэгэн боть бүтээлд 1932 оны үйл явдлыг зүүнтний алдаа нугалааг далимдуулан “харгис феодал, лам нар сүм хийдийг түшиглэж Японы империализмын дэмжлэгээр тус улсын баруун хэдэн аймагт хувьсгалын эсэргүү бослогыг гаргав”<sup>5</sup> гэж дүгнэжээ. Харин БНМАУ-ын түүхийн III ботид дээрх дүгнэлтийг онолын талаас үндэслэхийг оролдож “...энэ бослого бол тус оронд ангийн тэмцэл асар хурцадсаны тодорхой илрэл болсон бөгөөд феодалын эсэргүү тэмцлийн тэсрэлт<sup>6</sup> хэмээн ангийн тэмцлийн үүднээс тайлбарласан байна. Энэ дүгнэлт нь социализмын жилүүдэд улс төрийн чиг баримжаа, үзэл номлол болж ирснийг бид мэднэ.<sup>7</sup> Мөн энэ үед 1932 оны зэвсэгт тэмцлийн түүхэнд холбогдох дурсамж тэмдэглэл нэлээд хэвлэгдсэн хэдий ч зөвхөн нэг талын-бослого дарж явсан хүмүүсийн болон тэдний төрөл садангийн ба босогчдоос хохирсон хүмүүсийн дурдатгал, сэтгэгдэл нийтлэгдсээр ирсэн нь ... өрөөсгөл тодорхойлолт өгөхөд хүргэжээ.”<sup>8</sup>

1990 оноос түүхийг шинээр судлан тоймлох боломж бүрдэв. 1932 оны зэвсэгт тэмцлийг ангийн тэмцлийн үүднээс бус өргөн хүрээнд, шинэ хандлага, шинэлэг сэтгэлгээгээр үнэлж дүгнэсэн бүтээлүүд гарав.<sup>9</sup> 1932 оны үйл явдлыг зэвсэгт бослого, иргэний дайн байсан гэх талаар судлаачдын хооронд харилцан зөрүүтэй санал баримтлах болсон юм. Энэ чиглэлээр дагнан судалсан Д.Цэрэнбалжир, С.Ганболд нар

5 БНМАУ-ын түүх. УБ., 1954. т 354

6 БНМАУ-ын түүх. Гутгаар боть. УБ., 1969. т 292

7 Б.Дашзэвэг. БНМАУ-д хүрээ хийд, лам нарын асуудлыг шийдвэрлэсэн байдал. БНМАУ-ын капиталист бус хөгжлийн түүхэн туршлагын зарим асуудал. УБ., 1970. Ш.Жамсранжав. Баруун дөрвөн аймагт гарсан эсэргүү бослогыг дарсан нь. Ардын арми. 1969. № 4., Г.К.Плотников. Монгольская народная армия. М.1971., Монгол ардын армийн 50 жил. УБ., 1971 г.м

8 С.Л.Кузьмин. Ж.Оюунчимэг. Социализмын эсрэг 1932 оны Монгол дахь бослого. УБ., 2014. т.10

9 Хорьдугаар зууны Монгол. Түүхийн тойм. УБ., 1995., Монголын төрийн байгуулал, улс төрийн сэтгэлгээний хөгжил. УБ., 1995.,

дээрх үйл явдлыг зэвсэгт бослого гэж томъёолж буй бол Ч.Дашдаваа, Т.Лхагваа нар зэвсэгт бослого гарсан явдал иргэний дайны ирмэгт тулж ирсэн, Баабар, О.Батсайхан, Д.Золбоо нар “иргэний дайн” гэж үзэх болжээ.

### **Зэвсэгт тэмцлийн хэлбэр:**

#### **Иргэний дайн уу? Зэвсэгт бослого уу?**

Дэлхийн түүхэнд улс орнуудын дотоод дахь улс төрийн хямрал, хууль ёсны засаг төрийн эзэнгүйдэл ба давхардал, үндэстэн угсаатан, шашин хоорондын зөрчлөөс үүдсэн зохион байгуулалттай бүлгүүдийн хоорондын зэвсэгт мөргөлдөөнийг “иргэний дайн” (лат. *bellum civile*) гэж томъёолох ба уг нэр томъёо Ромын бүгд найрамдах улсын үе буюу НТӨ I зуунаас эхлэн тэмдэглэгдэж ирсэн байдаг. Гагцхүү энэхүү нэр томъёо нь өөрөө нэлээд бүрхэг, тайлбар, тодорхойлолт, шалгуур үзүүлэлтээс хамааран өргөн хүрээнд хэрэглэгдэж болох ухагдахуун юм. Зарим тохиолдолд тухайн үйл явдалд үнэлэлт дүгнэлт өгч байгаа этгээдийн (түүхч, судлаач, сурвалжлагч, төр засаг, шүүх, улс төрчид, олон нийт гэх мэт) хувийн үзэл бодол, итгэл үнэмшил, үзэмж төдийгүй өөрийнх нь оролцооны хэлбэрээс ч хамааран олон янзаар тайлбарлагдаж байна. Энэ бүхнээс шалтгаалан “иргэний дайн”-ыг нэг янзаар хатуу тогтоосон тодорхойлолт өнөөг хүртэл алга. Тухайлбал, аливаа зэвсэгт мөргөлдөөний үед баримтлах олон улсын эрх зүйн гол баримт бичиг болох Женевийн конвенцид ч “иргэний дайн”-ыг томъёолсон тодорхойлолт байхгүй. Харин энэ баримт бичигт “олон улсын бус зэвсэгт мөргөлдөөн” гэсэн ерөнхий нэршил дор зэвсэгт бослого, иргэний дайн хоёрыг хамтад нь тодорхойлж, дараах дөрвөн шалгуураар улс хоорондын дайнаас болон дотоодын үймээн, самуунаас зааглаж байна. Үүнд:

1. Мөргөлдөөнд оролцогч нэг тал нь тухайн улсын Засгийн газар, нөгөө тал буюу босогч тал нь улсынхаа нутаг дэвсгэрийн тодорхой хэсэгт хяналт тогтоосон байх,
2. Засгийн газрын тал улсынхаа хүн амыг засаглах де-юре эрхээ хэрэгжүүлж чадахгүй, босогч тал өөрийн захиргаанд байгаа нутаг дэвсгэрийн оршин суугчдын хувьд де-факто засаглал тогтоосон байх,
3. Босогч талд дайтагчдыг ямар нэгэн хэмжээгээр байлдааны ажиллагааны оролцогч гэж хүлээн зөвшөөрсөн байдал үүссэн байх,
4. Засгийн газрын тал босогч талын хүчний эсрэг байнгын цэргийн хүч ашиглахаас аргагүйд хүрсэн байх.<sup>10</sup>

10 Final Record of the Diplomatic Conference of Geneva of 1949, (Volume II-B, p. 121): on Third 1949 Geneva Convention, Article III, Section “A. Cases of armed conflict”

Дээрхээс үзэхэд, иргэний дайн нь хамгийн түрүүнд нэг улсын дотоодод өрнөдгөөрөө зэвсэгт бослоготой төстэй шинж чанартай (иймээс ч энэ хоёрыг олон улсын эрх зүйн чухал баримт бичигт нэг түвшинд адилтгасан байна) бөгөөд улс хоорондын дайнаас ялгаатай байна.<sup>11</sup> Харин тухайн цаг үед дайтагч нэг тал нь өөрийн захиргаанд оруулсан нутаг дэвсгэрийг тусгаар улс хэмээн зарлах, тусгаар улсын институтүүдийг хууль ёсны дагуу байгуулах явдал үүнд хамаарахгүй юм. Ийм нөхцөлд дайны мөн чанар нь улс хоорондын дайны шинжийг агуулна (талууд өөрийн дайтагчдыг Зэвсэгт хүчин гэж тооцох, байнгын цэргийн бүтэц, командлал, цол, ялгах тэмдэг, дүрэм хэрэглэх, төвлөрсөн байдлаар санхүүжүүлэх гэх мэт.). Үүний жишээ бол 1861-1865 оны Америкийн иргэний дайн юм. Ийм дайны эцсийн зорилго бол босогч тал Засгийн газрын талыг түлхэн унагаж өөрийн засгийг тогтооход бус, бүрэн салан тусгаарлаж бие даасан улс байгуулахад оршиж байдаг. Түүхэн нөхцөл байдлын эрхээр босогч тал амжилтад хүрч тусгаарлаж чадсан тохиолдолд “иргэний дайн” хэмээх нэр томъёог хэрэглэлгүй, “тусгаар тогтнолын төлөөх дайн” гэх зэрэг өөр нэршил түүх бичлэгт хэвшдэг байна. Улс хоорондын дайны хэлбэрээр эхэлсэн зэвсэгт мөргөлдөөн эцэст нь дайтагч талуудын нэгний ялалтаар төгсөж, нэгдмэл улс байгуулсан нөхцөлд хожим нь иргэний дайнд тооцогдох тохиолдол ч бий. Тухайлбал, 1963-1975 оны Вьетнамын дайн өнөөгийн БНСВУ-ын түүх бичлэгт нэг талаас дотоодын иргэний дайн, нөгөө талаас АНУ-ын түрэмгийллийн эсрэг дайн гэж нэрлэгдэж байгаа ба улс хоорондын дайнд тооцогддоггүй. Хэрвээ 1950-1953 оны Солонгосын дайн аль нэг талын бүрэн ялалтаар дуусч нэгдмэл улс байгуулагдсан үр дүнд хүрсэн бол мөн л улс хоорондын дайнд бус, иргэний дайнд тооцогдох байсан ажээ.

Харин босогч тал салан тусгаарлах зорилго агуулалгүйгээр засгийн эрхэнд байгаа хүчнийг түлхэн унагаж өөрийн засаглалыг тогтоохын төлөө дайтах явцад өөрийн захиргаанд буй нутаг дэвсгэр, хүн амын хувьд мөн тусгаар улсын нэгэн адил институтүүдийг байгуулах нь бий. Ийм төрлийн иргэний дайнд аль аль тал нь өөрийн төр, засгийн байгууллага, цэргийн дээд командлалтай, байнгын цэргийн дүрэм, цол, ялгах тэмдэг үйлчилдгийн жишээ болгож 1918-1922 оны Оросын иргэний дайн, 1931-1936 оны Испанийн иргэний дайн, 1945-1949 оны Хятадын иргэний дайныг дурдаж болох юм.

Улс төрийн талаас “иргэний дайн”-ыг жирийн зэвсэгт бослогоос ялгах нэг үндсэн шинж нь тухайн улсын улс төрийн амьдралд идэвхтэй оролцогч төр, цэргийн зүтгэлтнүүд дайтагч талуудын ялангуяа босогчдын талд орсон, босогч талын байгуулсан засаглалын институтүүдэд тодорхой зэрэг дэв, албан тушаал эрхэлсэн байх

11 Nations, Markets, and War: Modern History and the American Civil War | Book Reviews “Two nations [within the U.S.] developed because of slavery.” October 2006. Retrieved July 2009.

явдал юм. Үүгээрээ тухайн мөргөлдөөнд хүргэсэн хямрал улс төрийн хагарлын шинжийг агуулдаг ба улс төрийн элит давхарга хагаралд ороогүй нөхцөлд босогчид нь жирийн дээрмийн бүлэглэл, партизануудаас ялгагдахгүйд хүрдэг ажээ. Дээр өгүүлсэнчлэн, ийм нөхцөлд сая босогч талд байлдааны ажиллагаанд оролцогсдыг ямар нэгэн хэмжээгээр “дайтагч тал” хэмээн хүлээн зөвшөөрөх сэтгэл зүйн урьдач нөхцөл засаг баригч талд бүрэлддэг бололтой ба энэ нь яваандаа түүх бичлэгт тусгалаа олж үлддэг ажээ. Өмнө дурдсан иргэний томоохон дайнууд бүгд тухайн улсынхаа төр, цэрэг, нийгэм улс төрийн амьдралд зонхилох эрх үүрэг бүхий зүтгэлтнүүд хоёр талд хагаран хуваагдсанаас үүдсэн байна. Үүнээс үзэхэд, “иргэний дайн”-ыг тодорхойлох улс төр, эрх зүйн томъёолол нэлээд өргөн, үндсэндээ түүх бичлэгийн асуудал болдог ажээ. Харин цэвэр цэргийн шинжлэх ухаан талаас нь томъёолсон зүйл бас ховор байна.

Дайтагч талуудаас байлдааны ажиллагаанд оролцогч хүний тоо, зэвсгийн нэр, төрөл, тоо, хэмжээгээр тодорхойлох байдал байдаг ч тухайн улсын хүн ам, нутаг дэвсгэрийн харьцангуй хэмжээ, мөргөлдөөн үүссэн газар орны онцлог зэргээс хамааран хатуу тогтоох боломжгүй ажээ. **Хамгийн дөхөмтэй тодорхойлж болох нэгэн үзүүлэлт бол дайтагч талуудаас үрэгдсэн хүмүүсийн тоо юм.** Зарим судлаачид хоёр талаас нийлээд хамгийн багадаа 1000 хүн үрэгдсэн тохиолдолд “иргэний дайн” гэж тооцож болно<sup>12</sup> гэж үзэж байгаа бол энэ тоог цаг хугацааны тодорхой хэрчим дотор тавих ёстой, тухайлбал, нэг жилийн турш хоёр талаас нийлээд дунджаар 1000 хүн үрэгдсэн байх ёстой гэж үздэг судлаачид ч байна.<sup>13</sup> Энэ тоог ч хатуу тогтоох боломжгүй, тал талаас тус бүр 100-гаас илүү хүн үрэгдсэн байх ёстой гэсэн шалгуур тавьдаг судлаачид мөн байна.<sup>14</sup>

Монгол дахь 1932 оны зэвсэгт тэмцлийн хор уршиг, хүн хүчний болон эд материалын хохирлын хэмжээг нарийвчлан тогтоож чадаагүй, эдүгээ тогтоох бараг боломжгүй бизээ. Тухайн үед буюу 1933 онд хэвлэгдсэн “Тус улсын баруун аймгуудад 22 онд хувьсгалын эсэргүү хөдөлгөөнийг удирдан явсан гэмт хэрэг бүхий 39 хэрэгтний тухай ялын төлөвлөгөө” гэх баримт бичигт “...бүрэн гүйцэд бус мэдээгээр авч үзвэл эсэргүү нарын удирдагчид ба идэвхтэйгээр оролцогчдын алсан, зодож зовоосон хүний тоо 400 гаруй болно. Үүний дотроос нэг сайд, нэг доктор ба ардын хувьсгалт улаан цэргийн дарга хэд орсон бөгөөд түүнээс гадна сүйтгэж устгагдсан анхны хоршоо 45, сумын захиргаа 35 болохын дээр хэд хэдэн цахилгаан шуудангийн хороо ба үлэмжхэн тооны хамтралыг сүйтгэж устгасан”<sup>15</sup> нь улсад 10 гаруй

12 James Fearon, “Iraq’s Civil War” in Foreign Affairs, March/April 2007.

13 Ann Hironaka, Neverending Wars: The International Community, Weak States, and the Perpetuation of Civil War, Harvard University Press: Cambridge, Mass., 2005, p. 3.

14 Edward Wong, “A Matter of Definition: What Makes a Civil War, and Who Declares It So?” New York Times November 26, 2006

15 БНМА Улс хөрөнгөтний биш хөгжлийн төлөө тэмцэлд. Баримт бичгүүд (1925-1940). УБ., 1956. т 137

сая төгрөгийн хохирол учруулсан гэсэн нь хохирлын талаар нэгтгэн дүгнэсэн анхны баримт юм. Зэвсэгт тэмцлийн үеэр учирсан хүн хүчний хохирлыг тооцохдоо зөвхөн босогчдын гарт алагдсан үрэгдсэн улсын тоог гаргахыг голчилсон болохоос нийт хэдэн хүн үхэж үрэгдсэн, шархадсан зэргийг тоолж гаргаагүй ажээ.

Сүүлийн жилүүдэд 1932 оны зэвсэгт тэмцлийн талаар судалсан эрдэмтэд энэ талаар өөрсдийн тооцоог гаргажээ. Судлаач Д.Цэрэнбалжир бослого гаргагчид нь нийт 700 хүний амь насыг бусниулсан<sup>16</sup> гэсэн бол профессор Д.Гомбосүрэн зэвсэгт бослогыг дарах явцад 2056 хүн амь үрэгдсэн<sup>17</sup>, доктор С.Ганболд дунджаар 5976 буюу 6000 орчим хүн хоёр талаас амь насаа алдсан, [хүн хүчний хохирлын 53,4 хувь буюу 4176 хүн алагдсан цаазлуулсан]<sup>18</sup>, С.Л.Кузьмин зөвхөн байлдаанд үрэгдсэн босогчдын тоо 1915 хүн, засгийн газрын отрядуудаас 409 хүн алагдсан<sup>19</sup> гэж үзжээ.

**Энэ бүхнээс харахад, “зэвсэгт бослого”, “иргэний дайн” гэх хоёр нэр томьёо нь харилцан бие биеэ үгүйсгэх альтернатив тодорхойлолт биш, харин сэлгэн хэрэглэгдэж болох бөгөөд “иргэний дайн” хэмээгч нь улс төрийн, цэргийн, түүгээр зогсохгүй эрх зүйн гэхээсээ илүү түүх бичлэгийн ухагдахуун болох нь харагдаж байна.**

1932 онд БНМАУ-ын нутаг дэвсгэрийн тодорхой хэсэгт дэгдсэн зэвсэгт бослого нь салан тусгаарлах зорилго агуулаагүй ч нэлээд олон үзүүлэлтээр тухайн цаг үеийнхээ нөхцөлд “иргэний дайн”-ы хэмжээнд хүрсэн байжээ гэж дүгнэж болохоор байна.

### *1932 оны зэвсэгт тэмцэлд оролцогсдыг цагаатгах үндэслэл бий юу?*

Юуны түрүүнд 1932 оны зэвсэгт тэмцэлд хичнээн хүн хамрагдсан буюу нийт босогчдын тоог тогтоох нь чухал байгаа юм. Энэхүү хөдөлгөөнд нийтдээ 3000 илүү хүн хүн 13 бүлэглэл болон оролцсон<sup>20</sup> гэж үзсээр ирсэн нь бодит байдалтай нийцэхгүй юм. Доктор С.Ганболд бослогын эхний үед буюу 4-7 дугаар сард босогчдын тоо багаар бодоход 6000-8000 хүрсэн гээд тэдний дотор нийгмийн бүх давхаргынхан, үүнд нийгмийн хамгийн идэвхтэй, тэргүүний хэсэг гэгдэж байсан нам, эвлэлийн гишүүд хэдэн зуугаараа бослогод хамрагдсан бөгөөд тэдгээрийн дотор намын их хурлын төлөөлөгч, УБХ-ын гишүүд хүртэл байв гэжээ. Босогчдын зэвсэгт тэмцэлд оролцсон байдал нь учир ялгавартай байсан юм. Босогчдын нэг хэсэг нь төр засгийн бодлогод дургүйцэн бухимдаж зэвсэгт тэмцэлд сайн дураараа нэгдсэн

16 Д.Цэрэнбалжир. 1932 оны зэвсэгт бослого. УБ., 1990. т 94

17 Д.Гомбосүрэн. Монгол Улсын Зэвсэгт хүчний байгуулалтын түүх (1921-1956). УБ., 1998., т 53

18 С.Ганболд. Монголд 1932 онд гарсан зэвсэгт бослого. (Цэрэг-түүхийн шинжилгээ). Докторын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол. УБ., 2000. т 119. Зохиогчоос зөвшөөрөл авсан болно.

19 С.Л.Кузьмин. Ж.Оюунчимэг. Социализмын эсрэг 1932 оны Монгол дахь бослого. УБ., 2014. т.180-181

20 БНМА Улс хөрөнгөтний биш хөгжлийн төлөө тэмцэлд. Баримт бичгүүд (1925-1940). УБ., 1956. т 137



бол олон зуун хүн босогчдын сүр хүчинд автагдан босогчидтой хүчээр нийлснийг тэмдэглэх ёстой. Коминтерн, БХК(б)Н-аас Монголын удирдагчдад “...бослогыг зохион байгуулж удирдагч феодалууд ба дээд лам нар хийгээд мөн түүнчлэн бослогод ил тодорхой, идэвхтэйгээр оролцогсод, нам эвлэлийн талаас урваж бослогын талд орогсдыг хайр найргүй устгах”-ыг зааварчилсан бөгөөд МАХЦ-ийн отрядууд босогчдод хатуу ширүүн хандаж бараг толгой дараалан устгах байр суурь баримталж байснаас энэ хэрэг явдал улам даамжран газар авахад хүрсэн байдаг. Бослогод оролцсон хэмээн олон хүнийг гэр орноос нь баривчилж шийтгэх, буудан алах ял оноож байсан зэргээс нийгэмд, олон нийт асар их айдаст автсан гэлтэй. Ийнхүү 1932 оноос хойш “эсэргүү бослого”-д оролцсон хүмүүсийг хувьсгалын эсэргүү гэж үзэн шийтгэж, биеийн байцаалтад хувьсгалын эсэргүү бослогод оролцсон эсэхийг лавлаж шалгах болжээ. Үүний баримт нь БНМАУ-ын Бага Хурлын гишүүн, ЭХЯ-ны сайд Чойнбүрэнгийн Жүгдэрнамжил (1913-1992)-ын амьдрал юм. Түүнийг 1932 оны эсэргүү бослогод оролцож явснаа нуун далдалсан хэргээр баривчлан 1940 оны 9 сарын 10-нд таван жилийн хорих ялаар шийтгэсэн байдаг.<sup>21</sup>

**Эдүгээ 1930-1932 оны зэвсэгт тэмцэлд оролцогсдыг цагаатгах асуудал нэг мөр болоогүй байна.** Босогчдын зорилго юу байсан, тэдэнд мөрийн хөтөлбөр байсан эсэх, тэд салан тусгаарлахыг зорьж байсан эсэх, төрөөс босогчдыг буруутгасан ялын дүгнэлт, үндэслэл чухам юу байсан? Ер нь босогчид буруутай юу гэдэг асуулт тавигдаж байна.

1930-1932 онд Монголд дэгдсэн зэвсэгт тэмцэл үүдэн гарах болсон эх сурвалж бол нам төрөөс явуулсан ангич, намч бодлого байсан юм. 1928 оны эцсээр Коминтерн, БХК(б)Н-аас Монголд ордны эргэлт зохион байгуулж, түүний дүнд “зүүнтнүүд” засгийн эрхэнд гарч, зөвлөлт маягийн социализмыг түргэвчилэн байгуулах улс төр, эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн юм. Монголд практик социализм байгуулах үйл явц 1928-1932 онд үргэлжилж, нийгмийн анги бүлгийг хагаралдуулах, иргэдийг гарал угсаа, үндэс язгуур, хөрөнгөөр ялгаварлах, хувийн өмчийг хяхан хавчих, нийгмийн үнэт зүйл болсон шашныг хавчин устгахыг зорьсон нь иргэдийн язгуур эрх, эрх чөлөөг шууд зөрчихөд хүргэж, Монгол орныг нийгэм-эдийн засгийн гүнзгий хямралд оруулсан юм. Коминтерн, БХК(б)Н-аас шууд удирдан зааварчилж байсан энэхүү бодлогыг Монголын ард иргэд эсэргүүцэн зэвсэг барин тэмцсэн. Энэ утгаараа Монголын 1930-1932 оны үйл явдал нь социализмыг эсэргүүцсэн, Зөвлөлтийн эсрэг тэмцэл байсан юм. Энэхүү тэмцэл нь хожим социалист системийн орнуудад, тухайлбал 1956 онд Унгар, Польш, 1968 онд Чехословакт болсон

21 С.Далайхүү. Чойнбүрэнгийн Жүгдэрнамжилын улс төрийн намтар. УБ., 1997

үйл явцтай төстэй юм. Харин эдгээр орнуудад дээрх хөдөлгөөнд оролцогсдыг цагаатгасан төдийгүй үндэсний баатрууд хэмээн дурсан хүндэтгэх болжээ. Босогчид гаднаас тулгасан бодлогыг зөнгөөрөө сөрөн эсэргүүцсэн тэмцсэн болохоос тэдэнд нэгдсэн мөрийн хөтөлбөр гэж байсангүй, тэр ч байтугай Монголын тусгаар тогтнолыг устгаж, харьд нийлүүлэх, салан тусгаарлах үзэл санаа огт байгаагүй юм. Шүүхийн материалд хувьсгалын эсэргүү нар Монголын тусгаар тогтнолыг устгаж, түүнийг Япон эсвэл Хятад улсад нэгдүүлэх гэснийг нотлох баримт гаргаж үзүүлээгүй байна.<sup>22</sup> Бодлогыг эсэргүүцэх нь буруутгах үндэслэл болох ёсгүй. Монголчуудын тэмцлээс үүдэн Коминтерн, БХК(б)Н өөрийн бодлогоо эргэн харахад хүрч “шинэ эргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх зорилгыг дэвшүүлсэн билээ. Энэ бодлогыг тунхаглахдаа эн тэргүүнд зүүнтний жилүүдэд тогтоосон бүхий хууль тогтоолыг хүчингүй болгохоор заасан юм. 1934 онд БНМАУ-ын дээд эрхийг барих Улсын VII Их Хурлаас “... үүний урьд Улсын VI Их Хурлаас гаргасан аливаа тогтоол шийдвэрүүд нь тус улсын олон нийгмийн ба эдийн засаг, үндэс угсаа, хэв заншлын зэрэг байдалд харилцан тохирохгүй бөгөөд эндүү алдаатай зүйл мөний тул цөм хүчингүй болгосугай”<sup>23</sup> гэж тогтоожээ. Ийнхүү гаднаас тулган хэрэгжүүлэхийг зорьсон улс төр, эдийн засаг, нийгэм соёлын бодлогыг төрөөс хүчингүй болгон цуцалсан нь язгуур эрх, эрх чөлөөнийхөө төлөө тэмцсэн ард иргэдийн [Монголчуудын] тэмцэл зүй ёсны, шударга тэмцэл байсныг нотлон харуулж байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ шийдвэр босогчид буруугүй гэдгийг төр хүлээн зөвшөөрсөн үйл явдал байсан юм.

Босогчдыг буруутгасан дүгнэлт, үндэслэл чухам юу байсан бэ? Үүнд “Тус улсын баруун аймгуудад 22 онд хувьсгалын эсэргүү хөдөлгөөнийг удирдсан явсан гэмт хэрэг бүхий 39 хэрэгтний тухай ялын төлөвлөгөө”-д босогчдыг “...Хувьсгалт засаг төрийг устгахын тулд ... хувьсгалын эсэргүү байгууллагыг хийж... хувьсгалын эсэргүү ажил явуулгыг идэвхтэйгээр явуулсан. [Хувьсгалын эсэргүү хөдөлгөөний удирдагч нарын мэдүүлэг дээрээс авч үзэхэд] гадаадын Банчин богдтой харилцааг байгуулсан”<sup>24</sup> гээд Банчин богдоос хувьсгалын эсэргүү хөдөлгөөний зорилго, хэдийд бослого гаргахыг тодорхой зааварчилсан гэж буруутгажээ.

### **Босогчид хувьсгалт засаг төрийг устгахын төлөө тэмцсэн үү?**

Босогчид засаг төрийн явуулж буй бодлогыг эсэргүүцэн боссоноос бус хувьсгалт засаг төрийг устгахыг зориогүй юм. Магадгүй босогчдыг зарим нь хувьсгалт засаг төрийг үзэж ядаж устгахыг хүсч байсан байж болох ч энэ нь бослогыг уг зорилгыг тодорхойлохгүй нь мэдээж.

22 С.Л.Кузьмин, Ж.Оюунчимэг. Социализмын эсрэг 1932 оны Монгол дахь бослого. УБ., 2014. т.154

23 БНМАУ-ын VII Их Хурлын илтгэл, тогтоол. УБ., 1935. т.16

24 БНМА Улс хөрөнгөтний биш хөгжлийн төлөө тэмцэлд. Баримт бичгүүд (1925-1940). УБ., 1956. т.127, 132

Хэрвээ хувьсгалт засгийг унагаж шинэ засгийг байгуулахыг зорьж байсан аваас тэдэнд нэгдсэн зохион байгуулалт, мөрийн хөтөлбөр байх ёстой. Зэвсэгт тэмцлийн хүрээ тэлж, харилцан уялдаагүй, зохион байгуулалтгүй байсан зэргээс үүдэн бослогын явцад босогчдыг нэгдсэн зохион байгуулалтад оруулахыг оролдож байсан нь баримтаас харагддаг. Босогчдыг нэгтгэж байсан гол зүйл бурхан шүтээнээ хамгаалах явдал байсан нь илт юм.

Босогчдыг буруутгаж буй бас нэгэн зүйл бол **хувьсгалын эсэргүү байгууллага байгуулж**, хувьсгалын эсэргүү ажил явуулж байсан гэх ял зэм юм. Үүнийгээ багтахын тулд “Монголын ардын засгийг устгах, үүний оронд феодал хуучин засгийг байгуулах”-ыг зорьж асан феодал Эрэгдэндагвын бүлэг (1931), гачин лам Эрэгдэнбүрэлгүүгийн бүлэг (1932)-ийг илрүүлэн тэдний хувьсгалын эсэргүү үйл ажиллагааг таслан зогсоосон гэх суртал нэвтрүүлэг юм. Энэ байгууллагын дотор оролцсон этгээдээр уламжлан босогчид Банчин богдтой холбоо тогтоосон төдийгүй Банчин богдод явуулсан бичигтээ хувьсгалын эсэргүү хөдөлгөөнийг удирдуулахаар [Самбуу түвчин, Баруун Асгатын хүрээний лам Чойжин, Жалханзын хүрээний гавж хувилгаан] 3 хүнийг томилж, Банчин богдод батлуулахаар явуулсан гэж буруутгаж байжээ. Гэтэл байцаагдсан хүмүүсийн олонх нь бослогын үүсэл, удирдлагын талаар мэдүүлэг өгөөгүй байдаг. Судлаач Д.Цэрэнбалжир, н.Аюурзана, н.Бямбаа, н.Самдан нарын мэдүүлгийг бослого гаднаас зохион байгуулагдсан, түүнийг Самбуу дүвчин толгойлсон гэж батлахын тулд ашигласан гээд эдгээр нотолгоо нь зохиомол зүйл байж магадгүй гэж тэмдэглэсэн байдаг. Шүүгдэгчдийн мэдүүлгийг үндэслэн тэднийг буруутгасан байна. Янз бүрийн зөрүүтэй мэдүүлгийг нягтлан шалгах, эд мөрийн баримттай тулгах, эд мөрийн баримтыг шалгаж баримтжуулаагүй зэрэг нь босогчдыг зөвхөн буруутгах яллахыг голлож байсантай холбоотой мэт. Шүүх хурал дээр Самбуу “өмнөх мэдүүлэгт үнэн ч юм бас худлаа ч юм бий... үнэн хэрэгтээ захиа авчирсан халзан Доржтой уулзаж байгаагүй” гэх зэргээр мэдүүлж байсан нь дээрхийг нотолно. 1932 оны зэвсэгт тэмцлийг бэлтгэхээр хувьсгалын эсэргүү бүлэг байгуулсан гэдэг нь баримт нотолгоогүй зүйл болох нь тодорхой байна.

Эцэст тэмдэглэхэд 1930-1932 онд зэвсэгт тэмцэлд оролцогсдыг шүүхийн болон шүүхийн бус байгууллагын шийдвэрээр буруу зөвийг ялгалгүй таслан шийтгэж, амь насыг нь хөнөөсөн нь хэлмэгдүүлэлтийн нэгэн хэлбэр болжээ. Иймд зэвсэгт тэмцэлд оролцсон нэрийдлээр олон зуун хүнийг шийтгэсэн хэргийг дахин хянан үзэж, нэр төрийг нь сэргээн цагаатгах цаг нь болсон гэж үзэж байна.

## УЛС ТӨРИЙН ХЭЛМЭГДҮҮЛЭЛТЭД МАХЦ-ИЙН БИЕ БҮРЭЛДЭХҮҮН ӨРТСӨН НЬ



*С.Ганболд  
Доктор (Ph.D), Профессор, хурандаа  
Батлан хамгаалахын эрдэм  
шинжилгээний хүрээлэнгийн Цэргийн  
түүх судлалын төв*

Монгол орны XX зууны түүхэнд тохиолдсон хамгийн эмгэнэлтэй хар толбо болон үлдсэн үйл явдал бол улс төрийн хэлмэгдүүлэлт билээ. Энэ хэлмэгдүүлэлтэд монголын олон арван мянган иргэд, эрдэмтэн, сэхээтэн, лам хувраг, албан хаагчид түүний дотор өндөр боловсрол, мэргэжил эзэмшсэн цэргийн дарга нар, жирийн цэргүүд хүртэл өртсөн юм. Энэ хэлмэгдүүлэлтэд цэргийн удирдах дээд байгууллагаас эхлээд корпус, дивиз, хороо, дивизион, суман, салаа, тасаг хүртлэх бүх л нэгжүүд, ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжнаас цэрэг, цэргийн дээд цолтой маршалаас жирийн байлдагч хүртэл бүх л албан тушаалтан, цэргийн албан хаагчид өртсөн юм.

Анх 1922 онд Ардын Засгийн газрын ерөнхий сайд асан Д.Бодоог “Бүгд найрамдах засгийн хэрэг” гэгчид холбогдуулан цаазалснаар Монгол оронд хууль ёсыг ноцтойгоор завхруулж улс төрийн талаар хэлмэгдүүлэх гунигт үйл явдлын эхлэл тавигдсан юм. Д.Бодоогийн хэрэгт 15 хүн холбогдон цаазлуулсны гурав нь цэргийн албан хаагч байв. Үүний дараа Бүх цэргийн жанжин С.Данзанг Монгол улсын цаашдын хөгжлийн талаар өөрийн үзэл бодлоо илэрхийлэн түүнийгээ хамгаалж байсных нь 1924 онд цаазлан хороосон байна.

Монгол оронд гарсан улс төрийн хэлмэгдүүлэлтэд олон мянган хүн өртсөний дотор цэргийн албан хаагчид багагүй хувийг эзэлж байгаа бөгөөд одоогийн байдлаар бидний олж тогтоосон улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн цэргийн албан хаагчид нь нийт хэлмэгдэгсдийн 4 хувийг эзэлж байна.

Хэлмэгдэлд өртсөн цэргийн албан хаагчдын дийлэнх нь 1937-1939 онд буюу П.Гэндэн, Г.Дэмидийн хувьсгалын эсэргүү байгууллагын

хэрэгт холбогдон шийтгүүлсэн бөгөөд эхний ээлжинд даргалах бүрэлдэхүүн илүүтэй хэлмэгдсэн юм. Улс төрийн хэлмэгдүүлэлт нь МАХЦ-т ноцтой хор уршиг учруулсан бөгөөд тэрхүү хохирлыг олон жилийн туршид арилгаж чадаагүй юм.

Монгол орон даяар нийтээр нь дайчлан баривчлах ажиллагаа 1937 оны 09 сарын 10-ны шөнө эхэлсэн бөгөөд ЗХУ-аас ирүүлсэн “Заговор” (хуйвалдаан) гэдэг томьёолсон нэрийн дор нэн даруй дайчлан баривчлах 115 хүний нэрсийн жагсаалтад орогсдыг эхний ээлжинд баривчилжээ. Уг жагсаалтад орогсдын дөрөвний нэг нь МАХЦ-ийн удирдах албан тушаалтнууд байв.

Хилс хэрэгт дайчлан баривчлах ажиллагаа МАХЦ-ийн хэмжээнд өрнөж 1937 оны 11 дүгээр сар гэхэд Цэргийн яам, Жанжин штаб зэрэг удирдах дээд байгууллага төдийгүй корпус, дивизийн удирдлагууд бүхэлдээ баривчлагджээ. Түүнчлэн хороо, дивизион, салаа, сумангийн удирдах бүрэлдэхүүн ч үүнд өртөв. Эдгээр баривчилсан цэргийн албан хаагчдыг онцгой бүрэн эрхтэй комиссын хурлаар таслан шийтгэж байжээ.

Нийтийг хамарсан баривчилгааны дараахан төр засаг, цэргийн томоохон албан тушаалын 14 хүний хэргийг 1937 оны 10 сарын 18-21-нд Улаанбаатар хотод олон нийтийн өмнө Улсын дээд шүүхийн нээлттэй хуралдаанаар анх удаа таслан шийтгэсэн байна. Энэхүү “14-ийн хэрэг” гэгч зохиомол хэрэгт МАХЦ-ийн Жанжин штабын дарга Ж.Малж тэргүүтэй цэргийн удирдах албан тушаалын 6 хүн холбогдож цаазаар авах ял шийтгүүлжээ.

Энэхүү “хувьсгалын эсэргүү бүлэг”-ийн толгойлогч гэгдэх дээрх хүмүүсийг олон нийтийн өмнө шүүн тасалсан нь үнэхээр хувьсгалын эсэргүү бүлэг бий гэдэгт ард түмнийг итгүүлэх, өөрсдийн хийж буй ажлыг дэмжүүлэн зөвтгөх, улмаар уг ажлаа хойшид өргөжүүлэх гэсэн далдын зорилготой байв.

ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжны албан тушаалд томилогдсон Х.Чойбалсан 1937 оны 11 дүгээр сарын 15-нд 221 тоот тушаал<sup>1</sup> гаргажээ. Энэ тушаал нь цэргийн удирдах бүрэлдэхүүнийг баривчилсан үйлдлээ зөвтгөх, уг үйлдлийнхээ хүрээг өргөтгөн улмаар цэргийн нийт бие бүрэлдэхүүнд тулган хүлээлгэх зорилготой бөгөөд “өөрийгөө илчлэх тушаал” гэж түүхэнд тэмдэглэгдсэн байдаг.

Уг тушаалын үзэл санаа нь ард түмний дайсан бий гэдэгт цэргийн албан хаагчдыг итгүүлэн үнэмшүүлэхийг зорьсны дээр “хувьсгалын эсэргүү бүлгэмийн удирдагч нар гол төлөв баригдсан тул бусад үлдэгдлүүдийг цөмийг барих” зорилт дэвшүүлсэн нь цаашид гэм зэмгүй олон зуун хүнийг хэлмэгдүүлэхэд хүргэсэн байна.

1 БХТА. Сх.1, Д.1 ХН. 334. Хуудас 613-617.

Энэ тушаалын дагуу 1937 оны 11 дүгээр сараас 1939 оны 5 дугаар сар хүртэлх жил хагасын хугацаанд 761 хүн<sup>2</sup> “биеэ илчилсэн” байна. Эдгээр хүмүүсийн дийлэнх олонхийг улс төрийн талаар найдваргүй хэмээн цэргийн албанаас халж дараа нь баривчилжээ. Энэхүү цэргийн албан хаагчдыг улс төрийн талаар найдваргүй хэмээн цэргээс халах явдал улам даамжирч 1938 оноос бүх цэргийн хэмжээнд цэвэрлэгээ явуулах болов.

Х.Чойбалсан 1938 оны 6 дугаар сарын 19-нд бүх нэгтгэл ангиудын удирдлагад хандаж 17 тоот албан захидал<sup>3</sup> гаргажээ. Энэхүү захидалдаа МАХЦ-ийн бие бүрэлдэхүүнээс улс төрийн талаар найдваргүй этгээдүүдийг зориуд урьдчилан судалж улмаар цэргийн албанаас халахыг мэдэгдсэн байна. Цэргийн албан хаагчдыг улс төрийн учир шалтгааны үүднээс үл итгэн халахдаа МАХЦ-ийн жагсаалд байгаа хар шар феодал, тайж, сүм хийдээс татагдсан лам нар, дотоод, гадаадын оргодол, эсэргүү бослогод идэвхтэй оролцогсод, эсэргүү нарын үр хүүхэд буюу ойрын харилцаа холбоо бүхий төрөл садангийн хүмүүс гэгчлэн элдэв нэр хаяг зүүж урьдчилан гаргасан нэрсийн жагсаалтаар халахыг зааварлажээ. Энэ захидлын дагуу МАХЦ-ийн эгнээнээс 1032 дарга, улс төрийн ажилтан, цэргийг халсан байна<sup>4</sup>.

Энэ л хандлагын дагуу Монгол оронд түүний дотор МАХЦ-т улс төрийн хэлмэгдүүлэлт 1940-өөд оны эцэс 1950-иад оны эхэн хүртэл үргэлжилжээ. Дээр дурдсан зүйлс бол улс төрийн хэлмэгдүүлэлт гарах болсон үндэс түүнийг зөвтгөн дэвэргэж байсан дотоод хүчин зүйлс юм. Улс төрийн хэлмэгдүүлэлтийн хор уршгаар тус улсын баглан хамгаалах хүч чадал ноцтой суларсан төдийгүй МАХЦ-ийн байлдах чадвар алдагдсан юм. Үүнийг 1939 онд болсон Халхын голын дайн тодорхой харуулав. Ялангуяа цэргийн боловсон хүчин их хохирол үзэж түүний хор уршгийг арилгахад олон жил зарцуулжээ.

ухайн үед ЗХУ өөрийн хил хязгаарт Японы цэргийг ойртуулахгүй байх, Японтой тэмцэж буй Хятад улсад улс төр, цэрэг, эдийн засгийн тусламж үзүүлэн ингэснээр түрэмгийллийн аюулыг өөрөөсөө холдуулах арга зам нь Монгол оронд өөрийн цэргийн хүчийг оруулж байрлуулах, тус орон дахь өөрийн нөлөөгөө алдахгүй улам бататгах явдал гэж үзэх болжээ. Энэхүү бодлого нь Монгол орны эрх баригчид, ялангуяа МАХЦ-ийн дээд удирдлагын үзэл бодол, байр суурьтай ямар нэг байдлаар зөрчилдөхөд хүргэсэн бөгөөд ЗХУ өөрийн бодлогоо ямар ч аргаар болов хэрэгжүүлэхийг зорьж байв. Энэ бүхний эцэст БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн ерөнхий сайд П.Гэндэнг албан тушаалаас нь огцруулж ЗХУ-д аваачиж шийтгэн цаазалсан бөгөөд ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжин Г.Дэмидийг ЗХУ-ын нутагт амь насыг нь хорлосон юм.

2 Монгол цэргийн түүхийн товчоон. Дэд дэвтэр. УБ., 1996. 268 дахь тал.

3 ЗХТА. Ф. 1, Д.1, ХН. 460. Хуудас 1-2.

4 Даваасүрэн Б. МАХН-аас цэргийн боловсон хүчин бэлтгэх талаар явуулсан бодлого, үйл ажиллагаа (1921-1940). УБ., 1990. 71 дэх тал.



Улс төрийн хэлмэгдүүлэлтэд хэлмэгдэгсдийн чухам хэд нь цэргийнхэн болох талаар нарийвчилсан тоог өнөө хэр үнэн зөв тогтоож чадаагүй бөгөөд түүх бичлэгт энэ талаар янз бүрээр дурдсан байдаг. Тухайлбал, цэргийн түүхч, доктор, Б.Даваасүрэн 840 гаруй<sup>5</sup>, доктор, профессор Д.Гомбосүрэн 1239<sup>6</sup>, А.Думбурай 790<sup>7</sup> гэж тогтоосон ба хэлмэгдэгсдийн судалгааны төв 550 гаруй, цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс 200 гаруй<sup>8</sup> цэргийн албан хаагч улс төрийн хилс хэргээр хэлмэгдсэн гэж үздэг байна.

Бидний хийсэн судалгааны явцад улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн байж болох 1500 гаруй цэргийн албан хаагчийн нэрсийг олж тогтоов. Гэвч цагаатгалын материалаас үзэхэд дээрх цэргийн албан хаагчдын тавь гаруй хувийг нь л цагаатгасан байх бөгөөд бусад нь цагаатгаагүй, шалгаж үзээгүй үлдсэн хүмүүсийн тоонд орсон байж болох талтай.

Өнөөгийн байдлаар холбогдох материалыг нь шалгаж цагаатгасан 802 цэргийн албан хаагч байна<sup>9</sup>. Эдгээр цэргийн албан хаагчдын албан тушаал, шийтгүүлсэн он, ял шийтгэлийн байдлыг авч үзвэл:

ЦЯЯ-ны сайд-1

Бүх цэргийн жанжин-2

ЦЯЯ-ны сайд бөгөөд Бүх цэргийн жанжны орлогч-5

Жанжин штабын дарга-2

Жанжин штабын орлогч дарга-2

Улс төрийн газрын дарга-4

Улс төрийн газрын даргын орлогч-2

Бүх цэргийн бэлтгэлийн газрын дарга-3

Бүх цэргийн бэлтгэлийн газрын даргын орлогч-2

ЦЯЯ-ны газрын дарга, орлогч түүнтэй адилтгах албан тушаалтан-35

ЦЯЯ-ны хэлтсийн дарга, орлогч түүнтэй адилтгах албан тушаалтан-37

Морьт корпусын дарга-3

Морьт корпусын штабын дарга, комиссар, бэлтгэлийн дарга-7

Морьт дивиз, хуягт бригадын дарга-16

Морьт дивизийн даргын орлогч, түүнтэй адилтгах албан тушаалтан -28

Хорооны дарга-25

Хорооны даргын орлогч-32

5 Даваасүрэн Б. МАХН-аас цэргийн боловсон хүчин бэлтгэх талаар явуулсан бодлого, үйл ажиллагаа. (1921-1940). УБ., 1990. 70 дахь тал.

6 Гомбосүрэн Д. Монгол улсын зэвсэгт хүчний байгуулалтын түүх (1921-1956). Тэргүүн дэвтэр. УБ., 1998, 143 дахь тал.

7 Думбурай А. Залхаан цэрлүүлэлт (БНМАУ-д 1930-1940-өөд онд болсон хэлмэгдүүлэлт) УБ., 1997. 9 дэх тал.

8 Ардын эрх сонин. 1998.03.19 №064.

9 Ганболд С. Хилсээр хэлмэгдсэн мянган зүрх. УБ., 2002.



Аймгийн цэргийн хэлтсийн дарга-8  
 Дивизионы дарга, түүнтэй адилтгах албан тушаалтан-14  
 Дивизионы даргын орлогч, түүнтэй адилтгах албан  
 тушаалтан-15  
 Хязгаарын цэргийн отрядын дарга- 6  
 Хязгаарын цэргийн отрядын даргын орлогч, түүнтэй адилтгах  
 албан тушаалтан-18  
 Хязгаарын цэргийн заставын дарга, орлогч-16  
 Сумангийн дарга, улс төрийн удирдагч, түүнтэй адилтгах албан  
 тушаалтан-63  
 Салааны дарга, түүнтэй адилтгах албан тушаалтан-55  
 Техникч, механикч-26  
 Бага дарга, түүнтэй адилтгах албан тушаалтан-34  
 Цэрэг-281  
 Хэлмэрч, орчуулагч-10  
 Хүн, малын эмч, санитар-18  
 Цэргийн академийн сонсогч -5  
 Цэргийн сургуулийн сурагч-8  
 Энгийн-19 хүн байна.

Шийтгүүлсэн оноор	<b>Ял шийтгэлийн байдлаар</b>
1922 онд 3 хүн	Цаазаар авах ялаар - 278хүн
1924 онд 1 хүн	25 жил хорих ялаар -1 хүн
1933 онд 66 хүн	15 жил хорих ялаар - 3 хүн
1934 онд 74 хүн	14 жил хорих ялаар - 2 хүн
1935 онд 4 хүн	12 жил хорих ялаар - 2 хүн
1936 онд 1 хүн	11 жил хорих ялаар - 2 хүн
1937 онд 91 хүн	10 жил хорих ялаар - 125 хүн
1938 онд 247 хүн	9 жил хорих ялаар - 2 хүн
1939 онд 226 хүн	8 жил хорих ялаар - 32 хүн
1940 онд 31 хүн	7 жил хорих ялаар - 18 хүн
1941 онд 22 хүн	6 жил хорих ялаар - 63 хүн
1942 онд 5 хүн	5 жил хорих ялаар - 63 хүн
1943 онд 3 хүн	4 жил хорих ялаар - 19 хүн
1945 онд 1 хүн	3 жил хорих ялаар - 19 хүн
1946 онд 1 хүн	2 жил хорих ялаар - 2 хүн
1948 онд 2 хүн	1 жил хорих ялаар - 2 хүн
1949 онд 22 хүн	Мөрдөн байцаагдаж байгаад
1950 онд 1 хүн	холбогдолгүй болж суллагдсан - 158
1966 онд 1 хүн	Хорихоос өөр төрлийн ял шийтгэлээр - 1
Мөрдөн байцаалтын явцад нас барсан – 5 хүн	
Нас барсан хойно нь нэр холбогдуулсан – 2 хүн	
Шийтгэл нь тодорхойгүй - 3 хүн байна.	

Улс төрийн хэлмэгдүүлэлтэд өнөөгийн генерал цолтой дүйцэх цол хүртсэн 78 дээд даргын 66 нь буюу 84,6 хувь нь хэлмэгдэж, ихэнх нь цаазлуулжээ. Хэлмэгдүүлэлтээр учирсан хор уршгийг доктор Б.Даваасүрэн “хувьсгалт хууль ёсыг ноцтойгоор зөрчсөн энэ балмад явдлын уршгаар БНМАУ батлан хамгаалах хүч чадал ноцтой суларч, цэргийн боловсон хүчинд хүнд цохилт болсон”, “асар их үнээр бэлтгэсэн цэргийн боловсон хүчин, цаашилбал үндэсний сэхээтэн бүрэлдэх процесст муугаар нөлөөлжээ”<sup>10</sup> хэмээн дүгнэжээ.

Улс төрийн хэлмэгдүүлэлтэд цэргийнхэн хэрхэн өртсөн талаар цэргийн түүхч, шинжлэх ухааны доктор Д.Гомбосүрэн олон арван бүтээл туурвисныг цохон тэмдэглэх ёстой юм. Тэрээр хэлмэгдүүлэлтийн уршгаар МАХЦ-ийн даргалах бүрэлдэхүүний 50 орчим хувийг устгасан буюу цэргийн албанаас зайлуулсныг тогтоогоод “Зөвлөлтийн улаан армид 1936-1937 онд нийт офицерын 6,9 хувь, 1938-1939 онд 2,3 хувь нь цэргийн албанаас зайлуулагдсан юм. Үүнтэй харьцуулахад МАХЦ-т учирсан хохирол улаан армийнхаас бараг 10 дахин илүү байна. Ийм хохирол үзсэн арми Сталины дарангуйллын үед Монголоос өөр хаана ч байхгүй”<sup>11</sup> гэж онцлон үзжээ. хэлмэгдүүлэлтийн зорилгыг “ЗСБНХУ-ын улс төр, эдийн засаг, цэргийн БНМАУ-д улам бэхжүүлэхэд оршиж байв” гэсэн дүгнэлт өгсөн байна.

Улс төрийн хэлмэгдүүлэлтийн чиг үзүүр нь цэргийнхэнд илүүтэй чиглэж ирснийг түүх бичлэгт тусгасан байдлаас авч үзвэл түүний дараах байдлаар тайлбарлаж болох мэт. Юуны өмнө 1937 оноос эхэлж дэгдээсэн хувьсгалын эсэргүү нэр хаягтай олон хэргийн томоохон нь “Гэндэн, Дэмидийн хувьсгалын эсэргүү байгууллагын” гэх нэртэй хэрэг байв. Хэлмэгдсэн цэргийн албан хаагчдын дийлэнх нь энэ хэрэгт холбогдсон байна. Дээрх эсэргүү байгууллагын толгойлогч Дэмид нь ЦЯЯ-ын сайд, Бүх цэргийн жанжин байсан учир МАХЦ-ийн бие бүрэлдэхүүн түүний хамсаатан төдийгүй гол түшиг тулгуураар тодорч байсан нь мэдээж.

Түүнээс гадна улс орон даяар өрнөсөн баривчилгааг тухайн үед цэргийнхэн дотор шүүмжлэн ярих явдал их гарч, Чойбалсанг Бүх цэргийн жанжны албан тушаалд томилсныг дээд, ахлах дарга нар төдий л талархан хүлээн аваагүй нь илэрхий байсан учир Дэмид жанжиныг нягт хүрээлж, хүндэтгэлтэй ханддаг байсан цэргийнхнийг хавтгайруулан баривчилж, замаа цэвэрлэх явдал шаардлагатай байснаас цэргийнхэн, түүний дотор даргалах бүрэлдэхүүн илүүтэй өртсөн гэж үзэж болно.

10 Даваасүрэн Б. МАХН-аас цэргийн боловсон хүчин бэлтгэх талаар явуулсан бодлого, үйл ажиллагаа. (1921-1940). УБ., 1990. 70 дахь тал.

11 Гомбосүрэн Д. Монгол улсын зэвсэгт хүчний байгуулалтын түүх (1921-1956). Тэргүүн дэвтэр. УБ., 1998, 143 дахь тал.

Түүх бичлэгийн тоймоос харахад МАХЦ-ийн бие бүрэлдэхүүнийг хэлмэгдүүлсэн үйл явц хэд хэдэн онцлогтой байна. Үүнд:

1. Цэргийн албан хаагчдыг хэлмэгдүүлэхдээ голчлон даргалах бүрэлдэхүүнийг хамруулжээ.

2. Хэлмэгдүүлэх процесс нь хувь хүн рүү чиглэсэн үйл явц байсан ч цэргийнхний хувьд хамт олноор нь хэлмэгдүүлж байв. Үүнд жишээ болгон Халхын дайнд 9 дүгээр сарын 11-ний өдрийн байлдаанд ухарсан хэргээр буруутсан 22 дугаар морьт хорооны дайчдыг нэрлэж болно.

3. Улс эх орны эрх чөлөө, тусгаар тогтнолын хувь заяаг шийдвэрлэх асуудал тулгараад байсан Халхын голын дайны үед ч цэргийнхэн хэлмэгдэлд өртсөөр байжээ. Байлдаж буй хороо, ангиудын удирдлагын талаас илүү хувь нь баригдаж шийтгүүлсний дээр дайны гал ид дүрэлзэж байсан 1939 оны 5-9 дүгээр сарын хугацаанд дарга нарын дутуу орон тоог нөхөх зорилгоор цэрэг, бага, дунд дарга нараас 940<sup>12</sup> хүнийг дэвшүүлэн томилсон нь хэлмэгдүүлэлтийн жилүүд дэх томилгооны дээд үзүүлэлт болсон.

4. Дэлхийн II дайн дуусч, энхийн цаг ирээд байсан үед ч барилгын батальоны цэргүүдээс хэдэн арваар нь хэлмэгдүүлж байсан нь 1930-аас эхээр Өвөрмонгол руу дүрвэн гараад 1945 онд буцаж ирэгсдийн үр сад байсантай холбоотой хэрэг байв. 1940-өөд оны сүүлээр Зөвлөлтөд сурч байхдаа ЗХУ-ыг гүтгэн доромжилсон хэргээр ч цэргийнхэн хэлмэгдэж байв.

5. Улс төрийн хэлмэгдүүлэлтэд, цэргийнхэн 1922 оноос эхлэн 1930-аас 1940-өөд онд онд, бүр 1966 онд ч өртөн хэлмэгдэж байв. Намын эсрэг бүлгийн хэрэгт л гэхэд бидний сайн мэдэх доктор, профессор, хурандаа Д.Цэен багш агсан өртөж хэлмэгдэж байсан юм.

Эцэст нь дүгнэж хэлэхэд улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртсөн цэргийн алба хаагчдын судалгааг лавшруулах шаардлагатай байгаа бөгөөд үүнд судалгааны байгууллагуудын хамтын ажиллагаа нэн чухал байгааг онцлон тэмдэглэж байна.

12 Ганболд С. МАХЦ-ийн хэлмэгдүүлэлтийн асуудал түүх бичлэгт. Улс төрийн хэлмэгдүүлэлт цэргийн албан хаагчид. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ.,2008.

## МОНГОЛД 1930-ААД ОНЫ УЛС ТӨРИЙН ХЭЛМЭГДҮҮЛЭЛТИЙГ ХИЙХ НИЙГМИЙН СЭТГЭЛ ЗҮЙГ БЭЛДСЭН НЬ



*Д.Даашдулам  
Доктор (Ph.D), Профессор  
МУИС, ШУС, Түүхийн тэнхим*

Монголд улс төрийн хэлмэгдүүлэлт эхэлсэн 1920-иод оноос хойш даруй ер гаруй жил, 1930-аад оны хэлмэгдүүлэлтээс хойш наяд гаруй жил өнгөрчээ. 1930-аад оны их хэлмэгдүүлэлтэд гэм зэмгүй энгийн олон зуун, мянган иргэд итгэл үнэмшил, шашин шүтлэг, угсаа гарвал, үзэл баримтлал, нийгмийн байдал, өмч хөрөнгө, нас, хүйсээс үл хамаарч хувьсгалын эсэргүү, ангийн дайсан, японы тагнуул, урвасан этгээд хэмээн хилс хэрэгт холбогдон хийгээгүй хэргийнхээ төлөө, мэдэх ч үгүй, сонсоо ч үгүй хүмүүсийн хамсаатан болж, эх орноосоо урвасан эсэргүү этгээд гэх хилс хэргийг үүрч ихэнх нь цаазлуулсан байдаг.

Судлаачид 1930-аад оны хэлмэгдүүлэлт гарах болсон нөхцөл шалтгаан, хор уршиг, сургамжийн талаар 1990-ээд оноос хойш тасралтгүй 27 жилийн турш судалгааг хийсээр ирсэн, одоо ч хийсээр байна.

Энэхүү илтгэлдээ, 1930-1940 онд явагдсан улс төрийн хэлмэгдүүлэлт явагдах нийгмийн уур амьсгал, сэтгэл зүйг хэрхэн бэлдсэн талаар санал солилцохыг зорьлоо.

Монгол улс эртнээс нааш хоёр их гүрний дунд оршдог, хөгжлийн хувьд төдийлэн нөлөөтэй бус хэдий ч үеийн үед их гүрнүүдийн ашиг сонирхлыг татсаар ирсэн нь нууц бишээ. Хоёр хөршийн хувьд Монгол улс нь аль алинд ашигтай, бамбай бүсийн үүрэг гүйцэтгэх хэдий ч тэд, Монголын асуудлыг биднээс үл хамаарах зарчмаар шийдвэрлэдэг байлаа.

Энэ хүрээнд монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлт явагдсан бөгөөд гарах болсон шалтгааныг гадаад талаас илүү анзаарч харахыг хичээлээ. Хэлмэгдүүлэлтийг явуулахад гадаад, дотоод шалтгаанууд адилхан үүргийг гүйцэтгэсэн ч тухайн үед монголчууд хэлмэгдүүлэлтийг нийтээрээ эсэргүүцсэнгүй, хэсэг бүлгээрээ, ганц нэгээрээ эсэргүүцэж байсан тул хэлмэгдүүлэлтийг зогсоож чадаагүй, улам бүр өргөжсөөр баривчлагсадын дийлэнх нь алтан амиараа хохирсон.

Яагаад энэхүү эмгэнэлт байдалд хүрэв? Яагаад нийгмийн гол цөм зогсоож чадаагүй, Яагаад Х.Чойбалсангийн дарангуйллыг нийтээрээ хүлээн зөвшөөрөх болов? анхнаасаа энэхүү тогтолцоог хүлээн зөвшөөрсөн үү? гээд олон асуулт гарч байна. Энэ бүхэнд хариулахын тулд хэлмэгдүүлэлтэд нийгмийн сэтгэл зүйг хэрхэн үе, шаттай бэлтгэж хэрэгжүүлсэн талаар нийгмийг цочроосон том хэргүүдийг хаанаас хэн зохион байгуулсан болохыг холбон өгүүлье. Мөн хэлмэгдүүлэлтийг явуулахад олон түмэн цочирдохгүй, гайхахгүй, эргэлзэхгүй, харин ч баривчилгаа, ялын бодлогыг зөвтгөх маягтай, олноороо итгэн үнэмших олон үйл явдлуудыг ар араас нь үргэлжлүүлэн гаргаж, хамрах орон нутаг, хүмүүсийг бүрэн хамарчээ. Энэ бүхэн дотоод гэхээсээ гадаад нөхцөлтэй шууд уялдан гаднаас зохион байгуулагдаж, гадныхан шууд чиглүүлсэн бөгөөд түүнд нь монголчууд өөрсдөө ил, далдаар дэмжин хамжилцжээ.

1921 оны хувьсгалаас хойш ЗХУ, Коминтерний явуулсан бодлого монголыг ЗХУ-ын нөлөөнд бүрэн оруулахыг чухалчилсан.

Ялангуяа ЗХУ дээрх зорилго, байр сууриа Коминтерний нэрээр халхавчилж, Монголыг нөлөөндөө бүрэн оруулахыг зорьж байлаа. Тухайн үед бүс нутаг, Монголд нөлөөгөө тогтоохын тулд Япон, ЗХУ далдуур шаргуу өрсөлдөж, энэхүү тэмцэлд хэн хэндээ зай тавьж өгөхгүй нь тодорхой байлаа.

Зөвлөлтийн хувьд өөрийн давуу байдалдаа түшиглэн Монголыг дуулгавартай захирах, бүрэн хамаарах, японы хувьд өвөр монголоор дамжуулан ар монголд нөлөөгөө тогтоож, ЗХУ-ыг эзлэх түшиж газраа болгох давхар, давхар санаа олон жилийн уртад явсаар байлаа.

ЗХУ, 1920-оод оны дунд үеэс Монголын талаар явуулах бодлогоо Коминтернээр дамжуулан хэрэгжүүлэх болсон. Үүнийг өнгөц харвал асуудалд ЗХУ огт хамааралгүй мэт харагдавч үнэн бодит байдал дээр Коминтернийг БХК(б)Н шууд удирдан чиглүүлж, гишүүн орнуудад нөлөөлж байлаа.

Тухайн үед ЗХУ гадаад улсуудаар хүлээн зөвшөөрүүлэх идэвхтэй дипломат бодлого явуулж, хөрш ДИУ-тай үг хэлээ “ойлголцох” эхний үр дүнд хүрчээ. Тухайлбал, Хятад- Зөвлөлтийн хооронд 1924 оны

тавдугаар сарын 31-ний өдөр Бээжин хотноо “ЗСБНХУ ба ДИУ-ын хоорондын асуудлыг зохицуулах ерөнхий зарчмын тухай хэлэлцээр”<sup>1</sup> байгуулжээ. Зөвлөлт-Хятадын хоорондын харилцаа урагшлахад “монголын асуудал” чухалд тавигдсаар ирсэн бөгөөд ДИУ-тай үг хэлээ ойлголцохын тулд Монголыг золигт гаргаж, хариуд нь Дорнод Хятадын төмөр замыг өөртөө авч, Зөвлөлт засгийн газрыг Хятадаар хүлээн зөвшөөрүүлжээ.

Хэдийгээр, хэдхэн жилийн өмнө 1921 онд “Зөвлөлт Орос улс БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн боловч Монгол дахь Хятадын эрх мэдлийг цаасан дээр “онолын” хувьд зөвшөөрсөн хоёрдмол бодлого явуулсан”<sup>2</sup>

ЗХУ, Азид хувьсгалын онолыг түгээн дэлгэрүүлэх, нөлөөгөө өргөжүүлэхдээ малчин, ядуу ардууд хувьсгал хийсэн монголыг түших замаар хятад, өвөрмонгол, баргад хувьсгал хийхийн тулд асар их хөрөнгө, хүн хүчийг хаяж, дайчилж байлаа.

Гэвч энэ нь тийм амархан бүтэх ажил бус цаг ямагт хөрөнгө зарцуулах хирээр төдийлэн амжилт олохгүй байлаа. Харин ингэж их хөрөнгө, цаг хугацаа үрэхийн оронд нийтэд зориулагдсан “тоглолт” явуулах, түүгээр дамжуулан олон нийтийн оюун санааг өөрсдийн зорилгод ашиглах нь харьцангуй хямд, хурдан, найдвартай арга байсан. Үүний тулд хамгийн чухал бүс нутаг монгол, монголчуудын итгэл үнэмшлийг өөрт хандуулах, ялангуяа өвөр монголчуудын дунд асар идэвхтэйгээр нөлөө, байр сууриа тэлэх болсон Японыг аль болох хараар будах нь чухал байсан. Учир юу хэмээвэл, өвөр монголчуудаар дамжуулан ар монголд японы нөлөө тогтоох, өсгөх талаар маш их болгоомжилж байв. 1930-аад оны япон эх газар чиглэсэн бодлогуудыг хэрэгжүүлэх болсон нь үнэхээр бодит аюулыг хаана, хаанаа бий болгож байлаа.

Ийм нөхцөлд олон түмэнд япон, японы дайнч үзлийг буруутган, дайныг өдөөх, дайтахад тэд бэлэн мэтээр ойлгуулахыг оролдож байлаа. Үүний тулд олон зүйлийг хийснийг тоймлон хүргэхийн ялдамд тус бүрээр товчхон өгүүлье. Хамгийн анхны томоохон дуулиан бол “Танака меморандум байсан.

### **Танака меморандум**

“Танака меморандум” нь Японы 26 дахь Ерөнхий сайд Танакагийн нэрээр түүхэнд алдаршсан. “Танака меморандум”-ын талаар судалгаа хийсэн судлаачид уг баримт бичиг “байсан”, “байгаагүй” гэдэг дээр эсрэг, тэсрэг байр суурийг баримталсаар ирсэн. Энэ талаар цухасхан хөндөе.

1 Орос- Хятадын гэрээ, хэлэлцээрүүдийн эмхэтгэл., УБ., 2001., тал., 149-150

2 Ц.Пунцагноров., Оуэн Латтиморын БНМАУ-ын тусгаар тогтнол, Монгол –Америкийн харилцааны талаарх үзэл бодол.,





### Танака Гиичи (1864-1929)

“Танака меморандум”-ыг “байдаг” хэмээн үздэг судлаачид, Ерөнхий сайд Танакагаас Шёва Эзэн хаанд 1927 оны наймдугаар сарын 25-нд өргөн барьсан, **“Хятадад явуулах бодлогын мөрийн хөтөлбөр”** хэмээх бодлогын шинжтэй боловсруулсан баримт бичгийг “Танака меморандум” хэмээн тайлбарласаар иржээ.<sup>3</sup>


Харин, “Танака меморандум” гэж ерөөсөө байгаагүй хэмээн үздэг судлаачид, хэвлэгдэн нийтэд түгсэн “эх” болгон ашигладаг баримтыг “зохиомол”<sup>4</sup>, үйл явдлын өрнөлийг урьдчилан тааварлан бичсэн хэмээн тайлбарладаг.

### “Танака меморандум”

Тухайн үеийн Японы дипломаатууд Мацуока Ёсүке\*, Шигэмицү Маморү\*\* нар тайлбар хийхдээ, цэрэгтэй холбоотой хүмүүсийн бичсэн зүйлүүдийг өөрчлөн бичсэн байж болзошгүй хэмээн үзсэн байдаг.

Хамгийн сонирхолтой нь уг дуулиантай баримтын жинхэнэ эхийг одоо болтол олж үзсэн хүмүүс байдаггүй, Дэлхийн II дайн дууссаны дараа дайны гэмт хэрэгтнүүдийг шүүсэн Токиогийн олон улсын шүүх хурал дээр, “Танака меморандум” -ын талаар нухацтай хэлэлцээд ч олж үзэж чадаагүй аж.

Нийтэд түгсэн баримтын гол агуулга нь Манжуур Монгол, түүний эргэн тойрон дахь төмөр зам, нутаг орны ард түмнийг хамгаалах, төмөр зам, худалдаа зэрэгтэй холбоотой “Манжуур Монголд явуулах идэвхтэй бодлого”, “Дотоод, Гадаад Монголд явуулах бодлого”,



3 Хироаки Мацүи, Д.Дашдулам, “Танака меморандум” – ыг судлах нь: Үнэний эрэлд., Монгол-Японы харилцаа: Өнгөрсөн ба эдүгээ (XX зуун), олон улсын элш хурал., 2010.09.09-11

4 Iris Chang., The Rape of Nanking., p. 178

\* Мацуока Ёсүкэ (1880-1946) улс төрч, Гадаад хэрийн сайдыг албыг (1940.07.22-1941.07.18) хашиж байсан.

\*\* Шигэмицү Маморү (1887-1957) улс төрч, Гадаад хэрийн сайдыг албыг (1943.04.20-04.07.1945, 1945.08.17- 1945.09.15, 1954.12.10-1956.12.23) хашсан.



“Манжуур Монгол бол Хятадын газар нутаг биш”, “Солонгос иргэдийн цагаачлалыг хөхүүлэн дэмжих”, “Эх газрын бодлого ба Манжуур Монголын төмөр зам”, “Эмнэлэг, сургуулийг бие даасан менежменттэй болгох”, “Манжуур Монголын соёлын баталгаа”, “Манжуур дахь худалдааны бодлого”, “Кицүкай төмөр зам” зэрэг нийт 21 бүлэгтэй.<sup>5</sup>

Уг баримтыг яагаад Ерөнхий сайд Танакагийн нэртэй холбох болов? гэх асуулт зайлшгүй гарна. Хамгийн амархан, энгийн өнгөц, хялбаршуулсан гаргалгаа бол тухайн үед Танака нь Ерөнхий сайд учраас Эзэн хаанд өргөн барьсан байх магадлалтай. Ингэж үзэхэд хүргэсэн гол зүйл бол түүнийг нийгэд түгэхээс өмнө Японы Токио хотод “Дорнодын хурал”<sup>6</sup> (1927.06.27- 07.07) хуралдсан. Уг хурлаас гарах шийдвэрийг Төв, зүүн хойд Азид нөлөөлөл, ашиг сонирхол бүхий бүх улсууд онцгойлон анхаарч байлаа.

Учир нь Хятадад “нээлттэй хаалга”-ны бодлого хэрэгжиж, их гүрнүүд идэвхтэй бодлого явуулах болсон тул Японы хувьд их гүрнүүдтэй өрсөлдөн Хятад дахь нөлөөллөө хэвээр хадгалан үлдэхийн тулд Шидэхарагийн “зөөлөн”<sup>7</sup> бодлого дуусгавар болж, Танакагийн “хатуу” бодлогод шилжих нь зайлшгүй, тодорхой байлаа.

“Дорнодын хурал” хуралдахын өмнө, дараа нь хурлын агуулгыг тусгасан зүйлийг Хятадын сонин, хэвлэлд “Танакагийн өргөн айлтгах бичиг” гэсэн гарчигтайгаар хэд, хэдэн удаа хэвлэн гаргасан. Хожим нь товхимол болгон гаргаснаар дэлхий нийт, ялангуяа хятад, ЗХУ, монгол улсууд японы түрэмгийлэл азид тэр дундаа монгол, хятадыг “залгина” хэмээх сурталыг Коминтернээр дамжуулан оросын тал идэвхийлэн хийх болжээ.

Энэ санаагаа Коминтерний хурал, гишүүн улсуудад тараагдах бодлогын шинжтэй баримт бичгүүдэд дээрх санааг нэвт шингээж, гишүүн улсуудад нөлөөлөхийг зорьж байв. Бусад намуудыг бодвол Монголд Коминтерний нөлөө аажим, аажмаар өргөжин түгж, Коминтернээс ирүүлэх бодлого, чиглэлийг зарчмын хувьд МАН дэмжин, дагадаг байлаа.

Тухайн үед Зөвлөлт, Хятадын аль, аль нь Японы бодлогыг сөрөх, зогсоох бэлтгэл хангагдаагүй тул японыг харлуулах хирээр өөрийн аюулгүй байдлыг хангаж, цаг хожиж байлаа. Зөвлөлтийн аюулгүй байдлыг хангах найдвартай ар тал бол буфер улс Монголоос өөр хэн ч, зөвхөн монголчууд байсан.

1920 оны дунд үеэс эхлэн ЗХУ-ын стратегийн сонирхол илт давамгайлан, Хятадтай харилцах харилцаагаа харилцан ашигтайгаар идэвхжүүлсэний дүнд Монголыг нөлөөндөө бүрэн оруулахын тулд бүх хүчээ дайчилсан.

5 Iris Chang., *The Rape of Nanking.*, p. 178

6 William Fitch Morton., *Tanaka Giichi and Japan's China policy.*, p. 96

7 Sadako Ogato., *Defiance in Manchuria: The making of Japanese foreign policy.*, 1931-1932., p. 7

ЗХУ, тусгаар тогтнол нь дээсэн дөрөөн дээр яваа Монголыг нөлөөндөө оруулахын тулд гадны аюулаар айлган олон түмнийг итгэж үнэмштэл, зөв бурууг ялгахын аргагүй болтол сэтгэл зүйн довтолгоо хийж эхэлсэн.

1930-аад онд япончууд Азийн улсууд руу хаа сайгүй түрэмгийлэн довтолж, манай улстай хиллэх болсон нь бүр ч үнэмшилтэй болгожээ.

### **“1932 оны бослого” олон түмний сэтгэл зүйд нөлөөлсөн нь**

Зүүнтэнүүдийн явуулсан нийгэм, эдийн засгийн бодлого улс орныг гүнзгий хямралд хүргэж, олон түмний сэтгэл санааг тогтворгүй, айдастай, төр, засагтаа итгэх итгэлийг алдагдуулсан. Бослого оролцогчид төр засгийнхаа эсрэг анх удаа зэвсэг барин тэмцсэн. 1990-ээд оноос өмнө уг эсэргүүцлийг түүх бичлэгт “Хувьсгалын эсэргүү лам нарын бослого” гэж ярьж, бичиж, нийгэм ч тэр утгаар нь хэвшсэн ойлголттой байсан. Тиймээс ч олон нийт “эсэргүү” бослого байсан хэмээн хүлээн зөвшөөрч, итгэхийн хамт оролцогчдыг “эсэргүүчүүд”, “гэмт хэрэгтэн”, “ардын дайсан” хамгийн муу хүмүүс мэтээр үзэж, энэ ойлголт, хандлага зарим талаар одоо ч байсаар байна. Гэхдээ нийт оролцогчдын хэрэгт оролцсон байдлаар ялгавартай хандаж, хэргийн шинж, нийгэмд учруулсан хорт байдлаар нь төрийн эсрэг гэмт хэрэгтэн үү? аль эсвэл хүчинд автан бослогод оролцсон уу? Хор хөнөөлтэй юу хийв? зэргийг нарийн тогтоож, зарим нэгийг нь цагаатгах асуудал ч яригдах цаг нь болсон болов уу? Бослогын учир шалтгаан, нэр томъёоны талаар хөндөх зорилго тавиагүй гагцхүү зэвсэгт бослого нь хэлмэгдүүлэлтэд олон түмний сэтгэл зүйг бэлдэхэд чухал хүчин зүйл болсон.

Бослогыг “хувьсгалын эсэргүү бослого” хэмээн зөвхөн нэг талаас үзэж, тайлбарласаар ирсэн нь асуудлыг бүрхэгдүүлэн хэвшмэл ойлголтоос гарч чадахгүй байсаар олон түмний сэтгэл зүйд тэр утгаараа хоногшсон. Нөгөө талаар, зэвсэгт бослогод оролцогчид хоршоо, эмнэлэг, сургуулийг шатаах, нам, эвлэлийн гишүүдийг онцгойлон харгислаж тамлан алсан балмад авир, үйлдэл нь ингэж ойлгоход хүргэх нь аргагүй.

Зэвсэгт бослогыг дан ганц лам нарын бослого хэмээн үзвэл учир дутагдалтай, энгийн иргэд, лам хуврага, эмч, цэрэг, нам, эвлэлийн гишүүд, төр засгийн ажилтнууд гээд нийгмийн бүх давхаргынхан өргөн хүрээтэй оролцсон. Бослогод намын их хурлын төлөөлөгч, бага хурлын гишүүн оролцсон тул массын сэтгэл зүйг алдагдуулахгүй, хувьсгалын үнэлэмжийг олон түмний дунд бууруулахгүйн тулд “лам нарын эсэргүү бослого” хэмээн нэрлэжээ.

Нөгөө талаар, нийгмийн хямралт, зөрчилт байдлын бүх буруу, алдаа оноог зөвхөн Монголын лам нарт хамаатуулах оросуудын хэрэгцээ, шаардлага байсан учир “лам нар”-ын хэмээх тодотголыг авчээ.

Ардын засгаас олон арга хэмжээг хэрэгжүүлсэн хэдий ч монголчуудын амьдралд шашин шүтлэг, сүм хийд, лам нар урьдын адил нөлөөтэй хэвээр, нийт монголчуудын оюун санааны нэгдэл, төвлөрөл нь томхон хүрээ хийдийг тойрч бөөгнөрсөн хэвээр байсантай холбоотой болов уу.

Сүм хийд, лам нараар дамжсан өвөрмөц холбоонд “багш”, “шавь”-ийн барилдлага ихээхэн нөлөөтэй, хэдэн үе дамжин уламжлагдсаар ирсэн нь зөвлөлтийнхэнийг илтэд болгоомжлоход хүргэж, лам нарын нөлөөг бууруулах, тэднийг сулруулахын тулд хэд хэдэн үе шаттай бодлогыг хэрэгжүүлжээ.

Ямар ч нөхцөлд олон түмний сэтгэл зүйн шинэ дүр төрх, уур амьсгал бий болохдоо, тухайн цаг үеийн албан ёсны үзэл суртал, ердийн ухамсарын түвшин дэх сэтгэл зүйн өөрчлөлтүүдийн холбоо хамаарал, зөрчлөөр илэрдэг. Үүний тодорхой илрэл нь 1932 оны зэвсэгт бослого бөгөөд төр засгийн бодлого, шийдвэр болон шашин шүтэх наад захын эрх, эрх чөлөөнийхээ төлөө иргэд эвсэн нэгдэж тэмцсэн хэрэг байлаа.

Баримтаас үзэхэд, зэвсэгт бослогод оролцож, буудуулсан хүмүүсийн 55-60 хувь нь нам, эвлэлийн гишүүн байжээ. Уг тоон үзүүлэлтээс хэд хэдэн зүйлийг анзаарч болно.

Юуны өмнө нэгдүгээрт, бослогод оролцогсодын дийлэнх нь нам, эвлэлийн гишүүд байжээ. Хоёрдугаарт, бослогыг дарагсад тэдэнд илүү харгис, ширүүн хандсан. Гуравдугаарт, тэд нам засгийн бодлогыг хэрэгжүүлэхэд оролцож, гажуудлыг биеэрээ мэдэрсэн. Дөрөвдүгээрт, бослогод итгэл үнэмшилээрээ оролцсон нь дийлэнх нь байсан. Тавдугаарт, олон түмэнд сөрөг нөлөө үзүүлэхээс болгоомжлон ялын дээд хэмжээ буудан алах ялаар шийтгэсэн.

Бослогыг лам нартай холбон “эсэргүү” хэмээн тодотгосон нь олон хүнийг хамруулан шийтгэх шалтгаан, нөхцөл болж, лам нарыг ангийнх нь хувьд үзэн ядах, хавчих, үл итгэх улмаар иргэд хоорондоо дайсагнах сэтгэл зүй, хандлагыг олон түмэнд суулгасан.

Бослогоор нийгмийн ангиудын дунд үл итгэх байдлыг өдөөж, лам нарыг япон, хятадуудад урвах ангийн дайсан мэтээр харлуулсанаараа таван жилийн дараа буюу 1937 оноос лам нарыг үй олноор нь хядсан хэлмэгдүүлэлтэд бэлтгэн, нийтээр нь “гайхширалд” орохооргүйгээр нийгмийн сэтгэл зүйг бэлдсэн.

Монголчуудын оюун санааны хөгжилд томоохон үүрэгтэй явсаар ирсэн лам нарын буудан алсанаар лам нарыг бүрмөсөн устгах хууль, эрх зүйн үндсийг баталгаажуулсан. Нөгөө талаар багш ламаа урвагч, улс төрийн хэрэгтэн, өөдгүй этгээд болсныг харахаар олон зуун жилээр итгэж, биширч явсан хүмүүсийн итгэл бишрэл өөр зүйлд дагахдаа ч хялбар байсан нь ойлгомжтой.

### Монгол үндэстэн, “панмонголизм”-ын үзлийг нухчин дарсан нь: “Лхүмбийн хэрэг”

1930-аад он болж ирэхэд монгол, зөвлөлтийн хил хязгаар улам бүр түгшүүртэй ялангуяа монголын зүүн хил хязгаар тайван бус байлаа. Япончууд өвөр монголд улс төр, эдийн засаг, соёл боловсролын талаар идэвхтэй бодлого явуулж, зүүн хойд хятадыг эзлэн Манжго улсыг байгуулсан.



Манжго улс (1932-1945)

тул бүгдийг баривчлах, нутагтаа буцаах, эс бөгөөс бүгдийг далимдуулан устгах ёстой найдваргүйчүүд хэмээн үзэж байлаа.



МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн  
дарга Ж.Лхүмбэ (1902-1934)

Монголын зүүн хязгаарт япончууд идэвхтэй ажиллагаа явуулахын хирээр оросууд монголчуудад итгэх итгэл алга болсоор бүгдийг урвагч, дайсан хэмээн үзэж, монгол нутагт ирсэн буриадуудыг октябрын хувьсгалаас зугтсан урвагчид, цагаантанууд

Зохиомол хэрэгт олон хүнийг холбогдуулахад олны дунд нэр нөлөөтэй Ж.Лхүмбийг сонгосон нь ч учиртай. Магадгүй, өндөр алба хашдаг, нэр нөлөө бүхий Ж.Лхүмбэтэй холбохгүйгээр Октябрын хувьсгалаар дүрвэн гарсан олон буриадууд, “пан монголизм”-тай тэмцэж, олон түмнийг айдсаар хучиж, нийгмийг гүн цочролд оруулж чадахгүй

байсан. Зөвлөлтийн тал “Лхүмбийн хэрэг”-ээр нийгмийн сэтгэл зүйг эрчимтэй бэлдэн дасгаж, 1937 оны хэлмэгдүүлэлтийн суурь болгосон.

Уг хэргээр нийгмийн сэтгэл зүйд Монголын хаа сайгүй гадны тагнуулууд олноороо үйл ажиллагаа явуулдаг, япончууд цэрэглэн довтлоход бэлэн, тэдний түшиг бол буриадууд гэсэн ойлголтыг нийтэд байршуулсан.

Хамгийн гол нь энэ хэргээр халхавчлан нийт монгол үндэстэний нэгдэн нийлэх гэсэн хүсэл эрмэлзэлийг нухчин дарсан юм.

### **1937 оны зун болсон учир битүүлэг хэргүүд: Их хэлмэгдүүлэлт эхэлсэн нь**

1937 оны зуны долоо, наймдугаар сард учир битүүлэг, гэнэтийн хэд хэдэн ноцтой хэрэг ар араасаа гарчээ. Тухайлбал, ЗХУ-д амьдарч байсан БНМАУ-ын Ерөнхий сайд асан П.Гэндэнг долдугаар сарын 17-нд Сочид амарч байхад нь ЗХУ-ын ДХАК-аас баривчлан<sup>8</sup>, 1932 оноос японы байгуулсан тагнуулын байгууллагад элссэн” гэх мэдүүлгийг гаргуулан авчээ. Мөн ЗХУ-д ажиллаж, амьдарч байсан эрдэмтэн Ж.Цэвээнийг наймдугаар сарын 10-нд, мэргэн гүн Гомбожавыг наймдугаар сарын 11-нд баривчлан монгол угсаатны нэгдмэл хүчирхэг улс байгуулах гэсэн хэмээн үндсэрхэг үзэлтэн, Японы тагнуул болгон харлуулж, харгис хэрцгий аргаар мэдүүлэг гаргуулан авчээ. Нэгэнт санаснаараа мэдүүлэг гаргуулан авсан тул дараагийн өрнөл хоромхон зуур хуурай өвсөнд түймэр дэгдэх мэт хурдан өрнөв.

Долоо хоногийн дараа буюу наймдугаар сарын 19-нд Г.Дэмид жанжин Дорнод Сибирийн Тайга өртөөний орчим учир битүүлэг нас барсан. Түүний үхэл ч бас л учир битүүлэг, зөвлөлтийн талын санаачлагаар замаасаа тодорхой бус шалтгаанаар буцах, дахин ирэх хүсэлтийн дагуу ирж, явсан байдаг. Жанжин Г.Дэмидийн үхэл гэнэтийнх шигээ гэнэтийн зүйлүүдийг араасаа дагуулжээ.

Түүний үхэл харамсал гашуу дагуулж, тухайн үед өвчнөөр нас барсан гэхээсээ элдэв гайхсан, эргэлзсэн олны сэжиг таавар нилээд байсныг батлах мэт удалгүй Дэмид жанжин эсэргүүн болсон “тодорч” дараагийн үйл явдлын зангилааг улам нэмсэн аж.

Монголчууд болж буй үйл явдлыг ухаж, төнхөх сэхээгүй шахам байхад наймдугаар сарын 24-ны өдөр ЗХУ-ын БХЯ-ны орлогч сайд П.А.Смирнов, ДЯЯ-ны орлогч сайд М.П.Фриновский, ЗХУ-аас Монголд суух элчин сайд С.Н.Миронов нар Монголд гэнэт ирсэн. Түүнтэй зэрэгцээ шахам 1937 оны наймдугаар сарын 23-24-нд Монголын талын зөвшөөрөлгүйгээр зөвлөлтийн цэргийн ангиуд орж ирсэн байдаг.

8 Ш.Агваан, Х.Чойбалсан ба Дотоод явдлын яам., УБ., 1991., тал., 45



*П.А. Смирнов (1897-1939) С.Н. Миронов (1894-1940) М.П.Фриновский (1898-1940)*

1937 оны наймдугаар сарын 30-нд “Хуйвалдаан” хэмээх хувьсгалын эсэргүү хэрэгт холбогдолтой 115 хүний нэрсийн жагсаалтыг ДЯЯ-нд гардуулж, монголд хийх хэлмэгдүүлэлтийг албан ёсоор “захиалжээ”. Есдүгээр сарын 10-нд их баривчилгааг хотод эхлүүлж, монголын нийгмийн сор болсон хүмүүсийг баривчлан “хувьсгалын эсэргүү” японы тагнуулчид болгон мянга, мянган гэм, зэмгүй иргэдээ хэлмэгдүүлсэн юм.

Монголчуудын зүрхэнд хүрсэн айдас хүйдэст он жилүүд, харгислал, тамлал, мянга, мянган эх орончдыг хилс хэрэгт холбогдуулан хороохын тулд урт хугацаанд бодож боловсруулсан бодлого, түүнийг нь сэжиглэх тааварлах аргагүйгээр нийгмийн сэтгэл зүйг бага багаар бэлдсээр 1937 онтой золгосон.

Гадаад, дотоод шалтгаан бүрдсэн хэлмэгдүүлэлт 1937 оны есдүгээр сард Улаанбаатар хотоос эхэлж удалгүй орон даяар хийгдэж нийгмийн бүх төлөөлөл магадгүй үнэнч шударга байсныхаа төлөө “хэлмэгдэн” цаазлуулсан.

ЗХУ-ын Батлан хамгаалах ардын комиссараас 1937 оны есдүгээр сарын 4-нд 57-р онцгой корпусыг Монголд байгуулах шийдвэрийг гаргаж, тусгай эрхтэйгээр монголын засаг төрийн бодлогоос ангид оршиж, улс төрийн хилс хэрэгт нам төр, цэргийн удирдлагуудыг хууль бусаар баривчлан тамалж, зөвлөлтөд хүргүүлж байсан. Үүнийг нэг талаас тусгаар улсын дотоод хэрэгт гадны улс дураар дургиж байсан гэж үзэх ч нөгөө талаас монголын нийгэм тэр аяараа бусармаг, хууль бус ажиллагааг сөрөх нийгмийн сэтгэл зүй байхгүй болсоныг батлах мэт.

1937 оны аравдугаар сарын 2-нд Шүүх яамны сайд Г.Цэрэндорж, УБХ-ын гишүүн Д.Лувсаншарав, Х.Чойбалсан нар “ОБЭК”-ыг байгуулсанаар<sup>9</sup> зөвлөлтийн онцгой эрхт гурвал монгол хөрсөнд амилж, шүүхээс давуу эрхтэйгээр ял ноогдуулах болсон.

9 Ш.Агваан., Х.Чойбалсан ба Дотоод явдлын яам., УБ., 1991., тал., 31



## Дүгнэлт

1937 оны намраас их баривчилгаа эхэлж, Монголын нийгмийн бүх төлөөллийг улс төрийн хилс хэрэгт холбогдуулан баривчилж 1940-оод он хүртэл үргэлжилсэн. Монголд явагдсан улс төрийн хэлмэгдүүлэлт нь тухайн үед ЗХУ-д болсон хэлмэгдүүлэлтийн шууд загвар, зааварчилгаагаар хийгдсэн.

Хэлмэгдүүлэлтийг явуулахдаа нийгмийн сэтгэл зүйг урьдчилан бэлтгэж, дасгасан төдийгүй нийгэм бүхэлдээ японы тагнуул туршуул болсон, хажууд нь байсан мэтээр хүлээж авсан. Нэг ёсны “нөхөр”, “дайсан” гэх ойлголт адилхан болж, хүн хүндээ итгэх хамгийн эрхэм чанар монголчуудаас алслагдсан.

Хэлмэгдүүлэлтэд олон мянган хүмүүсийг хамруулахдаа нийгмийн хөрс суурь, сэтгэл зүйг олон жилийн өмнөөс бэлдсэн байх бөгөөд томоохон хэргүүдэд хамрах хүний тоо, газар нутаг улам бүр тэлж, олон түмний дунд хувьсгалын эсэргүү, японы тагнуул гэх хардлага, сэрдлэгийг бодит болгосон.

1937 оны хэлмэгдүүлэлт нь урьд өмнө гарсан улс төрийн хэлмэгдүүлэлтээс зорилго нь улам бүр харгис шинжтэй, нас, хүйс, шашин шүтлэг, үндэс язгуур, нийгмийн байдал, үзэл бодлоос үл хамааран хамрах хүрээний хувьд өргөн, цаг хугацааны хувьд олон жилийг хамарч, нийгэмд учруулсан оюун санаа, сэтгэл зүйн хувьд асар их хохирлыг учруулсан. Тэр дундаа монгол хүний зан төлвийг өөрчилөхөд нөлөөлсөн гуравдахь (эзэнт улсын дараах задрал, манжийн эрхшээлд байсан үе, их хэлмэгдүүлэлтийн үе) давтамж ч болсон хэмээн үзэж байна. Тиймээс өмнөх хэлмэгдүүлэлтүүдээс онцлон ялгаж, “их хэлмэгдүүлэлт”-ийн он жилүүд хэмээн үзэх саналтай байна.

1930-1940-өөд оны их хэлмэгдүүлэлт нь монголын нийгэмд хүн ам, удмын сан, соёл иргэншил, улс төр, эдийн засгийн бүх салбарт ноцтой урхаг учруулсан. Уламжлалт суурь хүмүүжил, сэтгэлгээг пролетарчилсан ёс суртахуунаар халсан. Аймхай, хувиа хичээх, аминчхан, долигонуур, бялдууч байдлыг хөхүүлэн дэмжсэн нь монгол хүний язгуур чанарыг алдуулахад хүргэсэн гурав дахь давалгаа болсон болов уу.

1930-40-өөд оны их хэлмэгдүүлэлтийн шуурганаар амь үрэгдсэн, амьд үлдсэн аль аль нь хувь хүн талаасаа нийгэм, эдийн засаг, сэтгэхүйн хувьд маш их хохирол амссан. Тэрхүү сэтгэлийн шархыг хэн ч юу ч эдгээж чадахгүй.



## УЛС ТӨРИЙН ХЭЛМЭГДҮҮЛЭЛТИЙГ ЭРГЭН ХАРЖ, ДҮГНЭН ШИНЖЛЭХ АЖЛЫН ЭХЛЭЛ ТАВИГДЖЭЭ.



*Даниел Шмюкин  
Доктор (Ph.D)  
Конрад-Аденауэр-Сан*

### Социалист нийгмийн үеийн Монгол оронд гарсан улс төрийн хэлмэгдүүлэлт

Монгол орон нь 70 гаруй жилийн турш социалист нийгмийн дарангуйлалд байж, энэ хугацаанд олон мянган хүн улс төрийн хэлмэгдүүлэлтийн золиос болсон гашуун түүхтэй. Өнөөгийн Монгол оронд түүхийн энэхүү цаг үеийг эргэн харж, дүгнэн шинжлэх ажлын эхний алхмууд нэгэнт хэрэгжиж эхлээд байна. Юуны өмнө улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн байр сууринаас харвал тодорхой ажлууд хийгджээ. Жишээлэхэд улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдэд зориулсан хөшөө дурсгал босгосон, тэдний дурсгалыг хүндэтгэх өдрийг тэмдэглэн өнгөрүүлдэг болсон, цаашилбал Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс ардчиллын үйл явц өрнөөд удаагүй байхад байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхэлсэн зэргийг дурдаж болох юм. Харин цаашид хийх шаардлагатай ажлууд, авч үзэх ёстой асуудлууд нэлээдгүй байна. Юун түүрүүн улс төрийн хэлмэгдүүлэлт болж өнгөрсөн түүхэн хугацааг хэт богиносгон авч үзэж байгаа асуудлыг эргэн харах ёстой. Үүнээс гадна гэмт үйлдлийн буруутан нь хэн байв гэдэг асуудал өнөөдрийг хүртэл хөндөгдөхгүй байсаар байна. Түүгээр ч үл барам тухайн үеийн эрхтэн дархтнуудыг дахин шүтсэн байдал өнөөг хүртэл хэвээр байгаа нь хачирхалтай. Энэхүү нийтлэлээр бид улс төрийн хэлмэгдүүлэлтэд хандаж буй дээрхи хандлагын цаад учир шалтгаан нь юунд байна, энэ нь Монгол оронд шинэ тутам үүсэн бий болсон ардчилсан нийгэмд ямар хор уршигтай байж болох вэ гэдэгт хариулт өгөхийг зорьлоо.<sup>1</sup>

<sup>1</sup> Тайлангийн ихээхэн хэсгийг Др. Проф. О. Багсайханы судалгааны ажилд үндэслэн бичсэн бөгөөд тайланд тусгагдсан мэдээллийг хянах, цэгцлэх ажилд тусалж үнэтэй хувь нэмэр оруулсанд талархсанаа илэрхийлж байна.

1924 онд Монгол Улсын шашин, төрийн тэргүүн Богд хаан таалал төгссөнөөр Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН) засгийн эрхийг гартаа авсан. 1921 онд өрнөсөн Ардын Хувьсгалын өмнөхөн үүсэн бий болсон тус нам нь тухайн жилдээ дэлхийн хоёр дахь социалист орон болох Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг зарлан тунхаглаж, энэ нь 1990 оны ардчилсан хувьсгал өрнөх хүртэл оршин тогтносон түүхтэй. Энэхүү 70 гаруй жил үргэлжилсэн коммунист дэглэмийн үед олон мянган иргэдийг улс төрийн хилс хэрэгт буруутган, улмаар цаазлан хороосон байдаг. Хилс хэрэгт холбогдон, цаазаар авахуулсан иргэдийн тоо ойролцоогоор 35.000<sup>2</sup>-аас 36.000<sup>3</sup> байсан гэж үзэж байгаа юм. Харин ямар нэг хэлбэрээр хэлмэгдүүлэлтэд өртсөн иргэдийн тоог судалгаан дээр үндэслэн 100.000 гаруй гэж тооцоолж байгаа ч үүнээс илүү олон тооны хүн улс төрийн хэргийн золиос болсон байх магадлалтай. Үүнээс үзэхэд 1930-аад оны үед 800.000 хүн амтай байсан Монгол оронд хэлмэгдүүлэлтэд өртөөгүй гэр бүл нэгээхэн бээр ч үгүй гэж дүгнэж болохоор байна.

Улс төрийн хэлмэгдүүлэлтийг үндсэндээ тэр чигээр нь тухайн үеийн Зөвлөлт Холбоот Улсаас (ЗХУ) удирдан, зохион байгуулж, үүнийгээ Монголын улс төрийн өндөр албан тушаалтнуудад дарамт үзүүлэх замаар хэрэгжүүлсэн<sup>4</sup>. Нэн ялангуяа ардын хувьсгалын анхны долоогийн нэг, МАХН-ын үүсгэн байгуулагч, Монгол Улсын ерөнхий сайд асан Х.Чойбалсан нь Сталины нөлөөнд хэт автсан байсан бол түүнийг залгамжилан засгийн эрхийг авсан Ю.Цэдэнбал мөн ялгаагүй Москвагай ойр дотно харьцаатай байж иржээ. Ийнхүү ЗХУ нь Монголд өөрийн нөлөөг улам бүр батжуулж, социалист төрийн тогтолцоог бий болгон, улмаар засгийн эрх мэдлийг байнга гартаа байлгахын тулд нийт нийгмийг хамарсан залхаан цээрлүүлэх ажиллагаа явуулсан юм.

Энэ нь 1922 онд Монгол Улсын анхны Ерөнхий сайд Д.Бодоог цаазаар авснаар эхэлсэн гэж үзэж болно. Энэ үеэс лам хувраг, сурвалжтан ноёд, улс төрийн зүтгэлтнүүдийг хилс хэрэгт буруутгах явдал ихэссэн хэдий ч 1937 онд Бүрэн эрхт онцгой комисс байгуулагдах хүртэл харьцангуй цөөн тооны хүн улс төрийн хилс хэрэгт буруутгагдан, яллан шийтгүүлсэн байдаг. Энэхүү комисс нь 1937 оны 9 сарын 10-нд байгуулагдан, Х. Чойбалсангаар даргалуулан 1939 оны 4 сарын 22-ыг хүртэл 51 удаа хуралдахдаа нийт 20.000 хүнд цаазаар авах ял, 5.000 илүү хүнд 5-10 жил шоронд хоригдох ял ногдуулж байжээ.

2 О. Батсайхан (2016 он): Монголд гарсан улс төрийн хэлмэгдэл: Дүгнэлт, сургамж; „Монгол болон ХБНГУ дахь улс төрийн хэлмэгдэгсдийн цагаатгал: дүгнэлт, сургамж, цаашид авах арга хэмжээнүүд“ сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал дээр тавьсан илтгэл, 2016 оны 4 сарын 25-ны өдөр.

3 Д. Дамбасүрэн (2016 он): Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах талаар төрөөс авч буй арга хэмжээ; „Монгол болон ХБНГУ дахь улс төрийн хэлмэгдэгсдийн цагаатгал: дүгнэлт, сургамж, цаашид авах арга хэмжээнүүд“ сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал дээр тавьсан илтгэл, 2016 оны 4 сарын 25-ны өдөр.

4 Баркманн, Удо (1999): Монгол Улсын түүх, Бонн хот, Бувиер хэвлэлийн газар, 325-р хуудас.

Улс төрийн хэлмэгдүүлэлтэд хамгийн ихээр өртсөн хүмүүс нь лам нар юм. 1930-аад оны сүүлчээр буюу улс төрийн хэлмэгдүүлэлт ид гаарч байх үед 18.700 тооны лам, хуврагыг баривчилан хорьж, тэднээс 17.000 гаруйг цаазлан хороосон<sup>5</sup> бөгөөд тэднээс үлдсэн хүмүүсийн хувь заяа хэрхсэн талаар өнөөдрийг хүртэл ямар нэгэн мэдээ баримт алга байна.

Тухайн үед нам, төрийн өндөр албан тушаал хашиж байсан, улс төрийн энэхүү үйл явцад хариуцлага хүлээх ёстой хүмүүс хүртэл өөрсдөө хилс хэрэгт холбогдон, албан тушаалаасаа огцорч, цаазлан хороогдсон, учир битүүлгээр алга болсон мэдээ баримт бий. Бүрэн эрхт онцгой комисс гэхэд л үйл ажиллагаа явуулж эхлээд удаагүй байхдаа улс төр, цэргийн нөлөө бүхий 14 хүнийг Японы тагнуул гэх шалтгаанаар цаазлан хороох шийдвэр гаргасан байдаг. Үнэндээ 1922-оос 1990 оны хооронд нам, төрийн дээд алба тушаал хашиж байсан нийт 33 хүний зөвхөн найм нь л улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртөөгүй юм<sup>6</sup>.

Үүний хажуугаар сурвалжтан ноёд, эрдэмтэн зохиолч, бичгийн хүмүүс, төрийн болон цэргийн албан хаагчид, залуучууд, тэр дундаа 1920-оод оны дунд үеэс Герман, Франц зэрэг орнуудад суралцаж байгаад дуудагдсан ирсэн оюутнууд гээд нийгэмд шинэлэг үзэл бодол бий болгох боломж бүхий чадварлаг хэсгийг мөн л хоморголон хилс хэрэгт буруутгаж байсан. Хилс хэрэгт зөвхөн эдгээр хүмүүсийг өөрсдийг нь буруутгаад зогссонүй, тэдгээрийн ар гэрийг хяхан хавчиж, нийгмээс тусгаарлан дарамтлан зовоож байлаа.

Энэхүү хэлмэгдүүлэлтийн дүйвээнд Монгол орны соёлын өв, үнэт зүйлс мөнхүү ихээхэн хэмжээгээр үрэгдэж сүйдсэн. Шашны сүм хийдийг нийтэд нь шахуу эвдлэн сүйтгэснээр Монгол урлагийн бүтээлүүд устан үгүй болсон. Улмаар нүүдэлчин өв уламжлалыг орхигдуулан, 1940-өөд оноос үндэсний бичиг үсгийг халж, крилл үсгийг хэрэглээнд нэвтрүүлсэн байдаг. Үүнээс хойш уйгаржин монгол бичгийг дахин хэрэглээнд нэвтрүүлэх гэсэн хэд хэдэн оролдлого бүтэлгүйтсэн юм.

### **Социалист нийгмийн үед хийгдсэн улс төрийн хэлмэгдүүлэлтийг эргэн харж, дүгнэн шинжлэх ажлууд**

1930-аад оны сүүлч буюу улс төрийн хэлмэгдүүлэлтийн ид үед улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн ард иргэдийн нэр хүндийг сэргээх ажлыг Х.Чойбалсан өөрийн биеэр эхлүүлсэн нь их хачирхалтай. Тэрээр 1939 онд цагаатгалын комисс байгуулах шийдвэр гаргаж, энэхүү комисс нь Дотоод явдлын яамны доод шатны байгууллагуудын алдаатай үйл ажиллагаанаас болж хилс хэрэгт буруутгагдсан 2015

5 Д. Дамбасүрэн (2016 он) – Тайлбар 3-ыг үз.

6 О. Батсайхан (2016 он) – Тайлбар 2-ыг үз.

хүний хэргийг хянан үзэж цагаатгаж байв. Үүний дараагийн жилүүдэд улс төрийн хэлмэгдүүлэлттэй холбоотой хэргийг шүүн таслах онцгой эрх бүхий цорын ганц байгууллага нь энэхүү цагаатгалын комисс байлаа.<sup>7</sup>

Харин Х.Чойбалсангийн үүрэг рольд шүүмжлэлтэй хандах хандлага 1956 онд хуралдсан Зөвлөлт Холбоот Улсын Коммунист Намын 20-р Их хурлаас хойш тодорхой илэрч гарч ирсэн. Н.С.Хрушев тус их хурлын үеэр болсон хаалттай хуралдаан дээр тавьсан илтгэлдээ Сталины буруутай үйлдлийг илчлэн, Сталиныг дахин шүтэх явдлыг халж хаях эхлэлийг тавьсан юм. Тус их хуралд Монголоос оролцсон төлөөлөгчид тухайн жилийнхээ дөрвөн сард МАХН-ын Их хурлыг зарлан хуралдуулж, 1952 онд таалал төгссөн Х.Чойбалсангийн баримталж байсан Сталиныг дахин шүтэх үзэл баримтлалыг хурцаар шүүмжилцгээсэн байдаг.

Энэхүү үйл явдлаас улбаалан Дотоод Явдлын Яамны дэргэд 1937-оос 1947 оны хооронд улс төрийн өндөр албан тушаал хашиж байсан хүмүүстэй холбогдох хэргийг дахин хянах үүрэг бүхий комисс байгуулж байв. Үүнээс хойш жилийн дараа, 1930-аад оны сүүлчээр улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийн хэргийг дахин хянан үүрэг бүхий комисс шинээр байгуулагдаж, нийт 294 хүний хэргийг цагаатгасан байна<sup>8</sup>.

Хэлмэгдүүлэлтэд гар бие оролцож байсан олон тооны хүмүүс тухайн үед төр засгийн, намын өндөр албан тушаалд байсан хийгээд, улс төрийн хилс хэрэгт буруутгах явдал нэгэнт дуусгавар болоогүй үе байсан тул эдгээр комиссуудын үйл ажиллагаа ихэд хязгаарлагдмал байдалтай байсаныг дурдах хэрэгтэй. Жишээлэхэд л Намын Төв хорооноос гаргасан шийдвэрийн дагуу комисс нь зөвхөн хар, шар феодал бус, энгийн ард иргэдийн хэргийг цагаатгах боломжтой байв. 1961 оны сүүлчээр комиссыг ахлан ажиллаж байсан Т.Гэндэн 600 хуудас бүхий томоохон хэмжээний тайланг Төв хороонд хүлээлгэн өгч байсан боловч төд удалгүй 1962 оны эхээр комиссын үйл ажиллагааг зогсоон, татан буулгах шийдвэр гарч, тус тайланг нууцалсан байдаг<sup>9</sup>.

Энэ үеэс хойш цагаатгалын ажлыг Дээд шүүх, Нийгмийг аюулаас хамгаалах яам хариуцах болсон. Цагаатгах ажлыг хариуцсан комисс дахин шинээр байгуулагдаж байсан хэдий ч, тус комисст зөвхөн 1930-аас 1940 оны хооронд хилс хэрэгт холбогдсон нам, төрийн өндөр албан тушаал хашиж байсан иргэдийн хэргийг хянан шалгах үүрэг ногдуулсан байна. Ийнхүү 1939-өөс 1989 оны хооронд нийтдээ ердөө л 2926 хүний хэргийг хянан үзэж цагаатгасан гэдгийг энд бас дурдах нь зүйтэй.<sup>10</sup>

7 О. Батсайханы илгээсэн цахилгаан шуудан.

8 О. Батсайхан (2016 он): – Тайлбар 2-ыг үз.

9 Тус тайланг 1999 онд хэсэгчилэн хэвлүүлсэн. Т.Гэндэн: Гурван түмэн амь, Улаанбаатар хот, 1999 он.

10 Д. Дамбасүрэн (2016 он) – Тайлбар 3-ийг үз.

Ю.Цэдэнбалыг засгийн эрхэнд байх хугацаанд улс төрийн хэлмэгдүүлэлт үргэлжилсээр ирсэн боловч хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийн тоо нэлэнхүйдээ буурсан, мөн хилс хэрэг гэдэг нь илт тодорхой харагдахааргүй хэргүүдийг таслан шүүсэн байдаг. 1964 оноос хойш «ард иргэдийг төөрөгдүүлсэн, намын үзэл бодлыг эсэргүүцсэн» гэх хэргээр олон тооны сэхээтнүүдийг мөрдөн байцааж, нутаг заан цөлж байв. Ийм маягаар хэрэгт татагдаж байсан хичнээн тооны хүн байж, эдгээр хүмүүсийн хувь заяа хэрхсэн, энэ хэрэгт буруутай этгээд хэн байв гэдэг асуултаудад өнөөг хүртэл хариултгүй байсаар байна. Х.Чойбалсангийн үед улс төрийн хэлмэгдүүлэлт болсныг олон нийтээр хүлээн зөвшөөрсөн хандлагатай байдаг бол 1950-аад оноос хойшх үеийн улс төрийн хилс хэрэгтэй холбогдох мэдээлэл тун ховор байна.

### **Ардчилсан хувьсгалын дараагаар**

Монгол оронд Ардчилсан хувьсгал өрнөхөөс хэдхэн жилийн өмнө ЗХУ-д өрнөсөн өөрчлөн байгуулалт буюу перестройкагийн нөлөөгөөр цагаатгалын ажил хариуцсан комисс дахин байгуулагдаж байсан хэдий ч социалист дэглэмийн үеийн хэлмэгдүүлэлтийг эргэн харах, дүгнэн шинжлэх бодит ажлууд үнэн хэрэг дээрээ ардчилсан хувьсгалын дараагаар эрчимтэй хийгдэж эхэлсэн.

Одоогийн ерөнхийлөгч Ц.Элбэгдорж тухайн үед Цагаатгах ажлыг зохион байгуулах улсын комиссын даргаар ажиллаж байхдаа санаачилснаар, Монгол Улсын Засгийн газар 1996 онд улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдээс албан ёсоор уучлал хүссэн. Тухайн жилдээ 9 дүгээр сарын 10-ны өдрийг улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр болгон тэмдэглэж байхаар шийдвэрлэсэн. Учир нь 1937 оны тус өдөр Бүрэн эрхт онцгой комисс байгуулагдаж байсан байна. Мөн энэ үед Улаанбаатар хотод улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалын музей үйл ажиллагаа явуулж эхэлсэн, 200 гаруй хөшөө дурсгал, суврага, дурсгалын самбар зэргийг Улаанбаатар хот, хөдөө орон нутаг болон Оросын Холбооны Улсын (ОХУ) Бутовод босгосон, гудамж талбайг улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн нэрээр нэрлэсэн, цаашилбал улс төрийн хэлмэгдүүлэлтийн тодорхой нэг түүхэн цаг үеийг харуулсан баримтат кино, урлагийн болон шинжлэх ухааны бүтээлүүд шинээр бий болсон гээд нэлээдгүй ажлууд хийгдсэн.

Улс төрийн хэлмэгдүүлэлтийг эргэн харж, дүгнэн шинжлэх ажлын хүрээнд төрийн зүгээс хийгдсэн нэг чухал алхам бол 1990 оны Ардчилсан хувьсгалын дараахан Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссыг байгуулсан явдал юм. Хуучин социалист хэмээгдэж байсан орнуудын дундаас Монголоос өөр оронд ижил төстэй үүрэг, үйл ажиллагаа бүхий байгууллага байхгүй болохыг энд тэмдэглэх нь зүйтэй.<sup>11</sup> Тус байгууллага нь 1922 оноос хойш улс төрийн

11 Акерт, Маркус (2013): „Монгол Сталины“ урт сүүдэр, „Цорихын шинэ сонин“-ийн нийтлэл, цахим

хэлмэгдүүлтэд өртсөн хүмүүсийн хэргийг дахин хянах үүрэгтэй үйл ажиллагаа явуулж байна. Ингэхдээ улс төрийн хилс хэрэгт буруутгагдсан иргэдэд 1998 онд батлагдсан Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн дагуу нөхөн төлбөр олгох асуудалд онцлон анхаарч ажилласан байна. Одоогийн байдлаар тус комиссоос хилс хэргээр хэлмэгдсэн 31.000 хүний хэргийг цагаатган, нэр хүндийг нь сэргээгээд байгаа нь албан ёсны тоогоор хилс хэрэгт хэлмэгдэгсдийн 90 гаруй хувийг цагаатган, нэр хүндийг нь сэргээсэн гэсэн үг юм.<sup>12</sup> Тус комисс нь цаазаар авахуулсан хүмүүсийн нэрсийг цуглуулан олон нийтэд хүргэсэн, хэлмэгдэгсдийн түүх, намтарыг хэвлэн нийтлүүлсэн, судалгааны ажлуудыг эрхлэн хэвлүүлсэн гээд улс төрийн хэлмэгдүүлэлтийн талаар олон тооны ажлыг хийж гүйцэтгэсэн хэдий ч мөн л 1937-оос 1939 оны хооронд болсон “Их хэлмэгдүүлэлт,-ийн үеийг түлхүү авч үзсэн байдал ажиглагддаг. Монгол Улсын Засгийн Газраас 1990-ээд оны эхээр ийнхүү дорвитой алхмуудыг хэрэгжүүлж байсан бол өнөөдөр улс төрийн хэлмэгдүүлэлтийг нэг бүрчлэн, нухацтай авч үзэж, дүн шинжилгээ хийх улс төрийн хүсэл зорилго байхгүй болсон гэж дүгнэж болохоор харагдаж байна.

#### **Улс төрийн хэлмэгдүүлэлтийг хянан үзэх, дүгнэн шинжлэх ажилд учирч буй асуудлууд**

Энэ ажилд учирч буй олон асуудлуудаас жишээлэн дурдахад Цагаатгалын комисс, судалгааны ажил эрхэлж буй байгууллага, хувь хүмүүсийн аль аль нь архивт хадгалагдан буй материалтай, тэр дундаа Ю.Цэдэнбалын засгийн эрх барьж байсан үеийн баримт бичигтэй танилцах боломжгүй байсаар байна. 1998 онд батлагдсан Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль нь өнөөгийн цагаатгалын комиссын үйл ажиллагааны эрх зүйн үндсэн бичиг баримт болж байгаа юм. Тус хууль нь анхандаа хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй байхаар төлөвлөгдөж байсныг энд дурдах хэрэгтэй. Тухайн үед МАХН-ын зүгээс хоёрдугаар бүрэлдэхүүн хэсгийг хасвал хуулийг дэмжинэ гэсэн байр суурьтай байснаас, Ардчилсан Нам уг саналыг хүлээн авч, улмаар хууль батлагдах нөхцөл бүрдэж байсан. Хуулийн хоёрдугаар хэсэгт одоогоороо МАХН-ын мэдэлд буй намын архивыг улсад шилжүүлэх тухай заалт багтаж байсан тул хууль батлагдсанаар улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн талаарх олон тооны архивын мэдээлэл улсын мэдэлд шилжихээр байв. Ийнхүү өнөөг хүртэл МАХН-ын архив, Тагнуулын газрын архив, ОХУ-ын холбогдох архивууд үүд хаалгаа бүрэн гүйцэд нээгээгүй байгааг дурдах нь зүйтэй юм. Үүнээс шалтгаалан улс төрийн хэлмэгдүүлэлтийг судлах судалгааны ажил гол төлөв 1940 оны эхэн хүртэлх материалууд дээр

хуудас : <http://www.nzz.ch/die-langen-schatten-des-mongolischen-stalin-1.18181453>. [Сүүлчийн удаа 2016 оны 12 сарын 12-ны өдөр татсан мэдээлэл]

12 Д. Дамбасүрэн (2016 он) – Тайлбар 3-ийг үз.



төвлөрч байна.

Нөгөө талаас улс төрийн хэлмэгдүүлэлтийг эргэн харах, дүгнэн шинжлэх ажилд гар бие оролцох гэсэн иргэдийн санал санаачилга ямар их бэрхшээлтэй тулгарч байгааг “Монголын Улс төрийн хэлмэгдэгсдийн холбоо,-ны үйл ажиллагааны жишээн дээр харж болох юм. Тус холбоо нь 1991 онд байгуулагдсан бөгөөд өнөөг хүртэл улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн ард иргэдийн сонирхлын төлөөлөл болж ирсэн. Холбооны гишүүдийн ихэнх нь улс төрийн хэлмэгдүүлэлтийг өөрийн биеэр амссан, эсвэл хамаатан садан нь улс төрийн хилс хэрэг буруутгагдаж байсан хүмүүс байдаг. Тус холбоо нь санхүүжилт байхгүйн улмаас улс төрийн хилс хэргүүдийн талаар бие даан судалгаа явуулах боломжгүй байсаар ирсэн байна. Тус байгууллага нь улс төрд оролцон, улс төрийн хэлмэгдүүлэлтийг “ард түмнийг хоморголон устгасан гэмт хэрэг буюу геноцид” байсныг албан ёсоор зөвшөөрүүлэх чиглэлээр илүү хүчин чармайлт гарган ажиллаж ирсэн бөгөөд орон даяар тэмдэглэн өнгөрүүлэх болсон улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн өдрийг илүү чухалчлан үзэх ёстой гэсэн байр суурьтай байдаг ажээ.

Үүний сацуу улс төрийн талаар хэлмэгдэгсдийн судалгааны төв хэмээх төрийн байгууллага байгуулагдан, үйл ажиллагаа явуулж эхэлсэн хэдий ч санхүүжилт байхгүй гэсэн албан ёсны үндэслэлээр хэдхэн жилийн дараа үйл ажиллагаа нь зогссон. Гэтэл тус байгууллага нь үйл ажиллагаа явуулах ахархан хугацаандаа 20.000 гаруй иргэдийн хэргийг хянан шалгаж, цагаатгалын ажилд үнэтэй хувь нэмэр оруулсыг дурдах зүйн хэрэг биз ээ. Одоогийн байдлаар тус төвд цөөн тооны эрдэмтэн, судлаачид үйл ажиллагааг нь үргэлжлэн явуулж байна.<sup>13</sup> Хэргийг нь хянан үзэж цагаатгагдсан иргэдийн тоо энэ үеэс эрс буурсан бөгөөд үүнийг даган нөхөх олговор бараг олгогдоогүй. Иймээс ч Засгийн Газар жил бүрийн тайландаа цагаатгалын нөхөх олговрын талаар ямар нэгэн өөрчлөлт гараагүй гэсэн тайлбарыг бичсээр өнөөдрийг хүрсэн байна.

Ийнхүү улс төрийн хэлмэгдүүлэлтийн талаар хувь хүн, иргэдийн зүгээс, мөн төрийн зүгээс эрдэм шинжилгээ, судалгааны чанартай, эсвэл энэхүү үйлдлийг дүгнэн шинжилсэн ямар нэг ажил хийгдэхгүй зогсонги байдалтай байна. 1998 оны цагаатгалын тухай хуулиар улс төрийн хэлмэгдүүлэлтийг эргэн харж, дүгнэн шинжлэх ажил дууссан гэж үзэх хандлага эндээс мөн ажиглагдаж байгаа юм.

Нэгэнт улс төрийн хэлмэгдүүлэлтийн талаар олон нийтийг хамарсан өргөн хүрээтэй маргаан хэлэлцүүлэг явуулж байгаагүй учир улс төрийн хэлмэгдүүлэлтийг эргэн харах, дүгнэн шинжлэх ажлыг зөвхөн хилс хэргээр буруутгагдсан, цаазлан хороогдсон иргэдийн нэр

13 О. Батсайхантай хийсэн ярилцлага (2016 оны 9 сарын 16-ны өдөр).



төрийг сэргээх, цагаатгах ажлаар хязгаарлан гэм буруутай этгээдүүд, гэмт үйлдлийн эзэд нь хэн байсан гэдэг асуудлыг орхигдуулсан. Мөн гэмт буруутай этгээдүүдийг шүүхэд татах, хариуцлага ногдуулах нь бүү хэл гэмт үйлдлийг буруушаан эсэргүүцсэн байдал байхгүй байсаар өнөөдрийг хүрчээ. Судлаачид гэхэд л гол төлөв хилс хэрэгт хэлмэгдэгсдэд анхаарлаа хандуулж, гэм буруутай этгээдүүдийн асуудлыг авч үзэхээс зайлсхийж ирсэн байна. Ихэнх хүмүүс улс төрийн хэлмэгдүүлэлтэд ЗХУ-ыг буруутгах хандлагатай байна. Гэтэл 1993 онд хүчин төгөлдөр болсон хоёр орны гэрээний дагуу ОХУ нь ЗХУ-ын үед Монголын ард иргэдэд учруулсан аливаа гэмт хэргийн буруутан болж хариуцлага хүлээхгүй хэмээн зохицуулсан байдаг ажээ.

### **Гүйцэд хийгдээгүй ажлын хор уршиг**

Олон нийтийн хувьд улс төрийн хэлмэгдүүлэлтийн талаар мэдээлэл олж авахад маш хүндрэлтэй байна. Үндэсний түүхийн музейд гэхэд л улс төрийн хэлмэгдүүлэлтийн талаар ганц шилэн хорго дүүрэн үзмэрээс өөр зүйл байхгүй байна. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалын музей нь Монгол Улсын ерөнхий сайд агсан Гэндэнгийн гэр музейд байрлах бөгөөд түүний үр ач нар үйл ажиллагааг нь хувиараа санхүүжүүлэн явуулж байна. Тус музей нь холбогдох төрийн байгууллагуудтай олон жил ярилцсаны үр дүнд музейн нурах шахсан байрыг засварлах шийдвэрт хүрч, 2017 оны сүүлч хүртэл үйл ажиллагаа нь түр зогссон. Харин музейн мэдээллийн цар хүрээ бага, музейг үзэхээр сонирхон очих хүмүүсийн тоо маш цөөн гэдгийг энд тэмдэглэх нь зүйтэй. Энэ болон бусад шалтгааны улмаас хүн амын дунд болж өнгөрсөн гэмт үйлдлийн талаар тодорхой мэдээлэл байхгүй хэвээр байна. Иймээс ч Монголчууд өнөөдрийг хүртэл коммунист нийгэмд ард иргэдийг хэлмэгдүүлэн, тэднийг болон хамаатан садныг нь зовлон шаналалд учруулсан гэм буруутай этгээдүүд хэн байв гэдгийг мэдэхгүй байсаар байгаа юм.

Монгол Улсын Засгийн Газраас энэ асуудал дээр хоёрдмол байр суурьтай байсаар ирсэн. Засгийн Газраас Улс төрийн хэлмэгдүүлэлтийн гол буруутнуудыг албан ёсоор зэмлэн буруушаахаас илүүтэйгээр тэднийг хайцаалан, „ЗХУ-ын гар хөл болсон эдгээр хүмүүс ийм үйлдэл хийхээс өөр аргагүй байсан“ хэмээн тэдний үйлдлийг зөвтгөх хандлагатай байна. Нэг талаас авч үзвэл 1990-ээд оны эхээр Сталин болон Лениний хөшөөг буулган, 2012 онд уг хөшөөг буулгасны 20 жилийн ойн баяраар Улаанбаатарын хотын дарга, нийслэлийн захирагч Э. Бат-Үүл Лениний баримталж байсан үзэл бодол нь 30.000 хүний үхлийн шалтгаан болсон, үүгээр ч түүний хөшөөг авч хаях бүрэн үндэслэлтэй хэмээн албан ёсны байр суурь илэрхийлж байсан хэдий ч нөгөө талаас авч үзвэл бусад коммунист удирдагчдын хөшөө дурсгал

олон арваараа нийслэл Улаанбаатар, хөдөө орон нутагт байсаар байгаа билээ. Х.Чойбалсанг “Монголын Сталин”, байсан гэж нэрийддэг ч өнөөдрийг хүртэл түүний хөшөө МУИС-ийн өмнө сүндэрлэн, түүний нэрээр нэрлэгдсэн аймгийн төв хүртэл байсаар байна<sup>14</sup>.

Ю.Цэдэнбалын талаарх ойлголт бүр ч дорой байгааг дурдах нь зүйтэй. 1984 онд албан тушаалаас огцорсон тэрбээр Оросод амьдарч байсан бөгөөд тухайн үеийн Орос оронд өрнөсөн өөрчлөн байгуулалт буюу перестройкагийн нөлөөгөөр шүүмжлэлд өртөж, 1988 онд намаас хөөгдөж, бүх цол хэргэмээ хураалгуулсан байдаг. Гэвч 1995 онд буюу түүнийг таалал төгссөнөөс хойш дөрвөн жилийн дараа энэхүү шийдвэрийг цуцалж, бүх хэргэм зэргийг буцаан олгохоор шийдвэрлэсэн байдаг. Мөн энэ үед Ю.Цэдэнбалд зориулсан хөшөөг Улсын Эрдмийн Театрын өмнө босгосон нь өнөөг хүртэл байсаар байна. Мөн Ю.Цэдэнбалын мэндэлсний 100 жилийн ойг Монгол Улсын Засгийн Газраас 2016 оны 9 сарын 17-нд албан ёсоор тэмдэглэн өнгөрүүлсэн<sup>15</sup>. Энэ үеэр Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийг түүний нэрэмжит болгон<sup>16</sup>, ОХУ-д амьдарч буй түүний хүүг албан ёсоор Монгол Улсын иргэний харьяалалтай болгон<sup>17</sup>, Үндэсний түүхийн музейд түүний тухай үзэсгэлэнг зохион байгуулж байлаа. Энэ үеэр Ю.Цэдэнбалын бий болгосон бүтээн байгуулалтыг тэнгэрт тултал магтсан атлаа<sup>18</sup>, улс төрийн хэлмэгдүүлэлтийн талаар огт дурдаагүй өнгөрсөн байдаг.

Засгийн газрын албан ёсны байр суурь нь Ю.Цэдэнбалын үүрэг ролийг ийнхүү сайшаасан шинжтэй, улс төрийн хэлмэгдүүлэлтийг эргэн харах, дүгнэн шинжлэх ажлыг бүрэн гүйцэд хэрэгжүүлээгүй, үүнээс улбаалан ул суурьтай бүрэн гүйцэд мэдээлэл байхгүйн улмаас коммунист нийгмийн талаар нэг мөр ойголт үгүй болсон төдийгүй, энэхүү нийгмийн талаар эерэг ойлголт бий болоход хүргэж байна. Жишээлэхэд Монгол оронд социалист ардчиллыг бүтээн босгосон, хэлмэгдүүлэлтийг эргэн харах, дүгнэн шинжлэх ажлыг эхлүүлсэн хүн нь Ю. Цэдэнбал байсан мэт ярьж бичигцгээх нь элбэг байна.

Энэ нь шинэ төдий оршин тогтнож буй ардчилсан нийгэмд маш хор уршигтай байх нь дамжиггүй. Учир нь Монгол талаас улс төрийн хэлмэгдүүлэлтийн буруутан хэн байв гэдгийг тогтоох, гэм буруутай

14 Х.Чойбалсангийн хөшөө Дорнод аймагт сүндэрлэлээ (2016 оны 7 сарын 19-ны өдөр). Дараах цахим хуудаснаас үзнэ үү: <http://www.newscom.mn/10012071>. [2016 оны 12 сарын 12-ны өдөр татсан мэдээлэл]

15 Ю.Цэдэнбалын мэндэлсний 100 жилийн ой (2016 оны 8 сарын 31-ны өдөр). Цахим хуудас: <https://www.news.mn/r/311300>. [2016 оны 12 сарын 12-ны өдөр татсан мэдээлэл]

16 Б. Амарсайхан (2016 он): Эрдэнэт үйлдвэрийг Ю.Цэдэнбалын нэрэмжит болголоо (2016 оны 9 сарын 22-ны өдөр). Цахим хуудас: <http://en.montsame.mn/politics/erdenet-plant-named-after-yutsedenbal>. [2016 оны 12 сарын 12-ны өдөр татсан мэдээлэл]

17 Б. Амарсайхан (2016 он): Цэдэнбалын хүүд иргэний үнэмлэхийг нь гардууллаа (2016 оны 9 сарын 22-ны өдөр). Цахим хуудас: <http://en.montsame.mn/politics/tsedenbals-son-given-new-passport-citizenship>. [2016 оны 12 сарын 12-ны өдөр татсан мэдээлэл]

18 Жишээлбэл „Who was Tsedenbal?” нийтлэлийг дурдаж болно. The Mongolian Observer сонин, 2016 оны 9 сарын 7-ны өдөр, дугаар 18 (43).

этгээдүүдийг яллан шийтгэхэд бэрхшээлтэй болно гэсэн үг юм. Тухайн үед эрх мэдлийг дангаараа атгаж байсан МАХН гэхэд л өнөөдөр МАН гэсэн нэртэйгээр УИХ-д төлөөлөлтэй үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна. Улс төрийн хэлмэгдүүлэлтэд тус намын оролцоо ямар байсныг одоог хүртэл тодорхой болгоогүй, нам нь өөрөө тухайн үеийн улс төрийн золиос байсан хэмээн өөрийн үүрэг ролийг хэт жижигрүүлэн үзэх хандлагатай байна. МАН-ын зүгээс улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдээс өнөөг хүртэл албан ёсоор уучлал хүсээгүй байдаг. Энэ нь тэдний үйл ажиллагаанд огтхон ч муугаар нөлөөлөөгүйг тус нам 1990 болон 1992 онуудад явагдсан УИХ-ын сонгуульд олонхийн саналыг авснаар харагдаж байгаа юм. Үүнээс хойш МАН нь сонгуульд удаа дараа ялалт байгуулж, Засгийн Газар байгуулах эрхтэй болж байсан төдийгүй тус намаас нэр дэвшсэн хүмүүс мөн л удаа дараалан ерөнхийлөгчөөр сонгогдсон байдаг. Өнөөдөр гэхэд л тус нам төр барьж байгаа билээ.

Улс төрийн хэлмэгдүүлэлтийг эргэн харах, дүгнэн шинжлэх үйл ажиллагаа ийнхүү бүрэн гүйцэд хэрэгжээгүйгээс ард түмний зүгээс ардчиллыг үнэлэх үнэлгээнд муугаар нөлөөлөх хор уршигтай. “Сант Марал” сангаас жил бүр эрхлэн гаргадаг Монголын нийгэм, улс төр, эдийн засгийн байдлын талаар олон нийтийн санал бодлын судалгааны мэдээллээс авч үзвэл 2016 онд судалгаанд оролцсон нийт иргэдийн 40 хувь нь ерөнхийлөгч сайн байвал олон нам байх шаардлагагүй гэж үзсэн байгаа бол судалгаанд оролцогчдын 30 хувь нь зарим тохиолдолд диктатур ардчилсан нийгмээс илүү гэж үзсэн байна<sup>19</sup>.

Иргэний нийгэм, судалгааны байгууллагаас хийгдэж байгаа соён гэгээрүүлэх ажлууд ард иргэдэд хүрч чадахгүй байгаа нь эндээс харагдаж байна. Коммунист дэглэмийн үед юу болж өнгөрсөн талаарх бодит мэдээлэл ард иргэдэд хүрэхгүй байгаагаас тухайн үед хэлмэгдүүлэлтийг биеээр амссан ахмадуудаас эхлүүлээд, боловсролын тогтолцоогоор дамжуулан мэдээлэл авах боломжтой залуучууд хүртэл аль аль нь энэ талаар огт мэдээлэлгүй, ойлголтгүй байсаар байна. Улмаар ихэнх хүмүүс улс төрийн хэлмэгдүүлэлт болсон гэдэгт үл итгэсэн байдалтай эсвэл энэ нь зөв зүйтэй алхам байсан гэсэн байр суурьтай байна.

### Дүгнэлт

Улс төрийн хэлмэгдүүлэлтийг эргэн харах, дүгнэн шинжлэх ажилд ардчилсан хувьсгал өрнөснөөс хойшх 27 жилийн хугацаанд нилээд ахиц гарчээ. Хэдий ийм ч олон тооны асуултууд хариултгүй хэвээр байна. Энэ дунд хамгийн чухал бөгөөд шийдэхэд хүндрэлтэй асуудал бол гэмт буруутан нь хэн байв, тэдэнд ямар хариуцлага хүлээлгэх

19 Судалгааны дүнг дараах цахим хуудаснаас үзнэ үү: <http://www.santmaral.org/en/publications>. [2016 оны 12 сарын 12-ны өдөр татсан мэдээлэл].


ёстой вэ гэсэн асуулт юм. Эдгээр асуултын хариуг олохын тулд цаашид судалгааны ажлыг эрчимжүүлэх, юуны өмнө архивт чөлөөтэй нэвтрэх боломж бий болгох шаардлага зүй ёсоор бий болж байгаа юм.

Ингэснээрээ хувь хүний, МАХН-ын, ЗХУ-ын зүгээс үйлдсэн гэм бурууг тогтоох боломжтой болно. Үүнтэй уялдуулан өнгөрсөн үеийн тухай олон нийтийг хамарсан нээлттэй ярилцлага явуулах хэрэгтэй юм. Үүгээр ардчилсан нийгмийн давуу талыг ард иргэдэд илүү сайн ойлгуулах боломж бий болно. Олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг удирдан зохион байгуулах ажлыг 1990 оны эсэргүүцлийн хөдөлгөөнөөс төрөн гарсан Ардчилсан нам хариуцаж болох юм. Өнөөг хүртэл МАХН-ын өнгөрсөн үеийн алдаа оноог шүүн хэлэлцэх, улс төрийн хэлмэгдүүлэлтийг дүгнэн шинжлэх ажлыг дорвитой хэрэгжүүлэх тал дээр Ардчилсан намын зүгээс алдаатай хандсан зүйлүүд байна. Ардчилсан нам засгийн эрхэнд байх үедээ дээрх ажлыг эрчимжүүлэх бүрэн боломжтой байсан. Жишээлэхэд тухайн үеийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссыг иргэний нийгмийн, хараат бус комисс болгон өөрчлөх бүрэн боломж байсан.

Тус комиссын үйл ажиллагаа, зохион байгуулалтын тал дээр Германд байдаг Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсын аюулаас хамгаалах яамны бичиг баримтыг хянан шалгах комиссын үйл ажиллагаанаас харж, жишээ авч болох талтай. Энэхүү байгууллагын тэргүүнээр ажиллаж байсан Роланд Ян байгууллагынхаа үйл ажиллагааны мөн чанарын тухайд “Бид бурангуй дэглэмийг илүү сайн ойлгох тусмаа ардчилалыг илүү сайн төлөвшүүлж чадна,”<sup>20</sup> гэж хэлсэн байдаг. Ардчилсан хувьсгал өрнөснөөс хойш даруй 27 жил өнгөрсөн ч энэ үг Монгол орны хувьд утгаа алдаагүй байна гэдгийг энд тэмдэглэмээр байна. Улс төрийн хэлмэгдүүлэлтийг эргэн харж, дүгнэн шинжлэх ажил дуусаагүй байна. Энэ ажлыг цаашид нийт нийгмийг хамруулан өргөн хэмжээний үйл явц болгон зохион байгуулах зайлшгүй шаардлага байна.

20 Хуучин БНАГУ-ын Улсыг аюулаас хамгаалах газрын баримт бичгүүдийг хянан шалгах асуудал хариуцсан холбооны ажилтан Роланд Яны цахим хуудас: [http://www.bstu.bund.de/DE/Home/home\\_node.html](http://www.bstu.bund.de/DE/Home/home_node.html). [2016 оны 12 сарын 12-ны өдөр татсан мэдээлэл].

## 1932 ОНЫ БОСЛОГЫГ БАНЧИН БОГД, ЁНЗОН ХАМБА ХОЁР УДИРДАЛЦСАН



*Б.Зинамидэр  
Судлаач*

Өвгөн судлаач би олон арван мянган монгол хүнийг хилс хэрэгт хэлмэгдүүлснийг цагаатгасанд баярлаж талархдаг хүний хувьд цагаатгалын ажлыг араасаа хууль завхруулсан, түүх гуйвуулсан алдаа мадаг дагуулаагүй, нэр хүндтэй ажил болгох, улсынхаа түүхийг үнэн зөв байлгах зорилгоор “1932 он”-ы бослогыг Банчин Богд Ёнзон Хамба хоёр удирдалцсан” гэдэг илтгэлийг 50 жилийн судалгаандаа тулгуурлан та бүхнээр хэлэлцүүлэхийг хүсэж байна.

Хэлмэгдэгчидээ, хэлмэгдээгүйчүүдээс ялгаж ойлгоцгооё. Бурхан шашны төв, Төвд улс 1438-1937 онуудад Банчин богдыг тодруулан залж, тэд хүн юм болохоор оноо, алдааг хослуулж ирсэн түүхтэй.

Илтгэлээ дотор нь хоёр ангилж, нэгдүгээрт, Банчин Богдын үйл ажиллагааны талаар, хоёрдугаарт, Ёнзон Хамба Лувсанхаймчигт холбогдох хэргийн тухай асуудлыг хөндөн өгүүлье.

Нэгдүгээрт, IX Банчин богд БНМАУ-д буянаас илүү нүгэл үйлдсэн баримтыг сөхье. 1923 оны 11 дүгээр сард Банчин богд бурхан шашны тэргүүн XIII Далай ламтайгаа (Далай лам нь Төвд тусгаар улс байх, Банчин богд Төвд Хятадын бүрэлдэхүүнд байх ёстой гэж марган) зөрчилдөж Лхасаас хөөгдөх үедээ БНМАУ-д ардын хувьсгал ялсанд дургүй байсан Ц.Лувсанхаймчиггаа татан авч Хятад, Өвөрмонголын нутгаар хэсүүчлэн, улмаар Япон улсад (нэг бус удаа Латтимор) уригдаж айлчлан найрамдаж, Чан Кай Ши-гээр цэрэг зэвсэг, төсөв мөнгөөр тэтгүүлж Нанжин хотод суурьшжээ.

1923 онд Дондогдулам хатан, 1924 онд VIII Богд Живзундамба таалал төгссөн учир Ёнзон Хамба Ц.Лувсанхаймчиг хамт байсан Банчин богдоос VIII богдын хойд дүрийг тодруулан залах нэмэгдэл

үүрэг авч, 1924 оны эцсээр БНМАУ-д ирж VIII богдын шарилыг занданшуулаад суурьшсан билээ.

Энэ үед ард олны дунд ихээр тархан яригдаж байсан зүйлсийн талаар цухас дурдая: 1868, 1882, 1889 онд Утайд Дэлхийн (Азийн) хаад, богд, хутагт, Далай лам тэргүүтэй 18 гэгээн, 81 шидтэн, 12 хэлмэрч цугларч гаргасан гурван гэрээ бичгийн талаар өгүүлэе. Түүнд Халх Монголд төмөр хулгана жил (1924)-ээс эхлэн усан бич жил (1932) хүртэл хойд зүгээс хүний дүрстэй шар нүүртэй хүмүүс ирж, Монголын цогт эрдэнийг булаан авна. Энэ үед лам хүн цэрэг, ноён нохой мэт, шашин ор төдий болно. Төмөр хонин жилийн сүүлч, усан бичин жилийн эхэнд Монголд их цусан байлдаан болно.

Энэ гэрээ бичгүүдийг үндэслэн 1925-1926 оны үед манай улсад Банчин богд зарлиг ирүүлжээ. Тус зарлигт “Олон төрөлхтөн хийгээд аливаа ном төгсгөсөн гуравдугаар монголчуудын нүглийн зовлонг арилгах”-ын тулд ухуулах бичгийг тараав гээд Монгол улсын нүглийн сав дүүрчээ. Хүмүүний үхдэл гуу суваг дүүрнэ, цус нь гол болж урсана. Зам байвч явах хүнгүй, гэр байвч суух хүнгүй, дээл байвч өмсөх хүнгүй ийм цаг болов. ...Цагаан морин жил (1990 оныг хэлсэн бололтой) цаг тэгширнэ. Монголчууд сүсэг бишрэлээ сайн хичээ гэсэн ухуулах бичгийг уншсан хүн хэвлээд тараа, сонссон хүн бусдад ярьвал санасан хэрэг бүтэж, нэгэн биеийн зовлон арилна, гэртээ дарагдуулбал муу болно гэсэн анхааруулгатайгаар тархаажээ.

Энэ нь монгол хүн бүхэн айдастай амьдрах буюу нүүж дүрвэх арга олж хайхад хүргэсэн юм. Тус гэрээ бичгийн мэргэ төлөг, зөгнөл тааврын зарим үйл явдал, хугацаа утгаараа тохирч байгаа бөгөөд 1868 оноос 60 жилийн дараа БНМАУ-д дайн бослого гаргаж ардын төрийг устгаж хаант засаг байгуулах зорилгод чиглэсэн нь шашны бурангуй бүдүүлэг ёс мөн.

Банчин богдын ийм зарлиг байсныг VIII богдын лүндэнгүүдийн дотроос Дугарсүрэнгийн цуглуулгаас авч хадгалсан хувь, Ц.Батбилэг бид хоёрын сурагласаар Хөвсгөл аймгийн Жаргалант сумын малчин ард Ч.Цэрэнбат, Ч.Лхамсүрэн нарынхаас 2004 онд олдсон зарлигийн хуулбараар түүнийг бичиг мэддэг хүмүүс нь уншиж өгдөг, хуулж бичдэг байснаар нотлож болно.

Банчин богд гэрээ бичгүүдэд итгэж түүнийг хэрэгжүүлэхэд анхаарч байсан бол VIII богд Жибзундамба лүндэн, айлдвартаа зарим утга санааг нь оруулж бичдэг байжээ. VIII богд Жибзундамба таалал болсноос хойш Монголын лам нарын тахиж шүтэх хүн нь IX Банчин богд, Гэлэгнамжил, ёнзон хамба Ц.Лувсанхаймчиг хоёр болов. Энэ талаар зарим жишээ дурдвал зохиолч Лха Дарьсүрэн “Монгол Монголоо егүүтгэхүй” нийтлэлдээ Монголын феодалууд Банчин



богд гэгээнтнээ айлтган гуйх нь: “Манай Халх Монголчууд хуучин хэвээрээ муж болон улс гэрийн найрамдлыг зузаатгах, эрхэм Дундад улсад дагасугай хэмээхээс гадна басхүү богд Банчин эрдэнэ гэгээнтэн таныг Халх Монголд урин залж, бүгдээрээ өглөгийн эзэн болцгоож үүрд тахиж сүсэглэхийг хүснэ” гэж бичжээ.

Угсаатны зүйч урадын Э.Булаг Монголын эсэргүүнүүд 1929 онд Банчин ламд захидал бичиж, “Монголоос Оросуудыг хөөж, Монголыг Хятадын нэгэн муж болгон нэгтгэх хүсэлтээ илэрхийлсэн. Тэд хойд хилээ оросуудыг буцаж ирэхээс хамгаалахын тулд Банчингээс цэрэг гуйж, Жавзандамба хутагтыг сэргээн залж, сүм хийдийн тогтолцоог хуучнаар нь сэргээн хэмээн амласан”<sup>1</sup> гэж Английн түүхч, доктор Боуден<sup>2</sup> “Монголын орчин үеийн түүх” номдоо бичсэнийг эш болгожээ. Бас Банчин богд Монгол дахь хуйвалдагч лам нарт хариу өгсөн бөгөөд “1932 онд баруун нутагт эсэргүү хөдөлгөөн хийх, түүнийг удирдах хүмүүсийн нэрийг заасан тусгай зөвшөөрөл өгсөн, мөн намар Монголд биеэрээ морилж ардын хувьсгалыг дарах амлалт өгчээ”<sup>3</sup> гэж мөн эш татжээ.

Банчин богд бослогыг “Шашнаа хамгаалах уриа”-тайгаар 1932 оны зуны эхэн сард буюу 6 дугаар сарын 15-нд “Шамбалын дайн”-ыг гаргахыг даалгасан боловч бослогын зарим удирдагч нь баривчлагдсан тул ёнзон хамба яаравчлан зөвшөөрөл өгч 4 дүгээр сард эхлүүлснийг мэдэж байсан Банчин богд энэ өдрөө тохиолдуулан БНМАУ-ын хилийн ойролцоо Баруун сөнөд дээр 9 машинтай 200-гаад цэрэгтэй (үүнээс урвасан монгол цэрэг 15) ирж гурван давхар хамгаалалттай<sup>4</sup>-гаар БНМАУ-ын хилийн зүг хэд хэдэн их буу чиглүүлэн зоож хэд хоног тандаад буцсан нь түүний оролцооны нэг нотолгоо мөн. Тухайлбал, Банчин богдоос бослогыг 6-9-р сард гаргах төлөвлөгөөтэй байв.

Банчин богд XIII Далай лам Түвдэнжамц таалал төгссөнөөр далимдуулан, 1934 онд түүний дүрээр өөрөө тодорч залгамжлахыг санаархаж байхад нь БНМАУ саад болсон төдийгүй монголын IX богдоор тодруулж залахыг хүссэн хятадын Тай Сугийн саналыг дэмжээгүйд ихэд дургүйцдэг байжээ. Банчин богд БНМАУ-ын талаар эсрэг бодлого явуулж байсныг гадаадын хэвлэлд бичсээр, эсэргүү бослогын толгойлогчид гэрчлэн мэдүүлж баталгаажсан атал 1990 оноос 1932 эсэргүү бослогод гадаадын удирдлага нөлөө байгаагүй гэж УДШ, УЕПГ-аас дүгнэсэн нь түүх завхруулсан асуудал мөн.

Эсэргүү бослого гаргах талаар Банчин богдын холбогдолтой 5 захидал, нэг зам явах, хэрэгтнүүдийн мэдүүлгээс өөр материал ДЯЯ-нд байдаггүйгээс үзвэл 1932, 1937 оны эсэргүү бослогод Банчин богд

1 Урадын Э.Булаг. Хамтач үндэсний үзэл. УБ., 2015. т. 114.

2 Bawden C.R. The modern history of Mongolia. Лондон., 1989.

3 мөн тэнд, т. 317.

4 ТЕГ-ын тусгай архив. х.1, д-ДХТ, хн.74.



ямарч нөлөө оролцоогүй мэт боловч эсэргүү бослоготой холбоотой Банчин богдын зарлиг зааврыг дэд ангийн лам нар маш сайн нууцалж чаддаг байсантай уялдуулан авч үзэх ёстой.

Ялангуяа тэд харилцаагаа бурхан шашны шүтлэгтэй холбон халхавчилж булзааруулдаг, захидал зааврыг нь уншаад шатаадаг, авчирсан буцсан хүн илэрч баривчлагдаагүй, нууц асуудлыг итгэмжлэх захидалтай амаар хэлүүлдэг байсан зэрэг нь илэрхий ажиглагддаг.

1929-1933 онд Банчин богд БНМАУ-ын дархан хилийг урвагч “халзан” Дорж, “хувилгаан” Занабазар, лам Ням, Далай, тагнуул “цорж” Содовоор удаа дараа зөрчүүлэн ёнзон хамба Лувсанхаймчиг, Гачин лам Рэгдэлбүрэлбүү Хөвсгөлийн “аграмба” Цэрэнжав “Дүвчин” Самбуу нарт захидал заавар ирүүлж, 1932 онд феодал лам нарын эсэргүү бослогыг өдөөн гаргуулжээ. Бүрэн бус тооцоогоор 6000 гаруй монгол хүний амь насыг бусниулж их хэмжээний өмч хөрөнгө сүйтгэж олон мянган айл өрхийг дүрвүүлж нүүлгэжээ.

Тус бослогын хохирлыг цэргийн түүхч С.Ганболд: “Халх голын дайнаас 25 дахин их, чөлөөлөх дайныхаас 600 дахин их байгаа бөгөөд улс төрийн хэлмэгдүүлэлтийн дараа орох хүн хүчний асар их хохирол юм. Хамгийн гол нь монголчууд өөр хоорондоо байлдаж бие биенээ хөнөөн устгаснаараа Монголын түүхэн дэх эмгэнэл гэж болно” хэмээн оновчтой дүгнэсэн юм. Харин их нүүдэл дүрвэлтийн хор хохирлыг тооцсон тоо баримт гараагүй байдаг. Бас Хөвсгөл аймгийн нэхэмжлэгч төлөөлөгч Даваа, Өвөрхангай, Завханд алагдсан хүмүүсийг оролцуулбал 6000-аар тогтохгүй нэг түм (10 000) хүрсэн гэж нэхэмжилж байв. Тэдний 2000 орчим хүн нь халимагтай эр, үсээ тайрсан эмэгтэй, албан байгууллагын галч шар цэрэгт явахгүй гэсэн хүмүүс хувьсгалчид тооцогдон 30 гаруй аргаар тамлагдан алагдсан хүмүүс байжээ. Бас олон мянган хүний амь насыг сүйтгэснээр барахгүй 20 000 шахам лам нарыг хэлмэгдүүлэх шалтгааныг үүсгэжээ.

1933 онд БНМАУ-ын Хил хязгаарын цэрэг байгуулагдсанаар 1931-1933 онд ёнзон хамбатай харилцаатай байсан тагнуул цорж Содов 1933 оны 8 дугаар сард Хилийн цэрэгт алагдаж, түүний өврөөс Өвөрмонголын нэг ноёноос ёнзон хамбын итгэмжлэх зурвасыг үзээд олгосон зам явах гарчээ. Эсэргүү бослого дарагдсанд сэтгэл нь ханаагүй Банчин богд 1936 оны 10 дугаар сард Батаа буюу Намжилдэндэв гэгч тагнуулыг Архангайн “аграмба” Чойжилсүрэнд ардын нам, засгийг устгуулах даалгавартай явуулсан нь биелэгдэхгүй байсаар 9 сарын дараа илэрч, бослогоос урьдчилан сэргийлж таслан зогсоогджээ. Банчин богд бол БНМАУ дахь буддын шашны мөхөлд хувь нэмэр оруулсан хүн билээ. Тэрбээр 1932 онд зэвсэгт бослого гаргуулж чадсан бол, 1936-1937 онд ахин гаргах гээд чадаагүй юм.

Хоёрдугаарт, Банчин Богдын түшиг тулгуур нь суурин тагнуул Ёнзон Хамба Ц.Лувсанхаймчиг байсныг товч өгүүлье. 1915 онд Банчин богдоос VIII богд Жибзундамбын номын багшаар Ц.Лувсанхаймчигийг томилох үедээ, 1.Сайн багш болох, 2.Монгол хэл сайн сурах, 3.Банчин богдын нэр хүндийг VIII богд шиг өндөр болгох, 4. Тагнуул сайн хийх үүрэг хүлээлгэж, дараа нь таван захидлаар нууц утгаар тагнуул сайн хийхийг сануулжээ.

1929 онд төвд голдуу 27 хүнтэй “Гандан бүлэг” байгуулсан Ёнзон Хамба, Ц.Лувсанхаймчиг эсэргүү бослогод бэлтгүүлэхээр 1931 онд Архангай аймагт Шаравыг, Хөвсгөлийн дархад нутагт 1931, 1936 онд З.Содовсамбууг явуулж байв. Ёнзон хамбаас Архангай, Хөвсгөл аймагт эсэргүү бослого бэлтгэх үүрэгтэй очсон О.Вандансүрэн 1932 оны эхээр бослогыг удирдахаар томилогдсон Цэрэнжав, Дамдин нар Хөвсгөл аймгийн дотоодыг хамгаалахад баривчлагдсан учир сандарч ёнзон хамбад 10 төгрөг, соном хадагтай өргөн барьж, бослогыг Банчин богдын заасан 6 дугаар сард гаргах гэвэл илэрч магадгүй тул яаралтай эхлэх зөвшөөрөл өгнө үү гэж гуйсан ёсоор эсэргүү бослого 1932 оны 4 дүгээр 12-нд Рашаантаас эхэлжээ. Гэвч баривчлагдагсад гэмт хэргээ нуусан, бослого яаравчлан эхэлснээс төр засаг бослогоос урьдчилан сэргийлэх, таслан зогсоох боломж алдагдсан байна.

1932 онд зэвсэгт бослого баруун аймгуудад үүсэн гарсан учир шалтгаан нь:

1. Банчин богдоос та нар баруун талыг эзэл. Би зүүн талын эзлэнэ гэсэн заавар.
2. Баруун аймагт хүрээ хийд, лам нар мухар сүсэгтэн олонтой нутаг.
3. Гадаадын цэрэг зэвсгийн хүчээр довтлоход алслагдсан зайтай нутаг.
4. Зүүн өмнө талын нутагт бослого гаргахаас илүү дүрвэх хөдөлгөөнд анхаарснаас тэнд томоохон бослого гараагүй.
5. Монголын феодалууд ялангуяа дээд ангийн лам нар БНМАУ-д дургүйцэж хятадын харьяаны улс байхыг хүсэж Банчин богдоос тусламж гуйсан зэрэг үйл явдал нөлөөлжээ.

Энэ бүхнийг үндэслэн БНМАУ-ын Дээд Шүүхийн 1933 оны 5 дугаар сард 39 хүнийг таслан шийтгэсэн хурлын тогтоолд: “Тус улсын доторх хувьсгалын эсэргүү хэсэг бүлэг лам нар ба феодал нар бол тус улсын дотор өөрийн хорт хувьсгалын эсэргүү ажил явуулгыг үргэлжлүүлэн хийхдээ Монголын хувьсгалын эсэргүү гадаад төв ба мөн Хятад Японы эзэрхэг түрэмгий нараас тус улсыг эзлэн авах явдалд ашиглагдаж буй Банчин ламын зэрэг этгээд нарт түшиглэхийг үргэлж бодолхийлсээр ирсэн нь илэрхий байна” гэж тэмдэглэжээ.

Хэрэв О.Вандансүрэн Ёнзон Хамбаас бослогод бэлтгэх даалгавар авснаа, бослого эхлүүлэх зөвшөөрөл авч эхлүүлснээ нуухгүй илчилсэн бол Ёнзон Хамба Банчин Богдын суурин тагнуул, эсэргүү бослогын нууц удирдагчаар холбогдох хүний нэг байсан юм.

Гэвч гэмт хэрэг хэзээ нэгэн цагт илэрдэг жамаар 1937 онд илэрч Ц.Лувсанхаймчиг гэмт үйлдлээ шударгаар хүлээсэн бөгөөд түүхэн үйл явдлууд нотлон баталгаажуулсан билээ. Ц.Лувсанхаймчиг 1924 онд буцаж ирэхдээ Банчингаас IX богдыг тодруулж залах нэмэгдэл үүрэг аваад өмнө өгсөн дөрвөн үүргээ сайн биелүүлж чадаагүйгээ мэдүүлжээ.

Үүнийг 1937 онд Ёнзон Хамба Ц.Лувсанхаймчиг Банчин Богдын тагнуулаар ажилласнаа, ДЯЯ-ны орчуулсан таван захидал зөв байсныг, О.Вандансүрэнд эсэргүү бослого эхлүүлэх зөвшөөрөл өгснөө, 1931-1933 онд цорж Содовоор тагнуулын нууц харилцаатай ажилласнаа, бослогыг биеэр удирдаагүй боловч бослогын толгойлогчид, салбар бүлгийн удирдлагуудтай харилцаатай ажиллаж байсныг үнэнч шударгаар, гадны ямар нэг дарамт шахалтгүйгээр хүлээсэн байдаг. Гэтэл УДШ 1990 оны 7 дугаар сарын 25-ны 07-р тогтоолдоо шинэ нөхцөл байдал илэрснээр эрүүгийн хэргийн ажиллагаа үүсгэж шалгасан материалаас үзэхэд ёнзон хамба Лувсанхаймчиг, дэд хамба Дамдин нарыг “Хууль ёсны нотлох баримтгүй нөхцөлд зөвхөн сэжиг таавраар ял өгч шийтгэл оногдуулсан нь үндэслэл муутай болжээ. Одоо хэргийн талаар нэмэлт ажиллагаа хийж шалгаж тодруулах боломжгүй болсон байдлыг харгалзан УЕП-ын эсэргүүцлийг үндэслэн БНМАУ-ын Дээд шүүх таслах газрын 1937 оны 10 дугаар сарын 7-ны 37-р тогтоолыг хүчингүй болгож, нэр бүхий 23 хүнд холбогдох хэргийг ЭБШХ-ийн 196-р зүйлийн 2-т заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож” нэр бүхий хүмүүсийг цагаатгажээ. Гэтэл Ц.Лувсанхаймчиг анхны мэдүүлгээсээ эхлээд Банчин богдод байнга, Английн Цэрэнд хааяа тагнуулын мэдээ өгч харилцаатай байснаа, 1929 онд ардын төр засгийн эсрэг төвд голдуу 26 хүнтэй “Гандан бүлэг” байгуулж ажилласнаа, дараа нь энэ бүлгээ нэр хүндтэй болгох зорилгоор дэд хамба Дамдин, цорж Чойнзон, Жанцан нарыг оролцуулснаа зааглан мэдүүлснээс үзэхэд Лувсанхаймчигийг цагаатгахгүйгээр бусдыг нь цагаатгасан бол зөв болох байжээ гэж үздэг юм.

Харин Ц.Лувсанхаймчиг бол Банчин богдын удирдлага заавраар гадаадын тагнуул, бослогын толгойлогч нартай нууц харилцаатай удирдагч байсан нь 1933 онд ял шийтгүүлсэн хүмүүсийн мэдүүлэг, үйлдэл, ардуудын дурсамж, түүхэн үйл явдлаар судалгааны баримтаар нотлогдож Ц.Лувсанхаймчигийг тухайн үед ял шийтгүүлсэн нь зөв байсан нь тодорхой байдаг. Тиймээс 1990 оноос ардчилал халхавчаар элдэв туйлшрал гарч хууль завхрахад хүрч байгаад сэтгэл зовж,

хэдэн жилийн өмнөөс ёнзон хамба Ц.Лувсанхаймчигийн талаар ардын дурсамж яриаг сонсож архивт сууж, сонирхон судалсны хувьд түүнд шүүмжлэлтэй хандаж УДШ, УЕПГ-т санал бодлоо удаа дараа илэрхийлсэн юм. Миний энэ талаар бичсэн өргөдлийг МУДШ хүлээж аваад 2013 оны 9 дүгээр сарын 2-ны 2183 тоот бичгээр “... эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 359-р зүйлд заасны дагуу гомдлоо прокурорт гаргах нь зүйтэй” гэсэн хариу өгсөн тул 2013 оны 9 дүгээр сарын 17-нд УЕПГ-т хандсан юм. УПЕГ-ын 2013 оны 11 дүгээр сарын 11-ний 5/1590 тоот бичгээр “Энэ хэрэгт нэр холбогдсон 23 хүн төдийгүй шашны томоохон мяндаг тушаалтай, амьдралынхаа турш шашны мөр хөөж, бат итгэсэн олон сүсэгтнүүд ардын засгаас лам нар сүм хийдийг бүрмөсөн устгах, өмч хөрөнгийг нь хураах талаар явуулж байсан үйл ажиллагаанд дургүй байсан нь тодорхой бөгөөд 1932 оны эсэргүү хөдөлгөөн гарах болсон гол шалтгаан болохоос биш гаднаас ямарч удирдлага байгаагүй байна” гэсэн хариу өгч “эцсийн хариу” гэдгийг онцлон анхааруулсан юм.

Энэ шийдвэр нь хуулийн дээд байгууллага өнгөрсөн үеийнхээ зарим зөв шийдвэрийг хүчингүй болгож эрх мэдлээ хэтрүүлсэн гэж ойлгогддог.

Хуулийн дээд байгууллагын шийдвэр, бичгийг хүндэтгэн үзсэн боловч учир дутагдалтай санагдаж, ялангуяа ёнзон хамба Ц.Лувсанхаймчигийг тагнуул, бослогын нууц удирдагч байсан, гэмт үйлдэл нь бусдаасаа ялгарч тод томруун байхад цагаатгасан үндэслэл хангалттай бус бөгөөд Лувсанхаймчигийг цагаатгахад ихэд анхаарч цагаатгал руу туйлширч кампанчилсан нь илэрхий байна. Лувсанхаймчиг Хятад, Английн тагнуул байснаа хүлээснээр барахгүй цаазлагдахын өмнө амь өршөөвөл БНМАУ-д тагнуулаар үнэнчээр ажиллана гэсэн өргөдөлд тамга тэмдгээ дарж бичиж байснаас үзэхэд тэр мэргэжлийн тагнуул байсан нь илэрхий байдаг.

Бодит байдлаар 1921-1932 онд хүрээ хийдийн лам нараас хориод удаа бослого гаргаж дарагдсан олон нэртэй бослогыг 1990 оноос “Ардын бослого” гэж түүх гуйвуулдаг болсныг тодруулбал:

1. 1990 оны 7 дугаар сард УДШ-ийн тогтоолд гадаадын удирдлагагүй, дотоодын сүсэгтэн феодал, лам (олон сүсэгтэн), ардын дургүйцлээс бослого, хөдөлгөөн үүсэн гарсан гэж дүгнээд ёнзон хамба тэргүүтэй дээд ангийн 23 ламыг цагаатгаснаас эхэлж “Ардын бослого” гэсэн нэр томъёо үүсэн гарчээ.
2. Энэ шийдвэр 1990 оны 7 дугаар сард хуралдсан Монголын социал демократ намын анхдугаар их хуралд тусгагдаж “1932 оны баруун дөрвөн аймагт гарсан бослого нь бусдын

гар хөл бологчид болон зүүнтний бодлогыг эсэргүүцсэн ардын бослого байв” гэж тодруулжээ.

3. 2011 онд Б.Цэнддоо, С.Цацралт нар зохиож НЭПКО хэвлэлийн газар, Гамма фото агентлагаас” 100 жил үйл явдал” зургийн цомогт номын 99-р хуудсанд коммунизмыг эсэргүүцсэн монголын ард олны зэвсэгт бослого 1932 онд гарлаа” гэж бичжээ.
4. 2014 онд ОХУ-ын түүхч С.Л.Кузьмин “Социализмын эсрэг 1932 оны Монгол дахь бослого” номыг хэвлүүлжээ. Тиймээс С.Л.Кузьмин, Б.Цэнддоо, С.Цацралт нарын ойлгосон шиг монголын ард түмэн 1932 онд социализм, коммунизмыг эсэргүүцэх хэмжээний мэдлэгтэй болсон гэхэд үнэмшил төрөхгүй байна. Энэ зохиогчид 1921 оны ардын хувьсгалын ялалт, анхны жилүүдэд БНМАУ-ын олсон ололт амжилтыг гуйвуулах санаа агуулжээ.

Тиймээс 1932-1937 онд Монголын ард түмэн ардын төр, засаг МАХН-аа устгах хүсэл зорилго байгаагүйн томоохон нотолгоо бол 1945 оны 10 дугаар сарын 20-нд орон даяар санал асуулга явагдаж насанд хүрэгсэдийн 98.5 хувь буюу 480 000 хүн оролцож, тэдний 100 хувь нь БНМАУ-ын тусгаар тогтнолыг баталж гарын үсэг зурж байсныг эргэцүүлэн санацгаая.

Монгол хүн улс орныхоо түүхийг гутаан гуйвуулахгүйгээр үнэн зөвөөр ойлгож мэддэг, бахархдаг байх ёстой атал олон ном сонинд “Ардын бослого” гэж бичигдсээр нийтийн ойлголт болоход хүрлээ. Улс орныхоо төлөө хүчин зүтгэдэг ард түмэн нь 1932 онд “Эсэргүү босогч” байсан эсэхийг судлаач түүхчид тунгаан үзэх цаг болсон байна.

Эсэргүү бослогын эдрээтэй нууц асуудлын нэг бол дайн бослогын үед ДХГ-аас түр ажлаар очсон төлөөлөгч Лувсан-Ёндонгоос босогчдын дунд гадаадаас ирсэн хоёр хүн нууц нэрээр явж байгаа мэдээг ДХГ-таа утсаар явуулснаа нотолж чадаагүй боловч жанжин Б.Аюурзанаас Ням, Далай хоёр байсныг илчлэн мэдүүлжээ.

Банчин богд болвоос, Хятад, Япон, Монголд нэр хүндтэй, хүндлэгддэгээрээ далимдуулан монголчуудыг ардын нам засгаас шашнаа хамгаалан эсэргүүцэж босохыг уриалж турхираад өөрөө оролцож дэмжинэ гэсэн нь түүнийг дээд зэргээр хүндлэж, итгэж, өмгөөлж, хамгаалж байсан хүмүүс нь үнэнд гүйцэгдэж, түүнийг жигшин зэвүүцсэн байна.

Хэрэгтнүүд ардын нам, засгаас шашин сүм хийдийг хязгаарласныг Банчин богдод итгэж эсэргүүцсэн буруугаа хүлээн мэдүүлсэн нь түүний заавар зөвлөгөөгөөр, бие төлөөлөгчөөр удирдан оролцож

байсны нотолгоо мөн.

Харин хуулийн дээд байгууллага, зарим судлаач түүхчид монгол хүмүүсийнхээ мэдүүлгийг хууль ёсны гэж хүлээж авдаггүй нь монгол хүн үнэ цэнэгүй болсны илрэл мөн. Банчин богд өөрөө “Шамбалын дайн” гэж нэрлээд ёнзон хамбатай хуйвалдан хамтарч, дээд ангийн лам нараар бослогыг удирдуулсан, Очирбатын яамны бүрэлдэхүүнд феодал, тайж нарыг оруулсан, сүсэгтнүүдэд шашин шүтлэг, элдэв цуурхлаар ихээхэн нөлөөлсний улмаас “Шашны дайн түрэмгийлэл” гэж үздэг. Энэ бослого нь БНМАУ-ын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулсан юм.

Урадын Э.Булаг “Хамтач үндэсний үзэл” номондоо, “Банчин лам, Жанжаа хутагт нарын Монголд явуулсан ажиллагаа туйлын бүтэлгүй болсон бөгөөд Ванчин лам 1937 оны 12 дугаар сарын 1-нд Төвд рүү буцах замдаа бие баржээ” гэж бичжээ.

1937 онд Банчин лам бие барж, ёнзон хамба Ц.Лувсанхаймчиг цаазлуулснаас хойш бослогын тухай яриа гараагүй байна. 1932 оны бослогыг Банчин богд, ёнзон хамба хоёр турхирч гараагүй бол 1937 онд тэднийг бослогод бэлтгэсэн оролцсон хэргээр хэлмэгдүүлэхгүй байсан юм.

БНМАУ-ын олон мянган лам, хар олныг эсэргүү бослогоор далимдуулж Коминтерн, ЗХУ-ын Коммунист намын шахалтаар хэлмэгдүүлснийг 1990 онд цагаатгах ажлыг шуурхайлахдаа УДШ-ээс бослогыг гадаадын удирдлагагүй сүсэгтэн ардын бослого байсан гэж дүгнэжээ. Тагнуул С.Батаа Банчин богдын захидлыг “аграмба” Чойжилсүрэнгээс гадна Өвөрхангайн гурван ламд хүргэх, Архангайн Лодойжамцаас захидлын хариу авах даалгавартай ирсэн бол “оргодол” Баасантай нийлсэн “Гандан бүлгэм”-ийн гишүүн “Шавран”, “Төвд хувилгаан” Т.Равсалд Банчин богдын захидал ирсэн байна. Энэ бүхнээс үзэхэд Банчин Богд, Ёнзон Хамба хоёрын удирдлага оролцоог үгүйсгэх үндэслэл байхгүй. Эсэргүү бослогыг дахин гаргахаар Банчин Богдын даалгавраар ирсэн Батаа буюу Намжилдэндэв, 1932 оны эсэргүү бослогод идэвх зүтгэлтэй оролцож яваад баригдалгүй өш хонзонтой үлдээд бослогод дахин бэлтгэсэн Б.Баасан буюу Баасанжав, Б.Содов нарыг кампаничлан туйлширч цагаатгасан нь хууль завхруулж, түүх гуйвуулсан ноцтой асуудал мөн гэж дүгнэхэд хүргэв. Ялангуяа Банчин Богд Гэлэгнамжил, Ёнзон Хамба Лувсанхаймчиг хоёр нь 1932 оны бослогыг цэрэг зэвсгийн хүчээр биш, монголын хар болон лам нарыг захидал, заавар, бие төлөөлөгч, тагнуулаар турхирч, удирдлагыг томилж, эхлэх хугацаа, уриа нэрийг зааж удирдалцсан, сүсэгтэн олонд шашин шүтлэгээр нөлөөлсөн хүмүүс мөн гэж дүгнэж байна.

УДШ, УЕПГ, ЦАУЗБК-оос БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн 1933 оны 5 дугаар 15-ны 27-р тогтоолд: Эсэргүү босогчдыг “Эд нар бол гадаадын эзэрхэг түрэмгий харгис Японы удирдлага бүхий Банчинтай холбоо хэлхээ байгуулж, өөрийн тусгаар тогтносон хувьсгалт улсын засгийг устган унагаж, хуучны феодалын засаг байгуулах зорилтыг тавьж, тус засагтай зэвсэг барин босож тэрсэлдсэн” гэж дүгнэснийг эсэргүү бослогыг дарсны 85 жилийн ойгоор эргэцүүлэн судалж түүний мөрөөр ажиллах 6 саналыг дэвшүүлье. Үүнд:

1. 1932 оны бослогыг хуулийн дээд байгууллагаас гадаадын удирдлагагүй сүсэгтэн лам, ардын босого байсан гэж дүгнэсэн шийдвэрийг залруулах

2. Бослого, дүрвэлтийн талаар эрдэм шинжилгээний хурал, баримтаг цуврал нэвтрүүлэг хийлгэж, кино бүтээлгэж түүхээр талцуулах зөрүүтэй ойлголт, хандлагыг таслан зогсоох

3. Дайн бослогын 12 нэрийг нэг буюу түүхч С.Л.Кузьмины олон улсын иргэний дайны судалгааг үндэслэж Банчин богдын нэрлэсэн “Шамбалын дайн” нэртэй болгож, нэг мөр, нэгдсэн ойлголттой болгох

4. Банчин богдтой хуйвалдагч, тагнуул, дайн бослогын нууц удирдагч Ц.Лувсанхаймчиг, тагнуул Батаа буюу Намжилдэндэв, 1937 оны бослогод дахин бэлтгэсэн Баасан, (Баасанжав), (ТЕГ-ын Ц-6632 хэрэг) Б.Содов нарын цагаатгалыг хүчингүй болгуулах

5. МБШТөвөөс феодал лам нарын эсэргүү бослогыг дарсны 85 жилийн ойг тохиолдуулсан амь үрэгдсэн 6000 гаруй хүнд зориулсан сувраг босгуулах

6. Их нүүдэл, дүрвэлт, Шамбалын дайн, Халх голын дайны уялдаа холбоог гүнзгийрүүлэн судалж дүгнэлт гаргах ба Нанжин Тайваны архивт судалгааны баг явуулж ажиллуулах саналыг дэвшүүлж байна.

Монголчууд зөв түүхээ буруу болгон талцаж хойч залуу үеийнхээ хүмүүжил мэдлэгт хор холбогдол учруулж болохгүйг анхаарцгаая.

XVI зуунд Монгол улсад шарын шашин гүн дэлгэрсэн үеэс Эзэн Чингис хааныхаа мөнх хөх тэнгэр, хөрст алтан дэлхийгээ шүтэн биширдэг бөөгийн шүтлэгийг хүчээр устгаж, Манжийн колончлолд 220 жил хүлцэнгүй мөлжигдөж, 1930-аад онд эх орноосоо дүрвэх, урвах хөдөлгөөнд өртөж, дайн бослого гаргаж, өөрсдөө өөрсдийгөө алж, хорлон сүйтгэж байсан нөлөөлөл, хор хохирлыг үгүйсгэхгүй мэдэж, мартаггүй санаж, сануулж байх нь зохилтой гэж үзэж байна.



## БНМАУ-Д БУДДЫН ШАШНЫ СҮМ ХИЙДИЙГ УСТГАСАН НЬ: МЕХАНИЗМ БА УЧИР ШАЛТГААН



*С.Л.Кузьмин  
Түүхийн шинжлэх ухааны Доктор,  
Профессор  
ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины  
хүрээлэн*

Монголд 1921 оны хувсгалын өмнө монголчууд бараг бүгдээрээ шарын шашны талыг баримтлагч буддын (бурхны) шашинтнууд байсан. Иймээс буддын шашны сүм хийд болон Богд гэгээн Жавзандамба хутагт асар өндөр нэр хүндтэй байж, нийгмийн хувьсгал хийх нөхцөл шалтгаан байхгүй байсан. Гэвч 1921 онд хувьсгал гарч, 1930-аад оны сүүл гэхэд буддын шашны сүм хийд Монголд үгүй болсон.

Яаж, яагаад ийм юм болов? Энэ асуудлын учрыг би орос, монголын архивын баримтад тулгуурлан тайлбарлахыг хичээе.

БНМАУ-д шашныг устгасан үйл явдал нь МАХН дангаараа ноёрхож байсан цаг үед болсон юм. Энэ нам нь Монгол орноо хятадын эзлэн түрэмгийлэгчдээс чөлөөлөх хүсэл эрмэлзэл бүхий монголчуудын нууц бүлгэмүүдээс 1920 онд (зарим баримтад дурдсанаар 1919 онд) байгуулагдсан байдаг. Тэд өөрсдөө шашин шүтдэг байсан бөгөөд Жавзандамба хутагтын засаглалыг хүлээн зөвшөөрч байсан. Тэгвэл яагаад тийм хүмүүсийн үндэслэн байгуулсан МАХН шашны эсрэг бодлого хэрэгжүүлэх болов?

Нийслэл Хүрэн дэх оросын колонийн захиргаа, удирдлагын большевик үзэлтэй гишүүд эдгээр бүлгэмүүд дотор социалист үзэл суртлыг тарааж байсан. Чухам тэдний нөлөөгөөр бүлгэмүүд нийлж МАН байгуулагдсан.

МАН-ын төлөөлөгчид ЗСБНХОУ (Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Орос Улс)-ыг зорьсон анхны аялыг ЗСБНХОУ-ын гадаад хэргийн Ардын комиссаруудын газар, Оросын Коммунист (большевикуудын) Намын Сибирийн товчоо хариуцан зохион байгуулсан. МАН-тай цаашид ажиллахад Коминтерн чухал үүрэг

гүйцэтгэсэн. Монголын төлөөлөгчид өөрсдийн аяллыг Жавзандамба хутагтын тамгаар баталгаажуулсан Монгол лам, ноёдын захидлаар албажуулсан байсан. Харин Сибирийн большевикуудтай уулзаж ярилцсаны эцэст (үр нөлөөгөөр) тэд (МАН-ын төлөөлөгчид) энэ захидалд өөрсдийгөө хамааралгүй болохыг мэдэгдэж, улмаар хувьсгалт зорилго бүхий өөрсдийн захиаг бичсэн байдаг. Түүгээр зогсохгүй (МАН-ын) төлөөлөгчид хэлэлцээний үеэр монголын нийгмийг үндсээр нь өөрчлөх тухайгаа, бас эхэн үедээ Богд гэгээнийг “ёс болгож” (ёс журмыг эрхэмлэн) засгийн эрхэнд үлдээх тухайгаа мэдэгдсэн байдаг.

Төлөөлөгчид Монголд буцаж ирээд хувьсгалт суртал ухуулгыг дэлгэрүүлэх ажилдаа орсон. Тэр үед МАН шашны эсрэг байгаагүй.

МАН 1921 оны хоёрдугаар хагаст засгийн эрхийг большевикуудын тусламжтайгаар авсныхаа дараагаас буддын сүм хийдийн эрх дархыг хязгаарлах алхам хийж эхэлсэн. Энэ үеэс “Тангарагийн гэрээ” гэгч үйлчилж эхэлсэн. Энэ гэрээ нь VIII Богд гэгээний төрийн эрх мэдлийг хасах зорилгоор үйлдсэн нэг талт бичиг баримт байсан юм. Мөн сүм хийдийн орлого болон нэр нөлөөг хязгаарласан бичиг баримтууд (ар араасаа) гарч эхэлсэн. Төр засаг сүм хийдийн ажил хэрэгт хутгалдан оролцох болсон. Коминтернийн Алс Дорнод дахь Нарийн бичгийн дарга нарын газрын хараа хяналтын дор ХЗЭ байгуулагдсан. ХЗЭ нь шашинтай тэмцэх тэмцлийн хошуучлагч болсон.

1922 онд Саж лам Жамъянданзанг хуучны ёс журмаа сэргээх, өөрөөр хэлбэл, Богд гэгээний хууль ёсны хаант засаг тогтоох гэлээ хэмээн буудаж алсан. Мөн тэр жил МАН-ыг эсэргүүцэж, Японоос тусламж хүссэн Цэрэнпил гүний хуйвалдааныг илчилсэн. Энэ хуйвалдаанд Манзшир хутагт, Довчин хувилгаан, мөн хэд хэдэн лам оролцсон юм шиг байдаг. Энэ хэрэгтэй холбогдуулан Довчин хувилгаан болон өөр хэд хэдэн ламыг буудан хороосон байдаг<sup>1</sup>.

Тэгэхээр МАН засгийн эрхэнд гарсны дараа жил гэхэд хутагт хувилгаад, бас бусад лам нарыг цаазлан хороох эхний ажиллагаа эхэлчихсэн байсан.

Шашныг эсэргүүцсэн чиг хандлага VIII Богд гэгээнийг 1924 онд өөд болсны дараа улам ширүүссэн. Монголд хаант засаг халагдаж, ардын БНУ байгуулагдаж, анхны Үндсэн хууль батлагдсан. Сүхбаатар 1923 онд нас барсны дараа монголыг хэсэг хугацаанд удирдан залах гол хүн нь Элбэгдорж Ринчино хэмээх гадаадын иргэн байсан. Тэр хүн социализмыг баримталсан хөдөлгөөнийг дэмжиж, Коминтерн болон ЗСБНХУ-ыг бүрэн түшиглэх, капиталист бус хөгжлийн замаар замнахын төлөө байв. Бас сүм хийдийн эсрэг авч хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээнүүдийг санал болгон тавьж байсан.

<sup>1</sup> АВПРФ, ф. 0111, оп. 7, п. 118, д. 49, л. 1 — номонд: Сеницын, 2013, с. 266; Пүрэвжав, Дашжамц, 1965, х. 64–65; МУУТА, МБТ, ф. 4, д. 1, х.н. 19а, тал 1–145.

1926-1928 оны “барууны нугалаа”-ны үед сүм хийдийг төрөөс тусгаарлах тухай хууль гарсан. Уг хуулиар лам нарыг улс төрийн үйл ажиллагаанд оролцохыг хориглож, сүм хийдийг төр засгаас зохицуулах болж, сүм хийдийн төвлөрлийг сааруулах, эрх хэмжээг хязгаарлах явдлыг чухалчилсан. Хутагт хувилгаадын хойд дүрийг тодруулахгүй байх, лам нарыг хагалган бутаргах, сүм хийдийг албан татвараар дарамтлах гэх мэт арга хэмжээ авч эхэлсэн. Шинэ засагт дургүйцсэн лам нарыг баривчилж, буудан хороож байсан.

1925 онд батлагдсан “БНМАУ-ын Ардын Их Хурлын сонгуулийн тухай журам”-аар сүм хийдэд байнга шавилан суудаг хутагт, хувилгаан, лам нарын сонгох, сонгогдох эрхийг нь сэтгэл мэдрэлийн өвчтэй, гэмт хэрэгтэн зэрэг хүмүүсийн нэгэн адил хассан<sup>2</sup>.

Ийнхүү МАН “хэмжээт эрхт хаант засаг”-ын үед ч, мөн “барууны нугалаа”-ны үед ч шашны эсрэг бодлого авч хэрэгжүүлж иржээ.

1928 оны сүүл үеэс 1932 дуусталх хугацаанд “зүүний нугалаа” гарч байсан. Зүүний нугалаа нь Бүх Холбоотын К(б)Н-ын удирдагчдын зөвшөөрөлтэйгөөр Коминтернээс хийсэн тулгалт байсан юм. Энэ “нугалаа”-ны гол үндэс нь социализмыг түргэвчлэн байгуулах явдал байв: тухайлбал, хөрөнгө хураах, жасын алба байгуулах, хоршоолол, хамтрал байгуулж, дэмжлэг туслалцаа үзүүлэх, сүм, хийдийг хаах, лам нарын тоог цөөлөх, улмаар шашныг устгах явдал байлаа. Энэ үед лам нарын тоо ойролцоогоор гуравны нэгээр цөөрсөн.

“Зүүний нугалаа” гарах үед БНМАУ-д 92534 тооны лам байснаас “зүүний нугалаа” дууссан сүүлчийн жил-1932 онд янз бүрийн баримтаар, 51345 буюу өөрөөр 72300 тооны лам үлдсэн байна. Харин Зөвлөлтийн мэдээгээр, 1928 оноос лам нарын тоо их багасаж, 1928 оны эцэст 6663 лам, 1929 онд- 12740 лам, 1930 онд -11326 лам, 1931 онд ойролцоогоор 12836 лам нар энгийн хар болцгоосон байна<sup>3</sup>.

Лам нарыг хилс (зохиомол) хэрэгт буруутган яллах хэд хэдэн шүүх хурал болсон. Тэдний нэлээд олныг нь буудан хороосон. Үүнд: Зая бандид хутагт, Егүзэр хутагт, гэгээн Эрэгдэлбүрэлгү, хувилгаан Шаравжамц, Ёнзон хамба Доржзэвэг, Даян ламын хувилгаан Лувсанданзан, Эрдэнэ мэргэн ноён хутагт Содномцэрэн, гэх мэт лам нарыг, түүний дотор хувилгаадыг хэлмэгдүүлэн хороох явдал жирийн үзэгдэл болж ирсэн.

МАХН-ын хувьд ЗСБНХУ-д явагдсан Сталины хамтралжуулах хөдөлгөөн үлгэр жишээ болж байв. ЗСБНХУ-ын хамтралжуулах хөдөлгөөн 1928 оноос эхэлсэн (үндсэн оргил үе нь 1930-1933 онд өрнөсөн). Үүний зэрэгцээ мөн шашны эсрэг кампанит ажил өрнөж,

2 Монгольское законодательство, 1928, с. 21.

3 РГАСПИ, ф. 495, оп. 152, д. 143, л. 125-140об; Кузьмин, 2016, табл. 4.

сүм хийдэд өндөр албан татвар ногдуулах, лам нар болон сүжигтэн этгээдийг хавчин шахах, ухуулга сурталчилгаа явуулах, лам нарыг эгэл жирийн амьдралд оруулах арга хэмжээ авч байсан<sup>4</sup>. Тувад “баруунтан”-тай тэмцэх ажлыг Тувагийн Ардын Нам болон ХЗЭ-ийн гол хувьсгалт хүчнүүд удирдан зохион байгуулж байсан. Тэнд мөн л лам нарын сонгох, сонгогдох эрхийг хязгаарлаж, эд хөрөнгө хурааж, хамтралжуулж, шүүн таслах ажиллагаа явуулж, буудан хороож, сүм хийдийг хааж, сүйтгэж байсан<sup>5</sup>.

“Зүүний нугалаа”-ны үед МАХН-ыг эсэргүүцсэн бослого тэмцэл, хуйвалдаан дээд цэгтээ хүрсэн. Хамгийн их тавьдаг шаардлага нь шашныг хүндэтгэн үзэх, хуучны дэг ёсыг сэргээх, Жавзандамбын хойд дүрийг тодруулах явдал байв. Энэ үед хөрш зэргэлдээ орших Тувад ч бас бослого хөдөлгөөн нэгэн зэрэг гарч байсан.

1930 онд БНМАУ-д Төгсбуянт болон Бодончийн хүрээдийн орчим бослого гарч, түүнд лам нар голлох үүрэгтэй оролцсон. Энэ үеэр амь үрэгдсэн босогчдын тоо төр засгийн отрядын амь үрэгдэгсэдээс бараг 36 дахин их байсан нь олзлогдсон босогчдыг буудан хороосонтой холбоотой байдаг<sup>6</sup>.

1932 онд шашнаа хамгаалах, хуучин дэг ёсоо сэргээх уриан дор хамгийн өргөн олныг хамарсан ард түмний тэмцэл бослого өрнөж, иргэний дайн болтол өргөжсөн. Энэхүү тулаанд босогчид засгийн газрын цэргийн хүчнээс илүү их хохирол амссан: хохирлын хэмжээ нь 2-50%-иар их байсан, нэг тулаанд дунджаар 13%-иар илүү олон лам амь үрэгдэж байв. Амиа алдсан нэг улаантанд 55 хүртэл тооны босогч ногдож байсан. Төр засгийн цэргийн хүчнийхэн эхний хэдэн сард баривчилгаа явуулж, газар дээр нь шийтгэж байсан. Баривчлагдсан хүмүүсийн 12–40%-ийг нь шууд шийтгэж байсан. Харин сүүл рүүгээ баривчлагдсан хүмүүсийг шорон гянданд хүргэх болсон. Цэрэг армийнхан хийгээд дотоод яамныхан сүм хийдийг шатааж, зөвлөлтийн нисгэгчдийн оролцоотойгоор агаараас хэд хэдэн удаа бөмбөгдсөн байдаг<sup>7</sup>.

1932 оны бослого нь монголын ард түмний сонголт бол шашингүй үзэл болон социализм биш, харин буддын шашин болон хаант засаг байсан гэдгийг харуулсан. Энэ бослого нь МАХН-ын засаглалыг аюулын ирмэг дээр аваачсан. Чухам ийм учраас БХКН-ын Улс Төрийн Товчоо Сталины шууд заавраар МАХН-ын удирдлагад заавар чиглэл өгч байсан бөгөөд түүнийг нь нэгбүрчлэн хүлээн зөвшөөрч, гүйцэлдүүлж байсан. “Зүүний нугалаа”-ны дараа “шинэ засгийн (эргэлтийн) бодлого” авч хэрэгжүүлсэн.

4 Цыжипов, 2006, с. 85–98; Раднаев, 2013, с. 136; Синицын, 2013, с. 52–57, 89–103, 278.

5 Монгуш, 2001; Саая, Сат, 2009, с. 61–62.

6 Кузьмин, 2015, с. 53–59.

7 Кузьмин, Оюунчимэг, 2014.

Энэ бодлогын хүрээнд БНМАУ-ын төрийн эрх баригчид Москва руу нэг бус удаа явж, ЗСБНХУ-ын удирдлагуудтай уулзаж байсан. Сталин анхнаасаа л лам нарын талаар таагүй бодолтой байдгаа илэрхийлж, тэдэнтэй тэмцэхийг шаардаж байсан. Жишээлбэл, 1935–1936 онд Сталины бичиж тэмдэглэсэнээр, тэр лам нарт ашиг орлогын татвар ногдуулж, хувь хэмжээг нь байнга өсгөн нэмэгдүүлж байх, тэдний дундах зөрчлийг улам хурцатгаж, хүч, нөлөөг нь сулруулах нь зүйтэй гэж ярьдаг байсан байна. Сталины хэлснээр “Лам нар бол БНМАУ-ын дайсан мөн”<sup>8</sup>. 1934 онд нийт 617280 тоо бүхий монголын хүн амын 81774 нь лам нар байв<sup>9</sup>. Тэгэхээр Сталин Монголын хүн амын 10%-ийг дайсан гэж зарласан.

МАХН-ын удирдлагууд Сталинтай уулзсанаас хойш тэдний бодлого аймшгийн болсон. Насанд хүрээгүй хүнийг (хүүхэд багачуудыг) сүм хийдэд шавилуулбал эрүүгийн хэрэгт татах, лам нарын сонгох, сонгогдох эрхийг хасах, иргэний боловсролыг шашны боловсролын эсрэг сэргүүлэн тавих, лам нарын зэрэг зиндаанаас хамааран өсөн нэмэгдсэн хувь хэмжээ бүхий ашиг орлогын татвар ногдуулах, эдгээр хувь хэмжээг цаашид нэмэгдүүлж байх арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.

1934-1936 онд лам нарт хилс хэрэг хүлээлгэсэн шүүх ажиллагаа хэд хэдэн удаа болж, үүний үр дүнд хэрэгтнүүдийг буудан хороох, шоронд хорих шийдвэр гарсан байдаг.

БХК(б)Н-ын ТХ-ны 1937 оны 2 сарын 23-аас 3 сарын 3-нд хуралдсан Бүгд хурлаас ЗСБНХУ-д “их хэлмэгдүүлэлт (аллага)”-ийн гарааг эхлүүлсэн байдаг. 1937 оны 3 дугаар сарын 3-ны өдөр энэ бүгд хурал дээр Сталин бодит байдлыг мушгин гуйвуулж, өөрийн улс төрийн дайснууд болон дайсагнагч орнуудын зүгээс явуулж байгаа хорлон сүйтгэх-алан хядах ажиллагааны аюулын талаар мэдэгдэл хийсэн<sup>10</sup>. БХК(б)Н-ын ТХ-ны Улс Төрийн Товчооны 1937 оны 8 сарын 14-ний өдрийн хурлын № 637 тоот Протоколд (Тэмдэглэлд) “БНМАУ-д шуурхай ажиллагаа зохион байгуулахаар чекистүүдийн бүлгийг нөхөр Мироновын хамт томилон явуулахыг ЗСБНХУ-ын ДХАК даалгах” гэсэн заалт байсан<sup>11</sup>.

ЗСБНХУ-д өрнөсөн “их хэлмэгдүүлэлт”-ийг зохион байгуулагчдын нэг М.П.Фриновский (1937 оны) 8 дугаар сард Улаанбаатарт буусан. Энэ явдлын дараа тэрээр ЗСБНХУ-ын ДХАК-ын орлогч болсон байдаг. “Нам улсын төв болон орон нутгийн удирдах ажилтнуудаас хувьсгалын эсэргүү байгууллагатай холбоотой ажиллаж, нэр гутаасан гэх баримт бүхий хүмүүсийн нэрс”-

8 РГАСПИ, ф. 558, оп. 11, д. 352, л. 13–15, 22–24.

9 Девятый съезд, 1934, с. 76.

10 Доклад И.В. Сталина..., 1995, с. 3–15.

11 РГАСПИ, ф. 17, оп. 162, д. 21, л. 149.

ийн жагсаалтыг Фриновский гаргасан гэж үздэг. Олныг хамарсан баривчилгаа 9-р сарын 10-наас эхэлсэн.

Дотоод Хэргийн Ардын Комиссаруудын газар (ДХАК)-ын 1937 оны 6 сарын 30-ны өдрийн № 447 тоот тушаалаар ЗСБНХУ-д зөвлөлт засгийн эсрэг үйл ажиллагаа явуулсан гэмтнийг (элементүүдийг) илчлэн баривчлах, буудан хороох зорилго бүхий өргөн олныг хамарсан ажиллагааны явцад баривчлагдсан этгээдүүдийг шүүх танхимаас гадуур шүүн таслах эрх бүхий “гурвын комисс” байгуулагдсан байдаг. Энэ ажиллагааг большевикууд БНМАУ-д нэвтрүүлсэн. БХК(б) Н-ын ТХ-ны Улс Төрийн Товчоо 1937 оны 9 сарын 19-нд №П53/106 тоот шийдвэр гаргасан байдаг бөгөөд түүнд “Монголын лам нарын асуудлыг шийдэх эрх бүхий гурвал (гурвын комисс)-ыг Чойбалсан, Шүүх яамны сайд, МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулах тухай нөхөр Фриновскийн саналыг хүлээн зөвшөөрөх” гэж заасан байдаг<sup>12</sup>. Энэ бүтэц дараа нь Бага хурал болон Сайд нарын зөвлөлийн хамтарсан тогтоолын үндсэн дээр 1937 оны 10 сарын 2-нд бүрэлдэн тогтсон<sup>13</sup>. Түүнийг Онцгой бүрэн эрхт комисс гэж нэрлэх болсон.

БНМАУ-д Фриновскийтай хамт 1937 оны 8 сарын 19-ний өдөр ЗСБНХУ-ын бүрэн эрхт төлөөлөгчөөр, мөн ДХАКГ-ын БНМАУ дахь төлөөлөгчөөр томилогдсон С.Н.Миронов ирсэн. Энэ хүн бол ЗСБНХУ-ын янз бүрийн газар ажиллаж, арвин их туршлага хуримтлуулсан, 1920 оноос чекист болсон хүн байв. Түүнийг ДХАКГ-ын Сибирийн баруун хязгаарыг хариуцсан газрын даргаар ажиллаж байхад нь татан авчирч, ийнхүү бүрэн эрхт төлөөлөгчөөр томилсон байдаг. Энэ хүн БНМАУ-д дээд удирдагч мэт зангараглаж байсан нь түүнээс 1938 оны 2 сарын 11-ний өдөр ЗСБНХУ-ын Гадаад хэргийн Ардын Комиссаруудын газарт илгээсэн зурвасаас тодорхой харагддаг. Уг зурвасыг Сталинд хүргүүлсэн байдаг. Түүнд Миронов БНМАУ-ын удирдагчид болох Амар, Догсом, Баасанжав, Чойбалсан нарыг өрөөндөө дуудан цуглуулж, зад шүүмжлэв гэж бичсэн байдаг. Тэр хүн “улс төрийн үндсэн асуудал бол нам, засгийн зүгээс феодал ангийн үлдэгдэл бөгөөд японы тагнуулын байгууллагын гол түшиг болоод байгаа шарын шашны дээд толгой лам нарын эсрэг тэмцэх явдал мөн” гэдгийг цохон заасан байдаг. Мироновын энэ санааг тэд бүгд хүлээн зөвшөөрч байсан. Маргааш нь МАХН-ын ТХ-ны тэргүүлэгчдийн бүгд хурал хуралдахад илтгэлийн сэдвүүдийг Миронов хянан засч байсан байдаг<sup>14</sup>.

Мироновын Монголд ажиллаж байсан орон тооны чекистүүдийн багт М.И.Голубчик багтаж байсан. Голубчик Монголын Дотоод хамгаалах яамны зөвлөх болсон, өөрөөр хэлбэл, Чойбалсангийн

12 РГАСПИ, ф. 17, оп. 162, д. 22, л. 7.

13 Kaplonski, 2014, p. 208.

14 РГВА, ф. 33987, оп. 3, д. 1083, л. 29–40.



шууд “зааварлагч” болсон. Голубчик “Шарын шашны талаар ДХЯ-наас явуулсан шуурхай ажиллагааны урдчилсан дүн болоод цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ” гэсэн баримт бичиг үйлдэж, 1938 оны 2 сарын 27-нд Фриновский болон Мироновт хүргүүлсэн байдаг. Энэ баримт бичгийн эхний хэсэгт японы тагнуулын байгууллагаас үүсгэн байгуулсан бөгөөд монголд дэгдсэн бүх бослого тэмцлийг зохион байгуулсан гэх “Хувьсгалын эсэргүү лам нарын төв”-ийн талаар дэлгэрэнгүй бичсэн байдаг. Энэ төвийн толгойлогчдын хэргийг шүүн шийдсэний дараа шуурхай багийн ажилтнуудыг ДХЯ-ны аймгийн хэлтсүүд рүү илгээн, лам нарыг үй олноор нь баривчлах ажиллагааг эхлүүлсэн байдаг<sup>15</sup>. Голубчик БНМАУ-ын ДХЯ энэ ажлыг эхлүүлэхдээ дараах зүйлийг үндэс болгосон гэдгийг бас дурдсан байдаг:

“а) ардын хувьсгалт засаг бүрэн төгс ялах зайлшгүй нөхцөл нь феодализмын хүчин зүйл болох шарын шашныг бут цохиж, устгах явдал мөн. Сүм хийдийг ... нэг цохилтоор (нэг далайлтаар) биш ч гэсэн устгавал зохино;

б) японы аюул занал өсөн нэмэгдэж байгаа учраас ар талаа хувьсгалын эсэргүү, тагнуул, хорлон сүйтгэгчдээс цэвэрлэх ёстой. Энэ үндсэндээ, ер нь чухамдаа хувьсгалын эсэргүү лам нарыг бут цохих явдал болно... Дайсагнагч хүчнээс улс орноо цэвэрлэх энэ ажиллагааг богино хугацаанд гүйцэтгэх ёстой”. Энэ захиаг 2 хувь үйлдэн Сталинд илгээсэн байна<sup>16</sup>.

Миронов БНМАУ-д ажиллаад таван сар болоход юу хийсэн талаараа зурвас бичиж, Гадаад хэргийн Ардын Комиссар М.М.Литвиновт илгээсэн байдаг бөгөөд уг зурваст Голубчикийн боловсруулсан нарийвчилсан зөвлөмжүүдийг хавсаргасан байдаг. Уг зурваст дараах зүйлийг бичжээ: “Чойбалсангаас бусад бүх сайд нар хувьсгалын эсрэг янз бүрийн үзэлтэй байгууллагуудын гишүүд болсон байна. Бүх яам, байгууллагад хувьсгалын эсэргүү байгууллагын салбарууд буй болсон байна. <...> <...> Японы үндсэн бааз болон шарын шашны дээд толгой лам нарыг хавар болохоос өмнө бут цохих тооцоо гарган, тэмцлийн үндсэн тактикаа нөхөр Фриновскийтай хамтран боловсрууллаа. МАХН-ын ТХ-ны III бүгд хурлаас гаргасан шийдвэр нь МАХН-ын ТХ, консулууд, Чойбалсан болон Голубчик нараар дамжуулан дээд толгой лам нарыг бут цохих, лам нарт ногдуулах албан татварыг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн. Лам нарыг баривчлах ажиллагаа 100 гаруй сүм хийдийг хамарсан”<sup>17</sup>.

15 РГВА, ф. 33987, оп. 3, д. 1083, л. 52–65.

16 РГВА, ф. 33987, оп. 3, д. 1083, л. 52–65.

17 РГВА, ф. 33987, оп. 3, д. 1083, л. 66–80.



Голубчикийн зөвлөмжид ялангуяа дараах зүйлс тусгагдсан байв:

“1. Шарын шашныг бүрэн устгахын тулд ойрын хугацаанд бүх цохилтыг дээд толгой лам нарт төвлөрүүлэх. Энэ тэмцэлд доод лам нарыг ашиглах, дунд лам нарыг түр орхих.

2. Дээд толгой лам нарыг бут цохисноор феодал ангийн сүүлчийн үлдэгдлийг устгах явдал дуусгавар болсон болохыг Засгийн газрын зохих шийдвэрээр баталгаажуулах.

11. Буддын гүн ухаан болон түвдийн анагаах ухаан заадаг шарын шашин-төвдийн дацан сургууль төвлөрсөн Улаанбаатар, Булган, Цэцэрлэг дэх сүм хийдийг бүрэн устгах.

16. Шарын шашны дээд толгой лам нараас татвар хурааж гүйцсэний дараа... дээд толгой лам нарыг устгах ажиллагааг дуусгавар болгох... Үүний дараа дунд зиндааны лам нарын хувьсгалын эсэргүү хэсгийг бут цохих ажлыг эхлүүлэх”<sup>18</sup>.

Энэ баримт бичиг дээр “Энд 85 мянган лам нараас 51 мянга нь улс орон даяар таран бутарсан тухай түгшүүртэй мэдээ байна” гэж цохон тэмдэглээд, 1938 оны 3 сарын 23-нд Сталинд хүргэжээ<sup>19</sup>.

1930-аад онд явагдсан нээлттэй (нийтэд үзүүлэх) шүүх хурлуудаар лам нарыг олны нүдэн дээр баталгаажуулж, нарийвчлан тогтоох шаардлагатай байсан улс төрийн гэмт хэргүүдээр ялласан байдаг. Яагаад ингэсэн нь ч ойлгомжтой: Дээд толгой лам нар ихэнхдээ сүм хийдийн дэг журмыг зөрчдөггүй учраас ард олны дунд нэр хүндтэй байсан. Энэ хүмүүс Монголын өв уламжлалыг тээгчид байсан. Ийм учраас тэдний нэр хүндийг унагаж, тэднийг устгах нь хүн амын нүдэн дээр шашны нэр хүндийг унагахад хэрэгтэй байсан. Түүнээс гадна номдоо гэгээрсэн лам (эрдэмтэн лам) нарыг үгүй хийснээр шашны мэдлэг, ёс заншлыг үе уламжлуулан дамжуулах явдал тасарна гэсэн үг. Хэлмэгдэгсдийн дунд хувилгаан, гавж, өөр бусад эрдмийн зэрэг эзэмшсэн хүмүүс, даа лам зэрэг өндөр зиндааны, мөн хамгийн дээд зэргээр боловсорсон лам нар голлох хувийг эзэлж байсан байдаг.

Худал зохиомол баримт бүрдүүлэн шүүн таслах энэхүү (нийтэд) үзүүлэх ажиллагааны (нээлттэй шүүхийн) ноён оргил нь “Хувьсгалын эсэргүү төв”-ийн хэргийг шүүн таслах хурал байсан юм. Энд 23 хэрэгтэн ламын 19-д нь буудан хороох ял оноосон байдаг. Тэдний нэгээс бусад нь хувилгаан, эсхүл гавж, аграмба зэрэг шашны өндөр зэрэг хэргэмтэй байж. Манзшир хутагт л гэхэд гэгээн дүрийн хувьд Богд гэгээний дараа дээдлэгддэг, хоёр дахь хүн байж<sup>20</sup>. Манзшир хутагт нь бүр зөвлөлтийнхний үнэлгээгээр “онцгой цэвэр ёс суртахуун”-тай хүн

18 РГВА, ф. 33987, оп. 3, д. 1083, л. 66–80.

19 РГВА, ф. 33987, оп. 3, д. 1083, л. 81.

20 ЦАФСБ, ф. 65, д. 9920, л. 156–158.

байж<sup>21</sup>. Манзшир хутагт тэрээр шашин номоо хамгаалж, Богд гэгээний хойд дүрийг тодруулахын төлөө байж<sup>22</sup>. Ёнзон хамба Лувсанхаймчиг нь Улаанбаатар болон бусад хэд хэдэн газар асар их нөлөөтэй лам байж. Бусад хэрэгтэн лам нар нь ч бас өндөр нэр хүндтэй байж.

БНМАУ-д сүм хийдийг устгах ажиллагааны үед нийтдээ буддын шашны 16 мянга гаруй (гэхдээ 19 мянга хүрэхгүй) төлөөлөгчид хэлмэгдсэнээс ихэнх нь буюу 13-14 мянга нь буудуулан амиа алдсан болох нь илт байна. Монголын сүм хийд, лам нарын намтрын лавлахаас үзэхэд БНМАУ-д хувилгаадыг цаазлах ихэнх ажил 1937 онд хийгдсэн байна<sup>23</sup>. Зөвхөн нэг хутагт (гадаад орон руу гарсан Дилав) болон өөр 5 хувилгаан энэ цөвүүн цагийг амьд гэтэлсэн бололтой<sup>24</sup>.

Ерөнхийдөө, БНМАУ-д сүм хийдийг устгах үндсэн арга хэмжээнүүд дараах чиглэлээр явагдаж байсан байна: сүм хийдийг оршин тогтнох аргагүй болгох хэмжээний татварын дарамт үзүүлэх; лам нарыг хувьсгалын эсэргүү үйл ажиллагаа зохион байгуулсан болон Японы талд ажилласан хэргээр үй олноор нь хэлмэгдүүлэх; сүм хийдэд хамба болон цорж зэрэг мяндагтан бий болгохыг хорих; шашны эсрэг суртал ухуулга хийх; сүм хийдийг хил орчмын нутгаас нүүлгэн шилжүүлэх; бүх сүм хийдийг хаах.

Марксизм-ленинизмын үзэл санаанд суурилсан ардын боловсролыг хөгжүүлэх асуудал чухам механизм болов. Залуусын ухамсарт шинжлэх ухаан шашныг үгүйсгэдэг гэсэн хуурмаг итгэл үнэмшил суулгаж байв. Хуучин үед ард түмний сүшиг бишрэл болон лам нарын нөлөө нь тэдний өв уламжлалыг хадгалан үлдэх, монголчуудыг нэгтгэн зангидах үүрэг гүйцэтгэж байв. “Хамгаалалтын энэ хана”-ыг нураасан нь шашнаа ч, өв уламжлалаа ч гээхэд хүргэсэн.

БНМАУ-д шарын шашныг устгах гол гол шийдвэрүүдийг Сталины заавраар баталж ирсэн. Энэ шийдвэрийг хүчээр хэрэгжүүлэгч нь БНМАУ-ын ДХЯ байсны хувьд хамгийн нөлөө бүхий яам болж хувирсан. Маршал Чойбалсан хийгээд түүний удирдаж байсан ДХЯ-ыг зөвлөлтийн чекистүүд харж хандаж, дэмжин тусалж байсан. БНМАУ-д сүм хийдийг устгах ажиллагааны тухай мэдээг Сталин дор бүрд нь авдаг байсан.

БНМАУ, Тува, ЗСБНХУ-д сүм хийдийг устгах “их хэлмэгдүүлэлт” ижил зүйл олонтой. ЗСБНХУ-д бас хэлмэгдүүлэх, татварын дарамтыг нэмэгдүүлэх, сүм хийдийг хаах, зөвлөлтийн эсрэг үйл ажиллагаа явуулсан, хуйвалдаан зохион байгуулсан, Японы эрх ашгийн төлөө тагнан турших – хорлон сүйтгэх ажиллагаа явуулсан хэргээр яллах аргуудыг ашиглаж байсан. 1930-аад оны сүүл гэхэд Халимаг, Буриад-

21 РГАСПИ ф. 495, оп. 152, д. 29, л 181.

22 ЦАФСБ, ф. 2, оп. 8, д. 378, л. 67, 117.

23 Монголын сүм хийдийн..., 2009, с. 121-149.

24 Номын материалаас: Монголын сүм хийдийн..., 2009, с. 116-149; Улс төрийн..., 2010, 2012, 2013.

Монголд гэлэнгүүд болон үйл ажиллагаа явуулдаг сүм хийд үлдээгүй<sup>25</sup>. Тува дахь хэлмэгдүүлэлтийн ажлыг нутгийн (тэндхийн) сталинч үзэлтэн, Тувагийн Ардын Хувьсгалт Намын ерөнхий нарийн бичгийн дарга С.Того (С.Тока) бас л зөвлөлтийн холбогдох байгууллагуудын дэмжлэгтэйгээр зохион байгуулж байсан. Нөгөө л Фриновский “хувьсгалын эсрэг хуйвалдаанд оролцогчдын нэрсийн жагсаалт”-аа Тувад ч ашигласан. Тэнд мөн л японы империалистуудын талд ажилласан гэх мэт хэргээр яллаж байсан<sup>26</sup>.

МАХН шашны эсрэг бодлогыг зөвхөн “их хэлмэгдүүлэлт”-ийн үед хэрэгжүүлж байгаагүй гэдгийг тэмдэглэн хэлэх нь зүйтэй. Дээр хэлсэнчлэн энэ бодлогыг тухайн нам байгуулагдсан анхны жилүүдээс эхлэн баримталж ирсэн. Энэ бол Бүх Оросын К(б)Н болон Коминтернийг дагасны илрэл юм. Бүх Оросын К(б)Н болон Коминтернийн үзэл суртал коммунизм байсан. Коммунизмын нэг гол зорилго нь шашингүйн үзлийг дэлгэрүүлэх, шашныг устгах явдал байсан юм.

МАН өөрийн дэмжин туслагч байгууллага болох Коминтернд МАН-ын Төв Хорооноос 1921 оны 3 сарын 11-нд гаргасан хүсэлтийг үндэслэн нэгдэн орсон байдаг<sup>27</sup>. Коминтерн болон Бүх Оросын К(б)Н анхандаа хамтдаа БНМАУ-ын удирдлагын үйл ажиллагааг дэмжин тусалж байсан бөгөөд удалгүй энэхүү дэмжин туслах ажлыг Бүх Холбоотын К(б)Н дангаараа хэрэгжүүлэх болсон байдаг. Бүр 1924 оны 3 сард Ерөнхий сайд Б.Цэрэндорж “Засгийн газрын бүх үйл ажиллагаа НТХ-ны хяналтын дор явагдаж байна <...> Нам Коммунист Интернационалтай зорилго нэгтэй байна” гэж мэдэгдсэн байдаг<sup>28</sup>. Энэ нь ямар зорилго юм бол?

1924 оны 6 сард Коминтернийн V конгресс хуралдсан. Эндээс гарсан баримт бичгүүдэд Коминтерний бүх секцийг большевикжуулах тухай заалт байсан<sup>29</sup>. Коминтерний VI конгресс 1928 оны 9 сарын 1-нд хуралдаж, хөтөлбөр батласан. Бүх дэлхийн эцсийн зорилго бол коммунизм байгуулах, хувийн өмчийг халах, шашныг үндсээр нь устгах явдал гэж тунхаглан зарласан<sup>30</sup>.

Монгол оронд буддын сүм хийд өндөр нэр хүндтэй байсан. Тиймээс МАХН-ын хувьд энэ нэр хүндийг нь унагаж, өөрийн нэр хүндийг өсгөх шаардлага гарсан. МАХН-ын удирдлагын гол зорилго нь Монголын тусгаар тогтнол байсан. Тухайн үед Монголын тусгаар тогтнолын ганц баталгаа нь ЗХУ байсан. Тусгаар тогтнолынхоо төлөө төлөх төлөөс нь сүм хийдээ устгах явдал болсон. Гэхдээ үүнтэй төстэй

25 Цыжилов, 2006, с. 134; Синицын, 2013, с. 103–110, 123, 198–204.

26 Саая, Сат, 2009, с. 63–65.

27 Рошин, 1999, с. 35–37, 51.

28 РГАСПИ, ф. 495, оп. 152, д. 29, л. 63–92.

29 Пятый..., 1925, с. 47–52.

30 Программа и устав..., 1932, с. 56–119.

буддын шашныг бут цохих ажил Хятадын түрэмгийллийн үеэр Түвд улсад өрнөсөн боловч түүний үнэ цэнэ нь өөрийн тусгаар тогтнолоо алдаж, коммунист Хятадад эзлэгдсэн явдал болсон гэдгийг энд тэмдэглэх нь зүйтэй. ЗСБНХУ Монголыг хэзээ ч эзлэн түрэмгийлж байгаагүй, түүнийг өөрийн бүрэлдэхүүнд оруулахыг хэзээ ч санаархаж байгаагүй юм. ЗСБНХУ болон БНМАУ-д шашныг бут цохих ажлыг улаан намынхан ижил төстэй схемээр, хоёр орны ард түмний хүсэл зоригоос гадуур үйлдсэн юм.

Эндээс ямар практик дүгнэлт хийж болох вэ?

1) Тухайн үед МАХН-ын засаглал дор байсан төрөөс сүйтгэсэн шашныг дахин сэргээх ажилд төрөөс дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна. Монголын уламжлалт шашин болох буддын шашныг одоо төрийн зүгээс албан ёсоор дэмжин ажиллах нь маш чухал байна. Монголын шашны объект, мөн Монголын түүх, соёлын чухал дурсгал болох эвдэрч сүйрсэн сүм хийдийг сэргээн босгоход зориулж төр засгаас хөрөнгө төсөвлөж байх ёстой.

Өнөөгийн Орос оронд үнэн алдартны шашин (православие), лалын шашин (ислам), буддын шашин (буддизм), иудын шашин (еврейн шашин, иудизм)-ийг улс орны уламжлалт шашин гэж албан ёсоор хүлээн зөвшөөрсөн байгаа. Төр засаг юуны түрүүнд Москвагийн эцгийн эрхт ёсны үнэн алдартны шашныг дахин сэргээхэд тус дэм үзүүлж байна. Үнэн алдартны сүм хийдийг эрчимтэй сэргээн засварлах, шинээр барьж байгуулах ажил төр засгийн дэмжлэгтэйгээр явагдаж байна. Төв телевизэд үнэн алдартны шашны бие даасан сувагтай болсон. Өөр бусад ажлууд ч бас хийгдэж байна. Бүр БНХАУ-д ч төр засаг нь эвдэж сүйтгэсэн буддын сүм хийдээ сэргээн засварлахад зориулж тодорхой хэмжээний төсөв хөрөнгө гаргадаг болоод байна.

2) Түүхийн шударга ёсыг сэргээж, 1932 оны ардын бослогод оролцсон бүх хүнийг цагаатгах хэрэгтэй. Тухайн үед хүмүүс монголын ард түмний хүсэл зоригийн төлөө бус, харин зөвхөн БХК(б)Н болон Коминтернийн удирдлагын санаанд нийцсэн бодлого хэрэгжүүлж ирсэн засаг төрд нөлөөлөхийн тулд зэвсэгт бослого өрнүүлэхээс өөр аргагүй байсан юм. Энэ бослогын жинхэнэ буруутан нь МАХН, БХК(б) Н, мөн Коминтерн байсан юм. Тэр үеийн гажуудлын хариуцлагыг эд л үүрэх ёстой. Үүнийгээ албан ёсоор хүлээн зөвшөөрөх ч ёстой.

## Ном зүй

- АВПРФ — Архив внешней политики Российской федерации, Москва.
- Девятый съезд Монгольской Народно-Революционной Партии (28 сентября–5 октября 1934 г.). 1934. Улан-Батор.
- Доклад И.В. Сталина на февральско-мартовском Пленуме ЦК ВКП(б) 3 марта 1937 г. 1995 () Вопр. истории. № 3. - <http://istmat.info/node/29839>.
- Кузьмин С.Л. 2015. Западно-монгольское восстание 1930 г. в защиту религии () Религиоведение. № 1.
- Кузьмин С.Л. 2016. Теократическая государственность и буддийская церковь Монголии в начале XX века. Москва.
- Кузьмин С.Л., Оюунчимэг Ж. 2014. Социализмын эсрэг 1932 оны Монгол дахь бослого. Улаанбаатар.
- Монголын сүм хийдийн түүхэн товчоон. 2009. Улаанбаатар.
- Монгольское законодательство. Выпуск. 1. Основной закон и приложения. 1928. Улан-Батор-хото.
- Монгуш М.В. 2001. История буддизма в Туве (вторая половина VI – конец XX в.). Новосибирск: Наука. — [http://www.fidel-kastro.ru/religia/bud\\_tuva.htm](http://www.fidel-kastro.ru/religia/bud_tuva.htm)
- МУУТА — Монгол Улсын Үндэсний төв архив, МБТ — МАН-ын баримтын төв, Улаанбаатар.
- Программа и устав Коммунистического интернационала. Издание 2. 1932. Москва.
- Пүрэвжав С., Дашжамц Д. 1965. БНМАУ-д сум, хийд, лам нарын асуудлыг шийдвэрлэсэн нь. 1921–1940 он. Улаанбаатар.
- Пятый Всемирный конгресс Коммунистического интернационала. 17 июня – 8 июля 1924 г. Стенографический отчет. Часть 2. Приложения. 1925. Москва – Ленинград.
- Раднаев Г.Ц. 2013. Политические репрессии в Янгажинском дацане “Даши Шарбублинг” () Вестник Бурятского государственного университета. Вып. 7 (история).
- РГАСПИ — Российский государственный архив социальной и политической истории, Москва.
- РГВА — Российский государственный военный архив, Москва.

- Рошин С.К. 1999. Политическая история Монголии (1921–1940 гг.). Москва.
- Саая С.В., Сат С.Ч. 2009. Причины политических репрессий в Тувинской Народной Республике в 1930–1940 гг. () Вестник Тывинского государственного университета. Вып. 1.
- Симуков А.Д. 2008. Труды о Монголии и для Монголии. Т. 1. Осака.
- Сеницын Ф.Л. 2013. Красная буря. Советское государство и буддизм в 1917–1946 гг. Санкт-Петербург.
- Улс төрийн хэлмэгдэгсдийн Цагаан Ном. 2010–2013. Боть 1, 2010; Боть 2, 2012; Боть 3, 2013. Улаанбаатар. — <http://tsauzbuk.mn>.
- ЦАФСБ — Центральный архив ФСБ России, Москва.
- Цыжипов Э.Б. 2006. История политических репрессий в Бурят-Монголии. 1928–июнь 1941 г. Кандидатская диссертация. Улан-Удэ.
- Kaplonski Ch. 2014. The Lama Question. Violence, Sovereignty, and Exception in Early Socialist Mongolia. Honolulu.

## УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ



*Р.Мөнхтариа  
УЕП-ын газарт цагаатгал хариуцан  
хяналтын прокуророор ажиллаж  
байсан судлаач, хуульч*

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль нь Монгол улсын нутаг дэвсгэрт улс төрийн хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгаж нэр төрийг нь сэргээх, тэдэнд нэг удаагийн нөхөх олговор олгох, улс төрийн хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаварыг арилгахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ хуулийн зорилт оршиж байгаа юмаа.

Хуулийн 2-р зүйлд заахдаа: Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль тогтоомж нь Монгол улсын Үндсэн хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ гэж заасан байдаг. Илтгэлийн сэдэвтэй холбогдуулан бусад хууль тогтоомжуудтай хэрхэн холбогдож байгааг тайлбарлаж ярих нь зүйтэй.

Аливаа салбар хуулиудын үндсэн эх сурвалж нь тухайн улсын Үндсэн хууль байдаг болохоор дээрх хууль бол Монгол Улсын Үндсэн хуультай нягт холбоотой юм. "Улс төрийн хэлмэгдүүлэлт" гэдэг нь хүнийг нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан нам, төр, нийгэмд аюултай этгээд гэж тооцож, улс төрийн буюу төрийн эсрэг гэх мэт хэрэгт хууль бусаар холбогдуулж байжээ.

Эдгээр хэргүүдийг Тусгай, Онцгой Бүрэн Эрхэт комиссын болон нам төрийн, бусад байгууллагын шийдвэрээр баривчилан мөрдөх, эрүүгийн ял шийтгэл хүлээлгэж, ял эдлүүлэх, шүүхээс гадуур нутаг зааж суулгах, хууль бусаар эрх, эрх чөлөөг нь хязгаарлах, хасах замаар амь нас, эрүүл мэнд, нэр төр, сэтгэл санаанд төдийгүй эд хөрөнгийн хохирлыг давхар учруулж байснаараа хамгийн хор нөлөөтэй юм.



Хэлмэгдэгчдийг зохиомол хэрэг, гүтгэлэгт үндэслэсэн, албадлагын арга хэмжээг амь настай нь тэнцүүлэн авч байсан байдаг юм. Энэ утгаар нь авч үзэхэд хилс хэрэгт хэлмэгдэгчид гэсэн нэгэн нэр томьёо зайлшгүй гарч ирсэн байна.

Манай улсын Үндсэн хуульд заахдаа: Хүнийг нийгмийн гарал байдал, яс үндэс, шашин шүтлэг, үзэл бодлоор нь тэгш байх тухай, эрх, эрх чөлөөг зөрчиж болохгүй тухай заасан байхад улс төрийн хилс, хэрэгт ялгаварлан үзэж, дураараа баривчилах, хорьж цагдах эрүүдэн шүүж, бие махбодь, санаа сэтгэл зүйгээр нь дарамтлан гүтгэж, хийгээгүй хэргийг хүчээр хүлээлгэх зэргээр Үндсэн хуулийн заалтуудыг ноцтой зөрчсөн нь олон мянган хүмүүсийг улс төрийн хилс хэрэгт хэлмэгдүүлэх гол үндэслэл болсон байна гэж үзэж болох юм.

Мөн шүүн таслах эрхийг гагцхүү шүүх гүйцэтгэх ёстой байтал түүний эрхийг ДЯЯ-ны Комиссууд гүйцэтгэснээрээ тухайн үеийн Эрүүгийн хууль, Аливаа хэргүүдийг байцаах, шийтгэх тухай хуулийн заалтуудыг бүрмөсөн орхигдуулсан байдаг. Энэ талаар товч дурдахын учир гэвэл: улс төрийн хэрэг гэдэг нэр томьёог тухайн үед Эрүүгийн хуульд заасан боловч уг хуулийг зөрчиж, буруу хэрэглэсэн асуудал юм.

Одоогийн мөрдөж байгаа Цагаатгалын хууль бол дээрх зөрчил дутагдал бүхий хэргүүдийг хэрхэн шийдвэрлэх талаар нилээд нарийн заалтуудыг Шүүх, Прокурор, Тагнуулын ерөнхий газруудын тус тус гүйцэтгэдэг үүргийг харгалзан ялгавартай зааж өгсөн байна.

Тухайлбал: Шүүх болон Тусгай комисс, Онцгой Бүрэн Эрхэт комиссын хурлаар ял шийтгүүлсэн улс төрийн хэлмэгдэгчдийн талаарх нэхэмжлэлийн өргөдлийг шүүх хүлээн авч шийдвэрлэх, мөн тэдний хэргүүдийг Улсын Дээд Шүүхийн Хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэдэг юм. Гэхдээ хяналтын шатны шүүх хуралдаан уг хэргийг хэлэлцэж шийдвэрлэхдээ Прокурорын байгууллагаас цагаатгуулахаар бичсэн дүгнэлтийг үндэслэж хэргийг хэлэлцэж шийдвэрлэдэг. Прокурорын байгууллага нь баривчилагдаж, мөрдөгдсөн боловч шүүх, болон эрх бүхий комиссуудаар шийтгүүлсэн нь тодорхой бус, мөн баривчлагдаж яваад сураггүй болсон гэх мэтийн, нэхэмжлэлээр, ЭБШХ-нд заасан шинээр илэрсэн нөхцөл байдал гэж үзээд эрүүгийн хэрэг үүсгэж, ТЕГ-ын Мөрдөн байцаах хэлтэст өргөдөл материалыг шилжүүлэн мөрдөн байцаалтын ажиллагааг хийлгүүлдэг. Тагнуулын Ерөнхий Газар нь прокурорын тогтоолын дагуу мөрдөн байцаалтыг хийж дуусгаад хэргийг хэрхэн шийдвэрлэх тухай мөрдөн байцаагч саналтайгаа хамт хэргийг прокурорт хүргүүлдэг.

Прокурор хэргийг хянаж үзээд хэрэв улс төрийн хэрэгт хилсээр баривчилагдсан, мөрдөгдсөн нь нотлох баримтаар тогтоогдсон байвал

прокурорын тогтоолоор хэлмэгдсэнд тооцож цагаатгадаг юм.

Энэ бүх үйл ажиллагааг хэдийгээр Цагаатгалын хуулинд заасан байдаг боловч Шүүх, Прокурор, Тагнуулын Ерөнхий Газар нь Монгол Улсын Эрүүгийн Байцаан шийтгэх хуулийн заалтуудыг баримтлаж ажилладаг.

МУ-ын Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулинд 1922 оноос эхлээд 1926 оны Шүүх Цаазын Бичиг хүртэлх хугацаанд эрүүгийн ял шийтгэлийн талаарх Ардын Засгийн газрын тогтоолууд, 1926, 1929 оны нэмэлт бүхий 1934 оны Шүүх Цаазын Бичиг, 1942, 1961 оны Эрүүгийн хуулиудад цагаатгалд хамаарах Зүйл хэсгүүдийг нь тусгайлан заасан байдаг юм. Эдгээр заалтууд нь улс төрийн хэргүүдийн тухай заалтууд байдаг юм.

Өөрөөр хэлвэл Шүүх, Прокурор, Тагнуулын Ерөнхий газар нь хуульд заасан тодорхой хэсэг хэргүүдийг мөрдөн шалгаж, хянаж, нотлох баримтыг нь үндэслэж шийдвэрлэж байна. Эдгээр бүх үйл ажиллагаа нь Эрүүгийн болон Иргэний эрх зүйн хүрээнд хийж гүйцэтгэдэг учраас Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгаж байгаа хууль зүйн үндэслэл юм гэсэн дүгнэлт хийж болно.

### Ном зүй

1. 1929 оны шүүх цаазын бичгийн ерөнхий ангийн 1-4 дүгээр заалт.
2. Аливаа эрүүгийн хэргийн байцаан шийтгэх хууль 1929 он.
3. МУ-ын 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 357 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

## УЛС ТӨРИЙН ХЭРЭГ ЯВДАЛ БА МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ СОЁЛ (1935-1955 ОН)



*Б.Пунсалдулам  
Доктор (Ph.D), Профессор  
ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн*

Энэ удаагийн илтгэлд, 1935-1955 оны үеийн Монголын үндэсний соёлын хөгжилд нөлөөлсөн дотоод гадаад хүчин зүйл, улс төр, үзэл суртлын ямар нөлөө тусаж байсныг тодруулахыг зорив. Үүний тулд нэгдүгээрт, Монголын үндэсний соёлын дотоод бүтцийг тодруулах, хоёрдугаарт XX зууны Монголын үндэсний соёлын хөгжлийн туулж ирсэн замналыг тодорхой шалгуур үндэслэлийн дагуу үечлэн авч үзэхийг хичээлээ.

Монголын үндэсний соёл дотоод нарийн бүтэц тогтолцоотой. Энэхүү соёл нь язгуур, уламжлалт, шинэ соёлын нарийн нийлмэл юм. Учир нь цэвэр иргэншил, соёл байдаггүй байна. Тэрээр хувьсан хөгжихдөө харь буюу гадаад зүйлсээр баяжихын хамт өөрийн соёлын элемент зүйлийг ч өгөх харилцаанд оршдог байна. Соёлд хил хязгаар үйлчилдэггүй ажээ.

Монголын үндэсний соёлын дээрх нарийн бүтэц тогтолцоо нь өөрийгөө хамгаалж, оршин амьдрах нэг ёсны дархлалын механизм болж иржээ. Хэрэв гадны буюу бусдын соёлоос өөртөө хэрэгтэйг хүлээн авч, тэр нь амьдрал, цаг хугацааны шалгуурыг даван уламжлалт соёл болон өөриймших процесс явагдаж, олон өнгө аяс хэлбэр төрхөөр баяжихгүй бол малчдын язгуур соёл дангаараа эрин цагийн урт удаан алхаанд сульдан хоцрох болно. Гадны соёлоос зарим зүйлийг авч өөриймшүүлэх нь язгуур соёлыг баяжуулж, амьдрах чадварыг нэмэгдүүлэхийн хамт түүний үндсэн гол мөн чанарыг улам бүр батжуулж тодруулдаг байна.

Монголчуудын олон мянган жилийн туршид эрхлэж ирсэн нүүдлийн МАА нь тэдний язгуур соёлын үндсийг бүрдүүлнэ. Төв

Азийн өндөрлөгт орших Монголчууд нүүдлийн мал аж ахуй эрхлэн хөтлөх амьдралын арга замыг сонгосон нь санаан зоргоороо сайн дурын хэрэг биш байв. Монгол орны бүс нутгийн байгаль газар зүйн өвөрмөц байдал мал аж ахуйн нүүдлэн амьдрах хэлбэрийг тогтоожээ. Монголын тал хээр нутгийн цаг агаар, салхи хур тунадасын хэмжээ, хөрсний бүтэц, усны нөөц, ургамлын бүрхэвч зэрэг олон хүчин зүйл газар тариалан эрхлэн суурин аж төрөх боломжийг өгөөгүй байна. Харин энэ бүс нутагт нүүдлийн мал аж ахуй эрхлэн хөтлөх хамгийн боломжтой газар байжээ.

Нүүдлийн мал аж ахуй НТӨ II мянганы I хагасаас үүсч, хүрлийн хожуу үед үйлдвэрлэх аж ахуйд шилжин, мал аж ахуй дээр суурилсан эдийн засгийн үндэс бүрэн тавигджээ. Алтайгаас Хэнтийн нуруу хүртэл орших хиргисүүр, буган хөшөөний соёл, Өвөр Байгалийн зүүн хэсэг дэх дворцовын соёл, говь, тал хээрийн бүсэд түрүүлэг нь харуулан оршуулдаг соёлынхны дунд мал аж ахуй хэдийнээ эдийн засгийн үндэс суурь болсныг эртний түүхийн судлаачид, археологичид хэдийнээ баталсан билээ<sup>1</sup>. Ялангуяа хиргисүүр, буган хөшөөний соёлын тархалтын хүрээ, асар том цогцолбор дурсгалууд нь зөвхөн мал аж ахуй дээр суурилсан нарийн төвөгтэй нийгмийн бүтэц, зохион байгуулалттай овог аймгуудын дурсгал мөнөөс гадна оршуулгын зан үйлд мал аж ахуйн соёлын хэв шинж хурц тод илэрч байдаг. Өөрөөр хэлбэл хиргисүүр, буган хөшөөний соёлынхонд бэлчээрийн мал аж ахуй хөгжжээ.

НТӨ IV мянган жилийн үеэс цаг агаарын ихээхэн өөрчлөлт гарч, эх газрын шинжтэй, хуурай болж эхэлсэн нь Евразийн тал нутагт малчдын онцгой соёл, нүүдэллэхүй ёс хөгжин дэлгэрэхэд хүргэжээ. Нүүдэлчид адуу, үхэр, тэмээг уналга, тээвэрт өргөн ашиглах болсноор хөдөлгөөнт чанарыг хангаж, нийгэм эдийн засгийн хөгжилд ахиц гаргаж, арилжаа солилцоо дэлгэрэн хөгжих боломжийг нээжээ. Нүүдэлчин малчид алс хол нүүдэллэн бэлчээр нутаг шилж сонгох, арилжаа, наймаа хийх зэргээр хөршүүдтэйгээ харилцаа өргөжин тэлснээр соёлын тархалт, нийтлэгжилт хүчтэй явагджээ. Соёлуудын нөлөө ямагт харилцан нөлөөлөл байдаг. Үүний үр дүнд хиргисүүр, буган хөшөө, дөрвөлжин булшны соёл зэрэг асар өргөн уудам нутагт тархсан археологийн нэгдмэл соёл бүрэлдэн тогтсон байна.

Нүүдэлчдийн дунд нийгмийн давхраажлын ялгаа хүчтэй явагдаж, улмаар төмрийн түрүү үе гэхэд аймгийн холбоод, төрийн бүрдлүүд байгуулагдаж, зохион байгуулалтын шинэ харилцааны үндэс суурь тавигджээ. Эртний Монголын газар нутаг дээр төр улс үүсэн хөгжиж, Хүннү, Сяньби, Жужан, Түрэг, Уйгар, Кидан, Монгол зэрэг янз бүрийн нүүдэлчин ард түмний төр улсын анхны бүрдлүүд ээлж дараалан оршин тогтнож байв. Эдгээр төр улс цэцэглэн хөгжих

<sup>1</sup> П.Дэлгэржаргал, З.Батсайхан. Хүннү Монголын эртний түүх. Тэргүүн боть. УБ.,2017.т.187/

бүрдээ байнга нийслэлээ сольдог, улмаар хотын соёлыг хөгжүүлж, янз бүрийн бичиг үсэг ашиглаж, бусад салбар дахь өмнөх үеийнхнийхээ туршлагыг өвлөн авч хөгжүүлдэг байжээ.

Монголчуудын нүүдлийн МАА хүн амын өдөр тутмын хэрэгцээг хангах “таван хошуу мал” хэмээх хамгийн оновчтой бүтцийг олж чадсан байна. Энэ бүтэц нь бие биенээ нөхсөн, өөр өөрийн үүрэг бүхий салгахын аргагүй нүүдлийн аж ахуйн үндсийг бүрдүүлж байв. Үүний зэрэгцээ нүүдлийн бэлчээрийн аж ахуй өөрийн нэг онцлог нь байгаль орчинд ямар ч сөрөг нөлөөгүй байдаг нь газар нутаг олон мянган жилийн туршид унаган төрхөө хадгалсаар байдаг байна.

Дээрх бэлчээрийн нүүдлийн мал аж ахуй Монгол нутагт оршин суугчдын ахуй амьдрал, аж төрөх ёс, нийгэм соёлын хөгжилд үлэмж нөлөө тусгалаа үзүүлжээ. Аж ахуйн хэлбэрийн энэ нөхцөлд монголчуудын бүтээж, хөгжүүлж ирсэн оюуны танин мэдэхүй, мэдлэг ухаан, ёс заншил, зан суртахуун, гоо сайхны өвөрмөц сэтгэлгээ, ардын аман болон бичгийн уран зохиол, үлгэр туульс, ерөөл магтаал, ардын дуу хөгжим, бүжиг, бий биелгээ, эрийн гурван наадам, хуур, хөөмий, төрт ёсны монгол уламжлал болон материаллаг эд өлгийн олон зүйлийг язгуур соёл хэмээн ойлгоно. Энэхүү язгуур соёл нь Монголын үндэсний соёлын ноён нуруу, суурь дэвсгэр юм. Түүхийн бүх цаг үеийн туршид язгуур соёл, өөрийн мөн чанараа хадгалан, тэлэн баяжиж хөгжсөөр иржээ.

Монголчуудын эдийн соёлд орон сууц, хувцас хунар, хоол, хүнсийг хамруулан ойлгодог. Энэ хэдийгээр эд өлгийн зүйл мэт боловч хэрэг дээрээ хүний оюун ухаан, танин мэдэхүй, ёс заншил, сүсэг бишрэл, гоо сайхан, үзэл баримтлалын илэрхийлэл, үндэсний хэв маяг, технологийг агуулсан байдаг. Олон зуун жилийн туршид монголчуудын бүтээж боловсруулж, хөгжүүлж ирсэн орон сууц, гэр хувцас хунар эдлэл хэрэгсэл нь зөөж тээвэрлэхэд хөнгөн, олон дахин буулгах, задлах, угсрахад гарын ая даахуйц баг бөх, мөн цаг уурын янз бүрийн нөхцөлд, чийг дулааны хэлбэлзэлд өнгө чанараа алдахгүй байх, олон хувилбараар ашиглаж болох онцлогтой байдаг.

Эдгээрээс зөвхөн монгол гэрийн тухай цухас авч үзье. Монголчууд эсгий гэр хэмээх сууцыг бүр Хүннүгийн үед зохион бүтээж хэрэглэж байжээ. (Монгол, Орос, Германы археологчидын судалгааны баг 2004-2006 онд Баян Өлгий аймгийн Улаан Хус сумын нутагт орших 3000-аад жилийн өмнөх үед хамаарах булшинд хийсэн малтлагаараа тэр үеийн хүмүүс малгай, гутал зэрэг эсгий эдлэл хэрэглэж байсныг олж илрүүлжээ. Мөн хятадын эртний сурвалж бичигт Хүннү буюу эртний монголчуудын эсгий сууцыг өндөр гэр, бөмбөгөр гэр гэсэн хоёр хэлбэртэй хэмээн тэмдэглэжээ. Энэ хоёр хэлбэрийн эсгий гэр түүхийн урт удаан хугацаанд үндсэн төрхөө өнөөгийн хасаг ба монгол гэрт

уламжлан хадгалжээ. Гэр сууц бол монгол хүний оюун сэтгэлгээний гайхамшигт ололт мөн. Монгол гэр цөөн хүн тэрч байтугай ганц хүн ч богино хугацаанд задалж, угсарч болдог, өвөл зун, халуун хүйтэн чийглэг хуурай ямар ч нөхцөлд тохируулан хэлбэр дүрс, бүтэц бүрэлдэхүүнийг өөрчлөн олон зориулалтаар ашиглаж болдог, агаарын солилцоо, гэрлийн тусгал гойд сайн, хүний эрүүл ахуйн шаардлагыг хангасан, төмөр металл хийц мэт хүнд зүйлийг оруулаагүй зөвхөн хуурай мод, эсгий хоёроос бүрдэх тул хөнгөн авсаархан. Монгол гэрийн доторх орон зайг төв голомт, бурхан тахилын, ор дэр, эдлэл тавилгын орон гэсэн үндсэн бүсүүдэд хуваан үзэж тэдгээрийн дотроос онгон шүтээнээ байрлуулдаг хоймор, гал голомтын орон болсон төв хэсгийг онцгой хүндэтгэн үздэг байна. Монгол уран барилгын үндсэн загвар нь гэр хэлбэр юм.

Монголчуудын уламжлалт соёл хэмээх ойлголтод түүхийн урт удаан хугацааны туршид эдийн засгийн хөгжилд гарсан ахиц, арилжаа солилцоо, нийгмийн болон улс төрийн харилцааны явцад бусад ард түмний соёлын нөлөө тусаж зарим нэг зүйл нь нүүдлийн мал аж ахуйн хэлбэрт уусан өөриймсөх нэвтрэлцэх, бас устан солигдох зэрэг олон талын харилцааг ойлгож байна.

Эртний Монголын газар нутаг дээр төр үүсэн хөгжиж, нүүдэлчин ард түмнүүдийн төр улс солигдон оршин тогтнохын зэрэгцээ Уйгар, Түрэг, Перс, Хятад, Энэтхэг, Төвд, Манж, Дундад Ази болон Орос, Европын олон улс орнуудаас түүхийн янз бүрийн хугацаанд монголын ахуй амьдралд нэвтэрсэн соёлын харилцаа хөгжлийн явцад өөрийшиж, идээшин дассан байдаг. Жишээлбэл, буддын соёл, худам монгол бичиг, энэтхэг, түвд, хятадын утга зохиол, урлагийн зарим дэг сургууль, монгол үгсийн санд шингэсэн үг хэллэг, нэр томьёо, аж төрөх ёсны хувьд адил төсөөтэй манж, түвд зэрэг үндэстний эд өлгийн зарим зүйлс, хэлбэр хийц зэргийг оруулна. Эдгээр нь эхэндээ олдмол соёлын хэлбэртэй байснаа нүүдлийн иргэншлийн нөхцөлд идээшин манай ард түмний язгуур соёлтой нэвчин уусаж, уламжлалт соёлын нэг хэсэг болон хувирчээ.

Шинэ соёл буюу шинжлэх ухаан жинхэнэ утгаараа Өрнөдөд 1543 оноос (Николай Коперникийн ном хэвлэгдсэнээр шинжлэх ухааны хөгжлийн орчин үеийн агуулга тавигджээ. Улмаар Кеплер, Ньютоны нээлтүүд гарчээ.) хөгжиж, XX зууны эхэн гэхэд шинжлэх ухаан техникийн хоёр дахь хувьсгал (квант ба харьцангуй онол-Макс Планк 1908 онд, Альберт Эйнштейн) гарч, үйлдвэрлэлд нэвтэрч, улмаар хөгжлийн дараах үедээ орсон байв. Энэ боловсрол, шинжлэх ухааны мэдлэг буюу “Шинэ соёл”-ыг нэвтрүүлэх, хөгжүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх шаардлага тавигдсан байна. Шинэ соёл хэмээх ухагдахуун нийгэм, соёлыг өргөн хүрээнд шинэчлэл хийхийг ойлгож

байв. Үүний гол цөм нь боловсрол, шинжлэх ухааныг хөгжүүлэх, оюуны үйлдвэрлэлийг шинэ шатанд гаргах асуудал юм. Шинэ соёлыг Монгол оронд нэвтрүүлэх, хөгжүүлэх ажлын эхлэл бичиг үл мэдэх явдлыг устгахын төлөө явуулсан кампанит ажил байв Энэ нь Монголын нийгмийн оюун санааны хүрээнд ноёрхож байсан шашны үзэл суртал, ёс суртахууныг даван туулах, орчин цагийн иргэний боловсролыг системтэйгээр хөгжүүлэх, үндэсний мэргэжилтэй боловсон хүчнийг бий болгох, шинжлэх ухаан техникийн ололт амжилтыг нэвтрүүлэх, аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх, нүүдлийн мал аж ахуйг эрчимжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зэрэг өргөн утгыг агуулж байв. Шинэ соёлыг төлөвшүүлсэн үе шат нь Монголын оршин буй нийгмийн харилцааны шинж чанараас хамааран тавьсан зорилго, хэрэгжүүлсэн арга барилаар ялгагдаж байв.

Өнгөрөгч XX зууны Монголын үндэсний соёлын уламжлал, шинэчлэлийн түүхийг эргэн харахад үндсэн гурван үед хуваан дотор нь нарийвчлан харж учир шалтгааныг тодруулж болохоор байна. Үүнд:

1. XX зууны эхнээс 1930 оны дунд үе хүртэлх,
2. 1935 оноос 1950-иад оны дунд үе,
3. 1955 оноос хойшх.

Эхний хэсгийг Монголын үндэсний соёлын уламжлал шинэчлэлийн үе, удаахыг Шинэ нийгэм байгуулах үеийн Монголын үндэсний соёл, гурав дахь хэсгийг Үндэсний соёлын сэргэлтийн үе хэмээн нэрлэж байна.

Бидний ангилалын Шинэ нийгэм байгуулах үеийн буюу 1935-1955 оны үеийн Монголын үндэсний соёлын хөгжлийн явцын түүхийг эргэн харахад энэ үед монголчуудын уламжлалт соёл буюу шашин шүтлэг, бичиг үсэг түүнтэй холбоотой ном судар, сүм хийд, бусад ховор нандин өв дурсгал илүүтэй өртсөн байна.

Нэг хүнийг тахин шүтэх үеийн хэлмэгдүүлэлтийн хурц үзүүр тухайн үеийн монголын оюун санааны хөгжлийн оргил болж байсан шашны боловсрол мэдлэгт нэвтэрсэн, үндэсний эрх ашиг, тусгаар тогнолын төлөө санаа зовнидог тэргүүний дэвшилт хүмүүс эхлэн өртөж, улс орныг хамарсан байна. Энэ хэлмэгдүүлэлт монголын тэргүүний үзэл бодол, оюун санааны эсрэг балмад үйл ажиллагаа байв. Улс төрийн хэлмэгдүүлэлтэд олон хүмүүсийн амь нас амьдрал хохирохын хамт тэдний хийсэн бүтээсэн оюуны бүтээлийг ч хамт сүйтгэжээ. Энэ хүрээнд зөвхөн монголын уламжлалт соёлын үнэт өв сүйдэж устгахын хамт шинэ соёлын зарим зүйл эзнийхээ хамт устгагдаж дарагджээ.



Бурхан шашны сүм, хийд түүхийн дурсгалыг зөвхөн улс төрийн хэлмэгдлийн үед устгаагүй юм. Энэ нь улс төрийн хэлмэгдүүлэлтээс ч өмнө бас хойно ч гарч байсан сөрөг үзэгдэл юм. Монголын соёлын үнэт зүйлс ном, судар, урлагийн бүтээлүүдийг шашны бурангуй ёс, суртлын үлдэгдэл хэмээн устгах ажил VIII Богдын хөрөнгийг хураах ажлаас эхлэн үүсэж цаашдаа даамжиран монголын түүх соёлын олон дурсгал сүм хийд, уран барилга, ном судар, урлагийн бүтээлүүд эвдэрхий нуранги болон устжээ.

Энэхүү түүх соёлын дурсгалд хайр гамгүй хандаж үрэж үрэгдүүлэх балмад үйл ажиллагаанд улс төрийн харалган бодлого, гадны хүчин зүйл, боловсрол мэдлэг нимгэн байдал, амин хувиа хичээсэн харалган зан зэрэг олон зүйл нөлөөлжээ. Улс төрийн харалган бодлогын үрээр хориод оны дундуур хил хязгаарт ойрхон оршдог гэдгээр шалтаглан Халхын сүмийг хааж лам нарыг нь хошуу нутгийн гүнд шилжүүлэн гэрийн хурал байгуулжээ. Дараа нь уг сүмийг дайсны түшиц газар болохоос сэрэмжлэх нэрийдлээр нурааж газартай нь тэгшилсэн байна. Энэ тухайд манай нэрт дипломатч Б.Жаргалсайхан гуай “Тэгэхээр Халхын сүм бол Монголын олон мянган сүм хийдээс хамгийн түрүүнд устгагдсан газар болжээ. Бусад улс орон хилийн тус газраа хамгаалахын тулд аль болохоор түүнийгээ эдлэж эзэмшиж, тэр орчинд нь суурин гацаа байгуулдаг юм билээ. Гэтэл байж байсан сав нурааж хилийн бүс нутгаа эзгүйрүүлж хаядаг нь хаанахын ном байж таарах бэ?”<sup>2</sup> хэмээн гайхшран дурсжээ.

МАХН-ын IX их хурлын дараагаар түүний шийдвэрийг биелүүлэх ажлын хүрээнд 1935 онд уран сайхны улс төрийн зөвлөлийг Сайд нарын Зөвлөлийн дэргэд байгуулжээ. Уг зөвлөлийн анхны даргаар М.Ядамсүрэнг томилжээ. 1935 оны 3 сарын 8-ны өдрийн Ардын Сайд нарын зөвлөлийн IX хурлаар “Уран сайхны улс төрийн зөвлөлийн дүрэм”-ийг баталжээ. Дүрэмд уран сайхны улс төрийн зөвлөлийн зорилго болбоос тус улсын үндэсний тусгаар тогтносон хувьсгалт засаг төрийг бататгаж, эзэрхэг түрэмгий ба феодалын бүхийлэн үлдэгдлүүдийг эсэргүүцэх, хувьсгалыг өрнүүлэх үндсэн зорилт дор ажиллаж, улмаар өөрийн улсын үндэсний уран сайхны явдлыг хувьсгалын журам чанартай бөгөөд үндэсний хэлбэр маягтайгаар олон нийт, ардын хүсэл шаардлага лугаа уялдуулан хөгжүүлэх явдлыг өөрийн гол зорилго болгоно<sup>3</sup> хэмээн заажээ. Мөн дүрэмд ямар ажил үүрэг гүйцэтгэхийг “улсын театрын уран сайхны талын бүхийлэн ажлыг шууд удирдаж, ажлын төлөвлөгөөг хянах, жүжгийн зохиолыг хянан батлах, хэрэв үл тохирох бол устган зогсоох, театрын дэргэд дуу хөгжмийн ба гар урлал, кино, радиогийн уран сайхны талын ажлыг шууд хянан батлах, ном зохиол ба орчуулгын бүх ажлыг хянан батлах эрхтэй болохыг заажээ.

2 Б.Жаргалсайхан. Алаг жарны бодрол.УБ.,2015.т.16

3 МАХН-аас урлаг-утга зохиолын талаар гаргасан тогтоол шийдвэрүүд (1921-1966) УБ.,1967.т.213

Ийнхүү 1930-аад оны дунд үеэс 1921 оны ардын хувьсгалаас хойш хэвлэгдсэн бүх ном зохиолыг шүүрдэн хянаж, дээр байгуулагдсан эрх бүхий байгууллагаас удирдан хувьсгалын эсэргүү хэрэг гэгчид холбогдуулсан хүмүүсийнхээ зохиол бүтээлийг хүчингүй хэмээн зарлаж, хурааж авах, устгах, тэдний нэр, зураг орсон бол баллах сохлох ажлыг зохион байгуулах комиссыг төв, орон нутаг, албан газруудад байрлуулан, дээрээс өгсөн тусгай даалгавар чиглэлийн дагуу ажиллуулжээ.

БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлөөс томилогдсон комисс 1935-1936 онд хилийн чанадад явж их хэмжээний зардал гарган хуурч Д.Түдэв, лимбэч Л.Цэрэндорж, дуучин М.Дугаржав зэрэг алдарт хүмүүсийн пьанзанд бичүүлж ирсэн ардын урт, богино дууны анх удаа ноотлож хийсэн ховор бичлэг, эмхэтгэлийг хянан үзээд 1938 оны 9 дүгээр сарын 15-нд тогтоол гаргажээ. Үүнд, Ардыг гэгээрүүлэх яамнаас эрхлэн пьанзанд бичүүлсэн нийт 58 дуунаас “Хувьсгалын эсэргүү” Д.Түдэвийн хуурдсан “Өвгөн шувуу”, “Эр бор харцага”, “Дөмөн”, “Уяхан замбуутив”, “Жавхлант сүрэг”, “Хэрлэнгийн барьяа”, “Урьхан хонгор салхи”, “Ар хөвч”, “Тунгалаг Тамир”, “Урт сайхан”, “Идэр жинчин”, “Түмэн эх”, “Дөрвөн цаг”, “Бараатын түмэн эх”, “Баян Монгол”, “Хандармаа”, “Цоохор морь”, “Сумъяа ноён”, “Үлэмжийн чанар”, “Дүүжий хуар”, “Ум зандан ширээ”, “Сандуйтай мод”, “Сүнжидмаа”, “Дүйнхор да лам”, “Говийн өндөр”, “Эхийн ач”, “Сийлэн бөөр”, “Цэвэр охин”, “Монгол транс” зэрэг 31 дуу, Л.Цэрэндоржийн хөгжимдсөн “Үхэрчин хүү”, “Алтан Богдын шил”, “Сэр сэр салхи”, “Аргагүй амраг”, “Гантөмөр”, “Янжуур тамхи”, “Дөрвөн цаг”, “Тоорой банди”, “Гуалин гоо”, “Цонхон дээр суусан ялаа” зэрэг 14 дуу бүгд 45 дууг нийтэд хэрэглэх, худалдахыг шууд хориглон устгахаар заасан байна<sup>4</sup>./С.Дашдондог. Жаран жилийн шаштир (Монголын орчин үеийн театр урын сангийн он дарааллын бичиг) I боть. УБ.,1996.т.97)

Ардын дуучин М.Дугаржавыг хувьсгалын эсэргүү хэмээн хилс хэрэгт баривчилснаас үүдэн түүний дуулсан ардын болон зохиолын дууны пьанзыг бүгдийг устган эвдлэн сүйтгэжээ. Түүний гар оролцон ноотлож хэвлүүлсэн “Самартай мод”, “Юндэн гөөгөө”, “Арван хоёр жил”, “Дүүжий хуар”, “Зуун лангийн жороо луус”, “Ванлий”, “Довчин унзад”, “Ай нанаа”, “Үзэсгэлэн гоо”, “Найгал гол”, “Амбан цэцэн хааны унага”, “Тэгш таван хүсэл”, “Очирдарь”, “Эрдэнэ галбар абасун” зэрэг олон дууг “феодалын ёст байдлыг сайшаасан болон хүсэмжилсэн эсэргүү нарын зохиосон дуу байгаа тул устгах”-аар уг комисс тогтоожээ. Тус комиссын шийдвэрийг СнЗ-ийн 1938 оны 12 сарын 8-ны өдрийн 245 тоот тогтоолоор сайшаан баталжээ<sup>5</sup>.

4 С.Дашдондог. Жаран жилийн шаштир (Монголын орчин үеийн театр урийн сангийн он дарааллын бичиг) I боть. УБ.,1996.т.97

5 С.Идшинноров. Бүтээлийн чуулган II. Дэд боть. Соёмбо ХХК.УБ.,2013. т.106

Тус комисс хувьсгалын эсэргүү нарын зохиосон, оролцсон зарим дуу, зохиол бүтээлийг устгах, хориглох шийдвэр гаргахын зэрэгцээ ард олны дунд алдаршсан “Түмэн эх”, “Урт сайхан хүрэн”, “Замбуу тив”, “Эрдэний сайхан”, “Хээр халтар” ардын дуунуудыг хувьсгалын үзэл суртлын зорилгодоо нийцүүлэн засаж засварлах ажил хийж, тусгайлан батлуулсны дараа дуулж болох зөвшөөрөл олгож “өршөөжээ. Ард олны хайртай “Эртний сайхан” хэмээх дууны шүлэг, үгийг хэрхэн засварласныг харвал:

Эртний сайхан ерөөлөөр  
Энэ Монгол оронд нь  
Эзэн Чингис хааныхаа  
Язгуураас бүрдвэй хэмээх бадгийг  
Эртний сайхан ерөөлөөр  
Энэ Монгол оронд нь  
Эрх чөлөөт улсын маань

Алдар туг бүрхэвээ хэмээн сольжээ. Гэсэн ч ард олон хайртай дууныхаа үг ая, шүлгийг цээжиндээ хадгалсаар өнөөг хүрсэн нь өв соёлоо хадгалж тээж ирсэн монголчуудын бахархалтай уламжлалын нэг ажээ. Үүнээс гадна ардын дууны үг аянд хувьсгалч үг шүлэг, бадаг оруулж дуулах болжээ. Тухайлбал, “Хулсан ташуур” дууны аянд “Монгол транс”, “Эргэнэ булгийн ус” дууны аянд “МОПР-ын дуу” тус тус хийжээ.

Монголд өрнөсөн улс төрийн хэлмэгдүүлэлтийн үед “ардын дайсан”-ы ул мөрийг оргүй арилгах хийрхэл дэгдэж, 1937 оны XI сарын 15-нд хуралдсан намын төв хорооны тэргүүлэгчдийн хурал “ардын дайснууд”-ын ном бүтээлүүдийг “шүүрдэн бүртгэж хураан авах ба цаашид хэрэглэгдэх улс төрийн дэвтэр зохиох” ажлыг хариуцсан комисс байгуулжээ. Энэ комиссын шийдвэрээр 1920, 1930-аад онд хэвлэгдсэн ном, товхимол, сэтгүүлийн бүртгэлийг нэг бүрчлэн гаргуулж, улс төрийн хэргээр баривчлагдсан, шийтгэгдсэн хүмүүсийн бүтээж туурвисан ном, зохиолыг хураах, шатаах, сэтгүүлд хэвдсэн өгүүллүүдийг хайчлах, нэр, зургийг нь баллах, сохлох ажил хийгджээ.

1938 оны хоёрдугаар сард Сайд нарын Зөвлөлийн дэргэд уран сайхны хүрээлэнг дарга, орлогч, ерөнхий сургагч, театр, клубийн хэлтэс, кино ба гар урлагийн хэлтэс, сургуулийн шинэ хүчний байцаагч, орчуулагч зэрэг 14 хүний орон тоотойгоор байгуулж, уран сайхны улс төрийн зөвлөлийг өргөтгөн байгуулжээ. Энэ байгууллага Монголын шинэ цагийн соёл, гэгээрлийн ажилд чухал хувь нэмэр оруулсан боловч, нам, төрийн даалгавар, гадны хүчний шахалтаар Монголын түүх соёлын уламжлал, сэтгэлгээний эсрэг зарим нэг ажлуудыг хийсэн байна.

Монголын шилдэг сэхээтнүүд болох О.Жамъян, Ж.Цэвээн, С.Шагж, Эрдэнэбатхаан, Ч.Дашням, С.Буяннэмэх, Б.Ринчен, Х.Пэрлээ, Ч.Бат-Очир, Б.Дугаржав, Б.Ишдорж, Ц.Дамдинсүрэн, Д.Чимэд нарын зэрэг олон хүмүүсийн зохиосон, бүтээсэн, орчуулсан 140 номын нэг хэсгийг устгаж, заримыг нь хураах шийдвэр гаргажээ. Уран сайны хүрээлэнгээс томилогдсон устгах комисс хувьсгалын жилүүдэд зохиогдсон ном зохиолыг хянан үзээд С.Буяннэмэхийн “Баатар хөвгүүн Тэмүжин”, “Марал, Шар”, “Харанхуй засаг”. Ши.Аюушийн “Говийн хүүхэн Гүндэгмаа”, “Хатан Долгор, зарц Дамдин”, М.Ядамсүрэнгийн “Цоожтой хаалганы цаана” жүжгийн зохиол, урт богино дууны нот, “Театрын уран сайхан”, “Уран үсгийн чуулган”/1939) сэтгүүл, “Үндэсний соёлын зам” сэтгүүлийн 1934 оны №195, 1935 оны №1-10 дугааруудыг, 1938 оны №1-3 дугааруудыг устгах шийдвэрийг 1939 оны 6 дугаар сахрын 14-нд тогтоосон актын дагуу “Эсэргүү нарын зохиосон нэр, зураг, гарын үсэг оролцсон хэмээх шалтгаанаар гаргажээ.

“Ардын дайсан”-ны ул мөрийг ор мөргүй устгах хийрэлд дөнгөж байгуулагдаад удаагүй, хөл дээрээ тогтож байсан “Монголкино” үйлдвэр өргжээ. 1936-1939 онд хийсэн 30 шахам баримтат киноны нэлээдийг устгах буюу “хувьсгалын эсэргүү нар” оролцсон хэсгийг танаж сэглэсэн байна. 1940 оны эцсээр гаргасан актаас үзвэл негатив, позитив нийлсэн бүгд 91,2 мянган метр кино хальс устгажээ. Тухайлбал, 1936 онд “Майн баяр”, “Октябрийн баяр” гэдэг дуутай, дуугүй тус бүр нэг нэг бүлэг хоёр баримтат киног үйлдвэрлэснээ хоёуланг нь, 1937 онд “Майн баяр”, “Наадам”, “Октябрийн баяр”, “Цэргийн маневрийн тухай” 4 төрлийн 10 бүлэг баримтат кино үйлдвэрлэснээ бүгдийг нь, 1938 онд “Норжмоогийн зам”, “Аж үйлдвэрийн комбинат”, “Эдүгээгийн Монгол”, “Налайхын тухай”, “Боловсон худалдаа”, “Майн тухай”, “Октябрь”, “Наадам”, “Төлөөлөгчдийн хурал”, “Эвлэлийн III бүгд хурал” зэрэг арван төрлийн 28 кино хийснийхээ тавыг, 1939 онд “Май”, “Октябрь”, “Эрүүлийг хамгаалах”, “Намын арван жилийн ой”, “СССР-ийн Цирк”, “Шинэ хуучин Улаанбаатар”, “Протокол гэрээ”, “Наадам”, “ХХII бага хурал” зэрэг арван төрлийн 34 бүлэг кино бүтээснээс нэгийг нь тус тус устгуулсан байна<sup>6</sup>.

Тэр ч байтугай Монгол хэлний үгсийн санд ангич байр сууринаас хандаж феодал, лам нарын үг гэгчийг хэрэглэхгүй байхыг уриалж байжээ. Жишээ нь хэл бичгийн багш Жүрмэд гэгч монгол үсгийн санг феодалын болоод ардын гэж механикаар хоёр хуваажээ. Зарим нэг залуу зохиолчид иймэрхүү үзэлд хөтлөгдөн “ангийн хэл” байдаг мэтээр эндүү ташаа ойлгож байлаа. Сайхь эндүү ташаа үзлийг шүүмжлэгч Но.Данзан, зохиолч Д.Сэнгээ нар хамгаалан зүтгэж, эх хэлний уламжлалт, зүйрлэл, адилтгалыг хэрэглэхгүй байхыг уриалж байв. Тухайлбал, Д.Сэнгээ “Буяннэмэхийн холбоо шүлгийн цомирлогийн

6 С.Идшинноров. Бүтээлийн чуулган II. Дэд боть. Соёмбо ХХК.УБ.,2013. т.106

тухай” хэмээх шүүмждээ “Хөх тэнгэр”, “Ариун шашны ёс” гэх мэт үгсийг феодал ангитайгаа тонилох ёстой (Үндэсний соёлын зам сэтгүүл.1934.№3.т.14-15) мэтээр бичсэн бол, Но.Данзан “Хувилгаан цагаан үүл, хурмастын цагаан үүл” гэсэн Ц.Дамдинсүрэнгийн “Зугаацахаар мордсон нь” шүлгийн үгийг бурханы шашны үг, түүний суртлыг номлосон хэрэг болов гэх мэтээр бичиж байв. (Шинэ толь сэтгүүл.1938.№5)

Тухайн үеийн Монголын дэвшилт сэхээтнүүд С.Буяннэмэх, Ц.Дамдинсүрэн зэрэг хүмүүс “ангийн хэл” гэж байхгүй, энэ бол айхавтар төөрөлдсөн хэрэг гэдгийг шүүмжилж байжээ. С.Буяннэмэх “Нөхөр Жамбалоны шүүмжлэл ба Ринченгийн орчуулгын тухай” хэмээх өгүүлэлдээ: “гагцхүү хуучин бичгийн хэлийг шууд феодалын хэл бичиг, янз маяг хэмээж болохгүй. Тэр нь хэлний боловсрол, гоо сайхны нэгэн зүйл мөн бөгөөд зохих зүйлд хэрэглэгдэх болох ч болой. Феодалын ёсон хэмээхдээ гагцхүү мунхруулах чанартай зүйлийг өгүүлэх ба тиймийг тэмцэх хэмээсэн нь болой”/Үндэсний соёлын зам. Сэтгүүл. 1935.№7) хэмээн тухайн үеийн сонин сэтгүүлд үзэл бодлоо илэрхийлсэн сэхээтнүүдийг жишээ татан баримтаар өгүүлээд, эдгээр санаа оноо нь тухайн сэхээтний амьдралд хэрхэн нөлөөлсөн тухайд “Энэ зөв зүйтэй байр суурь нь дээрх зохиолчдын хилс хэрэгт гүтгэгдэх дөгөө болж өгсөн байна хэмээн дүгнэжээ”<sup>7</sup>.

1938 онд аймаг, хотын намын хорооны дэргэд байгуулагдаж, намын төв хорооноос нэрийг нь гаргасан 863 нэр төрлийн олон мянган хувь хэвлэгдсэн сурах бичиг, сэтгүүлийг номын сан, уншлагын газар, номын дэлгүүр, сургууль, албан байгууллагууд, айл гэрээс хураан авах ажлыг зохион байгуулжээ.

Монголын түүх соёлын эсрэг чиглэсэн энэ мэт үйл ажиллагаа цаашид ч үргэлжилж байв. Тухайлбал, МАХН-ын ТХ-ны УТТ-ны 1947 оны 3 сарын 4-ний өдрийн 8-р хурлын “Утга зохиол ба хэвлэл хянах газрыг байгуулах тухай” тогтоол, 1949 оны 10 сарын 27-ны өдрийн МАХН-ын ТХ-ны УТТ-ны 56/104-р хурлын “Ардын унших бичгийн” тухай тогтоол, 1959 оны 7 сарын 13-ны өдрийн МАХН-ын ТХ-ны УТТ-ны 251 хурлын “ Хоригдсон дуу, жүжиг, номыг дахин хянаж үзэх комисс байгуулах тухай” тогтоол, 1960 оны 4 сарын 15-ны өдрийн 127 хурлын “Доктор Б.Ринченгийн сүүлийн үеийн зохиолууд дахь зарим харш үзэл санааны тухай” зэрэг тогтоолуудаас харж болно. Гэсэн хэдий ч Монголын үндэсний соёлын сэргэлт ХХ зууны 1950 оны дунд үеэс эхэлсэн билээ.

7 МАН-ын түүх. Боть. III. УБ., 2009. т.192

### Ном зүй

1. Л.Бат-Очир. Чойбалсан. УБ., 1999
2. БНМАУ-ын соёлын түүх (1941-1960). I боть. УБ., 1981
3. БНМАУ-ын соёлын түүх (1941-1960). Дэд боть. УБ., 1986
4. С.Дашдондог. Жаран жилийн шаштир (Монголын орчин үеийн театр урийн сангийн он дарааллын бичиг) I боть. УБ., 1996. т.97
5. П.Дэлгэржаргал, З.Батсайхан. Хүннү Монголын эртний түүх. Тэргүүн боть. УБ., 2017. т.187
6. Б.Жаргалсайхан. Алаг жарны бодрол. УБ., 2015. т.16
7. С.Идшинноров. Бүтээлийн чуулган II. Дэд боть. Соёмбо ХХК. УБ., 2013. т.106
8. МАН-ын түүх. Боть. III. УБ., 2009
9. МАХН-аас урлаг-утга зохиолын талаар гаргасан тогтоол шийдвэрүүд (1921-1966) УБ., 1967. т.213

## ҮГҮЙСГЭЖ БОЛОХГҮЙ ХЭЛМЭГДҮҮЛЭЛТИЙН БАРИМТ



*Г.Пүрэвбат  
Бурханч лам*

### 1. XX зууны эхэн үеийн шашин төрийн байдал<sup>1</sup>

XX зууны эхнээс Монгол оронд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн улам хүчтэй өрнөж улмаар 1911 оны арван хоёрдугаар сарын 29-нд Монгол Улсын тусгаар тогтнолыг сэргээн тунхаглаж VIII Богд Жэвзүндамба хутагтыг Монголын шашин төрийг хослон баригч, наран гэрэлт, түмэн наст эзэн хаанаар, түүний хатан Дондогдулам цагаан дарыг Улсын эх дагинаар тус тус өргөмжлөн, Их хүрээг Нийслэл хүрээ хэмээн оны цагийг Олноо өргөгдсөн хэмээн тунхаглав.

#### **Богд эзэн хаан анхныхаа зарлигт:**

“Би өргөмжлөлийг хүлээж, Монгол Улсын хааны ширээнд суусан нь Бурханы шашныг буман нарны гэрэл мэт хиргүй мандуулан, хаан төрийг Сүмбэр уул мэт бат болгож, олон мянган албатыг энх түвшний соёлд оруулахыг үргэлжид шамдан хичээхийн дээр ялангуяа хан, ван, ноёдыг дараалан түмэн албат хүртэл төв шударга, хичээнгүй үнэнийг сүслэн эрхэмлэж, бүгд нэгэн сэтгэлээр шашин төрд сайнаар зүтгэхийг тус тус ухуулж хишиг тараана” хэмээжээ.

Богд эзэн хааны зарлигаар Монгол Улсын засгийн газрыг Шанзавын яамнаас гадна таван яамтайгаар батлан, Чингисийн хасбуу тамгаас санаа авч, Богд эзэн хааны тамгыг хас чулуугаар сийлснийг “Алтан тамга”, өргөмжлөлийг “Алтан өргөмжлөл” гэж нэрлэв.

<sup>1</sup> «Хаадын ном» (VIII Богдын тухай) Л.Түдэв, УБ 2001 он





*Шашин төрийг хослон баригч Наран  
гэрэлт, түмэн наст эзэн хаан VIII  
Богд Жэвзундамба*

*Улсын их дагина Дондог дулам цагаан  
дар | Б.Шаравын бүтээл |*

Монгол түмнийхээ мэлмий тунгалаг, сэтгэл ариун, төрийн бодлогыг нигүүлсэнгүй шударга байлгахын тухайтад наян тохой Мэлмий нээгч Хонсимбодисадыг сүмтэй нь 236 мянган лан мөнгө зарцуулан босгох тэргүүтэн бурхан шүтээн, сүм дуган шинээр бүтээх, сэлбүүлэн засах ажлыг ч эрчимтэй явуулсаар байлаа. Түүгээр үл барам Өвөр аймгийг хүртэл хамгаалан тэтгэх бодлого явуулан Олноо өргөгдсөний гуравдугаар оны намрын тэргүүн сарын 10-нд буулгасан зарлигтаа:

“Нэгэн сайн цагийг алдвал хожим гэмшивч юуны тус. Тиймийн тул би зарлиг тусгайлан буулгаж, олон монгол иргэнийг хамгаалан тохинуулахаар олон сайдуудыг тухай бүр цэрэг захиран мордуулсан бөгөөд өөр өөрийн хамгаалж тохинуулах газрыг ялган салгаж, гавьяа, ялыг тэмцэлдэн, түлхэлцэлгүй болговол түргэлэн хамгаалж тохинуулахад их л тустай тул Дамдинсүрэн, Чимэдцэрэн, Найданжав нар үзэмчин, хуучдаас эхлэн шар мөрний зүүн этгээдээр, Сумъяа, Бавуужав нар авга, авга нар, хишигтнээс эхлэн шар мөрний баруун этгээдээр тус тус явж, зүүн өмнөд гурван чуулганы монголчуудыг хамгаалан тохинуулсугай.

Насан-Арвижих, Мөрөнхан нар Сөнөдөөс эхлэн сүргийн цэрэг Цахар хошуудыг хамгаалан тохинуулж, Жанчхүүгийн сүв хязгаарыг батлан тогтоотугай.

Чэгдаржав, Галсандондогням нар Улаанцав, Их-Зуу, Алашаа, Торгууд, Хөх хотын түмэн олон монголчуудыг хамгаалан тохинуулан тогтоосугай.

Цөм тохиолдсон газрын ажил үйлдвэрийн номхон шударга иргэдийг өчнөөн төдий ч дарлан зовоолгүй хэвийн аж төрүүлэн хүмүүжүүлж, илбэн тохинуулж, басхүү Манж овгийн түшмэл, цэрэг тохиолдвол харилцан найзлахыг чухал болгон нөхөрлөн тусалж, хэрхэв хэмээн алдас үл гаргахаас ангид, монголын хязгаар хүрсэн хойно бусдын нутгийг тэмцэхгүй, захыг батлан сахиж, хэн алин этгээд өө сэв дэгдээх хэргийг үл гарган, харьяат олон монголчуудаа бүрэн бүтэн болготугай.

Хэдий өчнөөн бага үл ташааран, өчнөөн бага үл хожимдогтун! Басхүү нэгэн этгээдэд дайсны цэрэг онц олноор түрэн ирж хүчирхэн байлдахад хүрвэл аль ойрд чимээ нэвтэлцэн хүчин хавсарч сөнөөвөл болно.

Миний энэ зарлигийг яаран тушаан явуулж, хурдан түргэн дагаж шийтгүүлээрэй, нийтэд ухуулагтун!” хэмээжээ.

Богд эзэн хааны энэхүү зарлиг монгол туургатны сонорт хүрмэгц ялагдашгүй хүчин болон хувирчээ.

Богд эзэн хааны зарлигаар Улиастай, Ховдоос манжийн амбаныг цэрэгтэй нь хамт хөөн зайлуулж, баруун хязгаараар цөмрөн орж ирсэн Хятадын түрэмгий цэргийн хоншоорыг тас цохисон Хатанбаатар Магсаржавын цэрэг хөлгийн жолоог Богдын зарлигаар эргүүлэн, зүүн өмнө тийш залж, Сулинхээрээс эхлэн Хөх хотын чиглэлээр давшиж, Цагаан хэрэмд тулж очив.

Гурван улсын гэрээний сураг гарч хоёр их гүрний хавсайдалт улам хатуу хэцүү болсноор, Долнуур, Барга, Хөх хотоор байлдаж, тэндэх газрыг төвшитгөн тохинуулахад хүрмэгц арга буюу хөлгийн жолоог Халхын зүг эргүүлэв.

Монголын туурга тусгаар улс болсныг хамгийн түрүү Орос орон зөвшөөрлөө. Гэвч хоёр их гүрний шахалтаар Монгол, Орос, Хятад гурван улсын хэлэлцээ Хиагтад Олноо өргөгдсөний дөрөвдүгээр (1914) оны намрын тэргүүн сарын 25-наас хөхөгчин туулай жилийн (1915) зуны тэргүүн сарын 25-н хүртэл долоон сар үргэлжлэв. Орос, Хятад хоёр 22 зүйл бүхий гурван улсын гэрээ гэгчээ Монголд тулган хүлээлгэж Бүрэн эрхт хаант засагт Монгол Улс хагас эрхтэй болсноор барахгүй Өвөрмонгол, Ил Тарвагатай хилийн гадна үлдэв.

Сар, өдөр улиран өнгөрөх тутам цагийн байдал улам хэцүү болж Да лам Цэрэнчимэд, Чин ван Ханддорж, Засагт хан Сономравдан, Сайн ноён хан Намнансүрэн нар учир битүүлгээр амиа алдав.

Улмаар 1919 онд Сюй Шүжан генералаар удирдуулсан хятад цэрэг Монгол орноо нэвтрэн орж Монгол Улсын автономийг устгав.

1920 онд Барон Унгерн фон Штенбергээр толгойлуулсан оросын цагаантнууд Цэцэн хан аймгийн нутгаар Монгол орноо цөмрөн орж гамин цэргүүдийг үлдэн хөөснөөр Монголын автономит эрхийг сэргээснээ зарлалаа.

Ийнхүү Богд хаант Монгол Улсын засгийн газар тун хүнд нөхцөлд байх үед Нийслэл хүрээнд жижиг нууц бүлгүүд үүссэний нэг болох Зүүн хүрээний бүлэг Д.Сүхбаатар, С.Данзан нарын удирдлагаар 1919 онд байгуулагдсанаар Монгол ардын хувьсгалт байгууллагын эхлэл тавигдав. Нууц бүлгүүд 1920 оны зургадугаар сарын 25-нд болсон хурлаараа нэгдэж, байгууллагаа “Монгол Ардын Нам” хэмээн нэрлэн тангаргын бичгээ баталжээ.

1921 оны гуравдугаар сарын 13-нд Ардын түр засгийн газар байгуулагдан, 1921 оны гуравдугаар сарын 18-нд Ардын журамт цэрэг Хиагтыг, улмаар 1921 оны долдугаар сарын 6-нд нийслэл хүрээг чөлөөлснөөр Намын Төв Хороо, Түр засгийн газар нийслэл хүрээнд шилжин ирлээ. Үүний дараа Түр засгийн газрын гишүүд Богд хаанд бараалхан, Хэмжээт эрхт ардын цаазат засгийн газар байгуулав.

Ардын засгийн газрын бүрэлдэхүүнийг Богд хааны зарлигаар батламжлан “Тангаргийн гэрээ” байгуулж, түүнийг хэрэгжүүлэх дүрмийг баталлаа.

Тангаргийн гэрээ, дүрмийн ёсоор Монгол Улсын хаан Жэвзүндамба хутагт шашны Богд эзэн хаан хэмээгдэн бурхны шашны бүх үйл хэргийг эрхшээж нам, засаг түүнийг нь хүндэтгэн дэмжиж байв.

Бүх цэргийн жанжин Д.Сүхбаатар 1922 оны арван хоёрдугаар сард гаргасан бичигтээ “.. ардын эрхтэй засаг байгуулж, язгуурын багш, умар зүгийн шарын шашны эзэн Богд хаанаа эрдэнийн ширээнээ залж өргөмжлөн, элдэв хэргийг явуулан бүхий нь дан ганц гадаадын харгис дайсан этгээдийн дарлагдлыг дахин амсахгүй, бурхан шашнаа хүндэтгэж, ард түмнийг амгалангийн туйлд хүргэж, тэгш журамт, баян хүчирхэг улс болохыг гол болгосон хэрэг болно.”<sup>1</sup> гэжээ.

1923 оны сүүлээр Богд хааны бие лагшин чилээрхэн, 1924 оны дөрөвдүгээр сарын 17-ны өдөр жанч халав. Ардын засгийн газар яаралтай хуралдан буяны хурал, номын зүйлийг хэрхэн үйлдэх, түүнд засгийн газар яаж оролцох, шарилыг хаана, хэзээ, хэрхэн залахыг хэлэлцээд, энэ бүхнийг хамба, Шанзавын газраас эрхлэн гүйцэтгэхээр шийджээ. Улсын сангаас хойт мөрт нь зориулсан хурал номын зардалд 3 мянган лан мөнгө гаргав.

Олон яам, албан газар гурван өдөр эмгэнэж албан хэрэг шийтгэхгүй байхыг нийтэд зарлан, олон нийтээр 21 хоног гашуудах ёс гүйцэтгэв. Богд хааны шарилыг залах өдөр цэрэг жагсан, ард олны эмгэнэлийн цуглаан хийв. Хааны тамга, өргөмжлөлийг тавдугаар сарын 1-ний могой цагт Гүнгаадаржайлин сүмээс Засгийн газраа шилжүүлэн хадгалж, дараа их хуралд шилжүүлэхээр болов.

Ардын засгийн газар хутагтын шавь нарыг захирах яамны саналыг үндэс болгон бурхан, ном хуруулах, шарилыг суваргалах, шинэ дүрийг тодруулахад татгалзах зүйлгүй хэмээн Банчин богдод бараалхах асуудлыг цагийн байдлаас болон Засгийн газар түр хойшлуулжээ.

Наймдугаар богд Агванлуvsанчойжинямаданзанванчүгбалса нбугийн (1869-1924) зандшуулсан шарилыг залсан суваргыг Төгс баясгалант их хөлгөн хийдийн тусгай сүмд заллаа.

Ерөнхий сайд Б.Цэрэндоржоор даргалуулан хуралдсан Засгийн газрын хурал улсын төрийн тэргүүний тухай асуудал хэлэлцээд, “Богд хаан нэгэнт таалал төгссөн учир ардын ёсонд нийцүүлэн, Бүгд Найрамдах Засгийг явуулбал зохих болов уу” гэж үзэв.

1924 оны арваннэгдүгээр сарын 8-ны өдөр БНМАУ-ын Анхдугаар Их хурал хуралдан, арваннэгдүгээр сарын 26-нд Анхдугаар үндсэн хуулийг баталж, тус улсыг “Бүгд Найрамдах Монгол Ард Улс” хэмээн тунхагласан билээ. Түүхэн эгзэгтэй үед Зөвлөлт орос улсыг түшин Коминтерний бодлогын дагуу сонголт хийсэн нь өвөг дээдсээс эрхэмлэн дээдэлж ирсэн уламжлалт соёл шашнаа үгүйсгэн устгах бусдын бодлогын золиос болох зүг рүү эргэлт буцалтгүй түүхэн алхам хийснээр барахгүй олон зууны турш бүтээн буй болгосон соёлын үнэт зүйлс болон түүнийг уламжлан дамжуулах язгууртан, мэргэд дээдсээ буруутган хэлсдүүлэх хар үе эхэллээ.

XIX зууны сүүл үе гэхэд Ар Монголд 1000 илүү сүм хийд, 100000 гаруй лам хувраг, Өмнөд Монголд 1800 гаруй сүм хийд, хурал номын газар, 150000 орчим лам хуврагтай байв. Энэ нь Монгол оронд байсан сүм хийд, хүрээ хурлын газрыг бүрэн хамруулсан тоо биш юм. Нийт Монгол туургатан даяар бодолцвол үүнээс хэд дахин үлэмж буй нь илт бөгөөд эдгээр хүрээ хийдийг дагалдан «Гурван шүтээний элдэв ур хийцтэй тоолшгүй олон шүтээн урлал» -ын бүтээлүүд үлэмж түгсэн нь илт тодорхой билээ.

Монгол Улсын газар нутагт байсан сүм хийд, хүрээ хурлын газрыг нягтлан шинжилсэн баримтаас эш татвал<sup>2</sup>

Д/Д	Аймгийн нэр	Б.Ринчингийн судалгаа <sup>2</sup>	735 сүм хийдийн тухай баримт	“Монголын сүм хийдийн түүхэн товчоо”
1	Архангай аймагт	78	182	91
2	Баян-Өлгий аймагт	24	-	13
3	Баянхонгор аймагт	30	-	38
4	Булган аймагт	76	50	60
5	Говь-Алтай аймагт	24	-	34
6	Дорноговь аймагт	79	46	89
7	Дорнод аймагт	40	52	48
8	Дундговь аймагт	67	-	63
9	Завхан аймагт	-	36	47
10	Орхон аймагт	-	-	6
11	Өвөрхангай аймагт	38	40	55
12	Өмнөговь аймагт	45	65	51
13	Сүхбаатар аймагт	49	-	60
14	Сэлэнгэ аймагт	55	68	54
15	Төв аймагт	92	41	84
16	Увс аймагт	-	-	19
17	Ховд аймагт	62	24	22
18	Хөвсгөл аймагт	64	36	63
19	Хэнтий аймагт	86	95	104
20	Улаанбаатар хотод	32	-	27
21	Нийт монгол даяар	941	735	1028

**2. Монголын түүхэн хэлхээг таслах бодлого буюу Бурханы шашин устгагдсан нь<sup>3</sup>**

Улс үндэстнээ хэмээсэн дэвшилтэт сэхээтэн, ихэс дээдсийн байгуулсан нам нь коминтерний тулгалт, бодлогын заавраар ийн Ардын хувьсгалыг феодалын байгууллаас капитализмыг алгасан хөгжиж социализмд дэвшин орох замыг нээлээ хэмээн МАХН-ыг тунхаглаж, хуучин нийгмийн бүх тогтолцоог устгаж шинэ нийгэм байгуулах урьдач нөхцөлийг бэлтгэх зорилгоор хорь шахам жил шургуу үйл ажиллагаа явуулав. Ийн капитализм төрөн гарах бололцоог хаах явдал бол Монгол ардын хувьсгалын нэн тэргүүний зорилт, хөгжлийн замынх нь чухал зүй тогтол хэмээн хоцрогдсон орнууд социализмд шилжих арга хэмжээнүүдийн бэлтгэл шатны нэгэнд сүм хийд, лам хуврагуудын эдийн засгийн хүчин чадал, орших нөхцөлийг устгах үйл ажиллагааг орууллаа. Мөн хөдөлмөрчин олныг шашны үзэл бодол, түүнд шүтэх итгэлээс ангижруулах явдал төлөвлөгөөний чухал суурийг эзэлж байв.

<sup>2</sup> «Монгол Ард улсын угсаатны судлал хэлний шинжлэлийн атлас» Б.Ринчэн

<sup>3</sup> “Их Монголын Суварга” Бурханч лам Г.Пүрэвбат 2005 он



Монголын угсаа дамжсан язгууртнуудын эдийн засаг, оршин тогтнох нөхцөлийг эвдэн устгахаас сүм хийдийн эсрэг хийх тэмцэл нь их ярвигтай, шууд устгах алхам хийвэл олон ардыг хувьсгалын үйл хэргээс хөндийрүүлэхэд хүргэж болох байсан тул шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

МАХНамын төв хороо 1924 онд намаас сүм хийд, лам нарын талаар баримтлах бодлогыг боловсруулах тусгай комиссыг томилон ажиллуулж Намын Төв Хорооны тэргүүлэгчдийн 1925 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн тогтоолоор уг комиссын саналын дагуу боловсруулсан “МАХН-ын шашин шүтлэгийн тухай гол бодлого ба товч тогтоол” гэсэн баримт бичгийг батлан гаргав.<sup>4</sup>

1926 онд Засгийн газраас төр, шашныг тусгаарлан явуулах тухай хуулийг боловсрууллаа. Эдгээр баримт бичигт сүм хийд, лам нарын улс төр, эдийн засаг, үзэл санааны давуу талыг даван туулах талаар баримтлах намын бодлого шугамыг хураангуйлан заасан байна. 1926 онд хуралдсан намын V их хурал сүм хийдийн мал, хөрөнгөнөөс албан татвар хураах шийдвэр гаргав. 1927 оноос эхлэн сүм хийд, лам нарын хувийн хашаа байшингаас газрын түрээс хурааж, мөн хутагт хувилгаадын газар, бэлчээр, хошуу захирах, үе залгамжлуулах эрхийг нь устгалаа.<sup>5</sup>



*Егүзрийн хийдийн лам хувраг нарыг шүүн таслах хурлын үйл ажиллагаанаас (1936 оны есдүгээр сарын 28)*

4 “Монгол улсын түүх” I, II, III, IV, V боть УБ 2003 он

5 БНМАУ-ын хөрөнгөтний биш хөгжлийн төлөө тэмцэл” – Ц.Насанбалжир, 1956 он (Баримт бичгүүд 1925 - 1940)

МАХН-ын VII их хурлаар язгууртнуудын өмч хөрөнгийг хураах шийдвэр гарган 1929-1930 онуудад тэдний өмч хөрөнгийг хураах үеэр хутагт хувилгаадын хөрөнгийг ч бас хураалаа. Ийн сүм хийдийн хүчин чадлыг эвдэн устгахын тул жасын малыг хамтралууд болон аж ахуйтанд шилжүүлэн хариулгах, сүм хийдүүдэд оногдуулах, өсгөн нэмэгдүүлэх албан татварын бодлогыг тууштай явууллаа.<sup>6</sup>

Энэ явцад сүм хийдүүдийг битүүмжлэн, түүний мал хөрөнгийг хураах, 1930 он гэхэд Богд хаан уулын аймгийн Зүүн бүрэнгийн хошууны эрх баригчид тус хошуунд байсан 42 хэсэг хийд, сүм дуганаас 38-ыг битүүмжлэн мал хөрөнгийг нь хураах, Цэцэрлэг мандал аймагт 41 жасын хөрөнгийг хурааж, Хөвсгөл аймагт хогшил хөрөнгө бүхий лам нарын хөрөнгийг хурааж, албадан хар болгож байжээ. 427 язгууртан дээдэс ба хутагт хувилгаад, 302 түшмэдээс бүгд нийлээд 5.2 сая төгрөгийн үнэтэй эд хураасан бөгөөд энэ ажлыг гүйцэтгэхэд 20 мянга гаруй ядуучууд идэвхтэй оролцсон хэмээсэн байна. МАХН-ын наймдугаар хурлаас хойш 1931 оны арваннэгдүгээр сарын 15-ныг хүртэл 281 хутагт хувилгаадаас 1.5 сая төгрөгийн хөрөнгө хурааж, үүнээс хойш 300 шахам язгууртан хутагт хувилгаадаас 3 сая төгрөгийн хөрөнгийг хураав.<sup>6</sup>

Энэхүү сүм хийд, лам хувраг, үндэсний язгууртан, чинээлэг давхаргынхны эсрэг явуулсан ажиллагаа хэт хувьсгалжин туйлшрах ажил байснаас зарим аймгуудад эсэргүүцлийн хөдөлгөөн өрнөхөд хувьсгалын эсэргүү бослого хэмээн нэрийдэн хүч түрэн дарлаа.<sup>6</sup>

Ийнхүү 1930 он гэхэд сүм хийдийн хүчин чадлыг хязгаарлаад, хутагт хувилгаадын эдийн засгийн байр суурийг устгах зорилгоор жас болон сүм хийдэд оногдуулах албан татварын олон талт бодлого хэрэгжүүлэх, мөн жасаас өсгөн нэмэгдүүлсэн албан татвар авах, цэргийн насны лам нараас цэргийн татвар авах, их орлоготой дээд лам нараас олз ашгийн татвар авах, мөн ядуу доод лам нарыг нийгмийн тустай хөдөлмөрт шилжүүлэх зэрэг эдийн засгийн болон олон талын хүчтэй дарамт, шахалт, хүч түрсэн үйл ажиллагааны үр дүнд сүм хийдүүд олноороо хаагдаж эхэлжээ.<sup>6</sup>

Дорнод аймагт 48 хийд байснаас 1937 оны арван хоёрдугаар сарын байдлаар 30 нь хаагдаж, үлдсэн цөөн хийдүүд хаагдах төлөвтэй байна гэж Дорнод аймагт суугаа Засгийн газрын төлөөлөгч мэдээлж байжээ. Мөн Сэлэнгэ аймагт байсан 55 хүрээ хийд 1937 оны зургадугаар сард бүрмөсөн хаагдаж, орон нутгийн нам улсын байгууллагууд тэднийг цэвэрлэх ажлыг зохион байгуулсан байна.<sup>7</sup>



1938 онд сүм хийдүүд хаагдаж устгах явц улам хурдасч 1938 оны нэгдүгээр сарын байдлаар Төв аймагт нийт 40 сүм хийд, мөн оны зургадугаар сард Дорнод аймгийн бүх сүм хийд хаагдсан байна. Түүнчлэн, 1938 оны есдүгээр сарын байдлаар Өмнөговь аймагт ганц Луус сумын хийд л хэвээр үлдсэн байв. Учир нь арав гаруй лам хайлан хийж байсан тул тараагүй, хэдэн өдрийн дараа хаагдах төлөвтэй үлдсэн 44 хийд хаагдан цэвэрлэх ажлыг хийж байна хэмээн Намын Төв Хороонд мэдээ ирүүлж байлаа.<sup>7</sup>

Үүнээс гадна, 1938 оны 5 дугаар сард Завхан аймагт 30 гаруй хүрээ хийд бараг ламгүй болж тарсан ба зарим нэгэн хийдэд нь цөөн тооны хөгшин лам, хийдийн мэдээчин нар л байв. 1937 оны эцсээр Сайд нарын зөвлөл хил хязгаарын 60 орчим хийдийг дотогшлуулах шийдвэр гарган нүүлгэх үеэр 34 тооны сүм хийд тарсан.<sup>7</sup>

1938 онд үндсэндээ Монгол орон дахь бүх сүм хийдийг тараан устгаж Намын төв хороо тарсан сүм хийдийн мал хөрөнгийг ардын аж ахуйтанд шилжүүлэх, байшин барилгыг нь сургууль, эмнэлэг, малын эмнэлэг, цэргийн анги, өвс хадах станц, гар үйлдвэрийн артель, худалдааны байгууллагуудад ашиглуулахаар шилжүүлж өгөх шийдвэр гаргалаа. Энэ шийдвэр ёсоор 1939 оны эхээр ихэнх сүм хийдийн гурван шүтээн, эдлэл хэрэглэлийг хураах, нураах зөөх зэргээр цэвэрлэж дуусгаад зохих байгууллагуудад тараан шилжүүлэв. Энэ үед сүм хийдүүдийн 5953 тооны хашаа байшин гэрээс 5451-ийг нь шилжүүлсэн ба 500 орчим байшин барилга ашиглах нөхцөлгүй болон үлджээ. Соёл, олон нийтийн байгууллагуудад шилжүүлсэн дуган, сүмийн тоо 2756, хашаа 348, байшин 1796, саравч 173, гэр 378 болжээ.<sup>7</sup>

1939 оны тав, аравдугаар сард Намын Төв Хороо энэ асуудлыг дахин авч хэлэлцээд үлдээд буй цөөн тооны сүм хийдийг цэвэрлэж дуусгах шийдвэр гарган 1939 ондоо цэвэрлэн дуусгаад байшин барилга, хашаа хөрөнгийг бичиг үсгийн багш нарын түр сургуульд, хашаа модны зүйлийг ардын аж ахуйтанд шилжүүлэв. Хаагдаж устгагдсан сүм хийдийн 28 мянга гаруй тооны малаас 19 мянган толгой малыг ардын аж ахуйтанд үнэгүй олгон тараав.<sup>7</sup>




*Эдүгээ үлдэж хоцорсон цөөхөн сүм хийдийн нэг болох 3000 гаруй лам хувраг хурдаг байсан Амарбаясагалант хийдийн Цогчэн дуган*



*Төв аймгийн Мазуширын хийдийн Цогчэн дуганы туурь*



*Их хүрэн дэх Их гэр дуганыг эвдлэн нураах үе*



*Дорнод аймгийн Матад сумын Тэргүүнбуянт хэмээх Алтан очиртын хийдийн туурь*

Сүм хийдийн аж ахуйгаас 233 мянган төгрөг, үнэт эдлэл, алт, мөнгө зэрэг 5.9 тонн жин бүхий зүйл улсын санд оржээ. Мөн зэс, гуулин эдлэл зэрэг бүгд 566 машин зүйлийг улсын орлогод оруулах зэрэг үлэмж олон зүйл завсар зайнд нь устгагдаж түүх, соёлын дурсгалт уран барилгын сор болсон гайхамшигт сүм дуганууд эвдэрч устгагдан, тоолж үл барам бурхан тахилын эд хэрэглэл, олон үеийн турш нандигнан бүтээгдэж өвлөгдөж ирсэн монгол түмний алдарт шүтээн бурхад үрэгдэн, өч төчнөөн тоолж баршгүй ном судрууд талаар нэг хөглөрөн шатаагдаж хөсөр хаягдаж байлаа.

1933-1934 онд есөн аймгийн гүйцэт биш мэдээнээс эш татахад хууль зөрчиж шинэ дуган сүм барьсан хэргээр 15 лам, бага насны хүүхдийг лам болгосон хэргээр 19 лам, ард олноос өргөл барьц авсан хэргээр зургаан лам хуулиар шийтгэгдсэн байна. 1935 оны эхний зургаан сар гэхэд бадар барьсан хэргээр долоон лам, бага насны хүүхдийг лам болгосон хэрэгт гучин нэгэн лам холбогджээ.

6 “МАХН-аас Феодал ангийн улс төр, эдийн засгийн ноёрхлыг устгахын төлөө явуулсан тэмцэл”  
А.Минис, УБ, 1968 он

7 “МАХН-аас сүм хийд, лам нарын, эдийн засгийн хүчин чадлыг эвдэж устгахын төлөө явуулсан тэмцэл”  
А.Минис, УБ, 1972 он

Ийн шүтэн бишрэх, лам болох, номын үйл ажиллагаа явуулах бүхий уламжлалт дээдийн ёсыг алхам бүрд нь хорин боомилж хүнд хатуугаар шийтгэж эхэллээ.

1937 оны есдүгээр сараас 1939 оны дөрөвдүгээр сар хүртэл хугацаанд шүүх болон Онцгой бүрэн эрхт комиссоос бүгд 25824 хүнийг төрийн эсрэг гэмт хэрэгт холбогдуулан таслан шийдвэрлэж 20474 хүнд буудан алах, 5103 хүнд арван жил хорих, 240 хүнд арав хүртэл жил хорих ял шийтгэл оногдуулж, долоон хүнийг хэрэгт холбогдолгүй болгон сулласан нь одоогоор Тагнуулын газрын архив тоо бүртгэлийн алба болон Улсын дээд шүүхийн цагаатгалын ажлын тоо бүртгэлийн мэдээгээр тогтоогдоод байна.

Онцгой бүрэн эрхт комиссоос буудан алах ял оногдуулж гүйцэтгэсэн 20474 хүний 14201 нь лам нар байв. Ер нь 1937-1939 онд 17581 ламын хэрэг гэгчийг онцгой бүрэн эрхт комиссоос таслан шийдвэрлэсэн байдаг. Зөвхөн эхний үеийн хэлмэгдүүлэлтээр “Хувьсгалын эсэргүү” хэмээх тодотголтой 70 орчим хэргээс хожим 2004 оны байдлаар 60-аадыг нь л цагаатгасан билээ. Энэхүү Монголын уламжлалт шашин соёл, эрдэмтэн мэргэдийг устгасан үйл ажиллагааг дүгнэж Монголын эрх баригч намын тэргүүн Ю.Цэдэнбал хэлэхдээ “Олон мянган лам нарыг нийгмийн тустай хөдөлмөрт оруулж, дээд ангийн харгис лам нарыг ялсан нь ач холбогдлоороо 1921 оны хувьсгалтай бараг энэ зэрэгцэх хувьсгалт үйл явдал болсон юм” хэмээн дүгнэжээ. Ийн Монгол орноо ид мандан цэцэглэж оргилдоо хүрч байсан бурханы шашны наран бүрэн шингэж, дээдийн номын ёст монгол түмэн сэтгэлийн мухартаа өвгөдийнхөө үнэн ном гэрээслэл бүхнийг далдлан битүүмжиллээ.

1940 оноос хойш хүн амын мухар сүсэг хэмээн нэрлэсэн дээдийн үнэн номонд итгэх сүүлчийн итгэл бүхнийг нь даван туулах зорилт голлон, түүх болон өвгөд дээдсийн замнал, дээдийн номын тухай тэнгэр газрыг сольсон мэт эсрэг номлолын дуун үл тасрах болов.

Энэхүү түүхэн харанхуй үед монгол орон дахь дээдийн номын эх үндсийг дахин залгах цор ганцхан оч нь Төгс баясгалант их хөлгөн хийд болсон юм.

### 3. Долоон жилийн дараа дахин сүүмэлзсэн Бурхны шашны ГОЛОМТ

Монголын V Богд Цүлтимжигмэд данбийжалцан шороо нохой жилд (1838) Их хүрээний Далхын Дэнж хэмээгдэх газар Төгс баясгалант их хөлгөн хийдийг анх байгуулж нэжгээд мянга гаруй шавь нарт найман мянгат болон Богд Зонхабагийн буман зарлигийн эшийг хайрлалаа.<sup>9</sup>

V Богд бээр “Төгс баясгалант их хөлгөн хийдэд муу нэр бүү дуурсаг гэж даатган ерөөж эндээс өөр газарт үүсгэж болохгүй” хэмээн “бат оршоохын аргыг бодогтун” гэж дахин дахин айлдаж гэрээслэсэн байдаг. VIII Богдын үед эрдэм боловсрол, шашин соёлын гол төв нь болсон энэхүү Төгс баясгалант их хөлгөн хийд урьд өгүүлсэн түүхэн уршгаар 1938 онд бүр мөсөн хаагдан устгагдсанаас хойш долоон жил Монгол орон даяар дээдийн номын ёс бүрэн унтарч, эцэг өвгөдөөс уламжилсан бурхны шашны наран шингэлээ.<sup>9</sup>

1944 оны хөх бичин жилийн зуны эхэн сарын өлзий учралт сайн өдөр Улсын бага хурлын шийдвэрээр Төгс баясгалант их хөлгөн хийдийг “Мөргөлийн дуган” нэртэйгээр сэргээн анхны хурлаа хурсан түүхэн үе ирснээр 1993 оныг хүртэл бүхэл бүтэн жаран жилийн турш Монгол орон дахь цор ганц шашин соёлын төв нь болж байв.<sup>9</sup>



*Монголын бурханы шашны оюуны үнэт өв сан харамсалтай нь Төвд, Бутаны бурханы шашны соёл шиг дэлхий нийтэд алдаршиж чадалгүй XX зууны адармаатай түүхийн шуурганд хэлмэгдэн дарагдсан учраас дотоод бясалгалыг эрхэмлэх болсон Монгол үндэстэн юу бүтээн туурвисныг эдүгээ дэлхий нийт бүү хэл өнөөгийн бид өөрсдөө ч ухаарч мэдээгүйг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй нөхцөлд байна.*

## Хамбын овоон дахь хэлмэгдэгсдийн дурсгалд зориулсан Давхарлагат байшин суварга

1937-1939 оны үеийн засаг захиргааны хуваариар оршин тогтнож байсан Архангай, Булган, Дорнод, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Хэнтий, Увс, Ховд аймгуудын төвийн ойролцоо дунджаар 10~20км-ийн зайтай тодорхой газруудад улс төрийн хилс хэрэгт татагдан хэлмэгдэгсдийг бөөнөөр нь буудан алжээ. Улаанбаатар хотын орчимд ийм газрууд хэд хэд байдгийн нэгэнд 1990 онд дурсгалын хөшөө босгосон Сонгино уулын ар жалга болон Шар хад зэрэг газрууд ордог. Гэтэл 2003 оны дөрөвдүгээр сарын 8-нд “Хамбын овоо” гэдэг хотынхны хогоо хаядаг цэг байсан газраас баруун урагш уруудсан жалганд есөн хэсэг газраас үлэмж цогцсууд илэрлээ. Үүнтэй бурханч лам миний бие биечлэн танилцаж Хотын захиргаанд албан ёсоор хандсанаар маш шуурхай арга хэмжээ авч, Хотын аврах отрядынхонтой хамтран бүх цогцсонд хөндөлт хийв. Гарсан цогцоснуудын дунд чөмгийг нягтлан тоолоход 1150 байсныг хослуулбал 575 хүний цогцос болсон. Гэвч урьд нь барилгын шавар ачихад хамт ачигдсан, энд тэнд тарж үгүй болсон ясыг оролцуулан бодвоос бараг мянга гаруй хүний цогцос байсан болов уу. Бүтэн 348 гавлын ясыг авч шинжлэхэд ихэнх нь ар дагнаасаа буудуулсан сумны нүхтэй, мөн цөм цохиулсан гавлын яс ч гарч байв. Эндээс гарсан бүх цогцоснууд эрүүндээ шүдгүй өтөл өвгөнөөс авахуулаад гуч орчим насны идэр залуу зонхилж байна. Эд мөрийн баримтуудын 90 орчим хувь нь лам нарынх бөгөөд гарсан эд зүйлс тухайн цаг үеийн хөдөлшгүй нотолгоо болсон юм. Энэ бүх ажлыг удирдан хийхдээ эд мөрийн баримт болсон эд зүйлсийн хамт наян гавлыг авч хадгалан, бусад цогцсуудыг цэвэрлэж чандарлаад, ариун зай шавартай холин гучин зургаан зүйл төрлийн 6000 сац бүтээв. Эдгээр хэлмэгдэгсдийн дурсгалд зориулан Өндөр гэгээний ёсны есөн метр өндөр, алтан ганжирт “Давхарлагат байшинт суварга”-ыг тус жалганы зүүн хамрын дээр бүтээн босгож, дотоод тогтоол оршоолгын эд зүйлс, ном судрын хамт дээрх сацнуудыг тус суварганд заллаа. Давхарлагат байшин суварганы дээврийг ваарлан, давхар унь моднуудыг хээлж чимэглэн, алтан шармал суварган ганжирыг охь болгон залахад салхи нам гүмхэн болж, зөөлөн бороо удаан орсон юм. Энэ суварга нь эрдэмт олон дээдсийн цогцсыг чандарлан сацалж оршоосон анхны суварга бөгөөд анхны Давхарлагат байшин суварга болоод зогсохгүй хойч үедээ бидний эв эвдэрвээс бусдын бодлогын золиос болж, улс үндэстнээрээ мөхөхөд ойрхон болдгийг сануулсан түүхэн гэрч болсон юм.<sup>8</sup>

8 “Хурмаст тэнгэр” энэрэн нигүүлсэхүйн сонин, тусгай дугаар, Г.Мөнхцэцэг, УБ, 2003 он.

9 “Буцаах эрхгүй бурхадын гэрээслэл” Бурханч лам Г.Пүрэвбатын ярилцлага, илтгэлийн эмхэтгэл, цуврал нэг, 2003 он



## ... АХИЖ ИЙМ ЭМГЭНЭЛТ АЛДАА ГАРГАХ ЮМ БОЛ ДАХИН ТЭСЭН ГАРЧ ЧАДАХГҮЙ ...

ХЭЛМЭГДСЭН, ХЭЛМЭГДҮҮЛСЭН ТҮҮХЭН ЦАГ ҮЕ НЭГЭНТ АРД ХОЦОРЧ,  
ТЭДГЭЭРИЙН ХОЙЧ ҮЕ БОЛСОН БИД ЭНЭ АСУУДЛЫГ ТҮҮХИЙН  
СЭРЭМЖЛҮҮЛЭГ БОЛГОН ЗӨВХӨН ҮНЭНИЙГ ГАРГАН ТАВИХААС БУС ӨӨР  
ХООРОНДОО ЯС ХАЯЛЦАХ АСУУДАЛ

ХЭЗЭЭ Ч ГАРГАЖ БОЛОХГҮЙ.

УЧИР НЬ БИДНИЙ ЭВ ЭВДЭРВЭЭС БУСДЫН БОДЛОГЫН ЗОЛИОС БОЛЖ УЛС  
ҮНДЭСТНЭЭРЭЭ МӨХӨХӨД ОЙРХОН БОЛДГИЙГ ДЭЭРХ ТҮҮХИЙН ГЭРЧ  
САНУУЛЖ БАЙНА.

ҮГҮЙСГЭЖ БОЛОХГҮЙ ХЭЛМЭГДҮҮЛЭЛТИЙН БАРИМТ



*2003.04.10-ны өдөр. Улаанбаатар хот Хамбын овооны баруун жалга. Эндээс 1937 оны үед хэлмэгдсэн үй олон хүний цогцоснууд илэрсэн юм. Тэр үед манай Монгол улсын хэмжээнд 1000 гаруй сүм хийд устгагдан, 30000 гаруй шилдэг хүмүүс зүй бусаар хэлмэгдэн амь насаа алдсан юм.<sup>9</sup>*






*Илэрч гарсан цогцосны зөвхөн дунд чөмгийг нэгтгэн тоолбоос 1150-н дунд чөмөг тоологдсоныг хослуулбал 575 хүний цогцос боллоо.*

*Эдгээр цогцсуудыг цэгцлэн баримтжуулах хүнд бөгөөд нүсэр ажилд Нийслэлийн аврах отрядын 15 бие бүрэлдэхүүн. Шүүх эмнэлгийн шинжээч 2 эмч, Улс төрийн хэлмэгдэгсдийн холбооны тэргүүн А.Дашинамжил, гэрэл зурагчнаар Г.Аким нар Бурханч ламтай хамтран ажилласан юм.*

*Газрын дор он удсан цогцоснууд задрал илжрэлд орж, бөөнөөр нь нэгэн нүхэнд овооруулан хийснээс хичнээн хүний цогцос буйг тооцоолон гаргахад нэн хүндрэлтэй байв. Иймээс хамгийн бат бөх эвдрэл багатай үлдсэн дунд чөмгүүдийг түүн авч түүгээр нийт цогцосны тоог гаргаж баримтжуулахаар овоолон хураасан нь.<sup>9</sup>*





Ихэнх гавлууд задрал илжрэл явагдан гэмтсэн байсан боловч бүтэн үлдсэн бүх гавлуудыг нэгтгэн цуглуулахад 340 болов. Үүнээс 148 гавал нь буудуулсан сумны нүхтэй, 192 гавал нь цөм цохиулсан зэрэг янз бүр байв.

Цогцоснуудын хамт модон тагш, ялзарч муудсан орхимж, дээл, цамц, өмд, ширэн малгай гярга бүс зэрэг олон эд зүйлс гарсан бөгөөд ёроолдоо алх хадуур үйлдвэрийн тэмдэгтэй наалантай түлмэн, аяга гарсан нь он цагийг урагшлуулж хойшлуулж ч болохгүй их хэлмэгдүүлэлтийн үетэй холбогдоод байна.

Нийт есөн хэсэг газар байсан шарилуудыг ухааж цуглуулахад хоёр самосвал дүүрэн цогцсууд болж байлаа.<sup>9</sup>







Эдгээр гавлууд газрын хөрсөн доор он удаан байхдаа ямар ч халдварт нян тээж буйг мэдэх аргагүй тул Бурханч лам бээр Чулуунбаатар, Цогоо хэмээх хоёр шавийн хамт модон амбаарт нууцаар гарсан гавлуудыг эмийн уусмалд буцалган цэвэрлэж байна. Үүний дараа баримтжуулан хадгалж олны хүртээл болгоход эрүүл ахуйн талаас аюулгүй болох юм.

Эдгээр гавлуудыг хожмын түүхийн баримт болгон Бурханч лам бээр хүн судлаач, шүүх эмнэлгийн эмч нартай хамтран нууцлан авч үлдсэн юм. Үүнээс 120 гавлыг судлан шинжилсэн бөгөөд одоогоор дөрвөн хэсэг газар хуваагдан хадгалагдаж байна.

Содон судлалын музейд тавихаар дахин цэвэрлэгдэж буй Хамбын овооноос гарсан гавлууд. Музейн ажилтан Д.Угтахбаяр. Төв аймаг Борнуур сум.<sup>9</sup>




*Хэлмэгдэгсдийн цогцсуудыг ариусган чандарлаад 6000 сац бүтээхэд Шаины Урлах  
Ухааны Дээд Сургуулийн багш оюутан нийлсэн 46 хүний бүрэлдэхүүнтэй баг  
ажилласан байна. 2003.05.21-ний өдөр.*



*2003 оны 8 сарын 29-өөс 9 сарын 2-нд хэлмэгдсэн лам нарын хойчийн буянд зориулсан  
шарилын суваргыг сүншиглэх ажлыг гүйцэтгэсэн юм. Суварганы сүншүгт хийхээр  
шарилын сацыг хайрцаглаж байна. Бурханч лам*

*Г.Пүрэвбат шавь нартаа сацыг хэрхэн бүтээх ёсыг биечлэн зааж буй нь<sup>9</sup>*





2003 оны 06 сарын 14-нд Хамбын овоон дээр суварга бүтээх газар авах ёслолооны үе. Үүнд Монголын бурханы шашны тэргүүн хамба Д.Чойжамц, зүүн хүрээ Дашичойлин хийдийн хамба Дамбажав, Түвдийн Жадо ринбучи зэрэг олон ихэс хуврагууд оролцсон юм.

*Хамбын овоог шинэчлэн дахин босгохын хамт хэлмэгдэлд өртсөн дээдсүүдийн хойчийн буянд зориулан Давхарлагат байшин суваргыг бүтээх ажлын явц.*<sup>9</sup>



2003 оны 8 сарын 26 нд. Суварганы чимэг зураг эцсийн бүхий л гүйцэтгэлийг Бурханч ламын байгуулсан Шашны Урлах Ухааны Сургуулийн багш оюутнууд гүйцэтгэсэн юм.



Суншугийн дотоод оршоолгоны эд зүйлсийг тээвэрлэж буй нь<sup>9</sup>



Суншугийн дотоод оршоолгоны эд зүйлс



Хамбын овоон дээр босгосон 9 метр өндөр  
Давхарлагат байшин суварга.

2003.09.10-ны өдөр.<sup>9</sup>





*Хэлмэгдэгсдийн өдрийг тохиолдуулан Их суваргыг амилуулах үед Монгол Улсын Ерөнхийлөгч Намбарын Энхбаяр ирж хүндэтгэл үзүүлээ.*

*(2003.09.11)*



*Монгол Улсын Ерөнхий сайд Цахиагийн Элбэгдорж үг хэлж хүндэтгэл үзүүлж байна. 9 (2003.09.11)*





*Их суварганд сайтар оршиолог үйлдэхээр олон лам хуврагууд ирсэн юм. Урд эгнээнд Бурханч ламын багш Ж.Доржжанцан, Ламрин хийдийн унзад Гомбо, лам Батбаяр нар.*

(2003.09.11)



*Их суварганы нээлт, амилуулагын уйл ажиллагааны дараа багш Д.Данзангаа гаргаж өгч буй Бурханч лам.*

(2003.09.11)



2003 оны 10 сард сүүлчийн удаа Монголд морилохдоо Бакула ринбучи бээр лагшин хэдий их чилээрхүү байсан ч Хамбын овооны суварганд ирж хүндэтгэл үзүүлж ерөөл тавьсан юм. Тэрбээр Бурханч ламд “Хүү минь, энэ ажлыг хэзээ ч орхигдуулж болохгүй. Өвөг дээдсийнхээ тухайтад хэлмэгдэл болсон газар болгонд хойтын буяныг энэ мэтчилэнгээр үйлдэж байгаарай. Тэр үед Бурханы шашинт дэлхий нийтийг удирдан чиглүүлж байсан шашин соёлын чадварлаг эрдэмтэд ихэвчлэн Монгол хүн байсан юм” хэмээн гэрээслэн захисан юм.<sup>9</sup>



## ХЭЛМЭГДСЭН АМЬ БҮХНИЙ ӨМНӨ...!?, ХОТЛООРОО СЭТГЭЛИЙН ЗУЛ ӨРГӨЕ.



Төв аймгийн Борнуур сумын “Содон судлалын музейд”-д тавигдсан Хэлмэгдүүлэлтийн үеийн баримт болон Хамбын овооноос гарсан цогцоснуудын гавлын ясанд залбирал үйлдэж буй нутгийн хүүхдүүд. Ихэнх хүүхдүүд эдгээр гавлын яснаас огт айж цочихгүйгээр барахгүй сонирхон асууж их эрдэмт лам нарын гавал болохыг ойлгоод бүгд өрөвдөн хайрлаж чин сэтгэлээсээ мөргөн залбирдаг юм.<sup>9</sup>



Хожим их хядлагад өртсөн хүмүүсийн цогцсыг ухан гаргаж гавлын яснуудыг энэ өндөр шилэн байшинд олон давхар тавиур дээр өрж тавиад нийтэд үзүүлж байна. Камбучи улсад шавь Лхагвадорж, түүний хадам ээж Зулзага нарын хамт



Хүн ардаа хэлмэгдүүлэн хядсан улс орнууд тэдний цогцсонд болон үйлдсэн хэрэгт хэрхэн хандаж буйг судлан яваа Бурханч лам Камбучи улсад.<sup>9</sup>

### Камбучи улсад болсон их хядлагын баримтууд

1975-1979 оны хооронд улаан Кемерчүүд гурван жил долоон сарын дотор Камбучи улсынхаа нийт хүн амын гуравны нэг буюу хоёр сая гаруй

хүнийг хядан устгасан юм. Их хядлагын баримт болгон хэлмэгдэлд өртөгдсөн хүмүүсийн гавлын ясаар Камбучи улсын газрын зургийг үйлдэн дахин ийм хядлага явагдвал улс орноороо мөхөн сүйрэх аюулд орохын сэрэмжлүүлэг болгожээ.<sup>9</sup>

### Ном зүй

1. “Их Монголын Суварга” Бурханч лам Г.Пүрэвбат 2005 он
2. “Монгол улсын түүх” I, II, III, IV, V боть, УБ., 2003
3. “Хурмаст тэнгэр” энэрэн нигүүлсэхүйн сонин, тусгай дугаар, Г.Мөнхцэцэг, УБ., 2003
4. А.Минис “МАХН-аас Феодал ангийн улс төр, эдийн засгийн ноёрхлыг устгахын төлөө явуулсан тэмцэл”, УБ, 1968
5. “МАХН-аас сүм хийд, лам нарын, эдийн засгийн хүчин чадлыг эвдэж устгахын төлөө явуулсан тэмцэл” А.Минис, УБ, 1972
6. “БНМАУ-улс хөрөнгөтний биш хөгжлийн төлөө тэмцэл” УБ, 1956 (Баримт бичгүүд Ц.Насанбалжир 1925 - 1940)
7. Б.Ринчен «Монгол Ард улсын угсаатны судлал хэлний шинжлэлийн атлас»
8. «Хаадын ном» (VIII Богдын тухай) Л.Түдэв, УБ 2001
9. “Буцаах эрхгүй бурхадын гэрээслэл” Бурханч лам Г.Пүрэвбатын ярилцлага, илтгэлийн эмхэтгэл, цуврал нэг, 2003 он

### Товч тайлбар

1937 оны есдүгээр сараас 1939 оны дөрөвдүгээр сар хүртэл хугацаанд шүүх болон Онцгой бүрэн эрхт комиссоос бүгд 25824 хүнийг төрийн эсрэг гэмт хэрэгт холбогдуулан таслан шийдвэрлэж 20474 хүнд буудан алах, 5103 хүнд арван жил хорих, 240 хүнд арав хүртэл жил хорих ял шийтгэл оногдуулж, долоон хүнийг хэрэгт холбогдолгүй болгон сулласан нь одоогоор Тагнуулын газрын архив тоо бүртгэлийн алба болон Улсын дээд шүүхийн цагаатгалын ажлын тоо бүртгэлийн мэдээгээр тогтоогдоод байна.

Онцгой бүрэн эрхт комиссоос буудан алах ял оногдуулж гүйцэтгэсэн 20474 хүний 14201 нь лам нар байв. Ер нь 1937-1939 онд 17581 ламын хэрэг гэгчийг онцгой бүрэн эрхт комиссоос таслан шийдвэрлэсэн байдаг. Зөвхөн эхний үеийн хэлмэгдүүлэлтээр “Хувьсгалын эсэргүү” хэмээх тодотголтой 70 орчим хэргээс хожим 2004 оны байдлаар 60-аадыг нь л цагаатгасан билээ. Энэхүү Монголын уламжлалт шашин соёл, эрдэмтэн мэргэдийг устгасан үйл ажиллагааг дүгнэж Монголын эрх баригч намын тэргүүн Ю.Цэдэнбал хэлэхдээ “Олон мянган лам нарыг нийгмийн тустай хөдөлмөрт оруулж, дээд ангийн харгис лам нарыг ялсан нь ач холбогдлоороо 1921 оны хувьсгалтай бараг энэ зэрэгцэх хувьсгалт үйл явдал болсон юм”

хэмээн дүгнэжээ. Ийн Монгол орноо ид мандан цэцэглэж оргилдоо хүрч байсан бурханы шашны наран бүрэн шингэж, дээдийн номын ёст монгол түмэн сэтгэлийн мухартаа өвгөдийнхөө үнэн ном гэрээслэл бүхнийг далдлан битүүмжиллээ.

1940 оноос хойш хүн амын мухар сүсэг хэмээн нэрлэсэн дээдийн үнэн номонд итгэх сүүлчийн итгэл бүхнийг нь даван туулах зорилт голлон, түүх болон өвгөд дээдсийн замнал, дээдийн номын тухай тэнгэр газрыг сольсон мэт эсрэг номлолын дуун үл тасрах болов.

Энэхүү түүхэн харанхуй үед монгол орон дахь дээдийн номын эх үндсийг дахин залгах цор ганцхан оч нь Төгс баясгалант их хөлгөн хийд болсон юм.

## МОНГОЛ ОЮУТАН СУРАГЧИД УЛС ТӨРИЙН ХЭЛМЭГДҮҮЛЭЛТЭД ӨРТСӨН НЬ” (1926-1930 ОН)



*Р.Төрдалай  
Магистр  
ШУА-ийн Олон улсын харилцааны  
хүрээлэн*

### **1. Герман, Францад суралцсан монгол оюутан, сурагчдыг хэлмэгдүүлэх улс төрийн нөхцөл бүрэлдэж эхэлсэн нь**

Өнөөгийн бидний амьдран буй нийгмийн харилцааг нэгэн зууны өмнөх өвөг дээдэс маань холч ухаанаараа нээн харж чаджээ. Монгол орныг олон улсын эдийн засаг, худалдаа, соёл, шинжлэх ухаан хөгжсөн улс болж, ард иргэд нь баян чинээлэг, эрх чөлөөтэй, эрдэм мэдлэгтэй, ирээдүйн соёлч хүн төрөлхтөний нэгэн хэсэг байгаасай хэмээн тэд үнэн сэтгэлээ хүсч тэмүүлж байв. Энэ үүднээс сурагчдаа Герман, Франц улс руу бололцооныхоо хэрээр явуулан сургаж, өрнөдийн хөгжингүй орнуудын хөрөнгө оруулалттай үйлдвэр, аж ахуйн газруудыг манайд үүд хаалгаа нээхэд нь туслаж байлаа.<sup>1</sup>

1926 оноос Монгол-Германы боловсролын салбарт дахь харилцаа өргөжсөөр зохистой үр дүнд хүрсний илрэл нь “Герман, Франц дахь монгол сурагчдын захиргаа”, “Берлин дэх Монголын худалдааны төлөөлөгчийн газар” зэрэг байгууллага ажиллаж болж, манай улсын Өрнө дахин руу хандсан бодлого тогтворжиж шинжтэй болж иржээ. Гэвч энэ байдал удаан үргэлжилсэнгүй. ЗХУ, Коминтерний зүгээс Монгол улсад цэрэг, улс төр сонирхлоо дангаар тогтоох, цаашилбал тус улсыг гадаад ертөнцөөс бүрмөсөн салган тусгаарлах гэсэн улс төрийн зорилгоо хэрэгжүүлэхийг эрмэлзэх болжээ. Энэ нь манай улсаас Өрнөдийн орнууд, ялангуяа Герман улстай харилцаагаа бататган хөгжүүлэх гэсэн үзэл баримтлалтай илт зөрчилдөх болсон юм.

<sup>1</sup> Р.Төрдалай, Монгол-Германы соёл, боловсролын харилцаа: Монгол оюутан, сурагчид Герман улсад суралцсан нь (1926-1930 он), Герман: Судалгаа, мэдээлэл сэтгүүл, Улаанбаатар, 2004, 78-160 т.



ЗХУ нь манай улсыг цэрэг, улс төрийн үүднээс илүүтэй сонирхож байсан нь шалтгаан нь Дэлхийн I дайнаас сургамж авсан тус улсын Алс дорнод дахь аюулгүй байдалтай холбоотой геополитикийн ашиг сонирхол байсан бололтой.

Коминтернийг төлөөлөн Монгол улсад сууж байсан төлөөлөгч М.И.Амагаев манай Засгийн газрын гадаад харилцааны үзэл баримтлалыг ЗХУ, Коминтерний үйл ажиллагааны салшгүй хэсэг гэсэн улс төрийн идэвхтэй байр суурийг баримталж байлаа. Иймээс түүний ажлын төлөвлөгөөнд 1926 онд Герман, Францад суралцуулахаар илгээсэн 40 гаруй оюутан, сурагчдаас бүрдсэн залуучуудын багийг эргүүлэн татах, улмаас ЗХУ-аас гадна өөр түншлэл харилцааг эрэлхийлж байсан “баруунтан” удирдагчдын үзэл баримтлалыг илрүүлэн устгах явдал байв.

1927 оны сүүлээс Монгол-Герман хоёр улсын харилцаа, ялангуяа боловсролын салбар дахь хамтын ажиллагаа нь Коминтерний анхаарлын төвд байх болж, уг асуудлаарх ЗХУ-ын байр суурь эрс идэвхжсэн байна. 1927 оны 12 дугаар сарын 14-нд КИГХ-ны Дорнодын Нарийн Бичгийн дарга нарын газрын хуралдаан дээр Монголын асуудлаар М.И.Амагаевын тавьсан илтгэлд “Монгол улсын соёл, боловсролын байдал ба Герман улс дахь Монголын оюутан, сурагчдын төлөв байдал, үйл ажиллагааны цаашдын хандлагыг хөндөн авч үзсэн байдаг.

Тэрээр илтгэлдээ тэмдэглэхдээ “... Гадаадад очиж харь хэлээр суралцаж байгаа залуучууд Герман, Франц, ЗХУ, Хятадын алинд ч бай, соёлыг монгол хэлээр бус, өөр нэг харь хэлээр эзэмшээд ерөнхий соёлын наад захын зүйлийг өөрийн хэлээр дамжуулах чадваргүй ийм нэг нөхцөл байдлыг тэмдэглүүштэй. Бид Монголын хилийн гадна суралцаж байгаа бидний толгой дараалан мэдэх 140 залуугийн чанар чансааг үнэлэх үзлийн үүднээс ийнхүү хандаж байна. Эдгээр залуус Монгол орондоо хоёрдмол сэтгэхүйтэй болоод үндсэндээ харийн харш соёлтой хүмүүс болж ирнэ” гэжээ.

М.И.Амагаевийн дээрх хэлсэн үг нь ирээдүйд Монгол улсад харилцан адилгүй нийгэмшил, соёлын төлөвшлийг авсан Монголын залуу үеийн соёлын хямрал, зөрчилдөөн гарч болзошгүй тухай өгүүлсэн санаа агуулагдаж байна. Тэрээр илтгэлдээ цааш дурдахдаа:

“... Миний бодоход Герман, Франц зэрэг хөрөнгөтөн улсад суралцаж байгаа залуус хэдийгээр сэтгэхүй нь хоёрдмол ч гэсэн ЗСБНХУ-ын нутаг дэвсгэр дээр сурч буй хүмүүсийг бодвол дотоод сэтгэлийн хувьд илүү бүхэл, бүтэн шинжтэй байх болно. Яагаад гэвэл үүний нууц нь Герман, Франц гэх мэтийн оронд сурч байгаа хүмүүс тодорхой үзэл суртлыг эзэмших бөгөөд тэр үзэл суртал нь

2 «Коминтерн ба Монгол» (баримтын эмхэтгэл, УБ, 1996, 199-200 дугаар тал.

одоо Монголын албан ёсны олон нийтийн дунд ноёрхож байгаа үндсэн шугамтай зөрчилдөхгүй байгааг ухаарч мэдэхэд орших болно<sup>3</sup>” гэжээ.

КИГХ-ноос Монгол улсад болж буй үйл ажиллагааны тухай М.И.Амагаевийн тайлан илтгэлийг сонсоод 1928 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн КИГХ-ны Монголын комиссын хуралдаанаас Монголд КИГХ-ны төлөөлөгчийн газар байгуулах, МАХН-ын програм зохиох комисс томилох, нэн ялангуяа ЗСБНХУ-д суралцах монгол оюутны тоог нэмэгдүүлэх тухай тогтоол гаргасан байна.

Улмаар КИГХ-ны 1928/29 оны хичээлийн жилд Монгол улсаас суралцах нийт оюутны тоог 50 хүртэл нэмэгдүүлэх тухай КУТВ-ийн шийдвэрийг сайшаан батласан байна<sup>4</sup>.

Энэ шийдвэр нь Монгол улсын Засгийн газраас Баруун Европын хөгжингүй Герман зэрэг орнуудад оюутан, сурагчдаа илгээн суралцуулж байгаа асуудлыг таслан зогсоох, Монгол улсын ирээдүйн боловсон хүчнийг дан ганц ЗХУ-д бэлтгэгдсэн хүмүүсээр бүрдүүлэх замаар Монгол улсад хувьсгалын үзэл санаагаар төлөвшиж хүмүүжсэн нийгмийн шинэ ангийг бий болгож, Коминтерний улс төрийн байр суурийг бэхжүүлэхэд чиглэгдэж байв.

МАХН-ын VII их хурлын өмнөхөн гаргасан КИГХ-ны Улс төрийн нарийн бичгийн дарга нарын газрын дээрх тогтоол нь МАХН-д “барууны” аюул бүрэлдэн бий болгосны тэмдэглэж, тус нам дахь зүүн хөдөөгийн төлөөлөгчдийг дэмжих замаар МАХН дахь “эрүүл бус” гажуудлыг арилган засахад чиглэгдсэн байна.

ЗХУ, Коминтерний дээрх улс төрийн шахалтан доор МАХН дахь зүүний бүлгийн үйл ажиллагаа эрс сэргэж ирсэн бөгөөд 1928 оны 10 дугаар сарын 23-наас 12 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл хуралдсан МАХН-ын VII их хурал нь тус хүчний улс төрийн байр суурийг эрс идэвхжүүлжээ.

1921 оноос хөтөлбөргүй баримталж ирсэн Монгол Улсын гадаад бодлогын олон талт үзэл баримтлал энэ үеэс үндсэндээ өөрчлөгдөв. Намын VII их хурлын “Улс төрийн тухай” ерөнхий тайлан илтгэлд

“... одоогийн гадаад байдал түгшүүртэй болсон цаг үест гадаад лугаа харилцах бодлогоо улам тодорхой болгож ялангуяа манай улсын тусгаар тогтнох явдал Холбоот улс лугаа гүнээ холбогдох учир холбоо найрамдлыг улам бататгаж завсардуулах харшлах этгээдийг шууд эсэргүүцэн устгаваас зохино<sup>5</sup>” гэж зааснаас тодорхой харагдаж байна.

Гадаад улсуудтай харилцах явдалд Монгол улсын Засгийн газрын өмнө баримталж байсан эрх тэгш, харилцан ашигтай байх үндсэн

3 Мөн тэнд

4 Мөн тэнд 231-232 дугаар тал

5 МАХН-ын VII их хурал, УБ, 1980, Т.40

дээр ямар ч улстай холбоо харилцаа тогтооход бэлэн байсан олон талт гадаад бодлогын асуудал Намын Их хурал дээр санал зөрөлдсөн үндсэн асуудал болон хувирчээ. Ялангуяа гадаадад суралцахаар явж байгаа оюутан, сурагчдыг "... сайтар хянан шалгаж зөвхөн улсын санхүүг үрэн шамшигдуулж газар үзэж гарлага болгон тэнэж яваад хоосоор ирэх буюу эс бөгөөс ядуу дунд ангийн байдлаас их л дээрэнгүй бөгөөд баячууд хөрөнгөтний байдал дадлыг олж хувьсгалын дайсан мэт болж ирэх гэмүүдийг ариутган чухалчлахыг"<sup>6</sup> онцлон тэмдэглэжээ.

МАХН-ын VII Их Хурал дээр КИГХ-ны төлөөлөгчдийн тэргүүн Б.Шмералаас 1928 оны 12 дугаар сарын 5-нд Их хурлын ажлыг дүгнэж хэлсэн үгэндээ баруунтан удирдагчдын Германд оюутан, сурагчид илгээн суралцуулсан явдал нь ЗХУ, Коминтернээс холдон салах гэсэн санаархлын илрэл гэдгийг онцлон заасан байна.

Ийнхүү МАХН-ын VII их хурлын дараагаар Монгол улсын нийгэм, эдийн засаг, соёл, боловсролын салбар дахь үйл ажиллагааны хандлага төлөв эрс өөрчлөгдөж, 1921 оны Үндэсний ардчилсан хувьсгалын дараа өрнөсөн үндэсний уламжлал эрх ашгаа дээдэлсэн, олон тулгуурт гадаад бодлого явуулах хэтийн зорилготой төрийн бодлогын залгамж чанар алдагдаж, улс орон бүхэлдээ хэт хувьсгалжсан цаг үеийг туулах эхлэл тавигдлаа.

Энэ нөхцөлд Германд суралцаж байсан сурагчдаа эргүүлэн татаж авчрах нь тодорхой болсон бөгөөд 1930 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Зөвлөлтийн Гадаад Хэргийн Ардын Комиссарат Караханд Улсын Армийн Жанжин Штабын 4-р газрын дарга Берзинээс явуулсан маш нууц бичигт

"... Бидэнд байгаа мэдээгээр МАХН-ын эрх барьж байсан баруунтан удирдагчид хөрөнгөтөн оронд сурагч илгээжээ. Үүнээс 5 нь Парижийн Эдийн засгийн сургуульд, 20 нь Германы янз бүрийн сургуульд сурдаг ажээ. Монголын боловсон хүчнийг өөр улсад сургах нь бидний хувьд хүлээж авч эс болох зүйл. Монголын Засгийн газарт зохих хэлбэрээр даралт үзүүлж, Герман, Францад суралцаж байгаа монголчуудыг татуулан, улмаар залуучуудыг тэдгээр орны сургуульд цаашид илгээхээс татгалзуулах нь чухал гэж Цэрэг, Далайн цэргийн Ардын Комиссариатын орлогч Уиншлихт үзэж байгааг Танд мэдэгдэе"<sup>7</sup> гэжээ.

ЗХУ-аас ийнхүү олон талын даралт шахалт үзүүлэх арга хэрэглэж байснаас гадна манай дотоодод ч ихээхэн эсэргүүцэл өрнөх болжээ. МХЗЭ-ийн VIII Их хурал дээр төлөөлөгчдөөс "Герман, Франц зэрэг улсуудад явуулсан залуусаа яаралтай дуудвал зохино. Тэд бидэнд

6 Мөн тэнд

7 "Зохих хэлбэрээр даралт үзүүл" (архивийн баримтууд), Ил товчоо сонин. УБ 1995.

ямар ч ашиг тус өгөхгүй<sup>8</sup>” гэсэн саналыг зүүнтнүүдийн дийлэнх нь баримталж байв.

Зүүнтэн удирдагчдын зүгээс Герман дахь сурагчдын асуудалд анхнаасаа ангич байр сууринаас хандаж байсан боловч тэдгээр сурагчдыг нэгмөсөн эргүүлэн татаж авчирч чадаагүй бөгөөд харин хэсэг хэсгээр нь оюутан сурагчдаа татаж авах замаар 1930 онд багтаан бүх сурагчдыг нутагт нь дуудан авчирсан байна.

Ингэснээр Герман, Франц улсын 10-аад хотод төрөл бүрийн мэргэжлээр суралцаж байсан манай 40 гаруй оюутан, сурагчид сургуулиа бүрэн төгсөж амжилгүй эх орондоо дуудагдан ирсэн ба тэднийг хөрөнгөтөн оронд суралцсан хэмээн улс төрийн хилс хэрэгт холбогдуулан хэлмэгдүүлэх бараан өдрүүд хүлээж байсан юм.

## 2. “Герман тагнуулын хэрэг” гэх хэлмэгдүүлэлтэд өртсөн нь

Эх орондоо эргэн ирсний дараа Герман, Францад суралцсан залуусын амьдрал төдий л сайн байсангүй. Элдэв хардлага сэрдлэг, гүтгэлэг, дарамт тасардаггүй байсан бөгөөд ихэнх нь олигтой ажил төрөл эрхэлж, сурч мэдсэн эрдмээ бүрэн гүйцэд улсынхаа төлөө зориулж чадаагүй юм. Тэдгээр сурагчид нь ихэвчлэн язгууртан гаралтай гэр бүлд төрж өссөн хүүхдүүд байсан нь (Жишээлбэл, тайж угсаатай Д.Нацагдорж, Түшээт хан аймгийн Баатар вангийн хошууны угсаа залгамжилсан ноён Наваан-Юндэн, гүн Гомбожавын охин Хаалай гэх мэт) нийгмийн бүхий л үнэлэмж нь ангийн тэмцэл, хөрөнгөтний эсрэг тэмцэх уриатай болж байсан нийгэмд хамгийн түрүүнд улс төрийн хилс хэргээр хэлмэгдэх шалтаг болсон нь дамжиггүй биз ээ.

1932 оны 5 дугаар сарын 12-ны орчим Дотоодыг хамгаалах газрын дарга Намсрайн тушаалаар Германд суралцсан Д.Нацагдорж, Н.Наваан-Юндэн, Д.Намдаг, Б.Гомбо нарын зэрэг 12 хүнийг баривчилж, 1932 оны 5 дугаар сарын 18-ны өдрөөс Дотоодыг хамгаалах нууц улс төрийн хэлтэс байцаан хорьж эхлэснээр Германд суралцсан оюутан, сурагчид хэлмэгдүүлэлтэд өртөж эхэлсэн байна.<sup>9</sup>

Тэднийг баривчлан хорьсон гол үндэслэл нь 1932 оны шинэ жилийн баяраар “Манж-го” хэмээх улсын 1 жилийн ойг тэмдэглэсэн”, “Берлин Бат-Очирын Дотоодыг хамгаалах газарт явуулсан “Тайж Нацагдоржийн банкет” нэртэй гэрэл зураг”, “Намдагийн гэрээс олдсон Засгийн газрын тамганы дардас бүхий цэвэр хуудас”, түүнчлэн “Д.Намдаг нь Майн нэгний өдөр тагнуулын зорилгоор цэргийн зургийг нууцаар авч байсан”, “Д.Нацагдоржийг гадаадын тагнуулын

8 Б. Батбаяр “ XX зууны Монгол: Нүүдэл суудал, гарз олз”, Улаанбаатар, 1996, Т.390

9 Монгол улсын Тагнуулын Ерөнхий газрын Тусгай архив, Ф-1, ХН-Ц423, х-1.

байгууллагатай холбоотой ажилладаг<sup>10</sup>” зэрэг олон зохиомол зүйлүүд байжээ.

Эдгээр зохиомол зүйлүүдээр ял тулгаж тэдгээр залуусыг 1932 оны 10 дугаар сарын 19-нийг хүртэл байцаан хорьж хэлмэгдүүлсэн нь ангич онол, үзэл сурталжсан хардалтын хаялга байлаа. Их зохиолч Д.Нацагдорж эхний байцаалтаар:

“Миний бие Герман улсын Лайпциг хотын их сургуулийн багш Хэниш гэгч хүн лүгээ 19 онд нэг удаа захидал бичиж, латин үсгийн цагаан толгой нэгийг шуудангаар явуулсан. Мөн энгийн сайхан танилцсан хоёр герман эмэгтэй, манай Төмрийн заводад 1929 онд хамт ажиллаж агсан швед мэргэжилтэн, түүний гэргий нартай удаа дараа захидлаар харилцаж, хүн ёсны дагуу амар мэндээ мэдэлцэж явсан. 21 онд урьд таних Лооройсамбуу, Гомбожав, архины газрын сургагч орос, хэвлэлийн хорооны сургагч орос, Бат-Очир, Галун нар эхнэрийн хамтаар хэд хэдэн удаа архи ууж, наргиж цэнгэлдэж байсан бөгөөд харин эдний хэдэн этгээдтэй улс төрийн хор холбогдол бүхий үгийг ярих буюу хийж үйлдэж байсан ба үйлдсэн хийснийг огт мэдэж үзээгүй” гэж мэдүүлж байжээ.

Гэвч түүнийг хөрөнгөтний хүмүүс, тагнуул туршуултай холбоотой ажилладаг, гадаадад гарах санаатай, мөрийтэй тоглодог гэх мэтийн ялыг тулгасан бөгөөд эдгээр нь цөм үндэслэлгүй зүйл байсан нь тодорхой. Энгийн сайхан найз нөхөд хоорондоо уулзаж, нэгэн оны шинэ жилийг хамтаа угтаж тэмдэглэсэн нь улс орны хувь заяатай холбоотой улс төрийн томоохон хэрэг болно хэмээн тэдний хэн ч тааж мэдээгүй болов уу. Ялангуяа Д.Намдагийн хувьд 21 настай залуу хүн байсан тул энэхүү хэлмэгдүүлэн баривчилсан явдал нь ихээхэн хүндээр туссан байдаг. Энэ тухай Д.Намдаг гуай хожим өөрийнхөө дурдатгалдаа бичихдээ:

“Энэхүү 1932 он гэвэл тус орны дотоодод маш хатуу жил боллоо. Хөвсгөл, Завхан, Архангай гурван аймгийн дунд гарсан хувьсгалын том эсэргүү бослого бараг 6 сар үргэлжилж байж дарагдав. Миний хувьд гэвэл би 5 дугаар сарын 16-нд Дотоодыг хамгаалахад баригдаж, улс төрийн том хэрэгт байцаагдахад хүрэв. Гэхдээ энэ хэрэгт би ганцаараа биш, нийт 12 хүн. Энэ хэрэгт холбогдогсод цөм сэхээтнүүд. Эдний дундаас хамгийн бага, хамгийн мэдэц дорой, буурай нь би байлаа”<sup>11</sup> гэжээ.

Д.Намдагийг шоронд байх хугацаанд нь давхар биетэй үлдсэн эхнэр Лхам нь насан өөд болсон ба хадам эцэг партизан Балдандорж нь мөн баригдаж хэлмэгдсэн байлаа.<sup>12</sup>

10 Р.Төрдалай, “С.Наваан-Юндэнгийн байцаалтын протоколд хийсэн судалгааны зарим ажиглалт”, Герман судалгаа мэдээлэл сэтгүүл, УБ, №5(2006), Т.88-102.

11 Д.Намдаг, Шинэ Монголын шинэ театр, Дуртгал, УБ, 1988.

12 Ч.Болд, Алс газар сурахаар одогсод, Дэд дэвтэр, УБ, 2016.

Шоронд хоригдож байсан үеийнхээ тухай Д.Нацагдорж мөн оны 8 дугаар сарын 15-нд бичсэн нэгэн захидалдаа:

“...Өдгөө гянданд суун бие тэсэхүйеэ болж буйн” учрыг гаргаад хийсэн хэрэггүй “хилсээр хоригдон буй болох тул даруй хэргийг цагаатган өршөөлийг үзүүлмүү” гэж мэдүүлснээр удалгүй 1 жилийн тэнсэн харгалзах ялтайгаар Д.Намдагийн хамт 1932 оны 10 дугаар сарын 29-нд суллагдсан байна.<sup>13</sup>

Энэ үеэс их зохиолч Д.Нацагдоржийн амьдрал уруудах тал руугаа орсон гэж хэлж болно. Тэрбээр албан ажил, ар гэрийнхээ тал дээр ч ганцаардах болж дотны хэдэн найз нөхдийг эс тооцвол нийгмийн зүгээс түүнийг “гэмт этгээдийн” нүдээр үл итгэн харах болсон байлаа. Гэвч Д.Нацагдорж ЗХУ-д явж суралцан мэдлэг боловсролоо дээшлүүлэх үүднээс өргөдөл гаргаж, 1937 оны 10 дугаар сард түүний асуудал үндсэндээ шийдэгдээд байтал өмнө нь ял шийтгэл эдэлж байсан, өр суутгалтай, албан ажлын гэрээ дуусаагүй, архи дарс уудаг зэрэг шалтгаанаар гадагш явуулахыг хүчингүй болгосон байдаг.

Улс эх орон нь түүнд ийнхүү итгэл хүлээлгээгүй нь түүнд хүнд цохилт болж тэрээр 1937 оны 7 дугаар сарын 13-нд харамсалтайгаар нас эцэслэсэн юм. Энэ тухай Т.Гэндэн гуай бичихдээ:

“Боловсрол, мэргэжил олсон (Герман улсад Р.Т.) тэр залуучууд шорон гяндан дамжиж, эрэмдэг зэрэмдэг болсон төдийгүй насан турш сэтгэлийн шархтай, өөдтэй ч амьдралгүй өнгөрчээ. Их зохиолч Д.Нацагдоржийн амьдралын зам алмайрч, архиар сэтгэлээ засч, сүүл сүүлдээ бараг орох оронгүй, эрхлэх ажилгүй тэнүүчлэн явсаар цэл залуудаа гудамжинд өөд болсны буруутан Дотоод яам биш гэж маргах мэргэд олон гарахгүй байх гэж бодож байна”<sup>14</sup> хэмээсэн байдаг.

Өөрөөр хэлбэл, 1932 оны энэхүү хилс ажиллагааны агуулгаас харахад хожим Дотоод явдлын яамны буй болгосон “Герман тагнуулын хэрэг” гэгч зохиомол үйл ажиллагаа энэ үеэс үндэс сууриа тавьж байсан нотлогдож байна.

1930-иад оны сүүл үеэс олон улсын байдал нэн тогтворгүй болж, үзэл суртлаар зааглагдсан шинэ хүчний төвүүд бий болж, олон улсын байдал тогтворгүйжсэн зэргээс шалтгаалан БНМАУ-ын аюулгүй байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал ЗСБНХУ-аас нягт хамааралтай болсон юм. 1936 оны 3 дугаар сарын 12-нд Монгол-Зөвлөлтийн удирдлагууд 10 жилийн хугацаатай харилцан туслалцах протоколд гарын үсэг зурсан байна.<sup>15</sup>

13 А.Очир, Г.Дашням, Д.Нацагдорж: Нийгэм, улс төр, эрдэм судлалын үйлс, амьдрал, УБ, 1996, 165 дугаар тал.

14 Т.Гэндэн, “Гурван түмэн хүний амь”, Редактор Л. Чулуунбаатар, УБ, 1999.

15 “БНМАУ-ын гадаад харилцааны баримт, бичгүүдийн эмхэтгэл” (1921-1961), боть. 1, УБ 1964, Т. 288



Олон улсын тогтворгүй байдлаас шалтгаалан БНМАУ-д жил ирэх тутам ЗХУ-ын нөлөө, үзэл суртал хүчтэй болсон, түүнчлэн Герман дахь улс төрийн түгшүүртэй байдал зэргээс улбаалан 10 гаруйхан жилийн өмнө Германд сурагчдаа илгээн суралцуулж, худалдаа, эдийн засгийн өргөн харилцаа тогтоохыг чухалчилж байсан тэрхүү бүлээн дулаан үеийг санагдуулах зүйл монголчуудын дунд бараг үгүй болсон байлаа.

Олон улсын харилцааны хурцадмал байдлыг дүгнэн шинжилж 1937 оны 10 дугаар сарын 22-26-ныг хүртэл хуралдсан МАХН-ын Төв Хорооны III Бүгд хурал дээр Х.Чойбалсангийн илтгэлийг сонсоод гаргасан тогтоолын 1 дүгээр зүйлд:

“Одоо бүх дэлхийн олон улсын байдал улмаар хурцдаж байгаа бөгөөд фашистын засагт Япон, Герман, Итали улсуудын холбоо нь бага буурай улсуудыг дайран довтлох ажлуудыг эмхэлж, тэдний тусгаар тогтносон байдлыг эвдэн устгаж өөрсдийн колони болгохыг эрмэлзэн бүхий<sup>16</sup>” гэж онцлон тэмдэглэжээ.

1927 оны намын VII их хурлаас эхлэн ЗХУ-ын шууд дэмжлэгтэйгээр зүүнтнүүд удаа дараа албан ёсоор шүүмжилж байсан Герман, Францад сурагчдыг явуулсан асуудлыг энэ үеэс үзэл сурталжуулан дэвэргэж эхлэв. 1920-иод оны сүүлээр баруунтны олон удирдагчдыг хөрөнгөтөн улсуудтай түншилсэн хэргээр буруутгахад эл асуудал гол үндэслэлийн нэг болж байсан бол харин хожим олон улсын байдал тогтворгүй болмогц фашизмын эсрэг тэмцлийн бай болж хувирсан байна. Түүнийхээ баталгаа болгон Германд сургуульд явсан сурагчдыг мөрдөх ажлыг Дотоод явдлын яам 1938 оноос эхлүүлжээ.

Ийнхүү Герман оронд хүүхдүүдээ сургуульд явуулсан “томчуул”-ыг хэлмэгдүүлж дууссаныхаа дараа сургуульд явсан “бага”-чуудтай үргэлжлүүлэн “тооцоо бодож” эхэлсэн байна. БНМАУ-ын нүд чих болсон Дотоод явдлын яамны эл ажиллагаа нь манай талын хувьсгалч сонор сэрэмжийг ЗХУ-ын өмнө нотлон харуулахад чиглэгдсэн байж болох талтайг манай ахмад судлаачид бүтээлдээ тэмдэглэсэн нь бий.

1938 оны 3 дугаар сарын 23-ны өдөр Дотоодыг хамгаалах газраас эх орноосоо урван тэрсэлж, хувьсгалын эсэргүү Японы тагнуулын ажилд оролцож байсан нь баримттайгаар илэрсэн гэх үндэслэлээр Герман суралцаж байсан залуусыг дайчлан баривчилжээ. Тэдэнд мөрдөн байцаалт явуулж, зохиомол хэрэгт холбогдуулан шийтгэсэн боловч удалгүй мөн оны 9 дүгээр сарын 15-ны өдөр зарим хэргээ бүрэн хүлээгээгүй, нуун дарагдуулсан нь сүүлийн үеийн баримтуудаас тодорхой илэрсэн хэмээн дахин баривчилжээ.

16 “МАХН, Их, бага хурал, Төв Хорооны Бүгд хурлуудын тогтоол шийдвэр” (1921-1939), боть1, УБ 1956, Т.595.

Мөрдөн байцаалтын эхний шатанд тэдэнд Японы тагнуулын байгууллагын гишүүн байсан гэж тулгахыг оролдож байснаа удалгүй Германы тагнуулын байгууллагын идэвхтэн гишүүд болгохоор байцааж эхэлсэн байна. Энэ удаад Н.Наваан-Юндэн, Д.Намдаг, Ч.Бавуу, Бат-Очир, Ш.Цэвэг, “Бага” хэмээх Төмөрийн Нацагдорж нарын олон хүнийг баривчилан хорьсон байна. Ялангуяа Н.Наваан-Юндэн бага насандаа Баатар вангийн хошууны засаг ноён явсан тул Дотоод явдлын яам түүнийг ангийн дайсан, феодал гэж үзээд тулгасан хэргээ улам бүр дэвэргэхэд нөлөөлсөн байна.

Учир нь Н.Наваан-Юндэнг мөрдөн байцаасан үйл явцыг ажиглахад Дотоод Явдлын яамны байцаагчид түүнээс 1943 оны 8 дугаар сарын 20-ны өдөр авсан байцаалтаа “Феодал Баатар ван хэрэгтэн Наваан-Юндэнг байцаасан тогтоол<sup>17</sup>”, мөн оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн байцаалтаа “Хуучин Түшээт хан аймгийн Баатар вангийн хошууны ноён явсан тайж феодал язгууртай Даржаагийн хэрэгтэн Наваан-Юндэнд байцаалт явуулсан тогтоол<sup>18</sup>” гэх зэргээр нэрлэснээс тодорхой харагдана.

Энэ нь Дотоод явдлын яам Н.Наваан-Юндэнг 1913-1921 он хүртэл хуучин Түшээт хан аймгийн Баатар вангийн хошууны засаг ноён явсан, удаан хугацаагаар Герман улсын сургууль, соёлд суралцан хөрөнгөтний үзэл онолоор хүмүүжин хувьсгалт ёсыг үл ойшоон хөрөнгөтний үзэл, онолтой болж хүмүүжсэн, тиймээс эртнээс ардын хувьсгалт нам, засгийн эсрэг хандаж, тус улсын хувьсгалт нам, засгийг устган Монгол улсыг хөрөнгөтний замаар хөгжүүлэх зорилготой Германы тагнуулын байгууллагад элсэж тагнуулын тоог олшруулах зорилгоор уг байгууллагадаа гишүүн элсүүлэх, тагнуулын ажлуудыг үйлдэж явсан гэж хардаж сэрдсэнтэй холбоотой юм.

1938 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн Үнэн сонины № 77 (1552)-д Ерөнхий сайдын жинхэнэ орлогч бөгөөд Улсын өрлөг жанжин Х.Чойбалсан “Хувьсгалын 17 жилийн ойд хувьсгалын дайснуудыг тэмцэн устгасан түүхт туршлага ба цаашдын үүргүүд” гэдэг мэдэгдэл хийсэн нь Дотоод явдлын яамны мөрдөн байцаагч нарт Япон, Германы тагнуулчдыг илрүүлэн олж устгах ажиллагаанд нь үзэл суртлын суурь болж өгчээ. Тэрээр хэлэхдээ:

“... фашизмын дээрэмчний үнэн нүүрийг олон түмнийхээ өмнө илрүүлэн гаргаж тэдгээрийн хорт явуулга хөнөөлийг яруугаар огтчин устгаж дуусгаад товрог болгоход бүрэн нөхцөл буй бөгөөд хэрхэвч тэдэнд мэхлэгдэхэд хүрэхгүй болмой<sup>19</sup>” гэж цохон тэмдэглэсэн байна.

17 Мөн тэнд, 26 дугаар тал

18 Мөн тэнд, 55 дугаар тал.

19 Чойбалсан., “Хувьсгалын 17 жилийн ойд хувьсгалын дайснуудыг тэмцэн устгасан түүхт туршлага ба цаашдын үүргүүд”, Үнэн сонин, 1938 оны 7 дугаар сарын 15-ны өдөр, № 77 (1552).

Дотоод явдлын яамны бие бүрэлдэхүүн Герман оронд суралцсан сурагчдыг хилсээр хэлмэгдүүлэх ажиллагаа гүнзгийрэхэд энэ мэдэгдэл үзэл суртлын хувьд нөлөөлсөн нь дамжиггүй юм. Мөн Герман улсад улс төрийн байдал хурцадсан гэдэг үндэслэлээр БНМАУ-д ЗХУ-ын зөвшөөрлөөр худалдааны үйл ажиллагаа явуулж байсан Германы Востваг (Wostwag) кампанийг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1938 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн тогтоолыг үндэслэл болгон Сангийн яамны сайд Ю.Цэдэнбалын тушаалаар үйл ажиллагааг зогсоосон байна<sup>20</sup>. Ингэснээр ЗХУ-ын зөвшөөрлөөр БНМАУ-д үйл ажиллагаагаа явуулж байсан Германы хувь нийлүүлсэн кампанийг БНМАУ-аас шахан гаргажээ.

Дэлхийн II дайны жилүүдэд Германд суралцсан хүмүүсийг байцаан мөрдөх ажиллагаа эрс ширүүсч, Дотоод явдлын яамнаас “Герман тагнуулын хэрэг”-ийг зохиомлоор бий болгоод 1941 оны 7 дугаар сараас эхлэн 1942 оны 6 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл чангалан байцааж байв.

Улмаар 1943 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр УБХ-ын Тэргүүлэгчдийн 21 дүгээр тогтоолоор дээрх хэргийг шийдвэрлэх тусгай комиссыг байгуулсан байна.

Залуусыг шоронгийн орос, монгол байцаагчид ээлжлэн байцаах болж, Германы тагнуулын байгууллагатай хэдийнээс, хэрхэн холбогдон ажиллаж байсан, хэн хэнтэй хамсаатан болох, ямар ямар ажиллагааг зохион байгуулсан зэрэг зохиомол зүйлээ батлахын тулд хатуу чанд мөрдөн байцааж байжээ.

Эхний үед тэд “Германы тагнуулын ямар ч байгууллага байгаагүй, тагнуул хийсэн хүний тухай дуулсан, үзсэн харсан зүйл үгүй, бид Герман улсад эрдэм сурахаар явсан. Тагнуул хийхээр яваагүй” гэж чин үнэнээ мэдүүлсээр байсан боловч хэргээ хүлээхгүй нуун дарагдуулсан гэх үндэслэлээр тэднийг улам бүр чангалан байцаах болсон байна.<sup>21</sup> Зөвхөн “Герман тагнуулын хэрэг”-ээр хэлмэгдсэн хүмүүс ч бус манай улсын гэм зэмгүй олон иргэд Дотоод явдлын яамны тарчлаан зовоох байцаалтын хүнд бэрхийг амсаж, зарим нь шоронд амиа алдсан юм.

Жишээ нь, 1937 оны 9 дүгээр сарын 10-нд “Ж.Лхүмбийн хэрэг”-г холбогдон баривчлагдсан Б. Ринчин аругайг мөн хувьсгалын эсэргүү, Япон тагнуул гэж хилсээр ял тулган байцааж байжээ. Тэрээр Дотоод явдлын яамны тамлан зовоолтын улмаас хилсээр хэрэг хүлээж байсан тухайгаа Намын Төв Хорооны Тусгай комисст хожим бичихдээ:

“Миний бие 1937 оны 9 дүгээр сарын нэгэн шөнө гэнэт баривчлагдаад, Японы тагнуул хийж байсан гэдэг оргүй түмэн хилс хэрэгт тулгагдан байцаагдсан билээ. Ардын хувьсгалт төрийн хууль

20 Үндэсний Төв Архив. Фонд № 359, данс-1, хадгаламжийн нэгж-128, хуудасны дугаар 3.

21 Монгол улсын Тагнуулын Ерөнхий газрын Тусгай архив, Ф-1, ХН-Ц423.

ёсонд байж үл болох муухай харгис эрүү шүүлт, зодуур нүдүүр, нойр хоолгүй, өдөр шөнөгүй байцаагдан тулгуулж, Японы тагнуулын байгууллагын гишүүн болсон гэж хилс хэрэг хүлээсэн билээ<sup>22</sup>” гэсэн нь тухайн үеийн хилсээр байцаагдаж байсан олон хүн амь мултрах, зарим шийдсэн хэсэг нь зовохгүй түргэн нүд анихын тулд аргагүйн эрхэнд ухаантай ухаангүйн завсар хийгээгүй хэргээ хүлээж байсны нотлогоо юм.

Тухайн үед Дотоод явдлын яамны орос, монгол байцаагчид олон зохисгүй хүч хэрэглэх аргуудыг ашиглан мэдүүлэг гаргуулж байжээ. Тэдгээрээс заримыг дурдвал, бусдаас тулгаж албадан гаргуулсан худал мэдүүлгийг хүчээр хүлээлгэх, удаан хугацаагаар хөдөлгөлгүй суулгах, зодох, өлсгөх, карцерт хорьж дааруулах, нойргүй жижүүрлэн байцаах, хурц гэрэл тусган байцаах, сүрдүүлэн айлгах, зохиомол мэдүүлэгт танилцуулахгүйгээр гарын үсэг зуруулах зэрэг бусармаг аргуудыг хэрэглэж байв<sup>23</sup>.

Германд суралцаж байсан Бавуу гуай шоронд хоригдож байсан тухайгаа дурсахдаа:

“Шоронд өдөрт 100-150 грамм талх, төмөр крушкаар буцалсан ус орой нь цувдаа, нэг хоёр ширхэг уушигны хэрчим идээд болдог байлаа. Өдөрт нь цементэн шалан дээр явуулж, дараа нь хөл газар хүрэхгүй нарийн сандал дээр суулгана. Дээшээ босч болохгүй толгой тулна. Дараа нь том өрөөнд дотуур хувцастай дааруулан дагжаана. Бавуу би шоронгоос гарахдаа пальтогоо даахгүй байсан” гэжээ.

Мөн зохиолч Д. Намдагийг 1941 оны 10 дугаар сарын 6-нд дахин баривчилж ”фашист Германы тагнуул, гадаадын эзэрхэг түрэмгий фашист улсын шууд тусламжаар Монгол Ардын хувьсгалт нам, засгийн газрыг унагаах зорилго бүхий эх орноосоо урвасан хувьсгалын эсэргүү тагнуулын газрын идэвхтэй гишүүн, Герман улс хүчирхэг гэх буюу ... фашист Германыг зүйл бүрээр магтан сайшаахыг оролддог, мөн Зөвлөлт болон Монголын хөгжлийг аль болохоор гүтгэн муучлах буюу тагнуулын аргаар бусдыг талдаа татахыг оролддог” гэх зэрэг зүйлүүдийг үндэслэл болгон баривчласан байна.

Түүхийн ухааны доктор Х.Мэндсайхан бүтээлдээ “Д.Намдагийг чанга дэглэмтэй гянданд 810 хоног хорьж, нийт 53 удаа байцаасан” тухай дурдсан байдаг.<sup>24</sup>

Мөрдөн байцаалтын явцад эдгээр хүмүүс Дотоод явдлын яамнаас тулгаж байсан хэргийг хүлээхгүй байсан тул Дотоод явдлын яамнаас

22 Г. Дүйнхэржав, “Тамын тогоонд таван жил”, УБ, Сударын Чуулган, 1991, 88 хуудас.

23 А. Думбарай, “Залхаан цээрлүүлэлт: Бүгд Найрамдах Монгол Ард Улсад 1930-1940-иод онд болсон хэлмэгдүүлэлт”, УБ, Эрдэм, 1997, 233 хуудас., Г. Дүйнхэржав, “Тамын тогоонд таван жил”, Улаанбаатар, Сударын Чуулган, 1991, 88 хуудас.

24 Х.Мэндсайхан, Герман, Францыг зорьсон багш Базар Ишдорж, монгол сурагчдын хувь заяа, Улаанбаатар, 2015.

гадаадын тагнуулын байгууллагатай холбоотой ажиллаж, эх орноосоо урван тэрсэлсэн зэрэг үндэслэлээр шийтгэж, 1938 онд Н.Наваан-Юндэн нарын зарим хүнд цаазаар авах ял өгч байсан байна<sup>25</sup>. Гэвч өдгөө энэ шүүх хурлын тухайд холбогдох албан ёсны баримт нотолгоо олохгүй байна.

Байцаагдаж буй хүмүүсээс мэдүүлэг авахдаа “фашист Германы тагнуул, гадаадын эзэрхэг түрэмгий фашист улсын шууд тусламжаар Монгол Ардын Хувьсгалт Нам, Засгийн газрыг унагаах зорилго бүхий эх орноосоо урвасан хувьсгалын эсэргүү тагнуулын газрын идэвхтэй гишүүн” болгож харуулах хатуу байр суурь баримталж байжээ.

Гэвч энэ бүхэн нь эцэсдээ байцаагдаж буй хүмүүсийн зохиомол мэдүүлэг дээр үндэслэгдэж байсан бөгөөд мэдүүлэгт шинээр оруулж ирсэн баталгаатай баримт, мэдээ байхгүй байжээ. Өөрөөр хэлбэл энэ нь Дотоод явдлын яамны байцаагчид Герман, Францад суралцаж байсан залуусыг Германы тагнуул байсан гэж нотлох албан ёсны ямар ч баримтгүй байсныг нотолж байгаа байна.

Ийнхүү тэд зохиомол хэрэг хүчинд автан хүлээн мэдүүлсээр 1943 оны 12 дугаар сарын 14-нөөс 28-ны өдрийг хүртэл хуралдсан тусгай шүүх хурлаар Германд суралцаж байсан С. Бавуу, Д.Доржсүрэн, Ц.Бадарч, С.Цэвэг, М.Гомбожав нарыг удаан хугацаанд байцаагдсаны эцэст ял холбогдолгүй болгон суллахаар шийдвэрлэж, харин Н.Бат-Очир 25 жил, Н.Наваан-Юндэн 20 жил, Т.Нацагдорж 10 жил, Д.Гомбо 8 жил, Д.Намдаг 7 жил, Г.Цэвээн 7 жил, С.Лхүндэв 3 жилийн ял тус тус авч хэлмэгдсэн байна.<sup>26</sup>

Н.Наваан-Юндэн гуайн хожим бичиж үлдээсэн дурсамж тэмдэглэл болон Дотоод явдлын яаманд тухайн үед ажиллаж байсан Доохүү овогтой Шаарий гуайн өгсөн дурсамж зэргээс үзэхэд сүүл үедээ Ринчин Бямбаев, Н.Наваан-Юндэн, Дугаржав, Д.Намдаг, бүдүүн Самбуу, герман Бат-Очир нарын 7-8 хүн нэг гэрт сууж орчуулга хийх даалгавартай байсан бөгөөд бусадтай харьцуулахад сайн хоол ундтай, тусгай хувцас өмсдөг, харин хашаанаас гадагш гарах, хүнтэй уулзах эрхгүй байсан ажээ.

Н.Наваан-Юндэн бүр 1950 оны 3 дугаар сард 2 жилийн тэнсэн харгалзах ялтайгаар суллагдсан байна. Тэрээр “Герман тагнуулын хэрэг” гэгч зохиомол зүйлд холбогдон 12 жил 6 сар ял эдэлж, түүний амьдралын олон жилийг Дотоод явдлын яамны үзэл суртлын хийрхэл булаан авчээ. Зөвхөн Н.Наваан-Юндэн ч бус Герман, Францад суралцсан олон залуус энэ замыг туулсан юм. Тэд хожим ч олон жил

25 Т.Гэндэн, “Гурван түмэн хүний амь”, редактор Л. Чулуунбаатар, Улаанбаатар, Шувуун саарал, 1999, 161 дүгээр тал.

26 Улсыг аюулаас батлан хамгаалах газрын тусгай архивын лавлагаа, 1993.03.17. Ч.Болд, Алс газар сурахаар одогсод (1926-1930 онд Герман улсад суралцсан монголчууд), Улаанбаатар, 2016, Т.226-227.

хавчлагад өртөн амьдарч сэтгэл зүйн талаар ихээхэн хүнд амьдарч байжээ.

Өдгөө архивын баримт материалыг сөхөн харахад “Герман тагнуулын хэрэг”-т холбогдон хэлмэгдсэн хүмүүсийн Дотоод явдлын яаманд өгсөн мэдүүлгүүд хоорондоо ихээхэн зөрүүтэй, албан ёсны нотолгоогүй байдаг ба зарим ахмад судлаачдын мэдээлж байгаагаар уг хэрэг олон удаа задарсны зэрэгцээ хожим Зүүн Германы Аюулаас хамгаалах байгуулагаар шалгуулахад үндэслэлгүй худал болох нь нотлогдсон байна.<sup>27</sup>

1950-1960 онд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дэргэдэх Цагаатгах Ажлын Комиссын тогтоолоор дээрх хүмүүсийг улс төрийн хэрэгт хилсээр шийтгэгдсэн хэмээн нэр төрийг нь албан ёсоор сэргээсэн байдаг<sup>28</sup>.

Ийнхүү олон жилийн туршид хөрөнгөтөн, фашизмтай тэмцэх тэмцлийн гол бай болж байсан “Германы тагнуулын хэрэг” гэгч нь олон хүний амьдралыг хэлмэгдүүлснээр дууссан бөгөөд энэхүү зохиомол хэрэг нь тухайн үеийн БНМАУ-ын түүхэн нөхцөл, ЗХУ-аас БНМАУ-ын талаар баримталж байсан улс төрийн бодлого, түүнээс улбаалсан үзэл суртлын хийрхэлтэй нягт уялдаатайгаар бий болсон байна.

### 3. Дүгнэлт

XX зууны Монгол Улсын түүхэнд хар толбо болон үлдсэн нэгэн зурвас үе бол “улс төрийн хэлмэгдүүлэлтийн он жилүүд” юм. Цаг үе улиран өнгөрөхийн хэрээр улс төрийн хэлмэгдүүлэлтийг судлах талаар Монголын түүхийн судалгаанд шинэлэг хандлага нэвтэрч 1990-ээд оноос хойш дотоод, гадаадын эрдэмтэд өргөн цар хүрээтэй, жинтэй судалгааг явуулах болсоор уджээ.

“Улс төрийн хилс хэрэг”-т тулгагдаж хорвоог орхин одсон буюу бие, сэтгэлийн гашуун зовлонг амсаж үлдсэн тэдгээр олон мянган хүмүүсээс Монгол Улсын төр уучлал нэхэн гуйж, өдгөө энэ асуудлыг төрийн бодлогын хэмжээнд анхааран шийдвэрлэж байна. Хэлмэгдүүлэлтийн бараан үүл манай орны нийгмийн бүх хэсгийг хамран нүүхдээ тухайн үед дөнгөж бүрэлдэж байсан Монголын шинэ үеийн сэхээтний давхаргыг хамгийн түрүүнд дайрч өнгөрсөн билээ.

ЗХУ-аас гадна гадаад бодлогын хоёрдагч замыг эрэлхийлж, Герман зэрэг өрнөдийн хөгжингүй орнуудтай эдийн засаг, боловсролын салбарт харилцаагаа бэхжүүлэх гэсэн А.Амар, Б.Цэрэндорж, Ц.Дамбадорж, Н.Жадамбаа, Ж.Гэлэгсэнгэ, С.Гүрсэд, Ж.Цэвээн нарын

27 Т.Гэндэн, “Гурван түмэн хүний амь”, редактор Л. Чулуунбаатар, УБ, 1999, Т.161.

28 Цагаатгах Ажлыг Удирдан Зохион Байгуулах Улсын Комиссын дэргэдэх Хэлмэгдэгсэдийн Судалгааны Төвөөс авсан мэдээлэл



сэхээтнүүдийг ”ЗХУ-аас холдох оролдлого” хийсэн гэх нэрийн дор олон үндэслэлгүй ял тулгаж байлаа.

Баруун Европт сурагчдаа суралцуулах нь ирээдүйн Монгол улсад хэрэгтэй гэдгийг ХХ зууны Монголын төрийн тулхтай зүтгэлтэн А.Амар гуай төрийн холч, уужуу ухаанаар цэгнэн тунгааж, тэрхүү байр сууриа бат итгэлтэйгээр тууштай хамгаалсаар байсан нь 1940 оны 7 дугаар сарын 10-нд Москвад ЗСБНХУ-ын Дээд Шүүхийн Цэргийн Коллегийн хаалттай хуралдаанаар түүнд ЗСБНХУ-ын Эрүүгийн хуулийн 58-ын 1а, 2-р зүйл ангиар ялын дээд хэмжээ оноосон шүүх хурал дээр А.Амарын өгсөн сүүлийн мэдүүлэгт:

“... манай Монгол улстай алс хол оршдог учир Герман улстай холбоо тогтоохыг эрмэлзэж байлаа. 1926 он хүртэл Германы Гадаад явдлын яамны сайдтай дотно холбоотой байж, түүнтэй бичиг захидлаар харилцдаг байв. Оюутан сурагчид ч тийш нь илгээсэн.

... Би Герман улстай холбоо тогтоон БНМАУ-д эрдмийн ажилтантай болохыг хүсч байлаа. Мөн тэдний элчин сайд нь Улаанбаатарт очоосой гэж хүсч байлаа” хэмээн өгүүлж байснаас тодорхой харагдана.

Хэлмэгдүүлэлт Герман улстай найрсаг харилцааг хөгжүүлэе хэмээн зорьж байсан манай төрийн удирдагчдаас эхлээд Германд суралцаж ирээдүйд эх орноо хөгжүүлэх гэсэн үнэнхүү зорилгоо:

***“Бидний сурагч нарын бодлого болбоос Европын аль чухал сайныг нь олж сураад дараа харьяат улс төр, ард түмэндээ тус хүргэсүгэй”*** хэмээн үүрэг, зорилгоо тодорхойлж байсан жирийн сурагчдыг ч дайран өнгөрчээ.

Монгол улсаа олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн улсын дайтай улс болгох хэмээсэн монголчуудын туйлын хүсэл зорилго нь ЗХУ-аас Монгол улсад дангаар хяналтаа тогтоох гэсэн улс төрийн бодлоготой эрс зөрчилдөж байсан юм. Иймээс тэдэнд ”Япон, Германы тагнуул” гэсэн нэр, пайз зүүсэн байна.

Ийнхүү Герман, Франц улсад суралцаж, төрөл бүрийн боловсрол эзэмшсэн монгол сурагчид эцэсдээ эмгэнэлтэйгээр хэлмэгдэж, зарим нь тэрхүү амьдралын хүнд цохилтыг даван гарч чадалгүй хорвоогоос хальсан байхад зарим хэсэг нь насан туршид сэтгэлийн шархтай үлдэж, ид хийж бүтээх залуу насаа чийгтэй, хүйтэн чулуун хананы цаана харанхуйд сууж өнгөрөөсөн байх юм.

Хэдийгээр Герман, Францад суралцсан монгол залуусыг тухайн үеийн төр, засаг эмгэнэлтэйгээр хэлмэгдүүлж, заналт дайснаа хэмээн үзэж байсан боловч тэдгээр залуус хожим эх орныхоо хөгжил дэвшлийг жинхэнэ утгаар гартаа авсан оюунлаг давхраа болж, шинэ үеийн Монгол улсын түүхийг бүтээлцэн түүхэнд нэрээ мөнхөлцгөөсөн билээ.

Цаг хугацаа гэдэг түүхийн шүүгч байдаг хэмээдэг ч цаг хугацаа басхүү түүхийн аугаа их баллуур билээ. Цаг үе өөрчлөгдөн өнөөгийн бидний үе тэрхүү түүхэн үйл явцыг үнэн бодитоор нь шүүн ойлгохыг хичээж байгаа ч тухайн үеийн түүхэн үйл явцыг бүтээлцэж байсан хүмүүс өдгөө нэгэнт бидний дунд үгүй болжээ.

1926-1930-иад онд Герман, Францад суралцсан Монголын оюутан, сурагчдын хожим улс төрийн хилс хэрэгт холбогдуулж хэлмэгдүүлсэн талаар намтар судлалын чиглэлээр хэвлэгдсэн зарим бүтээл, сонины тухайлсан хөрөг найруулал зэрэгт цухас дурдсныг эс тооцвол өнөөг хүртэл тун бага судалжээ.

Эндээс дүгнэхэд цаашид энэ асуудлаар төрийн хэмжээнд анхааран өргөн цар хүрээг хамарсан нухацтай судалгаа хийх шаардлагатай гэж үзэж байна. Үүний тулд Герман, Францад анх суралцсан хүүхэд, залуусын нэр төрийг сэргээх асуудлыг цагаатгалын мэдэгдэл хуудсаар хязгаарлахгүйгээр зохион байгуулж, архивын сан хөмрөгт хадгалагдаж буй баримтыг нээлттэй болгох, эрдэм шинжилгээний хурал хийх, бүтээл хэвлүүлэх, дурсгалын хөшөө босгох, кино бүтээл гаргах зэргээр өргөн хүрээтэй арга хэмжээг тэдний үр хүүхдүүдийн оролцоотойгоор зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж байна.

## “ДЕЛО №17093” ...



*С.Туяа  
Түүхч, Судлаач*

Улс төрийн хэлмэгдүүлэлтийн түүх судлахад орхиж үл болох нэгэн сэдэв бол хилс хэрэгт гүтгэгдэн, тухайн үеийн ЗСБНХУ-ын эрх бүхий байгууллагын шийдвэрээр харийн шорон гянданд хоригдон байцаагдаж тамлагдаж, цаазын ял хүлээн буудуулсан, олон жилийн хоригдох ял авч хүнд хүчир хөдөлмөрт нухлагдан амь насаа алдсан, амьд үлдсэн ч эх нутгаа зорих эрхгүй хүний нутагт цөлөгдсөн БНМАУ-ын иргэдийн тухай юм.

Одоогоор бидэнд олдсон мэдээ баримтаар 1930-аад оноос хойш тухайн үеийн зөвлөлтийн эрх баригчдын шийдвэрээр монголын иргэдийг дараах гурван бүлэг хэрэгт хамруулан хилсээр шийтгэжээ. Үүнд:

### **Япон-буриадын төвийн хэрэг:**

Японы дэмжлэг туслалцаатайгаар Буриад монголд тогтсон зөвлөлт засгийг түлхэн унагаж, БНМАУ-д зөвлөлтийн нөлөөг үгүй болгож, монгол үндэстнийг нэгтгэсэн нэгэн улс байгуулах зорилготой буриад-монголын хувьсгалын эсэргүү төвийн хэрэг

### **Дело №17093:**

Японы цэрэг, тагнуулын байгууллагын тусламжтайгаар зэвсэгт бослого гаргаж, монголд төрийн эргэлт хийх зорилготой “панмонгол”-ын хувьсгалын эсэргүү хорлон сүйтгэх бүлгийн хэрэг

### **Даалгавар гүйцэтгээд японы талд урвасан хэрэг:**

Зөвлөлтийн 17 дугаар армийн тусгай даалгавраар манжуурт тагнуулын ажил гүйцэтгэж байхдаа японы цэргийнхэнд урваж, тэдний тагнуулын байгууллагад элсэгчдийн хэрэг хэмээх гурван бүлэг хэрэгт хилсээр хэлмэгдүүлэн шийтгэжээ. Энэ удаа Дело №17093 хэмээх хэргийн тухай товч өгүүлье.

БНМАУ-ын нутаг дэвсгэрээс японы тагнуулын байгууллагатай холбоотой, хувьсгалын эсэргүү бүлгийн хэрэг илрүүлэх ажиллагаа үргэлжилсээр байв. Японы талаас ч үйл ажиллагаа идэвхжиж хятадын хойт хэсэгт цэргийн бааз, хуаран, бактериологийн туршилтын бааз байгуулж, БНМАУ-ын хилийг байн байн зөрчсөн үйлдэл гаргах зэргээр өдөөн хатгаж байв. Энэ үед зөвлөлт орон даяар «пангерман», «пантурк», «пан-еврей», «панмонгол» болон бусад үндэстэн ястны хувьсгалын эсэргүү бүлгийн хэрэг илрүүлэх, мөрдөн байцаах, таслан шийтгэх ажиллагаа сүр дуулиантай явагдаж байсан.

Зөвлөлтийн эрх баригчид улам идэвхжиж, илэрхий заналхийлэх болсон Японы эсрэг цэрэг дайны үйл ажиллагаа явуулахад хөрш зэргэлдээ орших БНМАУ-ын нутаг дэвсгэрт илүү чөлөөтэй байх хэрэгтэй байлаа. Өөрөөр хэлбэл цэргийн хүчээ болзошгүй дайралт довтолгооныг угтуулан байршуулах, хэрэгцээ шаардлагатай гэж үзсэн үедээ цэргийнхэн чөлөөтэй явах зэрэг нөхцөл бүрдүүлэхийг хүсэж байсан хэрэг. Японы зүгээс БНМАУ-ын нутаг дэвсгэр рүү тагнуул туршуул илгээх нь нэмэгдсээр байгаа мэдээ ч түгшүүр төрүүлж байсан байж таарна. Харин манай төр засгийн өндөр албан тушаалын зарим хүн одоогоор зөвлөлтийн цэргийнхний зүгээс шахаж байгаачлан цэрэг оруулах шаардлагагүй гэж үзэж, түүнийгээ ч үндэслэн мэдэгдэж байсан юм. Ийм учраас БНМАУ-д төрийн эргэлт хийхээр японы тагнуулын байгууллагын дэмжлэг аван идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй «панмонгол»-ын бүлгийн гэх хэрэг зөвлөлтийн чекистүүд «илрүүлсэн» байдаг. Энэ хэрэгт монголын нам, төрийн болон ДЯЯ-ны удирдах олон ажилтанг хамруулж 1939 оны наадам болохоос өмнө амжин холбогдогсод хэмээгчдийн ихэнхийг дайчлан баривчилжээ.

Манай улсын эрх баригчид Орос улсад үүнээс өмнө хэд хэдэн удаа нутаг дээгүүрээ дамжин өнгөрөх төмөр зам тавих боломжийн талаар санал дэвшүүлж байсан боловч тэр бүрд нааштай хариу өгсөн баримт өнөө хэр олддоггүй юм. Харин Японтой хийх дайнд бэлтгэж ЗХУ өөрийн хүч хөрөнгөөр, манай улсын нутаг дэвсгэрт 1939 онд төмөр зам тавьж, түүнийгээ бүрэн өөрсдийн мэдэлд ашиглаж байжээ. Хил даван ЗХУ-аас орж ирсэн төмөр зам Баянтүмэн хүртэл өргөн, түүнээс зүүн урагш үргэлжлүүлэн нарийн төмөр тавьж ашиглаж байгаад бүр сүүлд Монгол улсын засгийн газарт үнэ төлбөргүй шилжүүлсэн байдаг. Энэ төмөр замыг цэрэг-дайны бэлтгэл ажил болгон тавьжээ. Гэхдээ энэ бол бас аж ахуйн үүрэг давхар гүйцэтгэж байгаагүй гэсэн үг биш.

Хөөн буй сэдэвтээ орцгооё. Баривчилгааг ДЯЯ-ны зөвлөх, сургагч нарын заавар, хяналтын дор 1939 оны 7 сард шуурхай хийсэн байдаг. Ингэхдээ ДЯЯ-ны сайд Х.Чойбалсангийн гарын үсэгтэй ордероор шууд баривчлах, «ажил хэргийн шаардлагаар» хэмээн хуурч маршалын өрөөнд дуудаж ирүүлээд баривчлах, бас заримыг албан томилолтоор

хөдөө явуулна хэмээн зөвлөлтийн цэргийн онгоцонд хуурч суулгах зэрэг аргаар хэрэгжүүлжээ.

Тухайлбал 1939 оны 7 сарын 9-ний өдөр баривчилгаа хэрхэн хийсэн талаар тэр үед ДЯЯ-ны Улсыг Аюулаас Хамгаалах газрын даргаар томилогдоод хориод хонож байсан Б.Жамбалдорж:-” 9-ний өдөр бүтэн сайн байсан. Би ажил шинэхэн аваад байсан болохоор ажилтайгаа танилцан албан өрөөндөө байтал утас дуугарсан. Авбал манай сайд Х.Чойбалсан байлаа. Намайг одоо хүрээд ир гэснээр яаравчлан очиж орлоо. Чойбалсангийн сандлын архан, хоёр хажууд нь XVII армийн бололтой энгийн хувцастай 2 залуу зогсож байв. Маршал намайг чи үүнийг дууд, түүнийг дууд гэж баахан сайд, дарга нарыг дуудуулж тэднийг XVII армийнхан Х.Чойбалсангийн өрөөнд баривчлан цааш нь аваад явдаг байсан. Энэ хүмүүсийг баривчлахыг манай яам огт мэдээгүй юм шүү»<sup>1</sup> гэсэн байна. Холбогдох баримт хөөн үзвэл нээрээ хэнийг баривчлахыг Чойбалсан шийдээгүй, зөвлөлтийн ДХАК-аас ирэгсэд шийдсэн бололтой. Наадмын урд өдрүүдэд баривчлагдсан хүмүүс, бас 1939 оны 1 сараас эхлэн баривчлагдан хоригдож байсан улсыг нийлүүлэн, онгоцоор ЗХУ-ын Чита муж руу явуулсан байна. ЗХУ-д сурч, ажиллаж, эмчлүүлж байсан монгол иргэдийг бас хамаатуулан оршин суугаа газрын хаягаар ДХАК-ын газрын даргын гарын үсэгтэй ордероор баривчилжээ. Хоёр улсын нутаг дэвсгэрийг дамнуулан энэ олон хүнийг хаа байгаа газраас нь яаран баривчилж эхэлсэн хэргийг ингэж зохион байгуулах боломж тэр үед ЗХУ-ын ДХАК-д л байсан. Өөр ямар ч байгууллага, хувь хүн ийм ажил хийх боломжгүй байсан юм.

БНМАУ-ын нутаг дэвсгэрт дайчлан баривчлах ажилд хэн оролцсон юм бол, нөгөө л муу нэртэй дотоод яамны ногоон малгайтнууд байх гэсэн бодол Танд төрж байгаа байх. Баривчлах ажилд оролцсон нь үнэн. Харин зөвлөлтийн ДХАК-ын ажилтнууд голлон оролцсоныг судлаачид бичих болоод байна.

Их хядлагын он жилүүдэд монголын иргэдийг монголын нутаг дэвсгэрээс баривчлахад Монголын ДЯЯ-ны ажилтнууд, тэнд ажиллаж байсан зөвлөлтийн сургагч, зөвлөх нар, Баруун болон Зүүн Сибирийн ДХАК-ын ажилтнууд оролцож байжээ.

Монголд «их хядлага» зохион байгуулахаар 1937 оны 8 сард ирсэн ДХАК-ын I орлогч М.П.Фриновский, зөвлөлтийн Улаан армийн улс төрийн удирдах газрын дарга П.А.Смирнов нарыг дагалдуулж хүч хавсрах зорилгоор»... Баруун Сибирийн хязгаарын ДХАК-ын Удирдах газрын дарга С.Н.Мироновыг ЗХУ-аас Монголд суух онц бөгөөд бүрэн эрхт төлөөлөгчөөр томилон, тусгай бэлтгэл бүхий хэсэг чекистүүдийг ахлуулан мөн илгээсэн»<sup>2</sup> байдаг. «Их хядлагын» баривчилгааг тэр чекистүүд Монголын Дотоод явдлын яамныхантай хамтран

гүйцэтгэжээ. Зүүн Сибирийн ДХАК-ын салбар 1930-аад оны эхэнд лам нарын бослого тэмцлийг дарахад оролцсон бөгөөд 1936 оноос зохион байгуулалтын хувьд өөрчлөгдөн Буриад-Монголын ба Читагийн ДХАК-ын салбар болон өргөжсөн<sup>3</sup> гэж судлаачид тэмдэглэжээ. Энэ хоёр салбарын ажилтнууд баривчлах, мөрдөн байцаах ажилд туслахын зэрэгцээ ДХАК-аас нэмж ирж байсан шийдвэр даалгаварыг ёсчлон гүйцэтгэж байжээ. Монгол улсад Читагийн ДХАК-ын салбарын чекистүүд байран суурин биш ч гэсэн хэрэгтэй цагт ирж ажиллаж байсан талаар ч оросын судлаачид баримт хөөн нотлосон байдаг.

Цэргийн хуульч Вячеслав Звягинцев хэлмэгдэн баривчлагдаж, шоронд сууж байгаад дайнд оролцон алдар гавьяа байгуулсан баатруудын тухай бичсэн «Трибунал для героев» бүтээлдээ «... цэргийн олон удирдагч 1942-1943 онд шоронгийн хувцасаа цэргийн хувцсаар солин дайнд оролцсон. Хамгийн сонирхолтой нь тэдний зарим нь «гадаадын тагнуул» нэртэй ял эдлэж явсан хэрнээ ЗХУ-ын баатар болж байжээ... ЗХУ-ын баатар, хурандаа генерал А.М.Кушев японы тагнуул хэмээн баривчлагдан шоронд хоригдож байсан боловч ... 1943 оны 12 сараас эх орны дайнд оролцож, 11 удаа сумны шарх авч бас алтан таван хошуу ч энгэртээ зүүсэн нэгэн»<sup>4</sup>. А.М.Кушевыг Монголоос “...ДХАК-ын тусгай ангийн ажилтнууд 1939 оны 6 сарын 25-нд баривчилсан”<sup>5</sup> гэж бичсэн байна.

Тэр үед мөрдөнд байсан манай хүмүүсийн дунд: «зөвлөлтийн дотоод яамны нэгэн анги манайд ирсэн. Тэнд манай дотоод яамнаас хавьгүй илүү аймшигтай байдаг гэнэ. Амгаланд байрладаг бололтой»<sup>6</sup> гэж ярилцдаг байсан, мөн хуягт танкийн газрын дарга байсан Гонжав: «Бид ч дүүрсэн хүмүүс болжээ. Би хүнд зовлон үзэж, та нарыгаа хүртэл барьж мэдүүлэв. Би нэг орос ангид хүргэгдэж очив. Тэнд дан орос дарга нар байна. Нарийн сэнж олсоор нүцгэн биен дээр зодож, усан цэврүү болгов. Тэнд очсон хүн хэрэг хүлээхгүй байх аргагүй юм хэмээж байсан»<sup>7</sup> тухай хожим дурсамж дурдатгал бичиж үлдээсэн байна.

Юутай ч энэ бүхнээс харахад ДХАК-ын тусгай ангийн ажилтнууд Монгол улсад баривчлах, мөрдөн байцаах ажиллагаа гүйцэтгэж байсан нь тодорхой болж байна.

1939 оны 7 сараас өмнө баривчилсан монголчуудыг шоронд хорьж, байцааж байгаад 7 сард баривчилсан бусадтай нь нийлүүлэн зөвлөлтийн цэргийн онгоцоор ЗХУ-ын Чита хот хүргэжээ. Тэднийг бүгдийг Читад хүргэсэн нь зам харилцааны боломжтой холбоотой байсан бололтой. Учир нь Баруун болон Зүүн Сибирийн ДХАК-ын салбар байгууллагын ажилтнууд цэргийн онгоцоор байнга ирж, очиж Монголын ДЯЯ-ны ажилд заавар зөвлөгөө өгөх, цэргийн зориулалттай бараа зөөх, мөн Монголоос түүхий эд ачдаг байжээ.



Баривчлагдагсдыг Чита хотод мөрдөн байцааж байхдаа «панмонгол»-ын хувьсгалын эсэргүү хорлон сүйтгэх бүлэг байгуулж, японы цэрэг-тагнуулын байгууллагын дэмжлэгээр зэвсэгт бослого гаргаж, монголд төрийн эргэлт хийхээр бэлдэж байсан гэх хэрэг тулган хүлээлгэжээ. 7-8 сарын турш дахин дахин байцааж, нүүрэлдүүлж, хэрэг бүрдүүлэн төв рүү буюу ЗХУ-ын ДХАК-ын удирдлагад илгээсэн байна. Удаа ч үгүй ДХАК-ын дарга Бериягийн гарын үсэгтэй шийдвэрээр тэдний хэргийг Москва руу татжээ. Энэ бол «зохиомол» хэрэгт хэр ач холбогдол өгч байсныг харуулж байгаа үйлдэл яах аргагүй мөн. Японы цэргийнхэний үйл ажиллагаа идэвхжиж, хойт хятадад дэглэмээ тогтоон, Монголын хил рүү өнгөлзөж байсан энэ цаг үед зөвлөлтийн эрх баригчид ээлжит зохиомол хэрэг бүрдүүлэн БНМАУ-ын удирдах ажилтнуудыг хамруулсан нь тодорхой зорилготой байсныг бид дээр өгүүлсэн. Их гүрний эрх ашиг гэгчдээ тулаад ирэхийн цагт олон улсын харилцаанд мөрдөгддөг дэг журам, дипломат ёс энэ тэр мартагддаг, тэр тусмаа их гүрэн, буурай жижиг Монгол хоёрын харилцаа ийм болдог ажээ.

Японы тагнуулын байгууллагатай холбоотой «панмонгол»-ын хувьсгалын эсэргүү бүлгийн хэргийг эрүүгийн мөрдөн байцаалтын Дело №17093 гэж дугаарласан байна. Энэ бүлэг хэрэгт монголд ажиллаж байсан 57 дугаар онцгой корпусын штабын дарга, хурандаа генерал А.М.Кушев болон зөвлөлтийн хэд хэдэн хүн хамрагдсанаас гадна одоогоор бидэнд олдсон баримтаар А.Амар, Д.Лувсаншанаа, Д.Лосол, С.Довчин, Г.Даншийцоодол, Г.Дамба, Р.Мэнд нарын зэрэг монголын удирдах албан тушаалын 40-өөд хүнийг хамруулан шийтгэн яллажээ. Манай түүх бичлэгт «Амар, Довчин нарын хэрэг», «Лувсаншарав, Лосол, Догсом нарын хэрэг» гэж ялган нэрлэж байвч зөвлөлтийн ДХАК-ын хувьд энэ нь «Дело № 17093» гэсэн дугаартай нэг бүлэг хэрэг хэмээн тооцогдож байжээ. ОХУ-ын судлаачид «... монголын төр засгийн удирдагчид, монгол ардын армийн удирдах дарга нар, соёл шинжлэх ухааны тэргүүлэх эрдэмтэд, төр олон нийтийн байгууллагын зүтгэлтэн олон хүнийг баривчилж, «панмонгол»-ын хувьсгалын эсэргүү байгууллага байгуулж, зэвсэгт бослого гаргахад бэлтгэж байсан, монголд төрийн эргэлт хийх гэсэн хэмээн ялласан ...»<sup>8</sup> гэж бичсээр байгаа юм.

Дело № 17093 тоот энэхүү «эрүүгийн хэрэг»-т чухам ямар хүмүүсийг хамруулан татсан нь ч бас сонин. 1930-аад оны эхнээс янз бүрийн шалтгаанаар БНМАУ-ны удирдах ажилтнуудыг зөвлөлтөд сургах, ажиллуулах гэсэн сайхан нэрээр үнэн хэрэг дээрээ улс төрийн цөллөгт илгээж байсан нь нэг бус удаа байдаг ажээ. Тухайлбал МАХН-ын тухайн үеийн эрх баригчид зүүнтэн болох Ө.Бадрах, З.Шижээ, Л.Лааган нарыг замаасаа зайлуулан зөвлөлтийн эрх баригчдын хатуу хяналтад явуулсан байжээ. Тэднийг Москва хотноо «гадаад ажилчдын хэвлэл»-


ийн газарт зөвлөхөөр ажиллаж байхад нь баривчилж энэ хэрэгт хамруулсан байдаг нь бас л сонин. Түүнчлэн энэ хэрэгт Монголын ДЯЯ-ны ажилтан нэлээд хэдэн хүнийг баривчлан хамруулсан байдаг.

Бас энд хэлэхгүй байж боломгүй хачирхалтай гэмээр нэг зүйл байдаг. Төдөлгүй ЗХУ-д бүхнийг айлгагч Ежовыг өөр ажилд шилжүүлэх нэрээр зайлуулан, ДХАК-ын удирдлагыг өөрчлөн, Л.Берия томилогдсон. Берияд эрх шилжсэнээр Ежов болон түүнтэй шадарлан ажиллаж байсан бүгдийг цэвэрлэх их аян өрнөсөн. Пролетарийн диктатур үйлдсэн нүглээ нэг хэсэг хүнд тохон буруутгаж өөрийнхөө нэрийг цэвэрлэж авдаг нь жам болоод байсан болохоор мэддэг хүмүүсийн хувьд энд уг нь гайхаад байх явдал үгүй л дээ. Өөрөөр хэлбэл Ежов болон түүнтэй хамтран ажиллагсдыг яллах замаар Сталин тэргүүтэй эрх баригчид нийгмийг цочроосон их хядлага-олон мянган хүнийг хэлмэгдүүлсэн ялаас нэрээ сугалж авах гэсэн ядарсан арга энэ байсан гэж одоо түүхч, судлаачид бичих болоод байгаа юм.

Бас ийм алхам хийснээрээ их хядлагын гол гэрч Ежов, бусад гэрчүүдээс салах гэсэн санаа байсан юм ч гэж бичих болжээ. ДХАК-ынханы заавар зөвлөгөөнөөр ажилладаг Монголын дотоод яамныхан мөн адил ажилтнуудаа баривчлан ЗХУ-д илгээжээ. ДЯЯ-нд ажиллаж байсан н.Насантогтох, н.Батсүх, н.Баясгалан нар энэ бүлэг хэрэгт хамрагдсан нь чухам ийм учиртай.

Халх голын дайн 1939 онд эхэлж монгол зөвлөлтийн армийн дайчид мөр зэрэгцэн японы түрэмгийлэгчидтэй тулалдсан. Дайтах байлдах туршлагагүй байснаас үүдэн олон хүний амь үрсэн алдаа дутагдал багагүй гарчээ. Тухайлбал, зөвлөлтийн нисэх хүчнийхэн японы цэрэгт хүчин зүтгэж байсан баргын отрядыг бөмбөгдөх гэж яваад андууран монгол дайчдаа бөмбөгдсөн хэргээ нуух гэхдээ тухайн ангийг удирдаж байсан дарга ажилтнуудыг энэ хэрэгт хамруулан баривчилсан байх ажээ. Дело №17093 хэрэгт цэргийн дарга Лувсандоной, 57 дугаар корпусын штабын дарга хурандаа Кушев нар ч энэ явдлын золиос болж баривчлагджээ.

Зөвлөлтийн эрх баригчид японы түрэмгийлэгчидтэй дайтахад бэлтгэх, Монгол улсын газар нутагт цэрэг оруулах болон бусад ажиллагааг үг дуугүй биелүүлэх тийм хүмүүсийг БНМАУ-ын удирдлагад тодруулан гаргахад саад тээг болно гэж үзсэн учраас



БНМАУ-ын ерөнхий сайд А.Амар, Сангийн яамны сайд С.Довчин, Улсын Бага хурлын дарга Д.Догсом, Д.Лосол нарын зэрэг хашир туршлагатай, Монгол улсаа гэх сэтгэлтэй улсыг бас баривчилж дело №17093 -г хамруулжээ.

Дээр хэлсэнчлэн тухайн үеийн зөвлөлтийн удирдлага өөрсдийн гар хөл болж, цусан мөр татуулсан хүмүүсээ гэрчийн хувьд баривчлан устгаж байсан явдал Монголд гарчээ гэж санагдахаар явдал цөөнгүй болжээ. Тухайлбал, МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга байсан Д.Лувсаншарав болон ДЯЯ-ны ажилтнуудыг баривчлан хороосон нь ингэж үзэх үндэс болж байна.

Ийнхүү хилс хэрэг үүсгэж, хамаатуулан баривчилсан БНМАУ-ын иргэдийг зөвлөлтийн цэргийн ачааны онгоцоор хойш нь ачин одсон гэдгийг бид дээр дурдсан.


Чита хотод хүргэсэн монголчуудыг бидний өмнөх бүлэгт өгүүлсэн Ежовын гарын үсэгтэй алдарт 00447 тоот тушаалд заасны дагуу хэрэг бүрдүүлэн Читагийн дотоод шоронд хорьжээ. Баривчлагдаад хүргэгдэж ирсэн монголын иргэдэд баривчлах ордер дахин бичиж хэрэгт хавсаргажээ. Бас эмнэлгийн үзлэгт оруулж, анкет бүртгэл үйлдэж, нэгжиж биед байсан эд зүйлсийг хураан авч тэмдэглэгээ үйлджээ. Энэ бол мөнөөх алдарт тушаалын дагуу хийгдэж байгаа ажил. Харин энд хачирхалтай гэмээр явдал нь баригдаж очсон зарим хүмүүс баривчилсан ордергүй байсан явдал ажээ.

Монголчуудыг Читагийн шоронд байцаах ажиллагаанд ДХАК-ын Удирдах газрын туршлагатай байцаагчид биечлэн оролцож байжээ. Тухайлбал Чита мужийн ДХАК-ын УГ-ын мөрдөн байцаах хэсэгт 1939 оны 8 сарын байдлаар 14 мөрдөн байцаагч ажиллаж байснаас хоёр нь хязгаар нутгаас ирэгсдийг, хамгийн туршлагатай тав нь «БНМАУ-ын хэсэг»-г хамаатайг, үлдэх долоо нь мөрдөн байцаагдаж байсан бусад 90 хүний хэргийг мөрдөж байжээ.<sup>9</sup>

Читагийн ДХАК-ын мөрдөн байцаагчид монголчуудыг элдэв аргаар тамлан байцааж дээрээс дэглэн зохиосон хэрэг тулган хүлээлгэж чадсан байна. Ингээд аюултай, онц хүнд гэмт хэрэгтэн болсон тэднийг бүгдийг ардын комиссар Л.Бериягийн гарын үсэгтэй шийдвэрээр Москвад ДХАК-ын мэдэлд шилжүүлэн явуулахаар болсон байна.

Читад бөөгнүүлэн хорьж байсан монголчуудыг 1939 оны 8 сард тусгай вагоноор Москва хүргэж, хатуу чанга дэглэмтэй Лефертовагийн гянданд хорьжээ. Энэ үед хоригдлуудыг тусгай тоногдсон вагон, машинаар хатуу чанга харуул хамгаалалттай зөөдөг байжээ. Зарим хоригдол замдаа нас барах явдал ч их тохиолддог байсан талаар олон ном бүтээлд тэмдэглэсэн байдаг.

Лефертовийн шорон гэгч аймшигт тамын газар байсан ажээ. ЗХУ-ын ДХАК-ын байгууллагад ажиллаж байгаад хэлмэгдэн баривчлагдаж, шорон дамжин байцаагдсаар олон жилийн ял аван, азаар амьд мэнд гарсан тагнуулч Михаил Шрейдер: «Намайг дөнгөж ухаан ормогц над руу нэгэн монгол эр (нэр нь Бадмаев гэсэн шиг санаж байна) дөхөж ирсэн.



*Лефертово шорон*

*Хоригдол зөөгч тусгай машин*

Түүнтэй танилцаж өөр өөрсдийн тухай ярьж байхад тэрээр ДХАК-ын орлогч М.П.Фриновскийн ахалж явсан бүлэгт багтан Монголд очиж, Монгол Ардын Намын удирдагчдаас Х.Чойбалсан болон өөр ганц нэг хүнийг үлдээн бусад олон арван удирдагчдыг баривчилсан, мөн Халх голд, японы армитай байлдах үеэр Монголын ихэнхи удирдагчдыг японы тагнуул хэмээн баривчилж Москвад авчран байцаасан, Бадмаев өөрөө Лефертовийн шоронд монголчуудыг мөрдөн байцаах үйл ажиллагаанд оролцон орчуулагчаар ажиллаж байгаад Ежовт сайшаагдаж, шагнуулж байсан боловч баригдсан монголчуудтай холбоотой, тэдэнтэй эвсэж Японы талд ажиллаж байсан хэмээн буруутган, баригдаж ирсэн гэж ярьж билээ. Түүний хэлснээр Монголын нам төрийн удирдагчдыг зодож занчиж элдвээр тамлаж байсан ажээ. Түүнийг (аюултай гэрчийн хувьд устгах зорилгоор) Лефертовод тамлан байцааж эцэстээ амь алдахын наана энэ эмнэлэгт хүргэгдэн<sup>10</sup> ирсэн хэмээн бичжээ.

Их хядлагын үед хамгийн аймшигтай газрын нэг нь энэ шорон байсан тухай ОХУ-д ном бүтээлд олонтоо бичсэн байх ажээ. Баривчлагдсан хүмүүс Лефертовод л очихгүй байх юмсан, тийш нь ачигдвал амьд үлдэх найдваргүй хэмээдэг байсан тухай цэргийн хуульч М.Шрейдер, М.Тепляков нар ч бичиж үлдээжээ.

Болсон явдлыг өнөө цаг үеэс эргүүлэн хөөж бодвоос Дело №17093 гэх хэрэг бүр анхнаасаа, зөвлөлтийн удирдлагын хэмжээнд бодож боловсруулан зохион байгуулагдсан хэрэг гэдэгт эргэлзэх зүйл алга аа.

Монголоос баривчлагдсан хүмүүсийг олон удаа байцааж, ихэнхдээ шөнө дөлөөр удаан хугацаагаар өртөөлөн байцааж байжээ.

Байцаалтын зорилго нь «японы ивээл дэмжлэгээр хувьсгалын эсэргүү «панмонгол»-ын хорлон сүйтгэх бүлэг байгуулж, БНМАУ-ын засгийн газар, хувьсгалт байгууллын эсрэг зэвсэгт бослого гаргаж, төрийн эргэлт хийх гэсэн» хэрэг тулгаж, нүүрэлдүүлж, залхаан цээрлүүлэх элдэв арга хэрэглэн байцаалтын тэмдэглэлд тухай бүр гарын үсэг зуруулж байжээ. Олон сарын зодуур нүдүүрээс залхсан зарим нь худал хэрэг хүлээж, дараа дараагийнхаа мэдүүлгээр нотлох гэж оролдох, эсвэл худал хэрэг хүлээснээ дараах байцаалтанд мэдүүлж байсан нь хавтаст хэргээс харагддаг. Аль болох олон хүний нэр мэдүүлүүлэх, шинээр нэр илэрвэл монголд ажиллаж байгаа сургагч зөвлөх нарт тэр даруй илгээж байжээ.

1940 оны хавраас тэднийг байцаахаа зогсоож, хэрэг хаах тогтоол үйлдэж дээд удирдлага\Л.Берия)-даа илгээсэн байдаг. Л.Берия 1940 оны 9 сарын 6-нд ЗХУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллегид 537 хүний хэрэг шийдүүлэхээр нэрсийн жагсаалт илгээсэн байна.

ЗСБНХУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 472 хүнд буудан алах ял оноосноос 1941 оны 7 сарын 5-ны өдөр БНМАУ-ын 37 иргэнд цаазын ял оноосон байна.

Ингэж 1941 оны 6 сард Орос-Германы дайн эхэлсний дараа гэнэт яаралтай шийдвэрлэн бүгдэд цаазын ял оноон буудан хороосон нь ч анхаарал татдаг. Зөвлөлтийн баруун фронтод байдал хүндэрч, германы цэрэг арми нутгийн гүн рүү дөхөж байхад германы хамсаатан, японы тагнуулын байгууллагын гар хөл болох бүлгийн хэргийг хурдан шийдвэрлэх шаардлага тулгарсан гарсан бололтой. Нутгийнхаа гүнд “панмонгол”-ын хорлон сүйтгэх бүлгийн гэмт этгээдүүдийг хооллож ундлаад, хорьж цагдаж байх шаардлагагүйн дээр БНМАУ-аас баривчлагдсан энэ хүмүүс зөвлөлтийн эрх баригчдын хувьд аюултай гэрч байсан болоод ийн яарсан биз.

БНМАУ 1941 онд ардын хувьсгалын 20 жилийн ойгоо тэмдэглэн баярлаж байх тэр үед Монголын удирдагчид зөвлөлтийн шорон гянданд хилс хэрэгт унан буудуулж байжээ. Энэ их нүгэлт явдлыг удирдан зохион байгуулсан И.В.Сталин ардын хувьсгалын 20 жилийн ойгоор Монголын ард түмэнд баярын цахилгаан ирүүлсэн шиг «амьд бурхан»-ны дүр үзүүлж байсан юм.

Дело № 17093 дугаартай Нармай монголын хувьсгалын эсэргүү хорлон сүйтгэх бүлгийн хэрэгт хамрагдан шийтгэгдсэн БНМАУ-ын иргэдийн нэрс:


**1. Амар** Агданбуу\Ананд)-ын 1887-1941)-Булган аймгийн Бугат сум. БНМАУ-ын ерөнхий сайдаар ажиллаж байхдаа 1939 оны 3 сард баривчлагдан 7 сард ЗХУ-ын Чита хотын шоронд, 8 сараас Москвад лефертовийн гянданд хоригдож байсан. ЗСБНХОУ-ын Дээд шүүхийн



Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 10-нд Эрүүгийн хуулийн 58-1а, 58-11 зүйлээр яллан цаазаар авах ял оноосон. Шүүх хуралдаан дээр А.Амарын хэлсэн сүүлчийн үг: ...Надад тулган хүлээлгэж байсан учир өмнөх мөрдөн байцаалтад өгсөн мэдүүлгээсээ би татгалзаж байна... Хэрэв БНМАУ эрх чөлөөтэй улс юм бол яагаад намайг зөвлөлтийн шүүх шүүж байгааг ойлгохгүй байна... Би монголын ард түмэнд хайртай, оросын ард түмэнд бас хайртай. Гэхдээ бусад том гүрнүүдийн нэгэн адил Монгол орныг колоничлох бодлого явуулж байгаа “улаантнууд”, тэдний засгийн газарт би дургүй. ...БНМАУ-д хувьсгалын эсэргүү ямар ч бүлэглэл байгаагүй...<sup>11</sup> гэжээ. Ялыг мөн оны 7 сарын 27-ны өдөр гүйцэтгэжээ. ЗСБНХУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллегийн 1956 оны 12 сарын 15-ны өдрийн 022693156 тоот магадлалаар цагаатгасан. БНМАУ-ын Ардын их Хурлын тэргүүлэгчдийн дэргэдэх Цагаатгах ажлыг эрхлэх комисс ЗХУ-ын Ерөнхий прокурорын 1960 оны 6 сарын 15-ны өдрийн маш нууц 35-43 СС тоот бичгийг үндэслэн БНМАУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын 1962 оны 1 сарын 25-ны өдрийн 78 дугаар тогтоолоор цагаатгасан.

**2. Бадрах** Өлзийтийн (1895-1941)-Увс аймгийн Давст сум. Сангийн яамны сайд, Эрүүлийг хамгаалах яамны сайд, МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн даргын алба хашиж байсан. 1934 онд Ж.Лхүмбийн хэрэгт холбогдон нэр илэрсэн гэж ЗХУ-д цөлөгдсөн. Улмаар 1937 оны 12 сард баривчлагдсан. 1938 оны 2 сард Монголд хүргэгдэн ирээд удалгүй ЗХУ-ын Чита, Москвад Лефертовийн гянданд хоригдож байсан<sup>12</sup>. ЗСБНХОУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 7-нд Эрүүгийн хуулийн 58-1а, 58-11 зүйлээр яллан цаазаар авах ял оноосон. Мөн сарын 30-ны өдөр ялын тогтоол гүйцэтгэжээ. ЗСБНХУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллегийн 1956 оны 12 сарын 15-ны өдрийн 022693156 тоот магадлалаар цагаатгасан. ЗХУ-ын Ерөнхий прокурорын 1960 оны 6 сарын 15-ны өдрийн маш нууц 35-43 СС тоот бичгийг үндэслэн БНМАУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын 78 тоот тогтоолоор 1963 оны 12 сарын 30-нд цагаатгасан.

**3. Базарханд** Санжийн (1912-1941)-Хэнтий аймаг. ДЯЯ-ны мөрдөн байцаах хэлтсийн дарга. 1939 оны 6 сарын 30-нд баривчлагдан Чита хотод шоронд хоригдож байгаад 8 сард Москва хотын лефертовын гянданд хүргэгдсэн. ЗСБНХОУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941





оны 7 сарын 6-нд “панмонгол”-ын хувьсгалын эсэргүү бүлэглэлийн идэвхтэй гишүүн, хорлон сүйтгэх ажиллагаанд оролцсон, хууль ёс зөрчсөн хэрэгт яллан цаазаар авах ял оноосон. Ялыг мөн сарын 30-нд гүйцэтгэсэн. ЗСБНХУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллегийн 1956 оны 12 сарын 15-ны өдрийн 022693156 тоот магадлалаар цагаатгасан. ЗХУ-ын Ерөнхий прокурорын 1960 оны 6 сарын 15-ны өдрийн маш нууц 35-43 СС тоот бичгийг үндэслэн БНМАУ-ын Дээд шүүхийн бүгд хурлаас 1963.9.13-нд цагаатгасан.

**4. Билэгт** Амгалангийн (1914-1941)-Завхан. ДЯЯ-ны улс төрийн хэлтсийн дарга. 1939 оны 7 сарын 3-нд баривчлагдан ЗХУ-ын Чита хотын шоронд хоригдож байгаад 8 дугаар сард Москвад лефертовын гянданд хүргэгдсэн. ЗСБНХОУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд хувьсгалын эсэргүү бүлэглэлийн ажиллагаанд оролцсон хэрэгт яллан цаазаар авах ял оноосон. Мөн сарын 27-ны өдөр ялын тогтоол хэрэгжүүлжээ. ЗХУ-ын Дээд шүүхийн бүгд хурлаас 1989 оны 11 сарын 28-нд цагаатгасан.

**5. Батсүх** Чоймболын (1911-1941) - Дорнод аймгийн Жавхлантшарга сум. ДЯЯ-ны тусгай хэлтсийн дарга. 1939 оны 7 сарын 7-нд баривчлагдан ЗХУ-ын Чита, тэндээсээ Москва руу лефертовын гянданд хоригдсон. ЗСБНХУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд хувьсгалын эсэргүү бүлэглэлийн ажиллагаанд оролцсон хэрэгт яллан цаазаар авах ял оноосон. Ялыг мөн сарын 30-нд гүйцэтгэсэн. ЗХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллегийн шийдвэрээр 1956 оны 12 сарын 15-нд цагаатгасан.

**6. Баясгалан** Жамцын (1909-1941) -Архангай аймгийн Хангай сум. ДЯЯ-ны эсэргүүцэн тагнах хэлтсийн дарга. 1939 оны 7 сарын 21-нд баривчлагдан ЗСБНХУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 7-нд хувьсгалын эсэргүү бүлэглэлийн ажиллагаанд оролцсон хэрэгт яллан цаазаар авах ял оноосон. ЗХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллегийн 1956 оны 12 сарын 15-нд цагаатгасан. ЗХУ-ын Ерөнхий прокурорын 1960 оны 6 сарын 15-ны маш нууц 35-43 СС тоот бичгийг үндэслэн БНМАУ-ын Дээд шүүхийн 1963 оны 9 сарын 13- ны өдрийн бүгд хурлын 52 тоот тогтоолоор цагаатгажээ.

**7. Бямбажав** Ядамсүрэнгийн (1910-1941) -Ховд аймгийн Мянгад сум. ДЯЯ-ны хэлтсийн дарга. 1939 оны 7 сарын 24-нд баривчлагдан ЗСБНХУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд хувьсгалын эсэргүү бүлэглэлийн ажиллагаанд оролцсон хэрэгт яллан цаазаар авах ял оноосон. Ялыг мөн сарын 27 гүйцэтгэсэн. ЗХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллеги 1956 оны 12 сарын 15-нд хэргийг хэрэгсэхгүй болгосон.

**8. Ванчинхүү** Бандийн (1912-1941) -Ховд аймаг. ДЯЯ-ны Ховд хэлтсийн дарга. 1939 оны 7 сарын 20-нд баривчлагдан. ЗСБНХУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд хувьсгалын эсэргүү бүлэглэлийн ажиллагаанд оролцсон хэрэгт яллан цаазаар авах ял оноосон. Ялыг мөн сарын 27 гүйцэтгэсэн. ЗХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллеги 1956 оны 12 сарын 15-нд хэргийг хэрэгсэхгүй болгосон. ЗХУ-ын Ерөнхий прокурорын 1960 оны 6 сарын 15-ны маш нууц 35-43 СС тоот бичгийг үндэслэн БНМАУ-ын Дээд шүүхийн 1963 оны 9 сарын 13-ны өдрийн бүгд хурлын 52 тоот тогтоолоор цагаатгажээ.

**9. Галиндэв** Сойрын (Суурийн) (1907-1941)-Увс аймгийн Хяргас сум. Эрүүлийг хамгаалах яамны сайдаар ажиллаж байхад 1939 оны 7 оны 20-нд баривчлагдсан. ЗСБНХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд ЗСБНХОУ-ын Эрүүгийн хуулийн 58-1а, 58-11-д заасан хэрэг өдүүлсэн гэж цаазаар авах ялаар шийтгэсэн. Ялыг мөн сарын 27-нд гүйцэтгэжээ. ЗХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллеги 1956 оны 12 сарын 15-нд хэргийг хэрэгсэхгүй болгосон. ЗХУ-ын Ерөнхий прокурорын 1960 оны 6 сарын 15-ны маш нууц 35-43 СС тоот бичгийг үндэслэн БНМАУ-ын Дээд шүүхийн 1963 оны 9 сарын 13-ны өдрийн бүгд хурлын 52 тоот тогтоолоор цагаатгажээ.

**10. Галсанпунцаг** Дэлэгийн (1913-1941) -ДЯЯ-ны тусгай хэлтсийн дарга. 1939 оны 7 сарын 18-нд баривчлагдсан. ЗСБНХОУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд хувьсгалын эсэргүү байгууллагын ажиллагаанд оролцсон хэрэгт яллан цаазаар авах ял оноосон. Ялыг 7 сарын 27-нд гүйцэтгэжээ. ЗХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллеги 1956 оны 12 сарын 15-нд хэргийг хэрэгсэхгүй болгосон.

**11. Гомбожав** Мөнхийн (1911-1941) -Архангай аймаг. ДЯЯ-ны улс төрийн 2 дугаар хэлтсийн дарга. 1939 оны 7 сарын 4-ний өдөр баривчлагдсан. ЗСБНХОУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд хувьсгалын эсэргүү байгууллагын ажиллагаанд оролцсон хэрэгт яллан цаазаар авах ял оноосон. Ялыг мөн сарын 28-нд гүйцэтгэсэн. ЗСБНХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллегийн 1990 оны 1 сарын 30-ны тогтоолоор цагаатгасан.

**12. Гонжав** Лэгцэгийн (1898-1941) -Төв аймгийн Галбадрах сум. Цэргийн Явдлын яамны Хуягт танкийн газрын дарга. 1939 оны 07 сарын 10-нд баривчлагдсан. ЗСБНХОУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд хувьсгалын эсэргүү байгууллагын ажиллагаанд оролцсон хэрэгт яллан цаазаар авах ял оноосон. Ялыг мөн сарын 28-нд гүйцэтгэсэн. ЗСБНХУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын 1990 оны 3 сарын 29-ний тогтоол, БНМАУ-ын прокурорын 1990 оны 5 сарын 14-ний өдрийн 4\83 тоот тогтоолоор цагаатгасан.

**13. Готовсүрэн** Цэвэгмидийн (1913-1941)- Архангай аймаг. ДЯЯ-ны 3 дугаар хэлтсийн дарга. 1939 оны 7 сарын 10-нд баривчлагдсан. ЗСБНХОУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд хувьсгалын эсэргүү байгууллагын ажиллагаанд оролцсон хэрэгт яллан цаазаар авах ял оноосон. Ялыг мөн сарын 27-нд гүйцэтгэсэн. ЗСБНХУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын 1989 оны 11 сарын 28-ны тогтоолоор цагаатгасан.

**14. Найдан** Гүнжидийн (1899-1941)-Төв аймгийн Эрдэнэдалай сум. МАХЦ-ийн Улс төрийн газрын дарга. 1939 оны 1 сарын 26-нд баривчилсан. 1941 оны 3 сарын 21-нд Бутырийн шоронгийн эмнэлэгт нас барсан. БНМАУ-ын Дээд шүүхийн Бүгд хурлын 1963 оны 3 сарын 16-ны өдрийн 3 тоот тогтоолоор цагаатгасан.

**15. Дамба** Готовын (1899-1941)-Хөвсгөл аймгийн Тариалан сум. 1939 оны 1 сарын 31-нд баривчлагдсан. ЦЯЯ-ны орлогч сайд. ЗСБНХОУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд хувьсгалын эсэргүү байгууллагын ажиллагаанд оролцсон хэрэгт яллан цаазаар авах ял оноосон. Ялыг мөн сарын 27-нд гүйцэтгэсэн. БНМАУ-ын Дээд шүүхийн бүгд хурал 1962 оны 2 сарын 13-нд цагаатгасан.

**16. Даншийцоодол**-Гомпилын (1905-1941)-Өвөрхангай аймгийн Дэлгэрэх-булаг сум. Шүүх яамны сайд. 1939 оны 7 сарын 9-нд баривчлагдсан. ЗСБНХОУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд хувьсгалын эсэргүү байгууллагын ажиллагаанд оролцсон хэрэгт яллан цаазаар авах ял оноосон. ЗСБНХУ-ын Ерөнхий прокурорын 1960 оны 6 сарын 15-ны маш нууц 35-43 СС тоот бичгийг үндэслэн БНМАУ-ын Дээд шүүхийн бүгд хурал 1962 оны 2 сарын 14-нд цагаатгасан.

**17. Дамба** Чимидийн (1900-1941) -Дорнод аймгийн Матад сум. ДЯЯ-ны Хорих газрын даргаар ажиллаж байхад нь 1939 оны 7 сарын 15-нд баривчилсан. ЗСБНХОУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд хувьсгалын эсэргүү байгууллагын ажиллагаанд оролцсон хэрэгт яллан цаазаар авах ял оноосон. ЗСБНХУ-ын Ерөнхий прокурорын 1960 оны 6 сарын 15-ны маш нууц 35-43 СС тоот бичгийг үндэслэн БНМАУ-ын Дээд шүүхийн бүгд хурал 1962 оны 2 сарын 14-нд цагаатгасан.

**18. Довчин** Санжийн (1895-1941) -Өвөрхангай аймгийн Өлзийт сум. Сангийн яамны сайд. 1939 сарын 02 сарын 11-нд баривчилж, 7 дугаар сард Чита, 8 дугаар сард Москвад лефертовийн гянданд хорьсон. ЗСБНХОУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд хувьсгалын эсэргүү байгууллагын ажиллагаанд оролцсон хэрэгт яллан цаазын ял оноосон. Ялыг мөн оны 8 сарын 17-нд гүйцэтгэжээ. ЗХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллеги 1956 оны 12 сард 15-нд хэргийг

хэрэгсэхгүй болгосон. БНМАУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын 42 тоот тогтоолоор 1965 оны 5 сарын 31-нд цагаатгасан.

**19. Догсом** Дансранбилэгийн (1884-1941) -Хэнтий аймгийн Баян-Овоо сум. БНМАУ-ын Бага хурлын дарга. 1939 оны 7 сарын 9-нд баривчлагдсан. ЗСБНХОУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 7-нд хувьсгалын эсэргүү байгууллагын ажиллагаанд оролцсон хэрэгт яллан цаазын ял оноосон. Ялыг мөн оны 7 сарын 17-нд гүйцэтгэжээ. ЗХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллеги 1956 оны 12 сарын 15-нд хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгасан. Цагаатгах ажлыг эрхлэх комиссын 1962 оны 1 сарын 25-ны өдрийн 78 дугаар тогтоолоор цагаатгасан.

**20. Дондог** Жалсрайн (1908-1941)-Сэлэнгэ аймаг. ДЯЯ-ны улс төрийн тусгай хэлтсийн орлогч дарга. 1939 оны 07 сарын 17-нд баривчлагдсан. ЗСБНХОУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд хувьсгалын эсэргүү байгууллагын ажиллагаанд оролцсон хэрэгт яллан цаазаар авах ял оноосон. ЗСБНХУ-ын Ерөнхий прокурорын 1960 оны 6 сарын 15-ны маш нууц 35-43 СС тоот бичгийг үндэслэн БНМАУ-ын Дээд шүүхийн бүгд хурал 1962 оны 2 сарын 14-нд цагаатгасан.

**21. Долгоржав** Цэвэгийн (1913-1941)-Дорнод аймгийн Матад сум. ДЯЯ-ны улс төрийн хэлтсийн дарга. 1933 оны 11 сарын 3-нд Дотоодыг хамгаалах газрын дэргэдэх Тусгай Комиссын 6 тоот шийдвэрээр хувьсгалын эсэргүү японы тагнуулын зэвсэгт бослого гаргах бүлгэмийн гишшү гэж 5 жил хорих ялаар шийтгүүлсэн. 1939 оны 7 сарын 20-нд дахин баривчлагдсан. ЗСБНХОУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд хувьсгалын эсэргүү байгууллагын ажиллагаанд оролцсон хэрэгт яллан буудан алах ял оноосон. Ялыг мөн оны 7 сарын 30-нд гүйцэтгэжээ. ЗХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллеги 1956 оны 7 сарын 18-нд хэргийг хэрэгсэхгүй болгосон.

**22. Дэжид-Осор** Жүрмэдийн (1889-1941) -Өвөрмонголын Жирмийн чуулганы Баарин хошууны уугуул. ДЯЯ-ны байгуулах хэлтсийн дарга. 1939 оны 07 сарын 12-нд баривчлагдсан. ЗСБНХОУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд хувьсгалын эсэргүү байгууллагын ажиллагаанд оролцсон хэрэгт яллан буудан алах ял оноосон. Ялыг мөн оны 7 сарын 27-нд гүйцэтгэжээ. 1989 оны 9 сарын 20-ны ЗХУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын 566-89 тоот тогтоолоор цагаатгасан.

**23. Цэндсүрэн** Гүржавын (1903-1941) -Ховд аймгийн Мянгад сум. ДЯЯ-ны улс төрийн 1 дүгээр хэлтсийн дарга. 1939 оны 7 сарын 16-нд баривчлагдсан. ЗСБНХОУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд хувьсгалын эсэргүү байгууллагын ажиллагаанд

оролцсон хэрэгт яллан буудан алах ял оноосон. ЗХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллеги 1956 оны 12 сарын 15-нд хэргийг хэрэгсэхгүй болгосон.

**24. Жамсран** Гэндэнгийн (1915-1941)-ДЯЯ-нд нарийн бичгийн дарга. 1939 оны 07 сарын 15-нд баривчлагдсан. ЗСБНХОУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд хувьсгалын эсэргүү байгууллагын ажиллагаанд оролцсон хэрэгт яллан буудан алах ял оноосон. ЗХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллеги 1956 оны 12 сарын 15-нд хэргийг хэрэгсэхгүй болгосон.

**25. Лосол** Дарьзавын (1890-1940)-Хэнтий аймгийн Батноров сум. БНМАУ-ын Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн орлогч дарга. 1939 оны 7 сарын 12-нд баривчлагдсан. 1940 оны 7 сарын 25-нд Бутырийн шоронгийн эмнэлэгт нас барсан. ЗХУ-ын Ерөнхий прокурорын тогтоолоор 1956 оны 11 сарын 2-нд хэргийг хэрэгсэхгүй болгосон.

**26. Пүрэвдорж** Зундуйн (1900-1941) -Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум. Мал тариалангийн яамны сайд. 1939 оны 7 сарын 9-нд баривчилсан. ЗСБНХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд ЗСБНХОУ-ын Эрүүгийн хуулийн 58-1а, 58-11-д заасан хэрэг өдүүлсэн гэж цаазаар авах ялаар шийтгэсэн. Ялыг мөн сарын 27 гүйцэтгэжээ. ЗХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллеги 1956 оны 12 дугаар сарын 15-нд хэргийг хэрэгсэхгүй болгосон.

**27. Мэнд** Рэнцэнгийн (1901-1941) -Завхан аймгийн Тайшир сум. Худалдаа аж үйлдвэр, тээвэр, харилцан нэвтрэлцэх холбооны яамны сайд. 1937 оны 8 сард Москвад худалдааны хэлэлцээр хийхээр очоод улс төрийн хилс хэрэгт холбогдон ДХАК-д баривчлагдсан. 1938 оны сүүлээр Монгол руу шилжүүлж ДЯЯ-ны шоронд хорьсон. 1939 оны 7 сард ЗХУ-ын Чита, Москвад лефертовын гянданд шилжүүлж, ЗСБНХУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд хувьсгалын эсэргүү байгууллагын ажиллагаанд оролцсон хэрэгт яллан цаазаар авах ял оноосон. ЗХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллегийн 1956 оны 12 сарын 15-нд №411-022693\56 тоот магадлалаар хэргийг хэрэгсэхгүй болгосныг үндэслэн БНМАУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын 1963 оны 12 сарын 14-ний өдрийн 021 дүгээр тогтоолоор цагаатгасан.

**28. Цэнд** Дамбын (1903-1941)-ДЯЯ-ны хэлтсийн орлогч. 1939 оны 7 сарын 21-нд баривчлагдсан. ЗСБНХУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд хувьсгалын эсэргүү байгууллагын ажиллагаанд оролцсон хэрэгт яллан цаазаар авах ял оноосон. Ялыг мөн сарын 27-нд гүйцэтгэсэн. 1992 оны 1 сарын 22-нд цагаатгасан.

**29. Насантогтох** Нэрэнмөрөнгийн (1904-1941)-Төв аймгийн Баянцагаан сум. 1939 оны 7 сарын 6-нд баривчилсан. ЗСБНХУ-ын

Дээд шүүхийн цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд ЗСБНХОУ-ын Эрүүгийн хуулийн 58-1а, 58-11-д заасан хэрэг өдүүлсэн гэж цаазаар авах ялаар шийтгэсэн. Ялыг мөн сарын 28-нд гүйцэтгэжээ. ЗХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллеги 1956 оны 12 сарын 15-нд хэргийг хэрэгсэхгүй болгосон.

**30. Чимиддорж** Нэрэндоогийн (1914-1941) -Төв аймгийн Уянга сум. ДЯЯ-ны Улс төрийн нууц хэлтсийн дарга. 1939 сарын 7 сарын 11-нд баривчлагдсан. ЗСБНХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд ЗСБНХОУ-ын Эрүүгийн хуулийн 58-1а, 58-11-д заасан хэрэг өдүүлсэн гэж цаазаар авах ялаар шийтгэсэн. Ялыг мөн сарын 28-нд гүйцэтгэжээ. ЗХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллеги 1956 оны 12 сарын 15-нд хэргийг хэрэгсэхгүй болгосон.

**31. Намжил** Бадрахын (1902-1941) -МАХА-ийн улс төрийн газрын ерөнхий хэлтсийн дарга, дивизийн комиссар. 1939 оны 07 сарын 3-нд баривчлагдсан. ЗСБНХУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд хувьсгалын эсэргүү байгууллагын ажиллагаанд оролцсон хэрэгт яллан цаазаар авах ял оноосон. Ялыг мөн сарын 28-нд гүйцэтгэсэн. ЗХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллеги 1956.12 сарын 15-нд цагаатгасан.

**32. Лувсандоной** Цэрэнжавын (1903-1941)-Төв аймгийн Баян-Өнжүүл сум. ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн орлогч жанжин. 1939 оны 07 сарын 1-нд баривчлагдсан. 1941 оны 7 сарын 13-нд бутырийн шоронгийн эмнэлэгт нас барсан. ЗХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллеги 1956 оны 12 сарын 15-нд цагаатгасан. БНМАУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын 1962 оны 12 сарын 14-ний өдрийн 23 тоот тогтоолоор цагаатгасан.

**33. Лувсаншарав** Доригжавын (1900-1941) -Хөвсгөл аймгийн Их-Уул сум. МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга. 1939 оны 7 сарын 9-нд баривчилсан. ЗСБНХОУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд хувьсгалын эсэргүү байгууллагын ажиллагаанд оролцсон хэрэгт яллан буудан алах ял оноосон. Ялыг мөн оны 7 сарын 27-нд гүйцэтгэжээ. ЗХУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1956 оны 12 сарын 15-нд цагаатгасан. БНМАУ-ын Цагаатгах ажлыг эрхлэх комиссын 1962 оны 2 оны 13-ны 80 тоот тогтоолоор цагаатгасан.

**34. Хас-Очир** Гэлэгийн (1897-1941) -ДЯЯ-ны сайд. 1939 оны 07 сарын 20-нд баривчлагдсан. ЗСБНХУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд хувьсгалын эсэргүү байгууллагын ажиллагаанд оролцсон хэрэгт яллан буудан алах ял оноосон. Ялыг мөн оны 7 сарын 30-нд гүйцэтгэжээ. ЗХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллеги 1960 оны 6 сарын 7-нд хэргийг хэрэгсэхгүй болгосон



**35. Сосоржав** Цэндийн (1912-1941)- Өмнөговь аймаг. ДЯЯ-нд тасгийн дарга. 1939 оны 07 сарын 9-нд баривчлагдсан. 1941 оны 7 сард хувьсгалын эсэргүү байгууллагын ажиллагаанд оролцсон хэрэгт яллан цаазаар авах ял оноосон. ЗХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллеги 1956 оны 12 сарын 15-нд хэргийг хэрэгсэхгүй болгосон.

**36. Бордух** Чимидийн (1913-1941)-Увс аймгийн Зүүнхангай сум. Хилийн тагнуулын албанд хэсгийн дарга. 1939 оны 07 сард 5-нд баривчлагдсан. ЗСБНХУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 5-нд хувьсгалын эсэргүү байгууллагын ажиллагаанд оролцсон хэрэгт яллан цаазаар авах ял оноосон. Ялыг мөн сарын 30-нд гүйцэтгэсэн. ЗХУ-ын Дээд шүүхийн бүгд хурлаас 1990 оны 1 сарын 30-нд хэргийг хэрэгсэхгүй болгосон.

**37. Чагдаржав** Дамдинсүрэнгийн (1902-1941)-Дорнод аймгийн Чойбалсан сум. Ерөнхий сайдын орлогч бөгөөд Худалдаа, тээврийн яамны сайд. 1939 оны 7 сарын 12-нд баривчлагдсан. ЗСБНХУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 4-нд хувьсгалын эсэргүү байгууллагын ажиллагаанд оролцсон хэрэгт яллан цаазаар авах ял оноосон. Ялыг мөн сарын 27-нд гүйцэтгэсэн. ЗХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллеги 1956 оны 12 сарын 15-нд хэргийг хэрэгсэхгүй болгосон. БНМАУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын 1965 оны 5 сарын 31-ний өдрийн 043 тоот тогтоолоор цагаатгасан.

**38. Шижээ** Золбингийн (1901-1941) -Москвагийн ДДХКС-ийн монголын тэнхимийн эрдэм шинжилгээний ажилтан. 1937 оны 12 сарын 17-нд баривчлагдсан. ЗСБНХУ-ын Дээд шүүхийн Цэргийн коллеги 1941 оны 7 сарын 9-нд хувьсгалын эсэргүү байгууллагын ажиллагаанд оролцсон хэрэгт яллан цаазаар авах ял оноосон. Ялыг мөн сарын 27-нд гүйцэтгэсэн. ЗХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллеги 1956 оны 12 сарын 15-нд хэргийг хэрэгсэхгүй болгосон.

Эдгээр 38 хүнээс Д.Лосол Бутырийн шоронгийн эмнэлэгт нас эцэслэсэн бөгөөд бусад 37 нь цөм цаазын ял авч буудуулсан гэдгийг дээр өгүүлсэн.

ОХУ-ын Холбооны Аюулгүй байдлын албаны Төв архиваас ирүүлсэн лавлагаанд Москва орчмын Бутово суурин, «Коммунарка» сангийн аж ахуйн полигонд хороогдсон 232 хүний нийтийн булшинд хувьсгалын эсэргүү «Панмонгол»-ын хорлон сүйтгэх бүлгийн хэрэгт яллагдан цаазлагдсан БНМАУ-ын дээр нэр дурдсан иргэдийн шарил байдаг.

Цөвүүн цагийн золиос болон алтан амиа алдсан Монгол Улсын иргэдийн нэр төрийг сэргээж, дурсгалыг мөнхжүүлэх үйлсийн нэгэн илэрхийлэл болгож энэ газарт Монгол Улсын төр засгаас хариуцан 2001 онд хөшөө босгож хүндэтгэл илэрхийлсэн юм.

Дээрх хэргийн тухайд дүгнэлт болгон өгүүлэхэд:

1. Дело №17093 гэх хэрэг бүрэнхнаасаа, зөвлөлтийн удирдлагын хэмжээнд бодож боловсруулан зохион байгуулагдсан хэрэг байв. Энэ нь тухайн үеийн зөвлөлтийн эрх баригчдын явуулж байсан геополитикийн бодлоготой холбоотой.
2. Энэ бүлэг хэрэгт хамрагдагсдын дотор эрх баригчдын заавраар хядлага үйлдэж байсан дотоод яамны удирдлагууд, гүйцэтгэгч нарыг хамруулсан нь өөрсдийн үйлдсэн хэргийн гэрч нарыг устгах хэмээсэн хэрэг байв.
3. Эл хэргийг 1941 оны 7 сард гэнэт шийдвэрлэж, БНМАУ-ын дээрх 37 иргэнд цаазын ял оноож, ялыг сарын дотор багтаан хэрэгжүүлсэн нь бас учиртай. Зөвлөлтийн баруун фронтод байдал хүндэрч, Германы цэрэг арми нутгийн гүн рүү дөхөж байхад Германы хамсаатан, японы тагнуулын байгууллагын гар хөл болох бүлгийн хэргийг хурдан шийдвэрлэх шаардлага тулгаран гарсан бололтой. Нутгийнхаа гүнд «панмонгол»-ын хорлон сүйтгэх бүлгийн гэмт этгээдүүдийг хооллож ундлаад, хорьж цагдаж байх шаардлагагүйн дээр БНМАУ-аас баривчлагдсан энэ хүмүүс зөвлөлтийн эрх баригчдын хувьд аюултай гэрч байсан болоод ийн яарсан биз.
4. Дело №17093 тоот мөрдөн байцаалтын хавтаст хэргээс үзвэл хууль бус хамгийн харгис хэрцгий аргаар байцааж, хүчээр ял хүлээлгэж байсан нь тодорхой байдаг.
5. Дело №17093 тоот хэрэгт хамрагдсан БНМАУ-ын иргэн эдгээр хүмүүсийн мөрдөн байцаалтын хавтаст хэргийг холбогдох газраас нь бүгдийг шилжүүлэн авах шаардлагатай байна.

Эх нутгаасаа зөвлөлтийн эрх баригчдын шийдвэр, дотоод яамны зөвлөх, сургагчид, ажилтнуудын гүйцэтгэх ажиллагааны үр дүнд улс төрийн хилс хэрэгт гүтгэгдэн баривчлагдаж харь гүрэнд цаазлуулсан, шорон гянданд хоригдон олон жилийн хүнд хүчир хөдөлмөрт нухлуулсан, цөлөгдсөн Монгол Улсын харьяат иргэдийнхээ тухай ултай судлахын тулд ОХУ-ын болон бусад гадаад орны эрдэмтэдтэй хамтран ажиллах зайлшгүй шаардлагатайг эцэст нь тэмдэглэе.

### Ном зүй

1. Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн намтрын товчоон IX боть. УБ., 2008. Тал 81
2. А.Е.Павлюков. ЕЖОВ Биография. Захаров хэвлэлийн газар. М, 2007, с 383
3. [www.yandex.ru](http://www.yandex.ru): И.В.Наумов. Органы государственной безопасности Восточно- Сибирского края (1930-1936)
4. [www.yandex.ru](http://www.yandex.ru): Вячеслав Звягинцев. Трибунал для героев. М., 2005 г
5. [www.yandex.ru](http://www.yandex.ru): Вячеслав Звягинцев. Трибунал для героев. М., 2005 г
6. А.Думбурай. Залхаан цээрлүүлэлт. УБ., 1997, тал 52
7. Мөн тэнд, тал 52
8. [www.yandex.ru](http://www.yandex.ru): Вячеслав Звягинцев. Трибунал для героев. М., 2005 г
9. А.Г.Тепляков. Машина террора. ОГПУ-НКВД Сибири в 1929-1941 г. М., 2008 г
10. [www.yandex.ru](http://www.yandex.ru): Михаил Шрейдер. НКВД изнутри. Записки чекиста. 1995 г
11. Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн намтрын товчоон. XV боть. УБ., 2012., тал 240-241

## МОНГОЛ ДАХЬ ХЭЛМЭГДҮҮЛЭЛТ БА НИЙГМИЙН ХӨГЖИЛ



*Удо Баркманн  
Доктор, профессор  
ХБНГУ*

Өнөөдрийн энэ хурлын хөтөлбөрийг анхааралтай уншиж үзсэн хүн хурлын сэдвээс “хэлмэгдүүлэлт”, “улс төрийн хэлмэгдүүлэлт”, “их хэлмэгдүүлэлт” зэрэг ойлголтыг олж үзэхийн дээр хэлмэгдүүлэлтийн золиос болсон “хэлмэгдэгчид” хожим “цагаатгагдсан” болохыг олж мэднэ. Миний бодлоор нийтлэг хэрэглэгддэг “хэлмэгдүүлэлт” хэмээх ойлголт сэдвийн гол санаатай авцалдахгүй байгаа юм. Түүхийн баримтуудыг нягтлах юм бол тэр нь Монголын төр бус, харин Зөвлөлт Холбоот Улсад тогтсон улс төрийн дэглэмээс эхтэй “төрийн террор”-ын нэг хэлбэр байжээ гэсэн дүгнэлт гарна. Гэхдээ гадны заавраар хэрэгжүүлсэн төрийн террорын арга хэмжээнүүдийг Монголын төрийн байгууллагууд гүйцэтгэсэн болохыг анзааралгүй орхиж болохгүй. Тиймээс Монголын төрийн бараг бүх өндөр албан тушаалтан хэрэг үйлдэгч ч, хэргийн золиос ч болсон билээ. Улс төр, ёс суртахууны гэм буруу ерөнхий сайд Х.Чойбалсангийн хувьд онцгой хүнд жин дарна

Үзэл суртал хэв шинж нь болсон дарангуйлагч дэглэм оршин буй нөхцөлд л бидний мэдэх “төрийн террор” бий болдог. Дайсны талаарх зохиомол ойлголт төсөөллийг буй болгож байж л “төрийн террор” ажиллана. Түүгээр бол “дайсан” гэдэг нь дарангуйлагч төр улс төр, үзэл сурталын зорилгодоо хүрэхийн тулд байнга өдөөхийг хичээдэг айдас хүйдэс, үзэн ядалт зэрэг сэтгэлийн хөдөлгөөнтэй холбогдсон гол дүр юм.

1921 оноос хойших Монголын хувьд ялгаатай тал нь тэр үед монголчууд улс орныхоо хөгжлийн чиг хандлагыг хязгаарлагдмал хэмжээгээр тодорхойлж байсанд оршино. Хэрэг дээрээ хөгжлийн

чиг баримжаа, түүний үзэл суртлын удирдамж чиглэлийг ихэвчлэн Москвагаас өгдөг байж. Зөвлөлт Холбоот Улс Монголд цэргийн хүчирхэг эрх мэдэлтэй болж, хаа сайгүй байсан төлөөлөгчид нь гүйцэтгэх засаглалын бүх түвшний үйл ажиллагааг тодорхойлж байв. Зөвлөлтийнхөн өгсөн удирдамжийг нь эс биелүүлэх аваас амь насанд нь аюултай болохыг Монголын элит хүрээнийхэнд тун эртнээс тодорхой ойлгуулж эхэлсэн байлаа. Үүнд 1921-1925 онуудад Зөвлөлтийн төлөөлөгч Элбэгдорж Ринчиногийн тэргүүлсэн “Бүх цэргийн зөвлөл” онцгой их үүрэг гүйцэтгэсэн юм. Тус Зөвлөл 1922 оны 7-р сарын 3-нд “Дотоодыг хамгаалах газар”-ыг байгуулсан байдаг.

Зөвлөлтийнхөн орой руу нь ортол хэлж зааварлаж, Монголын удирдлагаас уламжилсан дайсны талаарх ойлголт төсөөлөл өөрчлөгдөж эхлэв. Зөвлөлтийн большевикуудын тодорхойлсон дайсны талаарх ойлголт төсөөллийн гол нь 1921 онд Монголд тогтсон “Хятадын харгис ноёрхол”, “Оросын цагаантнууд”-ыг бут цохисны дараа юуны өмнө “олз ашиг, зэрэг хэргэмд шуналтай ховдог ноёд”-од чиглэж байсан бол овоо хараа нь Монголын Ардын засгийн газрын удирдах албан тушаалтнуудад чиглэх болжээ. Дайсны талаарх ойлголт төсөөллөөс үүдэн бий болсон гадаадын аюул заналхийллээс айх айдас улам бүр дотоод руу чиглэх болов. Зөвлөлтийнхний нарийвчлан тодорхойлсон нийгмийн хэсэг бүлгүүдийг “дайсны хамт олон” хэмээж, тэднийг устгах тэмцэл явуулах хэрэгтэй боллоо гэх болов.

Анхны золиос нь ерөнхий сайд Бодоо, түүний 14 хамтран зүтгэгч болж, тэднийг Элбэгдорж Ринчиногийн толгойлсон “Бүх цэргийн зөвлөл”, “гадаадын харгис дайсны этгээдтэй сүлбэлдэн нийлж, ардын засгийг устгах” гэлээ хэмээн буруутгасан байна. Хуулийн мөрдөн шалгах ажиллагаа урьдчилж явуулалгүйгээр Бодоо нарыг ялласан Засгийн газрын тогтоолд улс төрийн дээд хүрээнийхэн болон ард түмэнд хэдий хатуу ч гэсэн “шударга” шийдвэр гаргасан мэт санаа төрүүлэхүйц заалт орсон байлаа. “Цаазны бичгийн ёсоор цавчин алах ба хөвчдөн алах ял оноож хувьсан тогтоосон дүрмийн ёсоор цөм буудан алах” байсны оронд яллагдагсдыг “хорин дөрвөн цагийн дотор даруй буудан алах”-аар заасан байв. “Тэдний эм ба хөвгүүд, охидыг бүрнээ уучлан хэлтрүүлж, хуулиас ангид нигүүлсэн өршөөхийг үзүүлэх” болсон нь онц хорлонтой заалт байв.<sup>1</sup> Монголын удирдлагынхны дунд айдас хүйдэс газар авлаа. Байр суурь, албан тушаал нь зөвлөлтийнхний үзэл суртлын явуулгаас хамгаалж чадахгүй болсныг тэд ойлгов. Айдас хүйдэст улам автах тусмаа зөвлөлтийнхний шийдвэрийг эсэргүүцэх эсэргүүцэл нь суларч байв. Зөвлөлтийнхөн айдаст автахын ашиг тусыг ухаарах тэр хэрээрээ улс төр, үзэл суртлын зорилгодоо хүрэхэд нь тустай тэрхүү айдас хүйдсийг улам дэвэргэж байсан юм.

<sup>1</sup> Бодоо нарыг шийтгэх тухай тогтоол, Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл, Хоёрдугаар боть 1911-1926. V сар, Улаанбаатар 2010, 412.

Э.Ринчино МАХН-ын III их хурлын үеэр Монголд зөвлөлтийнхөн ямар зорилго тавьсныг тодорхой илэрхийлсэн байдаг. Тэрээр: “Монгол Ардын Намын эцсийн зорилт нь эв хамтын ёс мөн бөгөөд нам капитал хөрөнгөтний хөгжлийн шатыг алгасан энэ зорилгод хүрэхээр урагшаа давшин явж байна” гэжээ.<sup>2</sup> Ринчино улс төрийн өрсөлдөгч нь болох Д.Данзанг “Монголын хаан”-д өөрийгөө өргөмжлөхийг хүссэн хэмээн буруутгав. Тэрээр Данзан нарыг “баруунтан”, “хулгайч”, “урвагч” гэх зэргээр нэрлэж, “Хятадын мөнгө хүүлэгчидтэй нягт сүлбэлдэн ажиллах боллоо”, “Хятадын империалист хувьсгалын эсэргүүчүүдийн бие төлөөлөгч” хэмээж байв. Тэгээд явуулсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь ерөнхий сайд Д.Бодоогийнхтой төстэй байсан юм. Угтаа ямар ч эрх мэдэлгүй тусгай комисс мөрдөн шалгах ажиллагаа явуулалгүйгээр цаазаар авах ял оноогоод хэдхэн цаг болсны дараа Д.Данзанг буудан хороожээ. Намын их хуралд оролцогсад түүний дараачаас Элбэгдорж Ринчино болон зөвлөлтийнхний чиглэл болгосон зорилго зорилтуудыг баримтлан дагах болсон байна.

Бүгд Найрамдах Монгол Ард Улс байгуулагдлаа. Улсын III Их Хурал 1926 оны 10-р сард анхны “БНМАУ-ын Шүүх Цаазын бичиг”-ийг батлав. Тэр нь ерөнхий болон тусгай ангиас бүрдэж байсан бөгөөд тусгай ангийг нь тэр үед олон нийтийн хүртээл болж байсан баримт материалуудад нийтлээгүй. Тусгай ангид “Улс төрд тэрслэх нь” гэсэн 8-р бүлэг, “Улс төрөөс урвах нь” гэсэн 9-р бүлгийг оруулжээ. Үндсэндээ 5-аас доошгүй жил хорих ял оноохоор болсноос бус цаазаар авах ялын талаар заагаагүй нь сонирхол татна. Харин 1929 оны “БНМАУ-ын Шүүх Цаазын бичиг”-ийн тусгай ангид “Хувьсгалын эсэргүү гэмт хэргүүд” гэсэн бүлгийг оруулсан байна. Уг шүүх цаазын бичигт ч бас шийтгэлийг зөвхөн хорих ял хэлбэрээр оноохоор заасан юм. Цаазаар авах ялын талаар дурьдаагүй ажээ.<sup>3</sup>

1928 оны 10-аас 12 дугаар сарыг хүртэл хуралдсан МАХН-ын VII их хурлаар намын эгнээн дэх “баруунтнууд”-тай тэмцэл явуулав. Зөвлөлтийнхний хэлснээр дайсан намын эгнээнд шургалсан байжээ. “Баруунтнууд”-тай хийсэн тэмцлийн эцэст Улсын V Их Хурал 1929 оны 1 дүгээр сард “ардын диктатур” тогтоосноо тунхаглав. Маш нууц зэрэглэлтэй 1929 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн “Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын харилцааны үндсэн зарчмуудын тухай хэлэлцээр”-ийн үрээр эдийн засгийн харилцаа гүнзгийрч, Зөвлөлтийн талын чармайлтаар улс төрийн хувьд найдваргүй хүмүүсийг Монгол-Зөвлөлтийн эдийн засгийн хамтын ажиллагааны бүхий л салбараас шахан зайлуулах ажиллагаа эхлэв. Уг хэлэлцээрт:

2 Монгол Ардын Намын Гуравдугаар Их Хурал. Дэлгэрэнгүй тэмдэглэл, Улаанбаатар 1966, 157

3 Д. Адыабазар, Монгол Улсын 1921 оноос хойшх эрүүгийн хууль тогтоомжийн хөгжил, I- дэвтэр, Улаанбаатар хот 1998, 206 хуудас.



“Юуны өмнө БНМАУ-ын Засгийн газар (Улсын) V Их Хурлын шийдвэрт нийцүүлэн өөрийн байгууллагуудын бүтэц бүрэлдэхүүнийг ажиллагсдынх нь улс төрийн хувьд найдвартай, шаардлагатай мэргэжлийн ур чадвар эзэмшсэн эсэхийг харгалзан хянан үзэж, МАХН-ын хөгжил, ЗСБНХУ-аас уригдан ирсэн зааварлагчдын үйл ажиллагаанд саад болж болзошгүй хүмүүсийг тэдгээр байгууллагаас зайлуулснаар энэ дэмжлэг илрэх ёстой.” гэжээ.<sup>4</sup>

Хоёр тал Монголын Засгийн газраас тавьсан зорилттой улс төрийн хувьд санал эс нийлж халагдсан хүмүүсийг Зөвлөлт, Монголын байгууллагуудад ажиллуулахгүй байх үүргийг харилцан хүлээжээ. МАХН дахь “хөдөөгийн жигүүрийнхэн” гэнэт нам, төрийн албанд орох болж, түүнийг нь “Ардын диктатур” нь зөв зүйтэй хэмээн хамгаалж байв, ЗСБНХУ-д нийгмийн ийм бүлгийг Шариков гэдэг байсан. Уг жигүүрийнхэн юуны өмнө эгэл доод гарал үүсэл, боловсрол муутайгаараа ялгарч байв. Зөвлөлтийнхний хувьд тийм хүмүүсийг удирдахад амар байсан. Тэд нийгмийн хэсэг бүлэг хоорондын атаа жөтөөг өөгшүүлэн дэвэргэж, дуулгавартай байхгүй л бол тэр дор нь буцаагаад авчихаж болох эрх дархыг тэдэнд эдлүүлж байв. Улс төрд ахиж дэвших явдал, атаа жөтөө, өрсөлдөөн, архи дарс мэт нь зөвлөлтийнхний улс төрийн тоглоомын сайтар тооцоолж болохуйц байнгын хэрэглэгдэхүүн болж, түүгээр нь ч Монголын удирдлага хожоотойгоор жолоодон залуурдуулж байлаа.

“Ардын диктатур” хэмээх ойлголт ард түмний доод давхаргынханд “ардын дайснууд”-д эвлэршгүй хандаж байна гэсэн сэтгэгдэл төрүүлж байв. Төр засаг ноёд язгууртнуудын хөрөнгийг хураав. Нийт 729 ноёд язгууртны 669-ийнх нь хөрөнгийг хураасан байна. Түүний сацуу 400 хамтрал коммуныг байгуулсны уршгаар төд удалгүй мал аж ахуйн эдийн засаг сүйрлийн байдалд оржээ. 100-гаас дээш бодтой хүн бүрийн хөрөнгийг хураагаад зогссонгүй, тэднийг их бага ямар нэг хэмжээгээр “ангийн дайсан” болгов. “Ангийн дайсан” хэмээх ойлголт нь зөвлөлтийнхөнд ашигтай туссан юм. Энэ нь нийгмийн хувьд дайсны талаарх тэр үеийг хүртэлх бүх тодорхойлолтыг бодвол илт бүдэг бүрхэг ойлголт байв. Түүнд ноёд язгууртан төдийгүй лам хуврагууд, үндсэндээ сүм хийдүүдийг ч хамруулж байлаа. Юун түрүүн лам нар өмч хураасныг эсэргүүцэн тэмцсэн нь сүм хийдүүд, тэнд амьдарч байсан лам нарын амьжиргааны үндэс алдагдсанаас болсон. Төгсбуйантын хүрээ, Улаангомын хүрээнд гарсан лам нарын зэвсэгт бослого нийгэмд халдсан их түймэр болон тархаж, Баруун Монголыг бараг тэр чигт нь хамарсан билээ.

4 Строго секретно, Соглашение об основных принципах взаимоотношений между Союзом Советских Социалистических Республик и Монгольской Народной Республикой, Монгол Улсын Гадаад Харилцааны Яамны Архив.

МАХН-ын Төв Хороо тэдгээр бослогыг 1932 оны 4-р сард Япон болон “дотоодын хувьсгалын эсэргүү хүчин”-ий өдөөсөн “хувьсгалын эсэргүү үймээн самуун” хэмээн дүгнэсэн нь их учиртай: Дайсан гэнэт Монголын дотоодод ч, гадаадад ч бий болж, тогтоосон дэглэмд халдсан тул улс орны дотоодод цэргийн их хүч хэрэглэх хэрэгтэй байна хэмээн харуулахыг зорьсон хэрэг. Санаандгүй байтал 1921 оных шиг Монгол Улсын тусгаар тогтнол эрсдэлд орсон мэт харагдах болов. “Тусгаар тогтнолоо хадгалах” нэрийн дор хардлага сэрдлэг төрүүлэлгүйгээр, зөвхөн үзэл суртлын зорилгоо мөрдлөг болгон монголчуудын өмнө аливаа арга хэмжээг зөв зүйтэй хэмээн хамгаалах боломжтой байв.

Зөвлөлтийнхөн эдийн засгийн эмх замбараагүй байдлыг хариуцах учиртай “зүүнтэн”-тэй тэмцэх лоозонг дэвшүүлэв. Ингэж цаг ямагт шинээр айлган сүрдүүлэх жүжиг зохиох нь Зөвлөлтийн практикт хэвшил болсон байсан. Түүгээрээ Сталин, түүний тойрон хүрээлэгчдийн улс төрийн буруу шийдвэрт хүлээх улс төрийн хариуцлагаас хүмүүсийн анхаарлыг холдуулж байлаа. Террорын аппарат улам бүр бие даан ажиллах болж, террор төрийн удирдлагын дотоод логиктой огт авцалдаагүй хар аяндаа ажиллаж эхэлсэн нь түүний нэг үр дагавар байв. Нууцаар мэдээлэх явдал “Дотоодыг хамгаалах газар”, түүний Зөвлөлтийн зөвлөхүүдийн дэмжлэгтэйгээр Монголд газар авав. Энэхүү чанарын шинэ өөрчлөлт “Лхүмбийн хэрэг”-т тодорхой тусгалаа олсон буй.

1. МАХН-ын тэргүүлэгч гишүүн, нарийн бичгийн дарга Лхүмбийн үйлдсэн гэх гэмт хэрэг нь улс төрийн өөр зорилгод хүрэхийн тулд удирдамж чиглэл өгч, эсвэл хүчээр тулган хүлээлгэсэн зохиомол хэрэг байсан.
2. Зохиомол хэргүүдийг ямагт “Японы тагнуул” хэмээн буруутгах явдалтай холбоотойгоор гаргаж тавина.
3. Төр оршин тогтноход аюул занал учирлаа гэсэн санааг олон нийтэд төрүүлэхийн тулд зохиомол хэргийг ихэд дөвийлгөн харуулдаг байв. Үүний тулд намаа хайрлаж, үнэнчээр зүтгэх, Зөвлөлт Холбоот Улсад үнэнч байхыг уриалсан, нийгмийн бүлэг хоорондын атаа жөтөө, хардлага сэрдлэг, аймхай хулчгар зан, шунал, үзэн ядалт, байнгын айдас хүйдсийг ашигласан нууц мэдээллийг хөхүүлж байв. “Лхүмбийн хэрэг”-г холбогдуулан 317 хүнийг ялласны 126 нь Зөвлөлтийн ГУЛАГ-т ял эдлэх болжээ. Хуулийн талаас нь аваад үзэх юм бол мөрдөн шалгах үйл явц, шүүхийн шийдвэр гаргах ажиллагааны аль аль нь дан улс төрийн удирдамж чиглэлийг мөрдлөг болгож, хууль эрхийн ямар ч мэдлэг чадваргүй хүмүүс түүнийг гардан гүйцэтгэж байснаас хөгийн хоосон сүржигнэл төдий байжээ.

1937-1938 онуудад Зөвлөлтийн төрийн террор Монголд оргилдоо хүрэв. Москвагийн удирдлага устгавал зохих хүмүүсийн нэрсийн жагсаалтыг гаргаж, Зөвлөлтийн жишээгээр 1937 оны 10-р сарын 2-нд Онц бөгөөд бүрэн эрхт комиссыг байгуулуулах арга хэмжээ авсан бөгөөд уг комисс шүүхээс илүү эрх эдэлж байв. Тус комисс 1937-1939 оны хооронд 150 удаа хуралдахдаа 25824 хүнээс 20474-г нь буудан хороох ял оноожээ. Комисс ердөө 7 хүний ялыг хэлтрүүлсэн байна.<sup>5</sup> Улаанбаатарын Төв театрт Зөвлөлтийн жишээгээр улс төрч бие хүмүүс болон лам хуврагуудыг шүүх хурлыг үзүүлбэр болгон зохион байгуулдаг байв. Зөвлөлтийн аюулгүй байдлын зөвлөхүүдийн дүгнэснээр бие хүний хувьд сул тогтворгүй, архи их уудаг, хүүхэмсгийнхээ улмаас сайтар залж жолоодож, хянахад амарт тооцогдож байсан Чойбалсан “Монгол төрийн шинэ үеийн ангийн тэмцэл” хэмээх хэлсэн үгэндээ “Монголын хувьсгалын эсэргүүчүүд”-ийн эгнээнд 68000 лам, 900 феодал ноёд, 7000 цагаан буриад, 9289 худалдаачин буюу мөлжигч худалдаачид байгаа тухай заасан буй. Түүний дурдсан тоог “хувьсгалын эсэргүүчүүд”-ийг устгах төлөвлөгөөний үзүүлэлтийг тогтоохдоо үндэс болгон авчээ. Харин Монголын 700 орчим сүм хийдийг галдан шатааж, нураан устгахад номын сангуудад нь хадгалагдаж байсан монгол ном зохиол бараг бүрмөсөн устсан нь онц их уршиг тарьсан билээ.

Ингэхэд Зөвлөлтийн төрийн террор Монголын нийгмийн хөгжилд ямаршуухан нөлөө үзүүлсэн бэ? Энэ нь хэд хэдэн талтай, түүнээс энд цөөн хэдийг нь дурдая.

1930-аад оны үед Монголд багцаагаар наанадаж 50 000 эрчүүд алагдсан нь эрэгтэйчүүдийн 15 орчим хувьтай тэнцэнэ хэмээн дүгнэж болохоор байна. 25-55 насны тэдгээр эрчүүдийн ихэнх нь сурч, боловсорч, дадлага туршлага эзмшсэнийхээ хувьд нийгмийн цогц чадамж бүхий хүмүүс байсан. Тэд нийгмийн давхраажлын пирамидын оргил нь, үндсэндээ тэр үед хэнээр ч орлуулшгүй нийгмийн соёлын ноён нуруу нь болж байв. Тийнхүү Зөвлөлтийн төрийн террор нь Монголд соёл, оюун санааны геноцид үйлдэхэд хүргээд зогссонгүй, нийгмийн пирамидын оройд өөрсдөдөө ашигтай дурын хүмүүсийг тавих боломжийг зөвлөлтийнхэнд олгосон юм. Хүн ам цөөний дээр алагдсан эрчүүд хамгийн зохистой биологийн нөхөн үржихүйн насандаа байснаас хүн амын өсөлт илт саарсан байна. Бас хуучин лам байсан олон хүн 1938 онд өөрсдөд нь зориулж байгуулсан 100 үйлдвэрлэлийн нэгдэлд байран суурин ажиллах ёстой болсноос гэр бүл зохиох боломжгүй байсан нь хүн амын өсөлтөд сөргөөр нөлөөлсөн.

Төрийн террор ноёрхож байсан он жилүүдийн дараа монгол эрчүүдийн сэтгэл санааны байдал ямархуу байсан бэ? Бидний бага сага мэдэж байгаагаар тэд дотроо яахаа мэдэхээ больж хямарсан, айж түгшсэн, ёс суртахууны доройтолд орсон, сэтгэл хоргодох юмгүй

5 Дэмбэрэлийн Өлзийбаатар, Яагаад 1937 он?, Улаанбаатар 2004, 294 дэх тал.

болсон авч гаднаа тэр үеийн “эр хүн байх” хэм хэмжээний дагуу “ширүүн дориун эрс” болж харагддаг байв. Хууль эрхэд итгэх итгэл тэг заах хандлагатай болжээ. Тэр бүхний үр дагавар өнөөг хүртэл мэдрэгдсээр байна. Зөвлөлтийнхөн МАХН-ын тусламжтайгаар Макиавеллийн хэлсэнчлэн “ял шийтгэлээс айх айдас”-ыг хэзээ ч намжаахгүй байлгах тогтолцоог бий болгожээ. Тиймээс айдас хүйдэс хүмүүст удаан хугацаагаар “яс маханд нь тултал гүн” шингэж, хуучны нүүдэлчин нийгмийг бас ч гэж эерэг үр нөлөөтэйгээр хожмын хотжилтын үйл явцад бэлтгэн сахилгажуулж өгсөн юм. Гэхдээ айдас нь, түүнийг хүлээн авч, даван туулах юм бол хөгжлийн дараагийн алхмыг үүтгэж болдог, харин нүүр тулахаас эмээн булзаж бултаад байх юм бол зогсонги байдалд ч хүргэх талтай гэдгийг бид психоанализаас мэднэ. Сүүлчийнх нь тохиолдол 35-аас дээш насныхны дунд нийтлэг байсан нь мэдээж, гэхдээ арай залуу үеийнхэнд нөлөөлсөн байж болох. Юутай ч 1941 онд МАХН-ын Төв Хорооны дэргэд байгуулагдсан Намын Шинэ Хүчний Сургуулиар зөвхөн 18-35 насныхныг шинэ элитэд бэлтгэн сургаж байсан нь санамсаргүй тохиолдол биш юм. Гэхдээ тэднийг хоёр жил хагас суралцахад нь зөвхөн “сахилга бат, сурлагын амжилт, эрүүл мэндийн байдал, ажил хөдөлмөр эрхлэхэд бэлэн эсэх, улс төрийн хандлага” мэтээр нь байнга үнэлж дүгнэж байсныг мэдэх юм бол энэ нь шинэ элитийн талаар бага сага юм хэлээд өгнө.

Бас тэр үеийн Монголын нийгэмд явагдсан нийгэмшлийн үйл явцын талаар энд хэдэн үг хэлье. Хэрэв нийгэмшлийн үйл явцыг нийгэм-соёлын загварууд (үнэт зүйлс, хэм хэмжээ)-ыг сурах, хүлээн зөвшөөрөх, тэдгээрийг өөрийн болгох явцдаа зан үйлдээ тавих дотоод хяналтыг бий болгох явдал гэж үзвэл Зөвлөлтийн төрийн террорын үед үе үеийнхэн их, бага ямар нэг хэмжээгээр эвдэрсэн нь тодорхой болно. Уламжлалт нийгэм-соёлын загварын хувьд байнга хэмжээ хэтрүүлэх явдал өдөр тутмын амьдралыг тодорхойлж байсан. Лам хуварга зэрэг бүхэл бүтэн нийгмийн давхаргуудыг устгаж, сүм хийдүүдийг нурааж, монгол ном зохиолыг үгүй хийсний улмаас нэг далайлтаар Азийн үнэт зүйл, амьдралын хэм хэмжээнээс хөндийрч хүйн холбоо нь тасарсан юм. Гэхдээ зөвлөлтийнхэн тэр хоосон зайг өөр хувилбараар нөхсөн. Монголд кирилл үсгийг 1941 оноос нэвтрүүлж, 1946 оноос албан ёсных болгон зарлав. 1935 онд хүн амын 5.8 хувь нь бичиг үсэгтэн байв. Юуны өмнө лам нар, цөөн тооны албан тушаалтнууд бичиг үсэгтэн байсан болов уу, тэд төрийн террорын золиос болсон байх талтай. 1940-өөд оноос сургуулийн тогтолцоог өргөжүүлэв: 1941 онд Багшийн сургуулийг байгуулж, 1942 он гэхэд 31000 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд хамрагдаад байжээ. 1950 оны байдлаар хүн амын 62.4 хувь нь бичиг үсэгтэй болсон гэдэг нь юуны өмнө хүүхдүүд байсан биз ээ. Сурагчид Зөвлөлтийн жишгээр зохиож, кирилл үсгээр бичсэн сурах бичгээр хичээллэж байв. Шинэ тутам боловсрол нь

Зөвлөлтийн буюу үзэл суртлын хэв шинжтэй ч Европ боловсрол байсан юм, өөрөөр хэлбэл монголчуудын сэтгэхүй европжих үйл явц эхэлсэн байлаа ... Нийгэмшлийн үйл явц өөрчлөгдөв. Хоёр дахь нийгэмшлийн үйл явц өргөжин тэлэв. Гол оролцогч болох хүүхдүүд буюу монгол залуучууд үүсэл хөгжлийнхөө шатанд буй боловсролын тогтолцоонд татагдан орсны үндсэн дээр нийгмийн хэд хэдэн бүлгийн гишүүн болж, эцэг эхийнх нь үеийг бодвол анх удаа нийгмийн янз бүрийн сонголт бий болсон шинэ тутам нийгэмд өсч өндийсөн билээ. Бусдаас ялгарах өвөрмөц мөн чанар нь ихэд алдагдсан, гэхдээ түүхийн хэмжүүрээр хэмжээд үзэх юм бол шинээр олж авсан онцлог чанар нь бүр ч их ашиг тус үзүүлээгүй гэж үү?!

“Энэ илтгэгч юу гэх гээд байна вэ?” гэж зарим хүн хэлэх байх. Зөвлөлтийн террорын зарим үр дагавар ... гэж арай хэлэх гээгүй байгаа?

Тэгвэл илтгэгч юу хэлээд байна вэ? Тэр Иоханн Вольфганг фон Гётегийн “Фауст”-тай ижил бодолтой агаад тэнд түүний нэн эрхэмлэн үздэг Мефистофель өөрийнхөө тухайд ийн хэлсэн буй:

*Би бээр үргэлжид мууг хүсэхдээ үргэлжид сайныг бүтээгч тэр  
хүчний нэгээхэн хэсэг билээ ...*

*Би бээр үргэлжид үгүйсгэгч сүнс билээ! үүссэн бүхэн устаж үгүй  
болдог хойно тэгэхээс яахав.<sup>6</sup>*

6 Johann Wolfgang Goethe, Faust. Eine Tragödie. Erster Teil, Leipzig 1971, 45 дахь тал.

## МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ ЦЭРГИЙН БАЙШИНТЫН 7 ДУГААР МОРЫТ ДИВИЗЭЭС УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДСЭН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН СУДАЛГАА



*Н.Хүдэрбат  
Магистр, хошууч  
Батлан хамгаалахын эрдэм  
шинжилгээний хүрээлэнгийн Цэргийн  
түүх судлалын төв*

1930 оны дунд үеэс Монголын дорнод хязгаарт цэрэг улс төрийн байдал хүндэрсэнтэй холбогдуулан улс орон, цэрэг армийг дайны байдалд шилжүүлж эхэлсэн үетэй давхцан Монголын нийгмийг хамарсан улс төрийн хэлмэгдүүлэлт явагдаж эхэлсэн билээ.

Энэхүү их хэлмэгдүүлэлтэд МАХЦ-ийн анги, салбарын жагсаалын цэргээс салаа, суман, дивизионы дарга, штабын дарга, дивизийн бэлтгэлийн дарга болон Бүх цэргийн жанжны орлогч, цэргийн дээд цолтой маршал хүртэл бүх л албан тушаалтан, цэргийн алба хаагчид өртсөн юм.

Ийнхүү улс төрийн хилс хэрэгт өртөж, амь насаараа хохирсон, болон бие мах бодь, сэтгэл санааны асар их дарамт шахалт амссан цэргийн алба хаагчдын төлөөлөл болгон Байшинтын 7 дугаар морьт дивизийн бие бүрэлдэхүүний талаар хийсэн судалгааны ажлаа нэгтгэн та бүхэнд хүргэж байна.

Юуны өмнө тус дивизийн түүхийн талаар цухас дурдах нь зүйтэй болов уу. 1930 оны эхээр Монгол Улсын Зэвсэгт Хүчин шинэ бүтэц зохион байгуулалтад шилжсэн бөгөөд ЦЯЯ-ны сайд бөгөөд Бүх цэргийн жанжны 1932 оны 3 дугаар сарын 12-ны 41 тоот тушаалаар тус бүр 2 морьт дивиз бүхий морьт корпусуудыг байгуулсан бөгөөд 2 дугаар морьт корпусын бүрэлдэхүүнд нутгийн 3 дугаар хороог 7 дугаар морьт дивиз болгон өөрчлөн 1932 онд Хэнтий аймгийн төвд байгуулсан юм.



1936 оны эхээр Монгол улсын дорнод хил хязгаарт дайны аюул занал бодит байдлаар нүүрлэсэнтэй холбогдуулан БНМАУ-ын ЦЯЯ-ны сайд бөгөөд Бүх цэргийн жанжны гаргасан н/17 тоот тушаалаар 7 дугаар морьт дивиз одоогийн Сүхбаатар аймгийн Баяндэлгэр (Хонгор) сумын нутаг **Байшинт сүм**<sup>1</sup> хэмээх газар шилжин, Өргөө гурван толгой хэмээх газар байрласан бөгөөд 1945 оны Чөлөөлөх дайнд оролцож үүргээ амжилттай гүйцэтгэсэн билээ.

Гэвч Монголын түүхэнд хар толбо болон үлдсэн улс төрийн хилс хэрэгт холбогдсон тус дивизийн удирдах албан тушаалд ажиллаж байгаад дэвшин томилогдсон ба тухайн үед дивиз хорооны удирдах ба дунд тушаалын цэргийн алба хаагчдын судалгааг нэгтгэн үзүүлэв.

## Хүснэгт 1

## Дивизийн удирдах бүрэлдэхүүнээс

## Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн дарга нарын овог нэр

№	Тухайн үед хашиж байсан албан тушаал	Овог нэр	Үндсэн захиргаа
1	Жанжин штабын дарга	Цэрэн Жамсрангийн	Хөвсгөл. Рашаант
2	Улс төрийн хэлтсийн зохиолын хэлтсийн дарга	Сүрэнхорлоо Доржийн	Улаанбаатар
3	Бүх цэргийн намын комиссын даргаар	Жамсран Аюушийн	Ховд. Манхан
4	Бүх цэргийн бэлтгэлийн газрын дарга	Балжинням Гонгорын	Завхан. Шарга
5	Мал эмнэлгийн газрын дарга	Жадамба Шаравын	Төв. Галбадрах
6	Корпусын шүүхийн дарга	Лхаван Дамдины	Архангай. Гурванбулаг
7	Корпусын комиссар	О.Шагдарсүрэн (2 мк)	Сэлэнгэ
8	Дивизийн дарга	Гончигшарав Банзрагчийн (1 мд)	Дорнод. Цагаан овоо
9		Даваажаргал Жамсрангийн	Төв. Эрдэнэ
10		Цэрэн Дамбын	Завхан
11		Цэрэндагва Данзангийн (8 мд)	Улаанбаатар
12		Цэдэв Аюушийн (8 мд)	Булган. Орхонтуул
13	Дивизийн комиссар	Дашням Хайдавын	Дорнод. Баяндун
14		Лувсанбаяр Банзрагчийн (6 мд)	Хэнтий. Жаргалтхаан
15	Дивизийн намын комиссын дарга	Дашням Өвгөний	Хэнтий. Галшар
16	Штабын дарга	Жанцан Минжүүрийн	Төв. Эрдэнэдалай
17	Дивизийн штабын даргын орлогч	Дамдинжав Цэндийн	Хэнтий. Мандал

<sup>1</sup> Анх 1741 онд гэлэн Данзанренчин хэмээгч Байшинт хэмээх сүмийг байгуулсан бөгөөд Дүйнхэр, Жүд, Цаннид хэмээх 3 дасантай, гэлэн гэцэл 20, сул хувраг 800, хурлын багш гавж 1хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж байжээ.

18	Дивизийн бэлтгэлийн дарга	Баасан Лувсангийн	Архангай. Гурванбулаг
19	Дивизийн бэлтгэлийн даргын туслах	Юндэн Базарын	Хэнтий. Лхүмбэ
20	Хорооны дарга	Дагва (Даваа) Лувсангийн	Өвөрхангай. Эрдэнэцогт
21		Чулуун Равжирын	Төв. Лүн
22	Дивизионы дарга	Ваанчиг ванчиг Жамсрангийн	Хөвсгөл. Цагаан-Уул
23	Сүхбаатарын сургуулийн комиссар	Гэндэн Жамсрангийн	Дорнод. Жаргалант
24	Моторт хорооны дарга	Гончигжав Молом (Ролом)-ын	Завхан.Нөмрөг
25	Хорооны комиссар	Самданжамц Бадамын	Дорнод. Баян-Уул
26	Улс төрийн удирдагч	Чүтэм Дэндэвийн	Хөвсгөл
27	Дивизийн клубын дарга	Лувсандорж Цэрэнгийн	Архангай. Булган
28		Дамдинжав Аюурын	Хэнтий. Биндэр
29	Сумангийн улс төрийн удирдагч	Дэлгэр Аюушийн	Хэнтий. Биндэр
30	Батарейн дарга	Дэндэв Баясгалангийн	Төв. Батширээт
31	Удирдах салааны дарга	Цэрэнжамц Шаравын	Хэнтий. Уулбаян
32	Салааны туслах	Цэдэнжав Чимэдийн	Хэнтий. Балж
33	Тасгийн дарга	Далхсүрэн Гүрийн	Хэнтий. Балж
34		Дондол (Донтол) Навааны	Хэнтий. Биндэр
35	Их эмч	Тойвгоо Довдонов (Довдонгийн )-ын	Сэлэнгэ
36	Холбооны сумангийн даргаар	Шагдар Мархайн	Хэнтий дадал
37	Холбооны сумангийн багш	Жалсангийн Бавуу	Хэнтий. Дадал
38	Мал эмнэлгийн санитар	Дондог Дугарын	Дорнод. Баяндун
39	Сурагч	Бавуу Батжаргалын ЗХУ-ын В.И.Ленины нэрэмжит улс төрийн академид	Ховд. Чандмань
40		Дашпунцаг Цэнд (Ханд)-ийн ЗХУ-ын Москва хотын цэргийн дээд сургуульд	Архангай. Цагаан гол
41		Цэвэгжав Авзайн Ленинградын хүн эмнэлгийн дээд сургуульд	Сэлэнгэ. Шаамар
42		Уламбаяр Будрагчаагийн дивизийн бага даргын сургуульд	Завхан. Сонгино
<b>Бүгд 42</b>			

Тус дивизэд давхар албан тушаалтай ба жагсаалын цэргээр үүрэг гүйцэтгэж байгаад хэлмэгдсэн цэргийн алба хаагчдын судалгааг нэгтгэн үзүүлэв.

## Хүснэгт 2

**Хугацаат цэргийн алба хаагчдаас  
Улс төрийн хэлмэгдэлтэнд өртсөн цэргүүдийн овог нэр**

№	Тухайн үед хашиж байсан албан тушаал	Овог нэр	Үндсэн захиргаа
1	Цэрэг-хэрэг хөтлөгч	Цэрэндаш Сэвжидийн	Хэнтий. Баян
2		Чойдор Ванчигийн	Хэнтий. Биндэр
3	Цэрэг-эх зохиогч	Дамдинжав Цэндийн	Хэнтий. Баян
4		Содов Билэгт (Билэг)-ийн	Хэнтий. Баянхутаг
5	Цэрэг-түгээгч	Мятав Ишийн	Хэнтий. Баян
6		Рэнцэнням Дондогийн	Хэнтий. Дадал
7		Сангарал Самбуугийн	Хэнтий. Балж
8		Цэрэндорж Эрдэнийн	Хэнтий. Баян
9		Жигмэд Боролзойн	Хэнтий. Дархан
10	Цэрэг-хэлмэрч	Доржханд Балдангийн	Хэнтий. Биндэр
11		Сампилдорж Сангаагийн	Хэнтий. Баян
12	Цэрэг- бичээч	Бадам Цэрэнгийн	Хэнтий. Дадал
13		Бадам Батмөнхийн	Хэнтий. Дадал
14		Бат Рэнцэнгийн	Хэнтий. Дадал
15		Буджав Пунцагийн	Хэнтий. Ддадал
16		Гарамдаш Готовын	Хэнтий. Биндэр
17		Даваа Бандийн	Хэнтий. Биндэр
18		Долгоржав Зэвэгийн	Хэнтий. Балж
19		Дорж Рэнцэнгийн	Хэнтий
20		Зарав Нямын	Хэнтий. Балж
21		Цэрэг- жолооч	Дугаржав Онгойн
22	Чойндон Эрдэнийн		Өвөрхангай, Баянзүрх

23	Жагсаалын цэрэг	Ампил Нямын	Хэнтий. Биндэр	
24		Батцэрэн Жамьянгийн	Хэнтий. Биндэр	
25		Бизьяа Шагдарын	Хэнтий. Биндэр	
26		Буяндэлгэр Балдангийн	Хэнтий. Мандал	
27		Гунгаа Гомбын	Дорнод	
28		Дамба Дагвын	Хэнтий. Биндэр	
29		Дамбаравжаа Ванчигийн	Хэнтий	
30		Дамбийням Дэмбэрэлийн	Хэнтий. Балж	
31		Дамдин Даваагийн	Хэнтий. Дадал	
32		Дашдамба Дамдинжавын	Хэнтий. Өлзий	
33		Дашцэрэн (Дашрэнцэн) Лхам (Лхамхүү)-ын	Хэнтий. Идэрмэг	
34		Дамдхаа (Дамдинжав) Чойвооны	Дорнод. Баяндун	
35		Данзаням Ишийн	Хэнтий. Балж	
36		Даш Базарын	Хэнтий. Дадал	
37		Дондов Гомбын	Хэнтий. Биндэр	
38		Дондог (Дондов) Цэдэнгийн	Хэнтий. Биндэр	
39		Дондог Раднаагийн	Хэнтий. Дадал	
40		Жалсан Эрдэнийн	Хэнтий. Биндэр	
41		Жамц Сангаагийн	Хэнтий	
42		Лувсан Дугарын	Хэнтий. Балж	
43		Лувсан Цэрэнпилийн	Хэнтий. Балж	
44		Лувсанбазар Доржийн.	Хэнтий. Дадал	
45		Лувсанцэрэн Шагдарын	Хэнтий. Мандал	
46		Лувсанчүлтэм Жанцангийн	Хэнтий. Мөрөн	
47		Мөнхөө Дарьзавын	Хэнтий. Биндэр	
48		Мөнхөө Раднаагийн	Хэнтий	
49		Пүрэв Баасанхүүгийн	Хэнтий. Мөрөн	
50		Пунцагдаш Мөнхийн	Хэнтий. Дадал.	
51		Тамжав Дамдиндоржийн	Хэнтий	
52		Равдандорж Ачитын.	Хэнтий. Баян	
53		Рэнцэн Гарамжавын	Хэнтий	
54		Самбуу Дашийн	Архангай. Хотонт	
55		Чимэг-Очир Дамдингийн	Хэнтий. Биндэр	
56		Чойнбол Балдангийн	Хэнтий. Дархан	
57		Чойжинням Балдангийн	Хэнтий. Баян	
58		Чүлтэм Дэндэвийн	Хэнтий	
59		Шагдарсүрэн Билгээ (Билэг)	Хэнтий. Өмнөдэлгэр	
60		Ядамсүрэн Батын	Хэнтий. Өлзийт	
		<b>Бүгд 60</b>		

## Хүснэгт 3

**7 дугаар морьт дивизээс улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэж хохирсон  
нийт цэргийн алба хаагчдын нутаг дэвсгэрийн харьяалал**

№	Үндсэн захиргаа	Хот, сум	Цэргийн алба хаагчдын тоо
1	Улаанбаатар хот	Улаанбаатар	2
2	Төв аймаг	Галбадрах 1, Эрдэнэ 1, Эрдэнэдалай 1, Лүн 1, Батширээт 1	5
3	Сэлэнгэ аймаг	Шаамар 1, сум тодорхой бус 2,	3
4	Ховд аймаг	Манхан 1, Чандмань 1, сум тодорхой бус 2,	2
5	Хөвсгөл аймаг	Рашаант 1, Цагаан уул 1, сум тодорхой бус 1,	3
6	Завхан аймаг	Шарга 1, Нөмрөг 1, Сонгино 1, 1 сум тодорхой бус	4
7	Архангай аймаг	Гурванбулаг 2, Булган 1, Цагаан 1, Хотонт 1	5
8	Өвөрхангай аймаг	Эрдэнэцогт 1, Баянзүрх 1	2
9	Булган аймаг	Орхонтуул	1
10	Хэнтий аймаг	Жаргалтхаан 1, Галшар 1, Идэрмэг 1, Баянхутаг 1, Лхүмбэ 1, Уулбаян 1, Өлзийт 1, Өлзий 1, Өмнөдэлгэр 1, Дархан 2, Мөрөн 2, Мандал 2, сум тодорхой бус 6, Балж 9, Баян 9, дадал 12, Биндэр 16,	67
11	Дорнод аймаг	Баяндун 4, Жаргалант 1, Цагаан-Овоо 1, сум тодорхой бус 1	7
12	Өмнөговь аймаг	Дэлгэрхангай	1
<b>Нийт хүний тоо 102</b>			

**Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн цэргийн алба хаагчдыг  
насны байдлаар нь ангилвал**

- 20-30 нас. Удирдах албан тушаалын 16 цэргийн алба хаагч
- 30-45 нас. Удирдах албан тушаалын 26 цэргийн алба хаагч
- 19-25 нас. Гүйцэтгэх албан тушаалын 41 цэргийн алба хаагч
- 25-37 нас Гүйцэтгэх албан тушаалын 19 цэргийн алба хаагч

**Дивизийн цэргийн алба хаагчдыг хэрэгт холбогдсон  
байдлаар нь ангилвал**

- Ж.Лхүмбий хэрэгт дунд албан тушаалын 10, давхар албан тушаал хашдаг цэрэг 18, жагсаалын цэрэг 34
- Дэслэгч Г.Дамбын хэрэгт удирдах албан тушаалын цэргийн алба хаагч 1

- Японы тагнуулын хэрэгт дунд албан тушаалын 1, давхар албан тушаалтай 1, жагсаалын цэрэг 1
- Цуу үг тараасан хэрэгт удирдах албан тушаалтан 1 (сурагч), дунд албан тушаалын 1 (сурагч)
- Гэндэн, Дэмидийн хэрэгт удирдах тушаалын 22 дунд тушаалын 2, давхар албан тушаалын 1, цэрэг 1 (сурагч)
- Хувьсгалын эсэргүү хэрэгт удирдах албан тушаалтан 1, дунд албан тушаалын 2, цэрэг 1 (сурагч)

### 3 жилийн хорих

№	Тухайн үед хашиж байсан албан тушаал	Овог нэр	Тайлбар
1	Сүхбаатарын сургуулийн комиссар	Гэндэн Жамсрангийн	Дорнод. Жаргалант. Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. 1940.11.16-ны өдрийн тогтоолоор суллагдсан.
<b>Бүгд 1</b>			

### 5 жилийн хорих

№	Тухайн үед хашиж байсан албан тушаал	Овог нэр	Тайлбар
1	Корпусын шүүхийн дарга	Лхаван Дамдины	Архангай. Гурванбулаг. Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. 1939.12.23
2	Дивизийн штабын даргын туслах	Дамдинжав Цэндийн	Хэнтий. Мандал. Японы эсэргүү тагнуулын хэрэгт холбогдсон. 1933.11.03
3	Дивизийн бэлтгэлийн даргын туслах	Юндэн Базарын	Хэнтий. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.3
4	Дивизийн клубын дарга	Лувсандорж Цэрэнгийн	Архангай. Булган. Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. 1939.7.20
5	Батарейн дарга	Дэндэв Баясгалангийн	Төв. Батширээт. Хувьсгалын эсэргүү хэрэгт холбогдсон. 1939.11.10
6	Удирдах салааны дарга	Цэрэнжамц Шаравын	Хэнтий. Ууулбаян. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.3
7	Салааны туслах	Цэдэнжав Чимэдийн	Хэнтий. Балж. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.3
8	Тасгийн дарга	Далхсүрэн Гүрийн	Хэнтий. Балж. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.3
9		Дондол (Донтол) Навааны	Хэнтий. Биндэр. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.3 5
10	Цэрэг-хэрэг хөтөлгөч	Цэрэндаш Сэвжидийн	Хэнтий. Баян. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
11	Цэрэг-түгээгч	Жигмэд Боролзойн	Хэнтий дархан Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03



12	Цэрэг-хэлмэрч	Доржханд Балдангийн	Хэнтий. Биндэр. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
13	Цэрэг-бичээч	Бадам Батмөнхийн	Хэнтий. Дадал. Японы эсэргүү тагнуулын бүлгэмийн гишүүн хэмээн баригдсан. 1933.11.3
14		Даваа Бандийн	Хэнтий. Биндэр. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
15		Долгоржав Зэвэгийн	Хэнтий. Балж. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
16		Зарав Нямын	Хэнтий. Балж Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
17	Жагсаалын цэрэг	Батцэрэн Жамьянгийн	Хэнтий. Биндэр. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
18		Бизьяа Шагдарын	Хэнтий. Биндэр. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
19		Буяндэлгэр Балдангийн	Хэнтий. Мандал. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
20		Гунгаа Гомбын	Дорнод. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
21		Дамба Дагвын	Хэнтий. Биндэр. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
22		Дамбаравжаа Ванчигийн	Хэнтий. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
23		Дамбийням Дэмбэрэлийн	Хэнтий. Балж. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
24		Дамдин Даваагийн	Хэнтий. Дадал. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
25		Дашдамба Дамдинжавын	Хэнтий. Өлзий. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
26		Дашцэрэн (Дашрэнцэн) Лхам (Лхамхүү)-ын	Хэнтий. Идэрмэг. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
27		Данзанням Ишийн	Хэнтий. Балж. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
28		Даш Базарын	Хэнтий. Дадал. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
29		Дондог (Дондов) Цэдэнгийн	Хэнтий. Биндэр. Японы эсэргүү тагнуулын бүлгэмийн гишүүнээр холбогдсон. 1933.11.03
30		Жалсан Эрдэнийн	Хэнтий. Биндэр. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
31		Лувсан Дугарын	Хэнтий. Балж. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
32		Лувсан Цэрэнпилийн	Хэнтий. Балж. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
33	Лувсанбазар Доржийн	Хэнтий. Дадал. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03	
34	Лувсанцэрэн Шагдарын	Хэнтий. Мандал. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03	
35	Лувсанчүлтэм Жанцангийн	Хэнтий. Мөрөн. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03	
36	Мөнхөө Дарьзавын	Хэнтий. Биндэр. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03	

37	Жагсаалын цэрэг	Мөнхөө Раднаагийн	Хэнтий, Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
38		Пүрэв Баасанхүүгийн	Хэнтий, Мөрөн, Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
39		Пунцагдаш Мөнхийн	Хэнтий дадал, Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
40		Тамжав Дамдиндоржийн	Хэнтий Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
41		Самбуу Дашийн	Архангай, Хотонт Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
42		Шагдарсүрэн Билгээ (Билэг)	Хэнтий, Өмнөдэлгэр, Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
43		Ядамсүрэн Батын	Хэнтий, Өлзийт, Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
Бүгд 43			

## 6 жилийн хорих

№	Тухайн үед хашиж байсан албан тушаал	Овог нэр	Тайлбар
1	Бүх цэргийн бэлтгэлийн газрын дарга	Балжинням Гонгорын	Завхан, Шарга, Хувьсгалын эсэргүү хэрэгт холбогдсон. 1940.2.5
2	Дивизийн комиссар	Лувсанбаяр Банзрагчийн (6 мд)	Хэнтий, Жаргалтхаан, Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. 1939 .10.12
3	Улс төрийн удирдагч	Чүлтэм Дэндэвийн	Хөвсгөл, Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
4	Холбооны сумангийн даргаар	Шагдар Мархайн	Хэнтий, Дадал, Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
5	Цэрэг-эх зохиогч	Дамдинжав Цэндийн	Хэнтий, Баян, Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.3
6	Жагсаалын цэрэг	Ампил Нямын	Хэнтий, Биндэр, Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
7		Дамдхаа (Дамдинжав) Чойвооны	Дорнод, Баяндун, 5 мд дотор байгуулагдсан хувьсгалын эсэргүү хэрэгт холбогдсон. 1934 3.5
8		Жамц Сангаагийн	Хэнтий, Хувьсгалын эсэргүү хэрэгт холбогдсон. 1933.11.03
9		Чимэг-Очир Дамдингийн	Хэнтий, Биндэр, Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
10		Чойнбол Балдангийн	Хэнтий, Дархан, Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
11		Чойжинням Балдангийн	Хэнтий, Баян, Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
12	Чүлтэм Дэндэвийн	Хэнтий Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03	
Бүгд 12			

## 7 жилийн хорих

№	Тухайн үед хашиж байсан албан тушаал	Овог нэр	Тайлбар
1	Улс төрийн хэлтсийн зохиолын хэлтсийн дарга	Сүрэнхорлоо Доржийн	Улаанбаатар. Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. 3 жил сонгуулийн эрхийг нь хассан. 1946 оны 6 сард өршөөлөөр суллагдсан.
<b>Бүгд 1</b>			

## 8 жилийн хорих

№	Тухайн үед хашиж байсан албан тушаал	Овог нэр	Тайлбар
1	Бүх цэргийн намын комиссын даргаар	<b>Жамсран Аюушийн</b>	<b>Ховд. Манхан. Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. 1940.2.5</b>
2	Хорооны комиссар	<b>Самданжамц Бадамын</b>	<b>Дорнод. Баян-Уул Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. 1939.7.20</b>
3	Сурагч	<b>Цэвэгжав Авзайн Ленинградын хүн эмнэлгийн дээд сургуульд</b>	<b>Сэлэнгэ. Шаамар. ЗХУ-ын эсрэг хорт цуурхал тараасан. 1942.12.30</b>
4	<b>Цэрэг түгээгч</b>	<b>Сангарал Самбуугийн</b>	<b>Хэнтий. Балж. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03</b>
5	<b>Цэрэг-бичээч</b>	<b>Бат Рэнцэнгийн</b>	<b>Хэнтий. Дадал. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03</b>
<b>Бүгд 5</b>			

## 10 жилийн хорих

№	Тухайн үед хашиж байсан албан тушаал	Овог нэр	Тайлбар
1	Дивизийн клубын дарга	Дамдинжав Аюурын	<b>Хэнтий. Биндэр. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.3</b>
2	Холбооны сумангийн багш	Жалсангийн Бавуу	<b>Хэнтийн. Дадал. Японы эсэргүү тагнуулын бүлгэмийн гишүүн гэсэн хэрэгт холбогдсон. 1933.11.03</b>
3	Мал эмнэлгийн санитар	Дондог Дугарын	<b>Дорнод. Баяндун. 1934.3.5</b>
4	Сурагч	Бавуу Батжаргалын ЗХУ-ын В.И.Ленины нэрэмжит улс төрийн академид	<b>Ховд. Чандмань. Зөвлөлтийн эсрэг цуурхал тараасан. 1948.11.5</b>
5	Цэрэг-түгээгч	Цэрэндорж Эрдэнийн	<b>Хэнтий Баян. Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. 1938.04.22</b>

6	Цэрэг-жолооч	Дугаржав Онгойн	Өмнөговь. Дэлгэрхангай. Эсэргүү цуурхал тараасан хэрэгт холбогдсон. 1938.06.26
7		Чойндон Эрдэнийн	Өвөрхангай. Баянзүрх. Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. 1938.3.4
8	Жагсаалын цэрэг	Дондов Гомбын	Хэнтий. Биндэр. Эсэргүү хэрэгт холбогдсон. 1938.03.12
9		Дондог Раднаагийн	<b>Хэнтий. Дадал. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03</b>
10		Равдандорж Ачитын	Хэнтий. Баян. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
Бүгд 10			

### Шоронд нас барсан цэргийн алба хаагчдын овог нэр

№	Алба хааж байсан албан тушаал	Овог нэр	Тайлбар
1	Цэрэг-бичээч	Гарамдаш Готовын	Хэнтий. Биндэр Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 10 жилийн хорих ялаар шийтгүүлсэн. ЗХУ-ын Дорнод Сибирийн улс төрийн нэгдсэн газрын бүрэн эрхт комиссын шийдвэрээр 5 жилийн хорих ялаар өөрчилсөн. 1934.5.4 Печерын хорих газар нас барсан. 1933.11.03
2	Цэрэг- түгээгч	Рэнцэнням Дондогийн	Хэнтий. Дадал. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. 8 жилийн хорих ялаар шийтгэгдсэн. ЗХУ-ын 10 жил болгосон. ЗХУ-ын Дорнод Сибирийн улс төрийн нэгдсэн газрын бүрэн эрхт комиссын шийдвэрээр 10 жилийн хорих ялаар өөрчилсөн. Печерын хорих газар нас барсан. 1933.11.03
3		Мятав Ишийн	Хэнтий. Баян. Ж.Лхүмбийн хэрэгт холбогдсон. Мөрдөн байцаалтын явцад шоронд нас барсан. 1933.11.03
4	Цэрэг-бичээч	Бадам Цэрэнгийн	Хэнтий. Дадал. Эсэргүү хэрэгт холбогдсон. Мөрдөн байцаалтын явцад өвчнөөр нас барсан. 1933.11.03
Бүгд 4			

### Ялын дээд хэмжээ авсан (цаазын ял) авсан цэргийн алба хаагчдын овог нэр

№	Тухайн үед хашиж байсан албан тушаал	Овог нэр	Тайлбар
1	Жанжин штабын дарга	Цэрэн Жамсрангийн	Хөвсгөл. Рашаант. Дэслэгч жанжин Г.Дамбын эсэргүү хэрэгт холбогдсон. Дивиз командлан захирагч цолтой. 1941.10.08
2	Мал эмнэлгийн газрын дарга	Жадамба Шаравын	Төв. Галбадрах. Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. 1937.10.25
3	Корпусын комиссар	Шагдарсүрэн Очирын (2 мк)	Сэлэнгэ. Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. Бригадын комиссар цолтой. 1940.2.7

4	Дивизийн дарга	Гончигшарав Банзрагчийн (1 мд)	Дорнод. Цагаан овоо. Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. Дивиз командлан захирагч цолтой. 1937.10.25
5		Даваажаргал Жамсрангийн	Төв. Эрдэнэ. Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. Бригад командлан захирагч цолтой. 1937.10.25
6		Цэрэн Дамбын	Завхан. Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. Хурандаа цолтой. 1938.4.15
7		Цэрэндагва Данзангийн (8 мд)	Улаанбаатар. Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. Бригад командлан захирагч цолтой. 1937.10.25
8		Цэдэв Аюушийн (8 мд)	Булган. Орхонтуул. Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. 10 жил болгож өөрчилсөн. Бригад командлан захирагч цолтой. 1939.10.27
9	Дивизийн комиссар	Дашням Хайдавын	Дорнод. Баяндун. Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. Хорооны комиссар цолтой. 1938.04.15
10	Дивизийн намын комиссын дарга	Дашням Өвгөний	Хэнтий. Галшар. Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. Хорооны комиссар цолтой. 1938.04.15
11	Дивизийн штабын дарга	Жанцан Минжүүрийн	Төв. Эрдэнэдалай. Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. Хурандаа цолтой. 1938.03.25
12	Дивизийн бэлтгэлийн дарга	Баасан Лувсангийн	Архангай. Гурванбулаг. Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. 1938.3.25
13	Дивизийн их эмч	Тойвгоо Довдонов (Довдонгийн)-ын	Улаанбаатар. Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. 1938.01.28 өдөр
14	Хорооны дарга	Дагва (Даваа) Лувсангийн	Өвөрхангай. Эрдэнэцогт. Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. Хурандаа цолтой. 1938.4.8
15		Чулуун Равжирын	Төв. Лүн. Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. 1915.1940.12.18
16	Дивизионы дарга	Ваанчиг (Ванчиг) Жамсрангийн	Хөвсгөл. Цагаан-Уул. Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. 1938.4.15
17	Моторт хорооны дарга	Гончигжав Молом (Ролом)-ын	Завхан нөмрөг. Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. Хурандаа цолтой.
18	Сумангийн улс төрийн удирдагч	Дэлгэр Аюушийн	Хэнтий. Биндэр. Гэндэн, Дэмидийн хэрэгт холбогдсон. 1933.11.3
19	Сурагч	Дашпунцаг Цэнд (Ханд)-ийн ЗХУ-ын Москва хотын цэргийн дээд сургуульд	Архангай. Цагаан гол. Гэндэн, Дэмид хэрэгт холбогдсон. Бригад командлан захирагч цолтой. 1937.12.23
20		Уламбаяр Бүдрагчаагийн дивизийн бага даргын сургуульд	Завхан. Сонгино. Амь өршөөгдсөн. 10 жил болсон. 1938.5.12
21	Цэрэг-хэрэг хөтлөгч	Чойдор Ванчигийн	Хэнтий. Биндэр. Ж.Лүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03

22	Цэрэг-хэлмэрч	Сампилдорж Сангаагийн	Хэнтий. Баян Ж.Лүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
23	Цэрэг-бичээч	Буджав Пунцагийн	Хэнтий. Дадал Ж.Лүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
24		Дорж Рэнцэнгийн	Хэнтий. Ж.Лүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
25	Цэрэг-эх зохиогч	Содов Билэгт (Билэг)-ийн	Хэнтий. Баянхутаг. Ж.Лүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
26	Цэрэг	Рэнцэн Гарамжавын	Хэнтий. Баян. Ж.Лүмбийн хэрэгт холбогдсон. 1933.11.03
Бүгд 26			

Ялын дээд хэмжээ авсан цэргийн алба хаагчдыг цолных нь эрэмбээр ангилвал: Дивиз командлан захирагч 2, Бригад командлан захирагч 4, Дивизийг мэдэгч 1, Бригадын шүүгч 1, Хурандаа 3, Дивизийн комиссар 1, Бригадын комиссар 3, Цол нь тодорхой бус 2, Хорооны комиссар 2, Бага дарга 1, Цэрэг хэрэг хөтлөгч 1, Цэрэг хэлмэрч 1, Цэрэг бичээч 2, Цэрэг эх зохиогч 1, Жагсаалын цэрэг 1 байв.

1936-1939 оны хооронд МАХЦ-ийн анги, салбарууд (зөвхөн 5, 6, 7, 8 дугаар морьт дивиз)-аас өвчнөөр нас барсан цэргийн алба хаагчдын тоон судалгаа

Он	1936 он				1937 он				1938 он				1939 он				Нэгдсэн дүн							
Дивизүүд	Нас барсан хүний тоо		Сүрьеэ, цусан хатгалгаар		Гэдэсний халдвартаар		Бусад өвчнөөр		Нас барсан хүний тоо		Сүрьеэ, цусан хатгалгаар		Гэдэсний халдвартаар		Бусад өвчнөөр		Нас барсан хүний тоо		Сүрьеэ, цусан хатгалгаар		Гэдэсний халдвартаар		Бусад өвчнөөр	
	5 мд	64	34	3	27	110	63	6	41	106	55	-	51					280	152	9	119			
6 мд	55	26	6	23	50	42	3	5	133	75	14	44					238	143	23	72				
7 мд	85	37	14	34	81	52	3	26	14	10	-	4					180	99	17	64				
8 мд	46	30	2	14	126	39		87	75	48	7	20					247	117	9	121				
Бүгд	250	127	25	98	367	196	12	159	228	188	21	119					945	211	58	379				
<b>7 дугаар морьт дивизээс өвчнөөр нас барсан нийт цэргийн алба хаагчдын тоо 720</b>																								



## ДУГНЭЛТ

1. Монголын нийгмийг хамарсан улс төрийн зохиомол хэрэг болох 1933 оны Ж.Лхүмбийн хэрэгт Монголын зүүн хязгаарт Хэнтий аймгийн Өндөрхаанд байрлаж байсан хожмоо Байшинтын хэмээн алдаршсан домог түүхтэй 7 дугаар морьт дивизийн бие бүрэлдэхүүнээс мэдлэг боловсролын хувьд боломжийн давхар албан тушаал хашиж байсан цэргийн алба хаагчдыг үндэс угсаагаар нь ялгаварлан гадуурхан хэлмэгдүүлж байсан нь судалгааны явцад харагдаж байна.

2. 1938 онд тус дивизийн удирдах албан тушаал (цэргийн дээд албан)-ын өндөр мэдлэг боловсролтой цэргийн алба хаагчдыг Гэндэн, Дэмид, Дамбын эсэргүү хэмээх хэрэгт холбогдуулан хуулийн дээд хэмжээ ноогдуулж, шууд гүйцэтгэж байсан нь тухайн үед улс төр, үзэл бодлын зөрчилдөөн туйлдаа хүрсэн, нийгмийн байдал тогтвортой бус хойд хөршийн удирдагчид эрх мэдлийн хүрээгээ тэлж явуулах үүднээс тэдний эсрэг хандсан нөхдийг хавчин гадуурхаж, нухчин дарах үйл ажиллагааг Монголд явуулж байсан нь мэдэгдэж байна.

3. Японы тагнуул, хувьсгалын эсэргүү, цуу үг тараагч хэмээх хэргүүдэд холбогдуулан олон тооны цэргийн алба хаагчдыг хэлмэгдүүлсний үр дүнд МАХЦ-ийн боловсон хүчний асуудал туйлын хүндрэлтэй байдалд орсон.

1939 оны Халхын голын дайн, 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон МАХЦ-ийн даргалах бүрэлдэхүүн байлдааны ажиллагааны туршлагагүй, цэргээ үлгэрлэн дагуулах чадвар муу, сахилга хариуцлагын зөрчлийн асуудал гэх мэт олон сөрөг муу зүйл гарч байсныг дивизийн захирагч дарга, зөвлөхүүдийн илтгэлд дэлгэрэнгүй дурдсан байдаг.

4. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн МАХЦ-ийн анги, салбаруудын цэргийн алба хаагчдын намтар түүхийг анги, салбаруудаар нь нэгтгэн харуулсан товхимол, эмхэтгэл гаргах шаардлагатай хэмээн үзэж байна.

5. Ахмад дайчдын аман ярианаас гадна зарим судлаачид Байшинтын 7 дугаар морьт дивизээс 1936-1939 оны хооронд маш олон цэргийн алба хаагчид нас барсан явдлыг англи давсанд хордсон буюу санаатайгаар хорлогдсон, буудуулж нас барсан гэх мэт олон таамаглал дэвшүүлдэг. Архивын баттай эх сурвалжаар тухайн цаг үед 7 дугаар морьт дивизээс нийт 720 орчим цэргийн алба хаагчид нь өвчнөөр нас барсан гэсэн мэдээлэл байгаа боловч өвчнөөр нас барсан цэргийн алба хаагчдын бүртгэлийг судлан үзэхэд тус дивизээс 180 орчим хүн нас барсан нь тодорхой болсон.

Харин дээр дурдагдсан цэргийн алба хаагчид бүгд өвчнөөр нас барсан нь эргэлзээтэй байгаа юм. Ийм учраас дээрх асуудлуудыг ул суурьтайгаар судлан үзэж, газар орон дээр нь тусгай судалгааны анги томилон явуулж, нарийн судалгаа хийлгэн нэг мөр болгон цэгцлэх цаг нь болсон хэмээн үзэж байна.

### Ном зүй

1. **БХТА.Сх.1 д.1**
2. Банзрагч.Ч Сайнхүү.Б “Монголын хүрээ хийдийн түүх” УБ., 2004.
3. Ганболд .С “Хилсээр хэлмэгдсэн мянган зүрх” УБ., 2002 .
4. Гомбосүрэн.Д “Монгол улсын зэвсэгт хүчний байгуулалтын түүх”, УБ.,1998.
5. МУБХЯ-НЫ ЭШХ “Монгол цэргийн түүхийн товчоо” УБ.,1996. дэд дэвтэр
6. МУЦАУЗБУК “Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгал цагаан ном” УБ., 2010. Боть I, II
7. ЦАУЗБ УҚДУТТХСТ “Улс төрийн хэлмэгдэгсдийн намтрын товчоон” УБ., 2004. Боть.III
8. ЭШБХЭ “Улс төрийн хэлмэгдэлт-цэргийн албан хаагч “ УБ., 2008.

## ХЭЛМЭГДҮҮЛЭЛТ БА ЦАГААТГАЛ



*Д.Цотгбаатар  
Улс төр судлаач, эрх зүйч  
Улс төрийн хэлмэгдэгсдийн холбоо*

### **Нэг. Улс төрийн хэлмэгдүүлэлтийн гарал үүсэл, эх сурвалж, хор уршиг:**

Монгол Улсад улс төрийн хилс хэргээр ард иргэдээ үй олноор нь яргалах, хядах явдал, ер нь хэзээ эхэлсэн юм бэ? Хэн үйлдсэн, хариуцлагыг хэн хүлээх ёстой вэ? Монголчууд бид өөрсдөө. Тэгвэл, түүнийг судлах, бодит үнэнийг олон түмэнд илчлэхийг монголын үе үеийн удирдагчид болгоомжилж ирсэн байдаг. Нэрнээс нь эхлээд харь хэлний орчуулгаар “хэлмэгдүүлэлт” гэдэг зөөллөн ойлгох ойлголтыг олж тавьсан нь сонирхол татдаг. Өмнөх нийгмийн байгууллын үзэл суртлын дарангуйлал, нөлөөгөөр энэ сэдвийг судлах, бодит үнэлгээ өгөх, дүн шинжилгээ хийх нь монгол хүн, хэн бүхэнд халгаатай, шудрагаар хэлэхэд шууд хаалттай байсан.

Монгол Улс ардчилал шударга ёсны зам сонгосон цагаан морин жилээс монгол хүний амны цоож нээгдэж, түмэн зовлон туулж амьд үлдэгсэдийн нуруу тэнийсэн. Харин тэр үеийн эрхтэн дархтанууд гэм буруугаа хүлээж, нүглээ наминчлахгүй л байлаа. Цаг цагаараа байдаггүй, цахилдаг хөхөөрөө байдаггүй. Их эрдэмтэн, гүүш Б.Ренчиний айлдсанаар мөс мөнх биш ажээ. 1996 онд “Цагаан морин жилийн ардчилсан хувьсгал”-ыг санаачлан хэрэгжүүлэгчид төрөө түших боломж анх удаа бурханы авралаар олдсон. Тэдэнд УИХ-ын 76 суудлын 50-ыг сонгогчид өгчээ. Тэгмэгц УИХ-аас жил бүрийн есдүгээр сарын 10-ны өдрийг улс төрийн хилс хэрэгт “Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр” болгон тэмдэглэж байх тогтоол гаргалаа. Үүний дагуу 1996 оны 9 дүгээр сарын 10-нд Сүхбаатарын талбайд болсон “Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр”-ийн анхны цуглаан дээр УИХ-ын дэд дарга, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга Цахиагийн Элбэгдорж Монгол төрийн нэрийн өмнөөс ард түмнээсээ анх удаа уучлал гуйсан билээ.

Түүх сөхвөл, Модун шаньюгаас Хүннү Их Гүрний монгол төрийн байгуулал үүсэн хөгжиж, улс орныхоо хил хязгаарыг “овоо” босгон тогтоохоос эхлээд тухайн үеийн олон аймаг, улс орнуудтай, мөн шинэ үеийн Монгол Улс хойт, урд хөршүүдтэй гоеполитикийн хувьд байнга холбоотой явж ирсэн түүхтэй. Энэ нь наашлаад 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалаар шинэ цаг үеийн Монгол Улсын бие даасан байдал, тусгаар тогтносон улсаа тунхаглахад мөн л урд, хойт улсын нөлөө хэрэгжсээр л байсан. Ийнхүү 1921 оны хувьсгалтай золгосон юм.

Үндэсний эрх ашгаа дээдлэн хамгаалж, Монгол Улс аль нэг улс гүрний хараат бус хөгжлийн зам сонгосон, эрхэмлэсэн хэн бүхнээ, ялангуяа 1921 оны хувьсгалыг эхлүүлсэн долоон хүний зургааг хөнөөснөөр Тухайлбал, Д.Бодоо, Д.Чагдаржав, да лам Пунцагдорж нарын 15 хүнийг өчиггүй буудан хороосноор улс төрийн хэлмэгдүүлэлтийн дарь ханхалж эхэлсэн. Улс төрийн хэлмэгдүүлэлтийг харь орны тулган шахалт, хүч түрэмгийллээс эхтэй гэх боловч, чин үнэндээ монголчууд, монголчуудаа хэлмэгдүүлсэн нь бодит үнэн. “Хэлмэгдүүлэлт” гэдэг өргөн ойлголтыг цогцоор нь авч үзэхгүйгээр хэдэн хүн ямар нэгэн гаднын нөлөөнд өртөн хэлмэгдсэн гэх ташаа мэдээллээр өнөөг хүртэл монголын нийгэм төөрөлдөж ирсэн гаж тогтолцоог өөрчлөх цаг болсныг өнөөдөр хэлэх нь зүйтэй.

Монголчууд үндэсний эрх ашгаас урван тэрслэгчдэд, монгол хүний мөс, чанараа алдан дайсагнагчдад хатуу гэсгээл, цээрлэл үзүүлж, шийтгэл зэмлэл хүлээлгэсээр ирсэн, үүгээрээ хүчирхэг төр, улс байгуулж чадсан түүхтэй улс. Харин гэм, буруугүй иргэдээ хоморголон хөнөөх хар нүгэл зөвхөн “Ардын хувьсгал”-ын жилүүдэд л тохиолджээ. Энэ нь МАХН/МАН хэмээх улс төрийн хүчний далд, хэзээ ч илрэн илчлэгдэхгүй гэж тооцоолсон захиалга, санаачилгаар хэрэгжиж ирсэнийг шудрага хэлэх ёстой. Монголын төрт ёсны 2000 жилийн түүхэнд нэг л удаа тохиолдсон энэ гутамшигт үйл явдал нь “аймшигт цуст яргалал, залхаан цээрлүүлэлт, аллага хядлага буюу бүх нийтийг хамарсан демоцит” байсан гэдэг нь нэгэнт тодорхой болжээ. Гагцхүү Монголын улс төрийн буурал түүхийн нэгэн цаг үед явагдсан энэ яргалал, хядлага нь улс төрийн демоцид байсныг Олон Улсын Шүүхээр тогтоолгох, дэлхий дахинд зарлан мэдээлж түүнээс сэрэмжлүүлэн жигшээхийг цаг үе шаардсаар байгаа. Харамсалтай нь өнөөг хүртэл энэ чухал ажил хийгдэхгүй байгаа нь демоцид үйлдсэн хүчин манай төр засгийн эрх мэдлийг удаан хугацаанд барьж ирсэнтэй шууд холбоотой байна.

Одоо хэлмэгдүүлэлтийн эх үндсийг хэзээ, хаана, ямар эх сурвалжаас, хэн бүрдүүлснийг товч авч үзье. 1924 онд Улсын анхдугаар их хурлаар батлагдсан Үндсэн хуулийг бид дунд сургуулийн хүүхэд байхаасаа эхлэн “Хамгийн ардчилсан, анхдугаар Үндсэн хууль” гэж

бахархан ярьж, тэгэж ойлгож, ойлгуулж ирсэн хүмүүсийн төлөөлөл. Тэгвэл тэс өөр ойлголт түүхийн цаг хугацаанд биднийг сэрээлээ. \_\_\_\_\_

Тодруулбал, 1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 16 цаг 17 минутад батлагдсан тус Үндсэн хуулийн “Монголын жинхэнэ ардын эрх чөлөөг илтгэн тунхаглах нь” гэсэн 1 дүгээр бүлгийн «Гурав. БНМАУ-ын хязгаарын дотор бүхий газар ба уурхай хийгээд ... энэхүү хөрөнгө бүрнээ ардын мэдэлд байвал зохих бөгөөд энэ тухай хувийн өмч байгуулж үл болно.

Дөрөв. Улсын аж ахуй ба эдийн засгийн бодлогыг чухал болгон... гадаадтай харилцах худалдааг улсын онц эрх болгон авах нь ... Ардын Эрхт Засгийг бататгахад чухал нөхцөл болох тул цөм улсаас эрхэлбэл зохино.» гэжээ. Мөн хуулийн “Иргэний сонгох, сонгогдох эрхийн тухай” заасан 4 дүгээр бүлгийн «35 дугаар зүйл. Аливаа хурлын төлөөлөгчдийг сонгох ба мөн төлөөлөгчдөд сонгогдох эрхгүй хүмүүс нь:

Нэг. Ямагт ашгийг эрмэлзэх, бусдыг зарж амьдрагчид

Хоёр. Ямагт бусдыг хөлслөн зарах ба хөрөнгө орлого зэргийн үржлээр амьдрагч жинхэнэ худалдааны ба мөнгө хүүлэгчид

Гурав. Урьдын ван, гүн ба хутагт хувилгаад, жич орон хийдэд үргэлж суух санваартан лам нар» гэж ангилжээ. Мөн хуулийн “Улсын тамга тэмдэг туг далбаа гурвын тухай” заасан 6 дугаар бүлгийн «Дөчин есдүгээр зүйл. Улсын туг далбааг улаан өнгөтэй бөгөөд дунд нь улсын сүлд тэмдгийг оруулан үйлдүүлж гүйцэтгэвэл зохино.

Тавьдугаар зүйл. Тус Улсын Их, Бага хурлыг Улаанбаатар хотод хуралдуулан байвал зохино» гэжээ.

Тайлбар №1: 1921 онд Монгол Улс дахь пүүс кампаниуд 234 байсан бол 1924 онд 635 болтлоо өссөн байв. Англи, Америкийнх 62, Хятад 462 байжээ.

Тайлбар №2: Марксист онолоор нийгэм нь хоорондоо эвлэрэшгүй зөрчил бүхий, эсрэг тэсрэг 2 ангид хуваагдах ёстой байдаг. 1924 оны Үндсэн хуулийн Нэгдүгээр бүлгийн заалтаар Монгол Улсад жинхэнэ ард, жинхэнэ бус ард гэсэн 2 ангийг ялган тодруулж өгсөн. Жинхэнэ бус ардад хөрөнгө чинээтэй хүмүүс болон лам нарыг багтаасан. Ийм ч учраас энэ Үндсэн хуулийн заалтын дагуу лам нарыг буудан алж, 1929 оноос өмчтэй хөрөнгөтэй хүмүүс, язгууртнуудын хөрөнгийг хурааж эхэлсэн байдаг.

Тайлбар №3: 1924 оны Үндсэн хуулиар төрийн Шар хамбан туг нь улаан туг, Нийслэл хүрээ маань Улаанбаатар нэртэй болж “бүх дэлхийд ялах ёстой” гэж тунхагласан улаан коммунизм Хөх Монголд довтлон орж ирсэн юм.

Тайлбар №4: Монголчууд 1920-иод онд ардын эрхтэй хэмжээт цаазагт Засгийг хүсэж байв. Харин Оросын Коммунист большевик нам, коминтерний төлөөлөгчид Монголд Ардын эрхт Бүгд Найрамдах Засаглал тогтоохыг хүсч байснаас зөрчилдөөн үүсч улмаар цуст тэмцэл өрнөн, олон эх орончдын амь үрэгдсэнээр коммунист үзэл сурталд нийцүүлсэн Үндсэн хууль, коммунист засаглал Монголд тогтсон байна. Тийм ч учраас энэ Үндсэн хуулийг баталсны өдөр болон баяр болгон тэмдэглэдэг өдрүүдэд манай төр засгийн тэргүүн байсан боловч эсэргүүн дайсанд тооцогдсон, өөрөөр хэлбэл “жинхэнэ ардын засгийн” эсрэг үзэл бодолтой байсан хүмүүсийг цаазаар авсан байдаг. Тухайлбал: 1937 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Ерөнхий сайд П.Гэндэнг, 1940 оны 7 дугаар сарын 25-нд Улсын Бага хурлын орлогч дарга Д.Лосол (ардын хувьсгалыг санаачилсан анхны долоон хүний нэг)-ыг, 1941 оны 07 сарын 10-нд Монгол Улсын Ерөнхий сайд А.Амарыг, 1941 оны 07 сарын 27-нд Улсын Бага хурлын дарга, бичгийн их хүн Д.Догсом (хувьсгалын анхны долоон хүний нэг)-ыг, 1941 оны 07 сарын 27-нд Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга Д.Лувсаншаравыг, 1941 оны 07 сарын 07-нд Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга Ө.Бадрахыг тус тус ЗХУ-д цаазласан билээ.

Тайлбар №5: Монгол Улс олон жил коммунизм руу хүчээр чихэгдэн орсон хар өдөр буюу жил бүрийн 11 дүгээр сарын 26-ны өдрийг бүх нийтийн баярын өдөр хэмээн тэмдэглэж ирсэнийг өөрчилж, харин 2011 оноос эхлэн 1911 оны 12 дугаар сарын 29-ний өдрийг Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо олж авсан баярын өдрөөр тэмдэглэх болсон билээ.

Тайлбар №6: 1924 оны Үндсэн хуулийг баталсаны дараа 1925 оны 3 дугаар сарын 7-ноос 9-ний өдрүүдэд МАХН-ын Төв Хорооны бүгд хурал хуралдаж дор дурдсан шийдвэрүүд гаргажээ. Үүнд:

1. Монгол Ардын Намын нэрийг Монгол Ардын Хувьсгалт Нам гэж өөрчлөх,
2. Дээрх шийдвэртэй холбогдуулж МАХН-ын шинэ мөрийн хөтөлбөр, дүрмийг төслүүдийг Коминтернд хүргүүлж засварлуулах, улмаар МАХН-ын IV их хурлаар батлуулах,
3. МАХН-ыг ариутган цэвэрлэх явдлыг үүсгэн явуулах (намд үгээгүй, ядуу ардуудыг олноор нь элсүүлэх),
4. Ардын журамт цэргийг Ардын улаан цэрэг гэж нэрлэх,
5. Марксын онол суртлыг түгээх, залуучуудыг боловсруулваас зүйтэй гэжээ.

Тайлбар №7: 1924 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн намын Төв Хорооны тэргүүлэгчдийн хурлаар “Аливаа улсын дээд албыг хүлээсэн



гишүүдийг Намын Төв Хорооны гишүүд захирна” гэсэн тогтоол гаргажээ. Энэ шийдвэр нь хэрэг дээрээ МАХН-д хязгааргүй эрх мэдэл олгож, түүнийг төр засгийн бүх байгууллагуудын дээрх байгууллага болоход хүргэсэн байна. Мөн 1924 онд хуралдсан тус намын III их хурлын тогтоолын 4 дүгээр зүйлд “...Манай ардын намаас өөр нам гаргаж үл болно.” хэмээн заажээ.

Тэгвэл, Ж.Цэвээн, Д.Бодоо нарын бичсэн Үндсэн хуулийн эх бидэнд байна. Тухайлбал, Д.Бодоогийн бичсэн “Хэмжээт засагтай, Монгол Ард Улсын Үндсэн хууль”-д:

«Хоёрдугаар бүлэг. Ардын эрх ба үүргийн тухай.

Аравдугаар зүйл. Монгол ард хэн ч болов хуучин эрх чөлөө, заншилаа эдлэхээс гадна сонгон хэрэглэхүйд нийлэлдэх эрдэм явдал буй бөгөөс бичиг цэргийн их тушаал ба бусад ямар ч албанд орж болно.

Арваннэгдүгээр зүйл. Монгол ард өөртөө засах журмыг яаж хэрэглэх явдлыг тусгаар хуулинд заан гаргамуй.

Арванхоёрдугаар зүйл. Монгол ард өөр өөрийн хөдлөх ба хөдлөхгүй хөрөнгийг эдлэх эрх буй. Гагцхүү тогтоосон хууль ёсоор албан татварыг хураалгаваас зохино.

Арвангуравдугаар зүйл. Монгол ард гагцаар буюу олноор нэр нийлж өөр өөрийн эрх ашгийг дэлгэрүүлэх бодлого гаргаж дээд газар өргөн мэдүүлэх эрх буй. Гагцхүү улсын хууль зөрчих ба захиргаанаас тогтоож үл болно.

Арвандөрөвдүгээр зүйл. Монгол ардууд шашин шүтлэгийг олны амгалан түвшинд нийлүүлж, ардын үүрэгт үл харшлахаар хэмжээг тогтоож шашин мөргөлийн шүтлэгийг үйлдэх эрх чөлөө олгомой.

Арвантавдугаар зүйл. Монгол ардуудыг хуулийн гадна зоримогоор барьж хорих ба гянданд хаах буюу орон нутгаас үлдэн хөөх хийгээд нэрийг нь гутааж доромжилбоос үл болно.

Арванзургаадугаар зүйл. Монгол ард хэн болов улс төрийн хэргийг сайжруулах зэргийн санал гаргаж цугларан хэлэлцэх ба хоршоо байгуулах эрх буй. Гагцхүү тэрслүү хортой санаа агуулах хоршоо, нам байгуулах ба зэр зэвсэг барьж эсэргүүцэх зэргийн хэрэг гаргаж үл болмой» гэжээ.

Эдгээрээс үзвэл Д.Бодоогийн бичсэн “Үндсэн хууль”-ийн төсөл харин ч ардчилсан агуулгатай, хүний эрхийг дээдэлсэн хууль байсан нь тов тодорхой байна.

Тэгвэл бидний шагшин магтаж, бахархан ярьж байсан 1924 оны Үндсэн хууль, харь орноос орчуулагдан, улмаар монголын ард түмэнд хүчээр тулган хүлээлгэсэн, ангийн үл эвлэрэх хагарал, тэмцлийг

хуульчилсан, энэ утгаараа “Хуульчилсан төрийн эргэлт” хийх үндсийг бүрдүүлсэн хууль байжээ. Асуудлын зангилаа ийнхүү тайлагдаж, монгол түмнийг хөнөөх “дүүжлүүрийн гогцоо” бэлтгэгдсэн нь илт байхад түмэн олондоо аюумшигт хэлмэгдүүлэлтийн эх үндэс, үйл явцын талаар анхнаас нь зөв ойлголтыг өгөөгүй өдий хүрсэн нь үеийн төрийн буруу юу?, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын үйл ажиллагааны арга менежментийн буруу юу?, Чухам юу гэж ойлгох вэ?

### **Хоёр. Иргэдээ хөнөөн хэлмэгдүүлсэн эрх зүйн акт, баримт болон үйл явц**

1921 онд “Саж ламын хэрэг” гэгчээр эхэлсэн хэлмэгдүүлэлт цаашлаад 1922 оны 1 дүгээр сарын 7-нд Ерөнхий сайд Д.Бодоо албан тушаалаасаа чөлөөлөгдөх өргөдлөө өгч, улмаар мал маллаж, жирийн амьдралд байхад нь дуудан авчирч, 1922 оны 8 дугаар сарын 31-нд Шар хадны энгэрт 14 хүний хамт буудан хороосноор хэлмэгдүүлэлтийн өрнөл өөрийн өнгө, төрхөө улам боловсронгуй болгож, улаан коммунистууд ангийн тэмцэлд ханцуй шамлан орсон байна. Хэлмэгдүүлэлтийн эзэн, түүний гаргасан хар мөрт шийдвэрүүдийн он дараалал, учруулсан гай, гамшгийн заримыг тоймлон харцгаая, анхаарагтун:

- 1925 он. МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчдийн хурлаар “Намын шалган цэвэрлэх комисс” байгуулан “анги ялгаварлах” бодлого хэрэгжүүлэх шийдвэр
- 1925 он. МАХН-ын IV их хурлаар баталсан МАХН-ын програмд “хар, шар харгисуудын үлдэгдлийг бүрмөсөн устган арилгах” шийдвэр
- 1927 он. МАХН-ын VI их хурал “...Нам улсын байгууллагад хуучин феодал, харгис түшмэдийн этгээдийг олноор нь шургалуулан бузарлаж байгаа... Баруун оппортунизмын эсрэг шийдвэртэй тэмцэн устгах...” шийдвэр
- 1928 он. МАХН-ын VII их хурал “феодалын эдийн засагт халдаж, тэдгээрийн хөрөнгийг хурааж, ангийн хувьд устгах бодлогод шууд шилжих...” шийдвэр
- 1929 он. Төв Хорооны II бүгд хурал “Хоосон ядууст ван гүн, хутагт лам нар зэрэг баячуудын хөрөнгийг шилжүүлэн эдлүүлэх” шийдвэр, 1932 оны 7 сар хүртэл 1300 хар, шар феодал түшмэдээс 10 сая орчим төгрөгийн хөрөнгө хурааж “МАХН-ын програмд буй “...феодалын өмчийг хурааснаар феодалын ангийг бүрмөсөн устгав.” гэх дүгнэлт
- 1930 он. МАХН-ын VIII их хурал “...Лам нарын талаар анги ялгаварлах бодлогыг улам нарийвчлан явуулах буддын шашны

хуурамч чанар, харгис ролийг... таниулж, шашны эсрэг суртал нэвтрүүлэг өргөн явуулах” шийдвэр

- 1930 он. “Богд хааны хойт дүрээр тодорсон Сэлэнгэ аймгийн Цэнджавын хүү Лувсандоржийн хэрэг”
- 1931 он. МАХН-ын Төв Хорооноос “хар шар феодалууд ба харгис толгой лам нарыг 1931 оны дотор хурдан түргэнээр явуулж тус намын IX их хурлыг хүртэл үндсэн дор устгах”-ыг хууль, хяналт, хүчний байгууллагуудад даалгасан нууц тогтоол, Егүзэр хутагт Галсандаш, Манзушир хутагт Цэрэндорж, Дилав хутагт Жамсроанжав нарын “38-ын хэрэг”
- 1932 он. МАХН-ын Төв Хороо, Төв Хянан Байцаах Комиссын хавсарсан III онц бүгд хурал “феодал ангийг ангийн хувьд устгах, харгис дээд лам нарыг шууд дайсанд үзэж бутцохих...Эсэргүү бослогыг бут цохих...” шийдвэр, З.Шижээ, Ө.Бадрах, Л.Лааган, Л.Цэндсүрэн нарыг МАХН-ын удирдлагаас зайлуулсан үйл явц, Ёнзон хамба Лувсанхаймчиг, Дэд хамба Дамдин нарын “Хувьсгалын эсэргүү лам нарын хэрэг”
- 1934 он. Монгол угсаатны зарим хэсгийг яргалан устгасан “Лхүмбийн хэрэг”
- 1936 оны МАХН-ын Төв Хорооны II бүгд хурлын тогтоол, “Жижиг хөрөнгөтний баян чинээлэг хэсгийн ашиг сонирхлыг илэрхийлэгч” П.Гэндэн нарын хэрэг
- МАХН-ын “Онцгой Бүрэн Эрхт Комисс” 1937 оны 10 дугаар сард байгуулсан тогтоол, тус комисс 1939 оны 4 сарын 22-ны өдөр хүртэл ажиллахдаа нийт 50 удаа хуралдаж, 25437 хүнийг шүүн 20099 хүнд цаазаар авах ял оногдуулсан хэрэг
- 1937 он. П.Гэндэн, Д.Дэмидийн “Хувьсгалын эсэргүү хэрэг”
- 1939 он. Ардын Сайд нарын Зөвлөлийн 1939 оны 12 сарын 1-ний өдрийн “Тусгай Комисс” байгуулсан тухай тогтоол, тус комисс байгуулагдаад 1939 онд 78 хүнийг, 1940 онд 42 хүнийг, 1941 онд 86 хүнийг хэлмэгдүүлсний дийлэнхийг ЗХУ-д (хуучин нэрээр) шийтгүүлэн хөнөөсөн хэрэг
- 1939 он. А.Амар, Д.Лувсаншарав нарын хэрэг
- 1940 он. “Зүүн аймаг, Сүхбаатар аймгийн малчдын хэрэг”
- 1942 он. МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчдийн “...зодох ба занчиж болох эрх, зөвшөөрлийг Дотоод явдлын яамны сайд нөхөр Шагдаржавын өөрийн хариуцлагад хатуу даалган өгсүгэй” гэсэн тогтоол

- 1944 он. “Хүүхэн хутагтын хойт дүрээр тодорсон Хэнтийн мэргэн жаал Ламаадангийн хэрэг”
- 1947 он. Порт-Артурын хэрэг
- 1956 он. МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны “Манай намын бодлогод харш үзэл санаа, үг өгүүлэл гарч байгаа тухай” 413 дугаар тогтоол, “Сэхээтний төөрөгдөл” гэх хэрэг
- 1956, 1958, 1962, 1963 оны МАХН-ын Төв Хорооны IY, II, III, Y бүгд хурлын тогтоолууд, нам төрийн зүтгэлтэн Д.Дамба, Д.Төмөр-Очир, Л.Цэнд Ч.Сүрэнжав нарын хэрэг
- 1964 он. МАХН-ын Төв Хорооны YI бүгд хурлын тогтоол, Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нар “намын эсрэг бүлэглэсэн явууллага хийсэн тухай” хэрэг.

Энэхүү жагсаалтаас ардын хувьсгалын жилүүдэд монгол түмнээ хэлмэгдүүлэн хөнөөсөн эзэн нь Монгол ардын хувьсгалт нам (Монгол ардын нам гэдэг улс төрийн байгууллага болохыг төвөггүй харж болно. Тус нам 2008 онд Монгол ардын хувьсгалт нам гэдэг нэрээ 1921-1924 онд хэрэглэж байсан Монгол Ардын нам гэдэг уугуул нэрээрээ сольж, хуучин нэрээ сэргээсэн билээ. Тус намын энэхүү үйлдэл 1921-1990-ээд он хүртэл үйлдсэн гэмт хэргээсээ бултан зугтаах гэхээсээ илүү, үйлдсэн нүгэл хилэнцээ хүлээн зөвшөөрөх, монголын ардчилсан сонголтыг хүлээн зөвшөөрч, өөрийгөө үзэл санаа үйл хэргийн хувьд бүрэн шинэчлэхэд чиглэсэн байгаасай. Өөрийгөө хэн гэж нэрлэх нь тухайн нам хүчний хувийн асуудал. Гэхдээ тус нам өөрийгөө яаж ч нэрлээд ХХ зуунд үйлдсэн сайн, муу үйл хэргээсээ зугтааж чадахгүй. Үүнийг өнөөгийн нийгэм зөвшөөрөхгүй.

Бид асуудлыг ийнхүү хөндөхдөө хэн нэг улс төрийн хүчнийг магтан мандуулах, эсвэл гутаан харлуулах зорилго өвөрлөсөнгүй. Гагцхүү хүн төрөлхтөний түүхэнд ховор тохиолдох яргалал, эрдэнэт хүмүүн бие биеэ хөнөөх гэмт хэрэг үйлдэхдээ ялалт байгуулж, гавьяа бүтээж байна хэмээн тархи мэдрэл нь 180 хэм эргэсэн хэнээрхэгчдийн төөрөгдөл дахин давтагдахгүй байх дархлаа бий болгох зайлшгүй хэрэгцээ байгааг л хэлэх гэсэн хэрэг.

### **Гурав. Шинэ цагийн улс төрийн хэлмэгдүүлэлт ба хүний эрхийн зөрчил**

1970-аад оноос өргөн цар хүрээг хамарсан залхаан цээрлүүлэлтийн эрч аажмаар саарч ирсэн боловч хэлмэгдүүлэлт зогсоогүй харин ч ихээхэн далдлагдсан, хорлонтой хэлбэрээр үргэлжилсээр байсан юм. Иргэдээ улс төрийн шалтгаанаар хорьж шийтгэдэг, тагнаж чагнадаг, мөрдөж хавчдаг, үзэл бодлоор нь ялган гадуурхдаг бусармаг үзэгдэл

оршсоор байв. Энэ талаар нэгэнт ил болсон зарим баримтыг эргэн санацгаая:

- 1969 он. Монголын түүхийн 1000 жилийн лит зохиосон эрдэмтэн Ц.Дамдинсүрэнгийн хэрэг
- 1975 он. Эрдэмтэн Б.Ренчинг мөрдөж мөшгөх ээлжит аян
- 1974 он. Яруу найрагч Р.Чойномын “Эсэргүү шүлэг бичсэн хэрэг”
- 1978 он. “Орос жолоочийн хэрэг”
- 1979 он. “Шүүхийнхний хэрэг”, “ШУА-ынхны хэрэг”, “Эмч нарын хэрэг”
- 1980 он. МАХН-ын Төв Хорооны “БНМАУ-ын түүхийн дээж бичгийн тухай” 70 дугаар тогтоол, Л.Жамсран, Г.Сүхбаатар нарын хэрэг
- 1985 он. Д.Төмөр-Очирын хэрэг
- 1999 он. УИХ-ын гишүүн С.Багчулуун, Д.Энхбаатар, Д.Баттулга нарыг баривчлан хорьж шийтгэсэн “Казиногийн хэрэг”
- 2003 он. Ж.Баатарын “Төрийн нууц задруулсан” хэрэг
- 2000-2004 он. МАХН дангаараа засгийн эрх барьж байсан он жилүүдэд АН-ын 15000 гишүүнийг төрийн албанаас халсан
- 2004 он. Хурандаа Санжаасүрэнгийн хэрэг
- 2008 он. Үзэл бодлоо илэрхийлэн жагсаал, цуглаан хийсэн иргэдийн үйл явдлын эсрэг Төрийн зүгээс галт зэвсэг хэрэглэж, хүчирхийлэл үйлдсэн хэрэг

Монгол Улс дэлхий нийтийн жишиг хандлага, олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг харгалзан монгол хүний эрхийг 1992 оны 1 дүгээр сарын 13-нд батлагдсан ардчилсан Шинэ Үндсэн хуулийн “Хүний эрхийн тухай” хоёрдугаар бүлэгт тусгаж баталгаажуулсан явдал өндөр ач холбогдолтой, түүхэн чухал үйл явдал болсон билээ. Монгол хүний эрх зүйн хамгаалалт ийнхүү бүрдсэн боловч парламентын засаглал, олон намын тогтолцоо гүйцэд төлөвшиж чадаагүй, эдийн засаг зах зээлийн харилцаанд шилжих шатандаа байгаа, хүн амын олонх ядуу буюу ядруу зэрэг бодит хүчин зүйлээс шалтгаалан хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөөр байна. Хүний эрхийн хэрэгжилтийн байдлыг тоймлон авч үзье:

- Амьд явах эрх. Монгол Улс цаазаар авах ял хэрэглэсээр байгаа орны нэг. БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1953 оны 93 дугаар зарлигаар “...энх тайван цагт алах ялыг хойшид хэрэглэх

хэрэггүй гэж үзнэ” гэж заасны дагуу 10 орчим сар цаазаар авах ялыг халсан удаатай. Албан ёсны мэдээгээр 1965-2007 оны хооронд онц хүнд гэмт хэрэг үйлдсэнийг буруутгаж 856 хүнд ялын дээд хэмжээг шүүхээс оногдуулжээ. Ардын хувьсгал ялсан 1921 оноос хойших хугацаанд ямарч гэм буруугүй олол мянган иргэнээ улс төрийн шалтгаанаар хэлмэгдүүлж устгасан тухай дээр өгүүлсэн. Энэ нь гэм буруутанд хариуцлага хүлээлгэхийг зүй ёсоор шаардсан түүхийн эмгэнэлт хар толбо болон угжирсаар байна. Нөгөө талаар төрөөс хүний амьд явах эрхийг баталгаатай хангаж чадаагүйн улмаас зөвхөн 2007-2010 оны дөрөвхөн жилд хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг 25988 гэмт хэрэг гарч, 1034 хүн бусдын гарт амь, насаа алджээ. Төрөөс иргэдийнхээ амьд явах эрхийг баталгаатай хангаж чадахгүй, энэхүү чухал эрх хангагдаж, хэрэгжиж чадахгүй байна.

- Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх. Монгол оронд байгаль, экологийн оновчтой бодлого тодорхойлогдоогүй, ашигт малтмалын нөөцийн замбараагүй олборлолт, хүний зохисгүй үйл ажиллагаа, дэлхийн дулаарлаас шалтгаалан экологийн тэнцвэрт байдал ихээхэн алдагдаад байна. Зөвхөн сүүлийн 20 жилд ус бүхий газрын хэмжээ 941.8, ой бүхий газрын хэмжээ 890.5, хөдөө аж ахуйн эдэлбэр газрын хэмжээ 12971.8 мянган га-аар тус тус хорогдож, нийт нутаг дэвсгэрийн 70 гаруй хувь нь цөлжилтөд нэрвэгджээ. 2010 оны эцсийн байдлаар Алт олборлолт явагдсан 10-аад аймгийн 4000 гектар газарт нөхөн сэргээлт хийгдээгүй, булж тэгшлээгүй нүх 566 байгааг тухайн үед Байгаль орчин, аялал жуулчлалын яам мэдээлжээ. Мексик Улсын Канкун хотноо “Уур амьсгалын өөрчлөлт ба агаарын чанар”-ын асуудал хэлэлцсэн Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 2010 оны чуулганаас дэлхийн хамгийн бохир агаартай 10 хотын 5-д манай нийт хүн амын 56 хувь оршин суудаг нийслэл Улаанбаатар хотыг нэрлэсэн байна. Мэргэжилтнүүд тус хотын агаарт зөвшөөрөгдөх хэмжээнээс хүхрийн хүчил 2 дахин их, хүхэрт устөрөгч 21 дахин их байгааг тогтоожээ. Хүн амын хоол хүнсний эрүүл ахуйн болон бусад стандартууд байнга зөрчигдөж, хэрэглэгчид хоол, хүнсний хордлогод өртөж эрүүл мэндээ төдийгүй амь насаа алдах тохиолдол гарч байна. Эрүүл мэндийн яамны судалгаагаар манай иргэдийн нийт өвчлөлийн 30 хувь нь хортой хүнс хэрэглэснээс шалтгаалсан гэжээ.

Хөдлөх үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрх. Хувийн өмчийн харилцааг Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөнөөр манай орны үндэсний нийт бүтээгдэхүүний 70 хувийг хувийн сектор бүтээдэг, эдийн засгийн бие даасан салбар



болж чадсан. Хувьчлалын ачаар иргэдийн өмчийн мал сүргийн тоо өсч, хөлсний байшинд амьдарч байсан төв, суурин газрын иргэд орон байртай болсон, 2009 оны байдлаар манай иргэдийн 30 хувь өөрийн гэсэн газартай болжээ. Гэвч өмч хувьчлалыг зориуд будилаантуулж, хяналтгүй хэрэгжүүлсэнээс шалтгаалан Монгол Улсын түүхийн туршид бүтээгдсэн үндэсний баялаг болох 1000 шахам улсын үйлдвэрийн газар, 255 нэгдэл, 43 сангийн аж ахуй, 18 тэжээлийн аж ахуйн болон улсын нөөцийн эд хөрөнгийг эрх мэдэлтнүүд хуваан завшсан. 1990 оноос хойш олгогдсон зээл тусламжийн хөрөнгө, ашигт малтмалын лицензүүд, улсын төсвийн хөрөнгө, Эрдэнэт мэтийн хувьчлагдаагүй үлдсэн томоохон улсын үйлдвэрийн хөрөнгө мөнгө, газар нутаг албан тушаалтнуудын хөлжих хөрөнгөжих хэрэгсэл болж, энгийн иргэдийн эд хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх эрх зөрчигдсөөр байна.

- Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрх. 1990 он гэхэд манайд 1000 орчим төрийн өмчийн үйлдвэр аж ахуйн газар байсан бол энэ тоо 2010 онд 69412 болж өсчээ. Ийнхүү хувь хүний аж ахуй эрхлэх эрх нээгдсэн, энэ хэрээр бизнесийн хүрээ тэлж байгаа боловч тодорхой бэрхшээлүүд байсаар байна. Тухайлбал, бүх төрлийн бизнесийн хүрээ дарамт ачаалал ихтэй, танил тал, эсвэл авилгалгүйгээр бизнес эрхлэх зэрэг ямарч асуудал шийдэх бололцоогүй, иргэний ялангуяа бага тушаалын болон үйлчилгээний ажилтнуудын цалин хөлс амьдралын наад захын хэрэгцээг хангахад хүрэлцэхээргүй бага байна. Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2011 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 140400 төгрөгөөр тогтоосон. Мөн “Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай Монгол Улсын хууль”-д заасны дагуу Үндэсний статистикийн газраас хүн амын амьжиргааны доод түвшин 2010 онд 101600 төгрөг гэжээ. Энэхүү доод түвшин айл өрхийн нэг сарын хоол хүнс, орон байрны зайлшгүй зардлаас 5 дахин бага байна. Үүний зэрэгцээ манай гурван хүн тутмын нэг нь энэхүү амьжиргааны доод түвшингээс ч бага орлоготой буюу огт орлогогүй ажээ.
- Өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрх. Улсын хэмжээнд бүтэн ба хагас өнчин хүүхэд 42900, өрх толгойлсон эмэгтэй 81000, тэтгэвэрийн насны хүн 204200, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 115000, төрсөн хүүхдийн тоо 63270 байна. 2010 оны байдлаар өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн зэрэг 4 төрлийн тэтгэвэрт 337500 хүн хамрагдаж, 375032,7 сая төгрөгийн тэтгэвэр олгосон нь нэг хүнд

сард дунджаар 92600 төгрөг ногдож байна. 2010 онд жирэмсэн болон амаржсаны, ахмад настаны, олон хүүхэдтэй эхчүүдийн, алдар цолтой ахмадуудын зэрэг 14 төрлийн тэтгэмжид 508400 хүн хамрагдаж, 135977.2 сая төгрөгийн тэтгэмж олгосон нь нэг хүнд сард дунджаар 22300 төгрөг ногдож байна. Ийнхүү зөвхөн тэтгэвэр, тэтгэмжид 2010 онд нийтдээ 845900 хүн хамрагдаж 511 тэрбум төгрөг (хүний хөгжил сангийн мөнгө ороогүй) зарцуулсан боловч нэг хүний тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ, ажиллагсдын сарын цалин хөлс, тэдний наад захын хэрэгцээг ч хангахад хүрэлцэхгүй бага байна. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл бүх насаараа төлсөн иргэн өндөр наслах, өвчлөх зэргээр хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд авч байгаа тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ тэдний наад захын хэрэгцээг хангаж хүрэлцэхгүй, хэвийн амьдралын баталгаа болж чадахгүй байна.

- Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх. 2010 оны байдлаар манай улсад сумын, сум дундын, аймаг дүүргийн, клиникийн болон төрөлжсөн эмнэлэг, төв 274, хувийн эмнэлэг 1113, эмнэлэгийн байгууллагад нийтдээ 39608 хүн ажиллаж байна. 2010 онд 679.6 мянган хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, 33810 хүн төрж, 15752 хүн нас баржээ. Улсын хэмжээнд хүн амын 60 хувь ямар нэг өвчтэй гэсэн мэдээлэл байна. Тахал, боом, шувууны томуу, ямааны ханиад, адууны ханиад, гахайн ханиад M1N1, гар хөл амны өвчин, энтеровирус 21, ДОХ зэрэг гоц халдварт өвчин гарсаар байна. 2010 оны 10 дугаар сарын байдлаар ДОХ-ын халдвар авсан 80 дахь тохиолдол бүртгэгджээ. Дэлхийн хэмжээнд 15000 төрлийн эм хэрэглэгддэгийн 30 хувь хуурамч гэсэн мэдээлэл байна. Хуурамч эм, тариа худалдаалагдсаар байна. Төв орон нутгийн эмнэлгүүдэд 2007 онд Мэргэжлийн хяналтын газрын хийсэн хяналт шалгалтаар 11537 зөрчил илэрсний дотор оношийн алдаа 92, буруу эмчилсэн 100, эмчийн ёс зүйн алдаа 57, хариуцлагагүй байдлын алдаа 29 байжээ. Даатгалтай иргэд эмчилгээ, оношлогооны ихэнх зардлаа хувиасаа төлж байна. Эмчилгээний чанарт иргэд сэтгэл дундуур байгаагаас шалтгаалан гадаадад явж эмчлүүлэх хандлагатай болжээ. Эмнэлэгийн байгууллагуудын үйл ажиллагаанд танил тал харах, шан харамж авах явдал түгээмэл байна. Эмнэлгийн байгууллагуудын төсвийн хөрөнгө, даатгалын хөрөнгийг ашиглан эрх мэдэлтнүүд эм, тариа, эмнэлгийн тоног төхөөрөмжийн шахааны бизнес ноцтой зөрчил давтагдсаар байна. Хүний эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх зөрчигдсөөр байна.

- Сурч боловсрох эрх. 2010/2011 оны хичээлийн жилд манай улсын 751 ерөнхий боловсролын сургууль, 176 их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 732.0 мянган хүүхэд, залуучууд суралцаж, боловсролын салбарт 40.4 мянган багш, сурган хүмүүжүүлэгчид ажиллаж байна. Их дээд сургууль их төлөв конторын ажилтан бэлтгэдэг, материал баялаг бүтээх чиглэлийн нарийн мэргэжилтэн ихээр дутагдаж байна. Бүх шатны мэргэжлийн сургуулийн сургалтын төлбөр айл өрхийн амьжиргаанд хүнд дарамт бэрхшээл учруулж байна. Хэдийгээр их төлбөр төлж мэргэжил эзэмшивч ажлын байр хүрэлцэхгүй, мөн зарим шинээр сургууль төгссөн мэргэжилтэн ажлын байрны шаардлага хангахгүй гологдож байна. Ажил албан тушаалд хүрэх, эсэхийг шат дараалсан үнэлгээ бүхий далд авилгал, эрх мэдэлтний татаас, дэмжлэг хэрэг дээрээ шийдвэрлэх болжээ.
- Соёл урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрх. Манай иргэдийн энэхүү чухал эрх нээлтэй байгаа. Гэхдээ ялангуяа шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл тууривахад төрөөс үзүүлэх дэмжлэг тусалцаа хангалтгүй, гаднын хүн, байгууллагыг шүтсэн, тэдэнд түшиглэсэн сэтгэлгээ хүчтэй хэвээр байна. Улсын төсвөөс шинжлэх ухааны байгууллагуудыг санхүүжүүлэхэд зориулагдсан улсын төсвийн санхүүжилтийн хэмжээ өндөр хөгжилтэй орны бараг нэг томоохон эрдэмтний цалингаас ихгүй байгааг мэдээлсэн. Хөрөнгө мөнгөний энэхүү гачигдал нь үндэсний оюуны чадавхийг хөгжүүлэх, үнэ цэнэтэй бүтээл тууривахад ихээхэн саад учруулдаг хэмээн үзэж байна.
- Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрх. Монгол Улсын иргэд Үндсэн хууль, УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн хууль, Төрийн албаны тухай хуулийн дагуу бүх шатны хурлын гишүүнд сонгох, сонгогдох эрхээр хангагдсан. УИХ-ын болон орон нутгийн сонгуулийг зориуд будлиантуулах үйлдэл байнга давтагдаж, сонгуулийн хууль тогтоомжийг санаатай зөрчсөн этгээд болон улс төрийн зарим нам хариуцлага хүлээх байтугай харин ч төр, засгийн эрх мэдлийг эзэгнэх тохиолдол гарсаар байна. УИХ-ын сонгуульд оролцож санал өгөхөөр бүртгэгдсэн сонгогчдын тоо нь орон нутгийн сонгуульд оролцохоор бүртгэгдсэн сонгогчдын тооноос 1996 онд 85500-аар, 2000 онд 141600-аар, 2004 онд 251300-аар, 2008 онд 277100-аар тус тус илүү байв. Зөрүү нь байнга нэмэгдэж иржээ. Энэ нь сонгогчдын нэрсийн жагсаалт худал гарсаныг харуулсан албан ёсны баримт юм. Насанд хүрсэн иргэн бүхнээ сонгуульд оролцуулахаар бүх шатны төрийн байгууллагаас гаргасан сонгогчдын тоо аль ч сонгуулийн хувьд

адил тэнцүү байх ёстой. Иргэний сонгох, сонгогдох тэгш эрх зөрчигдсөөр байна.

- Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрх. Монгол Улсын 1960 оны Үндсэн хуулийн 82 дугаар зүйлд “БНМАУ-ын иргэд үйлдвэрчний эвлэл, хоршоолол, залуучууд, биеийн тамирын эвлэл зэрэг байгууллага, соёл шинжлэх ухаан техникийн нийгэмлэг тэрчлэн улс түмний найрамдал, энх тайвныг бэхжүүлэх нийгэмлэг” зэрэг тусгайлан нэрлэсэн олон нийтийн цөөн байгууллагад эвлэлдэн нэгдэх эрхтэй гэж заагаад уг эрхийг “Улсын болоод, хөдөлмөрчдийн олон түмний бусад бүх байгууллагын манлайлагч бөгөөд жолоодогч МАХН-д ажилчид, хоршоолсон хөдөлмөрчид, хөдөлмөрч сэхээтний эгнээнээс шалгарсан хамгийн идэвхтэй ухамсартай иргэд эвлэлдэн нэгдэнэ” гэж тодотгосноор нэгд, олон нийтийн үүсгэл санаачлагын бүх байгууллага улс төрийн нэг намын хяналт дор ажиллах болсон, хоёрт, иргэдийн «шалгарсан, идэвхтэй, ухамсартай» хэсэг МАХН-ын ивээлд багтах, бусад нь (хөдөлмөр эрхлэгчид, залуучууд, эмэгтэйчүүд, ахмадууд, хүүхэд) МАХН-ын эрх ашгийг хангахад үйлчлэх ёстой болсон, гуравт, иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг үндсэн хуулиар хязгаарласан байв. Харин 1992 онд Монгол Улсын Шинэ үндсэн хууль батлагдсанаар иргэд “нийтийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, эвлэлдэн нэгдэх” эрхтэй, үүнийхээ төлөө гадуурхагдахгүй, хэлмэгдэхгүй байх боломж нээгдсэн. 2010 оны байдлаар Монгол Улсад 6915 төрийн бус байгууллага хэн нэгний хараа хяналт, удирдамж, зааваргүйгээр, өөр өөрсдийн хүлээн зөвшөөрсөн дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулж байна.
- Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэйн тэгш эрх. Жендэрийн хууль батлагдсанаар улс төрийн харилцаанд эрэгтэй эмэгтэйн тэгш эрхийг хангахад зохих алхам хийгдсэн. Гэвч эдийн засаг, нийгэм, соёлын амьдралд эмэгтэйчүүд хүйсийн дарангуйлал, ялгаварлалд байнга өртөж, гэр бүлийн амьдралд хүчирхийлэл өсөх хандлага ажиглагдсаар байна.
- Төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж, шийдвэрлүүлэх эрх. Төрийн ихэнх байгууллагууд иргэдийг хүлээн авах өрөө тасалгаа, цагийн хуваарьтай, иргэдийн өргөдөл гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, хариу өгөх журам дүрэмтэй байгаа нь сайшаалтай. Үүний зэрэгцээ асуудалд танил тал, улс төрийн ашиг сонирхлын үүднээс ханддаг, үгсэж

хуйвалддаг, авилгал хээл хахуулийн хар хүчээр бүхнийг шийддэг байдал хэвийн үзэгдэл болтлоо даамжирч, эдгээр бусармаг явдлыг бүх түвшинд хүлээн зөвшөөрөхдөө хүрчээ. Нийгэмд шударга, ёс зүй бүрэн алдагдсан байна.

- Халдашгүй чөлөөтэй байх эрх. 2010 онд улсын хэмжээнд 19825 гэмт хэрэг гарснаас ихээхэн хэсэг нь согтуугаар үйлдэгджээ. Энэ онд хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 6813 удаа гарч 972 хүний амь хохирчээ. Хүний амь хөнөөсөн гэмт хэрэг улам бүр харгис хэрцгий шинжтэй, хор хөнөөл ихтэй болсоор байна. Өмчлөх эрхийн эсрэг 7944 гэмт хэрэг гарсаны 5777 нь хулгайн, 1764 нь дээрмийн болон залилангийн шинжтэй гэмт хэрэг байна. Өдөр бүр 1-2 охид, бүсгүйчүүд хүчиндүүлдэг ажээ. УБ хотод 2000 мэргэжлийн хулгайч байгаа гэнэ. Хувь хүмүүстэй холбоотой гэмт хэргийн гол шалтгаан нь ажилгүйдэл, ядуурал болж байна. Хүн худалдаалсан гэмт хэрэг 1999-2006 оны хооронд 30, зөвхөн 2009 онд 8 гарсан гэж ЦЕГ-т бүртгэгджээ. Энэ төрлийн гэмт хэрэг дотор бусдын биеийг хүч хэрэглэн зохион байгуулалттайгаар үнэлүүлэх, хүний ялангуяа бага насны хүүхдийн эд, эрхтнийг наймаалах гэмт хэрэг ч мөн багтдаг байна. Хил Хамгаалах Ерөнхий Газрын албан ёсны мэдээгээр 2006, 2007 оны 2 жилд 64172 хүүхэд хил гарсны 5104 нь эргэж ирээгүй ажээ. Иргэний халдашгүй чөлөөтэй байх эрх хангагдаж чадахгүй байна.
- Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрх. Зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар олон улсын шүүхэд хандах явдал бараг хаалттай, энэ талаарх иргэний мэдээлэл туйлын хангалтгүй байна. Бусдын хууль бусаар учруулсан хохиролыг нөхөн төлүүлэх эрх үндсэндээ хэрэгжихгүй байна. Гэм буруутай нь хожим нотлогдоогүй иргэн баривчлагдах, байцаагдах, хоригдох явцад эрүүл мэндээр хохирсон, улмаар амь насаа алдсан ноцтой тохиолдол давтагдаж байгаа боловч хохирлыг нөхөн төлөх ажиллагаа хэрэг дээрээ хийгдэхгүй, хүний эрх зөрчигдсөөр байна. Шүүх засаглалын бие даасан, хараат бус байдал алдагдсан, их хэмжээний хохирол бүхий ноцтой гэмт хэргүүд зохих ёсоор шийдэгдэхгүй байгааг бүх түвшинд байнга шүүмжлэх боловч өөрчлөлт гарахгүй байна. Хэлмэгдэгсдийн

хохирлыг нөхөн төлөх ажиллагаанд эрх баригчид хөшүүн хойрго хандаж, ёс төдий “нөхөх олговор” олгон аргацааж ирэв.

- Шашин шүтэх эс шүтэх эрх чөлөө. Монгол Улсын 1992 оны шинэ Үндсэн хуульд “төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдлэх” зарчмыг хуульчлан тогтоож 1960 оны Үндсэн хуулийн 86 зүйлд байсан “БНМАУ-ын иргэд ... шашны эсрэг суртал нэвтрүүлэг хийх эрх чөлөөтэй” гэсэн, хүний эрхийг хаан боогдуулсан заалтыг үндсэн хуулиас хассанаар 750 гаруй хүрээ хийд, 4000 гаруй дуган, 115000 лам хуврагийг хөнөөн сүйтгэсэн гэмт үйлдэл дахин давтагдахгүй байх баталгаа эрх зүйн хувьд хангагдаж, Монгол нутагт бурхны шашин хүмүүн төрөлхтөний нэг хэсгийн үзэл бодол, итгэл үнэмшлийн илэрхийлэл болохын хувьд оршин тогтнох боломж бүрдсэн. Иргэний шүтэх, эс шүтэх эрх чөлөө нээгдсэн. Монгол Улсад 2008 оны байдлаар Будда, Христ, Ислам, Бөө, Бахай, Мум, Мормон зэрэг шашны нийт 461 сүм хийд үйл ажиллагаа явуулж байгаагаас 110 нь зөвшөөрөлгүй ажилладаг гэсэн мэдээлэл байгаа. Сүм хийдийн 2010 оны албан ёсны тоо 234 байна.
- Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөө. Үзэл бодол, үндэс угсаа, хөрөнгө чинээ, сүсэг бишрэлээр нь ялгаварлан олон мянган язгууртан, лам хувраг, үндэсний сэхээтэн, жирийн иргэдээ хөнөөж устгасан гашуун түүх давтагдахгүй байх баталгааг төр хангах ёстой. Гэтэл ийм баталгаа, дархлаа бий болоогүй төдийгүй хэлмэгдүүлэлт үргэлжилсээр байна. Үүний жишээ нь 2000-2004 онуудад буюу МАХН (одоогийн МАН) засаг төрийн эрх мэдлийг дангаараа барьсан, УИХ-д үнэмлэхүй олонх болсон он жилүүдэд Ардчилсан намын 15000 гишүүнийг төрийн албанаас халсан явдал юм. Нийгмийн дотор үзэл бодлоороо явцууран бүлгэрхэх, талцах явдал хавтгайрч энэ нь гэмт хэргийг нуун дарагдуулах, хууль завших, өмч хөрөнгийг хуваан идэж ашиглах, төрийн эрх мэдлийг хууль бусаар авах буюу авахыг завдах арга, хэрэгсэл болтлоо гүнзгийрчээ. Иргэний хэвлэн нийтлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөө нь нэг бол хэвлэл мэдээллийн байгууллагууд төлбөр шаарддаг, эсвэл захиалгат материал, гүтгэлэг түгээдэг гажуудал байгаагаас шалтгаалан бүрэн төгс хангагдаж чадахгүй байна.
- Төр түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрх. Мэдээлэл түгээх сүлжээ, арга хэлбэр ихээхэн өргөжиж, интернэт ашиглах болсноор иргэний мэдээлэл хайх, хүлээн авах боломж нээлттэй болсон. Тэгэхдээ нэн чухал, шуурхай мэдээлэлд



ойр байгаа албан тушаалтан, эрх мэдэлтэн энэхүү давуу байдлаа хувийн зорилгоор ашиглах, зарим шаардлагатай мэдээллийг зориуд нууцлах, ташаа мэдээлэл түгээх явдал ялангуяа улс төрийн болон бизнесийн хүрээнд байсаар, энэ салбарт хүний эрх зөрчигдсөөр байна.

- Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрх. Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсанаар монгол хүн төрөөс тусгайлан заасан газар нутагт цөлөгдсөн мэт түгжигдэн суудаг, улсынхаа хил хязгаарын дотор богино хугацаагаар зорчих нөхцөлд ч заавал ямар нэг эрхтэн дархтанаас зөвшөөрөл, тухайлбал «зам явах» гэгчийг авдаг гажуудал арилсан. Зөвхөн өөрийн орны дотор төдийгүй дэлхий ертөнцийн өөр аль ч улс оронд Монгол хүн чөлөөтэй зорчих эрх бас бодитойгоор нээгдсэн. Үүний баримт нь 2010 оны байдлаар манай 1300000 (1.3 сая) иргэн гадаадын улс орнуудад зорчиж, дэлхийн янз бүрийн улс орнуудад манай 150000 иргэн аж төрж, ажил хөдөлмөр эрхлэж байгаа явдал юм. Шинэ Үндсэн хууль батлагдсан 1992 оноос хойш нутаг дэвсгэрийн төв рүү ялангуяа Улаанбаатар хот руу чиглэсэн их нүүдэл үргэлжилж, хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай олон мянган залуус гадаад улс орнуудад зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүйгээр гарч ажил эрхлэх болсон, эдгээр байдлаас үүдэн олон эерэг, сөрөг үр дагавар гарч байгаа. Энэ байдал нь иргэд хөдөө нутгаасаа, залуус эх орноосоо уйдаагүй, иргэддээ чөлөөтэй зорчих эрх олгосноос ч ийм байдал үүсээгүй байх. Харин олон жилийн турш иргэдийнхээ чөлөөтэй зорчих эрхийг нь хааж, хашсан, монгол хүний хөдөлмөрийн үнэ, үнэлэмж дэндүү хямд, хот хөдөөгийн хүмүүсийн амьжиргаа ихээхэн ялгаатай, хөдөөд нийгэм-соёлын үйлчилгээ дэндүү дорой хязгаарлагдмал, хот хөдөөгийн залууст эрхлэх ажил хөдөлмөр олдохгүй байгаа, малын ашиг шимээр амьжиргаагаа залгуулж байсан иргэд зуд турхан болон бусад шалтгаанаар хотоо харлуулж малгүй болсноос амьдралын эрхээр хот, суурин бараадах болсон зэргээс үүдэлтэй гэж үзэж байна.

### **Шинэ цагийн хүний эрхийн зөрчлийн талаар дүгнэлт**

Хүүхдүүд, залуучууд, ажил хөдөлмөр эрхлэдэг болон ажилгүй хүмүүс, цэргийн албан хаагчид, хөдөлмөрийн чадваргүй иргэд, суралцагсад, тэр ч байтугай хоригдлууд, сэжигтэн хүртэлх нийгмийн бүх давхрагын иргэдийн эрх байнга зөрчигдөж ирлээ. Монголд хүний эрх, эрх чөлөө цаг минут тутамд зарчигдөж, нийгэмд эмх замбараагүй байдал газар авч, гар нүцгэн иргэд аллага, таллага,

хулгай, дээрэмдэлт, албан тушаалтны дарамт, дарангуйлалд байнга өртөж, үй олноороо өөрийн буруу биш шалтгаанаар ядуурч, өлсгөлөн гуйланчлалд нэрвэгдэж байхад тусгай хуулиар эрх, санхүүжилт авсан Хүний Эрхийн Үндэсний Комисс зөвхөн тайлан бичиж, өдрийн од шиг хааяа нэг нэхэмжлэл гаргасаар суугааг юу гэж ойлгох бэ? Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан зарим саналаа илэрхийлж байна:

- Монгол Улсад хүний эрх аливаа хэлбэрээр зөрчигдөх, завхрал хэлмэгдүүлэлт үүсэхээс бүх талаар урьдчилан сэргийлэх нь зөрчил, дутагдал аллага, гэмт хэрэг гарсны дараа сандран гүйлдэж «ниргэсэн хойно хашгирах»-аас үлэмж давуу үр өгөөжтэй гэж үзэж байна. Урьдчилан сэргийлэхэд олон талтай, өргөн хүрээтэй арга хэмжээ, хөрөнгө санхүүгийн эх үүсвэр шаардагдах хэдий ч нэгэнт гарсан зөрчлийн хор хөнөөлийг арилгахаас ямарч тохиолдолд хямд байх болно.
- Тус улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суугаа хүн бүрийн эрхийг хамгаалах, хүний эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн, хохирсон иргэдэд бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх хэрэгт алагчлал, ялгаварлал гаргахгүй байх явдал манай нөхцөлд чухал байна. Танил тал, хөрөнгө чинээ, улс төрийн намын харьяалал, эрхэлсэн ажил, албан тушаал зарим хүнийг даврааж, зарим хүнийг хохироож таарахгүй боловч чухамхүү энэ хүрээнд хүний эрх хамгийн ихээр зөрчигдөж байгаа. Манай улс эхлээд хүчний байгууллагад ажиллагсадыг, дараа нь төрийн нийт албан хаагчыг улс төрийн намын харьяаллаас түдгэлзүүлсэн. Цаашдаа нийт иргэдээ намын хатуу гишүүнчлэлгүй болгох нь зүйтэй гэж үзэж байна. Ядаж улс төрийн шалтгаанаар бүлэглэн хуйвалдах шалтгаан багасна.
- Жендэрийн тэгш байдлыг хангах, эхчүүд, эмэгтэйчүүд, хүүхдүүд, гадаадад оршин сууж, сурч, ажиллаж байгаа өөрийн орны иргэдийн болон манай улсад хууль ёсоор оршин суугаа гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүс, мөн тусгай хэрэгцээ, онцлог эрх ашиг бүхий хүмүүсийг нийгэмд ялгаварлан гадуурхахаас хамгаалах, эрхээ эдлэх нөхцөл бололцоог хангах эрх зүйн зохицуулалт, орчин нөхцөл, нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх нь чухал байна.
- Хүний бие эрхтэнийг дэлхий нийтийн жишиг хандлагад нийцсэн үнэ, үнэлгээтэй болгох замаар гэмт этгээдийн үйлдсэн хэргийн улмаас бусдад учруулсан бүх талын хохирол (хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, сэтгэл санааны гэх мэт)-ыг заавал нөхөн төлүүлэх эрх зүйн шаардлагатай орчин бүрдүүлэх, энэ талаар нэгэнт батлагдсан хууль, тогтоомжийг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

- Төрөөс иргэдийнхээ амьд явах эрхийг баталгаажуулж, цаазаар авах ялыг ялын төрлөөс хасах саналыг дэмжиж байна.
- Хүний амьдрах орчныг бохирдуулсан, байгалийн тэнцэл алдагдахад хүргэсэн аливаа үйлдэл, эс үйлдлийн эсрэг тууштай тэмцэхийг зөвхөн манай орны төдийгүй дэлхий дахины нийтлэг эрх ашиг, орчин цаг, үе шаардаж байгаа тул энэхүү гэмт үйлдлийг гаргуулахгүй байх хяналт, нөлөөллийг чангатгах, хүлээлгэх хариуцлагыг эрс өндөржүүлэх явдал чухал байна.
- Хүний эрхийн талаарх гэмт хэрэг, зөрчил, санал, гомдлыг бүртгэх мэдээллийн сан бүрдүүлж, лавлагааны тогтолцоо үүсгэн ашиглах, хүний эрхийн холбогдолтой хууль, тогтоомжыг шинжлэн судалж, байнга боловсронгуй болгох, энэ тухай нийт иргэддээ ил тод мэдээлж байгууштай санагдана.
- Хүний эрхийг зөрчихгүй ажиллах хэрэгт төрийн бүх шатны байгууллагын шийдвэр нийцэж байх, энэхүү зорилгын хэрэгжилтийг байгууллага бүр жилийн эцсийн тайландаа тусган хэлэлцэж, холбогдох арга хэмжээ авч байх, хүний эрхийн аливаа асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэд байнга хамтран ажиллах механизм бүрдүүлэх, хүний эрхийн байдлыг шинжлэн судлах, тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөх, иргэдэд энэ талын мэдлэг боловсрол олгох байнгын үйл ажиллагаа шаардлагатай байна.
- Олон улсын болон бүс нутаг, гадаад улс орны хүний эрхийн байгууллагуудтай харилцан мэдээлэл, туршлага солилцох, хүний эрх, хөгжлийн асуудлаар хамтран ажиллах явдал альч оронд, хэн бүхэнд хамаатай байна.

Аливаа орны хөгжил дэвшлийн бодит илэрхийлэл, толь тусгал нь тухайн улсын иргэдийн амьжиргааны хүрсэн түвшин байдаг бол энэхүү түвшинд хүрэх арга, механизм нь ямарч тохиолдолд хүний эрхийг зөрчихгүй байх, өөрөөр хэлбэл хүнээ дээдлэх явдал гэх үзлийг олонх улс орнууд, эрдэмтэд, судлаачид хүлээн зөвшөөрч байгаа бололтой. Бид энэ үзлийг бүрэн дэмждэг. Хичнээн их баялаг бүтээгдлээ ч түүнийг эрх мэдэлтэй хэдхэн хүн эзэмшиж бусад нь өлөн зэлмүүн аж төрдөг бол, гэм буруугүй иргэдээ төр нь улс төрийн шалтгаанаар хэлмэгдүүлэн хохироож, дур мэдэн амь насыг нь хөнөөдөг бол тэнд юуных нь хүний эрх яригдах билээ, хэрэв яригддаг бол хоосон цаас байх болно,

Хүн амынхаа зайлшгүй хэрэгцээг хангаад тэднийхээ эрх, эрх чөлөөг зөрчихгүйгээр аж төрөх олон талын бололцоонуудын дотроос хамгийн гол нь нийгэмдээ шударга ёс тогтоох явдал гэж үзэж байна.

### **Дөрөв. Цагаатгах үйл ажиллагааны эхлэл, өрнөл, сулрал**

МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчдийн хурлаар ДЯЯ-ны ажлыг авч хэлэлцээд 1939 оны 4 дүгээр сард 15 дугаар тогтоол гаргаж улс төрийн хэрэгт шийтгэгдсэн хүмүүсийн хэргийг дахин хянан үзэх шийдвэр гаргажээ. Энэхүү шийдвэрийн дагуу 1939 оны хавраас мөрдөнд болон хоригдож ял эдэлж байсан хүмүүст холбогдох хэргийг Тусгай комиссоор хэлэлцүүлэн дахин хянаж, суллан тавьж эхэлсэн боловч энэ ажлын эрч саарсаар эх орны дайн эхэлсэн болон бусад шалтгааны улмаас үндсэндээ зогссон бөгөөд энд хэлмэгдүүлэлт, завхрал эхлүүлсэн, хэрэгжүүлсэн хүмүүс энэ ажлыг зогсооход нөлөөлсөн баримт одоо ч байна. Ялангуяа социализмд аюул учирч фашизмтай үхэх сэхэхээ үзэн тэмцэлдэж байхад ардын дайсан, гадаадын тагнуул гэгдэн шийтгэгдсэн хүмүүсийг цагаатгах явдал байж болшгүй зүйл хэмээн үзэх хүн ялангуяа ДЯЯ-нд олон байсан бололтой.

Цагаатгах ажлын сураг чимээ ийнхүү нилээд хугацаад тасарсан бөгөөд харин 1956 онд дахин сонсогдож эхэлсэн байна. Тэр үед буюу 1956 оны 2 дугаар сард ЗХУКН-ын ХХ их хурал, мөн оны 4 дүгээр сард МАХН-ын Төв Хорооны IV бүгд хурал хуралдаж, бие хүнийг тахин шүтэж байсны уршгаар нэг хүнд хэт их эрх мэдэл төвлөрч, хууль ёс зөрчигдөж, олон тооны гэмгүй иргэд, шудрага хүмүүсийг хэлмэгдүүлж байсныг илчлээд байсан үе юм.

Ийнхүү 1956 онд ДЯЯ-ны ажилд гарч байсан алдаа завхралыг илрүүлэн засах Ширэндэв даргатай комисс байгуулагдаж хэдэн сар ажиллаад цагаатгалын асуудал эрхлэх байнгын ажиллагаатай комисс байгуулах, 36 хүнд холбогдох хэргийг цагаатгах санал тавьжээ. Энэ саналын дагуу 1957 оны 7 дугаар сард АИХ-ын Тэргүүлэгчдийн дэргэд Цагаатгах комисс байгуулан ажиллуулжээ. Тус комисс 6 жил шахам ажиллахдаа 700 орчим хүний хэргийг цагаатгасан байна.

Үүнтэй зэрэгцэн 1959 оны 3 дугаар сард хуралдсан Намын Төв Хорооны III бүгд хурлаар Намын Хянан Шалгах Хорооны даргаар сонгогдсон Т.Гэндэн, 1930-1940-өөд онд “ардын хувьсгалын эсэргүүн”, “нам, засгийн дайсан” гэгч хэргүүдэд баривчлагдаж шийтгэгдсэн 40-өөд мянган хүн, үнэхээр хувьсгалын эсэргүүчүүд, ард түмнээсээ урвагчид, гадаадын тагнуул, төлөөлөгчид болчихсон хүмүүс мөн эсэхийг шалган тогтоох саналыг 1959 онд Намын Төв Хороонд оруулснаар “цагаатгал” нэртэй ажлын эрчийг нэмэхэд хувь нэмрээ оруулжээ.

Ингээд Намын Хянан Шалгах Хорооны дарга, Дээд Шүүхийн дарга, Ерөнхий прокурор, Сайд нарын Зөвлөлийн Хуулийн хорооны дарга, Улсыг Аюулаас Хамгаалах Газрын дарга (хожим Сайд нарын Зөвлөлийн орлогч даргаар солигдсон), Нийгмийг Аюулаас Хамгаалах Яам (НАХЯ гэх)-ны шалгах хэлтсийн дарга нарын бүрэлдэхүүнтэй

Намын Төв Хорооны шалгалтын комисс Т.Гэндэнгээр даргалуулан байгуулагдаж, тус комисс НАХЯ-ны Шалгах хэлтэст тулгуурлан 1959-1961 онд уг асуудлаар тусгайлсан ажлыг эхлүүлж, гүйцэтгэсэн байна. Тус комиссын шалгалтаар Лхүмбийн, Ёнзон хамбын, Гэндэн-Дэмидийн гэх зэрэг хувьсгалын эсэргүү байгууллага, бүлэг, Монгол Улсад огт байгаагүй, “хувьсгалын эсэргүүнүүд” гэгдэгчид үнэхээр ард түмнээсээ урвагчид, Японы тагнуул, төлөөлөгчид болсон байсан бус, гагцхүү Х.Чойбалсангийн хатуу дарамтад орсон Монголын аюулаас хамгаалах байгууллага хуулийг ноцтой завхруулж, хүмүүсийг үй олноор нь хилсдүүлэн хэлмэгдүүлж байсныг; хэлмэгдэгчдийг айлган сүрдүүлэх, зодож занчих, тарчлаан зовоох, тамлан туйлдуулах, “орос” аргаар хилс, зохиомол хэргийг хүлээлгэн, хүмүүсийг бууддаг байсныг; тэр завхралын жинхэнэ эзэн нь Оросын большевикууд, Сталины монгол дахь дуулгавартай гар хөл болон хувирсан улсын маршал Х.Чойбалсан байсныг тодорхой баримтуудаар нотлон тогтоосон дүгнэлтийг хийжээ.

Тус комисс 1930-1940-өөд оны их хядлага, яргаллын үед төр засгийн бүх эрхийг дангаар барьж байсан МАХН гэмт халдлагаас ард олноо хамгаалах талаар юу хийж, ямар үүрэг хариуцлагатай байсныг бүрэн дүүрэн гаргаж хэлж чадаагүйг онцлон тэмдэглэж байна. Харин Дотоод явдлын яам (ДЯЯ гэх)-ны үйлдсэн гэх алдаа завхрал, хэлмэгдүүлэлтийн талаар тодорхой баримтуудад түшиглэн түүхэн үнэнийг гаргаж ирсэнээрээ ач холбогдолтой болжээ. Тэр үед шалгалтын комисс “ДЯЯ намын хяналтаас гарч, намын дээр гарах болсноос л хэлмэгдүүлэлт явагдсан” мэт ташаа дүгнэлтийг хийж байжээ.

Шалгалтын тайланг МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо 1962 оны хаалттай хуралдаанаараа хэлэлцэж, мөн хоёр хоногийн дараа болсон Намын Төв Хорооны бүгд хурал бас хаалттай хуралдаанаар хэлэлцэж, аргагүй тодорхой баримт нотолгоонууд бүхий энэ шалгалтын дүнг МАХН албан ёсоор хүлээн зөвшөөрсөн байдаг. Гэвч улс төрийн хэлмэгдүүлэлтийн учир шалтгааныг бүрхэгдүүлж, гол гэм бурууг Дотоод Яамны сайд байсан Х.Чойбалсанд үүрүүлэн өнгөрөөжээ. Шалгалтын дүнгийн тухай мэдээллийг олон нийтэд хүргээгүй, зөвхөн МАХН-ын дээд шатны удирдлагын цөөн хүнд сонсгосноор хязгаарлаж, уг материал олон түмнээс нууцлагдан дарагдсан байна.

Ийнхүү цагаатгалын ажил нилээд эрчимжиж ирсэн боловч иргэдээ анги ялгаварлан хөнөөх МАХН-ын ангийн тэмцлийн үзэл хэвээр байсан явдал цагаатгалыг цаашид өргөжүүлэн явуулах боломжгүй байдалд хүргэсэн байна. МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1960 оны 17 дугаар тогтоолд ангийн хувьд

зайлшгүй шийтгэгдэх ёстой хүмүүсийг цагаатгах боломжгүй гэж үзсэн бөгөөд мөн МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1963 оны 22 дугаар тогтоолд ”МАХН-ын Төв Хорооны санаачлагаар сүүлийн жилүүдэд үргэлжлэн явуулсан судалгаа шалгалтын дүнд 1930, 1940/50)-иад онуудад төрийн эсрэг онц аюултай гэмт хэрэгт холбогдон ихэвчлэн бүлгээрээ хамтран шийтгүүлсэн хүмүүсийн хэргийн төлөв байдал нь тогтоогдсон“ гэж дүгнэжээ. Өөрөөр хэлбэл МАХН “хар, шар феодалууд”-ыг цагаатгахаас шууд татгалзжээ. Улмаар Улсыг Аюулаас Хамгаалах байгууллагын ажиллагаан дахь алдаа завхралаас болж хэлмэгдсэн хүмүүсийн хэргийг хэсэг бүлгээр нь шалгаж дуусгасан хэмээн үзэж, МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1962 оны 4 дүгээр тогтоолоор АИХ-ын Тэргүүлэгчдийн дэргэдэх цагаатгалын комиссыг татан буулгаж, цагаатгалын ажил зогссон байна.

1960-аад онд зогссон цагаатгалын ажил 1988 онд МАХН-ын Төв Хорооны комисс байгуулагдсанаар 3 дахь удаагаа сэргэжээ. Тун удалгүй монголын нийгмийн байгууллын үзэл баримтлал ул сууриараа өөрчлөгдөж, ардчилал, шинэчлэл эрчимтэй өрнөсөн үед буюу 1991 онд Цагаатгах Ажлыг Удирдан Зохион Байгуулах Улсын Комисс/цаашид ЦАУЗБУК гэх) байгуулагдаж хэлмэгдүүлэлтийн талаар бүрэн шинжлэн судлах, цагаатгах ажлыг шинэ шатанд гаргахаар ажиллаж эхэлсэн. Аль ч үед түүхийн үнэнийг бодитой тогтоож олон түмэнд элдэв чимэг засваргүй хүргэнэ гэдэг амаргүй бөгөөд хариуцлагатай ажил. Энэ ажлыг олон жил залгуулж зүтгэж явсан Сампилноров гуай болон түүний хамтран зүтгэгчдэд талархал илэрхийлэх ёстой.

1939 оны 4 дүгээр сараас хойш өнөөг хүртлэх хугацаанд нийт 30 гаруй мянган иргэний хэрэг хилс болох нь хууль хяналтын байгууллагуудын шалгалтаар тогтоогдон цагаатгагдсан, нэр төр нь сэргээгдсэн, үүний 25.5 мянга нь ЦАУЗБУК-ын үед шийдэгджээ. 6600 хүний хэрэг материалыг эдүгээ шалгаж байгаа юм байна.

1998-2010 (эхний хагас) онд гэм буруугүй атлаа хэлмэгдэж хохирсон иргэн, тэдний гэр бүл, үр хүүхэд, төрөл төрөгсөд нийт 17803 хүн 16.3 тэрбум төгрөгийг нөхөх олговор авсан нь нэг хүнд дунджаар 915600 төгрөг ногдож байна. 1991-2010 (эхний хагас) онд 9722 хүнд 110.8 сая төгрөгийн нэг удаагийн мөнгөн тэтгэмж (нэг хүнд дунджаар 11400 төг/, 470 хүнд 2.4 тэрбум төгрөгтэй тэнцэх үнэтэй орон сууц тус тус олгосон байна. Мөн хураагдсан хөрөнгөө нэхэмжилсэн 25 хэлмэгдэгчид 220 мянган төгрөг олгожээ. ЦАУЗБУК байгуулагдсан цагаасаа хойш 49 хөшөө, 114 суварга босгож, 17 музей байгуулж, 99 ном товхимол хэвлүүлж, 29 кино хийсэн буюу дэмжин тэтгэсэн хэмээн тайлагнажээ.

Хэлмэгдэгсдийн дурсгалын гэрэлт хөшөөг 1994 онд босгосон. Хэлмэгдэгсдийн музей 1996 оны 9 дүгээр сарын 10-нд байгуулагдсан.



“Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай” Монгол Улсын хууль 1998 онд батлагдсан. Жил бүрийн 9 дүгээр сарын 10-ны өдрийг “Хэлмэгдэгчдийн дурсгалыг хүндэтгэх өдөр” болгон тэмдэглэж байх болсон. Эдгээр чухал арга хэмжээг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн идэвхтэй оролцоо, дэмжлэг туслалцаа жинтэй хувь нэмэр оруулсан билээ.

Өмнө дурдсан мэдээллүүдээс үзвэл цагаатгалын ажил зарим үр дүнд хүрчээ. Цагаатгалын комиссын хийж бүтээсэн олон жилийн ажлыг үгүйсгэх гэсэнгүй, гэхдээ энэ үр дүн хэлмэгдэгчдийн шаардлагыг хангаж байгаа юу?

Улс төрийн талаар хэлмэгдэгчдийн дурсгал цагаан ном 1993)-д дурдсанаар 1921-1953 оны хооронд төрийн эсрэг гэмт хэрэг 40 гаруй удаа гарч 80000 орчим хүн холбогдон хэлмэгдсэн баримжаа тооцоо буй гэжээ. 1953 оноос хойш энэ тоо ихээхэн нэмэгдэнэ. Хэлмэгдсэн хүмүүс эхнэр хүүхэд, эцэг эхтэй. Ер нь Монголд хэдэн хүн хэлмэгдсэн, эдгээрийн хэд нь амьд сэрүүн байна вэ? Цагаатгалын ажлыг ингэсгээд дуусгах хэрэг үү?

Өмнө дурдсанаар хэлмэгдсэн 30000 орчим хүнийг цагаатгаж, харин цагаадсан иргэн болон тэдний төрөл төрөгсөд 17803 хүнд нөхөх олговор олгосон гэжээ, бусдад нь хэзээ нөхөх олговор олгох вэ? Нэг өрх 5 ам бүлтэй гэвэл (30000\*5) 150000 хүн болно. Нэг хэлмэгдэгчид дунджаар 900000 төгрөгийн олговор, 11000 төгрөгийн тэтгэмж олгожээ. Энэ хөрөнгө тухайн хэлмэгдэгчид хэр тус нэмэр болох вэ?. Хэлмэгдэгчиддээ арай илүү зүйл хүртээж санаачлага гаргаж байв уу?

Ардын хувьсгалын жилүүдэд болж өнгөрсөн аймшигт аллага, таллага, хэлмэгдүүлэлтийн талаар олон түмэндээ, залуучууддаа, хойч үедээ системтэй мэдээлэл өгөх ажлыг яагаад санаачлахгүй, зохион байгуулахгүй байна вэ?

Хэлмэгдүүлэлт, дахин давтагдахаас сэрэмжлэх талаар ЦАУЗБУК-оос өнгөрсөн хугацаанд ямар ажил зохион байгуулсан бэ? Цаашид хэлмэгдүүлэлт гарахгүй гэх баталгаа бий юу?

Гэмгүй иргэдээ үй олноор нь алан хядсан энэ гэмт хэрэг зөвхөн хэлмэгдүүлэлт байсан уу Энэ асуудлаар ЦАУЗБУК-ын зүгээс эрх бүхий байгууллагад хандаж байв уу? гэх мэт олон асуудал хариу хүлээж байна.

МАН байгуулагдсаны 90 жилийн ойн баярын хуралд МАН-ын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд тавьсан илтгэлдээ “Их гүрнүүдийн геополитик, Коминтерн, Бүх холбоотын коммунист (Большевикуудын) намын тулгалтаар хийсэн улс төрийн хэлмэгдүүлэлт Монгол орныг нөмөрч, энэ хэлмэгдүүлэлтэд хамгийн түрүүнд намын

удирдлага, гишүүд өртөж, манай нам, төр, ард түмнийхээ хамт гашуун зовлон амссан. Улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртөн амь насаа алдсан, эд хөрөнгө, сэтгэл санаагаар хохирсон иргэд, албан хаагчид, цэргийн дарга нар, лам хуврага, намынхаа гишүүдийн ах, дүү, төрөл төрөгсөд, үр, ач нарт гүн эмгэнэл илэрхийлж, хэлмэгдүүлэлтийг таслан зогсоох, газар авхуулахгүй байх талаар хүчин мөхөстөндөө ард түмнээсээ МАН дахин уучлалт хүсч байна...Хэлмэгдэгсдийг цагаатгах ажил үргэлжилж, одоо үндсэндээ шувтарч байна” гэжээ. Энэ нь монголын ард түмнээ уучилт гуйсангүй, харин намын гишүүдээсээ уучлалт гуйж байгаа дүр зураг харагдаж байна.

### **Тав. Цагаатгах үйл ажиллагаанд хийх үнэлэлт, дүгнэлт зорилт**

Цагаатгалын үйл ажиллагааны байдлыг тоймлон авч үзлээ. Монгол хүн чонын сүрэгт боорлуулсан эзэнгүй сүрэг шиг арга тасарч, алуулж талуулж ирсэн аймшигт үзэгдэл түүхийн хог дээр нэгэнт хаягджээ. Монгол оронд ардчилал шударга ёс тогтож, төлөвшиж байна. Монгол Улс хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн хүнлэг ардчилсан, иргэний нийгэм байгуулах шинэ сонголтоо бүх нийтээрээ хүлээн зөвшөөрч хэрэгжүүлж эхлэв. Гэвч ажилгүйдэл ядуурал байсаар байна. Эрх мэдэл, албан тушаал ашиглан гэмт хэрэг үйлдэх явдал ноцтой түвшинд хүрчээ. Хэлмэгдүүлэлт давтагдахаас бүх талаар сэрэмжлэх, үүний тулд бүхий л мэдээллийг нээлттэй болгох шаардлагатай байна.

Насанд хүрсэн 5 эр хүн бүрийнхээ 1-ийг буудан алсан гэм нүгэлтнүүд улс төрийн тавцанд нөлөөтэй хэвээрээ явсаар өнөөдрийг хүрсэн. Тэд үйлдсэн жигшүүрт хэргээсээ бултан тойрч, илрүүлэх илчлэх, сэргээх сэдэрээх замыг хамаг хүчээрээ хааж ирсэн. Цагаатгалын комиссын ажил урагшлахгүй байсан нэг ноцтой шалтгаан чухамхүү үүнд оршиж байсан. Монголын шинэ төрд хэлмэгдүүлэлтийг далдлах, халхлах шалтгаан байхгүй баймаар. Энэ хэрэгт одоо зоримог шинэчлэл, санаачлага шаардагдаж байна.

Хүний заяагдмал болон олдмол эрх хаа сайгүй зөрчигдсөөр байна. Зөрчил хэтэрвэл дур зоргын үйлдэл буюу анархизмд халтиран орж болзошгүй. Монгол хүмүүний хамгаалалт бэхжиж чадаагүй, хэврэг хэвээрээ байна. Хэлмэгдүүлэлт давтагдсаар цаашид ч үргэлжилсээр байх төлөв, хандлагатай байна. Цагаатгалын комиссыг татан буулгах биш, ажлынх нь үр өгөөжийг улам эрчимжүүлэх, олон нийтийн үүсгэл санаачлагын байгууллагууд иргэдтэй нягт хамтран ажиллах явдал чухал байна.

Хэлмэгдэгсдийн шарх эдгэрээгүй, шаналсаар байна. Хэлмэгдэгсэд тэдгээрийн гэр бүл, үр хүүхдүүд бол нэгд, хамаг хөрөнгөө дээрэмдүүлсэн, хураалгасан ядуу хүмүүс; хоёрт, эмнэлгийн

тусламж авах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ хасуулсны улмаас өвчин зовлонд баригдсан, эрэмдэг зэрэмдэг болж үлдсэн хүмүүс; гуравт, үе удмаараа мэдээллээс таслагдаж, мэдлэг боловсрол олох ямар ч боломжгүй нөхцөлд хамаг амьдралаа үдсэн хүмүүс; дөрөвт, байнгын хардлага, хавчилт, мөрдлөгө хяналтын дор явж, бухимдаж цөхөрсөн, элэгдэж эмтэрсэн хөөрхий хүмүүс; тавд, энд дурьдсан бүхний эцэст хатаагдаж ширээгдсэн, харин гэм нүгэл үйлдээгүйгээ мэдэхийн учир хугарч нугараагүй, босоогоороо үлдсэн эгэл баатрууд. Эдгээр хүмүүст шинэ цагийн Монголын төр бүх талаар туслах шаардлагатай байна.

Цагаатгалын ажил 1991 оноос өмнө эрч далайцтай ажиллаж чадаагүй нь тодорхой байна. Учир нь тэр үед ангийн тэмцлийн онолд суурилсан улс төрийн бодлого хэрэгжиж байв. Эрх баригч МАХН “жинхэнэ ард”-аас бусад нийгмийн давхрагыг дайсан хэмээн үздэг. Хөрөнгө чинээтэй хүмүүс, лам нар, сурвалжит ноёд, түшмэл, тайж нар нэгэнт ангийн дайсан тул буудан алах ёстой. МАХН, Коминтерн болшевикуудтай нийлж ангийн тэмцлийг сайн зохион байгуулж хэрэгжүүлсэн нь түүхэн үнэн. МАХН-ын хувьд дайснаа цагаатгах, өршөөх, хамгаалах ямар ч боломжгүй гэсэн сэтгэлгээ ноёрхож байжээ. Нийгэмд ийм сэтгэлгээний үлдэгдэл одоо ч оршоор байгаа нь болгоомжлох асуудал мөн. Цагаатгалын ажилд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгээс гадна эрх зүйн шаардлагатай орчныг бүрдүүлэх, үзэл бодлын шинэчлэлт хийх шаардлагатай байна. Дор дурдсан саналыг толилуулав байна. Үүнд:

- Монгол улсын түүхэнд тохиолдсон эмгэнэлт, гутамшигт үйл явдал, бидний хэлж заншсанаар хэлмэгдүүлэлтийн эх сурвалж, хор уршиг, эзэн холбогдогчыг олон нийтэд ил тод зарлан мэдээлэх, хүүхэд, залуучууд, нийт иргэдийг хамарсан сургалт, сурталчилгаа явуулах ажлыг шинэ шатанд гаргах
- Улс төрийн хилс, зохиомол хэргүүдийг хэрэг бүрээр судлаж, цагаатгах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх
- Монголын түүхийн өв соёл, сүм хийдүүд, эмгэнэлт дурсгалт газруудын байршлыг тогтоох, багана босгох, дурсгалт цогцолбор байгуулах
- Монгол Их Гүрний хаад, нэрт жанжингууд, Чингис хааны алтан ургийнхан, Монголын Улсын тусгаар тогтнолын төлөө тэмцэгч, төр нийгмийн зүтгэлтнүүдийн түүхэн танилцуулга бүтээж, сурталчилгааны ажлыг өргөн хүрээтэй зохион байгуулах,
- 1932 оны “Зэвсэгт бослого”, ор сураггүй алга бологсдын асуудал болон барга, үзэмчиний олзлогдсон цэргүүдийн талаар судалгаа явуулж, цагаатгах талаар улс төрийн шийдвэр гаргах ,

- 1929-1932 онд феодал, лам нарын хөрөнгө хураах, 1932-1941 онд улс төрийн хилс хэрэгт холбогдогсдын хөрөнгө хураах, 1956-1959 онд нэгдэлжих хөдөлгөөний үеэр иргэдийн мал сүргийг нийгэмчлэх болон дахин нийгэмчлэх зэргээр ард иргэдийн хувийн өмч, хөрөнгөд халдаж, хураасан хэргийг нарийвчлан судалж, хохирлыг барагдуулах арга хэмжээ авах,
- Тагнуулын Ерөнхий газрын тусгай архивын баримт материалыг хуульд заасан журмын хүрээнд ил тод, нээлттэй болгох,
- Үндэсний монгол бичиг үсгийг устгасан тухайн үеийн төр, засгийн шийдвэрийг хүчингүй болгох, энэ аугаа соёлыг “цагаатган” сэргээж, Олон улсын “ЮНЕСКО”-ын өв соёлд бүртгүүлэн хамгаалах,
- Хэлмэгдүүлэлт давтагдах улс төрийн шалтгааныг арилгахыг эрмэлзэх, нийт иргэдийн намын харьяаллыг цуцлах,
- Улс төрийн хэлмэгдүүлэлтийн талаарх судалгааг тогтмол хийж, үр дүнгээр нь үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, чуулган зэргийг тогтмол зохион байгуулж байх,
- Улс төрийн хэлмэгдэгдүүлэлтийн түүхэн зурагт фото альбом бүхий “Хар ном” хэвлэн гаргах,
- Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын болон төрийн ажил үйлчилгээг Монголын Улс төрийн хэлмэгдэгсдийн холбоогоор гүйцэтгүүлэх боломжийг судлаж, хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх,
- Монголын улс төрийн түүхийн судалгаа, түүх бичлэг, кино урлаг, хөшөө дурсгалыг үзэл сурталжсан, коммунист сэтгэлгээ, хэв загвараас ангижруулах урьд өмнө судалгаанд хамруулаагүй зориудаар үлдээсэн бүлэг асуудлуудыг нарийвчлан судалж “түүхийн хар толбо”-ыг арилгах,
- Жил бүрийн 9 дүгээр сарын 10-ны өдөр хүний эрхийн асуудлын талаарх тайланг, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд хэлэлцдэг журам тогтоож, энэ асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг гарган зохицуулах,
- Олон улсын хүний эрхийн байгууллагын эрх зүйн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын хүлээсэн үүрэг хариуцлагын үүднээс “Хүний Эрхийн Ордон” бүтээн байгуулах зэрэг болно.

Улс төрийн талаар хэлмэгдэгсдийг цагаатгаж, нэр төрийг нь сэргээх, хэлмэгдүүлэлт давтагдахаас урьдчилан сэргийлэх, иргэнд учруулсан хохирлыг нөхөн төлөх зэрэг асуудлуудыг зохицуулах хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох, холбогдох эрх зүйн орчин бүрдүүлэх явдал чухлаар шаардагдаж байна.

### Ном зүй

1. Монгол улсын үндсэн хууль. УБ. 1992 он
2. БНМАУ-ын Их бага хурлын тогтоол, Үндсэн Хууль, тунхагууд. УБ. 1956 он.
3. Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлт (1921-1940 он) эрдэм шинжилгээ судлалын бага хурлын илтгэлүүд. УБ. 2010 он.
4. МАХН-ын түүхийн лекц . Нэгдүгээр дэвтэр. УБ. 1980 он.
5. МАХН-ын товч түүх. УБ. 1985 он.
6. МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. УБ. 1966 он.
7. Редактор П.Туваанжав. Хэлмэгдүүлэгчид гэж хэн байв. УБ. 2008 он
8. Монгол ардын намын түүх. III боть. УБ. 2011 он.
9. А.Думбурай. Залхаан цээрлүүлэлт. УБ. 1997 он.
10. Ю.Цэдэнбалын удирдсан нэгэн бүгд хурал. Маш нууц баримт. УБ, 1990 он.
11. Б.Гончигсүрэн. МАХН-аас явуулсан албан татварын бодлого. УБ.1973 он.
12. МАХН-ын түүхийн лекц . Хоёрдугаар дэвтэр. УБ. 1980 он.
13. Хүний эрх, олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхэтгэл.УБ 1976 он
14. Ц.Навагчамба. Хэлмэгдсэн заяа 38. УБ. 2004 он.

## ХЭЛМЭГДЭГЧИЙН НЭР ТӨР, ХҮНИЙ ҮНЭ ЦЭНЭ



*Ш.Цэрэндоо  
Шинжлэх ухааны тэргүүний ажилтан*

Нэр төр нь нэр хүнд гэдэг категоритой холбоотой, ёс суртахууны ухамсрын ухагдахуун, ёс зүйн категори. Энэ ухагдахуун хүн өөрөө өөртөө болон түүнд нийгмийн зүгээс хандах харилцааг нээн илэрхийлдэг. Нэр төрийн ухагдахуун бие хүний ёс суртахууны үнэт чанарыг, хүний нийгэмд эзлэх тодорхой байр, түүний эрхэлж буй ажлын төрөл зүйл, байгуулсан гавьяаг илэрхийлнэ. Бие хүний нэр төрийн хувьд бол хүний гавьяаг юуны өмнө хөдөлмөрийг анхааран үзэх бөгөөд эдгээрээс шалтгаалан түүнийг хүндлэх, дээдлэх хэмжээ тодорхойлогдоно. Хүнийг нийгмийн зүгээс үнэлэх үнэлгээ юм.<sup>1</sup>

I: Өнөөдөр хэлмэгдэгсдийн болон тэдний ойр төрлийнхний нэр төр, алдар хүнд, эрхэм зэрэг эрхэм чанар гэх асуудал тун эмгэнэлтэй, сөхөж тавьдаггүй явж ирсэн нарийн зүйлийг би эхлээд хөндөх гэсэн юм.

Нийгэмгүйгээр хувь хүн, хүмүүн үгүйгээр нийгэм оршин тогтнохгүйтэй адил нийгмийн дотор хүлээн зөвшөөрөгдөхгүйгээр бие хүн төлөвшиж, хөдөлмөр, ур чадвар, авьяас билгээ гаргах бололцоогүй. ХҮИ зууны билэг цэцэн Саган тайж

**“Язгуур төрөөд сац өгтсөн энхэрийн нэр**

Идэр бүхий алдрыг зөөсөн дуурьсах нэр

Имагт хойтсоо дурдадахуй мөнх нэр

Илт бүрдвээс хүний биеийн гавьяа тэр” гэж бичсэн нь хүний хөгжлийн үе шаттай хамт нэр нь хөгжиж алдаршиж байдгийн гаргаж тавьсан. Хүний нэр төр, алдар хүнд, хүнлэг чанар, эрхэмсэг оршихуй, хүний үнэлэмжийг бүхэлд нь хүний эрхэм чанар гэх боллоо.

<sup>1</sup> Монгол хэлний товч тайлбар толь. УБ 1966 он.



Монгол улсад улс төрийн хилс хэргээр иргэдээ хэлмэгдүүлсэн үйл ажиллагаа нь тухайлсан зорилготойгоор зохиомол хэрэг дэглэн эн тэргүүнд эх оронч, үндэсний үзэлтэн, учир танисан сэхээтнүүд, нэрд гарсан, хүндтэй болсон буюу өөрөөр хэлбэл тодорхой хүндэтгэл авсан хүмүүсийг баривчлан хэлмэгдүүлсэн байдаг юм. Тодорхой хэлбэл улс төрийн хилс хэргээр шийтгүүлсэн гучаад мянган иргэн бол цөм нийгмийн идэвхтэй гишүүнээс манлайлагчид нь явсан “эрхэм чанартай” хүмүүс байна.

Ойрын жишээ: ТӨВ аймгийн иргэдийн хэлмэгдүүлэлт 1922 оноос эхлэв. Бодоо, Чагдаржав, Лувсанцэвээн тэргүүн гэх мэт. Тус аймгаас хэлмэгдсэн 2930 хүний дотор

*Хаант Монгол улсын Ерөнхий сайд*  
*Ардын түр Засгийн газрын анхны дарга, Сангийн яамны сайд*  
*Ардын Засгийн газрын Ерөнхий сайд, Гадаад яамны сайд*  
*Хүрээний сайд*  
*МАХН-ын ТХ-ны тэргүүн дарга мэт дээд албан*  
*тушаалтан 40-өөд,*  
*Д.Бодоо, Д.Нацагдорж, Цэрэн-очир мэт авьяастнууд*  
*Монгол Ардын хувьсгалт цэргийн зүтгэлтнүүд:*  
*Бүх цэргийн жанжны орлогч, дэд жанжин*  
*Жанжин штабын даргаас эхлээд офицерууд*  
*Лам хуврагуудаас:*  
*Хутагт хувилгаан 8*  
*Хамба, дэд хамба 2*  
*Да лам 1,*  
*Агирамба 109*  
*Гавж 873,*  
*Гэсгүй 98*  
*Ловон 8,*  
*Мэргэч 7*  
*Зурхайч 5*  
*Унзад 67*  
*Аранжамба 21,*  
*Маарамба 20*  
*Авралч лам 13,*  
*Гүрэмч 248*  
*Лүйжинч 2,*

Жир лам 635 Бүгд 2030 хүн болно. Лам хуврагууд бол ямар ч атугай багш нар, тухайн тухайн хүрээлэлдээ алдар хүндтэй. Зөвхөн дээрх тооноос харахад эрдмийн цол зэрэгтэй, шашин соёлыг тээн явагчид, тэр цагийн Монголын оюуны соёлын сангууд байжээ.



Монгол элгэн зуураа ямар боловч ширүүн гараар хөдлөхгүй буй за хэмээн итгэх тул Ардынхны өмнөөс эсэргүүцэлгүйгээр найрамдахыг хичээвээс зохино. Аймаг савыг баригач ачит номун хан, эрдэнэ мэргэн Манзушри хутагт, Богд хаант Монгол улсын сүүлчийн Ерөнхий сайд Самбадондовын Цэрэндорж.



“Манай монголчууд одоо нэгэнт тусгаар төр байгуулж өөртөө эзэрхэх эртэй болсон бөгөөд үүнд ашгийн хөрөнгийг хуваарилан чадах ихээхэн пүүс нээн байгуулсангүй. ...Даруй энэ зүйлийн хэргийг хурдавчлан үүсгэн нээж шийтгэвээс олон монголчууд элдэв хэрэглэгдэхүүнд боогдон гачигдаж, бусад улсын зальт худалдааны хүнд ам санааны дураар идэгэн мөлжигдөхгүй”

*Ардын түр Засгийн газрын анхны дарга, Сангийн яамны сайд Дамбын Чагдаржав*



“Албан газарт нүгэл хийхүйеэ үнэхээр хялбар

Арван буяныг хураах хэмээвээс мөн ч бэрх”

“Чоныг дүрсэлж арьсыг зуравч ясыг зурахуйяа бэрх

Царайг үзэж хүнийг танивч зүрхийг танихуйяа бэрх”

*Ардын Засгийн газрын анхны Ерөнхий сайд,  
Гадаад яамны сайд Догсомын Бодоо*



“Би бол тус Монгол овогтны үндсийг хамгаалах бодлогыг хэзээнээс бодож эрмэлзсээр ирсэн, одоо нас өтөлсөн боловч миний ийнхүү хүсэл бодлого хэвээрээ билээ”

*Эрдэнэ жонон ван Ширэндамдин*



Алтан ургийн тайж, Хаант Монгол улсын Сангийн яамны тэргүүн сайд, Гомбожавын Лувсанцэвээн жанжин.



“Монголын ард түмэн ямар ч тохиолдолд тусгаар тогтнолоо хамгаалах болно”

*МАХН-ын Төв Хорооны тэргүүн дарга, ардын хувьсгалын партизан, зохиолч Цэрэн-Очирын Дамбадорж*



Цэргийн яамны орлогч сайд бөгөөд бүх цэргийн жанжны орлогч, корпус командлан захирагч Цэрэнжавын Лувсандоной



“Ямар ч хэрэг төвөг өдүүлээгүй үнэнч шударгачууд өдий төдийгөөр баривчлагдан хилс хэлмэгдэж буйн гай гамшгийг биеэр үзэх нь гарцаагүй боллоо. Дотоод яамныхан, нэг бол амь насанд тулсан хүнд хэрэг тулгаж сүрдүүлэн сөхөө сэхээ авах чөлөөгүй мөрдөн байцаана. Эсхүл уг дуугүй хорьж өлбөрөх ядрахын туйлд хүргэж үхүүлэх юм уу, буудан ална”

*Мал тариалангийн яамны нэгдүгээр орлогч сайд, “Үнэн” сонины хариуцлагатай эрхлэгч Өвгөөдэй хэмээх Цэндийн Дамдинсүрэн.*

Хувийн нэр хүнд дээр албан тушаалын, эрдэм боловсролын, багш авралчийн нэр хүнд эдгээр хүмүүст жин дарж байгааг тааварлаж цөхөх юмгүй.

*\*Нэг дээр НЭР*

Хоёр дор АЛДАР

*\*Нэрийн төлөө нэхэж*

Үрийн төлөө үхнэ

*\*Нэр хугарснаас яс хугарсан нь дээр*

*\*Нэр гутахад толгой гутах*

*\*Нэрээ алдвал-хүндээ гээх*

Нэхийгээ гээвэл хүйтэнд даарах

Монголын ард түмний хэлсэн үгс

Нэр төр гэдэг бол хүмүүн нийгмийн дотор тодорхой үнэ цэнэтэйгээ хувь хүн өөрөө ухамсарлах явдлыг илэрхийлж, басхүү нийгмийн

зүгээс тэрхүү үнэ цэнийг нь хүлээн зөвшөөрөхийг илэрхийлдэг ёс зүйн ухагдахуун юм.

Улс төрийн хилс хэргээр хэлмэгдүүлнэ гэдэг бол хүний эдгээрхүү нэр алдар хүндийг гутаан доромжилж, нийгэмд хүнийг үнэ цэнэгүй болгож байгаа хэлмэгдүүлэлт мөн.

Аль наяд жилийн тэртэй бузарлагдан гутсан нэрийг өнөөдөр хэрэг ялаас цагаатгасан гэсэн ганц үгээр ариутгадаг, сэргээдэг ч юм биш байна.

Нэр төртэй холбоотой “эрхэм зэрэг” гэж ухагдахуун бий. Энэ бол хүн өөрөө өөрийгөө үнэлэх үнэлгээ юм. Хүнд эрүү шүүлтийн тамлагаанд, хүчээр элдэв муу үйлдэл хийсэн мэтээр гарын үсэг зурсан буюу хурууны хуараа даруулсан, буудуулсан хүмүүн хэрхэн тэр “эрхэм зэргийг” эдлэхсэн билээ.

Ясан төрлийн гол зангилаа болсон эцгүүдийн нэр төр гутаагдсан нь тэр өрх амын, ялангуяа үр хүүхдийнх нь хувьд “муу нэрийг хусавч үл арилах” зарчмын дагуу өнөө хүрснийг тооцож хууль ёсны дүгнэлт гаргах ёстой. Ахлах хүндлэх ёс алдагдаж, зөвхөн “эсэргүүгийн хүүхэд”, хамаатан садан гэгдэж нутаг усныхан тэднээс “зай барьж”, “гахайн хүү гахай” буюу “эх хээр алаг бол унага нь шийр алаг” байдаг жамаар “мэдээтэй явахыг” хойч хойчдоо захисан нь өнөө ч уламжилсаар авай.

Үр хүүхдэд эцгийн нэр нь хэзээд амьд байдаг

Үр хүүхдүүдэд эцгийн мөрөөдөл нь ямагт үлдсэн байдаг<sup>2</sup>

Доромжлох: басамжлах, дээрэлхэх, дарлах

Басамжлах: хялбар доройд үзэж дайрах, дээрэнгүйлэх

Гутаах: гутаахад хүргүүлэх

Гутах: буурч доройтон зовних<sup>3</sup>

Бие хүний аз жаргал нийгмээс ангид байж болохгүй нь өвс ургамлыг хөрс шорооноос нь таслан авч улаан цулгүй элсэн дээр хаявал ургахгүйтэй адил (А.Н.Толстой)

Хүнд гай зовлон, муу зүйл учруулах нь тийм ч ухаан зарж цөхөх зүйл биш ээ. Харин хүнд аз жаргал хайрлах нь асар хүнд байдаг. (М.Горький)<sup>4</sup>

2 Шашдирын чуулган. УБ 2013 он. Т.30.

3 Монгол хэлний товч тайлбар толь. УБ 1966 он.

4 Эрүүл энхийн мөнхийн хүслэн (мэргэдийн сургааль). УБ 1988 он. Т.188.

## Нэр төрийг гутаан доромжилсон хэлбэрүүд:

### 1.Анги, бүлгийн байдлаар нь дуудаж гутаах

- Хар шар феодалын хүүхэд, хатан, эхнэр, хамаатан садан
- тайжийн, ноёдын
- ламын...

### 2.Хоч нэр өгч дуудах даажигнах басч доромжлон доог шоог хийх

- Сохор богд
- шар хувалз
- хувьсгалын эсэргүү
- япон тагнуул
- ангийн дайсан...

### 3.Баримтаар доромжлох

- сонин хэвлэл дээр нийтлэгдсэн зургийг нь сохлох
- хэвлэлд нийтлэгдсэн нэрийг нь баллах
- шог хошиноор зурж хэвлэлд нийтлэх

### 4.Хандлагаар гадуурхан доромжлох

- төр засгаас зориуд зохион байгуулсан гадуурхлын явуулгаар
- нийгмийн сайн сайхан үйл ажиллагаанд оролцуулахгүй хасах
- нам, олон нийтийн байгууллагын гишүүнд элсүүлэхгүй
- хийсэн бүтээснийг нь эс ойшоох, эс үнэлэх
- сургуульд суралцуулахгүй орхих
- хамгийн хэцүү хүнд ажилд дайчлах
- халамж анхаарлын гадна орхих
- Дотоод яамныхан ямагт “анхааран ил, далд халамжилж”

Ийм байдлаар монголын нийгэмд улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсэд, тэдний гэр бүл, үр хүүхэд, төрөл садны хүнийг хажиглан ганцаардуулан гадуурхаж хавчих үзэл ба суртал сэтгэлгээ, хандлага, үйл ажиллагаа бодитой хэрэгжсэн юм.

### Үр дүн:

Нийгэм болоод амьдралд ИТГЭЛГҮЙ болж, СЭТГЭЛ ГУТРАЛД оржээ.

*“Өөрийгөө хүмүүст хэрэгтэй гэдгээ ухаарах нь амьдралын хамгийн их эрхэм баяр баясгалан, эрхэм зүйл”* (М.Горький)<sup>5</sup>

Манай эрдэмтэд, судлаачид, сэтгүүлч, зохиолчид улс төрийн хилс хэргээр егүүтгэгдсэн төр, нам, нийгмийн зүтгэлтнүүдийн заримынх нь амьдрал, үйл ажиллагаа, үзэл сэтгэлгээг сурвалжлан судалж намтар,

5 Эрүүл энхийн мөнхийн хүслэн (мэргэдийн сургааль). УБ 1988 он. Т.188.

найруулал бичиж түүхэнд эзлэх байр суурийг нь сэргээж байгаа эхлэлийг хэн бүхэн сайшааж байна. Ингэх ёстой.

Дүгнэж хэлвээс: Хүний нэр төр хууль ёсоор үнэ цэнтэй, үнэлгээтэй. Сүүлийн жилүүдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр гүтгүүлж доромжлуулсан хүмүүс нэр төрөө сэргээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргаж хэдэн арван сая төгрөг гэж дуугарч байгаа баримт бий. Ингэх ёстой.

Тэгвэл Монголын төр хилс хэрэгт хэлмэгдүүлсэн 30 гаруй мянган иргэнийнхээ нэр төрийг гутаасных нь төлөө нөхөн төлбөр төлөх ёстой. Үүнийг бид шаардах эрхтэй.

Монгол улсын хүний эрхийн байгууллагууд, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд яагаад энэ зүгт анхаарч нэхэмжлэл гаргахгүй байгаа нь эрх зүйн мэдлэг мэдээлэл дутуугийнх биз.

Сүүлийн жилүүдэд ЦАУЗБУК-ын дэргэдэх Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн судалгааны төвийн судлаач эрдэмтэд “Улс төрийн хэлмэгдэгсдийн намтрын товчоон” цуврал ботиуд хэвлэн нийтэлж нилээд хэдэн хүний намтрыг хэвлэн гаргав. Төр засаг, нам, иргэний байгууллагууд түүхээ овоо шинэчилж хэлмэгдсэн удирдагчид, зүтгэлтнүүдийнхээ нэрийг зохих байранд нь оруулж байх шиг байна. Аймаг сумд ойн баяраараа түүхийн ном бичүүлж түүндээ бас хэлмэгдэгсэдээ дурдаж, зарим иргэд ургийн уулзалт баяр хийхдээ өвөг дээдсээ хүндэтгэн дурсах ажил хийдэг болж байна. Ингэх ёстой.

Гэвч хилсээр хэлмэгдсэн иргэн, тэдний үр хүүхэд, төрөл төрөгсөд, нутаг усныхны сэтгэлд хүрч нэр төрийг нь сэргээгээл мөн ч өдий байна даа.

Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.<sup>6</sup>

Монгол улсын Үндсэн хуульд “Хүний эрх, нэр төр, алдар хүнд”-ийг “хуулиар хамгаална”<sup>7</sup> “хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх”<sup>8</sup> тухай заалт бий. Эдгээр заалт хэр зэрэг хэрэгжсэн бэ? Нэрээ олж авсан хүн хэд байгаа вэ? Өнөөдөр үүнд хариулт алга

**II: Төрийн хууль цаазаар амь насыг нь бүрэлгэсэн, шоронд зовоосноо хилс явдал байлаа гээд засаг буруугаа хүлээчихлээ. Үүний хариу хэлмэгдсэн иргэд, тэдний нэхэмжлэгчидэд яаж ирээв ээ? Монгол хүний амь нас үнэ цэнэгүй, монгол хүн эрхэмлэгдэх үнэ цэнэгүй юу?**

6 Монгол улсын Үндсэн хууль. Хоёрдугаар бүлэг.14.2.

7 Монгол улсын Үндсэн хууль. Хоёрдугаар бүлэг.16.17.

8 Монгол улсын Үндсэн хууль. Хоёрдугаар бүлэг.17.2.



## ХҮНИЙ ҮНЭ ЦЭНЭ

Хорвоогийн гайхамшиг хүн.

Хүний гайхамшиг нь ухаан

А.Гамильтон

“Хүн бол асар их бүтээлч хүч, цоо шинийг санаачлан ургуулагч гайхамшигтай бүтээлч чанар юм.

Хүнийг ерөнхийд нь өнгөц харвал цөмөөр хувь шинж, хувь төрх, хувь үзэл бодол, зорилго чиглэл, арга барил, үр бүтээл мэт. гэсэн ч нарийвчлан үзвэл ердөө л цэвэр “би” биш, маш даяаршмал, нэгдмэл цогц ертөнц юм”<sup>9</sup>

Хүн бол нийгмийн бүх харилцааны цогц юм.

Хүнтэй цуг хөгждөг дөрвөн гол зүйл буй

1-рт: Хөдөлмөр

2-рт: Мэдлэг

3-рт: Соёл

4-рт: Хүмүүжил

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгч Монгол хүн?

- Монгол нутаг дэвсгэрийнхээ гол эзэн нь явсан
- Монгол эх хэлээ тээгч эзэн нь
- Олон ус үндэстний эв нэгдлийг эрхэмлэгч, хамтын хүчний эзэд
- Монгол засаглалын эзэд
- Монгол бүтээлийн эзэд
- Монгол мэдлэг, соёл, зан заншил, ёс суртахуун, хүмүүжлийн эзэд
- Таван хушуу малаа амьдралын баталгаа болгосон малчин<sup>10</sup>
  - Мал маллах эрдэм ухаан, арга барилд мэргэшсэн
  - малынхаа ашиг шимийг гар аргаар боловсруулж, гар үйлдвэрлэл хөгжүүлж хэрэглээгээ хангасан
  - Аян жин тээж, арилжаа худалдаа хийдэг
  - Гар урлал, газар тариалан эрхэлсэн
  - Ан гөрөө хийдэг, олзборыг бүрэн боловсруулдаг
  - Төрийн хэргийн зохих мэдлэгтэй, хууль журам сахидаг
  - Сүм дацанд суралцсан, хурал номд хурсан, шашин соёлын мэдлэгтэй
  - Сэтгэлгээний ном бүтээл туурвисан

9 “Хүн” алдрын гайхамшиг. III боть. УБ 2016 он. т.288.

10 “Хүн” алдрын гайхамшиг. III боть. УБ 2016 он. Т.233-236.

- Анагаах ухааны монгол болон дорно дахины туршлагатай гэх мэт

Нэр төр дээр хүний өөрийнх нь үнэ цэнэ гэж том асуудал нэмэгдэх ёстой гэж бодож байна.

Нөхөх олговор үүнд харилт өгсөн үү? өгөөгүй. Нөхөх олговор юунд хариу өгөв өө?

Алдар нэрийн төлөөс нөхөөс үү?

Амь насны төлөөс нөхөөс үү?

Авсан хураасан хөрөнгийн төлбөр үү?

Аль эсвэл юуных ч биш үү?

Хүний амь нас үнэтэй юу? Үнэтэй. Баримт:

**2008 оны ҮII сарын 1-ний өдөр** нийслэл Улаанбаатар хотод үүссэн олон нийтийн эмх замбараагүй байдлын үеэр буудуулж амь үрэгдсэн 5 хүний ар гэрт зориулж “Хохирогчид нөхөх олговор олгох тухай хууль” 2009 оны ҮII сарын 9-нд гарч ”Амь насаа алдсан иргэний ар гэрт тус бүр 50 сая төгрөг” олгожээ.

Төр монгол иргэний амь нас 50 сая төгрөгтэй тэнцэнэ гэж анх удаа үзсэн шиг байна.

Дүгнэлт: Үүгээр би монгол хүний амь насны нөхөн төлбөр гэж байх ёстойг хэлж байгаа юм шүү.

### **III: Хураагдсан хөрөнгө:**

“НӨХӨХ ОЛГОВОР ХЭМЭЭХ АРГА ЗАЛЬ” байсан шүү. Хэлмэгдэгчид хураагдсан хөрөнгөө нэхэхэд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс 1990 онд гаргасан цагаатгагдсан хүмүүст учирсан хохирлыг нөхөн арилгах тухай 119-р зарлигийг баримталж байлаа. Уг нь хураагдсан хөрөнгийг нь тэр үеийнх нь ханшаар бодож санхүүгийн болон Аюулаас хамгаалах газрын төв архивт байгаа юм хураасныг нотлох албан ёсны баримтыг үндэслэн өөрт нь олгож байхаар заасан байдаг.

Энэ зарлиг нь сайтар бодож хийсэн хоёр үндсэн цоожтой байв. Нэгд: нэхэмжлэгчээс хөрөнгө хураалгасан албан ёсны баримт олдохгүй. Хүмүүс архив хэсч дэмий л зүдэртлээ явж явж ирээд уур бухимдлаа гаргана. Тэгэхлээр тэр үед хүнийг эрх мэдэлтний ордороор баривчлахаа бодохоос биш хөрөнгийг нь хураахад бараг албан баримт өгч байгаагүй бололтой юм билээ.

Гэвч хэнээс хичнээн юу хураасан, түүнийг хураагч этгээд аль хуулийн этгээдэд тушаасан баримт хадгалагдахгүй байна гэж байхгүй шүү дээ. Үүнд төр харин тэр баримтын нуун дарагдуулаад, хүнд суртал

гаргасан хэрэг гэхээс өөр юун. Төв аймагт хураагдсан хөрөнгийн нөхөн төлөөсөө энэ зарлигаар авсан хүн нэг ч байхгүй.

Хоёрт: зөвхөн хэлмэгдсэн хүнд өөрт нь олгоно гэсэн болохоор нэхэмжилж байгаа хүмүүст өгөх хариулт ”түүний эхнэр, нөхөр, үр хүүхэд, ахан дүүст хураагдсан хөрөнгийн нөхөн олговор олгох заалт байдаггүй юм”  
Улсын комиссоос надад өгсөн 106 тоот хариу. Буудуулчихсан эзэнд нь олгоно гээд байгаа шүү, заль мэх гэж ийм.

Хэлмэгдсэн амьд сэрүүн байгаа хүмүүст түлээ, түлш, халаалт, халуун хүйтэн ус, байрны талбайн хөлсийг 50 хувь хөнгөлөх, эмнэлэг, үйлчилгээнд очерь дугааргүй үйлчлүүлэх гэх мэт Засгийн газрын тогтоолын үг байсан ч амьдралд хэрэглэгдэх нь хол байсан даа.

1998 онд Шүүхийн гаргасан шийдвэрийг “Өнөөдөр” сонинд нийтлэн зарлуулдаг байлаа. Цагаатгагдсан хэлмэгдэгч, түүний эхнэр буюу нөхөр, төрсөн, үрчилсэн үр хүүхэд, төрсөн ах дүү мөн болох нь Үндэсний түүхийн архив, бусад архиваар тогтоогдож, хэлмэгдэгч нь цагаатгагдсан тухай БНМАУ-ын Дээд Шүүхийн Цэргийн хяналтын хэрэг эрхлэх коллегийн шатны шүүхийн “Магадлал”, Улсын Аюулгүй байдлыг хангах газар буюу Тагнуулын Төв Газрын тусгай архивын лавлагаа болон Улсын дээд шүүхээс гэрчилээтэй, нөхөх олговор нэхэмжлэгч нь хэлмэгдэгчийн хувьд хуульд заасан хамааралтай болохын нотолсон гэрчүүдийн бичгээр гаргасан тодорхойлолт, мэдүүлэг зэргийг үндэслэж гаргасан сум дундын шүүхийн шийдвэр гарна. Түүгээр дээд тал нь нэг сая төгрөг нөхөн олговор гэж олгоно. Бид бодохдоо “Төр цагаатгалаа-уучлаарай” гэж хэлж буй үг гэж мөнгийг нь хүлээн авдаг байлаа. Түүнээс биш хураагдсан хөрөнгийн төлбөр биш, ял эдлүүлж хийлгэсэн ажлын хөлс биш, эрүүл мэндийг нь хохироосны төлөөс биш, нэр төрийг нь гутаасны нөхөх олговор ч биш.

Монгол хүний алтан амь юу гэж ганц сая төгрөгний үнэтэй байхав дээ???

### **Монгол төгрөгийн ханшийн доорх мэдээ цуглуулсан:**

1930-1940-өөд онд хураагдаж байсан эд хогшил, малын дундаж үнэ доорх байдалтай байжээ. Үүнд:

Цэмбэн олбог 14 төг,  
их Соном хадаг 8-10 төг,  
хуучин торго (амаар) 21 төг,  
минчүү орхимж 20 төг,  
нүдэн хивс 40 төг,  
ташуурын хулс 7-11 төг,  
цоохор хадаг 2 төг 50 мөн,

мөнгөн аяга 43 төг,  
шаазан аяга, таваг 6 төг,  
чулуун жижиг тээг 3 төг,  
ундрам эрхи 5 төг,  
шар эрхи 4 төг,  
жижиг алчуур 3 төг,  
таван ханатай гэрийн тооно 180 төг,  
богино, урт хивс 50-100 төг,  
гэрийн 81 ширхэг унь 100 төг,  
*10 нүдтэй сайн хивс 402 төг,*  
торгон тэрлэг 160 төг,  
шил, шаазан жижиг хөөрөг 1 төг 60 мөн,  
цайны хятад шаазан 2-3 төг,  
хаш хөөрөг 15 төг,  
чулуун өртэй ширээ 100 төг,  
янз бүрийн торгон ваадан 8-50 төг,  
хоргой ваадан 30-50 төг,  
таван ханатай гэрийн даавуун хөшиг 104 төг,  
савх модон хувин 10-11 төг,  
таван ханатын том дэвсгэр 50-60 төг,  
шүрэн ба чулуун жинсүүд 3 төг,  
*126 нүдтэй сайн хивс 5000 төг,*  
хоргой хуулга (амаар) 12-20 төг,  
луу хээтэй шар магнаг дээл 200 төг,  
паалантай шармал хутга сэрээ 10 төгрөг,  
мөнгөн халбага 2-3 төг,  
нэгдүгээр зэргийн сувд (цэнгээр) 210 төг,  
хоёрдугаар зэргийн сувд (цэнгээр) 200 төг,  
гуравдугаар зэргийн сувд (цэнгээр) 125 төг,  
эхнэр хүний чулуун шигтгээтэй эдлэл 500 төг,  
дунд зэргийн сувдан даруулга 446 төг,  
*16 лан муу мөнгө 3-4 төг,*  
чулуун шигтгээтэй 2 цэн 8 пунгийн алтан бөгж 803 төг,  
сийлбэртэй хүрэн суман сандал 45 төг,  
бургасан хана 6 ширхэг 145 төг,  
ширмэл ширдэг 20-40 төгрөг,

хивсэн олбог 20-25 төг,  
 хасаг тэргэний хос дугуй 300 төгрөг,  
 хуучин торгон тэрлэг 52 төг,  
 янз бүрийн булгаар богц 18-40 төг,  
 орос даалимба 1 төг 80 мөн,  
 хуучин луухчин гутал 45-60 төг,  
 таван алдын урт хадаг 150 төг,  
 ваар сав 80 төг,  
 хуучин модон авдар 21 төг,  
 монгол цоож 10 төг,  
 араг 6 төг,  
 зэс дашмаг 18 төг гэх мэт үнэтэй байжээ.

1938 онд азарга 100 төг, бүдүүн гүү 80 төг, даага 25 төг, бүдүүн үнээ 80 төг, шүдлэн үхэр 50 төг, бяруу 25 төг, эр хонь 20 төг, эм хонь 15 төг, эр ямаа 10 төгрөгийн үнэтэй байжээ. Хураагдсан хөрөнгийн нэр төрөл ч дээрхээс тодорхой болж байна.

Нэг жишээ:

Миний ижий Ц.Лхамжав:

-Хүн гэдэг хөгийн, сайн сайхан явахад ижий ахай, ад шоод үзэгдээд ирэхэд адуунд хамуу. Хамба ахын нэр сүрээр 12 тэмээ, 30 гаран адуу, 20-иод үхэр, 140 гаруй бог хураав.

Энэ бол 1929 оны явдлыг дурсаж ярьсан яриа юм. Лхамжав агсаны эхийнх нь төрсөн ах нь том шар феодал. Богд Жавзандамба хутагтын Хүрээний хэргийг захиран шийтгагч Хамба номун хан, шашныг өрнүүлэгч, тунгалаг билэгт, номч цорж, эрдэнэ мэргэн бандида, хутагт Пунцаг. Энэ хүн 1899-1920 онд уг алба тушаалыг 21 жил хашсан, Манж хятадаас Монголоо салгаж тусгаалахын төлөө, шар феодалын хаант засаг тогтоохын төлөө идэвхтэй тэмцсэн хүн гэж түүхэнд тэмдэглэдэг.

Бас нэг жишээ:

***1939 оны X сарын 5-ны өдөр ДЯЯ-н 55 тоот дайчлан баривчлах ордероор баривчлагдсан Өвгөөдэй Дамдинсүрэнгийнхээс хураагдсан эд зүйлс:***

Калбин буу, ширээний герман цаг, калибр буу, 18 сумтай, бугуйн цаг, радиогийн хэрэгсэл, хятад төгрөг 6, хятад 50-тын мөнгө 3, цагаан мөнгө (хэсгээр/, монгол төгрөг 76, мөнгө 14 ш, 15 жилийн ойн тэмдэг, альбом, элдэв бичгийн зүйл боодлоор, герман тонгорог, винтов бууны сум, минжин малгай, эсгий малгай, үстэй бор даавуу, ногоон торгон бүс, лоовууз, мөнгөн хэрэглэл бүхий хутга, мөнгөн аяга, дан бүрээстэй

5 ханатай гэр, дунд хэмжээний толь, 8 адуу, 30 үхэр.

Зарим зүйлийн одоогийн үнэ ханш  
Гэрийн мод 1,2 сая төгрөг  
Цагаан хаш хөөрөг 4,5-50 сая төгрөг  
Хөөрөгний шүрэн толгой 1 грамм нь 150,0-250,0=**5-15** сая төгрөг  
Алтан бөгж 1 грамм нь 85000 төгрөг  
Хуучны эдлэлийн мөнгөн аяга 1-10 сая төгрөг  
Хуучин модон авдар 350,0-1 сая төгрөг  
Зэс дашмаг 500,0-1 сая төгрөг  
Савхан хувин 500,0-2,5 сая төгрөг  
Монгол цоож 50000-150,0 төгрөг  
Хуучны шаазан аяга 250,0 төг, таваг, ваар 150,0-500,0 төгрөг  
Чулуун өртэй суман модон ширээ 3-4 сая төгрөг  
суман модон сандал 500,0-1,5 сая төгрөг  
Сувдан даруулга 250,0-650,0 төгрөг  
луу хээтэй шар магнаг дээл **1,5 сая төгрөг**

#### Ишлэл:

“феодал хэмээгчдийн хөрөнгийг хураах ажилд 100 ба түүнээс дээш хувийн хөрөнгө бүхий 920 гаруй өрхийг хамарч, тэднээс 729 нь тухайн үеийн ханшаар 5,2 сая гаруй төгрөгийн үнэ бүхий мал ба үл хөдлөх хөрөнгөө хураалгажээ. ...427 феодал ба хутагт хувилгаад, 302 түшмэдээс 4793392 төгрөг 89 мөнгөний үнэтэй мал, 358952 төгрөг 36 мөнгөний үнэтэй үнэ бүхий зүйл ба 70225 төг 50 мөнгөний үнэтэй үл хөдлөх хөрөнгө бүгд нийлсэн 5222567 төгрөг 72 мөнгөний үнэтэй юмсыг хураасан, хураасан мал хөрөнгө зоориноос 1560436 төгрөг 70 мөнгөний үнэ бүхий зүйлүүдийг ядуу ардуудад шилжүүлэн өгснөөс гадна бусад мал ба хөрөнгө зоорийг нь 130 хамтралуудад хуваан өгсөн.

Хөрөнгөө нуусан гэх хэргээр Дотоодыг хамгаалах газар 1931 оны сүүлийн хагаст 137 хүнийг хэрэгт татаж, шүүхийн шийдвэрээр 1 сая 123670 төгрөгийн хөрөнгө дахин хураажээ.<sup>11</sup>

### Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн

#### НӨХӨХ ОЛГОВОР гэгч чухам юуны олговор вэ?

НӨХӨХ: нөхөөс тавих, алдаагаа нөхөх, зардлаа нөхөх, нөхөн төлөх, шилжсэн: орлох-алба нөхөх

Нөхөн олговор-ямар нэгэн хэрэг явдлыг өнгөрсөн хойно нь зарцуулсан зүйлийн үнийг нөхөн төлөх

· Төлөөс үү?

<sup>11</sup> Монгол улсын түүх. Ү боть. УБ 2003 он. Т.173.



- Тэтгэмж үү?
- Тусламж уу?
- ???

### **Нэг сая төгрөг их хөрөнгө мөн үү?**

Статистикийн албан судалгаагаар “нийгмийн халамж хэтэрхий их болсон гээд байсан” 2010 онд улсын хэмжээнд нэг өрхийн сарын дундаж орлого 448027 төгрөг, үүнээс мөнгөн орлого нь 387099 төгрөг, үүнээс тэтгэвэр тэтгэмж 67131 төгрөг байсан байдаг. Үүгээр жишиж харвал хэлмэгдэгчийн нэг өрхөд дээд тал нь ердөө хоёр сарын бодит орлоготой тэнцэх нөхөн олговрын мөнгө олгосон хэрэг. Тэгэхэд нэг өрхийн сарын дундаж зарлага нь мөн онд 450206 төгрөг, үүнээс хүнсний зүйлийн зарлага 131940 төг, бусад бараа үйлчилгээний зарлага 244404 төгрөг байж дээ. Энэ тоо хэлэхийн учир мөнөөх нөхөх олговор айлын аж төрөлд яаж нөлөөлөх мөнгө вэ гэдгийг бодуулах гэсэн хэрэг л дээ.

2011 онд хийсэн судалгаараар Монгол улсын төвийн бүсд ядуурлын төвшин 28,2 хувьтай, хүн амын амьжиргааны доод түвшинг 2010 онд 91700, 2011 онд 106600, 2012 онд 117500, 2013 онд 132400 төгрөгөөр, 2017 онд 240 000 тогтоож байсан нь жил ирэх тутам өргөн хэрэглээний хүнс, бараа, үйлчилгээний үнэ өсч, дагаад ядуурал нэмэгдэж байсныг харуулдаг. 2014 онд статистик судалгаагаар манай улсын 3 хүн тутмын нэг нь хоногт 5000-аас доош төгрөгийн орлогоор амьдарч байна гэж монголчуудын амьдралын ерөнхий дүр зургийг гаргаж ирлээ. Энэ нь малаар баян монголд хагас кг үхрийн мах авах үнэ.

Нээлттэй нийгэм форумын 2014 онд гаргасан судалгаагаар монголын хүн амын 43 хувь нь өлөн зэмүүн амьдарч байгаа дүн гарчээ. Амьжиргааны баталгаажих доод түвшинээс доогуур орлоготой даанч өлөн хомс өрх маш олон боллоо. Тэдний үр хүүхэд өнөөдөр сургууль соёл гэхээсээ бор ходоодоо тэжээхийн тулд хог хаягдал цуглуулж, зах дээр хүнд ачаа зөөж, гар аргаар алт олборлогчдын мөнгөн ус, цианитэд хордож, далд уурхайд нүүрс ухаж, аль зөвшөөрөгдөөгүй хүчир хөдөлмөр эрхэлж яваа нь нууц биш боллоо.

Ялангуяа хэлмэгдэгч, түүний үр хүүхдийн аж төрлийг харахад социализмын үед голдуу “хар бор” гэгдэж байсан хамгийн бага цалинтай ажил олж хийн амь улжиж, ХАА-н нэгдэл нь тарж, үйлдвэр байгууллага нь зах зээлийн харилцааны шилжилтийн үед хувьчлагдан хүнийх болсноор хөдөлмөрийн дэвтэр нь үрэгдсэн, эсвэл бичилт хийлгээгүй зэрэг янз бүр шалтгаанаар тэтгэвэр тэтгэмжид хамрагдаагүй, эсвэл хамгийн бага хувь хүртдэг хүмүүс байдаг. Улсын хэмжээнд судалснаар амьд сэрүүн байгаа “хэлмэгдэгчдийн 70-аас

дээш хувь нь доод хэмжээний тэтгэвэр авч<sup>12</sup> байжээ. Тийм болохоор тэд ядуучуудын эгнээнд хэзээнээсээ нааш хамрагдаж иржээ.

Хилсээр хэлмэгдэгсэд, тэдний үр хүүхэд, ач зээ нарын амьдрал өнөөдөр маш хүнд байгаа учир тэтгэвэр тэтгэмжийн болон нөхөх олговрын хэмжээг нэмэгдүүлэх, орон сууц үнэ төлбөргүйгээр олгох, хураагдсан хөрөнгийн бүртгэлийг төрийн зүгээс ил болгож, иргэдийнхээ нэхэмжлэл гаргах бололцоог олгох талаар арав гаруй жилийн тэртэйгээс ярьж, боловсруулсан хуулийн төслийг эргэн харж, 10 жил заагдаж ял эдлэхдээ шоронгийн ялтны хувьд хийсэн хөдөлмөрийн хөлсний дунджыг гаргаж түүнийг олгох, мөн хүний нэр төр гутаасны дээр хүнд хортой нөхцөлд ажиллуулж эрүүл мэндийг нь хохироосны төлбөрийн асуудлыг судлан зохих төлбөр олгохоор нэмж боловсруулан УИХ-д дахин өргөн барьж шийдвэрлүүлэх цаг нэгэнт болжээ. Одоо нэг мөр Цагаатгалын хууль шинээр гаргах шаардлагатай болсныг цаг үе харуулж байна. Манай үндсэн хуулийн 2-р бүлгийн 19-р зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэдийнхээ өмнө хариуцна” гэж тов тодорхой заасан. Амьдрал дээр төр чухам эдгээр амин чухал асуудлыг хариуцаж байна гэхэд эргэлзээтэй.

Санхүүгийн эх үүсвэр нь хууль, дүрэм, журмын янз бүрийн гох дэгээнээс болж авч чадаагүй нөхөн олговор, нэхэмжлэгчгүй хэлмэгдэгчдийн хэмнэгдсэн мөнгө өдий төдий байгаа юм л даа.

### Үлдэгсэд

Хилс хэргээр хэлмэгдэгсдийн үлдэгсэдтэй уулзаж ярилцаж, сонсоход: нийгмээс гадуурхагдаж, нутгийн таньдаг мэддэг хүмүүс, тэр ч байтугай ах дүү хамаатан садангийнхан ч ойртож хавьтахгүй буруулан цэрвэх, “чухам сүүдрээсээ айх цаг” тул, эсэргүүгийн хомрогонд орчих вий гэж болгоомжлоод, нэг хэсэг нь зэрэгцсэн хүчтэй ухуулга сурталчилгаанд автаж үнэхээр эх орноосоо урвасан, сүйтгэсэн гэж итгээд үүдээр шагайх нь байтугай, салхин доогуур ч гарахаа байсан тийм үе. До яамныхан ямагт “анхааран ил, далд халамжилж” дээш нь мэдээлэл, орон нутгийн удирдлагад “анхааруулга” өгнө. Ажил, сургуульд орох цагт гурван үеийн намтар бичүүлдэг, авч уншаад нүдээ их болгож нэг харснаа “хэн хэндээ балаггүй явъя” гэх буюу “манай орон тоо гүйцсэн” мэтээр хариулж, олноор дайчлагдсан хадлан, тариа, гал түймэр, үер усанд хичнээн хичээж ажилласан ч кинонд гардаг шиг “ингээд л миний нэр байдаггүй” явж ирлээ гэлцэнэ.

Хэлмэгдэгсдийн үр хүүхдүүд нь эцэг эхийгээ баривчлагдахыг

12 Улс төрийн хэлмэгдүүлэлт ба цагаатгал, симпозиум, 2005 он, Т.19.

нүдээр үзэж, балмагдан айж, гэр орон, эд хогшил, мал хөрөнгөө хураалган, голомтоо сандаачилгаж, үнс нурам бужигнасан буйран дээрээ харах нүд нь нулимстай, халуун гар нь наана гэсэн ах дүүгийнхээ хормойноос зуураастай үлдэж, “эсэргүүний хүүхэд” нэрээр ертөнцийн боловсролоос гээгдэж, өөд нар харалгүй шоовдорлогдсон хүмүүс насан турш зовсоор өнөө эрүү өвдөг тулсан ядуучууд болжээ.

Сүлд овогтон Батнягтын Самбуу агсан дурдатгалдаа:

*1936 онд Улаанбаатар хотын Үлгэр жишээ III бага сургуульд орж суралцлаа. Сургуульд орохын өмнө ээж ааваараа монгол үсэг бичиг заалгаж, тэд маань намайг Ширнэнгийн Намсрай гэдэг багшид шавь оруулж, тэр бүхний буянаар тэргүүний сурагчийн эгнээнд суралцаж явлаа. Манай сургуульд Гэндэн сайдын Ира Цэрэндулам, зохиолч Чойжилын Чимэд, Э.Раднаа, эрдэмтэн Д.Элбэг (Дэмид жанжны), Д.Цэвээн (Догсом сайдын) нар суралцаж байлаа. Эцэг маань баривчлагдаж, эсэргүүний хүүхэд гэдэг шалтгаанаар сургуулиас хасагдлаа. Дээр нэр дурдсан сурагчдын зарим нь ч мөн шалтгаанаар, бид сэтгэлээр унаж хэцүү байсан. Эцэг Цэдэндамба Хоршоодын холбооны дарга, ээж Батнягт Улсын Дээд Шүүхийн орлогч дарга байсан юм. Би овогоо солив.*

Эдний талаар төр засгийн хэнч ямар ч арга хэмжээ авахгүй, авах ч сонирхолгүй ам хэлээрээ хэлэхгүй ч ачир дээрээ “хохь дуудан” өнөө хүрлээ.

Улсын Их Хурлаас 1996 онд тогтоол гаргаж жил бүрийн 9 дүгээр сарын 10-ны өдрийг улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр болгон тэмдэглэж байхаар боллоо. Тэр үеэр ийм хүнд 10000 төгрөг гар дээр нь тавина.

### Дүгнэлт, санал:

Даяаршиж буй, харгис түрэмгий болж буй дэлхий ертөнцөд цөөхөн монголчууд хойшдоо хэрхэн амьдарч, хөгжих бол оо?

Гадаадын хөрөнгө оруулалт нэрээр Монгол улсын нутаг дээр байршсан харь улсууд, тэдний уурхайн эзэд ноёдод монгол хүний амь, амьдрал даанч хямд байгаа нь нууц биш ээ. Энэ мэт олон шалтгааны үүднээс түүхийн хар сургамжид бодитой хандах ёстой боллоо, Одоогийн мөрдөж буй хууль асуудлыг өнгөц хуумгай авч үзэж шийдвэрлэсэн байна. Тухайлбал:

1. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн нөхөх олговор гэж чухам юуг хэлж буйг хуулийн нэр томьёонд зааж өгөөгүй.
2. Монгол иргэний үнэ цэнийн бүхэл бүтэн асуудлыг судалж, хуульд суулгалгүй орхигдуулсан
3. 1928 оноос эхэлж иргэдийнхээ хөрөнгө хурааж улсын орлого

болгосон баримтыг ил тод болгоогүй, хураагдсан хөрөнгийн нөхөн төлбөрийг нөхөх олговорт суулгаагүй

4. Монгол хүний нэр төрийг гутааж хэлмэгдүүлсний, нийгмээс гадуурхсны нөхөн төлөөс олгох ёстой байсан.
5. Хилс хэргээр ял эдэлж шоронд хоригдож байхдаа хийсэн хөдөлмөрийн хөлсийг нөхөн олгох ёстой байсан.

Одоо:

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсэд, тэднийг дагалдан хохирогсдын асуудалд бодитой хандаж үнэн зөв дүгнэлт гаргах, хохирлыг зөв тооцох шаардлагатай болжээ. Хохирлыг мөнгөн дүнгээр гаргалаа гээд төрөөс хэлмэгдэгсдэд өгөх мөнгө хөрөнгө зарлагадахаас өнгөрсөн. Хуулиар мөнгө төгрөг авах хүмүүсийн тоо бараг тэг болсон. Иймд их гарлага гарах байх гэж айх хэрэггүй. Ингээд уг хуулийг шинэчлэн боловсруулж хуульд нэмэлт хийх шаардлагатай. Иймд юуны өмнө:

1. Монгол хүнээ үнэ цэнэтэй гэдгийг нотлон тунхаглах нь одоо, ирээдүйд хэрэгтэй. Эрх зүйн баримжаатай болно.
2. Монгол аж амьдралын үнэ цэнийг мөн ил тод болгох хэрэгтэй болж байна.

### **Шинээр нэмж:**

Дам хэлмэгдэлтийн асуудлыг нөхөн судалж хуульчлах шаардлагатай. Тэд:

1. Нэр төр нь гутаагдсан
2. Нийгмээс гадуурхагдсан, ганцаардсан
3. Ажил, сургуулиас хасагдсан
4. Төрийн болон нийгмийн үйлчилгээнээс хасагдсан
5. Хамгийн хар бор , цалин багатай ажил олж хийсэн
6. Эдүгээ тэтгэвэргүй буюу хамгийн бага тэтгэвэр авдаг
7. Маш цөөхөн хүн үлдсэн

## ИХ ХЭЛМЭГДҮҮЛЭЛТИЙН ҮЕИЙН МОНГОЛЫН ОРОН НУТАГ: Хэнтий аймгийн жишээн дээр



*Да.Эрдэнэбат  
Доктор (Ph.D)  
ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн*

### Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Хэнтий аймгийн Чингис хотын архивын тасаг нь нэгэн жарны тэртээгээс үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ. МАХН-ын Төв Хороо, СнЗ-ийн 1957 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 92/66-р тогтоол, аймгийн гүйцэтгэх захиргааны мөн оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 205-р захирамжаар байгуулагдсан бөгөөд өдгөө 42 мянган хадгаламжийн нэгжтэйгээр ажиллаж байна.

Сэцэн хан аймгийн бүх хошуу (тус хошуу 1549 онд үүссэн), шавиас сонгогдсон төлөөлөгчдийн хурал 1923 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр хуралдаж, аймгийн яамыг дөрвөн хэлтэстэйгээр байгуулж, нутгийн захиргааг цаашид эмхэлж, Хан Хэнтий уулын аймгийн нутгийн захиргааны дүрмийг баримтлан 25 хошуу, хутагтын шавь хоёр, сум 109, баг 328, арван гэр 1643<sup>1</sup>-ыг зохион байгуулж, хошуудыг газар орон, уул усны нэрээр нэрийдсэн билээ (1924 оны 06 сарын 05-нд Хан Хэнтий уулын аймагт аймгийн намын хороо байгуулагджээ). Харин мөн оны 10 дугаар сарын 19-ний өдрийн хурлын 38-р зүйлд, “Сэцэн хан аймгийн чуулган даргын газраас харьяат аймгийн олон хошуу шавиас дүрмийн ёсоор сонгон гаргасан төлөөлөгчдийг чуулганы даргын газар хуралдуулан аймгийн хурлыг нээж, хэлтэс зохион байгуулсан ба харьяат аймгийн яам”<sup>2</sup>-ыг “Хан Хэнтий уулын аймгийн яам”<sup>\*</sup> хэмээн

1 Б.Өлзийсүрэн. Өнөөгийн Хэнтий. УБ., 1983. т. 29.

2 Г.Мягмарсамбуу. Хан Хэнтий нутгийнхан эх орноо батлан хамгаалах үйлсэд. (Хэнтий аймгийн цэргийн хэлтсийн түүхийн товчоон. 1923-2013). УБ., 2013. т. 38.

\* Дээрх анхдугаар хурлын тухай Засгийн газраас 1923 оны 11 дүгээр сарын 12-нд НТХ-нд илгээсэн албан бичигт, Сэцэн хан аймагт хурал нээж, хэрэг хэлэлцэн шийтгэсэн нь холбогдох дүрэмд төдий л

нэрлэж болох эсэхийг тогтоон заахыг өргөн мэдүүлсэн тухай ДЯЯ-наас оруулсан асуудлыг хэлэлцжээ. Ардын Засгийн газрын 1931 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 2 дугаар тогтоол, УБХ-ын тэргүүлэгчдийн мөн оны 5-р хурлын тогтоол ёсоор орон нутгийн засаг захиргааны хоёрдугаар өөрчлөлтөөр Дорнод аймгийг тусгаарлаж, Хэнтий аймаг шинээр байгуулагдсан билээ (28 сумтайгаар).

Хэнтий аймаг нь Монгол улсыг нутаг дэвсгэрийн зүүн хэсэгт орших бөгөөд зүүн талаараа Дорнод, зүүн урдуураа Сүхбаатар, урдуураа Дорноговь, баруун урдуураа Говьсүмбэр, баруунаараа Төв аймгуудтай залган, зүүн хойд талаараа ОХУ-тай 300 гаруй км, зах нийлж, 82.3 мянган ам км талбай бүхий нутаг эзлэн оршдог<sup>3</sup>.

Бид Хэнтий аймгийн архивын тасгийн сан хөмрөгт хийсэн судалгааны зарим ажлаас танилцуулах гэж байна. Иймийн учир илтгэлээ дотор нь нягтруулж зөвхөн хоёр зүйлд төвлөрүүлж өгүүлэхийг зорив. Их хэлмэгдүүлэлтийн үед Монгол улсын нэгэн аймаг ер нь ямар байдалтай байсан юм бэ? Хилсдүүлэлтийн үйл явц хэрхэн явагдсан юм бэ? нэг аймгаас хичнээн хүн өртсөн юм бэ? цаашид улс төрийн хэлмэгдүүлэлтэд эрсэдсэн хичнээн эрдэнэт хүний тооны нийлбэр судалгаа хийгдсэн ерөнхий дүнтэй мөргөж байна вэ? гэх мэт олон асуултуудын нэгээхэн атугайд ч хариулт олох зорилт өөртөө агуулав.

Нэгдүгээрт, Хэнтий аймгаас хэлмэгдүүлэлтэд өртсөн төр, засгийн зүтгэлтнүүд:

1. Сэцэн хан Навааннэрэн (1887-1937). Баянхутаг суманд төржээ (харьяат хошууг 1910-1923 онуудад захирч байв). Түүнд холбогдох баримтууд МУУТА, Улс төрийн нам, олон нийтийн байгууллагын архив, Гадаад хэргийн яамны төв архив, ТЕГ-ын архивын сан хөмрөгт хадгалагдаж байна. Сэцэн хан аймгийн 23 хошуу нь жагсаалтын №32-45, 154-157, 159-161, 206-207-д тус тус бүртгэгдэж хөмрөгийн дугаар авчээ. Манж Чин Улсын эрхшээлийн үеийн хөмрөгүүдэд Сэцэн хан аймгийн түүх газар нутаг, хүн ам, малын тооллого дансуудын тухай баримтууд элбэг байдаг. Сэцэн хангийн түүхэнд холбогдох баримтууд нь х-м.34, д.1, хн.1137-өөс эхэлдэг. Тэрбээр Монгол улсын үед Шүүх яамны сайд, Ардын хувьсгалын үед буюу 1922 оны эхээр Монгол Улсын Дотоод явдлын яамны тэргүүн сайдаар томилогдон ажиллаж байгаад 1933 оны эхээр Шинжлэх ухааны хүрээлэнгийн орлогч даргаар томилогдсон билээ. Их хэлмэгдүүлэлт эхэлсний хоёр дахь өдөр буюу 1937 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр Сэцэн хан Навааннэрэнг Х.Чойбалсангийн гарын үсэг бүхий

нийцээгүй учир түүнийг хүчингүй болгож, харьяат хошууны нутгийн захиргааг байгуулах хэргийг нэн даруй гүйцэтгэхийг тушаажээ.

3 Хан Хэнтийн товчоон. УБ., 2003. т. 273.



- 25 тоот ордероор<sup>4</sup> баривчилжээ. 1937 оны 10 дугаар сарын 23-нд Шүүх цаазны бичгийн 43, 44, 45 дугаар зүйлд заасан онц аюултай гэмт хэрэг өдүүлсэн хэмээн мөн сарын 25-нд баригдсанаас хойш 45 дахь хоног дээр нь хөнөөсөн байна. 1991 онд цагаатгагдсан юм.
2. Дансранбилэгийн Догсом (1884-1941). Баян-Овоо суманд төрсөн. Монгол төрийн нэрт зүтгэлтэн. Улс төрийн хилс хэрэгт буруутгагдан, ЗХУ-д (хуучнаар) цаазлагджээ. 1962 онд цагаатгагджээ.
  3. Дарьзавын Лосол (1890-1940). Монгол төрийн нэрт зүтгэлтэн, партизан. Батноров сумд төржээ. Улс төрийн хилс хэрэгт тулгагдан ЗХУ-д цаазлагдсан. 1962 онд цагаатгагджээ.
  4. Гончигийн Самбуу (1901-1937). Баян-Адарга сумын харьяат. Монгол Манжуурын хэлэлцээрт Монголын төлөөлөгчдийн тэргүүнээр ажиллаж байхад нь баривчлан (1937.09.02.), Дээд шүүхийн хурлын тогтоолоор цаазлах ял оногдуулжээ (1937.09.18-21) 1962 онд цагаатгасан.
  5. Намжилын Хаянхярваа (1876-1934). Цэнхэрмандал сумын харьяат. 1934 онд хувьсгалын эсэргүү япон тагнуулын хэрэгт баривчлагдан байцаагдаж 10 жилийн хорих ялаар шийтгүүлсэн авч нас баржээ. 1968 онд цагаатгагдсан.
  6. Хүүхэн хутагт Жамьяндамбийбалсан (-1929). Сүүлчийн хүүхэн хутагтыг 1929 онд ДХГ-ын боловсронгуй төлөөлөгч дайчлан баривчилж аймгийн төвийн шоронд хориход тэндээ таалал төгсчээ.
  7. Мөрдэндэвийн Ядамсүрэн (1904-1937). Хэрлэн цагаан эргийн Отог хэмээх газар төржээ. 1930 оноос Монголын хувьсгалт зохиолчдын холбооны дарга, улсын театрын дарга, улсын прокурор зэрэг ажлыг хийж байгаад хилс хэрэгт эрсэджээ.
  8. Наваанлуvsангийн Гэнэнпил (1905-1938). Дадал суманд төржээ. VIII богд Жибзундамбын сүүлчийн хатан учир хэлмэгдлийн их шуурганд өртөж хороогдсон.
  9. Дугарын Дунгаржид (1901-1939). 1927-1930 онд Хан Хэнтий уулын аймгийн эмэгтэйчүүдийн дарга, 1930-1931 онд Онон голын хошууны захирагчаар ажиллаж байсан, эмэгтэйчүүдийн байгууллагын ууган ажилтан, уран илтгэгч байв. 1962 онд цагаатгагдсан.

4 Д.Өлзийдолгор, Х.Ариун-Эрдэнэ. Махасамади далай сэцэн хан Цэрэндондовын Навааннэрэн. УБ., 2000. т. 51.

10. Нэрэнмөрийн Насантогтох (1904-1941). Оцол сансар уулын хошуу Цац-Уул сумын нутагт төржээ. 1939 оны эхээр Харилцан нэвтрэлцэх ерөнхий хорооны даргаар ажиллаж байхад нь баривчилж, ЗХУ-д цаазалсан. 1956 онд цагаатгагджээ.
11. Гэлэгийн Хасбазар (1897-1941). Хэнтий аймгийн Галшир сумын нутагт төрсөн. ДЯЯ-ны аж ахуй хэргийг эрхэлсэн дэд сайд бөгөөд хэрэг эрхлэх газрын даргаар ажиллаж байхад нь баривчилж, ЗХУ-д цаазалсан. 1960 онд цагаатгажээ.
12. Чойндонгийн Жамбал (1871-). Биндэр сумынх. Хувьсгалын эсэргүү, япон тагнуулын хэрэгт 1933 онд баривчлагдан мөрдөн байцаалтад хэрэг хүлээлгээгүй (62 настай). ДХГ-ын дэргэдэх тусгай комиссын 1933 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 6 дугаар хурлын тогтоолоор Шүүх цаазны бичгийн 42, 47 дугаар зүйлээр 5 жил хорьж, хөрөнгийг хураах ялаар шийтгүүлсэн билээ. ЗХУ-д хүргэгдэн Дорнод Сибирийн хязгаарын Улс төрийн нэгдсэн удирдах газрын (тройки) гурвын хуралдаанаар 1934 оны 2 дугаар сарын 6-нд ЗСБНХОУ-ын Эрүүгийн хуулийн 58-2, 58-6-д зааснаар 5 жил хорих ялаар шийтгүүлжээ. 1939 онд суллагадад удалгүй дэлхийн II дайнд торгуулын суманд алба хааж оролцоод Монголоо зорин ирж агаад дээрэмчдэд алагдсан юм. Ч.Жамбалыг 1962 онд БНМАУ-д цагаатгасан бол эчнээ ОХУ-д 1989 онд цагаатгажээ. Өнөөгийн байдлаар тус аймгаас **3468** хүн цагаатгагдаад байна.

Хоёрдугаарт, Хэнтий аймгийн архивын тасагт буй сан хөмрөгөөс.

1932 оны сүүлчээр гарсан мэдээгээр тус аймагт 9.5 мянган лам нар байснаас 546 нь 41-ээс дээш насных байсан нь нийт лам нарын 17.3%-ийг эзэлж байснаас гадна эдгээр лам нарын ихэнх нь залуу лам нар бөгөөд гуравны хоёр хувь нь мал аж ахуйтай холбоотой ядуу лам нар байв. Төр, засгаас лам нарын талаар явуулсан бодлоготой холбоотойгоор 1936 он болж ирэхэд аймгийн хэмжээнд буй том, жижиг 70 гаруй сүм хийдэд (87 хүрээ, хийд, хурал байв)<sup>5</sup> 8.8 мянган<sup>6</sup> лам нар шавилан сууж байжээ.

Хэнтий аймгийн улс төр, үзэл суртал, эдийн засгийн амьдралд гарсан нэг том үйл явдал бол сүм хийдийн зохион байгуулалт бүрэн эвдэрч, лам нарын асуудал шийдвэрлэгдэж дууссан явдал<sup>7</sup> гэж өмнөх орон нутаг судлалын бүтээлд дурдсан байдаг. Үүнтэй уялдан өгүүлэхэд улс төрийн хэлмэгдүүлэлт Хэнтий аймагт бүр 1933 оноос эхэлжээ.

5 Улс төрийн хэлмэгдэгчдийн дурсгал – цагаан ном. Боть XIX. Хэнтий., 1996. т. 30.

6 Б.Өлзийсүрэн, С.Ичинноров., Хэнтий аймаг. УБ., 1963. т. 61.

7 мөн тэнд, т. 66.

Тус хэлмэгдүүлэлтийн эх ундарга ЗХУ-ын (хуучнаар) удирдах байгууллагаас зохион байгуулалттайгаар хийгдсэн гэх баримтууд сүүлийн үед илэрсээр байгаа билээ. Тухайлбал, Ж.Лхүмбийг баривчилсан тухай И.Сталинд илгээсэн зурвас бичигт дурдахдаа: “Хэнтий аймагт гарсан хувьсгалын эсэргүү хуйвалдааны хэргээр шинэ мэдүүлэг авлаа. Хэнтийн байгууллагад удирдамжийн захидлыг дамжуулахад МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга Лхүмбийг зуучилсан гэж яллагдагч Цэвэгжав, Бадам, Мархаев нар өчин мэдүүлэв. ...Лхүмбэ бүр 1930 онд монголын баруунтны үзэл сурталч профессор Жамцаранотой (Ленинградд байгаа) хамт япончуудад хандан захидал бичиж байсан гэжээ. Лхүмбийг байцааж эхэллээ”<sup>8</sup> хэмээн хилс хэргийн бүрэн явц бүрийг мэдээлж байжээ. Мөн Лхүмбийг Улаанбаатарт явуулах тухай БХК(б)Н-ын Төв Хорооны улс төрийн товчооны хуралдааны 150-р протокол (1933.12.04.)<sup>9</sup>, “Ж.Лхүмбийн хэрэг”-т холбогдсон хүмүүст цаазаар авах ял хэрэглэх тухай БХК(б)Н-ын Төв Хорооны улс төрийн товчооны хуралдааны 10 дугаар протоколууд (1934.06.28.)<sup>10</sup> эл асуудлыг улам нотлон харуулж байна.

Бид эл удаа “Ж.Лхүмбэ”-ийн хэргийн талаар дурдахгүй, тус төрийн зүтгэлтний талаар хоёр ч эрдэм шинжилгээний хурал зохион байгуулагдаж байсан билээ. Цухас өгүүлэхэд, “Ж.Лхүмбийн хэрэг”-т нийт 317 хүнийг холбогдуулан баривчилснаас 53 хүнийг буудан алж, 136 хүнийг 3-10 жилээр хорих, 126 хүнийг ЗХУ-д цөлөх ялаар шийтгэсэнээс гадна тус хэрэгт нэр холбогдогсдын тоо 1500”<sup>11</sup>-д хүрчээ.

Хэнтийн бүлгийн Р.Цэвэгжав толгойлогчтой 174 хүний хэргийг (цэргийн 61, харчуудын 70, лам нарын 43 гэж гурван хэсэг болгон хуваажээ. Харин судлаач С.Ганболд тус хэрэгт Хэнтий аймгийн харьяат цэргийн албан хаагчдын тоо, 122 хүн буюу эдгээрийн 65 нь ба талаас илүү хувь нь хэлмэгдсэн гэжээ<sup>12</sup>.) 1933 оны 11 дүгээр сарын 3-нд ДХГ-ын дарга Намсрайгаар даргалуулсан тусгай комисс тасалж (буриад 151, халх 21, хятад 2), 30 хүнийг буудан алах, бусдыг нь 5-10 жил хорих, 36 хүнийг ЗХУ-д (хуучнаар) хугацаа заалгүй цөлөх ял оногдуулсан билээ (“Лхүмбийн хэрэг” гэгчид 2140 хүний нэрийг гаргаснаас 534 хүнийг баривчилсан бөгөөд тэдгээрийн 280 нь буриадууд байв). (Бид цахим үзүүлэнд зөвхөн Хэнтийн бүлгийг хүснэгтлэн оруулсан болно.)

Тухайн үед Хэнтий аймагт 1938 онд 6009, 1939 онд 5630, 1940 он гэхэд 5686<sup>13</sup> буриадууд амьдарч байв.

8 Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичигт (1920-1952). Баримтын эмхэтгэл, II боть. УБ., 2005. т. 22-23.

9 мөн тэнд, т. 52-53.

10 мөн тэнд, т. 85-86.

11 Да.Эрдэнэбат. Улс төрийн их хэлмэгдүүлэлт ба “Лхүмбийн хэрэг” илтгэл - (“Лхүмбэ-110 жил” эрдэм шинжилгээний бага хурал. УБ., 2012. т. 49-59.

12 Лхүмбийн хэрэг 80 жил. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2013. т. 70

13 Х.Мэндсайхан. Дагаар орсон буриадуудыг “Лхүмбийн хэрэг”-т холбогдуулж БНМАУ-ын харьяатаас татгалзуулсан нь. - (“Лхүмбийн хэрэг 80 жил. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2013. т. 108.

Улс төрийн хэлмэгдүүлэлтэд тус аймгаас өртөгдөгсдийг сумаар нь ангилбал: 1.Биндэр 209, 2.Баян-Адарга 162, 3.Баянмөнх 115, 4.Батноров 118, 5.Баян-Овоо 75, 6.Баянхутаг 85, 7.Галшар 151, 8.Дархан 55, 9.Дэлгэрхаан 50, 10.Дадал 394, 11.Жаргалтхаан 21, 12.Мөрөн 62 (тус номонд 54 хүний овог нэр байна)<sup>14</sup>, 13.Норовлин 110, 14.Цэнхэрмандал 72, 15.Өмнөдэлгэр 185, 16.Өлзийт 84, 17.Уулбаян 43, 18.Түвшинширээт 50, 19.Эрдэнэ 8. Нийтдээ **2049** болно. Гэхдээ тус тоо нь эцсийн байдлаар бусад судалгааны баримтуудтай харьцуулаагүй дүн мэдээ гэдгийг хэлэх нь зүйтэй юм.

Хэнтий аймгийн улс төрийн хэлмэгдэгсдэд зориулсан хөшөөн дээр 1937-1939 онуудад хилс хэрэгт татагдаж, хэлмэгдсэн **2654** хүнийг тухайн үед гүйцэтгэж байсан албан тушаал, зэрэг зиндаагаар нь ангилжээ (1941-1942, 1958-1962, 1930-1995 онуудад цагаатгасан байна. Да.Э). Үүнд: 1.Лам хувраг. Хамба лам 36, да лам 8, аграмба 144, гавж 690, гэвхүй, гэсгүй 80, ловон 6, зурхайч 2, унзад 38, мээрин 8, аранжимба 5, цорж 4, хувилгаан 1, маарамба 2, авралч 9, лам 231, зайсан 12, гүрэмч 93, гэвш 1, 2.Тайж, угсаатан, хуучин төрийн албан хаагчид. Тайж 170, залан 5, занги 1, феодал 1, нударган 1, гүн 4, захирагч 3, түшмэл 2, хиа 1. 3.Төрийн албан хаагчид. Сайд 2, ард 39, малчин 191, албан хаагч 53, цэрэг 48, ажилчин 1, оргодол 6, оюутан 2, хоригдол 3, тусгай газрын дарга 49, цэргийн ажилтан 20, эрхэлсэн ажил нь тодорхойгүй 682.

Хэнтийн бүлгийг нийгмийн давхаргаар нь ангилбал: гавж 3, унзад 1, лам 11 - нийт 14 лам, сайд, дарга нар 18, ажилтан 12, малчин 63 – төрийн албан хаагчид 93, цагдаа 1, цэргийн дарга 7, цэргийн албан хаагч 24, цэрэг 30 – цэргийн үүрэгтэн 62, эрхэлсэн тодорхой ажилгүй 4, нийт 174 болохоос буудан алах ялаар 30, хорих ялаар 140, шоронд нас барсан 4 болно. Үүнээс насаар нь ангилбал: 19-20 настан 3, 21-25 настан 53, 26-30 настан 24, 31-35 настан 20, 36-40 настан 13, 41-45 настан 9, 46-50 настан 14, 51-55 настан 18, 56-60 настан 14, 61-65 настан 8, 66-70 настан 6, 71-75 настан 1, нас бичигдээгүй 1<sup>15</sup> болно.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссоос эрхлэн гаргасан нэгэн бүтээлд, “1922-1940 онд хэлмэгдсэн 644 хүний нэрсийг лавлагааны чанартай намтрын товч мэдээтэйгээр”<sup>16</sup> хэвлэн нийтэлсэн нь тухайн сэдэвт холбогдох судалгааг явуулахад ихээхэн түлхэц болсон юм. Бид Хэнтий аймгаас хэлмэгдсэн хүмүүсийг хүснэгтэнд оруулж овог нэр, нас, ажил мэргэжил, ял шийтгэл, цагаатгагдсан эсэхийг багтаан жагсаалт хийхээр оролдсон болно (цахим үзүүлэнгээс дурдана).

14 Мөрөн сумын түүхэн товчоон. УБ., 2013. т. 399.

15 “Лхүмбийн хэрэг”-т хэлмэгдэгсдийн мэдээлэл. УБ., 2013. т. 7-9.

16 М.Ринчин. Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн дурсгал – цагаан ном. Тэргүүн боть. УБ., 1993. т. 5.

Аймгийн архивын тасагт буй баримтуудаас үзэхэд, тус орон нутагт буй сүм хийдэд шавилан сууж байсан лам нарын тоог бүр 1930-аад оны дундаас нэг бүрчилэн авч байсан баримтууд байна. Монголын бурхны шашин сүм хийд, лам нарыг устгах нь гуравдугаар коммунист интернационалын гүйцэтгэх хороо, БХК(б)Н-ын Төв Хорооны чухал зорилтын нэг байсан бөгөөд улс төрийн хэлмэгдүүлэлт нь Монгол орны хувьд санамсаргүй тохиолдол бус зайлшгүй зүйл байжээ гэдэг нь түүхэн баримтаас тодорхой байдаг<sup>17</sup>.

Эл хэрэгт холбогдогсдын бүрэлдэхүүнийг ажиглахад, нэгдүгээрт, үндэстнээ түшин ирсэн буриад зон олонх, хоёрдугаарт, зүүнтний үед нам, төрийн удирдлагад өндөр алба хашиж байсан З.Шижээ, Ө.Бадрах, Лааган, Дэндэв, Гонжоон, Баттөмөр нарыг, гуравдугаарт, Дотоодын хамгаалахын ажилтны өширхөх сэтгэлээр баривчлагдсан иргэд, дөрөвдүгээрт, цэргийн албан хаагчид гэж ангилж болохоор байна. Судлаач Ц.Цэрэн Хэнтийн Онон голын буриад хошууг 1922 онд байгуулагдсан, таван сумтай, 1000 гаруй өрхтэй, нийтдээ 3000-3500 хүнтэй хэмээгээд тус аймгийн Балж, Баян (ойролцоогоор 27), Онон, Дадал, Биндэр<sup>18</sup> сумуудад тархан нутаглаж байсан өнөөгийнхөөр Биндэр (48), Батширээт, Дадал (46) сум гэж судалгаандаа бүртгэсэн байдаг. Элхошуунаас хэлмэгдүүлэлтэд 558 хүн өртсөнийг тайлбарлахдаа 1930-аад оны хилсдсэн буриадуудын тоо гэж тодорхойлжээ.

Аймгийн архивт 1930 оноос хамтрал, коммунад ардын аж ахуйтныг нэгтгэх кампани өрнүүлж, албадсан, мөн оноос эхлэн лам нарт цэргийн тусгай татвар ногдуулж, аажмаар өсгөн нэмэгдүүлсэн, 1936 оноос дээд ангийн лам нарт олз ашгийн тусгай албан татвар оногдуулсан зэрэг сүм хийд лам нарт холбогдсон төрөөс явуулсан бодлогыг илтгэх баримтууд бий.

1937 оны 10 дугаар сард хуралдсан, МАХН-ын III бүгд хурал, “Тус орны доторх хувьсгалын эсэргүүчүүдийн ажиллагаа идэвхжиж байгаа асуудалд зориулагдсан” бөгөөд улс төрийн сонор сэрэмжийг бүх талаар дээшлүүлэхийн чухлыг онцлон тэмдэглэж, одоо намын гол зорилтын нэг бол дотоодын дайснуудтай тэмцэх явдал мөн гэжээ<sup>19</sup>.

“Лам нарын тоо бүртгэлийн тухай” ДЯЯ-ны сайдын тушаалд (1937.01.30.), “Манай улсын гол үндсэн зорилго болбол феодалын үндсийг үндсээр нь устгах зорилготой бөгөөд энэ нь даруй лам нарын суртал ба лам нар лугаа тэмцэх зорилт мөн бөлгөө”<sup>20</sup> хэмээн цохож, лам нарыг шашин шүтдэгийн хувьд бүрмөсөн нийгмийн давхаргаас арчин хаях бодлогыг агуулснаар барахгүй бүр аллага хядлагаар эл асуудлыг гүйцэтгэхээ зарлан тунхаглажээ.

17 Лам нар сүм хийдийн хэлмэгдэл ба цагаатгал. УБ., 2008. т. 19.

18 Ц.Цэрэн. “Лхүмбийн хэрэг” гэгчид холбогдуулан голчлон буриадуудыг хэлмэгдүүлсний учир шалтгаан илтгэл - (“Лхүмбэ-110 жил” эрдэм шинжилгээний бага хурал. УБ., 2012. т. 72-81.

19 БНМАУ-ын түүх. УБ., 1955. т. 375.

20 Ш.Агваан. Х.Чойбалсан ба Дотоод явдлын яам. УБ., 1991. т. 20-21.

Албан ёсны мэдээнд дурдсанаар, улс төрийн хилс хэрэгт өртөгдсөн 20 474, түүнээс хуулийн дээд хэмжээ оноогдсон 14 201 лам, 6273 нь сурвалжит угсаа гаралтан, чинээлэг малчид, худалдаачид, төрийн байгууллагын ажилтнууд, сэхээтнүүд, тодорхой ажил эрхлээгүй хүмүүс байсан бөгөөд 5103 нь 10 жилийн ял, 240 нь 10 хүртэлх жилийн хорих ялаар шийтгүүлсний 3380 нь лам нар, үлдсэн 1963 нь олон төрлийн ажилтай хүмүүс байв. МАХН, Ардын төр 1934-1937 онд шашин лам нарын талаар явуулсан бодлогын гол агуулга нь шашныг мөхөөхөд бүрэн чиглэж үүнийг хэрэгжүүлэхдээ эдийн засгийн хөшүүргийг гол болгосон юм. Бодит ашиг орлогоос хэт өндөр албан татварт сөхөрсөн бүх хүрээ хийд 1937 оны эцэс гэхэд үндсэндээ үйл ажиллагаагаа зогсоож, лам нар харын дансанд шилжсэн байна<sup>21</sup>.

Архивын 1937 онд хамаарах баримтад, ”...Хаагдсан хүрээ хийдийг хэрхэх тухай хянан боловсруулваас улсын дотор байгуулагдсан хүрээ хийд, жалгын жасын дуган бүгд нийлж долоон зуун далан нэгэн (771) тооны хурал, мөргөлийн газар байснаас энэ завсар долоон зуун жар (760) нь өөрийн урсгалаар бүрмөсөн хаагдаж утсан”<sup>22</sup>-г дурдаад уг хаагдсан сүм хийдийг юуны урьд олон сургууль, малын эмнэлгүүд, цэргийн ба хязгаарын отрядууд, өвс хадлангийн станцууд, лам нарын нэгдэл буюу гар үйлдвэрийн артель, эвлэлүүдэд ба худалдааны байгууллагуудад гол болгон чухалчилж олгох саналыг агуулжээ.

Төгсгөл: Их хэлмэгдүүлэлтийн үеийн орон нутгийн үнэн дүр төрхийг гаргахын тулд аман түүхийн судалгаа болон бичгийн сурвалж дахь задлан шинжилгээнд анхаарал хандуулан хэлмэгдүүлэлтэд өртсөн иргэдийн талаарх судалгааг лавшруулан хийх нь ганцхан орон нутгийн судалгаа бус нийт монголчуудад нүүрлэсэн аюулын талаарх нарийн дүн тоог гаргахад хэрэглэгдэх болно. Цаашид бид хэлмэгдэгсдийн тоог бүсчилсэн хэлбэрээр буюу аймгуудын архивын сан хөмрөгт буй баримтуудтай тулган, сум сумаар нь нягтлан гаргах хэрэгтэй байна. Ингэснээр эл аймшигт яргаллын үнэн дүр төрхийг хожмын судлаачдын болон олон түмний сэтгэхүйд зөвөөр ойлгуулахад дөхөмтэй юм.

21 Лам нар сүм хийдийн хэлмэгдэл ба цагаатгал. УБ., 2008. т. 47.

22 Монгол Улс, УТА. Улс төрийн нам ба олон нийтийн байгууллагын архив. х.4, д.6, хн.120, хуудас 6-12.



## ХАР ЖАГСААЛТ ХААНААС ЭХТЭЙ ВЭ?



*С.Энхжин  
Доктор (Ph.D), Дэд профессор  
МУБИС-ийн Түүхийн тэнхим*

Хураангуй: ХХ зууны тэргүүн хагаст үзэл суртлын сөргөлдөөний уршгаар дэлхийн улс орнуудад хэлмэгдүүлэлт хэмээх их яргалал явагдсан ба Монгол улс энэ үйл явцад татагдан орсон билээ. Монголд 1937 оны 8 дугаар сарын 24-нд ЗХУ-ын Дотоод хэргийн ардын комиссариатын орлогч М.П.Фриновский, Батлан хамгаалах яамны дэд сайд Д.И.Смирнов нар “Заговор” буюу “Хуйвалдаан” гэсэн хэргээр 115 хүний нэрсийн жагсаалт авч ирсний дагуу мөн оны есдүгээр сарын 10-ны шөнөөс өргөн баривчилгаа эхэлсэн билээ. Энэ жагсаалтыг судлаач миний бие хар жагсаалт хэмээн нэрлэсэн юм. Яагаад гэвэл тусгаар тогтносон бүрэн эрхт Монгол улсын дотоод хэрэгт Зөвлөлтийн зүгээс гүнзгий хутгалдан хэдийнээс бас хаанаас ийм олон хүний нэрсийн жагсаалт гаргаж ирсэн бэ? гэдэг асуудлыг дэвшүүлэн тавьж, түүхэн баримт түшиглэн судлан тодруулахыг зорив. Их хэлмэгдүүлэлт буюу их яргаллын түүх бичлэгт энэ тухай тусгайлан нягтлан судлаагүй ирсэн. Харин зөвхөн Фриновский 115 хүний нэрийг Гэндэн байцаагдаж байхдаа хэлсэн гэсэн байдаг. Гэхдээ Гэндэн түүний хамсаатан хэмээн байцаагдаж байсан хүмүүс хэлсэн төдий биш харин Зөвлөлтийн талаас Монголыг хяналтандаа авах гэсэн олон үйл ажиллагааны үр дүнд “Хар жагсаалт” үүссэн ба энэ жагсаалтыг цаашид өргөтгөх арга хэмжээ авч хэрэгжүүлэх зорилгыг анхнаасаа төлөвлөжээ.

**Түлхүүр үг:** Лхүмбэ, хувьсгалын эсэргүү, японы тагнуул, нэрсийн жагсаалт.

1930-аад оноос Коминтерний төлөөлөгчийн газраар дамжуулан Сталин тэргүүтэй Зөвлөлтийн удирдлага Монголын улс төр, нийгмийн харилцааны олон салбарын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцон өөрийн нөлөөний бүсэд оруулах болсон юм. Ялангуяа 1932 онд Япон манжуурт цэргийн хүчээ хуримтлуулан Монголын дорнод хил японы

түрэмгийллийн аюулд өртөх болсон явдалтай холбоотойгоор Зөвлөлт алс дорнодын аюулгүй байдалдаа онцгой анхаарал хандуулах болсноор Монгол улсын гадаад, дотоод харилцаанд бүрэн хяналтаа тогтоохыг эрмэлзжээ. Энэ байдлыг эсэргүүцсэн монголчуудын аливаа үйлдлийг Зөвлөлтийн эсрэг үйл ажиллагаа хэмээн үзэх болж улмаар монголын улс төр, нийгмийн зүтгэлтнүүдийн дунд ардын хувьсгал, ардын засгийн дайсан, Зөвлөлтийн эсрэг үзэлтэн, Японы тагнуулууд байна хэмээн тэднийг илрүүлэн, хорлон сүйтгэх үйл ажиллагааг нь таслан зогсоход гол анхаарлаа хандуулжээ. Үүнээс үүдэн Лхүмбийн хэрэг гэгч зохиомол хэргийг үүсгэн энэ хэргээс хойш хар жагсаалт хөтлөх болж, тэр жагсаалтаар их баривчлагаа эхлэн буудан алах ялаар 22000 гаруй хүний амь үрэгдсэн билээ.

### **Лхүмбийн хэрэг ба хар жагсаалт бичигдэх болсон нь**

МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга Ж.Лхүмбийг японы тагнуул хэмээн 1933 оны 7 дугаар сард баривчлан байцаажээ. Энэ хэргийн талаар 1934 оны 5 дугаар сарын 23-ны өдөр БХК(б)Н-ын Төв Хорооны Улс төрийн товчооны хурлаар хэлэлцжээ. Хурлаас японы тагнуулын байгууллагын удирдлагуудад ялын дээд хэмжээг хэрэглэх тухай хэлэлцсэн ба Монголын байгууллагын удирдлагуудад ялын дээд хэмжээ оногдуулах гэсэн монголын Дотоодыг хамгаалах газрын саналыг эсэргүүцэхгүй гэж тогтсоноос гадна хэрэв Улсын Бага Хурал дээд хэмжээний ял оноосон зарим хүмүүсийн шийтгэлийг хөнгөлөх санаачлагыг өөртөө авбал нөхцөл байдлыг тухайн үед нь мэдэгдэж байхыг Монголд төлөөлөгчөөр ажиллаж байсан С.Е.Чуцкаевт даалгасан байна. Энэ үеэс оросын тагнуулын ажиллагааны хяналтад Монголын засаг, төрийн удирдах албан тушаалтнууд, тэдний удирдлага дахь бүх шатны байгууллагад ажиллаж байсан боловсон хүчин орох болжээ. БХК(б)Н-ын Төв Хорооны Улс төрийн товчооны хурлын тогтоолыг хэрэгжүүлэх шахалтын доор Монгол Улсын Бага хурал 1934 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 22-р хурлаар Ж.Лхүмбэ тэргүүтэй 56 хүнд буудан алах ял оноожээ. Ж.Лхүмбийн хэрэг гэгчид холбоотой хэмээн 2500 хүний нэрийг гаргаж түүнээсээ 500 гаруй хүнийг баривчлан байцааж 317 хүний хэргийг шүүн таслажээ. Үүнээс 56 хүнийг буудан алах, 136 хүнийг 3-10 жилээр хорих, 126 хүнийг Зөвлөлтөт цөлсөн байдаг. Лхүмбийн хэрэгт холбогдуулан Орос руу цөлөгдсөн монголчуудыг тагнах болжээ. Түүгээрч зогсохгүй ЗСБНХУ-д Монголоос очсон хүмүүсийн нэрсийн жагсаалт гаргахыг А.Х.Артузовт даалгаж, ЗСБНХУ-д байсан зарим монгол хүмүүсийг буцаах боломжийг судлах, ЗСБНХУ-д байхдаа хийсэн үйл ажиллагааны байдлыг шалгах, ямар нутагт байсан, хаагуур явсан зэргийг судалж бүртгэлжүүлж эхэлсэн ба Лхүмбийн хэргээр цөлөгдсөн хүмүүстэй уулзах зэргээр ямар нэгэн байдлаар харилцаж байсан хүмүүсийг бүртгэж тэднийг японы тагнуул, хувьсгалын дайснууд хэмээн хардах болсноор хар жагсаалтын нэрс үүдэн бичигдэх болсон байна. Үүнийг нотлох нэгэн жишээг дурдвал Л.М.Каракан БНМАУ-д

явсан ажлын тайландаа Ерөнхий сайд П.Гэндэн түүнтэй уулзах үедээ тавьсан хүсэлтийн тухай бичжээ. Түүнд Ерөнхий сайд П.Гэндэн “Монголоос явуулсан тус байгууллагын хэрэгт холбоотой хүмүүсийг (суралцаж байгаа зэрэг монголчуудын дунд бүлэглэн ажиллах явдал гаргуулахгүйн тулд) Москвад нэг дор байлгахгүй байхыг хүссэнийг харгалзан монголоос ирүүлсэн ажилтнуудыг ажил, сургуульд томилох тухай Монголын комиссын тавьсан асуудлыг хурдавчлан шийдвэрлэхийг Улс төрийн товчооноос хүссэн байна.”<sup>1</sup> Энэ баримтаас Зөвлөлтөд Лхүмбийн хэрэгт холбогдон цөлөгдсөн монголчууд мөн сургуульд суралцахаар бас албан ажлаар очсон монголчуудын хоорондын холбоо харилцааны талаар нарийн судалгааг хийж эхэлснийг илтгэж байна.

### **Улс төрийн томилгоо ба хар жагсаалт**

БНМАУ байгуулагдсаны 10 жилийн ойд ЗСБНХУ-аас оролцох төлөөлөгч нарт Монголын нөхөдтэй үндсэн 5 асуудлаар тохиролцоо хийхийг төлөөлөгчдийн ахлагч Л.М.Караханд даалгажээ. Ажлын төлөвлөгөөний 3 дахь хэсэгт Ж.Лхүмбийн японы тагнуулын байгууллагыг устгасан сургамжийг харгалзан 1934 оны 9 дүгээр сард хуралдах МАХН-ын намын IX их хурал, 12 дугаар сард хуралдах Улсын VII их хурлаар сонгох гэж байгаа үндсэн дээд удирдлагын бүрэлдэхүүнд оруулах хүмүүсийн тухай Москвад илтгэхийн тулд урьдчилан итгэмжилсэн байх, итгэмжлэхийн тулд тэдний талаар сайн мэдэж авахыг хичээх гэсэн даалгавар өгсөн байна. Өөрөөр хэлбэл Монголын улс төрийн зүтгэлтнүүдийг аливаа албан тушаалд томилохдоо японы тагнуул, ардын дайсан биш гэдгийг тогтоон итгэмжлэх хэрэгтэй болноос үүдэн томилох хүнээ сайн судлах, итгэмжлэх нэрийдлээр монгол дахь зөвлөлтийн төлөөлөгч нар тагнан турших болсон ба монголчуудаас мэдээлэл цуглуулах нэрийдлээр нэгнээс нь нөгөөгийн талаар тандан асуух байдлаар олон сувгаар мэдээлэл авч байжээ. Энэ байдал нь монголын нөхдийн дунд зөрчилтэй нэгнээ ховлон гутаах, гүжирдэн гүтгэх байдлаар өөрийн замаасаа зайлуулах муу санаа агуулах хэмжээнд хүргэсэн нь монголд харийнхан эхлүүлсэн хэлмэгдүүлэлт газар авах дотоод үндсэн шалтгааны нэг төдийгүй хар жагсаалт бүрдэх нэгэн сэжүүр болжээ.

### **Лам нартай хийх тэмцэл ба хар жагсаалт**

БНМАУ-ын дорнод хилийн орчим түгшүүртэй нөхцөл байдал бий болжээ. Зөвлөлтийн удирдагч нар японы арми монголын нутаг дэвсгэрт цөмрөн орох үед тэдний Монгол дахь гол холбоотон бол харгис лам нарын дийлэнх хэсэг байх ба тэд японыг гар хөл болно. Улмаар сүсэг бишрэлийг ардуудыг ашиглан тэмцэлдээ татан оролцуулах зэргээр монголын тусгаар тогтнол, дотоод гадаад байдалд аюул учрах болно. Тиймээс лам нартай шийдвэртэй тэмцэх шаардлагыг монголын улс төрийн зүтгэлтнүүдэд тавьж, шахалт үзүүлж байв. Түүгээр барахгүй

<sup>1</sup> Монголын тухай БХК(б)-ын баримт бичиг. (баримтын эмхэтгэл) II боть. УБ., 2005.т.88

ЗХУКН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны хурлаар монголын дотоод асуудал болох лам нарын талаар ямар арга хэмжээ авах талаар хэлэлцэж тогтоол гаргаж байв. Жишээ нь ЗХУКН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо 1935 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн хурлын 34-р тогтоолд “*Лам нарын хувьсгалын эсэргүү байгууллага нь Монголын олон улсын байдал хурцдах тусам төдий чинээ хүчтэй болж Японы булаан эзлэгчдийн талд өөрийн ард түмнээс урвагчид болох тул лам нартай хийх тэмцлийг сулруулахгүй байхыг Монголын удирдлагад зөвлөх хэрэгтэй*” гэж заажээ.

Лам нар, сүм хийдийн зохион байгуулалттай хүчийг довтлон устгах нэрийдлээр олон мянган гэмгүй лам нарын амь насыг хороохоос болгоомжлон түүний эсрэг зогссон Монголын удирдагч, албан хаагч нарыг хар жагсаалтад оруулсан юм. Тухайлбал 1936 оны 3 дугаар сард Ерөнхий сайд П.Гэндэнг албан тушаалаас нь зайлуулж, амраах нэрийдлээр Зөвлөлтрүү явуулж, 1937 оны 7 дугаар сарын 17-нд хувьсгалын эсэргүү хэрэгт холбон баривчилж, улмаар түүнийг лам нарын “Төв” хэмээх хувсгалын эсэргүү хэрэгтэй холбосон байна.

### **Дотоодыг хамгаалах газар ба хар жагсаалт**

Монголын удирдлагуудын дунд үзэл баримтлалын зөрүүтэй байдлаа дэвэргэн өөрт таалагдахгүй нэгнээ буруутан болгох явдал 1935 оноос газар авах шинжтэй болжээ. 1935 оны 12 дугаар сарын 14-нд С.Чуцкаевын Г.Дэмидтэй хийсэн ярианы тэмдэглэл үүнийг нотлох нэг баримт болно. Тэмдэглэлд “Дотоодыг хамгаалах газрыг Гэндэн дангаараа удирдаж, Төв Хорооны Тэргүүлэгчдийн хуралд Дотоодын хамгаалах газрын асуудлыг хэлэлцүүлэхийг бараг огт зөвшөөрдөггүй гэж тэр хэлэв”. Намсрай Гэндэнгийн бүрэн захиргаанд байж, түүний бүх заавар, даалгаврыг биелүүлж байна. ...Тэргүүлэгч гишүүдийг мөрдөн мөшгөх ялангуяа Лувсаншаравтай Гэндэнгийн ярилцсан яриа. Үүнд Гэндэн хэн нэгний нэр хүндийг гутаахын тулд Намсрайгаар дамжуулан Дотоодыг хамгаалах аппаратыг ашиглах санаагаа илчилсэн явдал. Хэн нэгний тухай Намсрайд хэлэхэд л хангалттай. Тэрээр тэр даруй нь л Дотоодыг хамгаалахын протоколуудад таалагдаагүй тэдгээр хүмүүсийн эсрэг ямар ч ялыг бий болгочихно. ...Лувсаншаравтай ярилцсаны дараа Гэндэн түүнээс ихэд айх болж, аль болох түүний санаанд нийцүүлэх болсон. Лхүмбийн хэрэгт Гэндэн, Намсрай нар холбогдолгүй олон хүмүүсийг хутгалдуулсан. ...Ер нь дотоодыг хамгаалахынхны ажлын тухай, байцаалтын дамжлагын арга, айлган сүрдүүлэх зэрэг янз бүрийн хэргийн мөрдөн байцаалт буруу явагдаж байгаад гомдол мэдүүлсэн ихээхэн материал А.Амарт бий. Энэ бүх ажлыг Монголын мөрдөн байцаагчид явуулсан. Сургагч нар хэргийг дуустал судлаагүй байж эхний протоколд итгэн сул анхааралгүйгээр байдал гаргаж байна.”<sup>2</sup> гэжээ. Баримтаас дүгнэхэд Монголын төр засгийн байгууллагын удирдлага, албан хаагч нар ажил дээр гарсан зарим нэг санал зөрсөн асуудлыг

2 Монголын тухай БХКБН-ын баримт бичиг. II боть. УБ., 2005. т.155

шийдэхдээ нэг нөхрөө ажил хэрэгтээ зөвлөлтийн нөхдийн зөвлөгөөг дагахгүй байна хэмээн үзэл сурталжуулж коминтерний төлөөлөгч, сургагч, мэргэжилтэн нарт хов хүргэдэг байсан нь тэдэнд монголчуудын дунд зөвлөлтийн эсрэг үзэлтнүүд байгаа гэсэн итгэл үнэмшлээ бодит зүйл хэмээн улам олон хувьсгалын дайсан илчлэх эрэлд гаргадаг байжээ.

### Олонхийн улс төрийн шийдэмгий бус байдал ба хар жагсаалт

Монголын удирдагчдын дотор хэлмэгдүүлэлт, хууль ёсыг завхруулах байдлыг зүгээр хараад суугаагүй бөгөөд улс төрийн зоримог шийдвэр гаргаж байв. Ардын хувьсгалын 15 жилийн ойн баяраар Улсын Бага Хурлын дарга Д.Догсом, Ерөнхий сайд А.Амар нар хамтран Лхүмбийн хэрэгт холбогдон хилсээр ял эдлэгчдийг хамруулан суллах тухай тогтоолыг баталжээ. Гэвч уг тогтоолыг Намын Төв Хороо 1936 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн хурлаар хэлэлцэн буруушааж Ерөнхий сайд А.Амар, Улсын Бага Хурлын дарга Д.Догсом нарыг шүүмжлэн, дахин иймэрхүү тогтоолыг “Намын Төв Хорооны зөвшөөрөлгүйгээр гаргаж болохгүй гэсэн анхааруулга санамж авчээ”<sup>3</sup>. Үүнээс өмнө удирдагчдын дунд уг хэрэг (өршөөлд хамааруулах нь) буруу зүйл биш байсан гэж нэг биш удаа яригдаж байснаар барахгүй Дотоод яам болон холбогдох газрууд нь уг хэргийг нягтлан хилс хэрэг хэмээн тогтоож байжээ.

Энэ нь уг хурал дээр Ерөнхий сайд А.Амарын хэлсэн үгнээс тодорхой байна. А.Амар “... Ерөөс эсэргүү группийн хэрэгтнээс дөрвийг үлдээж бусдыг сулласан нь Дотоод яамны саналыг авч тогтоосон ба бас ч тухайд таван газраас томилогдсон бүрэн эрхтэй комисс нь бас л энэ хэргийг их л хянаж гүйцэтгэсэн хэрэг хэмээн санана. Гагцхүү бурууг Догсомд хүлээлгэхгүй би хамт хүлээлцэнэ”<sup>4</sup> гэсэн байна. Түүнчлэн Монголын төр, засгийн удирдагч нар хилс хэрэг удаа дараа гарах болсныг хүлээн зөвшөөрч, санал нэгдсэний үндсэн дээр гаргасан шийдвэрээсээ эргэж буцаж байгааг эрс шударга гэмдэглээд, цаашид шийдвэр гаргагчид өөрсдөө үнэн бодит байдлыг хэлэхээс айж болгоомжлох нь хилс хэрэгт олон энгийн ард хэлмэгдэн амь насаа алдах аюул даамжрахыг анхааруулж, хамтран хариуцлага үүрч, шударга жишиг тогтоох ёстой гэсэн улс төрийн байр сууриа илэрхийлсэн хэрэг юм.

Гэвч удирдагч нар нэг бат цул нэгдэл болж чадаагүй юм. Энэ нь дараах шалтгаантай. *Нэгд*, Зарим удирдагчид уг тогтоолыг батлан гаргахыг мэдсэн ч мэдээгүй мэт дүр эсгэж, хэргийг үнэнээр шийдэхээс айж цэрвэж байсан нь тодорхой байна.

*Хоёрт*, Төрийн эрх барих дээд хоёр субъект болох Улсын Бага хурал, Засгийн газраас гаргасан шийдвэр Намын шийдвэрээр няцаагдсан нь төрийн байгуулалтанд гажуудал гарсныг нотолж байна.

*Гуравт*, Дотоод яам болон холбогдох таван газраас томилсон комиссын саналыг Намын Төв Хорооноос үл тоож байгаа нь төрийн

3 Монгол Улсын Үндэсний төв архив, Улс төрийн нам, олон нийтийн архив. х.4, д.5, хн.189, хуудас 57

4 Монгол Улсын Үндэсний төв архив, Улс төрийн нам, олон нийтийн архив. х.4, д.5, хн.189, хуудас 80.

байгууллагуудын эрх мэдэл хязгаарлагдмал байсныг гэрчилж байна.

*Дөрөвт*, Тогтоолыг сарын өмнө баталж, хэрэгтнүүдийг нэгэнт сулласан үед буюу 8 дугаар сарын 10-ны өдөр дахин авч хэлэлцэж байгаа нь гадны буюу Коминтерний төлөөлөгч нарын ятгалга, буруушаалтаас үүдсэн гэж үзэж болохоор байна.

### **Зөвлөлтийн эсрэг этгээдүүд ба хар жагсаалт**

1936 онд ЗСБНХУ-ын Үндсэн хуулинд сонгуулийг ардчилсан зарчмаар явуулахаар заасан ч үнэн хэрэгтээ 1934 оноос газар авсан хэлмэгдүүлэлтийг гааруулж, улмаар хил дамнан Монгол зэрэг социалист системийн орнуудад хэлмэгдүүлэлт буюу их яргалал явагдах үндсэн шалтгаан болсон билээ. ЗСБНХУ-ын Дээд зөвлөлийн сонгууль 1937 оны 12 дугаар сард болохоос өмнө Зөвлөлтийн эсрэг этгээдүүдийг илчлэн, тэднийг сонгуульд оролцуулахгүй байх шаардлагын үүднээс их баривчлагаа эхэлжээ.

БХК(б)Н-ын Улс төрийн товчоо 1937 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаар “Зөвлөлтийн эсрэг этгээдүүдийн тухай” №51/94 тоот тогтоол гаргаж, түүний дагуу улс даяар их цэвэрлэгээ хийх тухай ДХАК-ын 00447 тоот тушаал гарчээ. Тушаалыг боловсруулах, бэлтгэл ажлыг хангах, төлөвлөх, хэрэгжүүлэхэд Ежовын орлогч М.Фриновский голлох үүрэг гүйцэтгэжээ. Тушаалын хэрэгжилтээр 1937 оноос “их хядлага” хэмээн нэрлэгдсэн хэлмэгдүүлэлт эхэлсэн гэж судлаачид үздэг. Энэ үеийг зөвлөлт-оросын түүхч, судлаачид уг тушаалд гарын үсэг зурж, хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулсан ДХАК-ын удирдагч Ежовын нэрээр “ежовщина” буюу “ежовчлол” гэж бас томъёолж ирсэн.<sup>5</sup>

Энэ ажиллагааны хүрээнд ЗСБНХУ-аас БНМАУ-д суух бүрэн эрхт төлөөлөгч Х.Таиров баривчлагдсан ба түүний оронд томилогдсон С.Миронов Ежовын орлогч М.Фриновскийн хамт монголд 1937 оны 8 дугаар сарын 24-нд Монголд иржээ. Энэ томилолтын бүрэлдэхүүнээс харахад Сталин, Ежов нарын хувьд Зөвлөлтийн бусад холбоотноос илүү чухал эмзэг цэг нь Зөвлөлтийн хяналтыг эсэргүүцсэн монголын улс төр, нийгмийн зүтгэлтнүүд, энгийн шударга ард иргэд, буриадууд, лам нар байсан учир тэднийг Зөвлөлтийн эсрэг этгээдүүд хэмээн хар жагсаалтыг зохион түүний дагуу их баривчлагаа эхлүүлжээ.

### **Зөвлөлтөөс Монголд томилогдон ажилласан төлөөлөгч нар ба хар жагсаалт**

Зөвлөлтөөс Монголд томилогдон ажилласан төлөөлөгч нар хилс хэрэг тохооход гол үүрэг гүйцэтгэж байсан юм. Ер нь 1930-аад онд Зөвлөлт болон түүний системд орсон улс орнуудад хувьсгалын эсрэг дайснуудтай тэмцэх тэмцлийн үед хэн ч байсан нэг өдөр хилс хэрэгт гүтгэгдэн амь насаа алдах аюултай тийм ороо бусгаа цаг үе байсан ажээ.

5 С.Туяа. Хийрхэлээс хэлмэгдүүлэлт (1930-1950-иад он) УБ., 2016. т.59



Монгол дахь Зөвлөлтийн бүрэн эрхт төлөөлөгч нар ч өөрсдөө хувьсгалын дайсан болохоос айж, И.В.Сталин болон большевик хувьсгалд үнэнч болохоо харуулах нь тэдний амьд үлдэх шалтгаан байжээ. Тиймээс тэд томилогдон очсон газраа аль болох олон хувьсгалын дайсан, Зөвлөлтийн эсрэг үзэлтнүүдийг илчлэн, баривчлах явдал чухал шалгуур байсан бөгөөд тэд сүржин бөгөөд маш үнэмшилтэй, итгэл төгс илтгэх хуудас бичиж байв. Энд нэг баримт өгүүлбэл Улаанбаатараас ЗСБНХУ-ын Дотоод хэргийн ардын комиссарын орлогч Фриновский Дотоод хэргийн ардын комиссар Ежовт илгээсэн 1937 оны 9 дүгээр сарын 13-ны цахилгаан мэдээнд “Энэ оны 9 дүгээр сарын 7-нд ”Чойбалсан, Амар нартай Ёнзон ба Дамдинг баривчлах тухай асуудлыг тохиролцлоо. ...Амартай тааламжтай холбоогоо ажил төрөлдөө ашиглаж, учрыг олохын тулд 300 хүртэл хүнтэй төвд лам нарын бүлгийг эцэст нь хүртэл бут цохих шаардлагатай гэж үзэж байна”<sup>6</sup> гэж А.Амар, Х.Чойбалсан нарт нөлөөлж баривчлагаанд аль болох олон хүн хамруулахыг хичээж байжээ.

### Онцгой комисс ба хар жагсаалт

Хувьсгалын эсэргүү нарын хэргийг шүүн таслах Онцгой комисс гэгчийг Х.Чойбалсангаар толгойлуулан 1937 оны 10 дугаар сарын 20-нд байгуулсан бөгөөд энэ комиссоор дамжуулан хар жагсаалтыг цааш өргөжүүлэх зорилготой байлаа. Энэ дүгнэлт нь Монголын тухайн үеийн түүхэнд холбогдох олон баримтаар нотлогдох ба энд нэг маш тодорхой тоо баримтыг толилуулъя. 1938 оны 4 дүгээр сарын 3-нд нэмэлт баривчилгааны тухай баривчлах ажлыг үргэлжлүүлэх нь зохистой эсэх талаар И.Н.Мироновоос М.П.Фриновскийд мэдээлсэн мэдээлэлд<sup>7</sup> “Хуйвалдааны нэгдсэн төвтэй холбогдсон хэргээр нэмэлт баривчилгаа явагдаад байна. 3 дугаар сарын 30-ны байдлаар бүгд 10728 хүн баривчлагдсан. Тэдгээрээс лам 7814, түүний дотор төвд лам нарын дээд зиндааныхан бүгдээрээ, буриадууд 1655, феодал 322, яамны хариуцлагатай түшмэл 300, Монголын Ардын хувьсгалт армийн дээд ба ахлах бүрэлдэхүүний 180 хүн, хятадууд 408 байна. 7171 хүнийг хянаж авч үзсэн түүнээс дотоод Монголын үндэсний үзэлтнүүд 6311 байна. Тагнан турших мөрдөлтийн нэмэлт материалаар 6000 ламыг тэдний дотор зөвхөн дээд зиндааныхны үлдэгдэл төдийгүй зөвлөх тарнич, үзмэрч, домч, сүүлийн үед хувьсгалын эсэргүү ажил нь ихээхэн идэвхжиж буй хөдөөтэй өөрийн холбоо сүлбээгээрээ аюулт хүч болох дундчууд байна. Баривчлахаар завдаж байна. Япон, Оросын буриадын байгууллагын хэргийн нэмэлт мэдүүлгээр 900 орчим хүн, мөн нэмэлт мэдүүлгээр 200 хятад, бас яамдын түшмэд 86 хүнийг баривчилбал зохих байна. ... лам нарын дээд зиндааныхны үлдэгдэл, дундаж лам нарын идэвхтэй хэсгийг 4 сард багтаан ойролцоогоор 4000 хүнийг баривчлах, Буриадуудын дотроос тооцооны ажилтнуудыг баривчлахыг 3 сар түдгэлзэх, Монголын Ардын хувьсгалт армийн цэрэг халагдах хүртэл

6 Монголын тухай БХКБН-ын баримт бичиг. II боть. УБ., 2005. т.248-249

7 Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичиг. (баримтын эмхэтгэл) II боть. УБ., 2005. т.261

цэргүүдээс энэ хугацаанд тэднийг тооцоонд сургах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрэв. Өөр тохиолдолд ихэнх худалдааны байгууллагын бүртгэл тооцоо зогсох болно. Яаралтай заавар өгөхийг хүсье”<sup>8</sup> гэжээ. Энэ ганцхан хуудас цаасанд ямар олон хүний амь нас, хувь заяа аймшигтайгаар шийдэгдэж байсныг харуулна.

И.В.Сталин тэргүүтний заавраар эхлүүлсэн гүжир гүтгэлэг, хууль зөрчсөн үйлдлийг Х.Чойбалсан үргэлжлүүлсэн нь түүхэн үнэн билээ. Тэдний үйл ажиллагаа хүний гараар могой бариулахтай адил хэмжээнд хүрсэн ба үүнд ч хууль бус энэ үйлдлийг 1934 оноос хүчтэй эсэргүүцэн 1936 онд Лхүмбийн хэргийг цагаатгах улс төрийн шийдвэр гаргаж байсан А.Амар сайд ч тагагдан орсон юм. Тухайлбал, Сайд нарын Зөвлөлийн 1937 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 30 дугаар хурлаар “Тус улсын олон яамд ба засаг захиргаа хийгээд аж ахуй, худалдаа, үйлдвэр олон нийтийн байгууллагуудад шургалан орж тэдгээр газруудын ажил хэргийг хорлон сүйтгэж байсан хувьсгалын эсэргүү Гэндэн, Дэмид нарын хорлон сүйтгэх ажлын үлдэгдэл хаягдлуудыг түргэн богино хугацааны дотор бүрэн устгах хийгээд ирэх 1938 онд дээрх олон байгууллагуудын дутуу орон тоонд 400-гаас доошгүй тооны шинэ хүчнийг дэвшүүлэх ба мөн 65 тооны шинэ хүчнүүдийг тусгай зардлаар бэлтгэх” тухай Ерөнхий сайд А.Амар, Х.Чойбалсан, Д.Лувсаншарав нар илтгэл тавьжээ.

### Дүгнэлт

Зөвлөлтийн талаас Монголыг бүхий л талаар хяналтандаа авах бодлого хэрэгжүүлж түүний үр дүнд “Хар жагсаалт” үүссэн ба энэ жагсаалтыг цаашид өргөтгөх арга хэмжээ авч хэрэгжүүлэх зорилгыг анхнаасаа хэрэгжүүлснийг түүхэн баримт, түүхэн үйл явдлууд нотлож байна.

Зөвлөлтийн алс дорнодын аюулгүй байдлаа хамгаалахад түшиц болох газарзүйн байршил болон зөвлөлтийн загварын социализм байгуулах дотоод их боломж нөөцтэй улс бол БНМАУ байлаа. Тиймээс зөвлөлтийн хяналтыг эсэргүүцсэн монголын улс төр, нийгмийн зүтгэлтнүүд, энгийн шударга ард иргэд, буриадууд, лам нарыг зөвлөлтийн эсрэг этгээдүүд, японы тагнуул хэмээн хар жагсаалтыг зохион түүний дагуу их баривчлагаа эхлүүлжээ.

Үүнийг бодит хэрэг болгосон гол хүчин зүйл бол 1935 оноос ЗХУКН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны хурлаас Монголын талаар гаргасан тогтоолуудын дагуу Монголын улс төр, нийгмийн хүрээний асуудлуудыг зохицуулахыг тулгасан ба Монгол улсын хууль эрх зүйн баримт бичгүүдээс ч илүү хүчтэй үйлчлэх болсон ба заавал биелүүлэх захирамжлалын шинжтэй баримт бичиг болжээ. Мөн Монголын төр засгийн байгууллагын шийдвэрээс илүү МАХН-ын Төв хорооны тогтоолыг хэрэгжүүлэхийг шаардах болжээ.

8 Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичигт” (баримтын эмхэтгэл) II боть, УБ., 2005.т.262

# II

ХЭСЭГ

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ,  
ЗӨВЛӨМЖ

## **“УЛС ТӨРИЙН ХЭЛМЭГДҮҮЛЭЛТ: ШАЛТГААН, ҮР ДАГАВАР, СУРГАМЖ” СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

*Н.Хишигт ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, Доктор (Ph.D), дэд профессор, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн.*

Олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан илтгэлүүдтэй холбогдуулан хийгдэх хэлэлцүүлгийг миний бие удирдан явуулна. Одоо ингээд нэгдсэн хэлэлцүүлэг эхэлж байна. Хэлэлцүүлгийн явцад зөвлөмжид тусгах саналаа хэлээрэй. Хэлэлцүүлгийн төгсгөлд бага хурлаас гарах зөвлөмжийг Та бүхэнд танилцуулна. Үг хэлэх хугацааг хүн бүр дээр 5 минутаар тогтоож байна. Ингээд Та бүхэн саналаа хэлнэ үү.

**Г.Чойжамц** (Монголын бурхан шаашинтны төв Гандантэгчинлэн хийдийн хамба лам):- Өнөөдөр их сайхан хурал боллоо. 1990 оноос хойш ийм юмыг хүсэн мөрөөдөж ирлээ. Нэлээн шахагдаж хавчигдан, хэлмэгдэж байсан тийм салбарын хамба хийдэг учраас ийм юмыг хүсэн хүлээж мөрөөдөж байсан. Олон жилийн турш мөрөөдсөн. Гэхдээ бодит биелэл гэдэг бол нэлээн хол байдаг юм байна. Ардчилал эхлээд ардчилсан хүмүүс болчихно гэж гэнэн сэтгэж бодож байсан юм. Маргааш нь ардчилсан улс болчихоод мундаг болно, хамаг буруу юмнууд нь засагдана гэж байсан чинь 27 жил болж байхад коммунист хэвээрээ л байж байх маягтай. Ерөөсөө хуучин нийгмээс тогтоож өгсөн, тэр янз бүрийн үзэл суртлаар тогтоосон зүйл, зүрх сэтгэлд оршиж байдаг тэр юмнууд нь дараагийн шинэ мэдлэг олж авах хүртэл оршин байдаг юм байна гэсэн ойлголттой байна.

Тийм учраас улс орны хөгжил дэвшил, намуудын хоорондын харьцаа, хүмүүс хоорондын харьцаа, өнөөдөр хэтэрхий дуураймтгай болж байгаа, үг хэл чангарч байгаа нь бид нар ардчилсан нийгмийн эхэн дээр алдаа, оноогоо сайн тунгаан бодолгүй, ганц эдийн засаг гэж улайрсны улаан гай боллоо, хамгийн түрүүнд боловсрол гэдгийг их анхаарах ёстой байж дээ гэж боддог.

Хэлмэгдлийн тухайд гарцаа байхгүй. Бид нарт хувьсгалын тохироо гэж хуучин коммунизмын үед ярьдагсан. Тийм тохироо бүрдэж хувьсгал болоогүй. Монгол Улс Манжаас тусгаарлах тохироо яах аргагүй 1911 онд бүрдсэн болохоос биш, коммунист хувьсгалыг хүлээж авах тийм суурь үндэс, нийгмийн байдал ч байгаагүй, энэ бол зохиомол хэрэг гэдэг нь бүр тодорхой. Энийг зохиомлоор оруулж ирэх явцад ганцхан Монгол биш, маш олон орнуудад хэлмэгдэл явагдсан. Бид ганцхан өөрөөрөө жишиж болохгүй.

Улс түмний найрамдал харьцааг бодох үүднээс өнөөдөр ганцхан улс руу, тэрний удирдагч улс руу ч юмуу зүхэж хараагаад байх нь зохисгүй байх. Яагаад гэвэл тэнд ч мөн адил байсан, асар их баялагтай, баян тансаг сайхан Орос орныг коммунист, социалист үзэл бодол ирж сүйдэлсэн, тэр үзэл бодлоо хамгийн мундаг юм гэж нэвтрүүлэх гэж яваад бусад орныг сүйдэлсэн байдаг. Тийм учраас энэ хэлмэгдүүлэлт бол ерөнхийдөө үзэл бодлын ангич, намч шинж чанар, буруу зөрүү онолын буруу, онолоо бүр буруудуулснаас гарсан гэж үзэх хэрэгтэй, ингэж явах юм бол бид нэлээн цэвэрхэндүү, энэ хэлмэгдлээ ярьж болох талтай юм болов уу даа гэж санагддаг юм.

Дээр нь сая Дашдулам “хэлмэгдүүлэлт нь тухайн үеийн нөхцөл байдлаас гарсан” гэж их сайхан хэллээ. Өнөөдрийн бид нарт гарч буй гачаал зовлонгуудын эхлэл хаана байна вэ? гэдгийг энэ хэлмэгдлээс эрэх хэрэгтэй, өнгөрсөн үзэл сурталжсан, ангижсан нийгмийн алдаа дутагдлаас гарсан зүйлүүд өнөөдөр үргэлжилж байгаа гэдэг нь ойлгомжтой байдаг. Энэ байдлуудыг өнөөдөр их сайхан тод гаргаж ирлээ.

Ер нь монголчууд ХХ зууны эхэн үед гацчихсан юм. Манай залуучуудын твиттер, фейсбүүк, олон нийтийн сүлжээ, сонин хэвлэлүүдийг үзэхэд ХХ зууны эхэнд л гацчихсан харагддаг юм. Үзэл суртал ХХ зууны эхэнд монголчуудыг гацаасан. Энэ гацаалт өнөөдрийг хүртэл гараагүй яваа. Манай залуучуудын сүлжээнд ороод харахад ил харагдаж байгаа. Тийм учраас энэ цаг үеэ мэдэрч өнөөдрийн манжирхуу маягтай үйл явдал, үзэл суртлын янз бүрийн юмнуудыг өнөөгийн нийгэмдээ тунгааж бодохгүй бол бид цаашдаа явахгүй болжээ гэдэг ийм юм энэ хурал дээрээс харагдлаа.

Хоёрдугаарт, энэн шигээ сайхан хурлуудыг зохион байгуулах хэрэгтэй юм байна. Хамгийн их хэлмэгдэлд өртсөн газар бол шашин ном, лам нар байсан. Тэд хэн байсан бэ? Тэдний эрхэлж байсан ажил хөдөлмөр, буддизмын ном философитой, өнөөгийн шинжлэх ухаантай тохирч байсан. Энэрэл нигүүлсэнгүй сургаалийг ярьж байсан тэдгээр хүмүүсүүдийг хадны мангаа болгосон. Тэр өнөөдөр ч үргэлжилж байгаа. Намайг Гандангийн хамба хийгээд 25 жил болоход, Лам нараа яаж шүү амьдруулаад байна, Гандан хийдийн мөнгө цаас чинь хүрэлцэж байна уу, үгүй юу?, байшин саваа ингэчихгүй дээ, энэ чинь нураад уналаа шүү дээ гэж асуусан хүн нэг ч байхгүй. Орж ирээд дандаа дээрэлхүү харцаар харж, Та нар сүсэгтний энэ их мөнгийг хаана хийсэн, ийм үгийг ярьдаг. Боллоцоо нөхцөлийг ярихаа байсан.

Энэ хэлмэгдэл бол үзэл бодол, шашин шүтлэгийнхээ эрх чөлөөнийхөө төлөө тэмцсэн, өмчөө хамгаалсан тэмцэл байснаас биш, засаг төрийн эсрэг байгаагүй гэдгийг хэлэх хэрэгтэй. Ийм учраас хоёр санал хэлчихмээр байна.

1. Хэлмэгдүүлэлт болсон Вьетнам, Кампучи, Лаос, Чех, Унгар, Орос, Хятад улсуудад шашин их хэлмэгдсэн, гэхдээ тэдгээр улсууд бүгдээрээ шашнаа зөв сэргээхийн тулд санхүүжилт хийж, сүм дуганыг, музейд байгаа хэрэглэлийг нь гаргаж өгсөн. Тэдгээр улсуудын хэлмэгдсэн шашнууд ард түмэндээ гараад ажлаа хийгээд явж байгаа.

Гэтэл Монголд болохоор, бид нарыг хаячихсан, бурхны шашныг бусад хүчтэй ар талтай шашнуудтай уралдаад ялбал ялаг, мөхвөл мөх гээд. Гэтэл энэ чинь хүн амын 60-70 хувь нь шүтдэг шашин, шашнаа хэзээ ч хаяхгүй, тэр үзэл бодлоо хаяхгүй нь монгол хүний араншинд байдаг. Хэрвээ энэ шашин буруу явах юм бол монголчууд хохирох юм. Америкт ч, Англид ч, хаана ч гэсэн тэр ард түмнээ зөв явуулахын тулд, зөв мэдлэг, зөв боловсрол, хүмүүжилтэй, хүмүүнлэг болгохын тулд ард түмнээ буруу явуулахгүйн тулд шашнаа дэмждэг.

Өнөөдөр, хэлмэгдлийг цагаатгахдаа хүн рүүгээ хандсанаас биш сүм хийд рүү хандаагүй шүү. Тийм учраас, хэлмэгдсэн шашнаа дээш татахад анхаарч, санхүүжилт өгч сүм дуганыг сайжруулж, боловсон хүчин бэлтгэх тал дээр анхаарч өгөөсэй гэж боддог, үүнийг хурлынхаа дүгнэлт, зөвлөмжид оруулж өгөөчээ.

2. Энэ улсын ирээдүйн хөгжил дэвшил хүүхдүүдээс хамаарна. Тийм учраас 10 жилийн сургуульд хэлмэгдлийн тухай, энэ болоод өнгөрсөн буруу үйл явдлуудыг үнэн зөвөөр нь гаргаж ирэхгүй бол “Сэрэлт”, “Улаан дарцаг” зэрэг кинонд итгэдэг хүүхдүүд төрж, коммунист хүүхдүүд өсч байна шүү. Өмчийн эсрэг хүмүүс болж өсч байна шүү. Үндэснийхээ хөрөнгөлөг хүмүүсийг, шашнаа ад үздэг ийм нийгмийг бид цогцлоохгүй шүү дээ, шинэ нийгмийг боловсон хүчингүйгээр хийхгүй. Бид 27 жилд ганц ч бодлого энэ тал дээр явуулаагүй шүү.

Л.Пүрэвдорж (МУТХХ):-Судлаачдад дуулгах нэг мэдээ байна. Энэ өдрүүдэд зохиолч Лодойдамбын мэндэлсний 100 жилийн ой болж байгаа юм. Сонин, хачин нэг мэдээ байдаг нь түүнийг шүдний эмчилгээний аргаар хорлож алсныг гэрчилсэн мэдээ юм. Тэр мэдээг ор үндэсгүй гэж хэлэхэд бас учир дутагдалтай. Гэрчилсэн хүн нь МАХН-ын Төв Хорооны УТТ-ны гишүүн, Төв Хорооны нарийн бичгийн дарга, СнЗ-ийн 1-р орлогч даргаар ажиллаж байсан хүн. Тэрээр Лодойдамбын үр хүүхдийг нь хэрэг болгож дуудаж уулзаад: би үхэхээс өмнө Та нарт нэг юм гэрчилье. Эцгийг чинь шүдний эмчилгээгээр дамжуулж хорлож алсан шүү. Энийг алсан хүмүүсээс гадна хоёрхон хүн мэднэ. Нэг нь тэр үед ЭХЯ-ны сайд байсан Дэмбэрэл, нэг нь би мэднэ гэсэн байдаг. Тэр хүн нь сүүлд ШУА-ийн ерөнхийлөгч байсан Базарын Ширэндэв. Энийг би нэг номонд бичсэн. Цаашаа яривал их юм бий. Миний бодоход, Ширэндэвт худлаа хэлэх шалтгаан ерөөсөө байхгүй юм шиг байгаа юм. Энэ нотлогдохгүй ч байж мэднэ. Гэхдээ



энийг судлаачдад дуулгачих юмсан, хэлмэгдэгчдийн холбоо бас мэдэж байгаасай гэсэн үүднээс хэлж байна.

Доктор Д.Дашдулам маш сонин санаа хэллээ. Хэлмэгдүүлэлт хоёр янз: 1950-иад оноос өмнөх нь аллага, хойшх нь улс төрийн хэлмэгдүүлэлт гэж, Яг тавиад оноос хойш хийж байсан улс төрийн хэлмэгдүүлэлт бүр зүсээ ч хувиргаагүй одоо хэрэгжиж байна шүү дээ. Намаар ялгаварлаад, улс төрийн үзлээр ялгаварлаад ажлаас халж байгаа нь чухамхүү улс төрийн хэлмэгдүүлэлт мөн биз дээ, өөр юу ч биш. Хичнээн олон хүний ажил амьдралыг сүйтгэж, үр хүүхдийг нь яаж байна, тэгээд төрийн албыг яаж бусниулж байна вэ, хохирол учруулж байна шүү дээ.

Тэгэхээр нэг ийм санал байна. Манай Хэлмэгдэгчдийн холбоо эхний алхам болгон улс төрийн үзлээр, улс төрийн шалтгаанаар ажлаас халагдаж хохирогсод, тэдний гэр бүл саданг бүртгэе. Улс төрийн хэлмэгдэгчдийн холбоон дээр гэсэн зар түгээгээд энийг бүртгэж үзвэл яасан юм бэ? Та нарт хүч хүрэхгүйг мэднэ л дээ, 7 хоногт 3 өдөр зарлаад бид мэтийн хүмүүс ирээд хөлс мөнгөгүй суугаад бүртгээд байхад болно. Ингэж бүртгэж үзээд үүнд Хэлмэгдэгчдийн холбоо дүгнэлт хийж үзвэл яасан юм бэ?. Ингээд байж болохгүй, хүнийг сүйдэлж байна шүү дээ. Бүртгэж үзэх энэ саналыг зөвлөмжинд оруулах юмуу?, Хэлмэгдэгчдийн холбоо бүртгэж үзэх д юм, харин хэлмэгдсэн эсэхийг сүүлд нь шүүх тогтооно шүү дээ.

Ш.Цогтоо (МУИС-ийн Хуулийн сургуулийн профессор):- Энд ирсэн хүмүүс ганц зорилготой, сэтгэл зүрхээ өвтгөн ирцгээсэн. Манай аав, ах, эгч буруугүй юм бол бидэнд хохирлыг минь төр засгаас барагдуулж өгөөчээ гэж зорьж ирсэн, олон ч жил ингэж зорьж яваа. Харамсалтай нь, энэ засагт АН, МАН, МАХН аль нь ч гарсан, Цагаатгалын комиссын даргаар 27 жилд тэдгээр намаас ээлжлээд ажилласан ч, энэ асуудалд тодорхой хандаагүй. Нэг, нэг сая төгрөг өгч хууран мэхэлсэнтэй бараг адил ийм юм болоод байна. Энэ юм яг хэвээрээ ингээд яваад байна гэдгийг эхэнд нь тэмдэглэж хэлье.

Хоёрт, Сайн илтгэлүүд байна. Баасандаш, Дашдулам профессорын асуудлыг шийдэх гэсэн тийм илтгэлүүд байна. Ихэнх нь хариуцлагагүй илтгэлүүд байна шүү дээ. Та нар боль л доо, лекц биш, магистрын ч түвшний биш юмнууд яриад, улиглаад бие биенийхээ юмыг давтаад байна. Хэрэв олон улсын, тэр дундаа эрдэм шинжилгээний хурал юм бол маргаан, мэтгэлцээн, шинэ үзэл бодол, шинэ хандлагагүйгээр энэ их хэлмэгдүүлэлт, цагаатгалын хэцүү асуудал чинь яаж урагшаа явах юм бэ? урагшаа явахгүй гэж би бодож байна. Хэлмэгдэл ба цагаатгалын асуудалд хандах хандлагыг өөрчлөх цаг нь болжээ. Тав, арван жилийн өмнө, ноднин ярьж байсан юмаа эргэн хурган ярихаас хэтрэхгүй хуучин сэтгэлгээндээ дүгнэлт хийгээчээ, манай Цагаатгалын

комиссынхон, Хэлмэгдэгсдийн холбоо ч ингэмээр байна. Үүний тулд би арга замыг нь нэг юман дээр хараад байна. Энэ хаалттай архивуудыг нээлттэй болгох шаардлагатай байна. Энэ шаардлагыг хангахгүй бол 20 жилийн өмнө хэлмэгдсэн гэж үзэж байсан хүмүүсийг, тэр үеийн төр засгийн удирдагч нарыг мөд хэлмэгдүүлэгч болгох буруу методологи, буруу подход, буруу үнэлэлт, дүгнэлт рүү явах тийм шинж ажиглагдаад байна гэдгийг хэлмээр байна. Манай судлаачид, түүхчид өөрсдөө шинэ хандлага, шинэ методологи руу ороочээ.

Гуравт, үнэнийг гаргаж тавих цаг болсон. Тэгэхгүй бол яаж энэ улсуудын төлбөрийг өгөх юм бэ? Үнэн гэхээр зэрэг ердөө л ЗХУ, Сталин, Чойбалсан, Коминтерн тэгээд л дуусаа. Тэд чинь бүгд байхгүй, дэлхийн хөрснөөс арчигдчихсан. Одоо хэн ч хариуцлага хүлээхгүй юм яриад байна. Тэрний оронд Баасандаш дарга, Дашдулам нарын яриад байгаа шиг монголчуудад өөрсдөд нь буруу байгаа шүү дээ, тэгвэл бурууг нь гаргаад тавьчих л даа, буруугүй нь хохирлоо аваг л даа, буруутай нь, хүүхэд нь бид нар ичээд сууж баймаар байна. Ийм юмыг хэлэхгүй, бүх архив нь хаалттай, бие биенийхээ юмыг эргэн эргэн хуулаад байна. Сталин чинь эхнэртэй нь явалдахын тулд нөхрийг нь баривчил гэж хэлээгүй, тэр ЗХУ чинь хэлээгүй шүү дээ. Энэ чинь монголчуудын өөрсдийнх нь хийсэн бузар булай юм, өнөөдөр ч үргэлжлээд энд тэндгүй явагдаж байна шүү дээ. 30, 40, 50, 60 оных гэлгүй архиваа нээх хэрэгтэй. Тэр тусмаа төр засгийн удирдлага буруу хандлага, методологи дээр чинь аргацааж өнгөрөөх юм хийгээд байна.

Сүүлд нь хэлэхэд, хохирлыг нь барагдуулж өгөх хэрэгтэй. Орос, Польш, Герман гээд олон оронд 2-3 өрөө байр өгч ам хаасан. Монголд ядахдаа 1-2 өрөө өг л дөө. Ингэж байж л, үр хүүхдүүд нь үеийн үед гомдоод байхгүй шүү дээ. Ийм юман дээр шинэ сэтгэлгээ, шинэ судалгааны аргаар хандаж энэ төр засагт давхар шахалт үзүүл л дээ. Тэгэхгүй бол 4 жилийн дараа буучихдаг улсуудын аманд багтаад ямар ч юм төсөвт суулгахгүй яваад байна шүү дээ.

Д.Дашдаваа:-Өнөөдрийн илтгэл дотор гол чухал асуудлууд хэлэгдэхгүй өнгөрөх явдал их байна. Монголд улс төрийн хэлмэгдүүлэлт 1921 оны 7 сараас эхэлсэн. Гэтэл өнөөдөр хүртэл зарим илтгэлд 22 онд Бодоогоос эхэлсэн гэж худлаа ярьж байна. Ингэж ярихаа больё. 1921 оны ардын хувьсгал ялмагц Барон Унгерний монгол цэргийн жанжин-тэргүүн тайж Лувсанцэвээн, сэргээгдсэн Богд хаант Монгол Улсын Сангийн сайдыг 7 сард баривчилж аваад шийтгэсэн. Ингээд Бодоотой хамт буудаж алсан. Энийг яагаад хэлэхгүй байгаа юм. Лувсанцэвээний дараагаар Саж лам, Богдын торгон цэргийн жанжин Жамъянданзан тэргүүтэй 48 хүнийг баривчилж, 7-г нь буудан алахаар шийтгэсэн. Төвдүүд байсан учраас буудаж алалгүй хөөгөөд, Лувсанданзанг Бодоотой хамт алсан.

Хоёрт, 1921 оны 7 сард эхэлсэн хэлмэгдүүлэлт жил бүр явагдсаар байгаад 30, 40 оны үед хамгийн дээд цэгтээ хүрч, оргил нь 1937-1939 оны Чойбалсангийн хядлага байсан. Энэ үед Монголын насанд хүрсэн эрчүүдийн 20%-ийг баривчилж яллаад 15%-г буудсан. Дэлхий дээр ийм хэлмэгдүүлэлт тэр үед хаана ч болоогүй. Оросод их том хэлмэгдүүлэлт болсон гэж ярьдаг, насанд хүрсэн эрчүүдийн дөнгөж 0,5 хувийг баривчилсан байдаг. Гэтэл Монгол 20%-ийг нь, энийг гаргаж ерөөсөө хэлэхгүй байна.

Бид уржигдар хэвлэлийн бага хурал хийгээд Монгол Улсын Аюулгүй байдлын Зөвлөлд хандаж нэг мэдээлэл хийж хүсэлт тавьсан. Заримыг нь хэлье.

1937, 1939 оны улс төрийн коммунист хэлмэгдүүлэлт, геноцидийг зөвтгөхийг оролдох, энэ хядлагын гол эзэн Чойбалсанг элдвээр өмөөрч бүр өргөмжлөх, хэлмэгдлийн хохирлыг төлж өгөхгүй байх нь далд коммунист ажиллагаа мөн гэсэн дүгнэлтийг хүргүүлсэн,

Их баривчилгаа, Чойбалсангийн их хядлага явагдсаны 80 жил тохиож байгаа 2017, 2019 оныг 1937, 1939 оны хэлмэгдүүлэлтийн бүх үнэнийг хэлж, хэлмэгдэгчдэд гүн хүндэтгэл үзүүлэх, хохирлыг барагдуулах он жилүүд болгон зарлах, коммунист яргачин Чойбалсанг дахин өргөмжлөхийг зогсоох, түүний хөшөөг буулгах, Дорнодын төвийг Баянтүмэн болгох саналуудыг бид тавиад байна.

Т.Батжаргал (ИНЕГ):- Маш сонирхолтой илтгэлүүд тавигдаж байна. Сайхан арга хэмжээ байна. Харамсалтай нь жилд нэг удаа явагдаж байгаа энэ хэлэлцүүлгээр бид цагт хавчигдмааргүй байна. Хэлмэгдүүлэлтийг судалдаг, ажилладаг улсууд чинь энэ ахмадууд, бид нарын үеийнхэн дуусаад дараагийн залуучууд чинь сонирхохгүй шүү. Бид нараар дуусна шүү.

Өнөөдрийн хэлэлцүүлэг дээр энэ хэлмэгдүүлэлтийг бүр илүү нарийсгах хэрэгтэй байсан юм. Салбар салбараар нь. Чухам аль салбараас хичнээн хүн ямар хүн, яаж хэлмэгдээд шийтгэгдсэн юм гэдгээр. Жишээ нь, манай нисэхийн салбараас гэхэд нийт 115 хүн хэлмэгдсэнээс 25 хүнийг буудан алж, 30-ыг нь 10 жилээр хорьж, 70 хүнийг бүх хөрөнгийг нь хурааж, ажлаас нь халсан байдаг юм байна лээ. Өнөөдрийн цугласан хүмүүст нэг хүнийг анхааралд нь хандуулах гэж байна. Уг нь Та бүхэнд илтгэлээр хүргэх байлаа, харамсалтай нь би мэдсэнгүй.

Энэ хүн бол Дэмбэрэлийн Жамбаа гэдэг Монгол Улсын анхны нисэгч хүн. ЗХУ-д бэлтгэгдсэн, дотооддоо 1925 онд Оросын мэргэжилтнүүдийг дагаж байлдааны онгоцны нисэгч болсон энэ хүний тухай хальт дурсах гэсэн юм. Энэ хүн бол анхны хурандаа, байлдааны 1-р отряд, шуудангийн отрядын анхны дарга, Монгол

Улсын нутаг дэвсгэр дээгүүрх агаарын шугамуудыг анх нээж байсан, ЗХУ-аас бэлэглэсэн онгоцнуудыг Улаан-Үдээс нааш нь угсарч, нисч ирэх ажлууд, монгол залуусыг нисэх онгоц жолоодож сургах, энэ бүх юмыг хийсэн бүхний анхдагч.

1936 оны 3-р сарын сүүл 4-р сарын эхээр зүүн хязгаарт халдсан Манжго, Японы түрэмгийлэгчдийн эсрэг баатарлаг байлдсан, 3 сарын 29-ний Адаг дулааны байлдаанд Дэмбэрэл, Шагдарсүрэн нарын хамт Япон-Манжийн 200 цэргийн өөдөөс тулалдаж зуугаадыг нь алж шархдуулсан нь Японы талын болон манай судалгаагаар нотлогдсон. Дэмбэрэл, Шагдарсүрэн хоёрт баатар цол өгсөн, энэ хүнд өгөөгүй. Учир нь түүнийг 1937 оны 8 сарын 10-нд хувьсгалын эсэргүү, японы тагнуул хэмээн баривчлагдаж, хилс хэрэг тулган яллаж 10 сарын 25-ны үүрээр Сонгины арын ууланд буудан хороосон юм байна лээ. Энэ хүн хэний ч хамаатан биш, энэ хүний хамаатан садан энд байхгүй, миний ч хамаатан биш. Би мэргэжил нэгтэй, адилхан хүний хувьд өрөвдөөд хамаг цаг заваа судалгаанд зориулж байгаа. 1965 онд манайд зөвлөх байсан ЗХУ-ын маршал Судец нисэх хүчний 40 жилийн ойгоор ирэхдээ: танай Дэмбэрэл, Шагдарсүрэн хоёр чинь баатар хүмүүс шүү, тэдэнд баатар цол нэхэн өгөөч гэж Цэдэнбал даргад хэлэхэд зөвшөөрсөн байдаг.

Нисэх хүчний 90 жилийн ойгоор Д.Жамбаад баатар цол нэхэн олгуулахаар манай ИНЕГ нэр дэвшүүлснийг Зам тээврийн яам, БХЯ, Зэвсэгт хүчний жанжин штаб, УИХ-ын Аюулгүй байдлын байнгын хороо, ЗГХЭГ, Ерөнхийлөгчийн Тамгын газар бүгд дэмжиж, Хөвсгөл аймгаас 10 мянган иргэдийн гарын үсэг цуглуулаад аваачаад өгсөн. Тэгсэн чинь баатар цолыг нэхэн олгохоо больсон гэж П.Цагаан дарга хэлсэн, ямар тогтоол, зарлиг, шийдвэрээр ийм болсон юм бол гээд үзэхээр гарч ирдэггүй. Өнөөдрийн хурлаас гарах шийдвэр, дээш уламжлах санал дотроо энэ хүнийг тусгаж өгнө үү. Эцэст, ийм хурал, хэлэлцүүлгийг олон, хагас жил тутамд хийж байгаач, энэ чинь манай дараагийн залуучуудад үлдэх юм.

Баатарсүрэн:-(Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум, сэтгүүлч) Гурван санал хэлье.

Нэгд, хэлмэгдүүлэлт явуулах сэтгэл зүйн үндсийг олон жилийн өмнөөс улс төрийн бодлоготойгоор бэлдэж байсан аж. Өнөөдөр ч бидний амьдарч байгаа нийгэм ирээдүйн хэлмэгдүүлэлтийн сэтгэл зүйг бэлдэж байгаа юм биш биз гэсэн сэтгэгдэл төрдөг. Жишээ нь, эх захгүй хэрүүл) айл гэрийн авгай нөхрийн, албан байгууллагын, хөдөө баг, сумын, парламентын, олон намын г.м.), олон шашны зөрчилдөөн, Телевизээр үзүүлж байгаа алаан хядаан, цус урссан кино чинь өсвөр үе, залуучуудыг ямар үзэл бодлоор хүмүүжүүлж байна вэ?, Ийм зүйлээр хүмүүжсэн улсууд магадгүй 10, 20 жилийн дараа бидний

дахин давтахгүй байх ёстой хэлмэгдүүлэлтийг хийхийг хэн байг гэхэв. Тиймээс үндэсний эрх ашиг, эв нэгдлийн төлөө эмх замбараагүй хэрүүлийг зогсоож, алаан хядаантай киног бүгдийг хаах хэрэгтэй.

Хоёрт, сэтгүүлч хүний хувьд элдэв юм үзэж сонирхдог. 1937 оны бурхан шашны өлгий нь Балданбэрээвэн хийд. Соёлын өв, үнэт зүйлийг маань устгахынхаа өмнө Оросоос 1935, 1936 оны үед гэрэл зургийн баг ирж, Монголын 600, 700 сүм хийдийн зургийг бүрэн бүтэн байхад нь бүгдийг нь аваад одоо өнөөдөр Орост хадгалж байгаа тухай мэдээ бий. Оросод явсан хүн надад Балданбэрээвэн хийдийн 1936, 1937 оны бүрэн бүтэн байх үеийн 3,4 зураг авчирч өгсөн, миний фондод байна. Хэрэв тийм юм байдаг юм бол эрж сурвалжлан олоод эх орондоо эргүүлж авчирч соёлынхоо үнэн мөнийг магадалж, энэ асуудалд анхаарал тавиачээ гэсэн санал байна.

Гуравт, их хэлмэгдүүлэлтээр баригдсан өчнөөн төчнөөн улсууд, ихэнх нь ар гэртэйгээ, авгай хүүхэдтэйгээ уулзаагүй, бууны суманд өртсөн. Манай ах лам хэлмэгдэж баригдсан. Лагс хүнд биетэй, оргож босохгүй хүн учраас ээж, эгч хоёр маань шоронгоос өдөр нь чөлөө аваад оронд нь хөллөгөө нэхэж ажил хийгээд, орой нь түрж аваачиж өгдөг байж. Тэрбээр (Уваа гэдэг байсан) цаазаар авахуулахынхаа урд орой нь "Үхэх цагт төрийн цаазанд өртөнө гэдэг бол гавьяатай үхэл" гэж хэлжээ. Энэ үг бол тэр хүний сэтгэл зүрх, үлдэгсдийн хүний хатан зориг, ерөөс нийт хэлмэгдсэн хүмүүсийн үг байсан байж магадгүй. Үүнээс санаа авч, 37 метр сүрлэг өндөр, 37000 хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэсэн, дээр нь "Үхэх цагт төрийн цаазанд өртөнө гэдэг гавьяатай үхэл" гэсэн ах ламынхаа үгийг сийлсэн, дор нь хэлмэгдэлд өртсөн олон мянган хүний хэлж чадаагүй үг ч байх юм билүү гэсэн үгтэй сүрлэг өндөр хөшөө босгоё гэж зургийг тайлбарын хамт хийж ирсэн юм. Энийг Та бүхэн бас тунгаан болгооно биз. Ингээд энэ хөшөөний зураг загварыг Цогтбаатар даргад гардуулъя.

Ц.Мягмар (Хөвсгөл аймгийн Рашаант сумын харьяат):- 1932 оны эсэргүү бослогын тухай эрдэмтэн судлаачид бодитой, үзэж харууштай дүгнэлтүүдийг өгсөнд баяртай байна.

1932 оны эсэргүү бослогод оролцсон гээд мөн оны 5 сарын 3-нд Хөвсгөл аймгийн Рашаант сумын 200 гаруй хүнийг хоёр жалганд хуваагаад буудсан байдаг. Энийг ноднин Мэргэн гүн Гомбожавын 110 жилийн ойгоор явж очсон улсууд гадарласан, мэдэрсэн. Ноднин 8 сарын 20-нд миний бие, Цагаатгалын комисс, Хэлмэгдэгсдийн холбоо хамтраад 3 хөшөөний санхүүжилт гаргаж анхныхыг нь Шар хаданд босгож, тайж нарыг устгасан нэг жалга, лам нарыг устгасан нэг жалган дээр хоёр хүндэтгэлийн хөшөө босгосон. Энэ мэтчилэнгээр бөөнөөр аллага хядлага болсон гуч гаруй газрууд байдаг, тэдгээрийг түүхэнд үлдэхээр тэмдэгжүүлэх зайлшгүй шаардлагатай. Энэ бол хийх ёстой зүйлийг нэг байх гэж бодож байна.

Манай Рашаант сумын хүрээ хийдийг ганц ч тоосго ч үлдээлгүйгээр устгасан. Тэрэн дээр ганцхан өнчин хайлаас үлдсэн байсан нь хоёр салаа болоод ургачихсан байж байгааг манай эрдэмтэн судлаачид, олон улсууд үзэж сонирхсон. Нэгэн цагт энэ хүрээ хийд, өв соёлоо сэргээх цагт хоёр болж ургах юм билээ гэсэн домог яриа байдаг. Тэр цаг нь ч юм уу, энэ онцгой цаг үед бид улс төрийн хэлмэгдүүлэлтийн талаар ярилцаж байна, цаашид зөв гольдрилоор, зөв замаар яваасай гэж бодож байна.

Хуралд тавигдсан илтгэлүүдийн дотор сайхан, сэтгэл татсан илтгэлүүд байсан ч, сул илтгэлүүд ч байлаа. Бид нарт нэг юм дутагдаад байгаа нь хайрцаглагдсан сэтгэлгээнээс гарч арай өөр өнцгөөс харж судалгаа, шинжилгээний ажлуудыг хийх ёстой болов уу гэж бодож явдаг юм.

Сая манай нутгийн алдартай нисэгчийн талаар ярилаа. Тэгвэл манай цэргийн түүхэнд алдар гавьяатай хүн өнөө болтол үүх түүх нь сэргээгдээгүй, хэн гэдэг нь мэдэгдэхгүй болсон нь бас бий. Жишээ нь, Халх голын байлдаанд Жанжин штабыг удирдаж байсан Жамсрангийн Цэрэн гэж хүн манай Хөвсгөл аймгийн Рашаант сумын хүн. Энэ хүний мэндэлсний 110 жилийн ой ирэх жил тохионо. Ойг нь тэмдэглэн өнгөрүүлэх тухай хөөцөлдөөд явж байна, гэтэл одоогийн мөрдөж байгаа байгаа журмаар Засгийн газраас тогтоол гардаг юм байна. Энэ журамд өөрчлөлт оруулах хэрэгтэй. Цэргийн өндөр дээд цолтнууд гэдэг юмуу, энд ороогүй зүйл байна. Энэ дээр тус дэм болоорой гэж Та бүхнээс хүсч байна. Хэлмэгдэлд айхтар их өртсөн хэлмэгдсэн газар бол Хөвсгөл аймгийн Рашаант сум. Энэний хөгжилд төрийн бодлогоор дэмжлэг үзүүлээч гэдгийг нутгийн ард түмнээс захьсан шүү.

Д.Цогтбаатар:-Бид хурал хийж байгаа. Дэгтэй байх ёстой.

Цэцийн гишүүн Цогтоогийн саналыг бид хүлээн авч, эрдэм шинжилгээний хурлыг жилд нэг удаа хийдэг байсан бол, энэ онд дахиад зөвхөн мэтгэлцээнтэй холбоотой асуудлуудаар хурал хийе гэж Цагаатгалын комиссын нарийн бичгийн даргатай сая яриад шийдчихлээ.

Пүрэвдорж гуай болон хэд хэдэн улсуудын саналыг бид аль болохоор дор нь шийдэхийг бодож байна. Зарим нэг хүсэлтийг холбогдох газар нь шууд тодорхойлж өгөөд дэмждэг чиглэлээр нь явуулаад шийдээд явчихъя, тиймээс өөрсдийн чадах юмаа шууд шийдээд явна, чадахгүй юмаа, төр засаг шийдэх юман дээр уламжлагаас өөр арга байхгүй шүү. Саналуудаа хэлээрэй, гадаадын эрдэмтэд байна, тэр хүмүүс бас үг хэлэх ёстой шүү дээ. Тийм учраас хүлээцтэй хандаарай гэж хүсч байна.



Цэрэннадмид (*Ж.Лхүмбийн зээ охин*):- Хэлмэгдсэн хүний хувь заяаг хэлмэгдэгсэд өөрсдөө л гартаа атгах хэрэгтэй гэж би бодож явдаг. Яагаад гэвэл, өнөөдөр төрийн мэдэлд хэлмэгдэгсдийн хувь заяаг атгуулчихсан, төрөөс цалин авдаг Цагаатгалын комисс бий, түүний дарга нь УИХ-ын дэд дарга гэж байгаа. Бид тэр хүнийг жилд нэг удаа халыг нүүрийг нь олж хардаг. Ийм, тийм ажилтай ажилтай гээд хурал хаяад явж байгаа биз дээ. Энд хурал тартал хэн сууж байна? Хэлмэгдсэн хүмүүс, аймшигтай хувь заяаг туулсан хүмүүс сууж байна. Юуны төлөө?, хувь заяаныхаа төлөө. Өнөөдөр би энд сууж байгаа хөгшчүүлээ харахаар зүрх шимширдэг. Тиймээс хэлмэгдэгсдийн хувь заяаг МУТХХ, хүний эрхийн төлөө ажилладаг Төрийн бус байгууллагуудад өгөх ёстой. Харин хариуцлага нь төрд байх ёстой. Монгол Улсын өндөр төрөө би хүндэлнэ. Харин төрд суугаа ялзарсан авилгачин, лоббичин, оффшорчин, эрх мэдлийн төлөө яахаас ч буцахгүй бусармаг улсуудыг би шүүмжилж байгаа юм. Тэдэнд би хувь заяагаа атгуулмааргүй байна. Хурлын шийдвэрт энэ талаар оруулж өгөхийг хүсье.

Хоёрт, 9-р сарын 1-ийг хэлмэгдэгсдийн өдөр болгоно гээд 10 жилийн хүүхдүүдэд хичээл ордог байсан шүү дээ. Одоо байхгүй. Аль болох хэлмэгдэгсдийн хувь заяаг мөлийлгөх, баллуурдах, үхэхийг нь хүлээх, гүүхээс арчих ийм юмыг зарим эрдэмтэд хүртэл хийж байгаа гэдэгт би огт эргэлзэхгүй байна. Тийм учраас улиг болсон юмаа өнөөдрийг болтол давтаж байгаа юм. Энэ түүхийг мартуулахгүйн тулд, эмгэнэлт хувь заяаг дахин гаргуулахгүйн тулд сургууль, их дээд сургуулийн хөтөлбөрт тусгайлан оруулах, бүр Улсын шалгалт авах асуудлуудын тоонд багтаах санал дэвшүүлж байна.

Гуравт, Лхүмбэ гээд яриад байдаг, бүх эрдэмтэн ярьна, хэдэн арван жил ярьж байна, судлаад байдаг Лхүмбийн гэдэг ганц номон хөшөө байхгүй. Энэнд би Лхүмбийн зээ охины хувьд үнэхээр сэтгэл эмзэглэж явдаг. Хэлмэгдэгсдийн хувь заяаг энэ төр, Цагаатгалын комисс, УИХ ингэж л авч яваа. Та бүхэн намайг таних байх. Би Ноён уулаа аврах хөдөлгөөний тэргүүн. Байгалийн террор аль хэдийн эхэлчихсэн. Улсын үндэс газар гэдэг мөртлөө газар шороондоо дайн зарлаад эхэлчихсэн. Бид нар ирээдүй хойч үедээ онгойсон нүх, ширгэсэн гол горхи, эмийн ургамал байхгүй, амьсгалах агаар байхгүй, тэгж үлдээх юмуу? Энэ бол хамгийн том хэлмэгдүүлэлт.

Нөгөө талаар Монголын эрчүүдийг гадаадад боолын хөдөлмөр эрхлүүлж, Эх орныг нь эзэнгүйдүүлж байна. Гадныхантай хуйвалдаад хятадуудыг өчнөөн төчнөөнөөр нь оруулж ирж байна. Энэ бол Монгол Улсын тусгаар тогтнол, язгуур эрх ашгийн эсрэг үйлдэл, улс төрийн зохион байгуулалттай хэлмэгдүүлэлт. Хэлмэгдүүлэлт ч биш энэ бол террор.

Сор болсон эмэгтэйчүүдээр үе үеийн хаадууд зөвлөгөө өгүүлж явсан, Монголын төр гурван сайхан эмэгтэй хаанаар төрөө удирдуулж явсан. Эмэгтэйчүүдийн талаар яагаад хэлэх болов гэхээр би Улс төрийн талаар хэлмэгдсэн Монголын эмэгтэйчүүдийн холбооны ерөнхийлөгчөөр 20-иод жил ажиллаж байна. Жинхэнэ хэлмэгдэл гэдгийг нуруундаа үүрч, дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу явсан хувь заяатай улсууд бол эмэгтэйчүүд юм. Лхүмбэ өвөөг буудаад алчихлаа гэхэд өнгөрсөн хүн үг хэлэхгүй, шаналахгүй, зовохгүй. Харин ажлаасаа халагдаад, чихээ сэт татуулаад цусаа гоожуулаад өлгийтэй хүүхдээ тэврээд явж байсан миний эмээ Лхүмбийн эхнэр нь болсноороо улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртөж, ажил төрөлгүй, хөхөө өвлийн хүйтэнд тэгж гараад хүү нь нас барсан. Энийг судлаачид Та нар бүгд мэдэж байгаа.

Өнөөдөр Монголын хойч, ирээдүй үеэ дээрэмдэж эхэлсэн. Үндсэн хуулиндаа газрын хэвлий доорх баялаг нийт ард түмний мэдэлд гэж байгаа, бас Монгол улсын иргэн бүр эрүүл, аюулгүй орчинд амьдрах, агаарын бохирдлоос хамгаалуулах, ажил хөдөлмөртэй, гэр оронтой байх эрхтэй. Хаана байна? Ийм лоозон, худлаа тунхаг, коммунист, социалист маягийн ийм хачин юмаар бид нар тархиа угаалгахаа больсон. Энэ дээр бас хойч ирээдүйнхээ талаар бичээрэй гэж хэлж байна.

Гуравт, уул ус, гол горхи хэлмэгдэж байгаа зүйлсийг анхаараарай гэж хэлж байна.

Дөрөвт, аль ч нам ялгаагүй ялзарсан. Нам дагаж намирсан нөхдөд хувь заяагаа атгуулмааргүй байна. Ажил төрөл, сонголт, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхаж хэлмэгдүүлж байна. Энийг нэг ч эрдэмтэн хэлэхгүй байна шүү дээ. Дашдулам хальт хэллээ. Монгол хүний үнэ цэнэ, бидний язгуур эрх хаана байна? Тэвчээрт хязгаар бий. Надтай адилхан Дашдаваа гуай болон тэр хөгшчүүл ер нь үхэхэд бэлэн, ганцхан хүмүүжилтэй учраас бид нар хатуу тэмцэлд орохгүй явж байгаа юм.

Монголын үүх түүх, өв соёл, газар шороо, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал энэ бүх юмыг хэлмэгдүүлж байгаа үйл явцыг энэ хуралдаа тусгаж өгөөрэй. Жилд ганц удаа хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тэмдэглэж байна хэмээн өнгөрөөдөг, гурван өндөрлөг нь машины зам дээр гарч ирж цаасан цэцэг өргөсөн болоод буцаад ордог. Энэ бол доромжлол гэж би бодож байгаа.

### **С.Л.Кузьмин:-/Орчуулгагүй яриу/**

О.Лхагварэнцэн:-Төрийн байгууллага хамгийн их хүчин зүтгэдэг ТББ-уудыг түшиж ажилладаг нь чухал юм. Энэ утгаараа, өнөөдрийн олон улсын эрдэм шинжилгээний хурал их ач холбогдолтой, материаллаг (материаллаг гэдэг нь оюун санааны хувьд хэлж байна) хурал болж байна гэж эрдэмтний хувьд үзэж байна. Хурлын тухайд

хэдэн үг хэлье. Санаж байгаа байх. Одоогоос жилийн өмнө 9 сарын 4-нд ийм хурал болж байсан. Илтгэлүүдийн хооронд координат хийх талаар эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэдтэй сайн ажиллаагүй гэж хэлмээр байна. Цаг их авсан илтгэлүүдийн улмаас үгээ хэлэх гэсэн хүмүүс сэтгэл санаа жаахан гонсгор үлдсэн нь харагдлаа гэж ойлгож байна.

2007 онд Улсын комисс судалгааны байгууллагатай байсан, Улс төрийн хэлмэгдэгсдийн холбоо ч түүнд түшиглэн ажиллаж байсан. Агуу их доктор, түүхч М.Ринчин гуай чиглэл өгсөн учраас их материаллаг хурал болсныг санаж байгаа гэж бодож байна. Эн тэргүүнд Хэлмэгдэгсдийн холбоо, Цагаатгалын комисс судалгааны байгууллагатай байх нь ийм юман дээр илүү харагдах ёстой. Судалгааны төвийн зарим материалууд энд хэлэгдэх ёстой, хэлэгдээгүй байна. Шинэ зүйл, тухайлбал, 1937 оны хэлмэгдүүлэлтийн тухай ярихад хилийн чанад дахь хэлмэгдүүлэлт зайлшгүй орох ёстой. Ариунболд докторант хэдэн үг оруулж байна. Бутово, коммунаркийн тухай, тэнд хөшөө босгож 259 хүний нэр бичигдсэн талаар Судалгааны төвд байгаа материал ашиглагдахгүй байна.

Хоёрт, Хэлмэгдэгсдийн холбоо 40-60, 60-80 гээд он дарааллаар эрдэм шинжилгээний хурал хийж байсан. Энэ материалаас эшлээд авах талаар эрдэмтэд муу байна, эрдэмтэд энэ талаар бас санамаар юм шиг байна. Храл эхлэл нь сайхан, сүүд рүүгээ давхардал ихтэй болсон нь хүмүүсийн сонирхлыг татахгүй байна. Эмхэтгэл гаргахдаа редакци сайн хийхэд анхаарах хэрэгтэй.

Харин, илтгэлийг урьдчилан тарааж өгсөн нь цаг хэмнэх, бас урьдчилаад харах, саналаа хэлэхэд их сайхан зүйл болсон байна шүү. Үүнийг хойшид улам бэхжүүлэх нь зөв байна.

Зарим сайхан илтгэлүүд байна. Жишээлбэл, Мөнхтариа прокурор, Пүрэвбат ламтан, 1935-1955 оны соёлын хэлмэгдүүлэлтийн тухай зэрэг сайхан илтгэлүүд байна. Үүний хамт шпаргалктай илтгэлүүд ч буй. Түүхийн үнэн мөнийг олох талаар түүхчид, эрдэмтэд анхаарч ажиллах нь зүйтэй байна.

Ө.Бавуу (Сэлэнгэ аймаг) Өнөөдрийн хурлыг харахад би онолын шинжтэй юмнууд ярих болов уу гэж харсан. Гэтэл дандаа процесс яваад болж өгөхгүй юм. Энэ хэлмэгдэл гэдэг юмыг мэдэхийн тулд нэр томьёоны хувьд, янз бүрийн нэршлүүдэд тодорхойлолт өгмөөр байна. Юу хэлмэгдсэн, хэнийг хэлмэгдэгч гэж нэрлээд байгаа юм, юуг хэлмэгдүүлэл гэж үзэх юм, эсэргүүн гэж хэн болох?, Тодорхойлолт өгч байж ярихгүй бол аллага, хядлага, хэлмэгдүүлэлт гэх зэргээр өөр өөрөөр хэлж буй. Эрдэм шинжилгээний хурал онолын талаар тодорхойлолт өгөх ёстой гэж бодож байна.

Хоёрт, мөнгө өгөх тухай асуудал яриад байна. Нэг сая төгрөг яах гэж өгч байгаа юм, ямар хохирол нөхөж байгаа юм. Энэ огт утгагүй асуудал. Энэ сэтгэл санааны хохирлыг төлж байна гэж байна. Огт төлж чадахгүй энэ чинь. Энэний оронд дундаж гаргаад, хэлмэгдэгсдийн ар гэрийнхэнд хэдэн үеэр нь тэтгэлэг хэлбэрээр тогтмол өгч байдаг, хишиг хүртээж байдаг ийм юмыг хуулиндаа нэмж оруулах нь зүйтэй болов уу.

Гуравт, орчин цагийн хэлмэгдэл үргэлжилж байна гэж ярьж байна. Энэ үргэлжилж байгаа. Улс төрийн нам, төрийн түшээдийг сонгодог байсан цагт хэлмэгдэл мөнх оршино. Тийм учраас намыг улс төрийн хүрээнээс хасах, ерөөсөө зайлуулах хэрэгтэй. Орчин үеийн хэлмэгдүүлэлт бол эдийн засгийн хэлмэгдүүлэлт, түүнд өртсөн хүн нь би өөрөө. Би Ардчилсан хувьсгалаас өмнө НТХ-ны мэдлийн боловсон хүчин байсан, түүнээс хойш хувийн юм хийж байна. Энэ бол хэлмэгдүүлэлт гэж бодож явдаг. Гэхдээ би хэлмэгдүүлээ гэж мөнгө авах гэж хэлж байгаа юм биш, ер нь иймэрхүү байдлаар хэлмэгдээд байгаа хүмүүс олон бий шүү гэдгийг хэлэх гэсэн юм.

Мөн баримт дурдахад, Сэлэнгэ аймагт 1399 хүн баригдсанаас 1 хүн сураггүй алга болж, 9 хүн 10 жилээр хоригдох ял аваад, үлдсэн нь цаазаар авахуулсан байдаг. Монголын оюуны төв болсон Амарбаясгалан хийд, Номун хааны хийд, Хараагийн Дарь Эхийн хийдүүдийг түшиглэсэн газруудад хэлмэгдэл хүчтэй явагдсан. Хамгийн олон сэхээтэнтэй, хамгийн олон хүнээ алуулсан аймаг бол Сэлэнгэ аймаг.

(нэрээ хэлээгүй):- Монголд бөөнөөр нь хэлмэгдүүлсэн явдал зөвхөн коммунист суртлын үед л гарах ёстой хэлмэгдүүлэлт. Бид нарын амны уншлага байсан марксизм, ленинизм, түүгээр тугаа болгосон МАХН гэдэг үг байсан шүү дээ. Энийг бид хэзээ ч мартаж болохгүй. Энэ бол Кузьмин докторын хэлдгээр Орост сталинизм сэргэж байна гэдэг нь хуучин цагийн балай хандлага руу хальтраад орчихож магадгүй гэдгийг сануулж байгаа хэрэг юм гэдгийг бид бодох ёстой.

Үзэл суртлын хэлмэгдэл, төөрөгдлийн хэлмэгдэл гэж их аюултай юм байгааг ойлгох ёстой. Бурхан багшийн сургаальд буруу үзлийг хамгийн том нүгэл гэж айлдсан байдаг юм гэнэ лээ. Энэ утгаараа Монголын залуучууд, бид нар хүртэл буруу үзэлд төөрөгдсөн чигээрээ, ө.х. коммунизм, фашизм гэдэг нийгмийн аймшигт халдварт өвчнөөс бүрэн илааршиж чадаагүй байгаа гэдгийг санаж, ард түмнийг гэгээрүүлэх, дархлаатай болгох талаар Хэлмэгдэгсдийн холбоо болон Та бүхэн их сэтгэл гаргаж, гэгээрүүлэхийн төлөө ажиллаач гэж уриалмаар байна.

**Ж.Баасандаш (МУТХХ):-** Товчхон 3 санал байна.

Нэгд, хэлмэгдэгсдийн судалгааны төвийг сэргээх тухай ярилаа, энэ маш зүйтэй, дэмжиж байна. Энэ асуудлыг ойрын хугацаанд шийдэхийн төлөө явцгаая, зөвлөмждөө оруулъя.

Хоёрт, Хуулийн төслийг өнөөдөр УИХ-д өргөн барьсан юм байна. Энэ их сайхан сонсогдож байна. Хуулийнхаа үзэл санааг энэ улсууддаа танилцуулж, саналыг нь авбал их зүгээр байна. Хууль өгсөн л гэж байна. Ямар янзын хууль орсныг бид мэдэхгүй сууж байгаа шүү. Сайн хууль өгсөн байх болтугай гээд залбираад сууж байна.

Гуравт, 1932 оны лам нарын хэлмэгдүүлэлтийн асуудлаар саналаа хэлэхгүй бол болохгүй нь. Лам нарын эсэргүү хөдөлгөөн бол төрдөө тэрсэлсэн хөдөлгөөн биш, төрийн буруу бодлогыг эсэргүүцсэн хөдөлгөөн байсан юм шүү гэдгийг нэгд хэлье. Хоёрт, түүхээс харахад лам нар хүн алаагүй, зүрхийг нь сугалаагүй юм байна лээ. Тэрнийг урван тэрсэлсэн янз бүрийн улсууд хийсэн юм байна лээ. Гуравт, 32 оны хөдөлгөөн, лам нар гаднын дэмжлэгийг ерөөсөө аваагүй. Харин түүнийг дарахын тулд төр гаднын асар хүчтэй дэмжлэг авсан.

Я.Дүгэр (Элчин сайд):- Би нэг асуудал хөндье гэж бодож байна. Манайд хэлмэгдүүлэлт олон удаа, үе шаттай, тус бүрдээ агуулга, хэлбэртэй явж ирсэн. Энэ дотроос гадаадын тусгай албадын шууд оролцоотойгоор, тэдний гар хөлөөр үйлдэгдэж, Монгол Улсын иргэн нутаг дээрээ гаднын хуулиар баригдаж, гадаадад шоронд хоригдож, амь насаа алдсан, миний гарт байгаа баримтаар 42 монгол хүн байна. Энэ бол Оросын архиваас авсан материал. Энэ асуудалд олон улсын эрх зүй, хүний эрхийн түгээмэл тунхаглалын үүднээс ямар дүгнэлт хийж байгаа юм бэ. Энэ чинь олон улсын эрх зүйд таарч байгаа юмуу. Би бол энийг олон улсын гэмт хэрэг гэж үзэж байгаа.

Энэ бол гадны хүчээр, гадны гараар хийгдсэн тодорхой зорилго бүхий ажил, тодорхой субъектын гараар хийгдсэн хэлмэгдүүлэлт. Дотоодын хэлмэгдүүлэлт бол мэдээжийн төр засгийн газрын буруутай үйл ажиллагаагаар хийгдсэн, энийгээ ч Монголын төр ёс зүйн хариуцлагаа хүлээгээд хэлмэгдүүлэлтийнхээ төлбөр төлөөсөө төлөөд явж байна, энэ бол зүй ёсны асуудал. Харин гадаадад сүйдсэн цөөн тооны хүнийхээ хариуцлагыг хэн хүлээх ёстой юм, тодорхой субъект нь байж байна. Энийг хөндөж тавьсан, судалсан, ярьж байгаа юм байна уу гэдгийг Хэлмэгдэгсдийн холбооноос хариулт авмаар байна.

Р.Мөнхтариа (Судлаач):- 1932 оны бослогын тухай энэ асуудлыг шинжлэх ухааны үүднээс хөндөж ярьж, бүхэл бүтэн ном бүтээж, өнөөдрийн илтгэлдээ оруулж, 2016 онд бас эрдэм шинжилгээний хуралд ирж оролцож байсан ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэнгийн доктор С.Л.Кузьмин Танд хуралд оролцож

байгаа хүмүүсийнхээ өмнөөс баяр хүргэе.

Энэ асуудлын талаар миний бодож явдаг зүйл. Би Улсын Ерөнхий прокурорын газар Цагаатгал хариуцсан хяналтын прокуророор 11 жил ажилласан, судлаач болчихсон хүн. Энэ жил гаргасан “Монголын язгуур эрүүгийн эрх зүйн их нүүдэл” номондоо Монгол Улсын эрүүгийн эрх зүйн гажуудал, Цагаатгалын бүх асуудал, хэлмэгдлийн талаар тусгаж тараасан байгаа.

32 оны эсэргүү хөдөлгөөний тухай асуудлыг бид нэг тийшээ шийдмээр байна. Улс төрийн хилс хэргийн гол ноён нуруу болсон Гэндэн, Дэмид нарын хэрэг, Ёнзонхамба нарын хэрэг гэсэн хоёрхон багана байгаа шүү дээ. Энэ хэргийг хилс хэрэг гэж шийдвэрлэх үндэслэлийг хаанах гаргасан гэхээр холбогдох байгууллагуудын тушаал шийдвэр гараал, СнЗ-ийн тогтоолын дагуу ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс тодорхой тооны эрдэмтэн судлаачдыг гарган дээрхи 2 хэргийг судлуулаад хэрэг мөн үү, биш үү, үнэхээр Японы тагнуулын байгууллага, Ардын засгийг эсэргүүцсэн хууль ёсны байгууллагууд байж уу, үгүй юу гэдгийг тогтоолгосон. Эрдэмтэд “...албан ёсны тийм байгууллага Монголд байгуулагдаагүй байна, энэ бол хилс хэрэгт хэлмэгдүүлсэн гэж үзэх үндэслэлтэй байна” гэсэн шинжлэх ухааны дүгнэлт гаргасан юм байна лээ. Энэ дүгнэлтийг үндэслээд өнөөдрийг хүртэл хуулийн байгууллагууд, миний бие 10 мянга гаруй шахуу хүний хавтаст хэргийг уншаад цагаатгачихсан байж байгаа.

32 оны хөдөлгөөний талаар асар их зөрүүтэй ойлголт, бодлууд яваад байдаг. Хуулийн байгууллагууд шийдэх гэхээр эсэргүү гэдэг нэр томъёо Монголын түүхэнд байж байгаа болохоор цагаатгаж болдоггүй. Гэхдээ би зүрх гаргаад 100 гаруй хүн цагаатгачихсан байж байгаа. Цагаатгах гэхээр энд ерөөсөө хэрэг материал байдаггүй. Зөвхөн хээрийн шүүхийн тогтоол гэсэн 1-р тогтоол байдаг, түүн дээр хүмүүсийг ганц ганц удаа асуусан мэдүүлгүүд байгааг үндэслээд бид 80 хэдэн хүнийг зориг гаргаад шийдээд цагаатгачихсан. Хэт нь буруудвал би ялаа үүрнэ биз.

Эрдэмтэддээ, Хэлмэгдэгсдийн холбоонд, Цагаатгалын комисст хандаж хэлэхэд: нэгд, зэвсэгт бослого юмуу, мөргөлдөөн юмуу гэдэг нэрээ тогтоож авъя, хоёрт, тэнд оролцсон хүмүүсийн тоог тогтооё, гуравт, энийг цагаатгах, эсэх асуудал. Зэвсэгт бослогын дотор хил дамнасан нүүдэл суудал гэж байгаа шүү дээ. Гадагшаа зугтаад амиа аваад гарчихсан улсуудыг эсэргүү хил дамнасан гээд цагаатгадаггүй. Олон хүний хувь заяа задгай хаягдах гээд байгаа учраас энэ асуудлуудыг шийдэж өгөөчээ. Өнөөдрийн зөвлөмждөө оруулж өгөөчээ.

Ж.Лхагвасүрэн (Зурхай, хүн судлалын төвийн тэргүүн):-Хамгийн гол нь их алан хядлага буюу их дээрэмд амь насаа алдсан хүн, их



дээрэмд сүм хийдээ шатаалгасан хохирол, их дээрэмд булаалгасан, хураагдсан эд хөрөнгө гээд энэ 3 юмыг яг зөвлөмжиндөө тусгаж оруулж өгнө үү. Алан хядлага, хэлмэгдэл хоёр чинь тусдаа, өөр зүйл, энэ хоёрыг салгаачээ гэж хүсье.

Хоёрт, яг дүгнээд хэлэх шинэ санаа хэлье, судлаач нарт. Ёс зүйтэй, ёс суртахуунтай хүнийг зөвхөн алтан ургаар бэлтгэж ирсэн түүхтэй. Мөн хаан ухаан, хатан ухааныг мөн алтан ургаар бэлтгэж ирсэн түүхтэй. Сайн хүн сайн засаглал тогтоодог. Ийм учраас алтан ургаас сайн бэлтгэж ирсэн ийм түүхтэй шүү. Энэ дээр сайн дүгнэлт хийж, цааш нь судалгаа хийх хэрэгтэй. Би өөрөө зурхай хүн судлалын төвийн тэргүүн хийдэг. Хүн судалдагийн хувьд илүү их тайлбар хийж болно.

Д.Дулмаа (*Хэлмэгдэгчийн хүүхэд*):- Би сурган хүмүүжүүлэгч багш. Энэ үнэ цэнэтэй цаг хугацааг өгч яриулах болсонд талархаж байна. Үг нь цэгцэрсэн хүн үйлс нь зөв байдаг. Тийм учраас бид нар их цэгцтэй, их бодлоороо зөв ярьдаг байх хэрэгтэй.

Олон жил тэтгэмж өгнө гэж ярилаа. Биелсэн юм алга. Яагаад өгч болдоггүй юм. Миний аав гэхэд бие сэтгэлээрээ хохирсон. Хүн шиг тийм үнэтэй капитал энэ ертөнцөд байхгүй. Энэ тэтгэмж олгоно гэдэг чинь үр хүүхдэд, бидний удам угсаанд хүртэл хэрэгтэй. Энэ мөнгийг гуйж авч байгаа юм биш. Миний аав гэхэд Москвад хөнгөн хүнсний техникийн дээд сургуулийг төгсч ирээд, 39, 45 оны дайны ар талын албыг дайн эхэлснээс аваад дуустал жижиг цех байгуулаад дайн дуустал хариуцлагатайгаар, шөнө өдөргүй, борви бохисхийлгүй ажилласан. Гэтэл тэрнийг үнэлсэн ч юм байхгүй, миний аав эцэст нь баруун хөлөө огтлуулаад идээлээд, тэгээд хөлгүй тахир дутуу болсон.

Хэлмэгдлийн гайгаар үр хүүхэд, ээж бид нар хэлмэгдсэн. Ийм учраас би 600 гаруй ахмадуудыг төлөөлөөд ярьж байгаа юм шүү. Төр засгаас гуйя, ер нь өөдрөг сайхан сэтгэлээр, үгээ сайхан бодож ярих хэрэгтэй байна. Тэгэхээр зүрх сэтгэлээ зөөллөөд, бидэнд өгөх ёстой юмыг өг, барагдуул. Тэгэж удаагаад өчнөөн жил болоод улиг домог болж байх ямар хэрэгтэй юм. Шаардлагыг өндөр тавина шүү дээ.

С.Бэхбат (*Хэлмэгдэгсдийн музейн захирал*):-Жил бүр нэг өдөр, хоёр өдөр гээд ярьдаг. Үндсэндээ бүгдээрээ санаануудаа хэлэх, сэтгэлдээ байгаа зүйлээ бас хуваалцах гэж бухимдалтай байдаг. Тийм учраас аль болох олон уулзаж байвал зүгээр байх. Сая ярьсан хүмүүстэй миний зарим санаа давхардах гээд байна. Хэлмэгдүүлэлтийн тухай жил бүр л ярьдаг, одоо хатуу чанга тавимаар байна. Их аллага гэдэг юмуу, яргалал гэдэг юмуу, 37, 39 оны хооронд ерөөсөө аллага шүү дээ. Тэгэхээр цаг хугацаагаар нь ялгагдаг юмуу, нэр томъёоны толь бичих хэрэгтэй, энэ ажлыг эхлэх хэрэгтэй байна, эрдэмтэн, судлаачид аа. Тэр маш хэрэгтэй. Судалгаа хийж байгаа хүүхдүүдэд хэрэгтэй байна.

Бас нэг асуудал, ардчилсан хувьсгалаас хойш бид коммунист, социалист үзэл суртлаасаа салаагүй. Зарим хуучин социалист оронд хуучин үзэл суртлын юмнуудыг хорьсон. Нэг кино театрт социализмын кино гардаг, дуртай хүн очоод тэрнийгээ үздэг. Бид тэгэхэд наадмаар “Улаан дарцаг” мэтийн кинонуудыг жил бүр үзээд, дандаа социалист, цаанаа коммунист ухуулгатай ийм хортой кинонуудыг үзүүлж байна шүү дээ. Тэгэхээр яаж хүүхдүүд чинь хэлмэгдүүлэлтийг ойлгох юм бэ? Киноны хувьд ярихад, социализмын үеийн кино гаргадаг нэг суваг байлгадаг юмуу, гадаадын янз бүрийн кинонуудыг насны ангиллаар үзүүлдэг юм уу, ер нь нарийн хийх хэрэгтэй байх. Нөгөөтэйгүүр, социализм гэж ямар нийгэм байсан бэ гэдгийг ерөөсөө мэдэхгүй. Настай хүмүүс, магадгүй бид нар ч гэсэн социализм гэж их гоё байсан, ямар ч ажилгүйдэл байхгүй, бүгдээрээ сайхан амьдарч тайван байсан гээд ярьдаг шүү дээ. Хүмүүс одоогийн хурдацтай, өрсөлдөөнтэй зах зээлийн нийгмийг өмнөх нийгэмтэй харьцуулаад муухай гэж бодоод байдаг. Тиймээс үзэл суртал, ухуулгын талаар дахин анхааруулмаар байна.

Би өвөөгийнхөө тухай товч дурьдахгүй бол болохгүй байх. Миний өвөөгийн тухай олон хүмүүс бичиж, ярьж ирсэн. Түүхч биш хүмүүс ч янз янзын баримт бичиг, хов живэнд суурилуулан муулах юмнууд хүртэл гаргаж байсан. Өнөөдөр харахад, Ж.Болдбаатар түүхч зарим юмнууд ярьж байна. Миний хувийн бодлоор түрүүнд Цогтоогийн хэлдгээр архивуудыг нээлттэй болгоё. Хаана ямар матаас, хов жив байсныг нь ялгах хэрэгтэй. Хүнийг янз янзаар муу хэлэхнэг өөр, тэр хүн ямар ажил хийсэн нь бас ялгаатай шүү дээ. Үндсэндээ 1924 оноос хойш 12 жил улсын хөгжлийн чигийг олох гэж бас л оролдож байсан тийм л хүн. Тусгаар тогтнолынхоо төлөө амиа алдсан хүн. Миний өвөө Гэндэн. Миний аавын аав Намсрай гэж хүн бас 1937 онд алагдсан, багш хүн байсан.

ОХУ-ын архивууд гэж яриад байна. Энийг жил бүр л ярьж байдаг. Бас л дахин хагуу саналаа тавьж байж нууцлаад байгаа юмнуудыг нь авч болдоггүй юм байх даа. Нэхээд авъя, болохгүй бол худалдаад ав л даа, яагаад болдоггүй юм. 1992 онд би ээжтэйгээ КГБ-ын архивт орж байсан. 2, 3 сарын дараа орох гэтэл оруулахгүй гэж байгаа юм. Тэгэхээр ялгаварласан гэдэг юмуу хэцүү байдал үүсээд байх шиг байна. Энэ маш чухал, энийг дахин тавимаар байна.

Хамбын овоон дээр нэг том цогцолбор байгуулах гэж байгаа тухай Пүрэвбат лам хэлсэн, Ажлын хэсэг байгуулах гээд явж байгаа, миний бие оролцож байгаа. Тэр том цогцолбор болох ёстой байх. Аймаг бүр, сум бүрт хөшөө цогцолбор байж байж сануулах ёстой. Ерөнхийдөө бүгдээрээ сануулах ёстой. Тэгэж байж хүүхдүүд мэддэг болно шүү дээ.

Музейн хувьд засвар хийх гэж зөвшөөрөл авах гэж өчнөөн олон жил болсон. Ерөөсөө хүнд сурталтнуудын дунд өчнөөн нервээ барлаа. Засвар хийх зөвшөөрөл гарч байна, засвараа эхлүүлнэ.

Цогтбаатар даргатай хэдэн жилийн өмнө ярьж байсан нэг асуудал буюу төрийн чиг үүргийг ТББ-аар гүйцэтгүүлэх асуудал байгаа. Би төр, хувийн хэвшлийн түншлэл гэж ярьдаг хүн. Цагаатгалын комисс гэдэг цөөн хүнтэй комисс байж болох бөгөөд харин санхүүжилтийг ТББ-д өгдөг байх. ТББ тэр байтугай санхүүжилтийг олно. Яагаад гэвэл төрийн биш газарт цаанаасаа янз янзын судалгааны мөнгө олддог юм. Төрийн байгууллагад гадаадтай хамтарсан судалгаанд мөнгө өгөхгүй шүү дээ. Японы гэдэг юмуу, Оросын, Хятадын гэдэг юмуу бусад байгууллагатай хамтраад томоохон судалгаанууд хийх юм бол Хэлмэгдэгсдийн холбоо байдаг юмуу, өөр судалгааны төвүүд хамтраад хийхэд болохгүй юм байхгүй. Нарандалай дарга энэ дээр анхаараад цаашдаа тийм хэлбэрт оруулах юм бол зөв байх гэж бодож байна.

Энэ бол бидний баярын өдөр биш үндсэндээ эмгэнэлийн өдөр. Тэгэхээр гашуудлын өдөр. Тийм учраас 9 сарын 10-ныг үндэсний гашуудал гэж бүр тугаа бөхийлгөдөг болгомоор байгаа юм. Энийг анхаармаар байна.

О.Батсайхан (ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн, Удирдлагын Академи) :- 9 сарын 10-нд хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр. 9 сарын 10-нд цэцэг өргөнө. Энд сууж байгаа хэдэн ахмадууд л очно. Цөөхөн хүн очдог шүү дээ, жилээс жилд цөөрдөг болсон.

Энэ яригдаж байгаа яриа ноднин яригдаж байсан, 5 жилийн өмнө яригдаж байсан, 10 жилийн ярьж байсан, хүмүүс нь цөөрөөд л байгаа, ирдэг нь багасаад л байгаа. Энэ яриаг энд биш төрд дуулдахаар хэлэх ёстой. Тэгэхгүй бол энэ үнэхээр ажил хэрэг болохгүй шүү.

10-нд бүтэн сайн өдөр байгаа, төрийн тэргүүнүүд цэцэг өргөдөг хуультай, энэ хүмүүс бүгд очих хэрэгтэй, хүүхдүүдээ дагуулаад очиж, хүндэтгэл илэрхийлж үзээч дээ, талбайд олон хүн байлгаач гэж гуйж байна. Энэ үнэхээр чухал шүү. Би дөнгөж сая Японоос ирсэн. Японы иргэн Акира Оно гэж хүн байна, 8 сарын 13-15-нд Японд дайнд ялагдсаны 72 жилийн ойг тэмдэглэсэн. Японы эзэн хаан тэр ялагдсан хүмүүсийн булшинд очиж хүндэтгэл илэрхийлж байна. Парламентын гишүүн, сайд нар, ард түмний төлөөлөл, муж мужаас адилхан хувцастай хүмүүс ирээд ...

Хоёрт, үнэхээр хэлмэгдсэн хүмүүст дурсгалаа илэрхийлж бид сурах хэрэгтэй байна. Тэгвэл ядаж төр засагт байгаа хүмүүсийн чихэнд хүрэх юм шүү. Бид нар баяр болохоор талбай дүүрээд байдаг, энэ дурсгалын юман дээр хэдхэн хөгшин зогсож байдаг юм. Бүгдээрээ

олуулаа ир л дээ. Цэцэг өргөх ёслолд аль болохоор олон хүн ирээрэй гэдгийг би уриалж байна.

Д.Цогтбаатар:- 9 сарын 10-нд үр хүүхэд, ач гучаа дагуулаад ирээрэй. Мөн 9 сарын 9-нд Хамбын овоон дээр том үйл ажиллагаа, тухайн үеийн үйл явдлыг харуулсан театрчилсан тоглолт болох юм. Аль болохоор сэтгэл гаргаад Та бүхэн очоорой гэдгийг давхар хэлье.

Г.Ариунболд:-Түрүүнд Дүгэрээ дипломатч яриад байсан. Миний илтгэлд яригдсан Панмонголизмын хэрэгт ЗХУ-ын Бутовод хэлмэгдсэн 40-өөд хүн, ер нь ЗХУ-д нийтдээ 500 гаруй иргэн хэлмэгдсэн гэж байгаа. Бутовод хэлмэгдсэн байршилд Монголын төр засаг дурсгалын хөшөө байгуулсан. Би нэлээн хэдэн жил судалж, сонирхож үзсэн. Яг тэр байршил бол биш. Буруу газар байршуулсан хөшөө.

Хоёрт, Оросын ФСБ, тагнуулын байгууллага яг тодорхой байрлал хэлдэггүй.Бид өөрсдөө хүсэлт тавьж тэр байршилыг тодорхойлох боломжтой. Тэр үед цаазын ял хэрэгжүүлж байсан, цаазаар авч байсан улсуудын нэрсийг олж болно. Энэ бол тийм асуудалтай зүйл биш, архивын баримтуудаар болон бусад аргаар тогтоох боломжтой гэж үзэж байгаа.

Д.Тод:-*(Түүх археологийн хүрээлэн)* Би урд нь цагаатгалын ажилд нэлээн хэдэн жил оролцон ажилласан. Комисс маань 1988 оноос хойш ажилласан. Сүүлд нөхөн олговор олгох гээд өргөжөөд явсан. Нийтдээ бараг 28, 29 жил ажиллачихсан байна. Илтгэл гаргасан уу?

Жишээ нь, дээр үед Гэндэн гуайн ахалсан комисс, Ширэндэв гуайн оролцсон комисс чинь 2, 3 жил ажиллаад хаагдсан ч илтгэлүүд, маш сайн илтгэлүүд гаргасан. ДЯЯ-ны үйл ажиллагаан дээрээ голлож гаргасан. Тэр үеийн нам төрийн удирдлага, бусад хуулийн байгууллагын талаар яасан юм, сайн судалгаа хийж чадаагүй. Тэр үедээ ангич, намч үзэл суртлын байр сууринаас хандаж байсан учраас, Чойбалсанг тахин шүтсэний улмаас Монголд хэлмэгдүүлэлт гарсан гэсэн дүгнэлт хийгээд орхисон. Тэрнээс хойш бараг 28, 29 жил цагаатгалын ажил явлаа, судалгаа ч хийлээ, их олон ч ном гарлаа. Комиссын илтгэл хийх хангалттай их хугацаа өнгөрчээ. Манай судлаачид олон үзэл бодол, янз янзын баримтыг гаргаж байна, энийг цэгцэлж, Цагаатгалын комисс мэргэжлийн байгууллага, шүүх прокурортой хамтраад илтгэл бичих болоогүй юу гэж асуумаар байна. Нэг барих юмтай болмоор байна шүү дээ.

Хоёрт, манайд нэлээн их ажил хийгдсэн. Судалгааны төв гээд олон хүний намтар түүхүүд их гарсан.Байнга л бичигдэж байсан. Түвшний хувьд янз бүр байгаа байх, сүүлийн үед жаахан зогсонги байдалтай байна уу гэж харагддаг. Тэгтэл энд Монголд хийгдсэн ажлууд лав л англи хэлтэй орнуудад огт хүрээгүй юм байна лээ. Геноцид

хэрэгжсэн орнууд гээд том том лавлах, түүхийн номнууд гардаг. Ганц Монгол байдаггүй, бусад бүх орон байдаг. Хуучин социалист байсан орнуудад бүгд хэрэгжсэн байдаг. Африк болон их олон оронд явагдсан ажил. Гадаадад энийгээ гаргадаггүй, дотроо л яриад байдаг. Энийг дэлхий нийтэд хүргэж таниулах хэрэгтэй юм гэж би боддог. Конрад Аденауэрын сангийн дэмжлэгээр явагдаж байгаа ажилд герман, франц дээр гарсан байхыг мэдэхгүй би. Ямар ч байсан англи хэлтнүүдэд хүрээгүй юм байна гэж боддог.

Д.Цогтбаатар:- Яг тодорхой хэлж байна. 90-ээд онд байгуулагдсан Цагаатгалын комиссын хувьд одоогоор яг илтгэл гарсан юм байхгүй байгаа. Ер нь цаашдаа гаргах тал дээр хууль хяналтын байгууллагууд, эрдэмтэн судлаачид хамтарч энэ ажлыг хийх нь зүйтэй байгаа гэж бодож байна.

Д.Уржинбадам (*Хэлмэгдэгчийн хүүхэд*):- Ийм хурлуудад оролцоод олон жил болж байна. Хоёр зүйл дээр тогтож ярья. Арван хэдэн жилийн турш Цагаатгалын комисс, Хэлмэгдэгчдийн холбооны шугамаар хамтарч ажиллаад явж байхад нэг зүйл харагддаг нь Комисс, Холбооны даргыг 2 өөр намаас тавьдаг явдал. Цагаатгалын комисс ажил хийхгүй тухай илтгэлд орсон гэж Р.Мөнхтариа хэлж байсан. Би үүнийг прокурор хүн, олон хуралд суусан хүний хувьд үнэтэй зөв дүгнэлт хийсэн гэж үзэж байгаа. Одоо бол юм бүрдэж байгаа. Сая хуульд нэмэлт өөрчлөлт орууллаа. Янз бүрийн байгууллагаар дэмжлэг өгөх хэрэгтэй.

Өнөөдрийн хурал бол их өөр болж байна. Ялангуяа Болдбаатар багшийн олон илтгэлийг сонсож байсан. Тэгэхэд өнөөдрийнх шиг эерэг гайгүй илтгэлийг энэ олон хуралд суухдаа сонсож байгаагүй. Тэгэхээр юм нааштай эргэж байгаа учраас бас бусдууд нь дэмжлэг өгч, дээшээ таньдаг, мэддэг, эрдэмтэн докторууд ярилцлага өгөхдөө бас зөв гарцуудаа гаргаж ярьж байгаарай гэж нэгд хэлмээр байна. Хоёрт, би "Б" зааланд салбар хуралдаанд оролцсон. Салбар хуралдаанд оролцож байхад сайн ч юм байна, муу ч юм байна. Муу юм нь нөхөх олговор бага байна, юу өгөөд байгаа юм, төлөөс өгөөд байгаа юмуу, төлбөр өгөөд байгаа юмуу, тэтгэмж, тусламж өгөөд байгаа юмуу гэж байна. Залуухан шинэхэн ардчилсан хүчнийхэн гарч ирээд нөхөн олговор олгоод сая төгрөг өгч уучлалт гуйсан гэдэг бол бас том амжилт.

Д.Дашдулам багшийг хүмүүс сайн юм хэллээ гээд ярилаа. Би бас тэрэн дээр эсэргүүцэж байгаа. Яагаад гэвэл тэрээр сүүлийн хэлмэгдүүлэлт хамгийн хэцүү гэж хэлээд байгаа, тэрнийг эсэргүүцэж байгаа. Яагаад гэвэл сүүлийн хэлмэгдүүлэлт хэцүү ч гэсэн энэ сайхан Монголын тал нутагт хэн ч, хаана ч, юу ч хийчих боломжтой. Түрүүчийн хэлмэгдүүлэлт бол ааваараа ч овоглож чадахгүй, ах дүүгээрээ ч орж чадахгүй, анд найз нартайгаа бүтэн инээж чадахгүй,

нэг хүнтэй ч гурван үг ярихад нэг нь очоод матчихдаг ийм л хэцүү байсан шүү дээ. Тэгвэл ардчилсан нийгэмд ажлаас халагдах бол байх л асуудал. Би 17, 18 жил багшаас захирал хүртэл хийж байсан. Ийм олон жил ажилласан хүн би ардчиллын үед албан тушаалаа хэтрүүлэн ашигласан гээд халагдахдаа гомдоогүй. Өнөөдөр намайг хэлмэгдсэн гэж үзье гэхээр Чи чаддаг юм бол өргөдлөө өгчихгэсэн, чадна гээд өгсөн. Тэгэхээр би хэлмэгдсэн биш өргөдлөө өгсөн хүн болж таарна шүү дээ. Би өнөөдөр хэнээс ч гуйгаагүй, хэнд ч ядуу гэж хэлэгдээгүй амьдарч байгаа. Иймэрхүү байдалд орсон олон мянган хүн байгаа. Түрүүний хэлмэгдэлтэй харьцуулах юм бол энэ нийгмийнх хэлмэгдүүлэлт биш гэж хэлмээр байна.

Дүгнэлтэд 3 санал оруулмаар байна. Хуулиа батлуулах тал дээр аль аль талаасаа, эрдэмтдийн зөвлөл ч дэмжих хэрэгтэй, төрийн бус байгууллагууд ч дэмжих хэрэгтэй. Дараа нь, сурталчилгаа маш муу байгаа. Сурталчилгаагаа хийхгүй байгаа юм чинь хэн ер нь яах юм бэ? энд байгаа хэд нь ярьдаг юмаа яриад л сууж байгаа шүү дээ. Сурталчилгааны зардлыг Цагаатгалын комисс төсөвтөө бүр оруулж өгөх хэрэгтэй. Нөхөн олговор бол зүгээр ярих асуудал биш, томруулах хэрэгтэй гэдгийг тогтмол хэлж сануулах шаардлагатай. Тэрэндээ энэ улсуудаа дайчил л даа, энэ хүмүүс чинь бараг дууслаа шүү дээ. Оюутан залууст ойлгуулах хөтөлбөр гаргах, тэр үзэж байгаа кино юман дээр нь нэмж оруулах, хэлмэгдсэн ахмадуудыгаа янз бүрийн телевиз, радио, ярилцлага сонингуудад холбож өгөх хэрэгтэй байна. Төрийн байгууллага учраас би Цагаатгалын комисст хандаж гол юмаа ярьж байна.

О.Энхбат (*Завхан аймаг*):-Миний аавын аав 1872 онд төрсөн, гэлэн Наваан гэж хүн 1938 оны 4 сарын 28-нд буудан авсан. Дараа нь миний аав, мөн гэлэнгийн хүү гавж Жамбалын Дагва гэж хүн 10 жилийн ял сонсоод 1942 онд суллагдсан байдаг. 1998 оны 4 сард цагаатгасан. Би энэ хоёр өвгөний хүү, одоо 60 дөхөж байна. 8 настайгаасаа эсэргүү том ламын хүүхэд гээд аж амьдрал, сурч боловсрох тал дээр гадуурхагдаж ирсэн, түүнийг туулаад өнгөрлөө л дөө.

Энэ тухай Сампилноров гуайтай сэтгэлээ хуваалцаад ярьж байхад чи угаасаа хэлмэгджээ. 70, 80-аад оны үеийн чиний амьдрал бүх л туулсан зам чинь хэлмэгдлийн хар шуурганд өртсөн байна. Энийгээ Дээд шүүхэд очоод танилцуулчих гэсэн. Очсон нь 40-өөд жилийн өмнөх юм чинь хэрэгсэхгүй гээд өнгөрөөж байсан. Өнөөдрийн хурал дээр ярьж байгааг сонсоод бодлоо. 70, 80-аад онд хэлмэгдүүлсэн, туулж өнгөрүүлсэнийг яах гэж байна вэ, хууль гарах уу, эсвэл яахав. Түрүүнд ярилаа, хэлмэгдэгсдийн хамгийн доод нас 80 байгаа гэж, би 58-тай. Тэгэхээр яахав, энэнээс хасагдах уу гэдгийг би асууж байна. Хэлмэгдлийг чинь дагаад хэлмэгдэл байдаг юм байна. Ингэхээр л



гашуун сургамж давтаад байна. Энийг цэвэрлэж чадахгүй байгааг би хэлж байна.

Н.Хишигт:-Манай нэгдсэн хэлэлцүүлэг нилээд өргөн хэмжээнд явагдлаа хэмээн үзэж байна. Та бүхний санал, зөвлөлгөө хүлээн авч холбогдох байгууллагуудад уламжлах тал дээр Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс, Монголын улс төрийн хэлмэгдэгсдийн холбоо анхаарч ажиллана байх аа. Зөвлөмжид давхардуулалгүйгээр тусгахийг хичээнэ.

Эхлээд өнөөдрийн олон улсын хурлын талаар товч дүгнэж хэлье.

XX зууны Монголын түүхэнд тохиосон эмгэнэлт үйл явдлын түүхийг судалж буй байдал, үр дүнг танилцуулах, шинэ баримт материалыг судалгааны эргэлтэд оруулах, сэдвийн хүрээг тэлэх зорилго бүхий манай хуралд Монгол Улсын ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Олон улсын харилцааны хүрээлэн, МУИС, МУБИС, БХИС, ТЕГ-ын Тусгай архив, МУТХХ, бусад байгууллагын судлаачид, ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэнгийн эрдэмтэн С.Л.Кузьмин, ХБНГУ-ын профессор Удо Баркманн, Конрад-Аденауэрийн сангийн төлөөлөгч, доктор Даниел Шмюкинг, Япон улсын Шизүока их сургуулийн профессор Акира Оно нарын эрдэмтэн, судлаачид нийт 24 илтгэл хэлэлцүүлээ. Хуралд Монгол улсын Их хурлын дэд дарга, Цагаатгах ажлын удирдан зохион байгуулах улсын комиссын дарга Я.Санжмятав, Монгол улсын Ерөнхийлөгчийн зөвлөх Ц.Хулан, Монголын Улс төрийн хэлмэгдэгсдийн холбоо, Монголын бурхан шашинтны төв Гандантэгчинлэн хийд, Дашчойлин хийдийн тэргүүн нар, ТББ-ууд, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн үр хүүхдүүд олон хүн оролцож санал бодлоо илэрхийллээ.

Цагаатгалын комисс болон энэ талын судалгааг ямар нэгэн хэмжээгээр хийж яваа манай түүхчдэд нэлээн шүүмжлэлтэй хандаж байна. Зарим нэгэн шүүмжлэлтэй зүйлүүдийг бид нар хүлээж авна. Гэхдээ өнөөдөр Монгол Улс хичнээн мянган жилийн түүхтэй билээ, хэдэн түүхчтэй билээ гэдгийг бид нар бас бодох ёстой.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн үр хүүхэд, төрөл садан Та бүхэн хуралд ирж, сэтгэл зүрхнээсээ хэлэх гэсэн бүхнээ хэлье гэж байгааг ойлгож хүндэтгэж байна. Үүний хамт бид түүхийн үнэнд бодитойгоор хандахын тулд түүхчид, судлаачдаа, Цагаатгах ажлыг эрхлэн гүйцэтгэж ирсэн комиссын ажилтнуудынхаа хийж бүтээснийг үгүйсгээд баймааргүй байна. Үнэхээр 27 жилийн өмнө энэ комисс байгуулагдаагүй бол өнөөдөр бид нар энэ асуудлыг чөлөөтэй яриад сууж байхад хэцүү байх гэдгийг дашрамд хэлье.

Өнөөдрийн хурлын тухайд дараах зүйлүүдийг онцлон хэлэхийг хүсч байна.

Нэгдүгээрт, энэ удаагийн эрдэм шинжилгээний хурал нь цар хүрээ, хамарсан сэдвийн хувьд өмнөхөөс өргөжиж ирснийг хэлэх ёстой. Учир нь өнөөдрийн хуралд ОХУ, БНХАУ-д гарсан болон манай улсад болсон улс төрийн хэлмэгдүүлэлт, түүнтэй төсөөтэй үйл явдлуудын талаар илтгэл тавигдаж байгаа нь энэ сонирхолтой байна. Бид зөвхөн Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлтийн асуудлыг ярих бус, энэ үйл явдлын уг сурвалж нь хаана байсан юм, хэдий хэмжээнд тэлсэн, хэрхэн нөлөөлсөн хөрс дэвсгэр дээр Монголын үйл явдлыг авч үзэж бодит үнэлэлт, дүгнэлт хийх ёстой.

Хурал дээр түүхчид, судлаачдыг шүүмжилж байна. Заримыг бид хүлээж авч байна. Гэхдээ, өнөөдөр улс төрийн хэлмэгдүүлэлт гэж юу болох, Монголд болсон үйл явдлыг үнэлж дүгнэсэн илтгэлүүдийг манай тэргүүлэх эрдэмтэд тавилаа.

Хоёрдугаарт, өнөөдөр шинэ сэдэв, судалгаа хийгдэж эхэлж байна. Тухайлбал, Монголын хөдөө орон нутагт хэлмэгдүүлэл хэрхэн явагдсаныг Хэнтий аймгийн жишээгээр авч үзэж байна. Энэ илтгэлийг хийхийн тулд доктор Д.Эрдэнэбат Хэнтийн архивт ажилласан. Судлаачид бололцооны хэрээр архивын материалыг шинээр илрүүлэн олж, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулсны дүнд өнөөдрийн зүйлүүдийг ярьж байгаа гэдгийг хэлэх хэрэгтэй. Илтгэлд өгүүлсэн зүйлүүд бол шинэ мэдээлэл мөн.

Монголын нийгмийн анги бүлгүүдийг хэлмэгдүүлсэн тухай бид ярьдаг. Лам нараа ярьж ирсэн, цэргийнхнийгээ ярьж ирсэн. Тэгвэл өнөөдрийн эрдэм шинжилгээний хурал дээр манай залуу судлаачид улс төрийн хэлмэгдүүлэлтэд нийгмийн бүлгүүдийн талаар илүү арга хүрээнд харж, заагтай авч үзсэн илтгэлүүд тавьж байна. Үүнд: ТЕГ-ын Тусгай архивын судлаач Н.Батболд Монголын төрийг үеийн үед барьж ирсэн угсаа залгамжилсан ноёдыг хэлмэгдүүлсэн асуудлыг тусгайлан авч үзэн, архивын материалд социологийн судалгаа хийж тоог нь гаргаад ирж байна. Эсвэл Герман, Францад явсан суралцагчдыг хэлмэгдүүлсэн гэж бид ярьж ирсэн, гэтэл энэ чинь оюутан сурагчид юм байна, Монголын дэвшил хөгжлийг авч явах ёстой тэр нийгмийн бүлгийг хэлмэгдүүлсэн гэсэн өнцгөөс авч үзсэн илтгэлийг докторант Р.Төрдалай хэлэлцүүлсэн. Энийг судалгаанд шинэ үг хэлсэн гэж бодож байна.

Дараагийн нэг шинэ зүйл бол нийгмийн сэтгэл зүйн орчны асуудлыг гаргаж тавьж байна. Үнэхээр хүний толгойд юу байгаа, тэр өөрөө үйлдэл болно. Дараа нь тодорхой хэргүүдийн тухай асуудлыг авч хэлэлцсэн.

Хоёр дахь багц асуудал нь, Монголд явагдсан улс төрийн хэлмэгдүүлэлт, түүний уршиг, үр дагаврын тухай байлаа. Хэлмэгдүүлэлт

бол хүний нийгэм, сэтгэл оюуныг өөрчилсөн, нийгэм, эдийн засаг, оюун санааны амьдралд хор хохирол учруулсан, түүх соёлын өвийг сүйтгэсэн, гэмтээсэн, устгасан, нийгмийн хөгжилд хойш нь татсан асуудлыг хөндсөн илтгэлүүд хийгдлээ. Энэ асуудлаар ХБНГУ-ын эрдэмтэн Монголын нийгэмд тохиосон сөрөг зүйлийг ярьж байна.

1950-иад оноос Монголын нийгэмд хэлбэрээ өөрчлөн гарч ирсэн хэлмэгдүүлэлт, нийгмийн гишүүдээ ялгаварлан гадуурхах асуудлыг түүхийн судлагдахууны хувьд тавих, хөндөх, үнэлж дүгнэхийг оролдсон илтгэлүүд байгаа нь сонирхолтой зүйл боллоо гэж үзэж байна.

Дараагийн багц асуудал бол яах аргагүй улс төрийн хилс хэргээр яллуулж, амь нас хохирсон Монгол улсын иргэдийн цагаатгасан, нэр төрийг сэргээсэн, нөхөн олговор олгосон тухайд холбогдоно. Энэ асуудал шийдлээ хүлээж байгаа нь хуралд санал бодлоо илэрхийлсэн байдлаас харагдаж байна. Та бүхний саналыг бололцооны хэрээр Зөвлөмжид тусгах болно.

Цагаатгалын ажил хийгдэж ирсэн, Улсын комиссын Судалгааны төвөөс олон арван лавлагаа, цуврал бүтээл, нэгэн сэдэвт зохиол ч гаргасаар ирсэн нь чамлалтгүй үр дүн мөн. Яагаад гэвэл Улсын комисс байгуулагдаад 27 жил болж байгаа нь тийм ч урт хугацаа биш. Цагаатгал цаашдаа ч үргэлжлэх байх, эл асуудал дээр манай төрийн болон төрийн бус байгууллагууд илүү тууштай, өргөн хүрээнд хамтарч ажиллах нь чухал байх.

Эцэст, хэдийгээр багагүй шүүмж байсан ч өнөөдрийн хурал улс төрийн хэлмэгдүүлэлтийн түүх, түүний цагаатгал, уршиг үр дагавар, түүнд өнөөдрийн монголчууд хэрхэн хандах тухай асуудлыг түүх, улс төр, цэргийн социологи, шашин судлал, соёлын харилцаа гэсэн олон шинжлэх ухааны салбар хүрээн дээрээс авч үзэхийг оролдсон ийм хурал боллоо, бас асуудал дэвшүүлсэн илтгэлүүд ч тавигдлаа гэж үзэж байна. Та бүхэнд баярлалаа.

Манай энэ хуралд оролцсон бүх хүмүүст чин сэтгэлийн талархал илэрхийлж, хурлаас гарах Зөвлөмжийг танилцуулая.

## **“УЛС ТӨРИЙН ХЭЛМЭГДҮҮЛЭЛТ: ШАЛТГААН, ҮР ДАГАВАР, СУРГАМЖ” СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛААС ГАРСАН ЗӨВЛӨМЖ**

2017 оны 09 дүгээр сарын 07

Улаанбаатар хот

Монгол улс, ОХУ, ХБНГУ, Япон улсын эрдэмтэн судлаачид оролцсон олон улсын бага хуралд тавигдсан илтгэлүүд болон Нэгдсэн хэлэлцүүлэг дээр гарсан санал хүсэлтийг зөвлөмж хэлбэрээр холбогдох байгууллагуудад хүргүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

### **Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их хуралд:**

1. Цагаатгах ажлын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор УИХ-д өргөн барьсан “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд хэлмэгдүүлэлт давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, нөхөн олговрын хэмжээг нэмэх, орон сууц олгох зэрэг багц асуудлуудыг тусгах, батлагдсан хуулийг олон түмэнд сурталчлах,
2. Монгол улсын Их хурлаас “Улс төрийн хэлмэгдүүлэлт”-ийн талаар улс төрийн дүгнэлт гаргах,
3. ОХУ-ын Холбооны Аюулгүй байдлыг архив болон бусад архивуудаас баримт хуулбарлан авах ажлыг Улсын комиссын шугамаар сэргээн үргэлжлүүлэх, Монгол улсын судлаачдыг томилон ажиллуулах,
4. Улс төрийн хэлмэгдэгсдийн талаарх судалгааны үйл ажиллагааг сэргээн шинэ шатанд гаргах, Судалгааны төвд хадгалагдаж байсан баримт, эх хэрэглэгдэхүүнийг Монгол улсын Үндэсний төв архивт шилжүүлэх, Тагнуулын Ерөнхий газрын Тусгай архивын баримт материалыг хуульд заасан журмын хүрээнд ил тод, нээлттэй болгох,
5. Улс төрийн хилс, зохиомол хэргүүд, түүний дотор 1932 оны “Зэвсэгт бослого”, ор сураггүй алга бологсад, Барга, үзэмчний олзлогдсон цэргүүдийн талаар судалгаа явуулах, цагаатгах талаар улс төрийн шийдвэр гаргах,

6. Монголын бурхны шашныг дэмжих, сүм хийдийн өвийг сэргээхэд төрөөс анхаарч хөрөнгө зориулах,
7. Хамбын овоо орчимд хэлмэгдэгсдийн булш байх магадлал бүхий газруудад малтлага хийж, гарсан цогцсуудыг чандарлаж, сацалж оршоох,
8. Хамбын овоо орчмын газарт "Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх цогцолбор" байгуулах ажлыг нийслэлийн төр захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх,
9. ЦАУЗБУК-ын зарим төрлийн ажил үйлчилгээг "Монголын Улс төрийн хэлмэгдэгсдийн холбоо"-оор гүйцэтгүүлэх боломжийг судлаж, хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх.

#### **Хоёр. Эрдэм шинжилгээ, судалгааны салбарт:**

1. Монголд явагдсан улс төрийн хэлмэгдүүлэлтийг судлах, цагаатгах ажлын хүрээнд нэр томьёоны асуудал (хэлмэгдүүлэлт, цуст яргалал, залхаан цээрлүүлэлт, геноцид, аллага хядлага, бүх нийтийг хамарсан демоцит" г.м олон янзаар нэрлэж буй.)-ыг шинжлэх ухааны үүднээс тодорхойлох ажлыг ЦАУЗБУК-оос эрхлэн Төрийн хэлний Зөвлөл, Улсын нэр томьёоны комисс, холбогдох яамд, ШУА, эрх зүй, түүх, улс төр судлал зэрэг олон салбарын судлаачдын оролцоотойгоор хийх,
2. Баримт бичгийн эмхэтгэлийг олноор хэвлэн нийтийн хүртээл болгох,
3. Баримт материалыг нухацтай судалж, эрдэм шинжилгээний эргэлтэд өргөнөөр оруулсны үндсэн дээр Монголд явагдсан улс төрийн хэлмэгдүүлэлтийн түүхийг бүхэлд нь үнэлж дүгнэсэн, нийгмийн амьдралд үзүүлсэн хор уршгийг дэлгэн харуулсан суурь бүтээлийг ойрын үед туурвих,
4. Улс төрийн хэлмэгдэгдүүлэлтийн талаар түүх-гэрэл зургийн ном бүтээх,
5. Судалгааны цар хүрээг өргөтгөх, шинэ судалгаа хийх, үр дүнг ном бүтээл болон эрдэм шинжилгээний хурлуудын хэлбэрээр олон хүргэх.

#### **Гурав. Танин мэдэхүй, сурталчилгааны чиглэлээр**

1. Нийт иргэд, хүүхэд, залуучуудад улс төрийн хэлмэгдүүлэлтийн талаар ойлголт өгөх, хор уршгийг

таниулах, түүхэн ухаарлын үүднээс хандах мэдрэмж ухамсрыг суулгах, нийгмийн гишүүдийг улс төрийн үзэл бодлоор ялгаварлан гадуурхах явдлаас сэргийлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг шинэ шатанд гаргах,

2. “Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалын музей”-г сургалтын бааз болгон ашиглах,
3. Судалгааны үр дүнг олон нийтэд хүргэх үүднээс Түүхээс суралцах, сургамж авах ажлыг судалгаа, сургалт, сурталчилгаа, хэвлэл мэдээллийн байгууллагууд хамтран явуулах,
4. Эмгэнэлт үйл явдал болсон газруудын байршлыг тогтоох, тэмдэгжүүлэх, дурсгалын самбар хадах, багана босгох, цогцолбор байгуулах ажлыг Монголын улс төрийн хэлмэгдэгсдийн холбоо болонбусад ТББ-ууд, хэлмэгдэгсдийн үр хүүхдүүдийн оролцоотойгоор хийх,

Эцэст, ХХ зууны Монголд тохиосон энэхүү эмгэнэлт үйл явдал эх түүхийн салшгүй хэсэг учир судалгааг эрс өргөжүүлэх, түүхэн сургамж авах, улс төрийн хилс хэрэгт өртөн хэлмэгдэгсдийн цагаатгах, нэр төрийг сэргээх, нийгмийн гишүүдийг улс төрийн үзэл бодлоор ялгаварлан гадуурхах явдал орчин үед шинэ хэлбэрээр гарахаас сэргийлэхэд Төрийн ба Төрийн бус байгууллагууд уялдаа холбоотой хамтран ажиллах нь чухал хэмээн үзэж байна.

### **Олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцогсод**



III  
ХЭСЭГ

ХАВСРАЛТ



МОНГОЛ УЛСЫН  
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
УЛСЫН КОМИССЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалыг  
хүндэтгэх 80 дахь жилийг тэмдэглэн  
өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын 1996 оны 33 дугаар тогтоол, Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дүрмийн 4 дүгээр зүйлийн 18 дугаарт заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс төрийн хэлмэгдэгсдийг санан дурсах, тэдний гэгээн дурсгалыг хүндэтгэн мөнхжүүлэх 80 дахь жилийг тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. “Улс төрийн хэлмэгдүүлэлтийн үр дагавар, сургамж” олон улсын бага хурлыг 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулсугай.

3. Улс төрийн хэлмэгдэгсдийг санан дурсах, тэдний гэгээн дурсгалыг хүндэтгэн мөнхжүүлэх 80 дахь жилийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, “Улс төрийн хэлмэгдүүлэлтийн үр дагавар, сургамж” олон улсын бага хурлыг зохион байгуулах Ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулж, шаардлагатай төсвийг батлуулан, хэрэгжүүлж ажиллахыг Улсын комиссын Нарийн бичгийн дарга /П.Нарандалай/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Я.САНЖМЯТАВ

464000016



Улсын комиссын даргын 2017 оны 46 дугаар сарын  
28-ны өдрийн 43 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

#### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч	П.Нарандалай Улсын комиссын нарийн бичгийн дарга
Гишүүд	О.Галбаяр Нийслэлийн салбар комиссын нарийн бичгийн дарга Д.Цогтбаатар Улс төрийн хэлмэгдэгсдийн холбооны тэргүүн /зөвшилцсөнөөр/ Ч.Болдбаатар МУБИС-ийн багш, Доктор /зөвшилцсөнөөр/ О.Батсайхан Түүхийн шинжлэх ухааны Доктор, Профессор С.Чулуун ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн захирал, Доктор /зөвшилцсөнөөр/ Д.Хоролдамба Архивын ерөнхий газрын дарга /зөвшилцсөнөөр/ Д.Авирмэд Тагнуулын ерөнхий газрын Тусгай архивын дарга, Доктор /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	Д.Ууганбаатар Улсын комиссын гишүүн



МОНГОЛ УЛСЫН  
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
УЛСЫН КОМИССЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 08 сарын 18 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Үзэсгэлэн зохион байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын 1996 оны 33 дугаар тогтоол, Монгол улсын цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын дүрмийн 4 дүгээр зүйлийн 18 дугаарт заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр, Улс төрийн их хэлмэгдэгдүүлэлтийн 80 дахь жилийг тэмдэглэн өнгөрүүлэх, хэлмэгдэгсдийг санан дурсах, тэдний гэгээн дурсгалыг хүндэтгэн мөнхжүүлэх, иргэд олон нийтэд хэлмэгдүүлэлтийн хор уршгийг ойлгуулан таниулах зорилгоор “Улс төрийн хэлмэгдүүлэлт” сэдэвт үзэсгэлэнг 2017 оны 09 дүгээр сарын 06-наас эхлэн Монголын үндэсний музейд зохион байгуулсугай.

2. “Улс төрийн хэлмэгдүүлэлт” үзэсгэлэнг зохион байгуулах, бэлтгэл хангах Ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Үзэсгэлэн зохион байгуулахад шаардагдах зардлыг батлагдсан төсвийн дагуу зохих зардлаас гаргахыг Улсын комиссын нарийн бичгийн дарга /П.Нарандалай/-д зөвшөөрсүгэй.

4. Ажлын тайланг 2017 оны 10 дугаар сарын 01-ний дотор танилцуулахыг Ажлын хэсэг /Д.Ууганбаатар/-т үүрэг болгосугай.


ДАРГА



Я.САНЖМЯТАВ

464000004

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын  
комиссын даргын 2017 оны 08 дугаар сарын 18-ны  
өдрийн 41 дугаар захирамжийн хавсралт



**Ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

Ажлын хэсгийн дарга	Д.Ууганбаатар Захиргаа, дүн шинжилгээний албаны дарга
Гишүүд	С.Бэхбат П.Гэндэнгийн нэрэмжит сангийн тэргүүн /зөвшилцсөнөөр/  И.Будбаяр Монголын үндэсний музейн Боловсрол, олон нийтийн хөтөлбөр, маркетингийн албаны дарга /зөвшилцсөнөөр/  Б.Цэндсүрэн Архивын Ерөнхий газрын Мэргэжил арга зүйн удирдлагын газрын дарга /зөвшилцсөнөөр/  П.Гандалай Тагнуулын Ерөнхий газрын Тусгай архивын ажилтан /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	Б.Пагам Улсын комиссын референт





2017 оны 9 сарын  
6-нд Өдрийн сонин  
байранд болсон  
хэвлэлийн бага хурал.  
(Баруун гар талаас  
Улсын комиссын  
нарийн бичгийн дарга  
П.Нарандалай, Улс  
төрийн хэлмэгдэгсдийн  
холбооны тэргүүн  
Д.Цогтбаатар, Улсын  
комиссын албаны  
дарга Д.Ууганбаатар  
нар/

2017 оны 9 сарын  
7-ны өдөр Нийслэлийн  
Хангарьд ордонд “Улс  
төрийн хэлмэгдүүлэлт,  
шалтгаан, үр дагавар,  
сургамж” сэдэвт  
олон улсын эрдэм  
шинжилгээний бага хурал  
боллоо.



Улсын Их Хурлын  
дэд даргын зөвлөх  
Р.Гончигдорж, ШУА-  
ийн Түүх, археологийн  
хүрээлэнгийн эрдэмтэн  
нарийн бичгийн дарга  
Н.Хишигт нар





Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын төлөөлөгчид. (Баруун гар талаас ХБНГУ-ын Конрад Аденауэрын сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Даниле Шмьюкинг, Японы Шизуока их сургуулийн профессор Акира Оно, Түүхийн шинжлэх ухааны доктор О.Батсайхан, ОХУ-ын ШУА-ийн доктор профессор С.Л.Кузьмин/

Монголын бурхан шашны төв Гандантэгчэнлин хийдийн тэргүүн хамба Г.Чойжамц, Дашчойлон хийдийн тэргүүн хамба Ч.Дамбажав нар





*Олон улсын эрдэм  
шинжилгээний бага  
хурлын нэгдсэн хуралдаан*



*Олон улсын эрдэм  
шинжилгээний бага  
хуралд оюутан  
залуус оролцон  
хэлмэгдүүлэлтийн  
талаарх сонирхсон  
асуултандаа хариулт  
авлаа.*





*Олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд оролцогсод*



*Тавьсан илтгэлтэй холбогдуулан хуралд оролцогсдын санал бодлыг сонсон хэлэлцүүлэг хийж зөвлөмж гаргалаа.*

*Хэлэлцүүлгийн үеэр хурлын төлөөлөгч нар санал бодлоо хэллээ.*



*Соёлын гавьяат зүтгэлтэн, МЗЭ-ийн  
шагналт зохиолч, генерал  
Л.Пүрэвдорж*



*Улсын комиссын нарийн бичгийн даргаар  
ажиллаж байсан доктор, профессор  
О.Лхагварэнцэн*



*Үндсэн хуулийн цэцийн гишүүн  
Ш.Цогтоо*



*П.Гэндэнгийн нэрэмжит сангийн  
тэргүүн С.Бэхбат*



*Иргэний нисэхийн ерөнхий газрын  
Захиргаа, удирдлагын газрын дарга  
Т.Батжаргал*



*Сэлэнгэ аймгаас оролцсон ахмад судлаач  
Ө.Бавуу*





Олон улсын бага хурлын зохион байгуулагчид (Баруун гар талаас Улсын комиссын ажилтан Ц.Нарантуяа, Ш.Гантуяа, Нийслэлийн салбар комиссын ажилтан О.Галбаяр, Улсын комиссын ажилтан П.Оюун, Б.Пагам, С.Энхбаяр, Улс төрийн хэлмэгдэгсдийн холбооны ажилтан Д.Цогзолмаа нар/

2017 оны 9 дүгээр сарын 10-ны Улс төрийн хил хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр Хэлмэгдэгсдийн хөшөөнд Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга, Монгол Улсын Их Хурлын дарга Миеэгомбын Энхболд, Монгол Улсын Их Хурлын дэд дарга, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга Я.Санжмятав, Улсын Их Хурлын гишүүд болон албаны бусад хүмүүс цэцэг өргөж, хүндэтгэл үзүүлэв.



Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга цэцэг өргөх ёслолын ажиллагааны үеэр хэлмэгдэгсдийн ар гэрийнхэнээс уучлалт гуйж, хүндэтгэл үзүүлэв.



Монгол Улсын Их Хурлын дэд дарга, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга Я.Санжмятав уг хэлэв.

Цагаатгах ажлыг  
удирдан зохион  
байгуулах улсын  
комиссын ажилтнууд  
Хэлмэгдэгсдийн хөшөөнд  
цэцэг өргөж байгаа нь







*Хэлмэгдэгсдийн хөшөөнд төрийн яамд, тусгай газрууд, улс төрийн намууд болон хэлмэгдэгсдийн ар гэрийнхэн цэцэг өргөж, хүндэтгэл үзүүлээ.*



1937 онд их хэлмэгдүүлэлт гарсны 80 жил, Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг 22 дахь жилдээ тэмдэглэж байгаатай холбогдуулан 2017 оны 9 дүгээр сарын 6-нд Монголын үндэсний музейд “Мартах эрхгүй давтах ёсгүй” үзэсгэлэн нээгдлээ.

Үзэсгэлэнгийн нээлтэд Бурхан шашны төв Гандантэгчинлэн хийдийн лам нар ирж буяны ном хурлаа.



Үзэсгэлэнг Улсын Их Хурлын дэд даргын зөвлөх Р.Гончигдорж болон албаны бусад хүмүүс үзэж сонирхлоо.





Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн Шашин,  
соёлын бодлогын зөвлөх  
Ц.Хулан, ОХУ-ын  
ШУА-ийн профессор  
С.Л.Кузьмин нар



Үзэсгэлэнд тавигдсан  
үзмэрүүдээс



*Үзэсгэлэнд тавигдсан үзмэрүүдээс*



*2017 оны 9 дүгээр сарын 06-ны өдөр Хамбын овоонд хэлмэгдэгсдийг хүндэтгэн дурсах шашин соёлын хүндэтгэлийн арга хэмжээ боллоо.*



*Хамбын овоод болсон  
шашин соёлын арга  
хэмжээнд Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн Соёл,  
шашны бодлогын зөвлөх  
Ц.Хулан оролцов.*

*Улсын драмын эрдмийн театрын  
жүжигчид хэлмэгдүүлэлтийн  
түүхийг харуулсан театрчилсан  
жүжиг тоглов.*



*Тус арга хэмжээнд Японы  
Шизүоказ их сургуулийн  
профессор Акира Оно  
оролцов.*





